МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ, САНГИЙН САЙДЫН
ХАМТАРСАН ТҮШААЛ

Монголбанкны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сан... 2018 оны 02 сарын 05-... өдрийн 38/48 дугаарт бүр...

2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр

Дугаар А-294/340

Улаанбаатар хот

Нягтлан бодох бүртгэлийн багц материалыг шинэчлэн батлах тухай

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Банкны нягтлан бодох бүртгэлийн заавар"-ыг нэгдүгээр хавсралтаар, "Дансны жагсаалт"-ыг хоёрдугаар хавсралтаар, "Санхүүгийн тайлангийн маягт, загвар" -ыг гуравдугаар хавсралтаар, "Банкны санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх аргачлал"-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус батлсугай.

Хоёр. Тус багц материалыг батлагдсан өдрөөс эхлэн банкны үйл ажиллагаанд нэвтрүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Монголбанкны Хяналт шалгалтын газар /Н.Батсайхан/-т үүрэг болгосугай.

Гурав. Энэ талаар мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Г.Түвдэндорж/, Монголбанкны Хяналт шалгалтын газар /Н.Батсайхан/-т үүрэг болгосугай.

Дөрөв. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан 2015 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн А35/20 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ
Н.БАЯРСАЙХАН

САНГИЙН САЙД
Ч.ХҮРЭЛБААТАР

Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн Сайдын
2017 оны ..11.. дүгээр сарын 27-ны өдрийн А-297/340
хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт

УХА0011 9131787

УХМ0814

БАНКНЫ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЗААВАР

ГАРЧИГ

НЭГ. НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ 8

ХОЁР. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ 9

ГУРАВ. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО 10

3.1. Нягтлан бодох бүртгэлийн зарчим 10

3.2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 11

3.3. Нягтлан бодох бүртгэлийн удирдлага, зохион байгуулалт 11

ДӨРӨВ. ХӨРӨНГӨ 12

4.1. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ, БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГАД БАЙРШУУЛСАН ХӨРӨНГӨ 12

а. Шууд холбогдох стандартууд 12

б. Тодорхойлолт 12

в. Хүлээн зөвшөөрөлт 13

г. Хэмжилт ба үнэлгээ 13

д. Бүртгэл 14

1) Бэлэн мөнгө 14

2) Чек 15

3) Монголбанкинд байршуулсан мөнгө 15

4) Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө 16

5) Овернайт зээл 16

6) Гадаад валютын спот арилжаа 17

7) Гадаад валютын ханшийн тэгшитгэл 17

е. Тодруулга 18

ё. Хяналт 18

4.2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 18

4.2.1. ҮНЭТ ЦААС 18

а. Шууд холбогдох стандартууд 18

б. Тодорхойлолт 18

в. Хүлээн зөвшөөрөлт 19

г. Хэмжилт ба үнэлгээ 20

1) Арилжааны үнэт цаас буюу ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаас 20

2) Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас 21

3) Борлуулахад бэлэн үнэт цаас 23

4) Зээл ба авлага гэж ангилсан үнэт цаас 26

д. Бүртгэл 27

1) Арилжааны үнэт цаас 27

2) Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас 29

3) Борлуулахад бэлэн үнэт цаас 30

е. Тодруулга 32

ё. Хяналт 32

4.2.2. ХАРААТ, ХАМТЫН ХЯНАЛТТАЙ, ОХИН КОМПАНИД ОРУУЛСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 33

а. Шууд холбогдох стандартууд 33

б. Тодорхойлолт 33

в. Хүлээн зөвшөөрөлт 33

1) Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт 33

2) Хамтын хяналттай компанид оруулсан хөрөнгө оруулалт 34

3) Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт 34

г. Хэмжилт ба үнэлгээ 35

д. Бүртгэл 35

1) Өмчийн аргаар бүртгэсэн хөрөнгө оруулалт 35

2) Өртгийн аргаар бүртгэсэн хөрөнгө оруулалт 37

е. Тодруулга 37

ё. Хяналт 38

4.3. ЗЭЭЛ 38
а. Шууд холбогдох стандартууд 38
б. Тодорхойлолт 38
в. Хүлээн зөвшөөрөлт 39
г. Хэмжилт ба үнэлгээ 39
1) Анхны удаа хэмжих 39
2) Банкны шимтгэл 39
3) Зээлийг бодит үнэ цэнээр бүртгэх тохиолдол 40
4) Дараа үеийн хэмжилт 43
5) Санхүүгийн түрээс 43
6) Зээлийн үнэ цэнийн бууралтыг тооцох 43
7) Зээлийн хуримтлуулж тооцсон хүүгийн авлага 49
8) Гадаад валютаар илэрхийлэгдсэн зээл 50
д. Бүртгэл 50
1) Зээл олгох, төлүүлэх, гадаад валютын зээлийг дахин үнэлэх 50
2) Зээлийн хүүгийн бүртгэл 51
3) Зээлийг дахин ангилах, зээлийн эрсдэлийн сан байгуулах, зарцуулах 52
4) Зээлийн эрсдэлийн санг СТОУС-ын дагуу үнэлж бүртгэх 53
5) Банк хоорондын захаар олгосон зээл 54
6) Хамтын зээлжүүлэлт 54
7) Зээл, зээлийн багцыг худалдах (Факторинг) 55
8) Батлан даалт, баталгаа 56
9) Санхүүгийн түрээс 56
10) Зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй олгосон зээл 57
е. Тодруулга 58
ё. Хяналт 58

4.4. ДЕРИВАТИВ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛ 58
а. Шууд холбогдох стандартууд 58
б. Тодорхойлолт 58
в. Хүлээн зөвшөөрөлт 60
1) Форвард хэлцэл 60
2) Своп хэлцэл 60
3) Опшин хэлцэл 60
4) Нуугдмал дериватив 60
5) Хейдж 63
г. Хэмжилт ба үнэлгээ 65
1) Энгийн дериватив 65
2) Хейджийн хэрэгсэл 65
д. Бүртгэл 66
1) Форвард арилжаа 66
2) Своп хэлцэл 70
3) Опшин арилжаа 74
4) Хейджийн хэрэгсэл 76
е. Тодруулга 82
ё. Хяналт 82

4.5. БУСАД САНХҮҮГИЙН БА САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ 82
а. Шууд холбогдох стандартууд 82
б. Тодорхойлолт 82
в. Хүлээн зөвшөөрөлт 84
г. Хэмжилт ба үнэлгээ 84
д. Бүртгэл 86
1) Авлага 86
2) Салбар хоорондын тооцоо 87
3) Урьдчилгаа 87
4) Бараа материал, үнэ бүхий зүйлс 88
5) Үнэт металл 89
е. Тодруулга 90
ё. Хяналт 90

4.6. ҮНДСЭН ХӨРӨНГӨ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗОРИУЛАЛТТАЙ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ, БОРЛУУЛАХ ЗОРИУЛАЛТТАЙ ХӨРӨНГӨ 91
а. Шууд холбогдох стандартууд 91
б. Тодорхойлолт 91
в. Хүлээн зөвшөөрөлт 92
г. Хэмжилт ба үнэлгээ 93
д. Бүртгэл 96
1) Үндсэн хөрөнгө худалдан авах ба бэлтгэх 96
2) Үндсэн хөрөнгийн элэгдэл, үнэ цэнийн бууралт 97
3) Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ 98
4) Үндсэн хөрөнгийг данснаас хасах, шилжүүлэх 99
5) Үндсэн хөрөнгийн засвар, үйлчилгээ 99
6) Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө 99
7) Борлуулах зориулалттай хөрөнгө 100
е. Тодруулга 101
ё. Хяналт 101

4.7. БИЕТ БУС ХӨРӨНГӨ 101
а. Шууд холбогдох стандартууд 101
б. Тодорхойлолт 101
в. Хүлээн зөвшөөрөлт 102
г. Хэмжилт ба үнэлгээ 102
д. Бүртгэл 103
е. Тодруулга 104
ё. Хяналт 104

ТАВ. ӨР ТӨЛБӨР 105

5.1. ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ 105
а. Шууд холбогдох стандартууд 105
б. Тодорхойлолт 105
в. Хүлээн зөвшөөрөлт 105
г. Хэмжилт ба үнэлгээ 106
д. Бүртгэл 106
1) Харилцах, хадгаламжийн данс нээх, хаах, хүүгийн бүртгэл 106
2) Харилцагчийн бэлэн мөнгөний орлого, зарлагын гүйлгээ 106
3) Бэлэн бус төлбөр тооцоо 106
4) Хадгаламжийн сертификат 107
е. Тодруулга 107
ё. Хяналт 107

5.2. БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС ТАТСАН ЭХ ҮҮСВЭР 107
а. Шууд холбогдох стандартууд 107
б. Тодорхойлолт 107
в. Хүлээн зөвшөөрөлт 108
г. Хэмжилт ба үнэлгээ 108
д. Бүртгэл 109
1) Монголбанк болон бусад банкнаас авсан зээл 109
2) Бусад банк санхүүгийн байгууллагаас байршуулсан харилцах хадгаламж 110
е. Тодруулга 111
ё. Хяналт 111

5.3. БУСАД ЭХ ҮҮСВЭР 111
а. Шууд холбогдох стандартууд 111
б. Тодорхойлолт 111
в. Хүлээн зөвшөөрөлт 112
г. Хэмжилт ба үнэлгээ 112
д. Бүртгэл 113
1) Банкнаас гаргасан бонд, өрийн бичиг 113
2) Репо үнэт цаас 114
3) Арилжааны эх үүсвэрийн тооцоо 116
4) Аккредитивийн тооцоо 116

5) Баталгааны эх үүсвэр ... 116
6) Зах зээлийн хүүгээс ялгаатай хүүтэй эх үүсвэрийн бүртгэл ... 117
7) Санхүүгийн түрээсийн өглөг ... 117
8) Үйл ажиллагааны түрээсийн өглөг ... 117
9) Түрээсийн хөрөнгийг борлуулаад эргүүлэн түрээслэх арилжаа ... 117
е. Тодруулга ... 119
ё. Хяналт ... 119

5.4. БУСАД САНХҮҮГИЙН БА САНХҮҮГИЙН БУС ӨР ТӨЛБӨР ... 119
а. Шууд холбогдох стандартууд ... 119
б. Тодорхойлолт ... 120
в. Хүлээн зөвшөөрөлт ... 121
г. Хэмжилт ба үнэлгээ ... 122
д. Бүртгэл ... 132
1) Өглөг, урьдчилгаа ... 132
2) Ажилтнуудын тэтгэвэр, тэтгэмжийн өглөг ба Нийгмийн хөгжлийн сан ... 132
3) Мөнгөн гуйвуулгын өглөг ... 134
4) Банк хоорондын тооцоо ... 134
5) Хөрвөх өр төлбөр ... 134
6) Санхүүгийн өр төлбөрийг өмчийн хэрэгслээр төлж барагдуулах (СТОУТХ 19) ... 135
7) Нөөц ба болзошгүй өр төлбөр ... 135
8) Зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй зээл ба буцалтгүй тусламж ... 137
9) Мөнгөөр төлөгдөх хувьцаанд суурилсан өр төлбөр ... 137
10) Хоёрдогч өглөг ... 137
е. Тодруулга ... 138
ё. Хяналт ... 138

ЗУРГАА. ӨӨРИЙН ХӨРӨНГӨ ... 139
а. Шууд холбогдох стандартууд ... 139
б. Тодорхойлолт ... 139
в. Хүлээн зөвшөөрөлт ... 139
г. Хэмжилт ба үнэлгээ ... 139
д. Ангилал ... 139
е. Бүртгэл ... 139
6.1. ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ ... 139
6.2. НЭМЖ ТӨЛӨГДСӨН КАПИТАЛ ... 140
6.3. ДАВУУ ЭРХИЙН ХУВЬЦАА ... 140
6.4. ХАЛААСНЫ ХУВЬЦАА ... 142
6.5. ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭГДЭЛ ... 142
6.6. ХУРИМТЛАГДСАН АШИГ, АЛДАГДАЛ ... 143
6.7. БУСАД ӨӨРИЙН ХӨРӨНГӨ ... 143
ё. Тодруулга ... 147
ж. Хяналт ... 147

ДОЛОО. ОРЛОГО БА ЗАРДАЛ ... 149

7.1. ОРЛОГО ... 149
а. Шууд холбогдох стандартууд ... 149
б. Тодорхойлолт ... 149
в. Хүлээн зөвшөөрөлт ... 149
г. Хэмжилт ба үнэлгээ ... 149
д. Бүртгэл ... 149
1) Хүүгийн орлого ... 149
2) Арилжааны орлого ... 150
3) Ханшийн тэгшитгэлийн орлого ... 150
4) Үнэлгээний тэгшитгэлийн орлого ... 150
5) Хураамж, шимтгэлийн орлого ... 150
6) Бусад орлого ... 151
е. Тодруулга ... 151

7.2. ЗАРДАЛ ... 151
а. Шууд холбогдох стандартууд ... 151

б. Тодорхойлолт 151
в. Хүлээн зөвшөөрөлт 151
г. Хэмжилт ба үнэлгээ 152
д. Бүртгэл 152
1) Хүүгийн зардал 152
2) Эрсдэлийн сангийн зардал 152
3) Арилжааны зардал 152
4) Ханшийн тэгшитгэлийн зардал 153
5) Үнэлгээний тэгшитгэлийн зардал 153
6) Үйл ажиллагааны бусад зардал 153
7) Бусад зардал 155
е. Тодруулга 155

7.3. АШИГ, АЛДАГДАЛ 155

7.4. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР 156
а. Шууд холбогдох стандартууд 156
б. Тодорхойлолт 156
в. Хүлээн зөвшөөрөлт 156
г. Хэмжилт ба үнэлгээ 157
д. Бүртгэл 159
е. Тодруулга 160

7.5. ЗОГСООСОН ҮЙЛ АЖИЛЛАГАА 161

НАЙМ. ТЭНЦЛИЙН ГАДУУРХ ДАНС 162
8.1. ЗЭЭЛ, ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨНД ХАМААРАХ ҮҮРЭГ 162
8.2. БАРЬЦАА ХӨРӨНГӨ 164
8.3. ТЭНЦЛЭЭС ХАССАН ХӨРӨНГӨ 165
8.4. ДЕРИВАТИВ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛ 166
8.5. ХАРИЛЦАГЧИЙН ӨМНӨӨС БАТЛАН ДААСАН ХӨРӨНГӨ 167
8.6. БАРЬЦААНД ТАВЬСАН ХӨРӨНГӨ 168
8.7. ТЭНЦЛИЙН ГАДУУРХ БУСАД ДАНСУУД 168

ЕС. ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ 173

НЭГ. НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Нийтлэг зориулалттай санхүүгийн тайлан (цаашид “санхүүгийн тайлан” гэх) нь мэдээллийн тусгай хэрэгцээнд бус, харин хэрэглэгчдийн нийтлэг хэрэгцээг хангахад зориулагдсан тайлан юм.

Бодит үнэ цэн нь ажил гүйлгээг бүртгэх өдөр зах зээлийн оролцогчид (холбоогүй талууд)-ын хооронд байнга хийгдэх арилжаагаар хөрөнгийг худалдах буюу худалдан авах үнэ юм.

Үр ашигт хүүгийн арга нь санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн хорогдуулсан өртгийг тооцоолж, хүүний орлого буюу хүүний зардлыг харгалзах тайлант хугацаанд хуваарилдаг арга юм.

Үр ашигт хүүгийн түвшин гэж санхүүгийн хэрэгслийн хүчинтэй байх хугацаанд ирээдүйн тооцоолсон мөнгөн төлбөр буюу мөнгөн орлогыг дискаунтчилан, дансны цэвэр дүнг гаргах тохиромжтой хувийг хэлнэ. Өөрөөр хэлбэл, үр ашигт хүүгийн түвшин нь хөрөнгө, өр төлбөрийн ирээдүйн мөнгөн гүйлгээг анх хүлээн зөвшөөрсөн дүн болгон дискаунтчилах дундаж хувь юм.

Санхүүгийн хэрэгсэл гэдэг нь нэг байгууллагын хувьд санхүүгийн хөрөнгийг, нөгөө байгууллагын хувьд санхүүгийн өр төлбөр, эсвэл өмчийн хэрэгслийг үүсгэж байдаг аливаа гэрээ юм. Үүнд мөнгөн хөрөнгө, авлага, зээл, үнэт цаас, гадаад валютын форвард, своп хэлцэл гэх мэт санхүүгийн хэрэгслийг арилжаалах хэлцлүүд болон эдгээртэй адилтгах гэрээ, хэлцэл багтана.

Санхүүгийн хэрэгслүүдийг санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөр, өмчийн хэрэгсэл гэсэн гурван хэсэгт ангилдаг.

Санхүүгийн хөрөнгөнд мөнгөн хөрөнгө, авлага, зээл, бусад байгууллагын өгсөн өмчийн хэрэгсэл, санхүүгийн хөрөнгийг авах гэрээний эрх, дериватив, тэдгээртэй ижил төстэй гэрээ багтана.

Санхүүгийн өр төлбөрт харилцах, хадгаламж, санхүүгийн хөрөнгийг шилжүүлэх гэрээний үүрэг, түүнтэй ижил төстэй гэрээ багтана.

Өмчийн хэрэгсэлд санхүүгийн өр төлбөр болохгүй гэрээний үүрэг, ижил төстэй хэлцэл багтана.

Тайлагналын өдөр гэдэг нь санхүүгийн тайланг бэлтгэн гаргах тайлант хугацааны эцсийн өдрийг хэлнэ.

Дансны үнэ (дансны үлдэгдэл) гэдэг нь санхүүгийн байдлын тайланд хөрөнгө, өр төлбөр, өөрийн хөрөнгийг хүлээн зөвшөөрч, толилуулсан дүнг хэлнэ.

Нөхөгдөх дүн (нөхөн төлөх өртөг) гэдэг нь хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан дүн ба ашиглалтын үнэ цэнийн аль ихийг хэлнэ.

Ашиглалтын үнэ цэн гэдэг нь хөрөнгийн ирээдүйд төлөгдөх мөнгөн төлбөрийн өнөөгийн үнэ цэн юм.

Албан ханш (спот ханш) гэж аж ахуйн нэгж, байгууллагуудын нягтлан бодох бүртгэлд мөрдөхөөр Монголбанкнаас зарласан тухайн өдрийн гадаад валютын ханшийг хэлнэ.

Валют гэдэгт төлбөр тооцооны хэрэгсэл болсон цаасан, зоосон гэх мэт бүх хэлбэрийн үндэсний валют (төгрөг) болон гадаад валют (төгрөгөөс бусад бүх төрлийн валют)-ыг хамруулан ойлгоно.

Мөнгөн зүйлс гэж тодорхой тооны валютыг бусдаас авах эрх, эсвэл бусдад өгөхөөр хүлээсэн үүргийг ойлгоно. Хөрөнгө ба өр төлбөр хэлбэртэй мөнгөн зүйлсэд гадаад валютын ханшийн тэгшитгэл хийх бөгөөд харин мөнгөн бус зүйлс (хөрөнгө болон өр төлбөр) -д гадаад валютын ханшийн тэгшитгэл хийхгүй. Мөн тодорхой тооны валютаар илэрхийлэгдэх бодит үнэ цэнтэй тогтмол бус тооны хөрөнгө, эсвэл өөрийн өмчийн хэрэгслийг банк тогтмол бус тоогоор өгөх буюу авах хэлцэл нь мөнгөн зүйл болно. Үүний эсрэгээр мөнгөн бус зүйл нь тодорхой тооны валютыг авах эрх эдлээгүй, эсвэл өгөх үүрэг хүлээгээгүй байхыг хэлнэ. Жишээ нь бараа, үйлчилгээний үнэнд төлсөн төлбөр (жишээлбэл, урьдчилж төлсөн түрээс), гүүдвил, биет бус хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, мөнгөн бус хөрөнгөөр барагдуулах нөөц гэх мэт.

Дискаунтчилах гэдэг нь аливаа хэлцэлд хамаарах ирээдүйн мөнгөн төлбөрийг тодорхой хүүгийн түвшинг ашиглан өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэхийг хэлнэ.

ХОЁР. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Банкны байгууллагын олон талт үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлд тусгаж, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэхэд энэхүү зааврын зорилго оршино. Энэхүү зааврыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид СТОУС гэх бөгөөд энэ нь хүчин төгөлдөр СТОУС-ууд, НББОУС-ууд болон тэдгээрийн хэрэглээний тайлбаруудаас бүрдэнэ) болон Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжинд нийцүүлж боловсруулсан болно. Энэ зааварт нягтлан бодох бүртгэлийн холбогдох зарчмыг тусгаж, дансдын нийтлэг бичилтүүдийг үзүүлсэн.

Энэхүү зааварт тулгуурлан банкууд дотооддоо СТОУС болон Монгол улсад мөрдөгдөж буй хууль, дүрэм, журамд бүрэн нийцсэн, нягтлан бодох бүртгэлийн бодлого, журам, дансны дэлгэрэнгүй жагсаалтыг боловсруулж мөрдөнө. Энэ зааварт Монгол улсын банкны секторт нийтлэг тохиолддог ажил гүйлгээг хамруулсан. Иймд энэ зааварт тусгагдаагүй зарим нэг зүйлс байж болзошгүй бөгөөд энэ тохиолдолд холбогдох СТОУС-ын заалтыг мөрдөнө. Энэ зааварт тусгагдаагүй шинэ бүтээгдэхүүн, арилжааг бүртгэх дансны харилцаа, бүртгэлийн зарчмыг Монголбанкинд урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авна.

Банк нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд заасны дагуу нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлж, тус хуулийн 14.2 дугаар зүйлд заасны дагуу ажил гүйлгээг дансны давхар бичилтийн аргаар бүртгэнэ.

Нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлтийн нэгж нь энэ хуулийн 7.2 дугаар зүйлд заасны дагуу Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөг, мөнгө байна.

Хүүтэй санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийн хүүг өдөр тутам хуримтлуулж бүртгэнэ.

Үнэт металл, гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөрийг Монголбанкнаас зарласан албан ханшаар өдөр бүр үнэлж, ханшийг тэгшитгэж толилуулна.

Дериватив зэрэг арилжааны зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн зах зээлийн жишиг үнэ мэдэгдэж байгаа тохиолдолд өдөр бүр, эсвэл зах зээлийн жишиг үнэ өөрчлөгдөх тухай бүр дахин үнэлж толилуулна.

Банк нь холбогдох хууль тогтоомж ба энэхүү зааврын дагуу банкны өр төлбөр болон өөрийн хөрөнгөнд тусгагдаж байгаа өр төлбөр, өмчийн хэрэгслийн эрэмбэ дараалыг тогтоож, шинэчилж байна.

Банкны удирдлага нь нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан, бусад мэдээ баримтыг тогтсон загварын дагуу үнэн зөв бэлтгэж, заасан хугацаанд багтаан гаргах үүргийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хүлээнэ. Өмнөх тайлант хугацаанд хамаарах мэдээллийг өөрчилж тайлагнах тохиолдолд Монголбанкинд урьдчилан мэдэгдэнэ.

ГУРАВ. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО

3.1. Нягтлан бодох бүртгэлийн зарчим

а. Санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг мөрдөх

Банк нь санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (цаашид СТОУС гэх)-ыг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөнө.

б. Нягтлан бодох бүртгэлийн суурь

Банк нь нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө. Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь гэж мөнгө хүлээн авсан эсвэл төлсөн эсэхээс үл хамааран орлогыг олсон үед болон зардлыг гарсан тухай бүрт нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг хэлнэ.

в. Нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлтийн нэгж

Нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлтийн нэгж нь Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөг, мөнгө байна.

г. Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тууштай мөрдөх

Банк Монголбанкнаас батлан гаргасан бүртгэлийн бодлого, зарчмыг тууштай мөрдөнө.

д. Үнэн зөв толилуулга

Банкны санхүүгийн тайлангууд нь санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв бодитойгоор илэрхийлсэн байна. Санхүүгийн тайланд тоон болон чанарын үзүүлэлтүүдийг харгалзан, шаардлагатай бол нэмэлт тайлбар, тодруулгуудыг бэлтгэнэ.

е. Хэлбэрээс агуулгыг илүүтэй анхаарах

Аливаа мэдээлэлд ажил гүйлгээ, үйл явдлыг зохих ёсоор тусгахын тулд мэдээллийн агуулга болон эдийн засгийн бодит байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр бүртгэнэ.

ё. Иж бүрэн байдал

Санхүүгийн тайланд тусгагдах мэдээллийн найдвартай байдлыг хангахын тулд мэдээллийг иж бүрнээр нь тусгана. Мэдээллийг орхигдуулах нь төөрөгдөлд оруулж болзошгүй ба ингэснээр мэдээллийн найдвартай байдал, зохистой чанар алдагдана.

ж. Тасралтгүй байх зарчим

Банкны удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэх явцад өөрийн банкны үйл ажиллагааг тасралтгүй байх зарчмын дагуу үргэлжлүүлэх чадварт үнэлэлт дүгнэлт өгнө. Банкийг татан буулгах, түүний үйл ажиллагааг зогсоох шийдвэр гараагүй тохиолдолд удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэнэ. Хэрэв банкны үйл ажиллагааг зогсоох гэж байгаа бол энэ талаар Монголбанкинд нэн даруй мэдэгдэнэ. Монголбанкны шийдвэрээр банкны эрх хүлээн авах арга хэмжээг хэрэгжүүлж байгаа тохиолдолд холбогдох хууль, журмыг даган мөрдөнө.

з. Илэрхийллийн тогтвортой байдал

Банкны үйл ажиллагаанд гарсан томоохон хэмжээний өөрчлөлтөөс бусад тохиолдолд санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн илэрхийлэл болон түүний ангиллыг нэг тайлант үеэс нөгөө тайлант үед өөрчлөхгүй.

и. Санхүүгийн мэдээлэл харьцуулагдахуйц байх

Энэхүү бүртгэлийн бодлого болон СТОУС-ын шаардлагын дагуу банкны санхүүгийн тайлангийн тоон мэдээллийг арга зүйн хувьд бүх тайлант хугацааны тоо мэдээллийг хооронд нь харьцуулж болохоор зохион байгуулна.

й. Цаг хугацаандаа байх зарчим

Цаг хугацаандаа байх зарчим нь мэдээллийг хэрэглэгчдийн шийдвэрт нөлөөлөх боломжтой хугацаанд болон Монголбанкнаас тогтоосон хугацаанд багтаан санхүүгийн тайланг бэлтгэж толилуулахыг хэлнэ.

к. Цэвэр дүн гаргах

СТОУС-д шаардсан эсвэл зөвшөөрсөнөөс бусад тохиолдлуудад хөрөнгө ба өр төлбөр, орлого болон зардлыг нэгтгэж, цэвэр дүнгээр тайлагнахгүй.

3.2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга

а. Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Нягтлан бодох бүртгэлийн бодлого гэж санхүүгийн тайлан бэлтгэх, толилуулахад тууштай мөрдөгдөх тухайн банкны баталсан зүй тогтол болон тогтсон дэг журмын суурь юм.

б. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт

СТОУС-д өөрөөр заагаагүй бол нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг Монголбанк хүлээн зөвшөөрсөн тохиолдолд буцаан үйлчлэх зарчмын дагуу тусгана.

Буцаан үйлчлэх горим гэж нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг анхнаас нь хэрэглэж байсан мэтээр хамгийн эхний тайлант үеэс хойш гарсан бүх ажил гүйлгээ, үйл явдлыг шинэ бүртгэлийн бодлогоор нөхөж орлуулан, бүртгэхийг хэлнэ.

в. Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт

Хөрөнгөөс хүлээгдэж буй ирээдүйн үр өгөөж болон өр төлбөрийн явц нь тухайн санхүүгийн нөхцөл байдалд үнэлгээ хийсний үр дүнд хөрөнгө, өр төлбөрийн дансдын үлдэгдэл болон хөрөнгийн хэрэглээний зарцуулалтын дүн өөрчлөгдөхийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэнэ.

Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтийг ирээдүйн тайлант үеүдэд хүлээн зөвшөөрнө.

Шинэ нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн өдрөөс хойших цаг хугацаанд ажил гүйлгээ болон өөр бусад үйл явдлын тооцооллын өөрчлөлтийн нөлөөг гарсан тайлант хугацаа эсвэл ирээдүйн тайлант хугацаанд хүлээн зөвшөөрч бүртгэхийг хүлээгдэж буй хандлага гэнэ.

г. Нягтлан бодох бүртгэлийн алдааны залруулга

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг хүлээн зөвшөөрөх, үнэлэх, толилуулах, тодруулахтай холбоотойгоор алдаа гарч болно. Нягтлан бодох бүртгэлийн алдааг тухайн тайлант үед багтаан илрүүлж, санхүүгийн тайланг тусган, хэвлэн нийтлэхээс өмнө залруулна.

СТОУС-д өөрөөр заагаагүй тохиолдолд өмнөх тайлант үеүдэд хамаарах нягтлан бодох бүртгэлийн алдааг илрүүлсэн тайлант үед нь буцаан үйлчлэх горимоор залруулна.

Нягтлан бодох бүртгэлийн алдааны залруулгыг хийхдээ Монголбанкинд урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авсан байна.

3.3. Нягтлан бодох бүртгэлийн удирдлага, зохион байгуулалт

Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүрэг, хариуцлагыг банкны удирдлага хүлээнэ.

Банкны удирдлага нь СТОУС болон Монгол Улсад мөрдөгдөж буй хууль, дүрэм, журамд бүрэн нийцсэн, нягтлан бодох бүртгэлийн бодлого, журам, дансны дэлгэрэнгүй жагсаалтыг боловсруулж мөрдөнө.

Банк санхүүгийн тайлангаа үнэн зөв гаргасан гэдгээ албан ёсоор нотолсон баримт бичиг үйлдэн он, сар, өдрийг тэмдэглэж, банкны төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх удирдлага, холбогдох бусад эрх бүхий албан тушаалтан гарын үсгээ зурж, тамга, тэмдэг дарсан байна.

ДӨРӨВ. ХӨРӨНГӨ

а. ТОДОРХОЙЛОЛТ

Хөрөнгө гэдэг нь банкны хяналтанд байгаа бөгөөд өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүсч, ирээдүйд эдийн засгийн үр өгөөж өгөх нөөц юм.

б. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

Доорх шинж чанарыг агуулсан хөрөнгийг хүлээн зөвшөөрч бүртгэнэ:

- Ирээдүйд эдийн засгийн үр өгөөж өгөх магадлалтай;
- Өртгийг бодитой тооцох боломжтой.

в. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

Хэмжилт нь санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг хүлээн зөвшөөрч, бүртгэх боломжтой мөнгөн дүнг тодорхойлох үйл явц юм. Үүний тулд хэмжилтийн суурийг тодорхойлно.

Санхүүгийн тайланг толилуулахдаа түүхэн өртөг, тайлант үеийн өртөг, цэвэр боломжит үнэ цэн, өнөөгийн үнэ цэн, бодит үнэ цэн гэх мэт хэмжилтийн суурриудыг ашигладаг.

г. АНГИЛАЛ

Санхүүгийн байдлын тайланд хөрөнгийг дараах байдлаар ангилж толилуулна.

1. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө
2. Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө
3. Хөрөнгө оруулалт
4. Зээл
5. Дериватив санхүүгийн хөрөнгө
6. Бусад санхүүгийн хөрөнгө
7. Бусад санхүүгийн бус хөрөнгө
8. Үндсэн хөрөнгө
9. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө
10. Борлуулах зориулалттай хөрөнгө
11. Биет бус хөрөнгө

д. ТОДРУУЛГА

Хөрөнгийн ангилал бүрээр нягтлан бодох бүртгэлийн ерөнхий ба тусгай бодлогыг тодруулна.

Санхүүгийн тайлангуудад толилуулаагүй боловч СТОУС-ын дагуу тодруулах шаардлагатай, эсвэл санхүүгийн тайлангуудад толилуулсан хэдий ч дэлгэрүүлж тайлбарлах шаардлагатай мэдээллийг тодруулна.

4.1. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ, БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГАД БАЙРШУУЛСАН ХӨРӨНГӨ

А. ШУУД ХОЛБОГДОХ СТАНДАРТУУД

- СТОУС 7 Санхүүгийн хэрэгсэл: Тодруулга
- СТОУС 9 Санхүүгийн хэрэгсэл
- СТОУС 13 Бодит үнэ цэнийн хэмжилт
- НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- НББОУС 7 Мөнгөн гүйлгээний тайлан
- НББОУС 21 Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө
- НББОУС 32 Санхүүгийн хэрэгсэл: Толилуулга
- НББОУС 39 Санхүүгийн хэрэгсэл: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Б. ТОДОРХОЙЛОЛТ

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд үнэ цэнийн өөрчлөлтөөс өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, түргэн борлогдох чадвартай касс дахь бэлэн мөнгө, чек, Монголбанкин дахь харилцах, хадгаламж, гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж зэрэг санхүүгийн хөрөнгө багтана.

Мөнгө нь касс дахь бэлэн мөнгө, чек, АТМ дахь мөнгө, 3 хүртэлх сарын хугацаатай Монголбанкинд байршуулсан харилцах, хадгаламж, гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хугацаагүй хадгаламж, 3 хүртэлх сарын хугацаатай хадгаламж, овернайт зээл зэргээс бүрдэнэ.

Мөнгөтэй адилтгах хөрөнгө нь 3 хүртэлх сарын хугацаатай Монголбанкны үнэт цаас, засгийн газрын үнэт цаас, засгийн газрын баталгаатай үнэт цаас, эдгээр үнэт цаасаар барьцаалсан урвуу репо зэргээс бүрдэнэ. Мөнгөтэй адилтгах хөрөнгө нь 90 хоног (3 сар)-ийн дотор мөнгөнд хөрвөх чадвартай, ямар нэгэн нөхцөлөөр хязгаарлагдаагүй байна. Энэ шалгуурыг хангаагүй мөнгөтэй адилтгах хөрөнгийг банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө, эсвэл хөрөнгө оруулалтанд бүртгэнэ. Тухайлбал, анх гаргасан хугацаанаас хойш 90 хоног (3 сар)-оос дээш хугацаатай, ямар нэгэн нөхцөлөөр хязгаарлагдсан (Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц) мөнгөн хөрөнгийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд оруулахгүй.

Үнэ цэнд гарах өөрчлөлтийн эрсдэл буюу үнэ цэнийн бууралтын эрсдэл тодорхойгүй тул Монголбанк болон засгийн газраас бусад этгээдийн (өөрөөр хэлбэл, арилжааны банк, бусад санхүүгийн байгууллага, компаниуд) гаргасан бонд, вексел гэх зэрэг үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалтыг мөнгө ба мөнгөтэй адилтгах зүйл гэж үзэхгүй. Ийм төрлийн үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалтыг 90 хоног (3 сар)-оос богино хугацаатай байсан ч хөрөнгө оруулалтаар бүртгэнэ. Үүний нэгэн адил үнэ цэнийн бууралтын эрсдэл байгаа, эсвэл мөнгөн хөрөнгийг хязгаарласан бөгөөд шууд зарцуулах боломжгүй тохиолдолд бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөнд бүртгэнэ.

Банк хоорондын клирингийн гүйлгээг хааж, дараагийн ажлын өдрийн клирингийн гүйлгээ нээх хүртэл хугацаагаар олгож байгаа зээлийг *овернайт зээл* гэнэ.

Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөнд Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц, дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, мөнгөтэй адилтгах хөрөнгөнд багтаагүй урвуу репо, хамтын зээлжүүлэлтийн зориулалтаар бусад банкинд байршуулсан мөнгө, анх гаргасан хугацаанаас хойш 3 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан мөнгөн хөрөнгө зэрэг багтана.

В. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө ба банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийг эзэмшиж, захиран зарцуулах эрх банкинд үүссэн нөхцөлд хүлээн зөвшөөрнө.

Г. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр бүртгэнэ.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг тайлагналын өдөр хорогдуулсан өртгөөр үнэлж тусгана. Иймд энэхүү хөрөнгөтэй холбоотой хуримтлуулан тооцсон хүүгийн авлагыг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн дансны дүнд оруулж, санхүүгийн тайланд толилуулна.

Төгрөгөөр байршуулсан мөнгөн хөрөнгийн бодит үнэ цэн нь нэрлэсэн үнэ юм.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг Монголбанкны албан ханшаар тооцон төгрөгт хөрвүүлэн хүлээн зөвшөөрөх ба төгрөг, валютаар давхар бүртгэнэ. Тайлагналын өдөр гадаад валютыг тухайн өдрийн албан ханшаар дахин үнэлэх ба ханшийн тэгшитгэлээр үүссэн зөрүүг тайлант хугацааны орлого, зардлаар хүлээн зөвшөөрнө.

Мөнгөн хөрөнгийг тодорхой хугацаатай, жишиг үнэгүй, дериватив бус авлага гэж үзээд бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан бол банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөнд бүртгэнэ. Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр бүртгэх ба тайлагналын өдөр хорогдуулсан өртгөөр үнэлж тусгана. Иймд энэхүү хөрөнгөтэй холбоотой хуримтлуулан тооцсон хүүгийн авлагыг Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн дансны дүнд оруулан толилуулна.

Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийг үнэлэхдээ мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн нэгэн адил зарчмыг мөрдөнө. Хугацаа хэтэрсэн буюу үнэ цэн буурсан санхүүгийн хэрэгсэл нь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн тодорхойлолтонд нийцэхгүй тул үүнийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөөс хасаж, холбогдох ангилалд (хөрөнгө оруулалт, зээл гэх мэт) шилжүүлэн бүртгэнэ. Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн үнэ цэн буурсан тохиолдолд банк эрсдэлийн сан байгуулна. Эрсдэлийн санг байгуулахтай холбоотой дэлгэрэнгүй аргачлалыг “Зээл” бүлгээс үзнэ үү.

Д. БҮРТГЭЛ

1) Бэлэн мөнгө

Бэлэн мөнгө дараах зүйлсээс бүрдэнэ. Үүнд:

- *Касс дахь бэлэн мөнгө:* Үндэсний болон гадаадын цаасан мөнгөн тэмдэгт, зоос, бутархай мөнгө.
- *Чек:* Дотоодын чек, гадаадын чек (замын чек, нэрийн чек, бэлэглэлийн чек гэх мэт), төлүүлэхээр явуулсан чек.
- *Замд яваа мөнгө:* Банк болон салбар хооронд бэлэн мөнгийг шилжүүлэх хугацаанд түр бүртгэсэн бэлэн мөнгө.
- *Тоолж шалгаагүй мөнгө*: Тоолох тасагт байгаа, хараахан тоолж баталгаажуулаагүй түр бүртгэсэн бэлэн мөнгө.
- *АТМ дахь мөнгө:* Автомат бэлэн мөнгөний машин дахь бэлэн мөнгө.

Бэлэн мөнгөний орлого, зарлагын гүйлгээ

Харилцагч бэлэн мөнгөний орлогын гүйлгээ хийхэд

Дебит: Бэлэн мөнгө
Кредит: Харилцагчийн харилцах данс

Харилцагч бэлэн мөнгөний зарлагын гүйлгээ хийхэд

Дебит: Харилцагчийн харилцах данс
Кредит: Бэлэн мөнгө

Кассын илүүдэл, дутагдал

Бэлэн мөнгөний үлдэгдэл нь бүртгэгдсэн дүнгээс их байвал

Дебит: Бэлэн мөнгө
Кредит: Бэлэн мөнгөний илүүдэл, дутагдлын түр данс

Банк бэлэн мөнгөний илүүдлийн шалтгааныг тогтоож, эзэн тодорхойгүй бол бусад орлого, тодорхой эзэнтэй бол буцаан олгохоор бүртгэнэ.

Дебит: Бэлэн мөнгөний илүүдэл, дутагдлын түр данс
Кредит: Холбогдох данс, Жишээ нь: Бусад орлого, Бэлэн мөнгө

Бэлэн мөнгөний үлдэгдэл нь бүртгэгдсэн дүнгээс бага байвал

Дебит: Бэлэн мөнгөний илүүдэл, дутагдлын түр данс
Кредит: Бэлэн мөнгө

Банк бэлэн мөнгөний дутагдлын шалтгааныг тогтоож, эзэн тодорхойгүй бол бусад зардалд, харин тодорхой эзэнтэй бол төлүүлэхээр тус тус бүртгэнэ.

Дебит: Холбогдох данс, Жишээ нь: Бусад зардал, Бэлэн мөнгө, Бусдаас авах авлага
Кредит: Бэлэн мөнгөний илүүдэл, дутагдлын түр данс

Тоолж шалгаагүй мөнгө

Харилцагчаас тушаасан мөнгийг тоолж баталгаажуулах хүртэл “Тоолж шалгаагүй мөнгө” дансанд бүртгэнэ. Тоолж шалгаагүй мөнгөний данс нь богино хугацаанд хаагдаж байх данс юм.

Харилцагч мөнгө тушаах үед дагалдах баримтанд тусгасан дүнгээр

Дебит: Тоолж шалгаагүй мөнгө
Кредит: Харилцагчийн харилцах данс

Тухайн бэлэн мөнгийг тоолсны дараа кассад шилжүүлж, тэр дүнгээр

Дебит: Бэлэн мөнгө
Кредит: Тоолж шалгаагүй мөнгө

Хэрэв бэлэн мөнгийг тоолж, шалгах үед дутвал дутагдсан дүнгээр

Дебит: Харилцагчийн харилцах данс
Кредит: Тоолж шалгаагүй мөнгө

Хэрэв бэлэн мөнгийг тоолж, шалгах үед ямар нэгэн илүүдэл гарвал илүүдсэн дүнгээр

Дебит: Тоолж шалгаагүй мөнгө
Кредит: Харилцагчийн харилцах данс

Замд яваа мөнгө

Банкны нэгж өөрийн төв рүүгээ бэлэн мөнгө тушаавал

i) Банкны нэгж нь:

Мөнгө хүргүүлэхдээ

Дебит: Замд яваа мөнгө
Кредит: Бэлэн мөнгө

Банкны төвөөс ирүүлсэн бэлэн мөнгө хүлээн авсан баримтыг үндэслэн

Дебит: Салбар хоорондын тооцооны авлага
Кредит: Замд яваа мөнгө

ii) Банкны төв нь:

Дебит: Бэлэн мөнгө
Кредит: Салбар хоорондын тооцооны өглөг

Банкны төв нь нэгждээ бэлэн мөнгөний зузаатгал хийхэд

i) Банкны төв нь:
Банкны төв мөнгө хүргүүлэхдээ

Дебит: Замд яваа мөнгө
Кредит: Бэлэн мөнгө

Банкны нэгжээс ирүүлсэн бэлэн мөнгө хүлээн авсан баримтыг үндэслэн

Дебит: Салбар хоорондын тооцооны авлага
Кредит: Замд яваа мөнгө

ii) Банкны нэгж хүргүүлсэн бэлэн мөнгийг хүлээн авахдаа

Дебит: Бэлэн мөнгө
Кредит: Салбар хоорондын тооцооны өглөг

Банк хоорондын тооцоогоор бэлэн мөнгөний зузаатгал хийх үед дээрхтэй нэгэн адил банк хоорондын тооцооны өглөг, авлагын дансанд бүртгэнэ.

2) Чек

Банк бэлэн гадаад валютын чекийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс худалдан авсан бол

Дебит: Гадаад валютын чек
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс /чекийн үндсэн дүнгээр/
Кредит: Хураамж, шимтгэлийн орлого /шимтгэлийн дүнгээр/

Гадаад валютын чекийг төлүүлэхээр явуулахад

Дебит: Инкасст яваа чек
Кредит: Гадаад валютын чек

Гадаадын банкнаас ирүүлсэн мэдэгдлийн дүнгээр

Дебит: Гадаадын банкин дахь харилцах
Кредит: Инкасст яваа чек

3) Монголбанкинд байршуулсан мөнгө

Монголбанкинд байршуулсан мөнгөнд Монголбанкинд байршуулсан төгрөг, гадаад валютын харилцах, хадгаламжийн данснууд багтана. Доор харуулсан дансны харилцаанууд нь “Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө” ба “Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө” гэж ангилсан хөрөнгөний аль алинд нь хамаарна.

Банк Монголбанк дахь өөрийн харилцах, эсвэл хадгаламжийн дансандаа бэлэн мөнгө тушаавал

Дебит: Монголбанк дахь харилцах, хадгаламж
Кредит: Бэлэн мөнгө

Хэрэв банкнаас Монголбанкинд тушаасан мөнгөнд ямар нэгэн дутагдал байсныг тухайн банкинд Монголбанкнаас мэдэгдвэл

Дебит: Бэлэн мөнгөний илүүдэл, дутагдал
Кредит: Монголбанк дахь харилцах данс

Хэрэв банкаас Монголбанкинд тушаасан мөнгөнд ямар нэгэн илүүдэл байсныг тухайн банкинд Монголбанкнаас мэдэгдвэл

Дебит: Монголбанк дахь харилцах данс
Кредит: Бэлэн мөнгөний илүүдэл, дутагдал

Бэлэн мөнгөний илүүдэл, дутагдал дансны үлдэгдлийг тохирох дансанд хаана. Тухайлбал, илүүдэл, дутагдлын шалтгаан тогтоогдохгүй бол үүнийг үйл ажиллагааны бус бусад орлого, эсвэл бусад зардал дансанд хаана.

Монголбанк тухайн банкны харилцах, эсвэл хадгаламжийн дансанд хүү тооцож, төлсөн бол

Дебит: Харилцах буюу хадгаламжийн холбогдох данс
Кредит: Хүүгийн орлогын данс

Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц дансыг санхүүгийн тайлагналын зорилгоор ашиглана.

4) Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө

Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөнд дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан төгрөг, гадаад валютын харилцах, хадгаламж багтана.

Банк, санхүүгийн байгууллагад харилцах, хадгаламжийн данс нээхдээ тухайн банктай байгуулсан гэрээ, хэлцэл, удирдлагын шийдвэрийг үндэслэнэ.

Банк нь банк, санхүүгийн байгууллагад харилцах, хадгаламж байршуулахад

Дебит: Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Эдгээр дансдад хүү тооцоолж, хуримтлуулахад

Дебит: Хүүгийн авлагын холбогдох данс
Кредит: Хүүгийн орлогын холбогдох данс

Хуримтлуулсан хүү төлөгдөхөд

Дебит: Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө
Кредит: Хүүгийн авлагын холбогдох данс

Банк харилцах, хадгаламжаас бэлэн мөнгө зарлагадах буюу дансаа хаахад

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө

5) Овернайт зээл

Банк, санхүүгийн байгууллагад овернайт зээл олгоход

Дебит: Овернайт зээл
Кредит: Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө

Овернайт зээлийг төлүүлэхэд

Дебит: Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө
Кредит: Овернайт зээл

Овернайт зээлийн хүүг хуримтлуулахад

Дебит: Хүүгийн авлагын холбогдох данс
Кредит: Хүүгийн орлогын холбогдох данс

Хуримтлуулсан хүү төлөгдөхөд

Дебит: Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө
Кредит: Хүүгийн авлагын холбогдох данс

6) Гадаад валютын спот арилжаа

Гадаад валютын спот арилжаа нь гадаад валютыг худалдах, худалдан авах арилжааг ажлын хоёр өдөрт багтаан гүйцэтгэх хэлцэл юм. Доорх дансдын харилцааг спот арилжааны төлбөр тооцоо хийгдэх өдрөөр хийнэ.

Төлбөр хараахан хийгдээгүй боловч арилжаа хийгдсэн (өөрөөр хэлбэл, зөвхөн хэлцэл хийгдсэн) тохиолдолд уг арилжааг төлбөр хийгдэх хүртэл тэнцлийн гадуурх дансанд бүртгэнэ.

Гадаад валют худалдан авах

Худалдан авсан гадаад валютын хувьд албан ханшаар

Дебит: Гадаад валютын холбогдох данс
Кредит: Гадаад валютын хөрвүүлэлтийн түр данс

Худалдан авах ханшаар холбогдох мөнгөн хөрөнгийн дансыг бууруулна.

Дебит: Гадаад валютын хөрвүүлэлтийн түр данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Валютын хөрвүүлэлтийн дансыг орлого, зардлын дансанд хаана.

Ашигтай бол

Дебит: Гадаад валютын хөрвүүлэлтийн түр данс
Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Алдагдалтай бол

Дебит: Гадаад валютын арилжааны зардал
Кредит: Гадаад валютын хөрвүүлэлтийн түр данс

Гадаад валют худалдах

Гадаад валютыг худалдахдаа хэлцлийн ханшаар

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Гадаад валютын хөрвүүлэлтийн түр данс

Гадаад валютаа дансны үнээр нь (Монголбанкнаас зарласан ханшаар)

Дебит: Гадаад валютын хөрвүүлэлтийн түр данс
Кредит: Гадаад валютын холбогдох данс

Ашигтай үед

Дебит: Гадаад валютын хөрвүүлэлтийн түр данс
Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Алдагдалтай үед

Дебит: Гадаад валютын арилжааны зардал
Кредит: Гадаад валютын хөрвүүлэлтийн түр данс

Санхүүгийн тайланд гадаад валютын арилжааны орлого, зардлыг хооронд нь хааж цэвэршүүлэн, орлого эсвэл зардлаар толилуулна.

7) Гадаад валютын ханшийн тэгшитгэл

Гадаад валютыг Монголбанкнаас зарласан албан ханшаар үнэлж, ханшийн зөрүүг тайлант хугацааны орлого, зардлаар хүлээн зөвшөөрнө.

Ханшийн тэгшитгэлээр гадаад валютын ханш буурсан бол

Дебит: Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал
Кредит: Гадаад валютын холбогдох данс

Ханшийн тэгшитгэлээр гадаад валютын ханш өссөн бол

Дебит: Гадаад валютын холбогдох данс
Кредит: Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого

Санхүүгийн тайланд гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого, зардлыг хооронд нь хааж цэвэршүүлэн, орлого эсвэл зардлаар толилуулна.

Е. ТОДРУУЛГА

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэлд гарсан өөрчлөлтийг тайлбарын хамт тодруулна. Тайлбараа мөнгөн гүйлгээний тайлангийн үзүүлэлтүүдийг хамруулан хийж болно.

Тайлагналын өдрөөрх гадаад валютын ханшийг тодруулна.

Банкны эзэмшилд байгаа боловч банк өөрөө ашиглах боломжгүй, хязгаарлагдмал хөрөнгийг тодруулна.

СТОУС 7-д заасан тодруулгад холбогдох үнэлгээний аргачлалыг ашиглан банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн үнэ цэн бууралтыг тодруулна. Үнэлгээний аргачлалаар үнэ цэнийн бууралтыг тогтоох боломжгүй тохиолдолд хөрөнгийн чанарын талаар тодруулж, тайлбарлаж болно.

Санхүүгийн тайлангийн тодруулгад багтах бусад тодруулгыг санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх аргачлал (Хавсралт 4)-аас үзнэ үү.

Ё. ХЯНАЛТ

- Ажилтнуудын ажил үүргийг зааглан тусгаарлана.
- Гүйлгээний баримтын бүрдлийг хангана.
- Бэлэн мөнгө, валютын кассын дэлгэрэнгүй бүртгэлийг хөтөлнө.
- Дэлгэрэнгүй бүртгэлийг хяналтын дансны гүйлгээ, үлдэгдэлтэй тохируулна.
- Кассын харуул хамгаалалт, аюулгүй байдлыг хангана.
- Кассын үлдэгдэлд гэнэтийн болон тогтмол шалгалт хийнэ.

4.2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

4.2.1. ҮНЭТ ЦААС

А. ШУУД ХОЛБОГДОХ СТАНДАРТУУД

- СТОУС 7 Санхүүгийн хэрэгсэл: Тодруулга
- СТОУС 9 Санхүүгийн хэрэгсэл (хараахан мөрдөгдөж эхлээгүй байгаа)
- СТОУС 13 Бодит үнэ цэнийн хэмжилт
- НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- НББОУС 32 Санхүүгийн хэрэгсэл: Толилуулга
- НББОУС 36 Хөрөнгийн үнэ цэнийн бууралт
- НББОУС 39 Санхүүгийн хэрэгсэл: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Б. ТОДОРХОЙЛОЛТ

Үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт нь санхүүгийн хэрэгслийн нэг төрөл тул НББОУС 32-т тодорхойлсон санхүүгийн хөрөнгийн тодорхойлолтонд хамаарна.

Үнэт цаасыг “Арилжааны буюу ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх”, “Хугацааны эцэс хүртэл эзэмших”, “Борлуулахад бэлэн”, “Зээл ба авлага гэж ангилсан үнэт цаас” гэж дөрөв ангилна.

“Арилжааны буюу ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх” (цаашид “арилжааны үнэт цаас” гэх) ангилалд 1) арилжааны (trading) ба 2) ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх сонголтыг ашиглан бүртгэсэн (under the fair value option) үнэт цаасыг хамруулан бүртгэнэ.

Ашиг олох зорилгоор худалдан аваад, богино хугацаанд эргүүлэн худалдах зориулалттай үнэт цаасыг “*арилжааны үнэт цаас (trading)*” гэж ангилна. Өөрөөр хэлбэл, арилжааны үнэт цаас гэж үнийн өөрчлөлтөөс ашиг хүртэх буюу маржин авах зорилгоор эзэмшиж буй өрийн ба өмчлөлийн үнэт цаас, эсвэл богино хугацаатай багцад багтсан үнэт цаасыг хэлнэ. Худалдан авснаас хойш 6 хүртэлх сарын хугацаанд буюу харьцангуй богино хугацаагаар эзэмшээд, эргүүлэн худалдах зорилготой үнэт цаасыг арилжааны гэж ангилна.

Арилжааны үнэт цаасны ангилалд *“ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаас (under the fair value option)”-ыг* бүртгэх бөгөөд энэ төрлийн үнэт цаасны ангилал нь өөрчлөгдөхгүй. Дараах тохиолдолд банкны удирдлага үнэт цаасыг энэ ангилалд бүртгэнэ: (а) үнэт цаасыг холбогдох хөрөнгө,

өр төлбөрийн бүртгэлийн нийцлийг *(accounting matching)* хангах үүднээс энэ ангилалд бүртгэсэн үед; эсвэл (б) санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг нийцүүлэн удирдаж, бодит үнэ цэнээр үнэлсэн.

Тодорхой, тогтмол төлбөрийн хуваарьтай, тогтсон хугацаанд дуусгавар болох үнэт цаасыг хугацааг нь дуустал эзэмшихээр шийдвэрлэсэн бол "*Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас*" гэж ангилна. Хэрэв банк үнэт цаасыг дуусгавар хугацаанаас нь өмнө эргүүлэн төлөх буюу худалдан авахыг үнэт цаас гаргагчаас шаардах эрхтэй тохиолдолд уг хөрөнгийг хугацааны эцэс хүртэл эзэмших шинж алдагдаж байна гэж үзэх тул энэ ангилалд бүртгэхгүй. Хувьцаа, түүнтэй адилтгах өмчийн хэрэгсэл болон дуусгавар хугацаа нь тодорхойгүй үнэт цаасыг энэ ангилалд бүртгэхгүй.

Банк "Хугацааны эцэс хүртэл эзэмших" гэж ангилсан үнэт цаасыг хугацааг нь дуустал эзэмшилгүйгээр харин зориулалтыг нь өөрчилж, бусдад худалдан борлуулах буюу шилжүүлсэн бол "уг ангиллыг цаашид ашиглах эрхгүй" болно. Өөрөөр хэлбэл, ийм арилжаа хийгдсэн тайлант үеэс хойш хоёроос доошгүй жил ямарваа үнэт цаасыг "Хугацааны эцэс хүртэл эзэмших" ангиллаар ангилах эрхгүй болно.

"Зээл ба авлага гэж ангилсан үнэт цаас" гэдэг нь идэвхтэй зах зээлийн жишиг үнэгүй (өөрөөр хэлбэл өрийн хэрэгсэл) бөгөөд тодорхой мөнгөн дүн бүхий дериватив бус санхүүгийн хөрөнгийг хэлэх ба үүнд дараах хөрөнгийг хамруулахгүй:

а) Арилжаалах зориулалттай эзэмшиж буй гэж ангилсан шууд, эсвэл ойрын хугацаанд худалдан борлуулах зорилготой хөрөнгө, анх удаа хүлээн зөвшөөрөхдөө ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэхээр ангилсан хөрөнгө;

б) Анх удаа хүлээн зөвшөөрөхдөө борлуулахад бэлэн гэж ангилсан хөрөнгө;

в) Эзэмшигч нь хөрөнгийн чанар муудсанаас бусад тохиолдолд өөрийн анх оруулсан хөрөнгөө бүгдийг нь эргүүлэн олж авч чадахгүй болсон (үүнийг борлуулах зориулалттай хөрөнгөнд ангилна).

Хувьцаа, түүнтэй адилтгах өмчийн хэрэгсэл болон дуусгавар хугацаа нь тодорхойгүй үнэт цаас энэ ангилалд багтахгүй.

Дээрх гурван ангилалд багтаагүй үнэт цаасыг "*борлуулахад бэлэн үнэт цаас*"-аар ангилна. Энэ ангилалд тодорхойгүй хугацаагаар банкны эзэмшиж буй хүү, валютын ханш, өөрийн хөрөнгийн үнэлгээ өөрчлөгдөхөд эргүүлэн худалдаж болох үнэт цаас багтана. Энэ ангилалд өрийн үнэт цаас (бонд гэх мэт) ба өмчлөлийн үнэт цаас (хувьцаа гэх мэт) -ыг хамруулна.

Мөн түүнчлэн үнэт цаасыг хугацаагаар нь 3 хүртэлх сарын хугацаатай, 3-12 сарын хугацаатай, 1-5 жилийн хугацаатай, 5-аас дээш жилийн хугацаатай гэж ангилж толилуулна.

Банк үнэт цаасны ангиллыг өөрчилсөн болон ийнхүү өөрчилсөн учир шалтгааныг Монголбанкинд мэдэгдэнэ.

В. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

Банк үнэт цаасыг эзэмших эрх үүссэн болон гэрээний нэг тал болсон үед санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрч толилуулна.

Банк бодитой нотолгоо бүрдүүлсний үндсэн дээр үнэт цаасыг тохирох ангиллаар ангилж бүртгэнэ. Тухайлбал, арилжааны үнэт цаасны хувьд үнэт цаасыг богино хугацаанд эзэмшиж, ашиг олохыг харуулсан нотолгоо баримт, хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаасны хувьд хугацааг нь дуустал эзэмших нотолгоо баримт гэх мэт.

Үнэт цаасны хугацаа дуусч, үнэт цаас гаргагч төлбөрөө бүрэн төлсөн, эсвэл үнэт цаасанд хамаарах бүх эрсдэл, өгөөж бусдад шилжсэн үед хөрөнгө оруулалтыг данснаас хасна. Банк санхүүгийн хөрөнгийг шилжүүлсэн нөхцөлд тухайн санхүүгийн хөрөнгийн өмчлөлтэй холбоотойгоор үлдсэн эрсдэл, өгөөжийг харгалзан хөрөнгийн үнэлгээг хийнэ. Энэ тохиолдолд:

а) Хэрэв банк санхүүгийн хөрөнгийн өмчлөлтэй холбоотой бүх эрсдэл, өгөөжийг шилжүүлсэн бол санхүүгийн хөрөнгийг данснаас хасч, үүний үр дүнд үлдсэн эрх, үүргийг хөрөнгө, өр төлбөрөөр хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

б) Хэрэв банк санхүүгийн хөрөнгийн өмчлөлтэй холбоотой бүх эрсдэл, өгөөжийг өөртөө үлдээсэн бол уг санхүүгийн хөрөнгийг хэвээр үлдээж, данснаас хасахгүй.

в) Хэрэв банк санхүүгийн хөрөнгийн өмчлөлтэй холбоотой бүх эрсдэл, өгөөжийг бүрэн шилжүүлээгүй бол уг санхүүгийн хөрөнгийн зарим хэсгийг өөртөө үлдээж, үлдсэн хэсгийг нь данснаас хасч бүртгэнэ. Өөрт үлдээх хэсгийг дараах байдлаар тогтооно:

(i) Хэрэв банк хяналтыг өөртөө үлдээгээгүй бол уг санхүүгийн хөрөнгийг данснаас хасна.

(ii) Хэрэв банк хяналтыг өөртөө үлдээсэн бол уг санхүүгийн хөрөнгөөс хяналтын хувь хэмжээгээр тооцоолсон өөрт харгалзах хэсгийг бүртгэлдээ үлдээнэ.

Хэрэв банк бүртгэлийн энэхүү зааврын дагуу арилжааны үнэт цаасыг данснаас хасч шилжүүлэх шалгуурыг хангаж байгаа эсэхийг нь тогтоох боломжгүй тохиолдолд дэлгэрэнгүй үнэлгээ, шинжилгээг гүйцэтгэнэ.

Г. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

Үнэт цаасны үнэлгээ нь түүний ангиллаас шалтгаалах тул эхлээд үнэт цаасны ангиллыг тодорхойлно.

Үнэт цаасыг дөрвөн ангиллын аль нэгээр ангилж бүртгэнэ. Санхүүгийн хөрөнгийг анхны удаад хүлээн зөвшөөрсний дараа түүний ангиллаас тайлагналын өдрөөр хийгдэх үнэлгээ, холбогдох орлого, зардлыг хэрхэн бүртгэх нь хамаарна.

Үнэт цаасны бодит үнэ цэн гэж тухайн өдрийн идэвхтэй зах зээлийн жишиг үнийг ойлгоно. Өөрөөр хэлбэл, олон улсын болон дотоодын зах зээл дээр идэвхтэй арилжаалж буй үнэт цаасны үнэ нь бодит үнэ цэн юм. Хэрэв үнэт цаасны зах зээл идэвхтэй биш бол үнэлгээний аргыг ашиглан бодит үнэ цэнийг тогтооно. Тухайлбал, дискаунтчилсан мөнгөн гүйлгээний шинжилгээ, опционы үнийн загвар гэх мэт тухайн төрлийн үнэт цаасанд түгээмэл ашиглагддаг аргачлалыг сонгон, бодит үнэ цэнийг тодорхойлно. Банк үнэт цаасны бодит үнэ цэнийг тооцоолох аргачлалаа өөрийн дотоод журмаар тогтоож мөрдөнө.

Худалдаад эргүүлэн авах гэрээ ба үнэт цаасыг барьцаалан зээл олгох хэлцэл зэргийг зохих ёсоор ангилж бүртгэхийн тулд дэлгэрэнгүй шинжилгээ хийнэ. Худалдаад эргүүлэн авах гэрээ (репо) нь өгөөжийг талуудад ашигтайгаар хуваарилдаг бөгөөд эрсдэлгүй санхүүгийн арилжаа юм. Ийм нөхцөлөөр худалдсан үнэт цаасыг данснаас хасч бүртгэхгүй. Уг үнэт цаасыг худалдах, эсвэл барьцаалах эрх банкинд үлдэж, үүнийг зохицуулсан журам байгаа тохиолдолд үнэт цаасны ангиллыг өөрчилж, барьцаанд тавьсан хөрөнгө оруулалт, үнэт цаасаар ангилах ба дээр дурдсан эрх банкинд үүсээгүй тохиолдолд уг ангиллыг ашиглахгүй. Холбогдох өр төлбөрийг “Бусад эх үүсвэр”-ийн “Буцаан худалдан авах нөхцөлөөр худалдсан үнэт цаас (репо)” дансанд бүртгэж толилуулна.

Буцаан худалдах нөхцөлөөр худалдан авсан үнэт цаас (урвуу репо) нь өгөөжийг талуудад ашигтайгаар хуваарилдаг бөгөөд талуудын хүлээж буй эрсдэл, дуусгавар болох хугацаа (өөрөөр хэлбэл, эх үүсвэрийг банк, түүний харилцагчийн аль нь татаж байгаа болон уг гэрээний хугацаа 3 хүртэлх сар, эсвэл 3 сараас дээш хугацаатай эсэх) зэргийг харгалзан “Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө”, “Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө”, “Зээл” -д бүртгэнэ.

<u>1) Арилжааны үнэт цаас буюу ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаас</u>

Арилжааны үнэт цаас буюу ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаасыг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр үнэлнэ. Энэ нь тухайн үнэт цаасыг худалдан авахад төлсөн мөнгөн дүн юм.

Энэ ангиллын үнэт цаасыг сар бүрийн эцэст бодит үнэ цэнээр нь дахин үнэлэх ба бодит үнэ цэнд гарсан өсөлт, бууралтыг үнэлгээний тэгшитгэлийн орлого, зардалд бүртгэнэ. Үр ашигт хүүгийн аргыг ашиглан арилжааны үнэт цааснаас тооцсон хүүг тухайн тайлант хугацааны орлогоор хүлээн зөвшөөрнө.

Ногдол ашиг авах эрх банкинд үүсч, авах магадлалтай гэж үзвэл ногдол ашгийн орлогод бүртгэнэ.

Энэ ангиллын хөрөнгийг данснаас хасах үед үүсэх арилжааны орлого, зардал болон хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тухайн тайлант хугацааны орлого, зардалд бүртгэнэ.

Энэ бүлгийн бүртгэлийн хэсэгт заасны дагуу хөрөнгийн үнэлгээтэй холбоотой хэрэгжээгүй орлого, зардлыг арилжааны буюу хэрэгжсэн орлого, зардлаас салгаж бүртгэнэ.

Банкны удирдлагын шийдвэрт үндэслэн арилжааны үнэт цаасны зориулалтыг өөрчилж, бусад ангилалд шилжүүлж болно. Банк үнэт цаасны ангиллыг өөрчлөхдөө арилжааны үнэт цаасыг тухайн өдрийн бодит үнэ цэнээр үнэлж бүртгэнэ. Өмнө нь хүлээн зөвшөөрч бүртгэсэн орлого, зардлыг хуримтлуулах буюу буцаах бичилт хийхгүй.

Үнэт цаасыг арилжааны үнэт цааснаас бусад ангилалд шилжүүлэх тохиолдолд дараах зарчмыг баримтлана:

- Хэрэв үнэт цаасны ангиллыг өөрчлөх гэж буй өдөр уг үнэт цаас зээл ба авлагын тодорхойлолтонд нийцэж байгаа бөгөөд банк тухайн өдөр уг хөрөнгийг ойрын хугацаанд худалдахгүй, эсвэл уг үнэт цаасны хугацааны эцэс хүртэл эзэмших зорилготой байгаа бол зээл ба авлага ангиллын үнэт цаасаар бүртгэнэ.

- Үнэт цаасыг арилжаалдаг зах зээл идэвхтэй, эсвэл уг үнэт цаас нь зээл ба авлага болохгүй хөрөнгийн багцад (тухайлбал, хөрөнгө оруулалтын сан) багтдаг тохиолдолд банк уг үнэт цаасыг зээл ба авлагаар ангилахгүй.
- Зээл, авлагын тодорхойлолтонд нийцэхгүй бусад санхүүгийн хөрөнгийн хувьд ойрын хугацаанд худалдах буюу буцаан худалдаж авах зорилгоор эзэмшээгүй (ховор тохиолддог) нөхцөлд хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаасаар ангилна. Ховор тохиолдол гэдгийг "ойрын хугацаанд дахин давтагдах магадлал тун бага, байнгын бус нэг удаагийн үйл явдал" хэмээн ойлгоно. Жишээлбэл, 2008 оны гуравдугаар улиралд тохиолдсон дэлхийн санхүүгийн зах зээлийн хямралын улмаас ангиллыг өөрчилж болзошгүй нөхцөл байдал үүссэн нь ховор тохиолдол болно.

Арилжааны үнэт цаас (мөн ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаас) -ны бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тухай бүр орлого, зардалд бүртгэн тайлагнаж байдаг тул үнэ цэнийн бууралтыг тусгайлан тооцохгүй.

<u>2) Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас</u>

Хугацааны эцэс хүртэл эзэмшихээр ангилсан үнэт цаасыг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэн дээр холбогдох шууд зардлыг нэмсэн дүнгээр бүртгэнэ.

Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаасыг санхүүгийн тайланд хорогдуулсан өртгөөр үнэлж толилуулна.

Үнэт цаасны хорогдуулсан өртгийг тооцохдоо анх хүлээн зөвшөөрсөн үнээс үндсэн төлбөрийн төлөлтийг хасч, үр ашигт хүүгийн аргаар тооцоолсон урамшууллын хорогдуулалтыг хасах, эсвэл хямдруулалтын хорогдуулалтыг нэмнэ. Үнэт цаасны хорогдуулсан өртөгт уг үнэт цаасанд хуримтлуулан тооцсон хүүгийн авлага мөн багтана.

Үр ашигт хүүгийн аргаар үнэт цаасны урамшуулал, хямдруулалтын хорогдуулалтыг тооцоолохдоо анхны үнээс тооцсон үр ашигт хүүгээс хүүгийн төлбөрийг хасна. Урамшуулал, хямдруулалтаас тайлант хугацаанд ногдох хорогдуулсан дүнг хүүгийн орлогод бүртгэнэ.

Хугацааны эцэс хүртэл эзэмшихээр ангилсан үнэт цаасны ангиллыг тусгайлан заасан нөхцөл байдлаас бусад тохиолдолд өөрчлөхийг хориглоно. Дараах шаардлагыг хангасан тохиолдолд ангиллыг өөрчилж болно:

- Үнэт цаасны дуусгавар хугацаа буюу буцаан худалдан авах өдөр ойртсон (жишээлбэл, үнэт цаасны хугацаа дуусахад 3 сараас бага хугацаа үлдсэн) ба хүүгийн түвшинд гарах өөрчлөлт нь тухайн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхгүй;
- Төлөвлөгөөт буюу урьдчилсан байдлаар тухайн санхүүгийн хөрөнгийн үлдэгдэл бараг төлөгдсөн; эсвэл
- Банкнаас шалтгаалаагүй хүчин зүйл нөлөөлсөн, тохиолдохоор хүлээгдээгүй, дахин давтагдахгүй үйл явдал тохиолдсон.

Үнэт цаасыг анх хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаасаар ангилах үед төлөвлөгдөөгүй нөхцөл байдал үүссэн бол бусад үнэт цаасыг хугацааны эцэс хүртэл эзэмшихтэй холбоотой удирдлагын зорилгыг өөрчлөлгүйгээр энэ үнэт цаасыг худалдаж болно. Тухайлбал:

- Үнэт цаас гаргагчийн санхүүгийн чадвар мэдэгдэхүйц хэмжээгээр муудсан
- Татварын хуульд нэмэлт, өөрчлөлт орсон
- Компанийн нэгдэл үүссэн, эсвэл хуваагдсан
- Холбогдох хууль тогтоомжинд нэмэлт, өөрчлөлт гарсан.

Банк хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаасны ангиллыг өөрчлөхдөө үнэт цаасыг бодит үнэ цэнээр нь үнэлж, борлуулахад бэлэн үнэт цаасанд ангилж бүртгэнэ. Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаасыг борлуулахад бэлэн ангиллаас бусад ангилалд шилжүүлж болохгүй.

Ийнхүү ангиллыг өөрчлөх болон хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаасыг хугацаанаас нь өмнө худалдах үед банкны удирдлагын зорилго болон багцын бүтцийг өөрчлөх болдог. Иймд дээр тайлбарласан зөвшөөрөгдсөн нөхцөлөөс бусад тохиолдолд хугацааны эцэс хүртэл эзэмших хөрөнгө оруулалтыг мэдэгдэхүйц их дүнгээр худалдан борлуулах, эсвэл ангиллыг нь өөрчлөх үед хугацааны эцэс хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын дансанд үлдсэн бусад үнэт цаасны ангиллыг өөрчилж, борлуулахад бэлэн ангилалд шилжүүлнэ. Энэ тохиолдолд үнэт цаасыг бодит үнэ цэнээр нь үнэлж, үүссэн үнэлгээний зөрүүг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэнэ.

Мөн хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаасыг худалдан борлуулсан бол үнэт цаасны хугацааг

дуусахаас өмнө уг арилжааг хийсэн талаар болон уг арилжааны улмаас энэ ангиллыг дахин ашиглах эрхгүй болсон эсэх талаар Монголбанкинд мэдэгдэнэ. Ингэхдээ НББОУС 39 болон энэхүү зааврыг мөрдөх ба ангиллыг ашиглах нөхцөл байдалд учир шалтгааныг нарийвчлан тайлбарлана.

Банк Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан "Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ын дагуу үнэт цаасны эрсдэлийн сан байгуулна. Үүний зэрэгцээ банк СТОУС-д нийцүүлэн үнэт цаасны эрсдэлийн сан байгуулж болно. СТОУС-д нийцүүлэн эрсдэлийн санг хэрхэн байгуулж бүртгэх талаар "Зөөл" бүлгээс үзнэ үү.

Жишээ: Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаасны үнэ цэнийн бууралт

Банк уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг компанийн 100 сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 10%-ийн нэрлэсэн хүүтэй, 5 жилийн хугацаатай бонд худалдан авсан. Хүүг жилд нэг удаа төлөх ба үндсэн төлбөр (нэрлэсэн дүн) -ийг бондын хугацааны эцэст барагдуулна. Уг бондыг нэрлэсэн үнээр нь худалдан аваад, удирдлагын шийдвэрээр хугацааны эцэс хүртэл эзэмших гэж ангилсан. Үр ашигт хүүгийн түвшин нь нэрлэсэн хүүгийн хувьтай адил 10%.

Төлбөрийн хуваарь дараах байдалтай байна:

20X1 оны 1 дүгээр сарын 1	Төлсөн мөнгө	-100
20X1 оны 12 дугаар сарын 31	Хүү төлөлт	10
20X2 оны 12 дугаар сарын 31	Хүү төлөлт	10
20X3 оны 12 дугаар сарын 31	Хүү төлөлт	10
20X4 оны 12 дугаар сарын 31	Хүү төлөлт	10
20X5 оны 12 дугаар сарын 31	Хүү ба нэрлэсэн үнийн эргэн төлөлт	110

Бондын хөрөнгө оруулалтыг анхны удаад төлсөн мөнгөний дүнгээр буюу 100 сая төгрөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Эхний жилийн төгсгөлд хуримтлуулан тооцсон хүүгийн авлагын 10 сая төгрөг төлөгдөх ба уг хөрөнгө оруулалтын хорогдуулсан өртөг нь 100 сая болно (100 + хуримтлуулан тооцсон хүүгийн авлага 10 - төлөгдсөн хүү 10 = 100 сая). Үүнтэй яг ижил тооцооллыг дараагийн 2 жилд гүйцэтгэнэ.

4 дэх жилд зээлдэгчийн үйл ажиллагаагаа явуулдаг салбарт бүтцийн өөрчлөлт хийгдсэний улмаас бонд гаргагч санхүүгийн хүндрэлд орох нь гарцаагүй болж, энэ нь бонд гаргагчийн хүлээсэн алдагдал болон төлбөрийн чадварын хүндрэлээр нотлогдож байгаа юм. Банк энэхүү бодит нотолгоонд үндэслэн үлдсэн хугацааны хүү болон (бондын хугацаа дуусах үед) нэрлэсэн үнийн төлбөрийг тус компани барагдуулах боломжгүй гэж үзсэн. Бонд гаргагчийн удирдлагаас өгсөн нэмэлт мэдээлэлд тулгуурлан үлдсэн хоёр жилийн хүү болон бондын нэрлэсэн дүнг дор хаяж 2 жилээр хойшлуулан барагдуулна гэж үнэлсэн. Энэ тохиолдолд эргэн төлөлтийн хуваарь доорх байдалтай болно:

20X1 оны 1 дүгээр сарын 1	Төлсөн мөнгө	-100
20X1 оны 12 дугаар сарын 31	Хүү төлөлт	10
20X2 оны 12 дугаар сарын 31	Хүү төлөлт	10
20X3 оны 12 дугаар сарын 31	Хүү төлөлт	10
20X4 оны 12 дугаар сарын 31	Хүү төлөлт байхгүй	0
20X5 оны 12 дугаар сарын 31	Хүү төлөлт байхгүй	0
20X6 оны 12 дугаар сарын 31	Хүү төлөлт байхгүй	0
20X7 оны 12 дугаар сарын 31	20X4, 20X5 оны хүү ба нэрлэсэн үнийн төлөлт	120

Банк 20X4 оны 12 дугаар сарын 31-нд хамгийн анхны үр ашигт хүүгийн түвшинг ашиглан хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийг тооцоолоход 90.16 сая төгрөг болсон.

PV = 120 / (1+0.1)^3 = 90.16

Бондын дансны үнэ нь нэрлэсэн үнэ 100 сая төгрөг дээр хуримтлуулан тооцсон хүү 10 сая төгрөгийг нэмээд 110 сая төгрөг болсон. Тэгэхээр дээрх хоёр дүнгийн зөрүү болох 19.84 сая төгрөг (110 – 90.16) нь СТОУС-ын дагуу тооцоолж гаргасан, үнэт цаасны эрсдэлийн сангийн зардлыг харуулна. Үүнийг 20X4 оны орлогын тайланд зардлаар бүртгэж тайлагнана.

Түүнчлэн банк холбогдох активын ангиллын журмын дагуу эрсдэлийн санг байгуулах ба хэрэв уг журмын дагуу тооцоолж гаргасан дүн өндөр гарч байвал зөрүүгээр нь эрсдэлийн сангийн нөөцийг хуримтлагдсан ашгаас байгуулна (энэ дүнг орлогын тайланд харуулахгүй).

Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн үнэт цаасыг гадаад валютаар илэрхийлсэн тохиолдолд гадаад валютаар илэрхийлэгдсэн хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн гүйлгээг тухайн санхүүгийн хөрөнгийн хамгийн анхны үр ашигт хүүг ашиглан дискаунтчилна. Гарсан дүнг эрсдэлийн санг байгуулах өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлнэ. Өнөөгийн үнэ цэнийн хөрвүүлсэн дүн ба хөрөнгийн дансны дүнгийн зөрүүг

эрсдэлийн сангийн зардалд бүртгэнэ. Үүний нэгэн адил тайлагналын өдрөөр эрсдэлийн сангийн зардлыг бүхэлд нь, эсвэл хэсэгчлэн буцаах тохиолдолд уг буцаалтыг бүртгэх өдрийн албан ханшийг ашиглана.

3) Борлуулахад бэлэн үнэт цаас

Борлуулахад бэлэн үнэт цаасыг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэн дээр холбогдох шууд зардлыг нэмсэн дүнгээр бүртгэнэ. Энэ нь үнэт цаасыг худалдан авахад төлсөн цэвэр дүнгээр илэрхийлэгддэг.

Санхүүгийн тайланд борлуулахад бэлэн үнэт цаасыг бодит үнэ цэнээр нь үнэлж, толилуулах ба бодит үнэ цэнэд гарсан өсөлт, бууралтыг үнэт цаасны дахин үнэлгээний нэмэгдэл дансанд хуримтлуулна. Үнэт цаасыг бусдад худалдах буюу шилжүүлэн данснаас хасах үед дахин үнэлгээний санг тайлант үеийн орлого, зардалд шилжүүлэн бүртгэнэ.

Үнэт цаасны зах зээлийн үнийг ашиглан бодит үнэ цэнийг тодорхойлох ба харин жишиг үнэ байхгүй тохиолдолд үнэлгээний аргачлалыг ашиглан бодит үнэ цэнийг тодорхойлно.

Борлуулахад бэлэн үнэт цаасны бодит үнэ цэнийг хэмжих боломжгүй тохиолдолд өртгөөр нь бүртгэнэ. Гэхдээ энэ заалт нь зөвхөн жишиг үнэгүй өмчийн хэрэгсэл ба түүнд суурилсан дериватив хамаарна.

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн үнэлгээний орлого, зардлыг доорхоос бусад тохиолдолд бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэнэ:

- Үр ашигт хүүгийн аргаар тооцоолсон хүүг орлого, зардалд бүртгэнэ. НББОУС 18-д заасны дагуу борлуулахад бэлэн өмчийн хэрэгслийн ногдол ашгийг авах эрх банкинд үүссэн өдөр тайлант хугацааны холбогдох орлогод бүртгэнэ.
- Мөнгөн хэлбэртэй санхүүгийн хөрөнгийн ханшийн тэгшитгэлийн орлого, зардлыг тайлант хугацааны орлого, зардалд бүртгэнэ.
- Эрсдэлийн сангийн зардлыг тайлант хугацааны зардалд бүртгэнэ. Өрийн хэрэгслийн эрсдэлийн сангийн зардлын буцаалтыг орлого, зардлын дансанд бүртгэх боловч өмчийн хэрэгслийн эрсдэлийн сангийн зардлын буцаалтыг доор тайлбарласан байдлаар бүртгэнэ.

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өсөлт, бууралтын тохируулгыг өөрийн хөрөнгийн "Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний нэмэгдэл" дансанд бүртгэж, бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрнө. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг үнэн зөв тооцоолж гаргахын тулд санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнийг тухайн өдрөөрх хорогдуулсан өртөгтэй нь харьцуулна. Энэ тооцоололд хуримтлуулан тооцсон хүүгийн авлагын дүнг оруулахгүй. Ийм төрлийн санхүүгийн хэрэгслийг санхүүгийн тайланд бодит үнэ цэнээр бүртгэж, харуулах боловч хүлээн зөвшөөрөх хүүгийн орлогын дүнг гаргах зорилгоор уг хэрэгслийн хорогдуулсан өртгийг үр ашигт хүүгийн аргаар тооцно.

Санхүүгийн хөрөнгийг данснаас хасах үед уг хөрөнгөтэй холбоотойгоор хуримтлуулж, дахин үнэлгээний нэмэгдэлд бүртгэсэн дүнг тайлант хугацааны орлого, зардалд шилжүүлэн бүртгэж, тохируулна.

Жишээ: Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтаар ангилсан бонд

20X5 оны 1 дүгээр сарын 1-нд банк 5 жилийн хугацаатай, 10%-ийн хүүтэй, жил бүрийн 7 дугаар сарын 1 ба 1 дүгээр сарын 1-нд хүү төлөгдөх 10 сая төгрөгийн бонд худалдан авсан. Бондыг худалдан авахад 10,811,100 төгрөг төлсөн. Ижил төстэй бондоос 8%-ийн өгөөж хүртэж байгаа тул 811,100 төгрөгийн урамшуулал төлсөн. Арилжаанд зориулан ямар нэгэн шимтгэл төлөөгүй ба үр ашигт хүүгийн түвшин 8% (үр ашигт хүүгийн аргыг Зээл бүлэгт дэлгэрэнгүй тайлбарласан).

Банк энэ бондыг борлуулахад бэлэн үнэт цаасаар ангилсан. Банк 3 дугаар сарын 31-ээр тасалбар болгон санхүүгийн тайлангаа бэлтгэдэг бөгөөд 20X5 оны 3 дугаар сарын 31-ний өдөр ижил хугацаатай бондын өгөөжийн түвшин ба зээлийн эрсдэл нь 7.75% байсан. Тухайн өдөр бондын бодит үнэ цэнийг 10 сая төгрөгийн нэрлэсэн үнэ болон 500,000 төгрөгийн хүүг 10 удаагийн төлбөрийн үечлэлээр 7.75% -ийн зах зээлийн хүүгийн хувиар дискаунтчилан тооцоолоход 11,127,710 төгрөг гарсан.

Уг бондыг борлуулахад бэлэн гэж ангилсан тул бодит үнэ цэнээр хэмжиж, бодит үнэ цэнд гарсан өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэнэ.

20X5 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар бондын бодит үнэ цэн нь төлөгдсөн мөнгөн дүн буюу 10,811,100 төгрөг байх ба банк үүнийг дараах байдлаар бүртгэсэн:

20X5 оны 1 дүгээр сарын 1

Дебит: Борлуулахад бэлэн үнэт цаас	10,811,100
Кредит: Мөнгөн хөрөнгө	10,811,100

20X5 оны 3 дугаар сарын 31-нд банк 8%-ийн үр ашигт хүүгээр тооцож, 10,811,100 × 8% × 3/12 = 216,222 төгрөгийн хүүгийн орлогыг бүртгэнэ. 500,000 төгрөгийн хүүгийн төлбөр 20X5 оны 7 дугаар сарын 1-нд хийгдэх тул 250,000 төгрөгийн хүүгийн авлагыг хуримтлуулан тооцно. Хүүгийн орлого ба хуримтлуулж тооцсон хүүгийн авлагын хоорондох 33,778 төгрөгийн зөрүүг урамшууллын хорогдол байдлаар орлого, зардалд бүртгэнэ. 20X5 оны 3 дугаар сарын 1-нд хүүгийн орлогыг дараах байдлаар бүртгэнэ:

20X5 оны 3 дугаар сарын 31

Дебит: Борлуулахад бэлэн үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	250,000	
Кредит: Борлуулахад бэлэн үнэт цаас		33,778
Кредит: Хүүгийн орлого		216,222

Ингээд 20X5 оны 3 дугаар сарын 31-нд бондын хорогдуулсан өртөг нь 10,777,322 төгрөг болно (10,811,100 – 33,778). 20X5 оны 3 дугаар сарын 31-нээрх бондын бодит үнэ цэн 11,127,710 төгрөг болно. Цэвэр үнэлгээг гаргах үүднээс эдгээр дүнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлагыг оруулахгүй. Тэгвэл бондын цэвэр үнэ нь 10,877,710 төгрөг болно.

Бондын 20X5 оны 3 дугаар сарын 31-ээрх цэвэр үнэ ба хорогдуулсан өртгийг харьцуулан үнэлгээний орлогыг дараах байдлаар гаргана:

20X5 оны 3 дугаар сарын 31-ээрх бондын бодит үнэ цэн - цэвэр үнэ	10,877,710
20X5 оны 3 дугаар сарын 31-ээрх бондын хорогдуулсан өртөг	10,777,322
Үнэлгээний өөрчлөлт - хэрэгжээгүй орлого	100,388

Энэ орлогыг бүртгэх 20X5 оны 3 дугаар сарын 31-ээрх дансны харилцаа:

20X5 оны 3 дугаар сарын 31

Дебит: Борлуулахад бэлэн үнэт цаас	100,388	
Кредит: Бусад дэлгэрэнгүй орлого		100,388

Борлуулахад бэлэн үнэт цаасны дансны дүн дараах байдлаар өөрчлөгдөнө:

20X5 оны 1 дүгээр сарын 1 - Бодит үнэ цэн (урамшууллыг оруулсан)	10,811,100
Хуримтлуулан тооцсон хүүгийн орлого (бодит үнэ цэнд шингээсэн)	250,000
Урамшууллын хорогдол	(33,778)
Бодит үнэ цэнийн тохируулга - орлого	100,388
20X5 оны 3 дугаар сарын 31 - Бодит үнэ цэн	11,127,710
Тайлант үеийн орлого, зардалд хүлээн зөвшөөрсөн - орлого	216,222
Бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрсөн - орлого	100,388
Бодит үнэ цэнд гарсан нийт өөрчлөлт	316,610

Банк Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу үнэт цаасны эрсдэлийн сан байгуулна. Үүний зэрэгцээ банк СТОУС-д нийцүүлэн үнэт цаасны эрсдэлийн сан байгуулж болно. СТОУС-д нийцүүлэн эрсдэлийн санг хэрхэн байгуулж, бүртгэх талаар “Зээл” бүлгээс үзнэ үү.

Борлуулахад бэлэн үнэт цаасанд эрсдэлийн сан байгуулсан тохиолдолд уг үнэт цаастай холбоотойгоор дахин үнэлгээний нэмэгдэлд хуримтлуулж, бүртгэсэн дүнг тухайн тайлант хугацааны эрсдэлийн сангийн зардалд шилжүүлэн бүртгэнэ.

Дээр дурдсан тайлант хугацааны эрсдэлийн зардалд шилжүүлэн тохируулах дүнг тооцоолохдоо анхны удаад хүлээн зөвшөөрсөн өртөг (үндсэн өрийн төлөлт ба хорогдлыг хассан цэвэр дүн) -өөс өмнө нь байгуулсан эрсдэлийн сангаар бууруулсан тухайн өдрийн бодит үнэ цэнийн дүнг хасна. Гадаад валютын өөрчлөлттэй холбоотойгоор хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлд бүртгэсэн дүнг мөн тайлант хугацааны зардалд шилжүүлнэ. Тухайн хөрөнгийг данснаас хасах хүртэл гадаад валютын өөрчлөлтөөс шалтгаалан тодорхойлогдсон хуримтлуулсан цэвэр зардлын хэсгийг тайлант хугацааны зардалд шилжүүлэн бүртгэнэ.

Жишээ: Борлуулахад бэлэн бондын эрсдэлийн сангийн зардал

Банк 20X3 оны 1 дүгээр сарын 1-нд 5 жилийн хугацаатай, хагас жил тутамд 5%-ийн хүүтэй, жил бүрийн 7 дугаар сарын 1 ба 1 дүгээр сарын 1-нд хүү төлөгдөх 10 сая төгрөгийн бонд худалдан авсан. Бондыг худалдан авахад 10,811,100 төгрөг төлсөн ба үүнийг ашиглан тооцоолоход урамшуулал 811,100 төгрөг, үр ашигт хүүгийн хувь 8% болсон (хагас жилийн 4%). Банк уг бондыг борлуулахад

бэлэн үнэт цаас гэж ангилсан.

20X3, 20X4 оны хүү хугацаандаа төлөгдсөн. 20X4 оны 12 дугаар сарын 31-нд уг бондын хорогдуулсан өртөг нь 10,524,220 төгрөг болсон. Энэ өдрийг хүртэл өөрийн хөрөнгийн дансанд хуримтлуулсан зардлын дүн 266,322 төгрөг байсан гэе.

20X5 оны 6 дугаар сарын 30-аар хагас жилийн хүү төлөгдөөгүй ба удалгүй уг үнэт цаасыг гаргагч нь санхүүгийн хүндрэлд орсон болохыг мэдсэн. 20X5 оны 12 дугаар сарын 31-нд банк үнэт цаас гаргагчийн санхүүгийн нөхцөл байдлыг шалгаж, бондыг эргүүлэн төлөх талаар судлаад, уг бондын үнэ цэн буурсан гэж тогтоосон. Банк тухайн үеийн мэдээлэлд тулгуурлан ирээдүйн мөнгөн гүйлгээний хамгийн сайн үнэлгээг хийхэд төлбөр барагдуулах төлөвлөгөөт өдрүүд болох 20X6 оны 12 дугаар сарын 31-нд 2 сая төгрөг, 20X7 оны 12 дугаар сарын 31-нд 7 сая төгрөг төлөгдөхөөр тооцсон.

Хэдийгээр энэ бонд нь хэвийн бус гэж ангилагдах боловч банк 20X5 оны 12 дугаар сарын 31-ний хүүгийн орлогыг анхны үр ашигт хүүгийн хувийг ашиглан тооцоолсон. Ингэхэд бондын хорогдуулсан өртөг нь 20X5 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 11,383,002 төгрөг болно.

Энэ бондыг борлуулахад бэлэн гэж ангилсан тул түүний бодит үнэ цэнийг 20X5 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тодорхойлох шаардлагатай. Энэ бондын хувьд олж авах боломжтой зах зээлийн үнэ байхгүй тул хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг тухайн үеийн зах зээлийн хүүгийн түвшинг ашиглан дискаунтчилан түүний бодит үнэ цэнийг тодорхойлно. Зэрэгцүүлэгдэх бондын зах зээлийн хүүгийн түвшин мэдэгдэхгүй байгаа үед тухайн бондын өнөөгийн зах зээлийн хүүгийн түвшинг тогтоох шаардлагатай.

- Энэ бондтой ижил нөхцөл, зээлийн эрсдэл бүхий зэрэгцүүлэгдэх бондын хүүгийн түвшинг үнэлэх нэг арга нь тухайн бондын үр ашигт хүүгийн хувь болох 8%-ийг бондын анхны зээлийн эрсдэлийн премиумаар тохируулах замаар өөрчилж гаргасан эрсдэлгүй хүүгийн түвшинг ашиглан үнэлж, дахин үнэлгээний нэмэгдэлд бүртгэнэ.
- Жишиг үнэгүй, өртгөөр бүртгэсэн өмчийн хэрэгслийн хувьд бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжгүй гэх шалтгаанаар эрсдэлийн сангийн зардлыг буцаахгүй.

Санхүүгийн хэрэгсэл гадаад валютаар илэрхийлэгдсэн байж болно. Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн дүнд гадаад валютын ханшийн тэгшитгэл хийж байгаа бол НББОУС 21-ийг мөрдөнө. Харин гадаад валютын хейджээс бусад санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн үнэлгээнд НББОУС 39-ийг мөрдөнө. НББОУС 21-ийн дагуу гадаад валютаар гарсан бүх арилжааг тухайн өдрийн спот ханшаар хөрвүүлэн бүртгэнэ. Гадаад валютаар илэрхийлэгдсэн бүх төрлийн санхүүгийн хэрэгслийг анхны удаад албан ханшаар хөрвүүлэн хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

Хүүгийн орлого, хүүгийн зардал, эрсдэлийн сангийн зардал гэх мэт санхүүгийн хэрэгсэлтэй холбоотой орлого, зардлыг бүртгэсэн өдрийн албан ханшаар хөрвүүлж, хүлээн зөвшөөрнө.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг тайлагналын өдөр хэрхэн үнэлж, харуулах нь уг хөрөнгө, өр төлбөр мөнгөн хэлбэртэй эсвэл мөнгөн бус хэлбэртэй байгаа эсэхээс шалтгаална. Өрийн үнэт цаасыг мөнгөн хэлбэртэй зүйл, харин өмчийн үнэт цаасыг мөнгөн бус хэлбэртэй зүйл гэж үзнэ.

НББОУС 21-д шаардсаны дагуу банк тайлагналын өдрөөрх гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийг тухайн өдрийн хаалтын ханшаар хөрвүүлнэ. Мөнгөн хэлбэртэй зүйлсэд ханшийн тэгшитгэл хийх болон мөнгөн хэлбэртэй зүйлс төлөгдөх үед үүссэн ханшийн зөрүүг тайлант үед нь орлого, зардалд бүртгэнэ. НББОУС 21-ийн дагуу гадаад валютаар илэрхийлэгдсэн, мөнгөн хэлбэртэй, борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртгийг тухайн валютаар нь тооцоолж, ханшийн тэгшитгэл хийнэ. Үүнээс үзэхэд борлуулахад бэлэн үнэт цаастай холбоотойгоор ханшийн тэгшитгэлийн орлого, зардал, хүүгийн орлого, эрсдэлийн сангийн зардал зэргийг тайлант хугацааны орлого, зардалд хүлээн зөвшөөрч, бүртгэх ба үнэлгээнд гарсан бусад өөрчлөлтийг дахин үнэлгээний нэмэгдэл дансанд бүртгэнэ.

Мөнгөн бус хэлбэртэй зүйлсэд ханшийн тэгшитгэл хийхдээ тэдгээрийг түүхэн өртөг эсвэл бодит үнэ цэнээр бүртгэсэн эсэхээс шалгаална. Түүхэн өртгөөр бүртгэсэн хөрөнгөнд ханшийн тэгшитгэл хийхгүй. Жишээлбэл, гадаад валютаар илэрхийлэгдсэн, жишиг үнэгүй хувьцааны хувьд бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжих боломжгүй байдаг тул өртгөөр нь бүртгэх ба үүнд ханшийн тэгшитгэл хийхгүй. Зарим мөнгөн бус санхүүгийн хэрэгслийг бодит үнэ цэнээр бүртгэнэ. Бодит үнэ цэнээр хэмжсэн, гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус хөрөнгийг дахин үнэлэхдээ тухайн өдрийн албан ханшаар хөрвүүлж, бүртгэнэ. Мөнгөн бус хэлбэртэй зүйлд хамаарах бүх орлого, зардлыг өөрийн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансанд бүртгэсэн тохиолдолд ханшийн тэгшитгэлийн орлого, зардлыг дахин үнэлгээний нэмэгдэл дансанд бүртгэнэ.

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг өөрийн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансанд бүртгэсэн, борлуулахад бэлэн, гадаад валютаар илэрхийлэгдсэн, мөнгөн бус хөрөнгийн үнэ цэн буурсан тохиолдолд дахин үнэлгээний нэмэгдэл данснаас эрсдэлийн сангийн зардалд шилжүүлэн бүртгэнэ. Энэ дүнг тухайн хөрөнгийг анх авсан өдрийн ханшаар хөрвүүлсэн өртгөөс үнэ цэн буурсан өдрийн ханшаар хөрвүүлсэн бодит үнэ цэнийг хассан дүнгийн зөрүүгээр тооцоолно.

Борлуулах зорилгоор эзэмшиж буй, гадаад валютаар илэрхийлэгдсэн, мөнгөн хэлбэртэй хөрөнгийн хувьд өнгөрсөн хугацаанд бүртгэсэн эрсдэлийн сангийн зардлыг орлого, зардлын дансаар дамжуулан буцааж болно. Энэхүү буцаах бичилт хийж буй өдрийн гадаад валютын ханшийг ашиглан буцаах дүнг илэрхийлнэ. Гадаад валютын ханшийн зөрүүний орлого, зардлыг НББОУС 21-ийн дагуу бүртгэхдээ мөнгөн хэлбэртэй, борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртгийг гадаад валютаар тооцоолох ба энэ үед буцаалттай холбоотой ханшийн зөрүүг тайлант хугацааны орлого, зардалд бүртгэнэ.

Борлуулахад бэлэн үнэт цаасыг “хугацааны эцэс хүртэл эзэмших” эсвэл “зээл, авлага гэж ангилсан үнэт цаас” зэрэг ангилалд шилжүүлэн өөрчилж болно.

Банк хугацааны эцэс хүртэл эзэмших ангиллыг ашиглах эрхгүй болохоос бусад нөхцөлд борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийг хугацааны эцэс хүртэл эзэмших ангилалд шилжүүлэн бүртгэхгүй. Жишээлбэл, банк борлуулахад бэлэн ангиллаар анх ангилсан, идэвхтэй зах зээлийн жишиг үнэ бүхий бондыг хугацааны эцэс хүртэл эзэмшихээр төлөвлөж байгаа бөгөөд ийнхүү эзэмших боломжтой тохиолдолд уг үнэт цаасыг хугацааны эцэс хүртэл эзэмших ангилалд шилжүүлэн бүртгэж болно. Хугацааны эцэс хүртэл эзэмших ангиллыг ашиглах эрхгүй болох дүрмийн хугацаа хоёр жил үргэлжилж дуусмагц уг ангиллыг эргэн ашиглах боломжтой болно.

Банк дараах тохиолдолд бонд гэх мэт дериватив бус санхүүгийн хөрөнгийг борлуулахад бэлэн ангиллаас зээл ба авлага ангилалд шилжүүлэн бүртгэнэ:

- Банк тухайн хөрөнгийг ойрын ирээдүйд эсвэл хугацааны эцэс хүртэл эзэмших төлөвлөгөө, боломжтой байгаа;
- Тухайн үнэт цаас нь зээл ба авлагын тодорхойлолтыг хангасан. Хэрэв санхүүгийн хөрөнгийн идэвхтэй зах зээлийн жишиг үнэтэй эсвэл хөрөнгийн чанар муудсанаас бусад тохиолдолд үнэт цаасыг эзэмшигч оруулсан хөрөнгө оруулалтаа бүгдийг нөхөн авах боломжгүй нөхцөлд уг үнэт цаас нь зээл ба авлагын тодорхойлолтыг хангахгүй. Иймээс ангилал өөрчлөх энэ хэлбэр ховор тохиолддог.

Үнэт цаасны ангиллыг өөрчлөхдөө тухайн өдрөөрх үнэт цаасны бодит үнэ цэнийг шинэ өртөг буюу хорогдуулсан өртөг болгон бүртгэнэ. Өмнө нь орлого, зардалд бүртгэсэн дүнг буцаахгүй. Харин уг үнэт цаастай холбоотойгоор дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдлийг тухайн хөрөнгө оруулалтын үлдэж буй хугацаанд үр ашигт хүүгийн аргаар орлого, зардалд хорогдуулж бүртгэнэ. Шинэ өртгийг цаашид тухайн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг үнэлэх суурь болгон ашиглана. Ангилал өөрчилж буй өдрийн бодит үнэ цэнийг үр ашигт хүүгийн хувь хэмжээгээр тооцоолон гаргана. Энд ашиглаж буй үр ашигт хүүгийн түвшинг ирээдүйн тайлант хугацаанд хүүгийн орлогын тооцоололд болон үнэ цэнийн бууралтыг хэмжих үед анхны үр ашигт хүү болгон тус тус ашиглана.

Харин ангилал өөрчлөгдсөний улмаас үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлогын дүн өөрчлөгдөхгүй (ангилал өөрчлөгдөхөөс өмнөх анхны хорогдуулалтын хүснэгтийг өөрчлөхгүй).

Гадаад валютаар илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгийг зээл ба авлагад шилжүүлэн ангилсан тохиолдолд ангилал өөрчилж буй өдрөөрх тухайн санхүүгийн хөрөнгийн “хорогдуулсан өртөг”-ийг гадаад валютаар тооцоолон гаргах бөгөөд дараа нь уг дүнгээ ангилал өөрчилж буй өдрийн албан ханшаар хөрвүүлнэ.

<u>4) Зээл ба авлага гэж ангилсан үнэт цаас</u>

Банк үнэт цаасыг (худалдан борлуулах бус) эргүүлэн төлүүлэх төлөвлөгөөтэй байгаа бөгөөд үнэт цаасыг хөрөнгийн бирж дээр арилжаалдаггүй буюу жишиг үнэ байхгүй тохиолдолд үнэт цаасыг зээл ба авлага гэж бүртгэнэ. Жишиг үнэгүй үнэт цаас нь хугацааны эцэс хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгийн тодорхойлолтыг хангахгүй тул банк жишиг үнэгүй үнэт цаасыг хугацааны эцэс хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын үнэт цаасаар ангилахгүй, харин “Зээл, авлага гэж ангилсан үнэт цаас” дансанд бүртгэнэ.

Зээл ба авлагаар ангилсан үнэт цаасны үнэлгээ, бүртгэл нь хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаастай (жишиг үнэтэй үнэт цаас) адил хорогдуулсан өртгийн аргаар бүртгэнэ. НББОУС 39-ийн дагуу энэ ангиллын үнэт цаасыг анхны удаад бодит үнэ цэн дээр тухайн үнэт цаасыг худалдан авахтай шууд холбоотой арилжааны шимтгэлийг нэмсэн дүнгээр буюу үнэт цаасыг олж авахын тулд төлсөн зардлыг хасч цэвэр дүнгээр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Ийм үнэт цаасыг тайлагналын өдөр хорогдуулсан

өртгөөрдүнгээр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Ийм үнэт цаасыг тайлаөгөөд өмчийн үнэт цаасыг арилжааны эсвэл борлуулахад бэлэн гэж ангилж, бүртгэх тул хугацааны эцэс хүртэл эзэмших эсвэл зээл ба авлага гэж ангилахгүй.

Банк зээл ба авлагын тодорхойлолтыг хангаж буй үнэт цаасыг анх авах үедээ борлуулахад бэлэн гэж ангилж болно. Банк зээл, авлага гэж ангилсан үнэт цаасыг борлуулахад бэлэн үнэт цаасны ангиллаас бусад ангилалд шилжүүлэн бүртгэж болохгүй.

Үнэт цаасыг зээл ба авлагаар ангилж, бүртгэсний дараа уг үнэт цаасны зах зээлийн жишиг үнийг тодорхойлох боломжтой болж, улмаар зээл ба авлагын тодорхойлолтыг хангахгүй болсон тохиолдолд банк уг хөрөнгийн ангиллыг өөрчлөх эсвэл хэвээр үлдээх эсэхээ өөрөө сонгож, шийдвэрлэх ба сонгосон бодлогоо тууштай мөрдөнө. Иймээс банк өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогодоо ангиллыг өөрчилнө гэж заасан бол идэвхтэй зах зээлийн жишиг үнэтэй болсон үед бүх зээл ба авлагыг борлуулахад бэлэн үнэт цаасны ангиллаар ангилна. Гэхдээ зээл ба авлагыг борлуулахад бэлэн үнэт цаасанд шилжүүлэн ангилах нь их ховор тохиолддог.

Д. БҮРТГЭЛ

<u>1) Арилжааны үнэт цаас</u>

Арилжааны үнэт цаасыг худалдан авахдаа

Дебит: Арилжааны үнэт цаасны данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Хэрэв үнэт цаасыг хоёрдогч зах зээлээс урамшуулалтай худалдан авсан бол

Дебит: Арилжааны үнэт цаасны данс (нэрлэсэн дүнгээр)
Дебит: Арилжааны үнэт цаасны хорогдуулаагүй урамшуулал (зөрүүгээр)
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Хэрэв үнэт цаасыг хоёрдогч зах зээлээс хямдруулалттай худалдан авсан бол

Дебит: Арилжааны үнэт цаасны данс (нэрлэсэн дүнгээр)
Кредит: Арилжааны үнэт цаасны хорогдуулаагүй хямдруулалт (зөрүүгээр)
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Үнэт цаасны хүүг тооцоолж, хуримтлуулахад

Дебит: Үнэт цаасны хүүгийн авлага
Кредит: Үнэт цаасны хүүгийн орлого

Үнэт цаасны хүү төлөгдөхөд

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Үнэт цаасны хүүгийн авлага

Арилжааны үнэт цаасыг дахин үнэлэх үед

Хэрэв үнэт цаасны ханш өссөн бол зөрүүгээр нь

Дебит: Арилжааны үнэт цаасны хорогдуулаагүй урамшуулал, хямдруулалт
Кредит: Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого

Хэрэв үнэт цаасны ханш буурсан бол зөрүүгээр нь

Дебит: Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн зардал
Кредит: Арилжааны үнэт цаасны хорогдуулаагүй урамшуулал, хямдруулалт

Тайлант хугацааны эцэст үнэт цаасны үнэлгээний орлого, зардлыг цэвэршүүлэн хаана.

Дебит: Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого
Кредит: Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн зардал

Арилжааны үнэт цаасыг худалдаж борлуулбал үнэт цаас худалдсан өдрийн дансны үлдэгдэл ба борлуулсан үнийн зөрүүг арилжааны орлого, зардлаар бүртгэнэ. Энэ үед үнэт цаасны урамшуулал, хямдруулалтын дансны үлдэгдлийг хааж тохируулна.

Ашигтай бол

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Үнэт цаасны арилжааны орлого

Кредит: Арилжааны үнэт цаасны данс

Алдагдалтай бол

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Дебит: Үнэт цаасны арилжааны зардал
Кредит: Арилжааны үнэт цаасны данс

Үүний зэрэгцээ үнэт цаасны үнэлгээний (хэрэгжээгүй) орлого, зардлыг үнэт цаасны арилжааны (хэрэгжсэн) орлого, зардал болгон шилжүүлж, тохируулна.

Үнэт цаасны үнэлгээний хэрэгжээгүй орлого, зардлыг хэрэгжсэн орлого, зардалд бүртгэх үед

Дебит: Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн зардал
Кредит: Үнэт цаасны арилжааны орлого

Эсвэл

Дебит: Үнэт цаасны арилжааны зардал
Кредит: Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого

Жишээ: Арилжааны үнэт цаас

Банк 200,000 мянган төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 5 сарын хугацаатай, сарын 8%-ийн хүүтэй, Засгийн газрын өрийн бичгийг 200,000 мянган төгрөгөөр худалдан авсан. Тус банк уг үнэт цаасыг 3 сарын дотор арилжаалж ашиг хүртэх зорилготой байгаа тул арилжааны үнэт цаасаар ангилсан.

Журналын бичилт (мянган төгрөгөөр):

1. Үнэт цаасыг худалдан авахад

Дебит: Арилжааны үнэт цаас - Засгийн газрын үнэт цаас		200,000
Кредит: Монголбанк дахь харилцах данс		200,000

2. Сарын эцэст үнэт цаасны хүү төлөгдсөн бол

Дебит: Монголбанк дахь харилцах данс	16,000	
Кредит: Хүүгийн орлого	16,000	

3. Тайлант сарын сүүлийн өдөр үнэт цаасыг бодит үнэ цэнээр нь дахин үнэлсэн ба тухайн өдөр Засгийн газрын өрийн бичгийг арилжаалж байсан үнэ 200,023 мянган төгрөг байв. Тэгвэл үнэт цаасны дансны үлдэгдэл 200,000 мянган төгрөг ба тухайн өдрийн бодит үнэ цэн 200,023 мянган төгрөгийн зөрүүгээр

Дебит: Засгийн газрын үнэт цаас	23	
Кредит: Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого	23	

4. Дараа сарын 15-ны өдөр үнэт цаасыг 200,523 мянган төгрөгөөр худалдсан бол

Дебит: Монголбанк дахь харилцах данс		200,523
Кредит: Үнэт цаасны арилжааны орлого		500
Кредит: Арилжааны үнэт цаас - Засгийн газрын үнэт цаас		200,023

Үүний зэрэгцээ үнэлгээний орлогыг хааж, арилжааны орлогоор бүртгэнэ

Дебит: Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого	23	
Кредит: Үнэт цаасны арилжааны орлого		23

Гадаад валютаар илэрхийлэгдсэн арилжааны үнэт цаасны хувьд гадаад валютын ханшийн өөрчлөлтийн орлого, зардлыг бодит үнэ цэнийг өөрчилсөн бусад орлого, зардлаас салгаж бүртгэх шаардлагагүй. Хүүгийн орлогыг нэрлэсэн хүүгийн түвшнээс ялгаатай байж болох үр ашигт хүүгийн түвшинг ашиглан тооцоолно. Үүний үр дүнд банк тайлант хугацаа бүрт үр ашигт хүүгийн аргаар хүүгийн орлогыг тодорхойлохын тулд хорогдуулсан өртгийг тооцоолно. Бодит үнэ цэнийн нийт өөрчлөлтийг үр ашигт хүүгийн аргаар тооцоолсон хүүгийн орлого ба үнэлгээний болон арилжааны орлого, зардлыг харуулсан үлдэгдэл хэсэг гэсэн хоёр хэсэгт хуваана. Үнэт цаасыг урамшуулал, хямдруулалттай худалдан авсан болон нэрлэсэн үнийг дуусгавар хугацаанаас өмнө хэсэгчилсэн төлбөрөөр цуврруулан барагдуулах тохиолдолд үр ашигт хүүгийн түвшин нь нэрлэсэн хүүгийн түвшнээс ялгаатай байна. Үр ашигт хүүгийн аргаар хүүгийн орлогыг тооцоолох тайлбартай жишээг “Зээл” бүлгээс үзнэ үү.

2) Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас

Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаасыг худалдан авахдаа бодит үнэ цэнээр бүртгэх ба үнэт цаасны нэрлэсэн үнэ ба бодит үнийн зөрүүгээр урамшуулал, хямдруулалтыг бүртгэнэ.

Урамшуулалтай бол

Дебит: Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас
Дебит: Үнэт цаасны урамшуулал
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Хямдруулалттай бол

Дебит: Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Үнэт цаасны хямдруулалт

Үнэт цаасны хүүг хуримтлуулан бүртгэж, орлогоор хүлээн зөвшөөрнө.

Дебит: Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага
Кредит: Хүүгийн холбогдох орлого

Хэрэв үнэт цаасыг анх урамшуулалтай авсан бол урамшууллыг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулсан дүнгээр үнэт цаасны хүүгийн орлогыг бууруулна

Дебит: Хүүгийн холбогдох орлого
Кредит: Үнэт цаасны урамшуулал

Хэрэв үнэт цаасыг анх хямдруулалттай авсан бол хямдруулалтыг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулсан дүнгээр үнэт цаасны хүүгийн орлогыг нэмэгдүүлнэ

Дебит: Үнэт цаасны хямдруулалт
Кредит: Хүүгийн холбогдох орлого

Үнэт цаасны хүү төлөгдсөн бол авлагыг бууруулна.

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага

Үнэт цаасны хугацаа дуусч үндсэн төлбөр төлөгдөхөд

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас

Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаасны үнэ цэн бууралтыг тооцож, эрсдэлийн сан байгуулбал

Дебит: Үнэт цаасны эрсдэлийн сангийн зардал
Кредит: Үнэт цаасны эрсдэлийн сан

Хэрэв үнэт цаасны үнэ цэнийн бууралтыг буцаасан бол

Дебит: Үнэт цаасны эрсдэлийн сан
Кредит: Үнэт цаасны эрсдэлийн сангийн зардал

Жишээ: Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас

Банк 200,000 мянган төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 5 сарын хугацаатай, сарын 8%-ийн хүүтэй Засгийн газрын өрийн бичгийг 225,977 мянган төгрөгөөр худалдан авсан. Тус банк уг үнэт цаасыг хугацааны эцэс хүртэл эзэмших зорилготой байгаа тул хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаасаар ангилан бүртгэсэн. Үр ашигт хүүг (Internal Rate of Return) 5%-иар тооцоолсон.

Журналын бичилт (мянган төгрөгөөр):

1. Үнэт цаасыг худалдан авахад

Дебит: Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас - Засгийн газрын үнэт цаас 200,000
Дебит: Засгийн газрын үнэт цаасны урамшуулал 25,977
Кредит: Монголбанк дахь харилцах данс 225,977

2. Үнэт цаасыг 25,977 мянган төгрөгийн урамшуулалтай байгаа бөгөөд сарын эцэст урамшууллыг үр ашигт хүүгийн аргаар тооцож, хорогдуулна.

Дебит: Монголбанк дахь харилцах данс 16,000
Кредит: Засгийн газрын үнэт цаасны урамшуулал 4,701
Кредит: Хүүгийн орлого 11,299

Үнэт цаасны урамшууллыг хорогдуулах хүснэгт (мянган төгрөгөөр)

	Хүү тооцох хугацаа	Хөрөнгө оруулалтын дансны дүн	Хүүгийн орлого	Нэрлэсэн хүүгийн төлбөр	Нэмэгдлийн хорогдуулалт	Хорогдуулаагүй нэмэгдэл
		(a)	(b)=(a)*5%	(c)=200,000*8%	(d)=(c)-(b)	(e)=(a)-200,000
0	2012.1.1	225,977				25,977
1	2012.1.31	221,276	11,299	16,000	4,701	21,276
2	2012.2.28	216,340	11,064	16,000	4,936	16,340
3	2012.3.31	211,157	10,817	16,000	5,183	11,157
4	2012.4.30	205,714	10,558	16,000	5,442	5,714
5	2012.5.31	200,000	10,286	16,000	5,714	-

3. Үнэт цаасны хугацаа дуусч, үндсэн төлбөр төлөгдсөн бол

Дебит: Монголбанк дахь харилцах данс 200,000
Кредит: Засгийн газрын үнэт цаас 200,000

Хүүгийн төлбөр, урамшууллын хорогдуулалт

Дебит: Монголбанк дахь харилцах данс 16,000
Кредит: Засгийн газрын үнэт цаасны урамшуулал 5,714
Кредит: Хүүгийн орлого 10,286

Бусад зээл ба авлагаар ангилсан үнэт цаасны бүртгэл нь хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаастай адил боловч ашиглагдах дансд нь ялгаатай байна.

<u>3) Борлуулахад бэлэн үнэт цаас</u>

Борлуулахад бэлэн үнэт цаасыг худалдан авахдаа бодит үнэ цэнээр нь

Дебит: Борлуулахад бэлэн үнэт цаас
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Үнэт цаасны хүүг тооцоолж, хуримтлуулахад

Дебит: Үнэт цаасны хүүгийн авлага
Кредит: Үнэт цаасны хүүгийн орлого

Үнэт цаасны хүүг хүлээн авахад

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага

Борлуулахад бэлэн үнэт цаасыг дахин үнэлэх үед үүссэн орлого, зардлыг “Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний сан” дансанд бүртгэж (орлогын тайланд тусгахгүй), бусад дэлгэрэнгүй орлогоор тайлагнана. Энэхүү дахин үнэлгээний нэмэгдэл данс эерэг, сөрөг ямар ч үлдэгдэлтэй байж болно.

Хэрэв үнэт цаасны бодит үнэ цэн нь дансны үнээс хэтэрсэн бол

Дебит: Борлуулахад бэлэн үнэт цаас
Кредит: Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний сан

Хэрэв үнэт цаасны ханш буурсан бол

Дебит: Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний сан
Кредит: Борлуулахад бэлэн үнэт цаас

Борлуулахад бэлэн үнэт цаасыг худалдаж борлуулбал үнэт цаас худалдсан тухайн өдрийн дансны үлдэгдэл ба борлуулсан үнийн зөрүүг арилжааны орлого, зардлаар бүртгэнэ.

Ашигтай бол

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Үнэт цаасны арилжааны орлого
Кредит: Борлуулахад бэлэн үнэт цаас

Алдагдалтай бол

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Дебит: Үнэт цаасны арилжааны зардал
Кредит: Борлуулахад бэлэн үнэт цаас

Үнэт цаасыг худалдах үед үнэт цаасны дахин үнэлгээний санд хуримтлагдсан үлдэгдлийг арилжааны орлого, зардалд хааж, бүртгэнэ.

Хэрэв үнэт цаасны дахин үнэлгээний сан эерэг буюу кредит үлдэгдэлтэй бол

Дебит: Үнэт цаасны дахин үнэлгээний сан
Кредит: Үнэт цаасны арилжааны орлого

Хэрэв үнэт цаасны дахин үнэлгээний сан сөрөг буюу дебит үлдэгдэлтэй бол

Дебит: Үнэт цаасны арилжааны зардал
Кредит: Үнэт цаасны дахин үнэлгээний сан

Борлуулахад бэлэн үнэт цаасны ангиллыг өөрчилсөн бол

Дебит: Үнэт цаасны холбогдох данс
Кредит: Борлуулахад бэлэн үнэт цаас

Жишээ: Борлуулахад бэлэн үнэт цаас

Банк 200,000 мянган төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 5 сарын хугацаатай, сарын 8%-ийн хүүтэй Засгийн газрын өрийн бичгийг 200,000 мянган төгрөгөөр худалдан авсан. Тус банк уг үнэт цаасыг борлуулахад бэлэн үнэт цаас гэж ангилсан.

Журналын бичилт (мянган төгрөгөөр):

1. Үнэт цаасыг худалдан авахад

Дебит: Борлуулахад бэлэн үнэт цаас- Засгийн газрын үнэт цаас		200,000
Кредит: Монголбанк дахь харилцах данс		200,000

2. Үнэт цаасны хүү төлөгдсөн бол

Дебит: Монголбанк дахь харилцах данс	16,000	
Кредит: Хүүгийн орлого	16,000	

3. Тайлант сарын сүүлийн өдөр үнэт цаасыг бодит үнэ цэнээр нь дахин үнэлсэн ба тухайн өдөр Засгийн газрын өрийн бичгийг арилжаалж байсан үнэ 200,023 мянган төгрөг байв. Тэгвэл үнэт цаасны дансны үлдэгдэл 200,000 ба тухайн өдрийн бодит үнэ цэн 200,023-ийн зөрүүг дахин үнэлгээний санд бүртгэнэ.

Дебит: Борлуулахад бэлэн үнэт цаас- Засгийн газрын үнэт цаас		23
Кредит: Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний сан		23

4. Дараа сарын 20-нд үнэт цаасыг 200,523 мянган төгрөгрөөр худалдсан бол

Дебит: Монголбанк дахь харилцах данс		200,523
Кредит: Үнэт цаасны арилжааны орлого		500
Кредит: Борлуулахад бэлэн үнэт цаас- Засгийн газрын үнэт цаас		200,023

Дахин үнэлгээний санг хаана.

Дебит: Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний сан		23
Кредит: Үнэт цаасны арилжааны орлого		23

Е. ТОДРУУЛГА

Банк үнэт цаасны ангиллыг тодорхойлсон үндэслэлээ баримтжуулж, баталгаажуулах бөгөөд ангилал тус бүрээр санхүүгийн тайлангийн тодруулга бэлтгэнэ.

Үнэт цаасны ангилал бүрээр эргэн төлөгдөх хугацааг тодруулна. СТОУС 7-д шаардсан бусад тодруулгууд (энэ зааврын “Санхүүгийн эрсдэл болон өөрийн хөрөнгийн удирдлага, бусад тодруулга” бүлгээс үзнэ үү) болон хөрөнгө оруулалтын үнэт цаасны чанарын талаарх тодруулга, дараах ангилал бүрээр хугацаа хэтэрсэн боловч үнэ цэн буураагүй үнэт цаасыг тодруулна: арилжааны үнэт цаас, ашиг, алдагдлаарх бодит үнээр илэрхийлэх үнэт цаас, хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас, зээл ба авлагаар ангилсан үнэт цаас. Эдгээр тодруулгыг бэлтгэхдээ банкны зээлжих чадварыг харуулсан гадаад ба дотоод зэрэглэлийг ашиглана. Банкинд гадаад ба дотоод зэрэглэл тогтоогдоогүй тохиолдолд хөрөнгийн чанарын талаар дэлгэрэнгүй мэдээллийг тодруулна.

Банк барьцаанд тавьсан хөрөнгө оруулалт, үнэт цаасыг санхүүгийн тайланд тусдаа мөрийн зүйлээр толилуулна. Барьцаанд тавьсан үнэт цаас гэж буцааж худалдан авах нөхцлөөр худалдсан үнэт цаас бөгөөд худалдан авсан тал үүнийг худалдах эсвэл барьцаанд тавих эрхтэй. Банк хугацаа хэтрээгүй бөгөөд үнэ цэн буураагүй гэж ангилсан өрийн үнэт цаасны хөрөнгийн чанарын талаар дэлгэрэнгүй мэдээллийг тодруулна.

Үнэт цаасны бодит үнэ цэнийг үнэлэн, тооцсон аргачлалыг тодруулна. Үнэт цаасны арилжаатай холбоотой хүлээж болзошгүй эрсдэл, эрсдэлийн үнэлгээ, шинжилгээний талаар тодруулна.

Ё. ХЯНАЛТ

- Ажилтнуудын ажил үүргийг зааглан тусгаарлана.
- Гүйлгээний баримтын бүрдлийг хангана.
- Үнэт цаасны ангиллыг тодорхойлсон үндэслэлийг баримтжуулна.
- Үнэт цаасны нэр, төрлөөр дэлгэрэнгүй бүртгэл хөтөлнө.
- Дэлгэрэнгүй бүртгэлийг хяналтын дансны гүйлгээ, үлдэгдэлтэй тохируулна.
- Үнэт цаасны бүртгэлийг үндсэн баримттай нь тулган шалгана.

4.2.2. ХАРААТ, ХАМТЫН ХЯНАЛТТАЙ, ОХИН КОМПАНИД ОРУУЛСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

А. ШУУД ХОЛБОГДОХ СТАНДАРТУУД

- СТОУС 3 Бизнесийн нэгдэл
- СТОУС 10 Нэгтгэсэн санхүүгийн тайлан
- СТОУС 11 Хамтын хэлцэл
- СТОУС 12 Бусад аж ахуйн нэгж дэх хувь оролцоог тодруулах
- НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- НББОУС 27 Тусдаа санхүүгийн тайлан
- НББОУС 28 Хараат компани ба хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалт
- НББОУС 36 Хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Б. ТОДОРХОЙЛОЛТ

Охин компани болон хараат компани нь Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар тодорхойлогдох ба СТОУС-д дараах байдлаар тодорхойлогдсон байдаг.

Охин компани гэж толгой компанийн (банкны) хяналтанд буй аж ахуйн нэгжийг хэлнэ.

Өгөөж хүртэхийн тулд охин компанийн санхүү ба үйл ажиллагааг бодлогын түвшинд удирдах эрх мэдлийг *хяналт* гэнэ. Хөрөнгө оруулагч охин компанид оруулсан хөрөнгийн хэмжээгээрээ ашиг хүртэх эрх үүссэн бөгөөд охин компани дахь эрх мэдлээрээ дамжуулан ашигт нөлөөлөх боломжтой үед охин компанид хяналтаа тогтоосон гэж үзнэ.

Хөрөнгө оруулагч (банк)-ийн охин компани эсвэл хамтын хөрөнгө оруулалтын аль ч биш бөгөөд хөрөнгө оруулагчийн зүгээс мэдэгдэхүйц нөлөө бүхий аж ахуйн нэгжийг *хараат компани* гэнэ.

*А*ж ахуйн нэгжийн үйл ажиллагааны бодлогын түвшний шийдвэр гаргахад оролцох эрхтэй боловч хяналт тогтоогоогүй бол *мэдэгдэхүйц нөлөө* гэнэ.

Хоёр ба түүнээс дээш оролцогч талууд үйл ажиллагаанд тавих хяналтыг гэрээгээр тохиролцож санхүүгийн болон үндсэн үйл ажиллагааны талаар шийдвэр гаргахад хамтын хэлцэл байгуулж, хамтын хяналтандаа байлгах аж ахуйн нэгжийг *хамтын хяналттай аж ахуйн нэгж* гэнэ.

Өмчийн арга гэдэг нь хөрөнгө оруулалтыг эхэлж өртгөөр нь хүлээн зөвшөөрч, дараагийн тайлант үед хараат ба хамтын хяналттай компанийн өөрийн хөрөнгөнд гарсан өөрчлөлтийг банкны эзэмшлийн хувиар тохируулан бүртгэх аргыг хэлнэ.

Өртгийн арга нь хөрөнгө оруулалтыг эхэлж өртгөөр хүлээн зөвшөөрч, бүртгэх арга ба хөрөнгө оруулалтын өртөг үнэ цэнийн бууралтаас бусад тохиолдолд өөрчлөгдөхгүй.

Хяналтын эрхгүй хувь оролцоо гэж охин компанийн хувьцаанаас толгой компанийн эзэмшээгүй хэсгийг ойлгоно.

В. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

Санхүүгийн байгууллага болон бусад аж ахуйн нэгжийн хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалт нь охин, хараат компани, хамтын хяналттай компанийн аль нь болох эсэхийг банк холбогдох хууль тогтоомж болон СТОУС-ын дагуу үнэлнэ. Хэрэв хяналт тогтоосон эсвэл мэдэгдэхүйц нөлөө буюу хамтын хяналт үүссэн болохыг нотлох нотолгоо байхгүй бөгөөд хувьцааг арилжааны зорилгоор эзэмшээгүй тохиолдолд уг хөрөнгө оруулалтыг борлуулахад бэлэн өмчийн үнэт цаасаар ангилж, бүртгэнэ.

Охин болон хамтын хяналттай, хараат компаниас банк ногдол ашиг авах эрх үүссэн үед ногдол ашгийг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

1) Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт

Аж ахуйн нэгжийн саналын эрхтэй хувьцааны 20 ба түүнээс дээш хувийг банк шууд болон шууд бусаар (охин компаниараа дамжуулан) эзэмшиж байгаа бол мэдэгдэхүйц нөлөөтэй байгаагаа нотолсны үндсэн дээр, мэдэгдэхүйц нөлөө үүссэн өдөр хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтыг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

Аж ахуйн нэгжийн саналын эрхтэй хувьцааны 20 ба түүнээс дээш хувийг банк шууд болон шууд бусаар эзэмшсэн бол банк уг аж ахуйн нэгжид мэдэгдэхүйц нөлөөтэй байна гэж үзнэ. Нөгөө талаас банк аж ахуйн нэгжийн саналын эрхтэй хувьцааны 20 хүртэлх хувийг шууд болон шууд бусаар эзэмшсэн бол уг

аж ахуйн нэгжид мэдэгдэхүйц нөлөөгүй гэж үзнэ. Гэхдээ хөрөнгө оруулагч мэдэгдэхүйц нөлөөтэй эсвэл мэдэгдэхүйц нөлөөгүй болохоо баталж чадвал дээрх аль нэг таамаглалыг няцааж болно. Ер нь аж ахуйн нэгжийн мэдэгдэхүйц их хэсгийг буюу дийлэнх хэсгийг өмчлөх нь тухайн хөрөнгө оруулагч нь мэдэгдэхүйц нөлөөтэй гэсэн үг биш юм.

Банк аж ахуйн нэгжид мэдэгдэхүйц нөлөөтэй эсэх талаар удирдлагын зүгээс гаргасан шийдвэрийг хэлэлцэж, баримтжуулахдаа ашиглаж болох, хөрөнгө оруулагчийн мэдэгдэхүйц нөлөөг хэрхэн илэрхийлэх талаарх доорх жишээнүүд НББОУС 28-д багтсан байдаг:

i) Хувьцаа гаргасан компанийн захирлуудын зөвлөл эсвэл адил эрх мэдэл бүхий удирдах нэгжид төлөөлөлтэй бол;

ii) Ногдол ашиг эсвэл ашгийн хуваарилалтын бусад шийдвэр гаргах зэрэг бодлого боловсруулах үйл ажиллагаанд оролцдог бол;

iii) Хөрөнгө оруулагч ба санхүүжигчийн хооронд материаллаг дүнтэй ажил гүйлгээ гарсан бол;

iv) Компанийн удирдах албан тушаалтанг харилцан солилцдог бол; эсвэл

v) Компанийн дотоод дэлгэрэнгүй мэдээллээр банкийг хангадаг бол.

Тиймээс компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад банк нэр дэвшүүлэх эрхтэй тохиолдолд банк уг компанид мэдэгдэхүйц нөлөөтэй байгаа гэж үзэн уг компанид оруулсан хөрөнгө оруулалтаа хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтаар бүртгэнэ. Дээр жишээ болгон дурдсан нөхцлүүдийг бүгдийг бус харин аль нэгийг нь хангаж байвал мэдэгдэхүйц нөлөө үүссэн нотолгоо бий болно.

Гэхдээ бодлогын шийдвэр гаргахад оролцож байгаа нь дангаараа эрх мэдэлтэй байгааг харуулахгүй. Аж ахуйн нэгжийн удирдах зөвлөлд хөрөнгө оруулагч багтдаг боловч хуралдаанд идэвхтэй оролцдоггүй эсвэл санал өгөхөөс түдгэлзсэн шалтгаанаар оролцоо багатай байж болно. Хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжийн удирдах зөвлөлд багтах нь тухайн хөрөнгө оруулагч бодлогын шийдвэр гаргахад оролцдоггүй гэсэн үг биш юм. Хэрэв хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжийн удирдах зөвлөлд ажиллаад үр дүнд хүрээгүй, аж ахуйн нэгжээс тодорхой хугацааны давтамжтайгаар санхүүгийн мэдээлэл авч чадаагүй эсвэл хөрөнгө оруулагчийн зүгээс нөлөөллөө хэрэгжүүлэх үйлдлүүдийг нь аж ахуйн нэгж эсэргүүцэж байгаа тохиолдолд мэдэгдэхүйц нөлөөлөл байгаа эсэхийг дахин үнэлэх шаардлагатай болно.

Банк нь хувьцааны баталгаа, хувьцаа худалдан авах опцион, хэрэгжсэн буюу хөрвүүлсэн үедээ банкны саналыг эрхийг нэмэгдүүлэх буюу бусад хувьцаа эзэмшигчдийн зүгээс аж ахуйн нэгжийн санхүү болон үйл ажиллагаанд тавих эрх мэдлийг багасгаж болзошгүй энгийн хувьцаанд хөрвөх өрийн ба өмчийн хэрэгсэл (өөрөөр хэлбэл боломжит саналын эрх) -ийг эзэмшдэг байж болно. Банк аж ахуйн нэгжид мэдэгдэхүйц нөлөөтэй эсэхийг үнэлэхдээ энэхүү боломжит саналын эрхийн үр нөлөөг авч үзнэ.

<u>2) Хамтын хяналттай компанид оруулсан хөрөнгө оруулалт</u>

Хамтын хяналттай компанид оруулсан хөрөнгө оруулалтыг хамтын хяналтыг нотолсны үндсэн дээр, хамтын хяналт тогтоосон өдөр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Дараах шинж чанарыг бүх төрлийн хамтын хяналттай аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтанд ашиглана:

i) Хоёр болон түүнээс дээш тал гэрээгээр үүрэг хүлээсэн;
ii) Гэрээний үндсэн дээр хамтын хяналтыг тогтоосон.

Хамтын хяналт тогтоох талаар гэрээ хэлцэл байгуулаагүй бол хамтын хяналттай компани гэж үзэхгүй. Гэрээ хэлцэл нь оролцогч талуудын хооронд байгуулсан гэрээнээс гадна оролцогчдын хурлын тэмдэглэл гэх мэт хэлбэртэй байж болно. Зарим тохиолдолд хэлцэлд хамтын хяналттай компанитай холбоотой хуулийн заалт, журам, заавар багтаж болно. Хамтын хяналттай компанид гэрээний үндсэн дээр хамтарсан хяналт тогтдог. Энэ шаардлагаас харахад аль нэг оролцогч дангаараа хяналт тогтоох боломжгүй юм. Байгуулсан гэрээнд оролцогчдын аль нэг нь хамтын хяналттай компанийн удирдлагад ажиллахыг заасан байж болно. Энэ албан тушаалтан хамтын хяналттай компанийг хянахгүй боловч гэрээнд заасны дагуу оролцогчдын харилцан зөвшөөрсөн хэм хэмжээнд санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд оролцоно. Хэрэв дээрх албан тушаалтан санхүү болон бусад үйл ажиллагааны бодлогыг удирдах эрх мэдэлтэй болсон тохиолдолд уг компанийг хамтын хяналттай компани бус харин охин компани гэж үзнэ.

<u>3) Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт</u>

Хэрэв банк аж ахуйн нэгжийн саналын эрхтэй хувьцааны 50, түүнээс дээш хувийг эзэмшиж хяналт тогтоосон бол хяналтаа нотолсны үндсэн дээр, хяналт тогтоосон өдөр охин компанид оруулсан хөрөнгө оруулалтыг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Толгой компани нь хяналт тогтохгүй гэж үзсэн тусгай нөхцөл

байдлаас бусад тохиолдолд шууд болон шууд бусаар охин компанийн саналын эрхийн 50%-иас илүүг эзэмшиж байгаа үед хяналт оршино. Саналын эрхийн 50%-иас бага хувийг эзэмшиж байгаа боловч доорх тохиолдолд хяналт тогтсон гэж үзэж болно:

i) Бусад хөрөнгө оруулагчидтай хэлцэл хийсний үндсэн дээр саналын эрхийн талаас илүүг гаргах эрхтэй болох;

ii) Хууль тогтоомж, гэрээ хэлцлийн дагуу компанийн санхүү болон үйл ажиллагааны бодлогыг удирдах эрх мэдэлтэй болох;

iii) Захирлуудын зөвлөл эсвэл түүнтэй адил төстэй удирдах дээд байгууллагын гишүүдийн дийлэнхийг томилох, халах эрх мэдэлтэй ба үүгээрээ дамжуулан уг компанийг хянах;

iv) Захирлуудын зөвлөл эсвэл түүнтэй адил төстэй удирдах дээд байгууллагын хурал дээр олонх саналыг гаргах эрх мэдэлтэй ба үүгээрээ дамжуулан уг компанийг хянах.

Г. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

НББОУС 39 (СТОУС 9) -ийн дагуу охин компанийн хөрөнгө оруулалтыг өртгөөр нь бүртгэх буюу өөрөөр хэлбэл борлуулахад бэлэн үнэт цаастай адил хэмжилт, бүртгэлийн зарчмыг ашиглана.

Банк хараат компани ба хамтын хяналттай компанид оруулсан хөрөнгө оруулалтыг өмчийн аргаар бүртгэнэ. Хэрэв банк НББОУС 27-ийн дагуу тусдаа санхүүгийн тайлан бэлтгэдэг бол хараат компани ба хамтын хяналттай компанид оруулсан хөрөнгө оруулалтыг тусдаа санхүүгийн тайланд өртгөөр эсвэл бодит үнэ цэнээр бүртгэж, тайлагнах бол нэгтгэсэн санхүүгийн тайланд өмчийн аргаар үнэлж, толилуулна.

Банк өмчийн аргын дагуу хараат ба хамтын хяналттай компанид оруулсан хөрөнгө оруулалтыг тэдгээр компанийн тайлант үеийн цэвэр ашиг, дахин үнэлгээний нэмэгдэл, бусад дэлгэрэнгүй орлогоор нэмэгдүүлж, тайлант үеийн цэвэр алдагдал, хуваарилсан ногдол ашиг, буцаасан хөрөнгө оруулалтын дүнгээр бууруулж бүртгэнэ.

Банк хараат ба хамтын хяналттай компани дахь мэдэгдэхүйц нөлөөгөө алдсан тохиолдолд өмчийн аргыг хэрэглэхгүй.

Банк санхүүгийн нэгдсэн тайлан бэлтгэдэг бол хараат, хамтын хяналттай компанид оруулсан хөрөнгө оруулалтыг өмчийн аргаар бүртгэнэ. Тусдаа санхүүгийн тайланд хараат, хамтын хяналттай компанид оруулсан хөрөнгө оруулалтыг өртгөөр эсвэл СТОУС-д нийцүүлэн (бодит үнэ цэнээр) бүртгэж, толилуулна.

Банк, банкны нэгдэл нь охин компанид хяналтаа тогтоосон өдрөөс эхлэн хяналтаа алдах хүртэл санхүүгийн нэгдсэн тайланг бэлтгэнэ.

Санхүүгийн нэгдсэн тайланг бэлтгэхдээ охин компанийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зардал, мөнгөн гүйлгээг зүйл зүйлээр нь нэгтгэх ба охин компанид оруулсан хөрөнгө оруулалтыг дансны үнээр нь хаана. Нэгтгэлийн үед охин ба толгой компани, охин компаниудын хооронд үүссэн орлого, зардал, хөрөнгө, өр төлбөрийг хооронд нь хаана.

Санхүүгийн нэгдсэн тайланд хяналтын эрхгүй хувь оролцоог бусад өөрийн хөрөнгийн хэсэгт толилуулна.

Банк Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу охин, хараат, хамтын хяналттай компанид оруулсан хөрөнгө оруулалтанд эрсдэлийн сан байгуулна. Үүний зэрэгцээ банк СТОУС-д нийцүүлэн үнэт цаасны эрсдэлийн сан байгуулж болно. СТОУС-д нийцүүлэн эрсдэлийн санг хэрхэн байгуулж, бүртгэх талаар “Зээл” бүлгээс үзнэ үү.

НББОУС 27, НББОУС 28, НББОУС 31-ийн дагуу тусдаа санхүүгийн тайланд өртгөөр бүртгэсэн охин, хараат, хамтын хяналттай компанид оруулсан хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтыг хэмжиж, бүртгэхэд НББОУС 36 -г мөрдөнө. Санхүүгийн нэгдсэн тайланд болон өмчийн аргаар бүртгэсэн хараат ба хамтын хяналттай компанид оруулсан хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтыг бүртгэхдээ НББОУС 36-г мөрдөнө. Гэхдээ үнэ цэнийн буурсан гэх нотолгоог тогтооход НББОУС 39-ийг мөрдөнө.

Д. БҮРТГЭЛ

1) Өмчийн аргаар бүртгэсэн хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалтыг анх өртгөөр нь бүртгэнэ.

Дебит: Хөрөнгө оруулалтын холбогдох данс

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Тайлант хугацааны эцэст санхүүжигч компани ашигтай ажилласан бол уг цэвэр ашгаас банкинд ногдох хувь хэмжээгээр буюу эзэмшлийн хувиар тооцоолж хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлнэ.

Дебит: Хөрөнгө оруулалтын холбогдох данс
Кредит: Хараат, хамтын хяналттай компанийн ашгаас хуваарилсан орлого

Тайлант хугацааны эцэст санхүүжигч компани алдагдалтай ажилласан бол уг цэвэр алдагдлаас банкинд ногдох хувь хэмжээгээр буюу эзэмшлийн хувиар тооцоолж хөрөнгө оруулалтаа бууруулна.

Дебит: Хараат, хамтын хяналттай компанийн алдагдлаас ногдох хувь (зардал)
Кредит: Хөрөнгө оруулалтын холбогдох данс

Хувьцаа гаргагч тал ногдол ашиг олгохоор зарлахад

Дебит: Ногдол ашгийн авлага
Кредит: Ногдол ашгийн орлого
Дебит: Хөрөнгө оруулалтын эрсдэлийн сангийн зардал
Кредит: Хөрөнгө оруулалтын холбогдох данс

Ногдол ашиг төлөгдөхөд

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Ногдол ашгийн авлага

Санхүүжигч компанийн эздийн өмчид гарсан бусад өөрчлөлт болон бусад дэлгэрэнгүй орлогыг хувь тэнцүүлэн хөрөнгө оруулалтаа тохируулна. Тухайлбал, санхүүжигч компани үндсэн хөрөнгөө дахин үнэлж, үнэ цэнийг нь нэмэгдүүлсэн бол дахин үнэлгээний нэмэгдлээс банкинд ногдох хувь хэмжээгээр буюу эзэмшлийн хувиар тооцоолж хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлнэ.

Дебит: Хөрөнгө оруулалтын холбогдох данс
Кредит: Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний нөөц (Бусад өөрийн хөрөнгө)

Хөрөнгө оруулалтыг худалдан борлуулсан бол хөрөнгө оруулалтыг дансны үнээр нь бууруулж, хүлээн авсан төлбөр ба дансны үнийн зөрүүг тайлант хугацааны орлого, зардлаар бүртгэнэ.

Дебит: Хөрөнгө оруулалтын холбогдох данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Өмчийн аргаар бүртгэсэн хөрөнгө оруулалтын үнэ цэн буурсан бол эрсдэлийн сангийн зардалд бүртгэнэ.

Дебит: Хөрөнгө оруулалтын эрсдэлийн сангийн зардал
Кредит: Хөрөнгө оруулалтын эрсдэлийн сан

Хэрэв дараагийн тайлант үед хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтыг буцаасан бол

Дебит: Хөрөнгө оруулалтын эрсдэлийн сан
Кредит: Хөрөнгө оруулалтын эрсдэлийн сангийн зардал

Өмчийн аргаар бүртгэсэн хөрөнгө оруулалтыг урт хугацаат хөрөнгөөр толилуулна.

Жишээ: Хөрөнгө оруулалт - Өмчийн арга

Банк санхүүгийн үйлчилгээ эрхэлдэг ББ компанийн хувьцааны 30%-ийг 10 сая төгрөгөөр худалдан авсан ба уг компанийн удирдлагын шийдвэр гаргалтанд шууд нөлөөлөх эрхтэй гэж үзээд тус компанийг хараат компани гэж тодорхойлсон. Тайлант жилд хараат компани ББ нийт 3 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласнаа тайлагнаж, саналын эрхтэй бүх хувьцаа эзэмшигчиддээ 2 сая төгрөгийг ногдол ашигт хуваарилсан.

Журналын бичилтүүд:

1. Хөрөнгө оруулалтыг анх бүртгэхдээ

Дебит: Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	10 сая
Кредит: Мөнгөн хөрөнгө	10 сая

2. Хараат компанийн тайлагнасан цэвэр ашгаас хувь тэнцүүлэн тохируулга хийсэн (3 сая*30%)

Дебит: Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	0,9 сая
Кредит: Хөрөнгө оруулалтын орлого	0,9 сая

3. Хараат компанийн зарласан ноогдол ашгийг хөрөнгө оруулалтаа бууруулж бүртгэнэ (2 сая*30%)

Дебит: Мөнгөн хөрөнгө	0,6 сая
Дебит: Хөрөнгө оруулалтын эрсдэлийн сангийн зардал	0,6 сая
Кредит: Ногдол ашгийн орлого	0,6 сая
Кредит: Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	0,6 сая

2) Өртгийн аргаар бүртгэсэн хөрөнгө оруулалт

Өмчийн хэрэгсэлд оруулсан хөрөнгө оруулалтыг өртгийн аргаар бүртгэх бол худалдан авсан өртгөөр нь хөрөнгө оруулалтыг бүртгэнэ.

Дебит: Хөрөнгө оруулалтын холбогдох данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Санхүүжигч компани ногдол ашиг олгохоор зарлахад

Дебит: Бусдаас авах авлага
Кредит: Бусад орлого - Ногдол ашгийн орлого

Зарласан ногдол ашиг төлөгдөхөд

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Бусдаас авах авлага

Өртгийн аргаар бүртгэсэн хөрөнгө оруулалтын үнэ цэн буурсан бол үнэ цэнийн бууралтыг зардалд бүртгэнэ.

Дебит: Хөрөнгө оруулалтын эрсдэлийн сангийн зардал
Кредит: Хөрөнгө оруулалтын эрсдэлийн сан

Хэрэв дараагийн тайлант үед хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтыг буцаасан бол

Дебит: Хөрөнгө оруулалтын эрсдэлийн сан
Кредит: Хөрөнгө оруулалтын эрсдэлийн сангийн зардал

Жишээ: Хөрөнгө оруулалт - Өртгийн арга

Банк санхүүгийн үйлчилгээ эрхэлдэг ББ компанийн хувьцааны 30%-ийг 10 сая төгрөгөөр худалдан авч, хөрөнгө оруулсан ба уг компанийн удирдлагын шийдвэр гаргалтанд шууд нөлөөлөх эрхгүй гэж үзээд хөрөнгө оруулалтаа өртгийн аргаар бүртгэхээр сонгосон. Тайлант жилд хараат компани ББ нийт хувьцаа эзэмшигчиддээ 2 сая төгрөгийг ногдол ашигт хуваарилсан.

Журналын бичилтүүд:

1. Хөрөнгө оруулалтыг анх бүртгэхэд

Дебит: Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	10 сая
Кредит: Мөнгөн хөрөнгө	10 сая

2. Зарласан ноогдол ашгийг бүртгэхэд (2 сая*30%)

Дебит: Мөнгөн хөрөнгө	0,6 сая
Кредит: Ногдол ашгийн орлого	0,6 сая

Е. ТОДРУУЛГА

Хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгж, охин компанийн саналын эрхтэй энгийн хувьцаанаас банкны эзэмшилд буй хувь оролцоо, түүнд гарсан өөрчлөлтийг тодруулна.

Санхүүгийн нэгдсэн тайланд хяналтын эрхгүй хувь оролцоо, түүнд гарсан хөдөлгөөнийг мөн тодруулна.

Хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид хамаарах банкны мэдэгдэхүйц нөлөө, охин компанид тогтоосон хяналтыг баримтжуулж, тодруулна.

Хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалтыг бүртгэсэн өмчийн арга, уг аргатай холбогдуулан хийсэн үнэлгээ, тооцооллын нэмэлт тодруулгыг хийнэ.

Хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгж, охин компанид оруулсан үнэт цаасны эрсдэлийн санд гарсан өөрчлөлтийг хөрөнгө оруулалтын ангилал тус бүрээр тодруулна.

Хөрөнгө оруулалтыг бусадтай хийх тооцоонд барьцаа болгосон бол энэ талаар тодруулна.

Ё. ХЯНАЛТ

- Ажилтнуудын ажил үүргийг зааглан тусгаарлана.
- Гүйлгээний баримтын бүрдлийг хангана.
- Мэдэгдэхүйц нөлөө, хяналттай холбоотой баримтжуулалтыг иж бүрэн бүрдүүлнэ.
- Үнэт цаасны нэр, төрлөөр дэлгэрэнгүй бүртгэл хөтөлнө.
- Дэлгэрэнгүй бүртгэлийг хяналтын дансны гүйлгээ, үлдэгдэлтэй тохируулна.
- Үнэт цаасны бүртгэлийг үндсэн баримттай нь тулган шалгана.

4.3. ЗЭЭЛ

А. ШУУД ХОЛБОГДОХ СТАНДАРТУУД

- СТОУС 7 Санхүүгийн хэрэгсэл: Тодруулга
- СТОУС 9 Санхүүгийн хэрэгсэл
- НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- НББОУС 32 Санхүүгийн хэрэгсэл: Толилуулга
- НББОУС 39 Санхүүгийн хэрэгсэл: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Б. ТОДОРХОЙЛОЛТ

Зээл нь банкнаас тодорхой зориулалт, хүү, хугацаа, эргэж төлөгдөх нөхцөл, барьцаа, эсвэл батлан даалттайгаар өөрийн болон хадгалуулсан бусдын мөнгөн хөрөнгийн зохих хэсгийг өөрийн нэрийн өмнөөс бусад этгээдэд зээлдүүлэх үйл ажиллагаа юм.

Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу зээлийг хугацаа болон чанарын үзүүлэлтээр нь хэвийн, анхаарал хандуулах, хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл гэж ангилна.

Түрээс нь түрээслүүлэгч тохиролцсон хугацаагаар тодорхой хөрөнгийг ашиглах эрхийг түрээслэгчид шилжүүлээд, тодорхой төлбөр авах хэлцэл юм.

Санхүүгийн түрээс нь түрээсийн хөрөнгийн эзэмшилтэй холбоотойгоор хойшид үүсэх эрсдэл болон өгөөжийг бүгдийг түрээслэгчид шилжүүлдэг түрээс юм. Хөрөнгийн өмчлөлийн эрхийг бүрэн шилжүүлэх, эсвэл шилжүүлэхгүй байж болно. Түрээсийн хөрөнгийн эзэмшилтэй холбоотойгоор үүсэх бүх эрсдэл, өгөөжийг түрээслэгчид шилжүүлдэггүй бол үйл ажиллагааны түрээс болно. Санхүүгийн түрээсийг ангилахдаа доорх нөхцөлийг дангаар нь болон хамтад нь авч үзэж болно. Тухайлбал:

i) Түрээсийн хугацааны эцэст түрээсийн хөрөнгийн эзэмшил түрээслэгчид шилждэг;

ii) Түрээсийн хөрөнгийг бодит үнэ цэнээс мэдэгдэхүйц бага үнээр худалдан авах сонголтыг түрээслэгчид олгосон ба түрээслэгч энэ боломжийг ашиглаж хөрөнгийг худалдан авах нь түрээсийн хугацааны эхнээс тодорхой байгаа;

iii) Хөрөнгийг эзэмших эрх шилжээгүй боловч түрээсийн хугацаа нь хөрөнгийн ашиглалтын хугацааны дийлэнхийг хамарсан;

iv) Түрээсийн хугацааны эхэнд түрээсийн хамгийн бага төлбөрийн өнөөгийн үнэ цэн нь түрээсийн хөрөнгийн бодит үнэ цэнтэй ойролцоо байх;

v) Түрээсийн хөрөнгө нь түрээслэгч ямар нэгэн өөрчлөлт хийлгүйгээр ашиглаж болох онцгой шинж чанар бүхий хөрөнгө байх.

Банк санхүүгийн болон үйл ажиллагааны түрээсийг зохих ёсоор ангилахын тулд НББОУС 17.10 – 12 -д заасан дэлгэрэнгүй шинжилгээг хийнэ.

Түрээсийн хугацааны эхлэл гэж түрээслэгч түрээсийн хөрөнгийг ашиглах эрх үүссэн өдрийг хэлнэ. Санхүүгийн түрээсийн авлага нь “Зээл”-д багтана. Санхүүгийн түрээс ба зээлийн бусад бүтээгдэхүүний хоорондох гол ялгаа нь санхүүгийн түрээсийн үед түрээслүүлэгч (банк) түрээсийн хөрөнгийг (тоног төхөөрөмж, машин гэх мэт) өмчлөх эрхийг эзэмшдэг ба түрээслэгч (харилцагч) уг хөрөнгийг ашиглаж буй явдал юм. Зээлийн төлбөрийг төлөхгүй байх тохиолдолд банк түрээсийн хөрөнгийг харилцагчаас хураан авч болно. Бусад төрлийн зээлийн бүтээгдэхүүний хувьд зээлийн барьцаа хөрөнгийг (зээлийн эх үүсвэрээр худалдан авсан, эсвэл барьцаа болгон ашигласан машин, тоног төхөөрөмж) банк өмчлөхгүй буюу уг хөрөнгө харилцагчийн өмч хэвээр байна. Мөн санхүүгийн түрээсийн хувьд авлага болон төлөгдөх төлбөрийн дүнг түрээсийн хөрөнгийн үнэ цэнээс хувь тэнцүүлэн тогтоодог. Барьцаат зээлийн хувьд зээл, түүнээс төлөгдөх төлбөрийн дүн нь барьцаат хөрөнгийн үнэ цэнтэй холбоогүй.

В. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

Банк зээлийн гэрээний нэг тал болж зээлийн гэрээ байгуулж, зээлдэгчид зээлийг олгосон үед санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, толилуулна.

Зээлийн хугацаа дуусч, зээлдэгч гэрээнд заасан төлбөрөө бүрэн барагдуулж, хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн, эсвэл гэрээгээр үүссэн эрхээ бусдад бүрэн шилжүүлсэн тохиолдолд зээлийг данснаас хасч бүртгэнэ. “Хөрөнгө оруулалт” бүлэгт дурдсанаар банк санхүүгийн хөрөнгөө (зээлийг оруулсан) бусдад шилжүүлэхдээ уг хөрөнгөтэй холбоотой эрсдэл, өгөөжийг шилжүүлсэн эсэхийг үнэлнэ. Мөн энэ зааврын дагуу банк нийлмэл арилжаатай (зээлийг худалдах гэх мэт) холбогдуулан хөрөнгийг данснаас хасах шалгуур хангагдсан эсэх нь тодорхойгүй байгааг тогтоосон тохиолдолд эцсийн дүгнэлт хийхээс өмнө дэлгэрэнгүй шинжилгээг гүйцэтгэж, бүртгэнэ.

Санхүүгийн түрээсийн гэрээнд банк түрээслүүлэгч болж байгаа бол санхүүгийн түрээсээр түрээслүүлсэн хөрөнгөө санхүүгийн байдлын тайланд авлага байдлаар түрээсийн цэвэр хөрөнгө оруулалтын дүнгээр харуулна. Санхүүгийн түрээсээр хөрөнгийн эзэмшилтэй холбоотой бүх эрсдэл, өгөөжийг түрээслэгчид шилжүүлдэг ба түрээслүүлэгч өөрийн хөрөнгө оруулалт, үйлчилгээг нөхөхийн тулд эргүүлэн төлөх үндсэн төлбөр болон санхүүгийн орлогыг түрээсийн авлагад бүртгэнэ. Санхүүгийн түрээсийг данснаас хасах шалгуур нь зээл гэх мэт бусад санхүүгийн хөрөнгийн шалгууртай ижил байна.

Г. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

1) Анхны удаа хэмжих

Зээлийг анх удаа хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр нь үнэлнэ. Зээлийн бодит үнэ цэнд зээл олгохтой шууд холбоотой орлого, зардал шингэнэ. Шууд холбогдох орлого, зардалд шимтгэл, хураамж, урамшуулал гэх мэт уг зээлийг олгохтой шууд холбоотой гарсан ажил гүйлгээний орлого, зардал багтана. НББОУС 39-ийн дагуу шууд холбогдох арилжааны зардал гэж санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийг олж эзэмших, гаргах, борлуулахтай шууд холбоотой өсөн нэмэгдэх зардлыг ойлгоно. Өсөн нэмэгдэх зардал нь банк тухайн санхүүгийн хэрэгслийг олж эзэмшээгүй, гаргаагүй эсвэл борлуулаагүй бол гарахгүй байсан зардал юм.

2) Банкны шимтгэл

НББОУС 18-ын дагуу санхүүгийн үйлчилгээний шимтгэлийн орлогын бүртгэл нь түүний зориулалт, холбогдох санхүүгийн хэрэгслийн бүртгэлийн суурь зэргээс шалтгаалан тодорхойлогдоно. Санхүүгийн үйлчилгээний шимтгэл нь уг ажил үйлчилгээний онцлог шинж, мөн чанарыг агуулахгүй байх тохиолдол гарч болно. Иймээс санхүүгийн хэрэгслийн үр ашигт хүүгийн аргаар тооцсон шимтгэл, үйлчилгээний шимтгэл, тодорхой үйлчилгээ үзүүлсний төлөө авсан хураамж зэргийг ялгаатай авч үзнэ.

1) Үр ашигт хүүгээр тооцох санхүүгийн хэрэгслийн шимтгэл. Дараах шимтгэлийг хойшлуулан бүртгэж, үр ашигт хүүгийн аргаар хорогдуулна:

а. Санхүүгийн хөрөнгийг анх гаргах, эсвэл худалдан авахтай холбоотойгоор төлөгдсөн шимтгэл (origination fees). Ийм шимтгэлд зээлдэгчийн санхүүгийн байдлыг үнэлэх, баталгаа, барьцаа хөрөнгө, үнэт цаасны хэлцлийг үнэлж, бүртгэх, санхүүгийн хэрэгслийн нөхцөлийг харилцан тохиролцох, холбогдох баримтыг бүрдүүлж, боловсруулах, арилжааг хаах зэрэг үйл ажиллагаанд хамаарах хураамж багтана. Ийм шимтгэл болон холбогдох арилжааны зардал (НББОУС 39-д тодорхойлсон) нь санхүүгийн хэрэгслийг бий болгох үйл ажиллагаанд хамаарах ба үүнийг хойшлуулан бүртгэж, үр ашигт хүүгийн аргаар хорогдуулна.

б. Зээлд хамаарах үүрэг хүлээсэн үед зээл олгохтой холбогдуулан банкинд төлөгдсөн шимтгэл. Банк зээлийн тусгай хэлцэл байгуулж, үүнтэй холбоотой зээлд хамаарах үүрэг нь НББОУС 39-ийн хамрах хүрээнд багтаагүй тохиолдолд болзошгүй үүрэгтэй холбоотойгоор төлөгдсөн шимтгэлийг холбогдох арилжааны зардлын (НББОУС 39-д тодорхойлсон) хамт санхүүгийн хэрэгслийг бий болгох үйл ажиллагаанд хамаатай гэж үзэх ба эдгээрийг хойшлуулан бүртгэж, үр ашигт хүүгийн аргаар хорогдуулна. Хэрэв банк зээл олгоогүй байхад уг үүргийн хугацаа дууссан бол хугацаа дууссан өдрөөр шимтгэлийг орлогод бүртгэнэ.

в. Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн өр төлбөрийг гаргах үед төлөгдсөн шимтгэл. Ийм шимтгэл нь санхүүгийн хэрэгслийг бий болгох үйл ажиллагаанд хамаарах орлого юм. Үүнийг холбогдох арилжааны зардлын хамт санхүүгийн хэрэгслийг анх удаад хүлээн зөвшөөрөх үеийн дансны дүнд оруулан тооцох ба эдгээрийг хойшлуулан бүртгэж, үр ашигт хүүгийн аргаар хорогдуулна.

2) Үйлчилгээний шимтгэлийг тайлант үеийн орлогод бүртгэнэ. Үүнд дараах шимтгэл багтана:

а. *Зээлийн үйлчилгээний шимтгэл.* Зээлтэй холбоотой үйлчилгээ үзүүлэх үед төлөгдсөн шимтгэлийг үйлчилгээг үзүүлсэн даруйд орлогод бүртгэнэ.

б. *Зээл олгоход хамаарах болзошгүй үүргийн шимтгэл.* Банк зээлийн тусгай хэлцэл байгуулж, үүнтэй холбоотой зээлд хамаарах үүрэг нь НББОУС 39-ийн хамрах хүрээнд багтсан тохиолдолд болзошгүй үүрэгтэй холбоотойгоор төлөгдсөн шимтгэлийг болзошгүй үүрэг хүлээх хугацаанд орлогоор хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

в. *Хөрөнгө оруулалтын удирдлагын шимтгэл.* Хөрөнгө оруулалтыг удирдахтай холбоотойгоор төлөгдсөн шимтгэлийг үйлчилгээ үзүүлсний дараа орлогод бүртгэнэ. Хөрөнгө оруулалтын удирдлагын гэрээ, үйлчилгээтэй холбоотой шимтгэлийн жишээнүүдийг НББОУС 18-д оруулсан.

3) Тодорхой үйлдлийг гүйцэтгэсний төлөө авсан төлбөр. Холбогдох үйлдлийг хэрэгжүүлж, гүйцэтгэсний дараа ийм шимтгэлийг орлогод бүртгэнэ. Тухайлбал:

а. *Харилцагчид хувьцаа хуваарилах шимтгэл.* Хувьцааг хуваарилсны дараа уг шимтгэлийг орлогод бүртгэнэ.

б. *Зээлдэгч, хөрөнгө оруулагчдын хооронд зээлийн хэлцэл хийхтэй холбоотой төлбөр тооцооны шимтгэл.* Зээлийн хэлцэл хийгдсэний дараа уг шимтгэлийг орлогод бүртгэнэ.

в. *Хамтын зээлжүүлэлтийн шимтгэл.* Зээлийн багцыг бүхэлд нь нөгөө талд шилжүүлж хамтын зээлжүүлэлтийн хэлцлийг зохион байгуулсны төлөө авч буй (эсвэл бусад оролцогчтой ижил үр ашигт хүүгээр тооцсон эрсдэлийн хэсгийг өөртөө үлдээсэн) үйлчилгээний төлбөр юм. Хамтын зээлжүүлэлт хийгдэж дуусаны дараа уг шимтгэлийг орлогод бүртгэнэ.

Банк шимтгэлтэй холбогдуулан дэлгэрэнгүй шинжилгээг хийж, үүнийг НББОУС 18 ба НББОУС 39 -ийн дагуу бүртгэсэн эсэхийг нягтлана.

Зээлдэгчийн хувьд шимтгэлийг дээрхтэй адил ангилж, бүртгэнэ. Өөрөөр хэлбэл банк зээлдэгч болсон тохиолдолд дээр заасны дагуу шимтгэлийг хойшлуулах эсэх болон ямар сууриар хойшлуулахыг тогтооно.

Зарим нөхцөлд төлсөн төлбөр (зээл олгох болон бусад санхүүгийн хөрөнгийг гаргах үед төлсөн) болон авсан шимтгэлийг (санхүүгийн өр төлбөрийг татан төвлөрүүлэх үед төлөгдсөн) санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнд оруулж тооцохгүй. Энэ нь хүүгүй эсвэл зах зээлийн хүүгээс ялгаатай хүүтэй зээл олгох үед тохиолддог. Татан төвлөрүүлсэн зээлийн болон бусад эх үүсвэртэй холбоотойгоор дээрх нөхцөл байдал үүсч болно. Энэ тохиолдолд бодит үнэ цэн нь төлсөн буюу авсан мөнгөн дүнтэй тэнцэхгүй бөгөөд тусгай нөхцөл хангагдаагүй тохиолдолд санхүүгийн хэрэгслийг анх удаад хүлээн зөвшөөрөх үед орлого, зардал хүлээн зөвшөөрч, бүртгэнэ (жишээлбэл, зах зээлийн хүүгээс ялгаатай хүүгийн түвшинг ашигласан тусгай зах зээлийн сегментийг тодорхойлох ба энэ талаар “Бусад санхүүгийн ба санхүүгийн бус өр төлбөр” бүлэгт оруулсан).

<u>3) Зээлийг бодит үнэ цэнээр бүртгэх тохиолдол</u>

НББОУС 39-ийн Ашиглах удирдамжийн НББОУС 39.АУ77 -д зааснаар санхүүгийн хөрөнгийг анх худалдан авах эсвэл санхүүгийн өр төлбөрийг гарган эх үүсвэр татан төвлөрүүлэх нь санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнийг тодорхойлох шаардлагатай зах зээлийн арилжаа юм. Ялангуяа, тухайн санхүүгийн хэрэгсэл нь өрийн хэрэгсэл (тухайлбал, зээл) болох бол түүний бодит үнэ цэнийг арилжаа хийгдсэн өдрийн зах зээлийн нөхцөл байдал болон бусад банкны ижил төстэй өрийн хэрэгслийн (дуусгавар хугацаа, мөнгөн гүйлгээ, валютын төрөл, зээлийн эрсдэл, барьцаа хөрөнгө, хүү тооцох суурь зэргээрээ ижил төстэй) хүүгийн түвшин эсвэл зах зээлийн өнөөгийн нөхцөл байдалтай холбож тодорхойлох боломжтой. Мөн НББОУС 39.АУ64-д зээлийн адил зэрэглэл бүхий ижил төстэй хэрэгслийн (валют, хугацаа, хүүгийн түвшний төрөл, бусад үзүүлэлтээрээ төстэй) давамгайлах зах зээлийн хүүгийн түвшинг ашиглан ирээдүйн мөнгөн орлогын гүйлгээг дискаунтчилан тооцоолж хүүгүй урт хугацаат зээл ба авлагын бодит үнэ цэнийг үнэлдэг жишээг оруулсан. Зээлдүүлсэн бусад нэмэлт дүнг хөрөнгийн бусад төрлөөр хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд зардалд бүртгэх буюу эсвэл орлогыг бууруулж бүртгэнэ.

Жишээ 1: Аж ахуйн нэгжид зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй олгосон зээл

Банк харилцагч Б-д 5 жилийн хугацаагаар 1000 төгрөгийн зээлийг жилийн 5%-ийн хүүтэй олгосон. Уг зээлийг анх удаад хүлээн зөвшөөрөх үед ижил төстэй 5 жилийн хугацаатай зээлийн зах зээлийн хүүгийн түвшин нь жилийн 10% байсан.

Үүний үр дүнд уг зээлийн бодит үнэ цэн нь ирээдүйд төлөгдөх 1000 төгрөг ба жил бүрийн 50 төгрөгийн хүүгийн төлбөрийг зах зээлийн хүү 10%-иар 5 жилийн хугацаагаар дискаунтчилан 810 төгрөг гарсан. Банк уг зээлийг анхны бодит үнэ цэн 810 төгрөгөөр бүртгэх ба энэ дүнг зээлийн

хугацаанд үр ашигт хүүгийн аргаар 1000 төгрөг болтол нэмэгдүүлнэ.

Мөн эдгээрийн зөрүү 190 төгрөгийг зээлийг анх хүлээн зөвшөөрөх үед зардалд бүртгэнэ.

Зээлийг анх удаа хүлээн зөвшөөрөхдөө (20X0 оны 1-р сарын 1):

Дебит: Харилцагчийн зээл 1000
Дебит: Зээл олголтын зардал 190
Кредит: Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэйгээр олгосон зээлийн бодит үнийн залруулга 190
Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө 1000

Дээрх бичилтийн үр дүнд харилцагчийн зээлийн дансанд олгосон зээлийн нэрлэсэн дүнгээр буюу 1000 төгрөгөөр бүртгэсэн боловч зээлийн бодит үнийн залруулга данс сөрөг 190 төгрөгийн үлдэгдэлтэй байгаа тул зээлийн дансны үлдэгдэл эдгээрийн цэвэр дүнгээр буюу 810 төгрөгөөр илэрхийлэгдэнэ.

Жилийн эцсийн журналын бичилт (810*10% - 50 төгрөг):

Дебит: Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэйгээр олгосон зээлийн бодит үнийн залруулга 31
Кредит: Хүүгийн орлого 31

Жилийн эцэст зээлийн хүүгийн төлбөр төлөгдөхөд (20X0 оны 12-р сарын 31):

Дебит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө 50
Кредит: Хүүгийн орлого 50

Нөгөө талаасаа зээлийн хорогдуулсан өртөг 810 төгрөгийг тооцоолоход зах зээлийн хүүгийн түвшин 10%-ийг ашиглан хүүгийн орлогыг тооцоолж гаргана. Өөрөөр хэлбэл 810*10%=81 гарч байна. Энэ нь дээрх хоёр дүнгийн нийлбэртэй тэнцэнэ.

Дээрх бичилтүүдийн дараа зээлийн хорогдуулсан өртөг 841 төгрөг болно (810+31=841).

Дараа жилийн эцсийн журналын бичилт (20X1 оны 12-р сарын 31)

Дебит: Харилцагчийн зээл 34
Кредит: Хүүгийн орлого 34

Жилийн эцэст зээлийн хүүгийн төлбөр төлөгдөхөд (20X1 оны 12-р сарын 31):

Дебит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө 50
Кредит: Хүүгийн орлого 50

Нийт хүүгийн орлого 84 төгрөг болж байна. Үүнийг нөгөө талаас зээлийн хорогдуулсан өртгөөс үр ашигт хүүгийн хувиар тооцоолж гаргана (841*10%=84 төгрөг).

Зээлийн хугацаа дуусахад зээлийн хорогдуулсан өртөг 1,000 болно. 5 жилийн туршид төлөгдсөн хүүн дээр нэмж хүлээн зөвшөөрсөн нийт хүүгийн орлого нь 190 болон ба энэ нь зээлийг анх бүртгэх үед хүлээн зөвшөөрсөн зээл олголтын зардлын дүнтэй тэнцүү байна.

Жишээ 2: Ажилтнуудад олгосон хүүгүй зээл

Банк ажилтнууддаа 1,000 төгрөгийн, 2 жилийн хугацаатай, хүүгүй зээл олгосон. Энэ үед иргэдэд олгох 2 жилийн хугацаатай зээлийн зах зээлийн хүүгийн түвшин нь 10% байсан (өөрөөр хэлбэл, хэрэв иргэн тус банкинд ажилладаггүй тохиолдолд ижил нөхцөл бүхий зээлийг 10%-ийн хүүтэйгээр олгоно).

Ажилтанд олгох энэ зээлийн дүн хоёр хөрөнгөөс бүрдэж байна:

1) Зээлийн бодит үнэ цэн нь $1,000/(1.10)^2 = 826$ төгрөг.
2) НББОУС 19-ийн дагуу зээлийн бодит үнэ цэн ба нэрлэсэн дүнгийн зөрүү 174 төгрөгийг ажилтнуудад олгосон урамшуулал гэж бүртгэнэ. Харилцагчдад олгосон зээлээс ялгаатай нь банк зээлийг анх удаа хүлээн зөвшөөрөхдөө зардал бүртгэхгүй ба харин НББОУС 19 -ийн дагуу бусад санхүүгийн бус хөрөнгөнд багтсан ажилтнуудад олгосон зээлийн урьдчилгааг шулуун шугамын аргаар хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

Зээлийг анх удаа хүлээн зөвшөөрөхдөө (20X0 оны 1-р сарын 1):

Дебит: Зээлийн холбогдох данс 1000
Кредит: Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэйгээр олгосон зээлийн бодит үнийн

залруулга 174

Дебит: Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэйгээр ажилтнуудад олгосон зээлийн урьдчилгаа 174

Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө 1000

Жилийн эцсийн журналын бичилт (20X0 оны 12-р сарын 31):

Дебит: Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэйгээр олгосон зээлийн бодит үнийн залруулга 83

Кредит: Хүүгийн орлого 83

Зээлийн хорогдуулсан өртөг 826-г гаргахад ашигласан зах зээлийн хүүгийн түвшин 10%-иар хүүгийн орлогыг тооцоолно. Хэдийгээр нэрлэсэн хүүгийн түвшин 0% -тай байсан ч СТОУС-ын дагуу зах зээлийн хүүг ашиглан хүүгийн орлогыг тооцоолж, бүртгэнэ.

Мөн ажилтнуудад олгосон зээлийн урьдчилгааг ажилтнуудтай холбоотой зардалд бүртгэнэ:

Дебит: Ажилтнуудтай холбоотой зардал 87

Кредит: Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэйгээр ажилтнуудад олгосон зээлийн урьдчилгаа 87

Зээлийн хугацаа 2 жил тул ажилтнуудтай холбоотой зардлыг олгосон урьдчилгаа 174 -ийн 50%-иар буюу шулуун шугамын аргаар тооцоолно. Ажилтнуудад олгосон урьдчилгааг шулуун шугамын аргаар хуваарилж байхад хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргаар хуваарилж байгаа тул орлогын тайланд тодорхой үр нөлөөлөл үзүүлэх боловч эдгээрийн зөрүү харьцангуй бага дүнтэй (87 – 83 = 4) гарах тул тохируулга хийхгүй.

Дараа жилийн эцэст хийгдэх журналын бичилт (20X1 оны 12-р сарын 31)

Дебит: Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэйгээр олгосон зээлийн бодит үнийн залруулга 91

Кредит: Хүүгийн орлого 91

Зээлийн хорогдуулсан өртөг 909 (826+83) -ийг гаргахад ашигласан зах зээлийн хүүгийн түвшин 10%-иар хүүгийн орлогыг тооцоолно. Иймд 20X1 оны 12-р сарын 31 буюу зээлийн хугацааны эцэст зээлийн хорогдуулсан өртөг түүний нэрлэсэн үнэ 1,000 (909+91) төгрөгтэй тэнцүү болно.

Мөн ажилтнуудад олгосон урьдчилгааг ажилтнуудтай холбоотой зардалд бүртгэнэ (ажилтнуудад олгосон урьдчилгааны 50%):

Дебит: Ажилтнуудтай холбоотой зардал 87

Кредит: Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэйгээр ажилтнуудад олгосон зээлийн урьдчилгаа 87

Үүний үр дүнд зээлийн хугацаа дуусахад ажилтнуудад олгосон зээлийн урьдчилгаа тэг үлдэгдэлтэй болно. 20X1 оны орлогын тайланд үүсэх үр нөлөөлөл нь 4 (91 – 87). Зээлийн хугацаанд орлогын тайлангийн нийт үр нөлөөлөл тэг болно (хүүгийн орлого 174 (83+91) -ыг ажилтнуудтай холбоотой зардал 174 (87+87) - тай харьцуулахад).

Зах зээлийн хүүгээс ялгаатай хүүтэй зээлийг дээр оруулсан хүүгүй зээлийн нэгэн адил бүртгэнэ. Гол онцлог нь зээлийн бодит үнэ цэнийг тооцоолохдоо зээлийн үндсэн өр болон хүүгийн нэрлэсэн хүүгийн түвшинг аль алиныг ашиглан зээлийн эргэн төлөлтийн мөнгөн гүйлгээг дискаунтчилан тооцдог.

Хэрэв зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй зээлийг харилцагчид буюу гуравдагч талд олгосон (зах зээлийн хүү 20% байх үед 10%-ийн хүүтэй зээл олгох) тохиолдолд банк уг зээлийг анх удаа хүлээн зөвшөөрөх үед зардалд бүртгэнэ. Ингэснээр бүртгэлд тусгах хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан зах зээлийн хүүгийн түвшин 20%-иар тооцоолох ба энэ нь нэрлэсэн хүүгийн 10%-иар тооцоолж гаргаад төлсөн буюу төлөгдсөн хүүгийн орлоготой харьцуулахад өндөр байна. Гэхдээ зээлийн хугацаанд орлогын тайланд үзүүлэх үр нөлөөлөл тэг болох ба харин тайлант жил тус бүрт зөрүүтэй нөлөөлөл үүснэ. Дээрх жишээнд тайлбарласнаар ийм зээлийг ажилтнуудад олгосон тохиолдолд зээлийг анх бүртгэх үеийн зардлыг ажилтнуудад олгосон зээлийн урьдчилгаанд бүртгэж, бусад санхүүгийн бус хөрөнгөөр тайлагнана. Хүүгийн орлогыг харилцагчдад олгосон зээлийн хүүгийн орлогын нэгэн адил бүртгэнэ. Гол ялгаа нь ажилтнуудад олгосон зээлийн урьдчилгааг зээлийн хугацаанд шулуун шугамын аргаар хорогдуулах ба хорогдуулсан зардлыг ажилтнуудтай холбоотой зардалд бүртгэнэ. Иймд дээрх жишээтэй яг адил бүртгэнэ.

Харилцагчдад буюу гуравдагч талд (банкны охин компани, санхүүжигчдээс бусад этгээд) зах зээлийн

хүүгээс өндөр хүүтэй зээл олгох үед зээлийг анх бүртгэхдээ орлого хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Жишээлбэл, зах зээлийн хүү 10% байх үед 20%-ийн хүүтэй зээл олгох. Энэ тохиолдолд банк хүүгийн орлогыг нэрлэсэн хүүгээс бага хүүгийн хувь (зах зээлийн хүүгийн түвшин) -иар тооцоолох ба өөрөөр хэлбэл бүртгэлд тусгах хүүгийн орлогын дүн нь төлсөн буюу төлөгдсөн хүүгийн орлоготой харьцуулахад бага байна. Зээлийг анх удаад хүлээн зөвшөөрөх бодит үнэ цэнийн тооцоолол болон зах зээлийн хүүгийн түвшинг ашиглан хүүгийн орлогыг тооцоолох нь дээрх жишээтэй адилхан байна. Харин журналын бичилт нь дээрхээс ялгаатай ба үүнийг доор харуулав. Мөнгөн дүнг тайлбар хийх зорилгоор оруулав.

Зээлийг анх бүртгэхдээ:

Дебит: Харилцагчийн зээл 1000
Дебит: Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэйгээр олгосон зээлийн бодит үнийн залруулга 400
Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө 1000
Кредит: Зээл олголтын орлого 400

Эхний жилийн эцэст:

Дебит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө 200
(зээлийн нэрлэсэн дүн 1000 -аас 20%-иар тооцож гарган, авсан хүү)
Кредит: Хүүгийн орлого 140
(үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүү: хорогдуулсан өртөг 1400-аас зах зээлийн хүүгийн түвшин 10%-иар тооцоолсон хүү)
Кредит: Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэйгээр олгосон зээлийн бодит үнийн залруулга 60

Ажилтнуудад олгосон зээлтэй холбоотойгоор “Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэйгээр олгосон зээлийн бодит үнийн залруулга”, “Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэйгээр ажилтнуудад олгосон зээлийн урьдчилгаа” дансдад бүртгэсэн дүнг үр ашигт хүүгийн болон шулуун шугамын аргуудын аль тохиромжтойг ашиглан хорогдуулна. Ажилтнуудад олгосон зээлийг гол төлөв зах зээлийн хүүгийн түвшинд, эсвэл зах зээлийн хүүгээс доогуур хүүтэйгээр олгодог тул зах зээлийн хүүгээс дээгүүр хүүтэй зээлийн бүртгэл үүнд хамаарахгүй.

4) Дараа үеийн хэмжилт

Гадаад валютаар олгосон зээлийг Монголбанкнаас зарласан албан ханшаар тооцож төгрөгт хөрвүүлэн төгрөг, гадаад валютаар давхар бүртгэх ба ханшийн хэлбэлзлээс үүсэх зөрүүг гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого, зардалд бүртгэнэ.

Санхүүгийн тайланд зээлийг хорогдуулсан өртгөөр үнэлж, тайлагнана. Зээлийн хорогдуулсан өртөг нь зээлийг анх хүлээн зөвшөөрч хэмжсэн дүн (бодит үнэ цэн)-ээс буцаан төлсөн зээлийн үндсэн төлбөрийн төлөлтийг хасч, хойшлогдсон орлого, зардлыг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулан хуримтлуулсан дүнг хасах буюу нэмж, зээлийн эрсдэлийн санг хассан дүн юм.

Зээлийн хүүгийн орлогыг зээлийн гэрээ, холбогдох заавар, журамд заасан хувиар тооцоолж, хуримтлуулан бүртгэнэ. Хуримтлуулан тооцсон хүүгийн авлагыг зээлийн хорогдуулсан өртөгт оруулж, тайлагнана. Зээлийн хойшлогдсон шимтгэлийг тусдаа дансанд бүртгэж, зээлийн үлдэгдлийг бууруулан тайлагнана.

5) Санхүүгийн түрээс

Санхүүгийн түрээсийн авлагыг ирээдүйд төлөгдөх түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр бүртгэнэ. Түрээслүүлэгч түрээстэй холбоотой санхүүгийн орлогыг түрээсийн хугацаанд системтэй бөгөөд үндэслэлтэй суурьяр хуваарилна. Орлогыг хуваарилахдаа санхүүгийн түрээст багтсан түрээслүүлэгчийн цэвэр хөрөнгө оруулалтын тогтмол өгөөжийг тусгасан шинж чанарт үндэслэнэ. Тайлант хугацааны үйлчилгээний зардлыг оруулаагүй түрээсийн төлбөрийг үндсэн зээлийн үлдэгдэл ба хэрэгжээгүй санхүүгийн орлогыг хоёуланг нь бууруулж, нийт хөрөнгө оруулалтанд ашиглана.

6) Зээлийн үнэ цэнийн бууралтыг тооцох

Банк зээлийн эрсдэлийн сангийн зардал (үнэ цэнийн бууралт)-ыг тооцохдоо Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ыг баримтлан сар бүр зээлийн эрсдэлийн санг байгуулна. Түүнчлэн тайлант жилийн эцэст СТОУС-ын дагуу зээлийн үнэ цэнийн бууралтыг тооцож болно (НББОУС 39).

СТОУС (НББОУС 39)-ын дагуу зээлийн үнэ цэнийн бууралтыг тооцоолох зорилгоор бүх төрлийн

зээлийг хоёр бүлэгт хуваана:

- Тусгайлан авч үзэх зээл
- Бүлгээр авч үзэх зээл

Банк тусгайлан болон бүлгээр авч үзэх зээлийг тодорхойлох бодлогыг дотооддоо боловсруулж, мөрдөнө. Тусгайлан авч үзэх зээл гэж үнэ цэн нь буурсан тохиолдолд банкны зээлийн багцын чанар болон цэвэр ашигт мэдэгдэхүйц нөлөөлдөг зээлийг ойлгоно. Банк тусгайлан авч үзэх зээлийг тодорхойлохдоо дараах зүйлсийг харгалзана:

- Тусгайлан авч үзэх зээл гэж тухайн банкны түвшинд ач холбогдолтой гэж үзсэн зээл (жишээлбэл, банкны Зээлийн хороо эсвэл удирдлагын зүгээс зээлийн эрсдэлийн түвшинг тогтоосон).
- Банк өөрийн хөрөнгө болон үйл ажиллагааны ашгийн тодорхой хувь хэмжээтэй харьцуулж, тусгайлан авч үзэхээр тогтоосон зээл.

Юуны өмнө банк тусгайлан авч үзэх зээлийн хувьд ганцаарчилсан байдлаар, бүлгээр авч үзэх зээлийн хувьд ганцаарчлан эсвэл бүлэглэн, үнэ цэнийн бууралтын бодитой нотолгоо байгаа эсэхийг үнэлнэ. Хэрэв санхүүгийн хөрөнгийн үнэ цэн буурсан гэх бодитой нотолгоо банкинд олдоогүй тохиолдолд тусгайлан авч үзсэн эсэхээс үл хамааран зээлийн эрсдэлийн шинж чанараараа ижил төстэй санхүүгийн хөрөнгийн хамт бүлэглэж, үнэ цэнийн бууралтыг нь бүлгийн аргаар тооцоолно. Харин тусгайлсан аргаар үнэ цэнийн бууралтыг тооцоолж, эрсдэлийн сан байгуулсан хөрөнгийг бүлгийн үнэлгээнд хамруулахгүй. Тусгайлсан үнэлгээгээр тооцоолсон эрсдэлийн сангийн зардал ба бүлгээр үнэлсэн эрсдэлийн сангийн зардлын нийлбэрээр эрсдэлийн сангийн зардал тодорхойлогдоно.

Тусгайлсан үнэлгээний аргаар зээлийн үнэ цэн бууралтыг тооцох

Банк тусгайлан авч үзэхээр тогтоосон зээл бүрийн хувьд үнэ цэн буурсан болохыг нотлох нөхцөл байдал үүссэн эсэхийг шалгах ба үүнд дараах зүйлс багтаж болно:

- Зээлдэгч буюу үүрэг хүлээгч санхүүгийн томоохон хүндрэлд орсон,
- Гэрээг зөрчих, тухайлбал: хүү ба зээлийн өрийн үлдэгдлийг хойшлуулах буюу төлөхгүй байх,
- Зээлдэгчийг санхүүгийн хүндрэлд оруулах гадаад хүчин зүйл, тухайлбал: эдийн засаг, хууль эрх зүйн хүчин зүйлээс шалтгаалан зээлдүүлэгч нь зээлдэгчтэй зөвшилцөн шийдэлд хүрэх боломжгүй болох,
- Зээлдэгч дампуурах гэж байгаа эсвэл санхүүгийн бүтцийн өөрчлөлт хийх магадлалтай байгаа,
- Улс орны эдийн засгийн хямралаас шалтгаалан тухайн санхүүгийн хөрөнгийн зах зээл идэвхгүй болсон.

Хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тооцохдоо зөвхөн нэг хүчин зүйлийг ашиглахгүй, хэд хэдэн хүчин зүйлсийн нөлөөллийг харгалзана.

Банк зээлийн үнэ цэнийн бууралтыг тооцох, эрсдэлийн санг байгуулах тухай заасан дотоод журамдаа үнэ цэнийг бууруулах үйлдлийг тодорхойлж, тусгайлан авч үзэх зээлд үнэ цэн бууралтын шалтгаан, үнэлсэн үнэлгээгээ баримтжуулсан байх талаар дурдана. Үнэ цэнийн бууралтыг зөвхөн хугацаа хэтэрсэн хоног болон чанарын хүчин зүйлээр хязгаарлалгүй үнэ цэнийн бууралтын нэмэлт үзүүлэлтийг ашиглана. Хүүгийн төлбөр төлөгдөхгүй хойшлогдох болон анхнаасаа төлөгдөхгүй гэж үзээд хугацааг нь үргэлжлүүлэн сунгах зээл (rollover) зэргийг үнэ цэнийн бууралтын шалтгаан гэж үзнэ. Мөн тусгайлан авч үзэх зээлийг гэрээний дагуу төлж барагдуулахтай холбогдуулан зээлдэгчийн байдлын талаарх тоон болон чанарын шинжилгээг хийнэ (санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, зээлдэгчийн үйл ажиллагааны орчин гэх мэт).

Тусгайлан авч үзэх зээлийн хувьд үнэ цэнийн бууралтыг зээл тус бүрээр тодорхойлох бөгөөд үнэ цэнийн бууралтыг зээлийн дансны үлдэгдэл болон ирээдүйд орж ирэх төлбөрийн өнөөгийн үнэ цэнийн (зээлийн анхны үр ашигт хүүгээр эсвэл тогтмол биш хүүтэй зээлийн хувьд одоогийн үр ашигт хүүгээр дискаунтчилсан зээл, түүний шимтгэл, хураамжийн дүнг оруулж тооцосон) зөрүүгээр тооцоолно. Үүнийг томьёогоор илэрхийлбэл:

Үнэ цэнийн бууралт = Ирээдүйд орж ирэх төлбөрийн өнөөгийн үнэ цэн – Зээлийн дансны үлдэгдэл

Энэ тооцооллыг хийхийн тулд ирээдүйд орж ирэх төлбөрийн хүлээгдэж буй мөнгөн дүн, түүний хугацааг үнэлнэ. Уг үнэлгээг хийхдээ дараах зүйлсийг анхаарна:

- Зээлдэгчээс төлөгдөх дүн (үндсэн төлбөр, хүү, шимтгэл, хураамжийг оруулсан);
- Батлан даагч этгээдээс төлөгдөх дүн (үндсэн төлбөр, хүү, шимтгэл, хураамжийг оруулсан);

- Барьцаат хөрөнгийг худалдаж нөхөгдөх дүн;
- Барьцаат хөрөнгийн бодит үнэ цэн;
- Зээлдэгчээс бусад төрлийн хөрөнгө авах замаар нөхөгдөх дүн (гэхдээ авах хөрөнгө нь хөрвөх чадвар сайтай тохиолдолд хөрөнгийг худалдаж орсон мөнгөний дүн ба хугацааг оруулж тооцоно);

Дээрх дүн, тэдгээрийн хугацааг бодитой бөгөөд найдвартай суурьяр үнэлнэ. Ялангуяа, барьцаа хөрөнгийг худалдаад орох мөнгөн гүйлгээний хугацааг үнэлэхдээ тухайн барьцаа хөрөнгийг олж, эзэмших болон худалдахтай холбоотой тодорхой хязгаарлалтыг харгалзан үзнэ.

$$\text{Ирээдүйд орж ирэх төлбөрийн өнөөгийн үнэ цэн} = \sum \frac{\text{Хүлээгдэж буй төлбөр}}{(1+\text{сарын хүү})^{\text{Зээлийн хугацаа /сараар/}}}$$

Эргэн төлөгдөх эсэх нь тодорхойгүй байгаа зээлийн хувьд орж ирэх мөнгөний дүн ба хугацааг үнэлж чадаж байгаа бол үнэ цэнийн бууралтыг тодорхойлох боломжтой болно. Тооцоололд ашиглах хүлээгдэж буй мөнгөн төлбөр нь санхүүгийн хэрэгслийн гэрээний мөнгөн дүн бөгөөд тайлагналын өдрөөр гарсан зардал, хугацаа өөрчлөгдөх таамаглал зэрэгт үндэслэнэ.

Жишээ: Мөнгөн гүйлгээний дүн, хугацаа өөрчлөгдсөний улмаас үүссэн үнэ цэнийн бууралт

Санхүүгийн хүндрэлийн улмаас харилцагч В зээлийн үлдэгдэл ба хүүгийн төлбөрийг хугацаанд нь барагдуулж чадахгүй болсон гэж банк үзээд зээлийн гэрээг шинэчлэн хийхээр болсон. Харилцагч В доор дурдсан зээлийн нөхцлийг өөрчлөх 5 тохиолдлын аль нэгийг хангасан байж болзошгүй гэж банк таамаглаж байгаа.

- Харилцагч В зээлийн үндсэн өрийг гэрээний хугацаанаас хойш 5 жилийн дараа бүрэн барагдуулах ба хүүгийн төлбөрийг хугацаанд нь төлөхгүй.
- Харилцагч В зээлийн үндсэн өрийг гэрээний хугацаанд бүрэн барагдуулах ба хүүгийн төлбөрийг хугацаанд нь төлөхгүй.
- Харилцагч В зээлийн өрийг гэрээний хугацаанд багтаан бүрэн барагдуулах боловч хүүгийн төлбөрийг гэрээнд зааснаас бага хувиар тооцож төлнө.
- Харилцагч В зээлийн өр, түүнд хуримтлуулан тооцсон хүүг гэрээний хугацаа өнгөрснөөс хойш 5 жилийн дараа бүрэн барагдуулах боловч гэрээг сунгасан хугацаанд хүү төлөхгүй.
- Зээлийн гэрээг 5 жилээр сунгаж, харилцагч В зээлийн үндсэн өр ба хүүг сунгагдсан хугацаанд бүрэн төлж барагдуулна.

Харилцагч В санхүүгийн хүндрэлд орсон нь үнэ цэн буурсан гэх бодитой нотолгоо болох тул зээлийн үнэ цэнийг бууруулна. Энэ тохиолдолд зээлийн эрсдэлийн сангийн зардлын дүнг зээлийн дансны дүн болон ирээдүйд орж ирэх мөнгөн төлбөрийн өнөөгийн үнэ цэнийн зөрүүгээр тооцоолно. Дээр дурдсан тохиолдлын эхний дөрвөн тохиолдлын хувьд ирээдүйд төлөгдөхөөр хүлээгдэж буй зээлийн өрийн үлдэгдэл ба хүүгийн төлбөрийг зээлийн анхны үр ашигт хүүгээр дискаунтчилж гаргасан өнөөгийн үнэ цэн нь зээлийн дансны дүнгээс бага гарч байна. Энэ зөрүүгээр зээлийн эрсдэлийн сангийн зардлыг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Хамгийн сүүлийн тохиолдолд зээлийн төлбөрийг барагдуулах хугацаа өөрчлөгдсөн хэдий ч банк хүү үргэлжлүүлэн авсаар байх тул ирээдүйд төлөгдөх зээлийн үлдэгдэл өр ба хүүгийн төлбөрийг зээлийн анхны үр ашигт хүүгээр дискаунтчилж гаргасан өнөөгийн үнэ цэн зээлийн дансны дүнтэй тэнцүү байх болно. Иймд энэ тохиолдолд уг зээлд эрсдэлийн сан байгуулахгүй.

Жишээ: Тогтмол хүүтэй зээлийн үнэ цэнийн бууралтыг СТОУС-ын дагуу тооцоолох

20X5 оны 1-р сарын 1-нд А банк 10 жилийн хугацаатай, 7%-ийн хүүтэй, 1 сая төгрөгийн зээлийн бүтээгдэхүүнийг гаргасан. Зээлдэгч уг зээлийг жил бүр тэнцүү 142,378 төгрөг төлсөөр 20Y4 оны 12-р сарын 31-нд бүрэн барагдуулна. А банк зээлдэгчээс зээл олгохтой холбоотой шимтгэлийг 1.25%-иар (12,500) авсан ба зээл олголттой шууд холбоотой зардалд 25,000 төгрөг төлсөн.

Зээлийг анх бүртгэх дансны дүнг дараах байдлаар тооцоолно:

Зээлийн үндсэн төлбөр	1,000,000
Зээлдэгчийн төлсөн шимтгэл	(12,500)
Зээлдүүлэгчийн төлсөн зардал	25,000
Зээлийн дансны үнэ	1,012,500

Зээлийн хугацаанд ашиглагдах үр ашигт хүүг тооцоолохдоо дансны дүнгээс тогтмол хувь хэмжээгээр авах ба энэ нь 142,378 төгрөгийн 10 удаагийн төлбөрийг дискаунтчилаад 1,012,500 төгрөг гаргах хүүгийн хувь хэмжээ бөгөөд ойролцоогоор 6.7322% болсон. Зээлийн хугацааны эцэс хүртэлх дансны үнийн тооцооллыг дараах байдлаар хийнэ:

	Мөнгөн гүйлгээ	**Хүүгийн орлого * 6.7322%**	**Дансны дүн**
20X5 оны 1-р сарын 1			1,012,500
20X5 оны 12-р сарын 31	142,378	68,164	938,286
20X6 оны 12-р сарын 31	142,378	63,167	859,075
20X7 оны 12-р сарын 31	142,378	57,835	774,531
20X8 оны 12-р сарын 31	142,378	52,143	684,296
20X9 оны 12-р сарын 31	142,378	46,068	587,987
20Y0 оны 12-р сарын 31	142,378	39,584	485,193
20Y1 оны 12-р сарын 31	142,378	32,664	375,479
20Y2 оны 12-р сарын 31	142,378	25,278	258,379
20Y3 оны 12-р сарын 31	142,378	17,395	133,396
20Y4 оны 12-р сарын 31	142,378	8,982	–
	1,423,780	**411,280**	

Аж үйлдвэрийн салбарын бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалан зээлдэгч санхүүгийн хүндрэлд орж, зээлийн зэрэглэл буурах нь 20X9 оны 12-р сарын 31-нд тодорхой болсон. Энэ өдөр анхны үр ашигт хүү 6.7322% -ээр тооцоолсон зээлийн хорогдуулсан өртөг нь 583,435 төгрөг болно.

Банк дээрх бодитой нотолгоонд үндэслэн зээлдэгч үлдсэн 5 жилд төлөх жилийн 142,378 төгрөгийн төлбөрийг барагдуулах боломжгүй болсон гэж тогтоосон. Иймээс банк зээлийн гэрээний нөхцлийг өөрчилж, 20Y0 оны 12-р сарын 31 хүртэл төлөгдөх төлбөрийг 20Y3 оны 12-р сарын 31 хүртэл сунгаж, жил бүр 175,000 төгрөгийг сүүлийн гурван жилд төлөхөөр болгосон. Үүнээс шалтгаалан хүүгийн түвшин 6.3071% болж буурсан. 20Y1, 20Y2, 20Y3 онуудын 12-р сарын 31-нд төлөгдөх 175,000 төгрөгийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнийг анхны үр ашигт хүүгийн түвшин 6.7322% -ийг ашиглаж тооцоолоход 432,402 төгрөг гарсан. Тооцооллыг доор харуулав.

		Хүлээгдэж буй эргэн төлөлт (А)	20X9 оны 12-р сарын 31-ний өнөөгийн үнэ цэн (Б)	Өнөөгийн үнэ цэнийн тооцоололд ашигласан томъёо
20Y0 оны 12-р сарын 31	Зээл төлөлт	0	0	B = A/(1+6.73%)^1
20Y1 оны 12-р сарын 31	Зээл төлөлт	175,000	153,620	B = A/(1+6.73%)^2
20Y2 оны 12-р сарын 31	Зээл төлөлт	175,000	143,930	B = A/(1+6.73%)^3
20Y3 оны 12-р сарын 31	Зээл төлөлт	175,000	134,852	B = A/(1+6.73%)^4
Хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэн			**432,402**	
Хамгийн анхны үр ашигт хүү	6.73%			

Иймд банк 151,033 (583,435 – 432,402) төгрөгийн эрсдэлийн сангийн зардлыг 20X9 оны 12-р сарын 31-нд бүртгэнэ. Тэгэхээр зээлийн дансны дүн эрсдэлийн сангийн дүнгээр буурна.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэн бууралттай холбоотойгоор барьцаа хөрөнгийн ирээдүйн хүлээгдэж буй мөнгөн төлбөрийн өнөөгийн үнэ цэнийг тооцоолохдоо барьцаа хөрөнгийг худалдаад орох дүнгээс уг хөрөнгийг олж эзэмших болон худалдан борлуулах зардлыг хассан цэвэр дүнг ашиглана. Ирээдүйн хүлээгдэж буй төлбөр ба хүүгийн төлбөрийг зээлийн анхны үр ашигт хүүгээр дискаунтчилж гаргасан өнөөгийн үнэ цэнийн зөрүүгээр үнэ цэнийн бууралтын хувь хэмжээг тооцоолно.

Жишээ: СТОУС-ын дагуу үнэ цэнийн бууралт тооцоолж, эрсдэлийн сан байгуулах - Барьцаат хөрөнгө

Зээл, түүний хуримтлуулсан хүүгийн дансны үлдэгдэл 9.5 сая төгрөг

Зээлийн хүү= 10%

Зээлдэгчийн баталгаа бүхий мөнгө 0.25 сая төгрөг

Нэг жилийн дотор чөлөөлөгдөх барьцаа 10 сая төгрөг

Тооцоолол:

Барьцаа, 10%-иар дискаунтчилсан дүн * (100/110) = 9.090909 сая төгрөг
Мөнгөний үнэ цэн (дискаунтчилаагүй) = 0.25 сая төгрөг
Нийт дүн = тооцоолсон мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэн = 9.340909 сая төгрөг

Харьцуулах нь:

Зээл, түүний хуримтлуулсан хүүгийн дансны үлдэгдэл = 9.5 сая төгрөг

Эрсдэлийн сангийн зардал = 0.159091 сая төгрөг

Зээл, түүний хүүгийн дансны үлдэгдэл тооцоолсон мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнээс (9.340909 сая) бага гарвал үнэ цэн буураагүй гэж үзнэ. СТОУС-д заасны дагуу тусгайлсан үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илэрч байгаа эсэхээс шалтгаалан эрсдэлийн сангийн зардлыг хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн үнэт цаасны үнэ цэнийн бууралтанд дээрх арга зүйг мөн ашиглана.

Хэрэв зээлийн хугацаанд зах зээлийн хүүгээс хамааран хүүгийн түвшинг өсгөсөн эсвэл бууруулсан тохиолдолд уг зээлийг тогтмол бус хүүтэй зээлээр бүртгэх ба ингэснээр эрсдэлийн сангийн зардлыг тодорхойлох дискаунтын түвшин нь гэрээний дагуу тогтоосон одоогийн үр ашигт хүү байх юм.

Бүлгийн аргаар зээлийн үнэ цэнийн бууралтыг тооцох

Үнэ цэнийн бууралтыг бүлгийн аргаар үнэлэхдээ гэрээнд заасан хугацаанд зээлийн бүх төлбөрийг төлөх зээлдэгчийн чадварт үндэслэн зээлийн эрсдэлийн ижил төстэй шинж чанарт суурилна (жишээлбэл: хөрөнгийн төрөл, аж үйлдвэрийн салбар, газар зүйн байршил, барьцаа хөрөнгийн төрөл, төлбөрийн хугацаа хэтэрсэн байдал, бусад холбогдох хүчин зүйлийг харгалзан тогтоосон зэрэглэл эсвэл зээлийн эрсдэлийн үнэлгээ зэрэгт үндэслэнэ). Үнэлж буй зээлийн гэрээний нөхцлийн дагуу хойшлогдсон төлбөрийн дүнг зээлдэгч барагдуулах боломжтойг харуулах замаар зээлийн бүлгийн ирээдүйн мөнгөн гүйлгээний үнэлгээг сонгож авсан хүчин зүйлстэй холбож үзнэ. Гэхдээ бүлгээр үнэлэх болон ганцаарчлан үнэлэхээс шалтгаалан гарах магадлалтай зардал ба бусад үзүүлэлтүүдийг дараах байдлаар ангилна а) үнэ цэнийн бууралтыг тусгайлан үнэлж, үнэ цэн буураагүй гэж тогтоосон, б) үнэ цэнийн бууралтыг нь бүлэглэн үнэлсэн тул үнэ цэнийн бууралтыг багцын дүнгээр бүртгэнэ. Хэрэв банкинд адил төстэй шинж чанар бүхий хөрөнгүүдийн бүлэг байхгүй тохиолдолд нэмэлт шинжилгээ хийх шаардлагагүй.

Үнэ цэнийн бууралтыг бүлэглэн үнэлэх үед эрсдэлийн сангийн зардлыг тусгайлан тодорхойлох нь бүлэглэсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тооцох үйл ажиллагааны завсрын үйлдэл юм. Бүлэгт багтсан боловч үнэ цэнийн бууралтыг тусгайлан үнэлэх мэдээлэл олдсон даруйд уг хөрөнгийг бүлгээс хасна.

Үнэ цэнийн бууралтыг бүлэглэн үнэлдэг санхүүгийн хөрөнгүүдийн бүлгийн ирээдүйн мөнгөн гүйлгээг тухайн бүлэгт багтсан хөрөнгөтэй зээлийн эрсдэлийн шинж чанараараа ижил хөрөнгийн хувьд түүхэн зардлын суурриар үнэлнэ. Хангалттай мэдээлэл хуримтлуулж амжаагүй банк санхүүгийн хөрөнгийн зэрэгцүүлэгдэх бүлгийн хувьд адил тэгш бүлгийн мэдээллийг ашиглана. Урьд өмнө тохиолдож байгаагүй нөхцөл байдал болон өмнө нь байсан боловч одоо байхгүй болсон нөхцөл байдлын нөлөөллийг арилгахын тулд одоо байгаа мэдээлэлд суурилан өмнө гарч байсан зардлыг тохируулна. Ирээдүйн мөнгөн гүйлгээний өөрчлөлтийг үнэлэхдээ тайлант хугацаа бүрт хамаарах өөрчлөлтүүдийн үр нөлөөг харгалзана (ажилгүйдлийн түвшин, үл хөдлөх хөрөнгийн үнэ, барааны үнэ, төлбөрийн статус, зардал үүсгэх бусад хүчин зүйлсийн өөрчлөлт). Үнэлсэн зардал ба бодит зардлын хоорондох зөрүүг бууруулах зорилгоор ирээдүйн мөнгөн гүйлгээг үнэлэхэд ашигласан арга зүй, төсөөллийг байнга шалгаж байна.

Банк НББОУС 39-ийн шаардлагыг хангаж буй зүйлд багцын үнэлгээг хийхдээ тогтсон загвар ашиглана. Хэрэглэгдэх загварт эрсдэлийн шинж чанараараа ижил төстэй хөрөнгүүдийн бүлэгт хамаарах өнгөрсөн хугацааны зардал болон одоогийн нөхцөл байдлыг тусгасан мэдээлэлд үндэслэн хөрөнгийн бүлэг бүрийг тодорхойлно.

Загварт ашиглагдах нэр томъёо:

Төлбөр төлөгдөхгүй байх магадлал (PD) гэж тодорхой цаг хугацаанд зээлийн хэдэн хувь нь чанаргүй болохыг илэрхийлэх хувь хэмжээг хэлнэ.

Алдагдал үүсэх магадлал (LGD) гэж зээл чанаргүй болж, төлбөр төлөгдөөгүй тохиолдолд гарахаар хүлээгдэж буй алдагдлын хувь хэмжээг хэлнэ.

Алдагдал тодорхойлох хүчин зүйл (LIP) гэж эрсдэлийн сангийн зардал гарсан өдөр ба алдагдал гарч болзошгүй өдрийн хоорондох хугацааг хэлнэ.

Арга зүй:

Банк хоёр шалтгааны улмаас зээлийн эрсдэлийн санг тооцохдоо зээлийг бүлэглэх шаардлагатай болдог.

i) зээлийн багцад багтсан бүх зардлыг мэдэх боломжгүй (мэдээлэлд харгалзах цаг хугацаанаас шалтгаалан)

ii) зээл тус бүрийн үнэ цэнийн бууралтыг бодитойгоор тусгайлсан үнэлгээний аргаар тооцоолох боломжгүй (ажилтан/нөөц/мэдээлэл дутагдсанаас шалтгаалан)

Банк түүхэн болон статистикийн загварыг ашиглан зээлийг бүлэглэн тооцож эрсдэлийн санг тогтоооно.

Зээлийг багцлах:

Бүлэглэн авч үзэх зээлийн үнэ цэнийн бууралтыг LIP, PD, LGD зэрэг үзүүлэлтийг харгалзан ижил төстэй шинж чанараар нь ангилан үнэлнэ (иргэд/жижиг бизнес эрхлэгч/том компани/засгийн газрын байгууллага, газар зүйн бүс нутгаар гэх мэт). Үнэ цэнийн бууралтыг тусгайлан үнэлсэн бөгөөд үнэ цэн буурсан гэх шинж тэмдэг илрээгүй зээлүүдийг ижил төстэй шинж чанараар нь сагсанд хуваана. Ганцаарчилсан үнэлгээгээр үнэ цэн буурсан болох нь тогтоогдсон бөгөөд үнэ цэнийн бууралтыг нь ирээдүйн мөнгөн төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр тооцсон зээлийг бүлэглэн тооцох үнэлгээнд оруулахгүй.

Бүлгээр авч үзэх зээл ба үнэ цэнийн бууралтыг тусгайлан тодорхойлсон зээлийг LIP, LGD зэрэг үзүүлэлтийг харгалзан ижил төстэй эрсдэлийн шинж чанараар (төлбөр төлөгдөөгүй зээлийн үлдэгдэл, хүүгийн төлбөр гэх мэт) нь ангилан, тэдгээрийг бүлгээр авч үзэх зээлийн дэд ангилал гэж үзэж үнэлнэ. Ийм зээлийн PD 100% гарна.

Ижил төстэй эрсдэлийн шинж бүхий зээлийг багцлахдаа нарийвчилсан түвшинд гүйцэтгэх ба энэ нь банкны зээлийн эрсдэлийн удирдлагын онцлогоос шалгатгаална. Багцлахдаа матрицан сууриар буюу зээлдэгчийн харъяалагдах аж үйлдвэрийн салбар ба төлбөрийн байдал зэрэгт үндэслэн гүйцэтгэнэ.

Дараах үзүүлэлтээр багцалж болно:

- Аж үйлдвэрийн салбар;
- Бүс нутаг;
- Зээлийн бүтээгдэхүүний төрөл;
- Зээлийн нас;
- Зээлийн дүн;
- Барьцаа хөрөнгийн төрөл.

Зээлийн эрсдэлийн сангийн зардлыг бүлэглэн тооцоолоход ашиглагдаж буй статистикийн мэдээллийг (PD, LGD, LIP) багц бүрээр тусад нь тооцно. Хэтэрхий нарийвчилсан сегментийг ашиглавал ижил төстэй бүлгүүд ихээр үүсч, бүлэгт бүрт статистик үзүүлэлт, төлбөр төлөгдөхгүй байх магадлал, алдагдал үүсэх магадлал зэргийг тодорхойлох шаардлагатай болно. Ялангуяа, их хэмжээний жижиглэнгийн зээлтэй банк уг багцын зээлийн төрөл (хэрэглээний, моргейжийн гэх мэт), бүс нутаг, насжилт (зээлийн наснаас хамааран дөнгөж олгосон, хугацаа нь дуусгавар болох гэж буй гэж ангилах) зэргээр нь багцалж болно. PD, LGD, LIP зэргийн талаарх статистикийн мэдээлэл нь дараах шалтгааны улмаас банк бүрт харилцан адилгүй байдаг

PD: Багцын төрөл (бүс нутаг, аж үйлдвэрийн салбар, валютын төрөл, зээлийн эрсдэл болон өгөөж гэх мэт) болон банкны зээл олгох үйл явц, хяналтаас шалтгаална.

LGD: Хууль эрх зүйн орчин (зээлийг нөхөх өртөг зардал, цаг хугацаа нөлөөлнө), эргэн төлөгдөх боломж, банкны өртгийн ерөнхий суурь, барьцаа хөрөнгөөс шалтгаална. Банк нягтлан бодох бүртгэлийн болон эдийн засгийн зардлыг харьцуулах боломжтой боловч үүсэх зардлыг зөвхөн бүртгэлийн бичилтэнд суурилан тодорхойлдог. Банкны өөрийн туршлага, зээлийг барагдуулах чадвар нь зээл эргэн нөхөгдөх түвшинд гол нөлөө үзүүлэх ба үүнийг LGD-г үнэлэхдээ харгалзах ёстой бөгөөд банк өөрийн туршлага, мэдлэгийн талаар эмпирик нотолгоог дотооддоо бий болгох ёстой.

LIP: LIP-ийн үнэлгээг багц бүрт тусгайлан тооцох тул энэ нь багц бүрт ялгаатай тодорхойлогддог (жишээлбэл, жижиглэнгийн болон том харилцагчийн багц). Багц бүрээр зардлыг тодорхойлж гаргасан болон бодитоор хэрэгжсэн хугацааны хоорондох мэдээллийг цуглуулах замаар ашиглагдсан LIP-ийн талаарх мэдээлэл банкинд шаардлагатай байдаг. Банкинд тусгайлан хамаарах үнэлгээг LIP-ийг тооцоход ашиглана.

Загвар:

Үнэ цэн бууараагүй тусгайлан авч үзэх зээл ба бүлгээр авч үзэх зээлийн хувьд дараах томъёог ашиглана

= Актив x PD x LGD x LIP

Үнэ цэн буурсан бүлгээр авч үзэх зээлийн хувьд дараах томъёог ашиглана

= Актив x PD x LGD

Жишээ: Бүлгээр үнэлсэн зээлийн үнэ цэнийн бууралт

2012.12.31-ээр тасалбар болсон тайланд хугацаанд иргэдэд олгосон зээлийн бүлгийн үнэ цэнийн бууралтыг тооцоолъё.

2012 оны 12-р сарын 31-нд банкнаас иргэдэд олгосон зээлийн багц 500 мянган төгрөг байсан. Банк уг багцтай холбогдуулан сүүлийн 4 жилийг хамарсан дараах мэдээллийг цуглуулсан:

Жил	Олгосон зээл, мянган төгрөгөөр	Үүнээс, тайлагналын өдрөөр төлбөр төлөгдөөгүй байгаа, мянган төгрөгөөр	Төлбөр төлөгдөхгүй байх магадлал %	Төлөгдөхгүй дүн , мянган төгрөгөөр
			=3/2	
2008 он	150	18	12%	13
2009 он	200	21	11%	16
2010 он	350	33	9%	27
2011 он	400	39	10%	32
Нийт \ Жигнэсэн дундаж	1100	111	10%	88

Энэ жишээнд төлбөр төлөгдөхгүй байх магадлал 10% (111/1100) буюу өөрөөр хэлбэл банкны зээлийн дунджаар 10% -ын төлбөр ямар нэгэн байдлаар төлөгдөхгүй гэж үзсэн.

Энэ жишээнд алдагдал үүсэх магадлал нь 80% (88/111) , өөрөөр хэлбэл банк төлбөр төлөгдөхгүй хойшлогдсон зээлийн (энэ жишээнд 10% болж байна) 80% нь алдагдал болно гэж үзсэн.

Сүүлийн 4 жилд гаргасан багцыг доорх хүснэгтээр харуулсан ба алдагдал тодорхойлох хугацааг дараах байдлаар тогтооно.

	Олгосон зээл (тайлант хугацааны эхэн)	Хойш-луулсан нийт төлбөр	Тооцоол-сон зардал (1-р улирлын эцэст)	Тооцоол-сон зардал (2-р улирлын эцэст)	Тооцоол-сон зардал (3-р улирлын эцэст)	Тооцоол-сон зардал (4-р улирлын эцэст)	Тооцоол-сон зардал (жилээр)	Тооцоо-лоогүй зардал (жилээр)	LIP (тооцоолоо-гүй зардлын хувиар)
									=9/3
1-р улирал	100	10	1.0	3.0	4.0	2.0	10.0	-	0%
2-р улирал	120	12	-	1.2	3.6	4.8	9.6	2.4	20%
3-р улирал	130	13	-	-	1.3	3.9	5.2	7.8	60%
4-р улирал	150	15	-	-	-	1.5	1.5	13.5	90%
	500	50					26.3	23.7	47%

Энэ жишээнд зээлийн алдагдал тодорхойлох хугацаа 47% (23.7/50) байна. Энэ нь тухайн жилд төлбөр төлөгдөөгүй зээлийн нийт дүнгээс 53% (26.3) -ийг банк мэдэж байсан гэсэн утгыг илэрхийлнэ. Тайлант хугацаанд 47% (23.7)-иар зардал гарна гэдгийг банк мэдээгүй.

Хэрэв банк харгалзан 25 сая төгрөг ба 475 сая төгрөгийн үлдэгдэл бүхий “үнэ цэн буурсан зээл” ба “үнэ цэн буураагүй зээл” гэсэн зөвхөн хоёр багцыг тодорхойлж ашигласан тохиолдолд үнэ цэнийн бууралтыг дараах байдлаар бүлэглэн тооцоолно.

Үнэ цэн буурсан зээлийн үнэлгээ = 25 x (PD) 10% x (LGD) 80% = 2 сая төгрөг
Үнэ цэн буураагүй зээлийн үнэлгээ = 475 x (PD) 10% x (LGD) 80% x 47% (LIP) = 17.9 сая төгрөг

Бүлэглэн тооцоолсон зээлийн эрсдэлийн сан 19.9 сая төгрөг болж байна.

СТОУС-ын дагуу тооцоолсон зээлийн эрсдэлийн сангийн зардлын дүнг гаргахдаа дээрх дүн дээр тусгайлан үнэлсэн зээлийн эрсдэлийн сангийн зардлыг нэмж тодорхойлно.

7) Зээлийн хуримтлуулж тооцсон хүүгийн авлага

Зээлийн үндсэн өр, хүүгийн төлбөрийн аль нэг нь зээлийн гэрээнд заагдсан төлөгдөх хугацаанаас хойш 90 хоногийн дотор төлөгдөөгүй бол 91 дэх хоногоос эхлэн хүүг хуримтлуулан бүртгэхийг зогсоож, өмнө нь хуримтлуулсан хүүг буцааж, тэнцлийн гадуурх дансанд бүртгэх бөгөөд уг гүйлгээг буцаахгүй.

8) Гадаад валютаар илэрхийлэгдсэн зээл

Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн санхүүгийн хөрөнгө (тухайлбал, зээл)-ийг гадаад валютаар илэрхийлсэн тохиолдолд хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн гүйлгээг тухайн санхүүгийн хөрөнгийн хамгийн анхны үр ашигт хүүг ашиглан дискаунтчилна. Харин түүнд байгуулсан эрсдэлийн санг тухайн өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлнэ. Зээлийн өнөөгийн үнэ цэнийг төгрөгт хөрвүүлсэн дүн ба дансны үлдэгдлийн зөрүүг эрсдэлийн сангийн зардалд бүртгэнэ. Үүний нэгэн адил тайлагналын өдрөөр эрсдэлийн сангийн зардлыг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн буцаах тохиолдолд уг буцаалтыг бүртгэх өдрийн албан ханшийг ашиглана.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн зээлийн эрсдэлийн санд сар бүр ханшийн тэгшитгэл хийх ба ханшийн зөрүүг ханшийн тэгшитгэлийн орлого, зардалд бүртгэнэ. Банк зээлийн чанар муудсан эсвэл сайжирснаас бусад тохиолдолд буюу тухайлбал гадаад валютын албан ханш өөрчлөгдсөнөөр зээлийн эрсдэлийн санг нэмэгдүүлэх буюу бууруулж бүртгэхгүй.

Д. БҮРТГЭЛ

1) Зээл олгох, төлүүлэх, гадаад валютын зээлийг дахин үнэлэх

Зээл олгох үед зээлийн гэрээний дүн буюу нэрлэсэн дүнгээр

Дебит: Зээлийн холбогдох данс
Кредит: Зээлдэгчийн харилцах данс эсвэл Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Зээлд шууд хамаарах хойшлогдсон шимтгэл, хураамжийг хойшлуулан бүртгэнэ.

Дебит: Зээлийн хойшлогдсон төлбөр
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс эсвэл Зээлдэгчийн харилцах данс

Хойшлуулсан зардлыг зээлийн хугацаанд үр ашигт хүүгийн аргаар хорогдуулж, хүүгийн орлогыг бууруулан бүртгэнэ

Дебит: Зээлийн хүүгийн орлого
Кредит: Зээлийн хойшлогдсон шимтгэл

Зээлийн хойшлогдсон шууд орлогыг бүртгэхдээ

Дебит: Зээлдэгчийн харилцах данс эсвэл Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Хойшлогдсон орлого

Хойшлуулсан орлогыг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулж, хүүгийн орлогыг нэмэгдүүлж тохируулна.

Дебит: Хойшлогдсон орлого
Кредит: Зээлийн хүүгийн орлого

Зээл төлөгдөхөд

Дебит: Зээлдэгчийн харилцах данс
Кредит: Зээлийн холбогдох данс

Гадаад валютаар олгосон зээлийн ханшийн тэгшитгэлийг бүртгэхдээ ханш өссөн үед

Дебит: Зээлийн холбогдох данс
Кредит: Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого

Хэрэв ханш буурсан бол

Дебит: Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал
Кредит: Зээлийн холбогдох данс

Санхүүгийн тайланд ханшийн тэгшитгэлийн орлого, зардлыг хооронд нь хааж, цэвэршүүлэн толилуулна.

Жишээ: Зээлийн хорогдуулсан өртгийг тооцох

Банк 20Х0 оны 1 дүгээр сарын 1-нд нэгэн харилцагчдаа таван жилийн хугацаатай, жилийн 12% хүүтэй, 100 сая төгрөгийн зээл олгож, зээл олгосны шимтгэлд 11 сая төгрөг авсан. Зээлийн гэрээнд зааснаар зээлдэгч нь жил бүрийн 12-р сарын 31-ний өдөр 27,740,973 төгрөг төлөх замаар зээлийг хүүгийн хамт төлж барагдуулна. Уг зээлд эрсдэлийн сан байгуулаагүй.

Зээл олгосны шимтгэлийг зээлийн бодит үнэ цэнэд шингээх ба зээлийн хүлээн зөвшөөрөх анхны үнэ нь 89 сая төгрөг болно (100сая - 11сая).

Үр ашигт хүүг дараах тэгшитгэлээс тооцоолно: $89,000,000 = 27,740,973 * (1-(1+i)^{-5})/i$

Эндээс хүүгийн хувь нь i=16.8792% гарч байна. Үр ашигт хүүг тооцоолохдоо гэрээний мөнгөн гүйлгээг (с багана) анхны өртөг болох 89 сая төгрөг (зээлийн нэрслэн дүнгээс хойшлогдсон шимтгэлийг хассан дүн) хүртэл бууруулах дотоод өгөөж буюу IRR функцыг ашиглана.

Тэгвэл хойшлогдсон орлогын хорогдуулалт нь дараах байдалтай болно: (мянган төгрөгөөр)

Жил	Хүү тооцох хугацаа	Зээлийн үлдэгдэл	Хүүгийн төлбөр	Гэрээний дагуу хийгдэх төлбөр	Зээлийн төлөлт	Хойшлогдсон орлогын үлдэгдэл	Зээлийн цэвэр дүн /хорогдуулсан өртөг/	Хүлээн зөвшөөрөх хүүгийн орлого	Хойшлогдсон орлогын хорогдуулалт
		(a)	(b) =(a)*12%	(c)	(d)=(c)-(b)	(e)=(a)-(f)	(f)	(g) =(f)*16.8792%	(h)=(g)-(b)
	20X0.1.1	100,000				11,000	89,000		
1	20X0.12.31	84,259	12,000	27,741	15,741	7,978	76,282	15,022	3,022
2	20X1.12.31	66,629	10,111	27,741	17,630	5,213	61,416	12,876	2,765
3	20X2.12.31	46,884	7,995	27,741	19,745	2,842	44,042	10,367	2,371
4	20X3.12.31	24,769	5,626	27,741	22,115	1,034	23,735	7,434	1,808
5	20X4.12.31	-	2,972	27,741	24,769	-	-	4,006	1,034
									11,000

Журналын бичилт:

20X0.1.1

Дебит: Зээлийн холбогдох данс 100,000
Кредит: Зээлдэгчийн харилцах данс 100,000

20X0.1.1

Дебит: Зээлдэгчийн харилцах данс 11,000
Кредит: Зээлийн хойшлогдсон орлого 11,000

20X0.12.31

Дебит: Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага 12,000
Кредит: Зээлийн хүүгийн орлого 12,000

20X0.12.31

Дебит: Зээлдэгчийн харилцах данс 27,741
Кредит: Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага 12,000
Кредит: Зээлийн холбогдох данс 15,741

20X0.12.31

Дебит: Зээлийн хойшлогдсон орлого 3,022
Кредит: Зээлийн хүүгийн орлого 3,022

20X0.12.31-нд санхүүгийн байдлын тайланд зээлийг дараах цэвэр дүнгээр толилуулна (үндсэн зээл ба хүүгийн төлбөр нь нэрлэсэн хүүгийн түвшинг ашиглан жил тутамд төлөгдөх буюу гэрээний мөнгөн гүйлгээ болно):

Зээлийн үлдэгдэл 84,259
Хойшлогдсон орлого (7,978)
Зээлийн эрсдэлийн сан -
Зээлийн цэвэр дүн (Зээлийн хорогдуулсан өртөг) 76,281

Орлого, зардлын дансанд гарах нийт өөрчлөлт (хүүгийн орлого): 12,000 (нэрлэсэн хүүнд үндэслэсэн хүүгийн орлого) нь зээлийн хойшлогдсон шимтгэлийг хорогдулсан дүнгээр (3,022) өсч 15,022 болно.

2) Зээлийн хүүгийн бүртгэл

Зээлийн хүүг хуримтлуулан тооцох үед

Дебит: Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага
Кредит: Зээлийн хүүгийн орлого

Санхүүгийн тайланд хуримтлуулж тооцсон хүүг зээлийн бодит үнэ цэнэд нэмэгдүүлж харуулна.

Хуримтлуулан тооцсон зээлийн хүү төлөгдөхөд.

Дебит: Зээлдэгчийн харилцах эсвэл Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага

Зээлийн хүүг хуримтлуулан тооцолгүйгээр шууд суутгасан бол хуримтлуулсан хүүгийн авлага үүсгэлгүйгээр хүүгийн орлого бүртгэнэ.

Дебит: Зээлдэгчийн харилцах эсвэл Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Зээлийн хүүгийн орлого

Зээлийн үндсэн өр, хүүгийн төлбөрийн аль нэг нь зээлийн гэрээнд заагдсан төлөгдөх хугацаанаас хойш 90 хоногийн дотор төлөгдөөгүй бол 91 дэх хоногоос эхлэн хүүг хуримтлуулан бүртгэхийг зогсоож, өмнө нь хуримтлуулсан хүүг буцааж, тэнцлийн гадуурх Хуримтлуулж тооцохыг зогсоосон зээлийн хүүгийн дансанд бүртгэх бөгөөд уг гүйлгээг буцаахгүй. Цаашид зээлд тооцох хүүг энэ дансанд нэмж бүртгэн, төлүүлэх арга хэмжээг үргэлжлүүлнэ.

Тэнцлийн гадуур бүртгэлтэй хүү төлөгдөхөд

Дебит: Зээлдэгчийн харилцах эсвэл Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Зээлийн хүүгийн орлого

Төлөгдсөн зээлийн дүнгээр тэнцлийн гадуурх данснаас зарлагдана.

<u>3) Зээлийг дахин ангилах, зээлийн эрсдэлийн сан байгуулах, зарцуулах</u>

Банк нь зээлийг хугацаа, чанар, эргэн төлөлтийг харгалзан ангилж, ангилал тус бүрээр нь тайлагнана. Зээлийн ангилал өөрчлөгдвөл дараах бичилтийг хийнэ. Жишээлбэл, зээлийг “Хэвийн зээл”-ээс “Анхаарал хандуулах зээл” рүү ангилал бууруулан бичвэл

Дебит: Анхаарал хандуулах зээл
Кредит: Хэвийн зээл

Хэрэв зээлийн чанар дараа үеүдэд сайжирвал дээрх бичилтийн урвуу бичилт хийх замаар ангилал дээшлүүлнэ.

Дебит: Хэвийн зээл
Кредит: Анхаарал хандуулах зээл

Зээлийн эрсдэлийн сан байгуулахад

Дебит: Зээлийн эрсдэлийн сангийн зардал
Кредит: Зээлийн эрсдэлийн сан

Илүү байгуулсан зээлийн эрсдэлийн санг буцаахад

Дебит: Зээлийн эрсдэлийн сан
Кредит: Зээлийн эрсдэлийн сангийн зардал

Хэрэв зээлийн эрсдэлийн санг буцаах дүн нь тухайн өдрөөрх зээлийн эрсдэлийн зардлын үлдэгдлээс хэтэрсэн бол зээлийн эрсдэлийн зардлыг хаагаад үлдсэн зөрүүг бусад орлогоор бүртгэнэ.

Дебит: Зээлийн эрсдэлийн сан
Кредит: Бусад орлого - Зээлийн эрсдэлийн сангаас буцаасан орлого

Зээлийн эрсдэлийн сангийн зардал данс хангалттай үлдэгдэлтэй болсон үед “Зээлийн эрсдэлийн сангаас буцаасан орлого”-ыг зээлийн эрсдэлийн сангийн зардалд эргүүлэн хаана.

Дебит: Бусад орлого - Зээлийн эрсдэлийн сангаас буцаасан орлого
Кредит: Зээлийн эрсдэлийн сангийн зардал

Зээлийн эрсдэлийн сангаас зээл хаахад

Дебит: Зээлийн эрсдэлийн сан
Кредит: Зээлийн холбогдох данс

Хаасан зээлийн дүнгээр тэнцлийн гадуурх “Зээлийн эрсдэлийн сангаас хаасан зээл”-ийн дансанд бүртгэж, зээлийг эргүүлж төлүүлэх ажиллагааг үргэлжлүүлнэ.

Хэрэв хаагдсан зээл бүтнээрээ буюу хэсэгчлэн эргэн төлөгдвөл төлөгдсөн дүнгээр

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Бусад орлого-Зээлийн эрсдэлийн сангаас хаагдсан зээлийн эргэн төлөлт

Төлөгдсөн зээлийн дүнгээр тэнцлийн гадуурх данснаас мөн зарлагадна.

Гадаад валютаар байгуулсан эрсдэлийн санд ханшийн тэгшитгэл хийх үед

Ханш өссөн бол

Дебит: Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал
Кредит: Зээлийн эрсдэлийн сан

Ханш буурсан бол

Дебит: Зээлийн эрсдэлийн сан
Кредит: Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого

Гадаад валютын ханш өөрчлөгдөхөд зээлийн багцын чанар өөрчлөгдөж болно. Жишээлбэл: харилцагчийн орлогыг төгрөгөөр илэрхийлдэг тохиолдолд төгрөгийн ханш сулралт нь зээлийн эрсдэлийг үүсгэнэ. Иймээс гадаад валютын албан ханш огцом өөрчлөгдөхөд СТОУС-ын дагуу тооцоолсон эрсдэлийн сангийн зардлыг дахин үнэлэх шаардлагатай болно (жишээлбэл, чанарын хүчин зүйлс нөлөөлж бас болно). Хэрэв дахин хийсэн үнэлгээний үр дүнд эрсдэлийн сангийн зардлыг өөрчлөх шаардлагатай болсон бол дараах байдлаар бүртгэнэ:

Хэрэв зээлийн эрсдэлийн санг нэмэгдүүлсэн бол

Дебит: Зээлийн эрсдэлийн сангийн зардал
Кредит: Зээлийн эрсдэлийн сан

Хэрэв зээлийн эрсдэлийн санг бууруулсан бол

Дебит: Зээлийн эрсдэлийн сан
Кредит: Зээлийн эрсдэлийн сангийн зардал

4) Зээлийн эрсдэлийн санг СТОУС-ын дагуу үнэлж бүртгэх

Хэрэв холбогдох активын ангиллын журмаар тооцоолсон эрсдэлийн сангийн дүн СТОУС-ын дагуу байгуулах эрсдэлийн сангаас бага гарвал СТОУС-ын дагуу тооцоолсон дүнгээр эрсдэлийн санг байгуулах ба эдгээрийн зөрүүг бүртгэлд тусгахгүй.

Дебит: Зээлийн эрсдэлийн сангийн зардал
Кредит: Зээлийн эрсдэлийн сан

Хэрэв холбогдох активын ангиллын журмаар тооцоолсон эрсдэлийн сангийн дүн СТОУС-ын дагуу байгуулах эрсдэлийн сангаас өндөр гарвал дээрх СТОУС-ын дагуу тооцоолсон дүнгээр дээрх бичилтийг хийж эрсдэлийн санг байгуулах ба эдгээрийн зөрүүг өөрийн хөрөнгийн “Эрсдэлийн сангийн нөөц” дансанд бүртгэнэ.

Дебит: Хуримтлагдсан ашиг
Кредит: Эрсдэлийн сангийн нөөц

Жишээ: СТОУС-ын дагуу зээлийн эрсдэлийн сан байгуулах

СТОУС-ын дагуу 10 сая төгрөгөөр, харин активын ангиллын журмын дагуу 12 сая төгрөгөөр эрсдэлийн сан байгуулахаар тооцоолсон гэж үзээд цэвэр ашиг 100 байх тохиолдолд дараах бичилтийг хийнэ.

Эрсдэлийн санг байгуулахдаа

Дебит: Зээлийн эрсдэлийн сангийн зардал	10
Кредит: Зээлийн эрсдэлийн сан	10

Зээлийн эрсдэлийн сангийн зардлыг хассаны дараах цэвэр ашгийг хуримтлагдсан ашигт хаахдаа

Дебит: Цэвэр ашиг	90
Кредит: Хуримтлагдсан ашиг	90

Зөрүүгээр нөөц байгуулахдаа

Дебит: Хуримтлагдсан ашиг	2
Кредит: Эрсдэлийн сангийн нөөц	2

Тайлант хугацааны эцсээрх дансдын үлдэгдэл:

Зээлийн эрсдэлийн сан нь өмнөхөөс 2 -оор бага болж, Эрсдэлийн сангийн нөөц 2 -ийн үлдэгдэлтэй болно.

Хуримтлагдсан ашиг дансны үлдэгдэл (88 = 90-2).

Бусад төрлийн санхүүгийн хөрөнгө, 90 хүртэлх хоног хугацаа хэтэрсэн хуримтлуулж тооцсон хүүгийн авлагыг дээрх зарчмын дагуу бүртгэнэ.

5) Банк хоорондын захаар олгосон зээл

Банк хоорондын захаар зээл олгох үед

Дебит: Банк хоорондын захаар олгосон зээл
Кредит: Зээлдэгч банкны харилцах

Зээлдэгч нь зээлийн үндсэн төлбөрийг эргүүлэн төлөхөд

Дебит: Зээлдэгч банкны харилцах
Кредит: Банк хоорондын захаар олгосон зээл

Банк хоорондын захаар олгосон зээлийн хүү, зээлийн ангилал өөрчлөх болон зээлийн эрсдэлийн санг бусад зээлийн нэгэн адил бүртгэнэ.

6) Хамтын зээлжүүлэлт

Хамтын зээлжүүлэлт гэдэг нь хоёр буюу түүнээс дээш банк, санхүүгийн байгууллагууд хамтран тодорхой төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зээл юм.

Удирдагч банк гэж төслийг санхүүжүүлэх үйл ажиллагааг удирдан явуулж байгаа бөгөөд оролцогчийг төлөөлж зээлдэгчтэй харилцдаг банк юм. Оролцогч банк нь удирдагч банкаар дамжуулан төслийг санхүүжүүлж байгаа банк юм.

Оролцогч банк хамтын зээлжүүлэлтэнд эх үүсвэрийг шууд байршуулах болон байршуулалгүйгээр оролцож болно.

Дотоодын банк, санхүүгийн байгууллагууд оролцсон хамтын зээлжүүлэлт

Гэрээний үндсэн дээр оролцогч банкнуудаас удирдагч банкинд эх үүсвэр төвлөрүүлэхэд

(а) Удирдагч банк

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Хамтын зээлжүүлэлтийн эх үүсвэр

(б) Оролцогч банк

Дебит: Хамтын зээлжүүлэлт (хөрөнгийн данс)
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Гэрээний нөхцлийн дагуу оролцогч банк эх үүсвэр байршуулалгүй зээлийн эрсдэлийн тодорхой хэсгийг хүлээхээр болсон тохиолдолд энэ нь ирээдүйд үүрэг хүлээх тул үүнийг тэнцлийн гадуур “Хамтын зээлжүүлэлтээр хүлээсэн үүрэг” дансанд бүртгэнэ.

Хэрэв хамтын зээлжүүлэлтийн гэрээний нөхцлийн дагуу банкууд зээлээс өөрт ноогдох хэсгийг зээлээр бүртгэх бол

(а) Удирдагч банк

Дебит: Зээлийн холбогдох данс (удирдагч банкинд ногдох зээлийн хэсэг)
Дебит: Хамтын зээлжүүлэлтийн эх үүсвэр (оролцогч банкинд ногдох зээлийн хэсэг)
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Үүний зэрэгцээ оролцогч банкинд ногдох зээлийг тэнцлийн гадуур “Хамтын зээлжүүлэлтийн оролцогч банкинд хамаарах зээл” дансанд бүртгэнэ.

(б) Оролцогч банк

Оролцогч банк нь эх үүсвэрийг шилжүүлэх хүртэл болзошгүй үүргийг тэнцлийн гадуур бүртгэх ба эх үүсвэрийг удирдагч банкруу шилжүүлэх үед:

Дебит: Зээлийн холбогдох данс (оролцогч банкинд ногдох зээлийн хэсэг)
Кредит: Хамтын зээлжүүлэлт (хөрөнгийн данс)

Удирдагч банк нь хамтын санхүүжилттэй зээлийн хүүг хуримтлуулан бүртгэнэ.

Дебит: Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага

Кредит: Зээлийн хүүгийн орлого (Удирдагч банкинд ногдох хүүний дүнгээр)

Удирдагч банк нь оролцогчдод ногдох хүүг хуримтлуулж, шилжүүлнэ.

(а) Удирдагч банк хүүгийн өглөгийг тооцоолоход

Дебит: Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага
Кредит: Хамтын зээлжүүлэлтийн эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг (Оролцогч банкинд ногдох хүүний дүнгээр)

Удирдагч банк хүүг оролцогч банкруу шилжүүлэхэд
Дебит: Хамтын зээлжүүлэлтийн эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

(б) Оролцогч банк хүүг хуримтлуулан тооцоход

Дебит: Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага
Кредит: Зээлийн хүүгийн орлого (Оролцогч банкинд ноогдох хүүний дүнгээр)

Хүү төлөгдөхөд
Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага

<u>Гадаадын банк, санхүүгийн байгууллагууд оролцсон хамтын зээлжүүлэлт</u>

Гэрээний үндсэн дээр дотоодын банк *удирдагч банкаар* оролцож байгаа тохиолдолд гаднаас орж ирсэн эх үүсвэрийн дүнгээр

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Хамтын зээлжүүлэлтийн эх үүсвэр

Хамтын санхүүжилттэй зээлийг олгохдоо

Дебит: Зээлийн холбогдох данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Хамтын санхүүжилттэй зээлийн хүүг хуримтлуулахдаа

Дебит: Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага
Кредит: Зээлийн хүүгийн орлого

Удирдагч банк нь оролцогчдод ногдох хүүг хуримтлуулж, шилжүүлэхдээ

Дебит: Зээлийн хүүгийн зардал
Кредит: Зээлийн хүүгийн өглөг

Оролцогч банкинд хүүг төлөхөд
Дебит: Зээлийн хүүгийн өглөг
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Гэрээний үндсэн дээр дотоодын банк *оролцогч банкаар* оролцож байгаа тохиолдолд шилжүүлсэн эх үүсвэрийн дүнгээр

Дебит: Гадаадын банк санхүүгийн байгууллагад олгосон зээл
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Хамтын санхүүжилттэй зээлийн хүүг хуримтлуулахдаа

Дебит: Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага
Кредит: Зээлийн хүүгийн орлого

Удирдагч банкнаас хүүг төлөхөд
Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага

<u>7) Зээл, зээлийн багцыг худалдах (Факторинг)</u>

Санхүүгийн хөрөнгийг шилжүүлэх болон санхүүгийн өр төлбөрийг барагдуулах үед холбогдох эрсдэл, өгөөжийг бүгдийг шилжүүлсэн эсэхийг тогтооно. Хэрэв эрсдэлийг бүрэн шилжүүлсэн бол уг санхүүгийн хэрэгслийг данснаас хасч, бүртгэх ба харин шилжүүлээгүй бол данснаас хасч болохгүй.

Энэ нь зээл, авлагыг худалдах үед илүү ашиглагддаг. Хэрэв харилцагч зээлээ эргүүлэн төлөхгүй бол алдагдлыг хэн хүлээх тухай асуудал чухал. Хэрэв банк эрсдэлийг үүрэх бол (recourse) хөрөнгийг дансаас хасахгүй. Хэрэв банк эрсдэлийн талыг хүлээх бол (фактор эрсдэлийн нөгөө хагасыг үүрнэ) хүлээж буй эрсдэлд харгалзах хөрөнгийн хэсгийг бүртгэлдээ тусгаж, үлдсэн хэсгийг данснаас хасна. Хэрэв фактор бүх эрсдэлийг (non-recourse) хүлээх бол банк уг хөрөнгийг данснаас хасч бүртгэнэ.

Банк өөрийн зээлийг эсвэл зээлийн багцыг бусад банк, санхүүгийн байгууллага, хуулийн этгээдэд гэрээний дагуу худалдан борлуулах буюу шилжүүлж болно.

Зээлийг шаардах эрхийн хамт худалдаж байгаа тохиолдолд тухайн зээл, түүний хуримтлуулсан хүүгийн дансыг хааж, худалдан авч байгаа талд шилжүүлнэ.

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Дебит: Үйл ажиллагааны бусад зардал
Кредит: Зээлийн холбогдох данс

Банк зээлийг худалдахдаа шаардах эрхээ шилжүүлээгүй, зээлийн эрсдэлийг банк хүлээх тохиолдолд худалдсан зээлийг данснаас хасалгүй, зээлийн бүртгэлийг үргэлжлүүлж, худалдсан өдрөөр өр төлбөр үүсгэн бүртгэнэ. Зээлийн хугацааг дуустал худалдсан зээлийн багцын талаар санхүүгийн тайланд тодруулга хийнэ.

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Дебит: Үйл ажиллагааны бусад зардал
Кредит: Бусад санхүүгийн өр төлбөр

Зээл худалдан авсан талд зээлийн төлбөрийг шилжүүлэх үед өр төлбөрийг бууруулан бүртгэнэ.

Дебит: Бусад санхүүгийн өр төлбөр
Кредит: Зээлийг худалдан авсан талын харилцах данс эсвэл Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

8) Батлан даалт, баталгаа

Банк харилцагчийн нэрийн өмнөөс зээлийн баталгаа, батлан даалт гаргаж болно. Батлан даалтын хугацаа дуусч, харилцагч зээлээ төлж чадаагүйгээс банк зээлийг төлж барагдуулах нөхцөлд зээлийн төлбөрийг хийхийн өмнө зээлийн хувийн хэрэг, төлбөр тооцоо хийсэн баримт болон холбогдох баримт материалыг тухайн зээлийг олгосон банкнаас эх хувиар нь гаргуулан хүлээн авсны эцэст зээлд бүртгэнэ.

Дебит: Зээлийн холбогдох данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Банк харилцагчийн нэрийн өмнөөс батлан даалт, баталгаа гаргасан бол тэнцлийн гадуур хүлээж болзошгүй үүргээр бүртгэнэ. Хүлээж болзошгүй үүрэг хэрэгжих үед харилцагчийн байршуулсан эх үүсвэрээр төлбөрийг бүрэн барагдуулж чадахгүй бол банк зээл болгож, шилжүүлэн бүртгэнэ.

Дебит: Зээлийн холбогдох данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Банк харилцагчид зээл олгосноор зээлдэгч өрөө барагдуулах чадваргүй болж болзошгүй тул зээл олгосны дараа зээлийн үнэ цэнийн бууралтыг тооцож үзэх шаардлагатай. Зээлийн эрсдэлийн сангийн зардлыг СТУОС 39 -ын дагуу тооцоолно.

9) Санхүүгийн түрээс

Банкны тухай хууль, бусад тогтоомжийн дагуу банк санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа явуулна. НББОУС 17-д багтсан санхүүгийн түрээсийн тодорхойлолтыг (энэ зааврын тодорхойлолтын хэсэгт оруулсан) хангаж буй авлагыг холбогдох дансанд бүртгэнэ.

Банк санхүүгийн түрээсийн бүтээгдэхүүн гаргасан нөхцөлд үүнийг дансны жагсаалтын “Зээл” бүлэгт багтсан санхүүгийн түрээсийн авлага дансанд бүртгэж, харуулна. Санхүүгийн түрээсийн тодорхойлолтыг ямар бүтээгдэхүүн хангах (энэ тохиолдолд банк түрээсийн хөрөнгийн өмчлөгч болох ба төлөгдөх дүн нь түрээсийн хөрөнгийн үнэ цэнээс шалтгаална) болон зээлийн ямар бүтээгдэхүүн хангахгүй (энэ тохиолдолд банк зээлийн барьцаа хөрөнгийн өмчлөгч болохгүй ба зээлийн төлбөрийн дүн нь зээлийн барьцаа эсвэл уг зээлээр худалдан авсан хөрөнгийн дүнгээс шалтгаалахгүй) талаарх бодлогыг дотооддоо боловсруулж, мөрдөнө. Мөн банк СТОУС-д нийцүүлэн бэлтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгад санхүүгийн түрээсийн авлагын дүнг тодруулна.

Хэрэв банк (хөрөнгө өмчлөгчийн хувьд) үл хөдлөх болон бусад хөрөнгийг санхүүгийн түрээсээр

түрээслүүлсэн тохиолдолд түрээсийн авлагыг түрээсэлсэн хөрөнгийн бодит үнэ цэн ба түрээсийн төлбөрийн аль багаар үнэлж, бүртгэнэ.

Түрээсийн гэрээгээр хөрөнгө (мөнгө) шилжүүлэх үед

Дебит: Зээлийн холбогдох данс - Санхүүгийн түрээсийн авлага
Кредит: Зээлдэгчийн харилцах данс эсвэл Мөнгөн хөрөнгийн холбогдох данс Үндсэн хөрөнгө (түрээслүүлсэн хөрөнгийн төрлөөр)

Санхүүгийн түрээсийн хүүг хуримтлуулан тооцох үед

Дебит: Хуримтлуулсан хүүгийн авлага
Кредит: Санхүүгийн түрээсийн хүүгийн орлого

Түрээс, хүүгийн төлбөрийг авах үед

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Хуримтлуулсан хүүгийн авлага
Кредит: Зээлийн холбогдох данс - Санхүүгийн түрээсийн авлага

<u>10) Зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй олгосон зээл</u>

Зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй олгосон зээлийг анх удаа хүлээн зөвшөөрөхдөө

а) Гадны харилцагчдад олгосон бол

Дебит: Зээлийн холбогдох данс *(зээлийн нэрлэсэн дүнгээр)*
Дебит: Зээл олголтын зардал *(зөрүүгээр)*
Кредит: Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэйгээр олгосон зээлийн бодит үнийн залруулга *(зээлийн бодит үнэ цэн ба нэрлэсэн дүнгийн зөрүүгээр)*
Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө *(зээлийн нэрлэсэн дүнгээр)*

б) Банкны ажилтнуудад олгосон бол

Дебит: Зээлийн холбогдох данс *(зээлийн нэрлэсэн дүнгээр)*
Дебит: Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэйгээр ажилтнуудад олгосон зээлийн урьдчилгаа *(зөрүүгээр)*
Кредит: Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэйгээр олгосон зээлийн бодит үнийн залруулга *(зээлийн бодит үнэ цэн ба нэрлэсэн дүнгийн зөрүүгээр)*
Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө *(зээлийн нэрлэсэн дүнгээр)*

Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэйгээр ажилтнуудад олгосон зээлийн урьдчилгаа дансанд бүртгэсэн дүнг зээлийн хугацаанд шулуун шугамын аргаар хорогдуулж, зардалд шингээнэ.

в) Хувьцаа эзэмшигчдэд олгосон бол

Дебит: Зээлийн холбогдох данс *(зээлийн нэрлэсэн дүнгээр)*
Дебит: Бусад өөрийн хөрөнгө *(зөрүүгээр)*
Кредит: Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэйгээр олгосон зээлийн бодит үнийн залруулга *(зээлийн бодит үнэ цэн ба нэрлэсэн дүнгийн зөрүүгээр)*
Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө *(зээлийн нэрлэсэн дүнгээр)*

Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэйгээр олгосон зээлийн бодит үнийн залруулга дансанд бүртгэсэн олгосон зээлийн бодит үнэ цэн ба нэрлэсэн дүнгийн зөрүүг зээлийн хугацаанд үр ашигт хүүгийн аргаар хорогдуулж хүүгийн орлогыг нэмэгдүүлж, тохируулна.

Дебит: Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэйгээр олгосон зээлийн бодит үнийн залруулга
Кредит: Зээлийн хүүгийн орлого

Дээрх тохируулгыг хийсний үр дүнд зээлийн хугацаа дуусахад энэ дансны үлдэгдэл тэг болно.

Зээл төлөгдөхөд

Дебит: Зээлдэгчийн харилцах данс
Кредит: Зээлийн холбогдох данс

Е. ТОДРУУЛГА

Зээлийн үлдэгдлийг хугацаа, чанарын үзүүлэлт, эдийн засгийн салбаруудаарх зээлийн төвлөрөл зэргийг харгалзан тохирох ангиллаар харуулж, тодруулна.

Зээлийн эрсдэлийн сан байгуулахад баримталж буй бодлого, түүнд гарсан өөрчлөлтийг тодруулна.

Зээлийн эрсдэлийн сангийн үлдэгдэл, түүнд тайлант хугацаанд гарсан өөрчлөлт, тайлант хугацаанд хүлээн зөвшөөрсөн зээлийн эрсдэлийн зардал, эрсдэлийн сангаас хаасан зээл, сангаас хаасан зээлээр эргэн төлөгдсөн дүнг тус тус тодруулна.

Зээлийн хүү, түүний тооцооллыг тодруулна.

Зээлийн барьцаа, батлан даалтыг тодруулна. Үүнд зээлийн дансны дүн, түүний барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнээс дээгүүр болон доогуур үнэлгээ бүхий барьцаа бүхий хөрөнгийн мэдээлэл багтана.

СТОУС 7-ын дагуу тодруулах шаардлагатай зүйлсийг (энэ зааврын Санхүүгийн эрсдэл болон өөрийн хөрөнгийн удирдлага, бусад тодруулга бүлэгт оруулсан) зээлийн хувьд дараах байдлаар ангилан тодруулна а) хугацаа хэтрээгүй бөгөөд үнэ цэн буураагүй; б) хугацаа хэтэрсэн боловч үнэ цэн буураагүй; в) үнэ цэн буурсан. Мөн зээлийн өрийн үлдэгдлийн зээлжих чадварыг тодруулах ба ялангуяа хугацаа хэтрээгүй бөгөөд үнэ цэн буураагүй зээлийн хувьд зээлжих чадварыг заавал тодруулна. Энэ тодруулгыг банкны дотоод үнэлгээ болон хөндлөнгийн зэрэглэлд үндэслэн гүйцэтгэнэ. Хэрэв ийм зэрэглэл ашиглагддаггүй бол банк зээлийн эрсдэлийг харуулсан бусад ангилалд хөрөнгийг үлдэгдлийг бүлэглэнэ. Жишээлбэл, зээлийн түүхтэй томоохон зээлдэгч, томоохон шинэ зээлдэгч, зээлийн түүхтэй жижиг дунд аж ахуйн нэгж, шинээр зээл авч буй жижиг дунд аж ахуйн нэгж, жижиг аж ахуйн нэгж, зээлийн тодорхой хязгаарлалтаас дээгүүр байгаа иргэд, зээлийн тодорхой хязгаарлалтаас доогуур байгаа иргэд.

Санхүүгийн тайлангийн тодруулгад багтах бусад тодруулгыг санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх аргачлал (Хавсралт 4)-д заасан. Банк иж бүрэн, үнэн зөв тодруулга бэлтгэхийн тулд энэ зааврын Хавсралт 4-аас гадна энэ зааварт багтсан санхүүгийн хэрэгслүүдэд хамаарах бусад стандарт, СТОУС 7-г дагаж мөрдөнө.

Ё. ХЯНАЛТ

- Ажилтнуудын ажил үүргийг зааглан тусгаарлана.
- Зээлдэгч бүрээр дэлгэрэнгүй бүртгэл хөтөлнө.
- Дэлгэрэнгүй бүртгэлийг дансны гүйлгээ, үлдэгдэлтэй тохируулна.
- Зээлийн барьцаа, батлан даалт холбогдох баримт материал, зээлийн хувийн хэргийг бүрдүүлж, найдвартай газарт хадгална.
- Зээлийн барьцаа хөрөнгийн биет байдалд байнгын хяналт тавина.
- Зээлийг холбогдох журмын дагуу ангилан бүртгэж, зээлийн эрсдэлийн санг шаардлагатай хэмжээгээр байгуулна.
- Зээл, хүүгийн гүйлгээ, хүүгийн тооцоололд дараалсан хяналт тавина.
- Тайлант жилийн эцсээр зээлийн үндсэн өр болон хүүгийн авлагыг зээлдэгчтэй тулган баталгаажуулна.

4.4. ДЕРИВАТИВ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛ

А. ШУУД ХОЛБОГДОХ СТАНДАРТУУД

- СТОУС 7 Санхүүгийн хэрэгсэл: Тодруулга
- СТОУС 9 Санхүүгийн хэрэгсэл
- СТОУС 13 Бодит үнэ цэнийн хэмжилт
- НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- НББОУС 7 Мөнгөн гүйлгээний тайлан
- НББОУС 21 Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө
- НББОУС 32 Санхүүгийн хэрэгсэл: Толилуулга
- НББОУС 39 Санхүүгийн хэрэгсэл: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Б. ТОДОРХОЙЛОЛТ

Дериватив (санхүүгийн үүсмэл хэрэгсэл) гэж үнэлгээ нь суурь хүчин зүйлийн үнээс хамаарч өөрчлөгддөг, ирээдүйд хэрэгжих нөхцөлтэй дараах шинжийг агуулсан гэрээ, хэлцлийг хэлнэ.

(а) Хүүгийн түвшин, санхүүгийн хэрэгслийн үнэ, барааны үнэ, гадаад валютын ханш, үнийн индекс, зээлийн зэрэглэл, эсвэл зээлийн индекс гэх мэт бусад үзүүлэлтийн өөрчлөлтөөс шалтгаалан үнэ цэн нь өөрчлөгддөг;

(б) Бусад төрлийн ижил төстэй гэрээтэй харьцуулахад анхны хөрөнгө оруулалт бага буюу эсвэл огт шаардагддаггүй.

(в) Ирээдүйд арилжаа хийгдэнэ.

Гэрээ, хэлцэлд оролцогч талд тусгайлан хамаарах санхүүгийн бус заалтуудыг дериватив гэж үзэхгүй. Жишээлбэл: а) гэрээнд оролцогч талын хөрөнгөд давагдашгүй хүчин зүйл тохиолдох, эс тохиолдох, б) тухайн байгууллагын орлого, хүү, татвар, элэгдэл, хорогдолын өмнөх ашиг, хуулиар шаардсан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ зэрэгт санхүүгийн дериватив үүсэхгүй.

Дериватив нь ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөр ангилалд багтдаг.

Дериватив олон төрлийн гэрээ, хэлцэл, санхүүгийн хэрэгсэл багтаж болох бөгөөд үүнээс банкинд өргөн ашиглагддаг төрлүүд нь гадаад валют, үнэт металлыг худалдах буюу худалдан авах форвард, своп, опшин, фьючерс юм.

Форвард хэлцэл нь гадаад валют, үнэт металлыг гэрээнд тохирсон үнээр, тогтсон хугацааны дараа (спот өдрөөс урт хугацаанд) худалдан авах буюу худалдах хэлцэл юм.

Фьючерс хэлцэл нь зуучлагч буюу биржээр дамжуулан санхүүгийн хөрөнгийг гэрээнд тохирсон үнээр, тогтсон хугацааны дараа (спот өдрөөс урт хугацаанд) худалдан авах буюу худалдах хэлцэл юм.

Гадаад валют, үнэт металлын своп хэлцэл гэж дараах хоёр арилжааг нэгэн зэрэг гүйцэтгэх хэлцлийг ойлгоно:

i. Валют, үнэт металлыг өнөөдрийн арилжааны ханшаар худалдаж, түүнийг тохиролцсон ханшаар ирээдүйд эргүүлэн худалдан авах; эсвэл
ii. Валют, үнэт металлыг өнөөдрийн арилжааны ханшаар худалдан авч, түүнийг тохиролцсон ханшаар ирээдүйд эргүүлэн худалдах.

Опшин хэлцэл нь гадаад валют, үнэт металлыг талуудын хооронд байгуулсан гэрээнд тохирсон үнэ, ханшаар ирээдүйд худалдан авах эрх (колл опшин) буюу худалдах эрх (пут опшин) юм. Опшин хэрэгжсэн үед валютыг худалдах буюу худалдан авах арилжаа хийгдэнэ.

Банк гадаад валютын ханшийн хэлбэлзэл болон бусад эрсдэлээс хамгаалах зорилгоор хейдж хийж болно.

Хейдж гэдэг нь хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэн, мөнгөн гүйлгээг ирээдүйд гарах өөрчлөлтөөс хамгаалж, дериватив, түүнтэй адилтгах санхүүгийн хэрэгсэл гаргах замаар эрсдэлийг бууруулах арга юм.

Хейджийн зүйл гэж дараах шинжийг агуулсан хөрөнгө, өр төлбөр, хүлээсэн үүрэг, гүйцэтгэх өндөр магадлалтай төлөвлөсөн арилжааг хэлнэ:

(а) бодит үнэ цэн, мөнгөн гүйлгээний өөрчлөлтийн эрсдэлээс хамгаалсан
(б) эрсдэлээс хамгаалагдахаар тодорхойлогдож, баталгаажуулсан

Хейджийн хэрэгсэл нь бодит үнэ цэн эсвэл мөнгөн гүйлгээний өөрчлөлт нь хейджийн зүйлийн бодит үнэ цэн, мөнгөн гүйлгээний өөрчлөлтийг нөхөхөөр хүлээгдэж буй дериватив, түүнтэй адилтгах санхүүгийн хэрэгсэл юм.

Хейджийн үр өгөөж нь хейджийн зүйлийн бодит үнэ цэн, мөнгөн гүйлгээнд гарсан өөрчлөлтийг хейджийн хэрэгслийн бодит үнэ цэн, мөнгөн гүйлгээнд гарсан өөрчлөлтөөр нөхөж буй хувь хэмжээг хэлнэ.

Хөрөнгө, өр төлбөр, хүлээж болзошгүй үүргийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс хамгаалах хейджийг *бодит үнэ цэнийн хейдж* гэнэ.

Хөрөнгө, өр төлбөр, хүлээж болзошгүй үүргийн ирээдүйд гарах мөнгөн гүйлгээний өөрчлөлтөөс хамгаалах хейджийг *мөнгөн гүйлгээний хейдж* гэнэ.

Мөнгөн гүйлгээ гэж мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн орох ба гарах урсгалыг хэлнэ.

Нуугдмал дериватив гэж дериватив бус үндсэн хэлцлийг багтаасан холимог гэрээний нэг хэсэг бөгөөд уг холимог гэрээний зарим мөнгөн гүйлгээ нь салангид дериватив тай адил байдлаар өөрчлөгдөх деравитивыг ойлгоно. Санхүүгийн хэрэгслийг дагалдан гаргасан боловч гэрээний дагуу тухайн

хэрэгслээс салгаж, шилжүүлж болдог эсвэл гэрээний нөгөө талууд нь ялгаатай байдаг деривативыг нуугдмал дериватив гэж үзэхгүй, харин энэ нь тусдаа санхүүгийн хэрэгсэл болно.

Үндсэн хэлцэлд нуугдмал дериватив агуулагдсан байвал *холимог гэрээ* (hybrid contract) гэнэ. Тухайлбал, ханшийн эрсдэлээс хамгаалах нөхцөл агуулсан зээлийн гэрээ, хүүгийн эрсдэлээс хамгаалах нөхцөл агуулсан хадгаламжийн гэрээ гэх мэт.

В. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

Банк гэрээ, хэлцэлд тал болон оролцож, хэлцэл хүчин төгөлдөр болсноор хэлцлээр үүссэн хөрөнгө (эрх), өр төлбөр (үүрэг) -ийг хэлцлийн дуусах хугацаа хүртэл тэнцлийн гадуур бүртгэнэ.

Хэлцлийн хугацаа дуусах хүртэл хэлцлийг бодит үнэ цэнээр үнэлж, санхүүгийн тайланд деривативаар хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Деривативын бодит үнэ цэнийг үнэлгээний тодорхой загвар ашиглан тооцоолно. Хэрэв банк деривативын бодит үнэ цэнийг тооцоолох техникийн боломжгүй бол үнэлгээчдээс туслалцаа авч болно.

Деривативын үнэлгээгээр орлого хүлээн зөвшөөрсөн үед дериватив санхүүгийн хөрөнгө, зардал хүлээн зөвшөөрсөн үед дериватив санхүүгийн өглөг тус тус бүртгэнэ.

Санхүүгийн тайланд деривативын дахин үнэлгээний орлого, зардлыг цэвэршүүлж, толилуулах ба мөн арилжааны орлогыг харгалзах зардалтай цэвэршүүлж, толилуулна.

<u>1) Форвард хэлцэл</u>

Гадаад валют, үнэт металлыг худалдах эсвэл худалдан авах форвард хэлцлээр хүлээсэн үүргийн дагуу үүсэх форвард арилжааны хөрөнгө, өр төлбөрийн нэрлэсэн дүнг хэлцэл хийсэн өдөр тэнцлийн гадуур бүртгэнэ.

Форвард хэлцлийн хугацаа дуусах хүртэл форвард хэлцлээр үүсэх деривативыг бодит үнэ цэнээр үнэлж, балансад толилуулах ба үүнтэй холбоотой орлого, зардлыг орлогын тайланд толилуулна.

Форвард хэлцлийг биелүүлэх буюу хэлцлийн хугацаа дуусахад арилжааны позицийг хааж, (форвард арилжааны деривативыг хааж, тэнцлийн гадуур бүртгэсэн форвард арилжааны хөрөнгө, өр төлбөрийн дансдыг зарлагадна) арилжааны орлого, зардлыг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

<u>2) Своп хэлцэл</u>

Хэлцлийн эхний арилжааг спот арилжааны нэгэн адил бүртгэж, үүссэн арилжааны зөрүүг орлого, зардалд бүртгэнэ. Өөрөөр хэлбэл деривативийн бодит үнэ цэнийг хөрөнгө эсвэл өр төлбөрөөр бүртгэнэ.

Своп хэлцлээр хийгдэх хоёр дахь арилжааг форвард арилжааны нэгэн адил бүртгэнэ.

Своп хэлцлийн хугацаа дуусах хүртэл своп хэлцлээр үүсэх деривативыг бодит үнэ цэнээр үнэлж, эхний арилжаанаас үүссэн хөрөнгө эсвэл өр төлбөртэй цэвэршүүлэх ба холбогдох орлого, зардлыг орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

<u>3) Опшин хэлцэл</u>

Хэлцэл байгуулсан өдрөөр опшин хэлцэлд заасан худалдах ба худалдан авах гадаад валют, үнэт металлын дүнгээр тэнцлийн гадуурх дансанд өглөг, авлага бүртгэнэ.

Хэлцэл хийсэн өдрөөр опшин арилжааны премиумыг деривативаар бүртгэж (премиум төлсөн бол хөрөнгө, премиум авсан бол өр төлбөр бүртгэнэ), хэлцлийн хугацаа дуусах буюу тухайн опшин хэрэгжих хүртэл дахин үнэлж, үнэлгээний зөрүү (деривативын бодит үнэ цэнийн өөрчлөлт)-г тайлант хугацааны орлого, зардалд бүртгэнэ.

Хэлцлийн хугацаа дуусах буюу тухайн опшин хэрэгжих үед опшины деривативыг хааж, арилжааны эцсийн үр дүнг орлого, зардалд хүлээн зөвшөөрнө. Мөн тэнцлийн гадуурх дансанд бүртгэсэн дүнг зарлагадна.

<u>4) Нуугдмал дериватив</u>

Санхүүгийн хэрэгсэл, санхүүгийн бус хэлцэлд агуулагдсан нөхцөл, заалт нь бие даасан деривативын нэгэн адил шинжийг хадгалсан байж болно. Энэ нь нуугдмал дериватив болно. Үндсэн хэлцэл ба нуугдмал деривативыг хоёуланг багтаасан хэлцлийг “холимог” хэлцэл гэнэ.

Бүх төрлийн гэрээ, хэлцэл, хэрэгсэлд дериватив багтсан байж болох ба үүний зорилго нь үндсэн гэрээнд тусгагдсан мөнгөн гүйлгээний шинж чанарыг өөрчлөх бөгөөд талуудын хооронд санхүүгийн эрсдэлийг харилцан ашигтайгаар шилжүүлэх явдал юм.

Гэрээнд заасан мөнгөн төлбөрийг өөрчлөх нь нэг буюу түүнээс олон нуугдмал дериватив агуулагдаж байгааг харуулах шинж тэмдэг болно. Холимог хэрэгслийн жишээнд биржийн индекс өөрчлөгдөхөд хүүгийн төлбөр дагаж өөрчлөгддөг зээл орно. Энэ гэрээний зээлийн өрийн үлдэгдлийг эргүүлэн төлөх нөхцөл нь үндсэн хэлцэл болох ба үүнд төлөгдөх хугацаа, мөнгөн дүн урьдчилан тодорхойлогдсон байдаг тул үүнийг "суурь нөхцөл" гэж нэрлэнэ. Энэ гэрээнд багтсан биржийн индекс өөрчлөгдөхөд төлөх хүүг өөрчлөх нөхцөл нь нуугдмал дериватив болох ба энэ нь үндсэн хэлцэлд заасан мөнгөн гүйлгээг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн өөрчлөх шалтгаан болж байна. Дээр дурдсанаар санхүүгийн хэрэгсэлд агуулагдсан боловч тухайн хэрэгслээс салган бусдад шилжүүлэх боломжтой эсвэл энэ нь гуравдагч талтай байгуулсан хэлцэл бол үүнийг нуугдмал дериватив гэж үзэхгүй ба бие даасан тусдаа дериватив болно. Тухайлбал, тусад нь хэрэгжүүлэх боломжтой хувьцаа худалдан авах эрх бүхий бонд нь үүний жишээ юм. Уг бондыг эзэмшигч нь бондоо эзэмшихийн зэрэгцээ хувьцаа худалдан авах эрхээ ашиглан бэлэн мөнгөөр хувьцаа авч болно. Энэ нь эзэмшигч тал опционыг хэрэгжүүлэхийн тулд бондоо эргүүлэн өгөх нөхцөлтэй хөрвөх бондоос ялгаатай.

Дараах нөхцлүүд бүгд биелсэн тохиолдолд нуугдмал дериватив үндсэн гэрээнээс салгаж, тусад нь деривативаар бүртгэнэ:

- Нуугдмал дериватив эдийн засгийн шинж чанар, эрсдэл нь үндсэн гэрээний эдийн засгийн шинж чанар, эрсдэлтэй нягт холбоогүй;
- Нуугдмал дериватив адил нөхцөл бүхий салангид хэрэгсэл дериватив тодорхойлолтыг хангасан;
- Холимог гэрээг ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр үнэлж, илэрхийлээгүй байх.

Дээр тодорхойлсон гурван нөхцлийн сүүлийн нөхцөлтэй холбогдуулан НББОУС 39-д заасны дагуу доор дурдсанаас бусад тохиолдолд гэрээнд нэг буюу түүнээс олон үүсмэл дериватив агуулагдсан үед банк холимог гэрээг ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрөөр хүлээн зөвшөөрч, бүртгэж болно:

- Нуугдмал дериватив улмаас гэрээнд заасан мөнгөн гүйлгээ үлэмж хэмжээгээр өөрчлөгдөөгүй; эсвэл
- Ижил төстэй холимог хэрэгслийн хувьд нуугдмал хэрэгслийг салгаж бүртгэхийг анхнаасаа хориглосон тохиолдолд нэмэлт шинжилгээ хийлгүйгээр салгаж бүртгэхгүй нь тодорхой байгаа үед. Тухайлбал, зээлийн хорогдуулсан өртөгтэй ойролцоо дүнгээр зээлийг урьдчилан төлж барагдуулахыг зөвшөөрсөн зээлийн гэрээний заалт.

Хэрэв нуугдмал дериватив салгаж бүртгэсэн бол бусад дериватив дансанд бүртгэж, санхүүгийн тайланд тусад нь харуулна.

Дээр тайлбарласнаар гэрээнд заасан мөнгөн гүйлгээний зарим хэсэг нь эсвэл бүгдээрээ нуугдмал деривативаас хамаарна. Энэ нь тодорхой хүүгийн түвшин, санхүүгийн хэрэгслийн үнэ, барааны үнэ, гадаад валютын ханш, үнэ болон хүүгийн индекс, зээлийн зэрэглэл буюу зээлийн индекс болон бусад хувьсагчаас шалтгаалдаг. Жишээлбэл: нийлмэл хэрэгслийн зарим мөнгөн гүйлгээ нь салангид дериватив ынхтай адил байдаг.

Санхүүгийн хэрэгсэлд хамаарах бүх үндсэн эрсдэлийг бүртгэлд зохих ёсоор тусгахад НББОУС 39-д тусгасан дээрх шаардлагуудын зорилго оршино. Тухайлбал, зээлийн хэлцэл нь хүүгийн бус эрсдэлд хамаарах нуугдмал дериватив агуулсан байж болно. Хэрэв уг өрийн хэрэгслээс хүүгийн бус эрсдэлд хамаарах активыг салгаж бүртгэхийг шаардаагүй тохиолдолд түүний бүртгэл нь уг хоёр хэрэгсэлтэй ижил эдийн засгийн үр дагавар бүхий хоёр тусдаа гэрээ байгуулснаас ялгаатай хийгдэнэ. Иймээс нуугдмал дериватив салгаж бүртгэх нь гэрээний үндсэн нөхцөл, эрсдэлд харгалзах активыг харуулахын зэрэгцээ салангид дериватив тай нэгэн адил бүртгэх боломжийг бүрдүүлнэ. Гэхдээ нуугдмал дериватив үндсэн гэрээнээс салгаж үнэлэхийн тулд дүн шинжилгээ хийх болон мэргэжлийн үнэлэлт өгөх шаардлагатай болдог ба заримдаа ингэж салгаж үнэлэх боломжгүй байдаг. Иймд үндсэн гэрээтэй нягт холбоотой нуугдмал дериватив ыг салгахгүй.

Нуугдмал дериватив ыг тодорхойлсны дараа түүний эдийн засгийн шинж чанар, эрсдэл (дериватив ын үнэ цэнийг өөрчлөх хүчин зүйлс) нь үндсэн гэрээний эдийн засгийн шинж чанар, эрсдэлтэй нягт холбоотой эсэхийг тогтооно. НББОУС 39-д ямар үед нягт холбоотой гэж үзэх талаар заагаагүй боловч уг стандартын хэрэгжүүлэх удирдамжинд нуугдмал дериватив үндсэн гэрээ хоёр нягт холбоотой байдаг болон холбоогүй байдаг жишээнүүдийг харуулсан. Үүнээс үзэхэд нуугдмал дериватив ын эдийн засгийн шинж чанар, эрсдэл нь үндсэн гэрээний эдийн засгийн шинж чанар, эрсдэлтэй тохирч байгаа эсэхэд анхаарал хандуулж байгаа явдал юм.

Нягт холбоотой эсэхийг тогтоох гол үзүүлэлт нь эрсдэл юм. Деривативын эрсдэлийг хүүгийн түвшин, гадаад валютын ханш, үнэ гэх мэт үндсэн үзүүлэлт болон төлбөр барагдуулах дүнг тодорхойлох үзүүлэлтийг ашиглан тогтооно. Үндсэн хэлцэлтэйгээ эдийн засгийн нягт холбоотой байдаг хүүгийн дээд, доод түвшний кап, флоор (cap and floor of the interest rate) гэх зэрэг нуугдмал хэрэгслийг нягт холбоотой гэж үзнэ. Өөрөөр хэлбэл өрийн хэрэгсэлд агуулагдсан нуугдмал дериватив нь эдийн засгийн шинж чанарын хувьд өмчийн хэрэгсэл болох (жишээлбэл, өгөөжийн түвшин нь хувьцааны арилжааны индексээр тодорхойлогддог дериватив) бол деривативын эдийн засгийн шинж чанар (хувьцааны үнийн эрсдэл) нь үндсэн гэрээний эдийн засгийн шинж чанараас (хүүгийн түвшний эрсдэл) ялгаатай гэж үзнэ. Энэ тохиолдолд нуугдмал деривативыг үндсэн гэрээтэй нягт холбоогүй гэж үзнэ.

Төгрөгөөр олгосон боловч харилцагч ам.доллар-төгрөгийн ханштай холбоотойгоор зээлийн нэрлэсэн үнийн өөрчлөлтийг төлөх нөхцөлтэй зээлд ийм дериватив ажиглагддаг. Энэ үед үндсэн хэрэгсэл нь зээл, нуугдмал хэрэгсэл нь зээлийн мөнгөн төлбөрийн дүнг өөрчилж буй гадаад валютыг заасан гэрээний нөхцөл болж байгаа юм. НББОУС 21-д зааснаар мөнгөн зүйлсэд хамаарах гадаад валютын ханшийн өөрчлөлтийг НББОУС 39-ын дагуу тайлант хугацааны орлого, зардалд бүртгэх тул уг деривативыг үндсэн хэрэгслээс салгаж бүртгэхгүй.

Өөр нэг тохиолдол нь түрээсийн гэрээнд агуулагдсан нуугдмал дериватив бөгөөд дараах нуугдмал деривативыг үндсэн гэрээтэй нягт холбоотой гэж тооцно: (i) түрээсийн төлбөрийг хэрэглээний үнийн индекстэй харьцуулсан индекс гэх мэт инфляцитай холбоотой индекс (түрээсийг хөшүүргийн зорилгоор ашиглаагүй боловч уг индекс нь аж ахуйн нэгжийн эдийн засгийн орчин дахь инфляциас хамааралтай), (ii) холбогдох борлуулалтанд үндэслэн түрээсийн болзошгүй төлбөр төлөх эсвэл (iii) хөвөгч хүүгийн түвшинд үндэслэн түрээсийн болзошгүй төлбөр төлөх. Үндсэн гэрээнд агуулагдсан хөшүүргийн нөхцлөөс шалтгаалан гэрээний мөнгөн гүйлгээний зарим нь эсвэл бүгдээрээ өөрчлөгдөж болно. Ерөнхийдөө нэг буюу хэд хэдэн үндсэн үзүүлэлтээр тодорхойлох гэрээний зарим буюу бүх мөнгөн төлбөрийг уг үзүүлэлтүүдээр үржүүлэх буюу уг үзүүлэлтүүдэд гарсан өөрчлөлтөөр тохируулах замаар өөрчилж барагдуулдаг тохиолдолд холимог хэрэгсэлд хөшүүргийн нуугдмал нөхцөл агуулагддаг. Үүний жишээ нь түрээсийн төлбөрийг инфляцийн индексээр үржүүлж гаргадаг тохиолдол юм. Энэ жишээнд деривативыг дериватив бус үндсэн хэлцлээс салгаж бүртгэх шаардлагатай. Хөшүүргийн үр нөлөөлөл нь зөвхөн нуугдмал дериватив хамаарах ба үүнийг үндсэн гэрээтэй “нягт холбоотой” гэж үзнэ. Дериватив бус үндсэн гэрээтэй “нягт холбоотой” гэж үзсэн нуугдмал дериватив л зөвхөн хөшүүрэг нөлөөлнө. Хөшүүрэг гэж үзсэн эсэхээс хамааралгүйгээр “нягт холбоогүй” нуугдмал деривативыг үндсэн хэлцлээс салгаж бүртгэж болно.

Үндсэн хэрэгслээс салгаж бүртгэх нуугдмал деривативын жишээ:

- Бараа бүтээгдэхүүний үнийг индексжүүлсэн хүү болон үндсэн төлбөр бүхий өрийн хэрэгсэл (өрийн хэрэгслийн хүү болон өрийн үлдэгдлийг алт гэх мэт барааны үнэтэй индексжүүлсэн) нь үндсэн гэрээтэйгээ нягт холбоогүй. Учир нь үндсэн гэрээний болон нуугдмал деривативын эрсдэлүүд хоорондоо холбоогүй байдаг.
- Хувьцааг индексжүүлсэн хүү болон үндсэн төлбөр бүхий өрийн хэрэгсэл (өрийн хэрэгслийн хүү болон өрийн үлдэгдлийг хувьцааны үнэтэй индексжүүлсэн) нь үндсэн гэрээтэйгээ нягт холбоогүй. Учир нь үндсэн гэрээ болон нуугдмал деривативын эрсдэлүүд нь хоорондоо холбоогүй байдаг.
- Хөрвөх өр төлбөрийн өөрийн хөрөнгө болох хэсэг нь уг хэрэгслийг эзэмшиж буй талын хувьд өрийн үндсэн хэрэгсэлтэй нягт холбоогүй.

Нуугдмал дериватив үндсэн гэрээтэй “нягт холбоотой” эсэхийг үнэлэхдээ тухайн нуугдмал дериватив төдийгүй үндсэн гэрээний эдийн засгийн шинж чанар, эрсдэлийг таньж мэдэх шаардлагатай болдог тул үндсэн гэрээ, түүнд агуулагдсан байж болох аливаа деривативыг тодорхойлоход ашиглах ерөнхий зарчмыг анхаарна. Дериватив агуулсан үндсэн хэлцлийн нийтлэг жишээг доор үзүүлэв. Банк доорх төрлийн хэлцэлд нуугдмал дериватив агуулагдсан эсэхийг шинжилж, тогтооно.

- Өрийн хэрэгсэл, үүнээс хөрвөх бонд;
- Өмчийн хэрэгсэл;
- Түрээс;
- Тусгай нөхцөл заасан гэрээ, хэлцэл (ирээдүйд гүйцэтгэлийг нь хэрхэн хангах нөхцлийг харилцан тохиролцсон гэрээ), тухайлбал, худалдах, худалдан авах гэрээ (худалдан авагч болон борлуулагч талын аль алиных нь бүртгэлийн валютаас ялгаатай валютаар илэрхийлэгдсэн худалдан авалтын гэрээ эсвэл барааны үнийн опционыг багтаасан үнийн дээд ба доод хязгаарлалтыг тогтоосон тогтмол тооны барааны борлуулалтын хоёр жилийн хугацаа бүхий гэрээ);

- Даатгалын гэрээ;

Холимог гэрээнд “дериватив” гэсэн ойлголтыг бараг ашигладаггүй тул гэрээний нөхцөлд үнэлэлт, дүгнэлт өгсний үндсэн дээр нуугдмал дериватив агуулагдсан эсэхийг тогтооно. Нуугдмал дериватив агуулагдсан гэж үзэх тодорхой нөхцлүүд байдаг. Ийм нөхцөлд тодорхой томъёолол ашиглан үнэ тогтоох, арилжаалах боломжийг олгосон эрх, индексжүүлсэн байх, татгалзах, хойшлуулах, буцааж худалдан авах, эргүүлэн өгөх эрхтэй байх, шагнал/хязгаарлалт тогтоох зэрэг нөхцөл багтана. Гэрээнд нуугдмал дериватив агуулагдсан эсэхийг тогтоох өөр нэг арга нь гэрээний нөхцлийг (хүүгийн түвшин, дуусгавар хугацаа гэх мэт) ижил төстэй, энгийн хэлцэлтэй харьцуулах юм. Өөрөөр хэлбэл банк зах зээл дээрх ердийн нөхцөл ба гэрээний нөхцөл хоорондоо ялгаатай эсэхийг магадлана. Ажиглагдсан зөрүүг судалж, нуугдмал деривативыг илрүүлж болно.

Өмчийн хэлцэлд агуулагдсан нуугдмал деривативын хувьд юуны өмнө тухайн үндсэн хэлцэл нь өмчийн хэлцэл болох эсэхийг тогтоох шинжилгээг хийнэ. Үүний дараа үндсэн гэрээнд урьдчилан тодорхойлж, заасан дуусгавар хугацаа байгаа эсэхийг тогтоох ба ийм хугацаа заагаагүй бол аж ахуйн нэгжийн цэвэр хөрөнгөөс ноогдох хувь хэсгийг тогтооно. Үндсэн хэлцэлд өмчлөлийн эрх агуулагдсан бол энэ нь өмчийн хэлцэл болно. Өмчийн хэрэгслийн үнэ цэн нь хувьцааны үнэ буюу индексийг тодорхойлох суурь үзүүлэлт болж ашиглагдана. Иймээс нягт холбоотой байхын тулд нуугдмал деривативт өмчийн шинж чанар хадгалагдсан байх шаардлагатай болно.

Өрийн хэрэгслийн үнэлгээг гэрээнд хамаарах хүүгийн түвшинг ашиглан тодорхойлно. Өрийн хэрэгсэлд хамаарах хүүгийн түвшинг ихэнхдээ дараах хүчин зүйлсийг ашиглан тогтооно: эрсдэлгүй хүүгийн түвшин, зээлийн эрсдэл, хүлээгдэж буй дуусгавар хугацаа, хөрвөх чадварын эрсдэл. Иймд дээр дурдсан шалтгаануудын улмаас өрийн хэрэгслийн өгөөжид нөлөөлдөг нуугдмал деривативыг нягт холбоотой гэж үзнэ. Өөрөөр хэлбэл нуугдмал деривативын эдийн засгийн шинж чанар, эрсдэл нь хүүгийн түвшинтэй холбоогүй (хувьцааны эсвэл барааны шинж чанартай) тохиолдолд энэ нь үндсэн гэрээтэй нягт холбоогүй гэж үзнэ. Санхүүгийн болон үйл ажиллагааны түрээсийн гэрээнд нуугдмал дериватив агуулагдсан байж болно. Энэ үед уг нуугдмал дериватив нь түрээсийн гэрээтэй нягт холбоотой эсэхийг тогтоохын тулд өрийн хэрэгсэлд ашиглаж байсан аргуудыг хэрэглэнэ.

Дээр дурдсанаар банк гэрээ, хэлцэлд тал болон оролцох үед нуугдмал деривативыг үндсэн гэрээнээс салгаж, деривативаар бүртгэх шаардлагатай эсэхийг эхлээд үнэлнэ. Гэрээний нөхцөл өөрчлөгдөж, үүний улмаас нуугдмал дериватив, үндсэн хэлцэл эсвэл эдгээртэй хоёулантай нь холбоотой ирээдүйн мөнгөн гүйлгээ нь өмнө ашиглаж байсан хүлээгдэж буй мөнгөн гүйлгээнээс мэдэгдэхүйц хэмжээгээр өөрчлөгдөх хүртэл анх хийсэн дээрх үнэлгээ өөрчлөгдөхгүй. Гэрээний нөхцөл өөрчлөгдсөний улмаас гэрээний ирээдүйн мөнгөн гүйлгээ нь өмнө ашиглаж байсан хүлээгдэж буй мөнгөн гүйлгээнээс мэдэгдэхүйц хэмжээгээр өөрчлөгдсөнөөс бусад тохиолдолд зах зээлийн нөхцөл байдал өөрчлөгдсөнөөс үүдэн хүлээгдэж буй мөнгөн гүйлгээ мэдэгдэхүйц хэмжээгээр өөрчлөгдсөн бөгөөд энэ нь үндсэн хэлцэл болон нуугдмал дериватив хоорондоо нягт холбоотой эсэхийг тогтоох гол үзүүлэлт болон ашиглагдсан нөхцөлд мөн анхны үнэлгээг өөрчлөхгүй.

Түүнчлэн ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх санхүүгийн хэрэгслийн ангилал (үүнд арилжааны үнэт цаас мөн хамаарна)-аас гарган, өөр ангилалд шилжүүлэн ангилж буй санхүүгийн хөрөнгийн хувьд нуугдмал деривативыг салгаж бүртгэх шаардлагатай эсэхийг үнэлж үзэхийг НББОУС 39 шаардсан байдаг. Энэхүү үнэлгээг дараах хугацааны аль сүүлд тохиолдсон үйл явдалд суурилан гүйцэтгэнэ: (а) банк гэрээний тал болсон өдөр эсвэл (б) гэрээний мөнгөн төлбөрт мэдэгдэхүйц өөрчлөгдөх нэмэлт өөрчлөлтийг гэрээнд оруулсан өдөр. Нуугдмал деривативаар бүртгэсэн гэрээний нөхцөл нь тухайн өдрөөр нуугдмал деривативаар бүртгэх нөхцлөөс зөрүүгүй байна.

<u>5) Хейдж</u>

Санхүүгийн хэрэгслийн өртөг, хорогдуулсан өртөг эсвэл үнэлгээний өсөлт, бууралтыг өөрийн хөрөнгөнд бүртгэх бодит үнэ цэнээр үнэлсэн хөрөнгө, өр төлбөр, эсвэл санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөөгүй төлөвлөсөн арилжаа, тэнцлийн гадуур бүртгэсэн болзошгүй үүрэг зэрэгт хейдж хийх зорилгоор дериватив санхүүгийн хэрэгсэл гаргадаг. Үүний үр дүнд холбогдох орлого, зардлыг хүлээн зөвшөөрч, бүртгэх хугацаа зөрдөг.

Хейджийн хэрэгсэл болон хейджээр хамгаалагдсан зүйлд хамаарах орлого, зардлыг бүртгэх хугацааг өөрчлөх замаар зөрж буй хугацааг тохируулахад хейджийн бүртгэл чиглэнэ. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн ердийн зарчмын дагуу деривативын орлого, зардлыг тайлант үеийн орлого, зардалд бүртгэсэн тохиолдолд үүсэх тогтворгүй байдлаас зайлсхийхтэй холбоотой.

Хейдж хийсэн зүйлийн нийтлэг жишээг доор харуулав:

- Тогтмол ба хөвөгч хүүтэй зээлийн эх үүсвэр (хүүгийн эрсдэл);
- Хийгдэх магадлал өндөртэй гадаад валютаар илэрхийлэгдсэн борлуулалт, худалдан авалт (гадаад валютын эрсдэл);
- Гадаад валютаар илэрхийлэгдсэн авлага, өглөг, эх үүсвэр, хөрөнгө оруулалт (гадаад валютын эрсдэл);
- Борлуулахад бэлэн өмчийн хөрөнгө оруулалт (хувьцааны үнийн эрсдэл);
- Зээл ба авлага (хүүгийн эрсдэл болон зээлийн эрсдэл);
- Хийгдэх магадлал өндөртэй борлуулалт, худалдан авалт (өргөн хэрэглээний барааны үнийн эрсдэл).

Зээлийн эрсдэл, зах зээлийн эрсдэл, төлбөрийн чадварын эрсдэл гэх мэт бизнесийн эрсдэлийн улмаас санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөртэй холбоотойгоор алдагдал хүлээх эрсдэлээс хамгаалах зорилгоор банк хейдж хийдэг. Дериватив хэрэгсэл, цэвэр позиц, санхүүгийн бус хөрөнгө, санхүүгийн бус өр төлбөр (гадаад валютын эрсдэлээс хамгаалахаас бусад тохиолдолд), өөрийн гаргасан хувьцаа зэрэгт хейдж хийж болохгүй.

Хейджийн бүртгэлийг доор дурдсан гурван төрлийн хейджид ашиглана:

- Хүүгийн түвшин, гадаад валютын ханш, зах зээлийн үнэ гэх мэт зарим үзүүлэлт өөрчлөгдсөнөөс шалтгаалан хейджээр хамгаалагдсан зүйлийн *бодит үнэ цэн* өөрчлөгдөх эрсдэлд хейдж хийсэн үед хейджийн хэрэгсэлд хамаарах орлого, зардал болон хейджээр хамгаалагдсан зүйлд хамаарах цэвэршүүлж гаргасан орлого, зардлыг тайлант хугацааны орлого, зардалд хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Энэ нь бодит үнэ цэнийн хейдж юм.
- Дээрх үзүүлэлт өөрчлөгдсөнөөс шалтгаалан хейджээр хамгаалагдсан зүйлийн ирээдүйн *мөнгөн гүйлгээ* өөрчлөгдөх эрсдэлд хейдж хийсэн үед хейджийн хэрэгсэлд хамаарах орлого, зардлыг анхны удаад бусад дэлгэрэнгүй орлогод бүртгээд дараа нь хейджээр хамгаалагдсан зүйлийн орлого, зардлыг хүлээн зөвшөөрч, бүртгэсэн тайлант хугацааны орлого, зардалд өөрийн хөрөнгөөс шилжүүлж бүртгэнэ. Энэ нь мөнгөн гүйлгээний хейдж юм.
- Гадаад валютын ханш өөрчлөгдөхөд гадаад үйл ажиллагааны *цэвэр хөрөнгө оруулалтын* дансны үнэ өөрчлөгдөх эрсдэлд хейдж хийсэн үед хейджийн хэрэгсэлд хамаарах орлого, зардлыг анхны удаад бусад дэлгэрэнгүй орлогод бүртгээд дараа нь уг гадаад үйл ажиллагааг худалдсан буюу данснаас хассан тайлант хугацааны орлого, зардалд шилжүүлж бүртгэнэ. Энэ нь гадаад үйл ажиллагааны цэвэр хөрөнгө оруулалтын хейдж бөгөөд гадаад дахь охин компанид оруулсан хөрөнгө оруулалтыг гадаад валютаар илэрхийлэгдсэн зээлээр санхүүжүүлэхэд ашиглагдана. Ийм хейдж нь хейджийн дээрх хоёр төрөлтэй харьцуулахад ховор тохиолддог.

Дараах шалгууруудыг бүгдийг хангасан гэрээ, хэлцлийг хейджийн нягтлан бодох бүртгэлээр бүртгэнэ.

- Хейджийн эхний өдөр хейджийг тодорхойлж, баримтжуулах ба уг хейджийг хэрэгжүүлэх банкны эрсдэлийн удирдлагын зорилго, стратегийг гаргасан байна. Баримтжуулалтанд хейджийн хэрэгслийг тодорхойлсон байдал, хейджээр хамгаалагдсан зүйл эсвэл ажил гүйлгээ, хамгаалагдсан эрсдэл, хейджийн үр өгөөжийг хэрхэн үнэлэх талаар тусгана.
- Тодорхой хейджтэй холбогдуулан анх баримтжуулсан эрсдэлийн удирдлагын стратегийн дагуу хейдж хийсэн эрсдэлд хамаарах бодит үнэ цэн, мөнгөн гүйлгээний өөрчлөлтийг тухайн хейдж үр өгөөжтэйгээр нөхөж чадна гэж таамагласан. Дараах хоёр нөхцөл хангагдаж байгаа тохиолдолд хейджийг үр өгөөжтэй гэж үзнэ:
    - Хейджийг бүртгэсэн эхний өдөр болон дараагийн тайлант үеүдэд хейдж хийсэн эрсдэлд хамаарах бодит үнэ цэн, мөнгөн гүйлгээний өөрчлөлтийг тухайн хейдж үр өгөөжтэйгээр нөхөж чадна гэж таамаглаж байгаа. Энэ таамаглалыг янз бүрийн арга замаар тайлбарлаж болно. Тухайлбал, хейджийн эрсдэлд хамаарах хейджээр хамгаалагдсан зүйлийн бодит үнэ цэн, мөнгөн гүйлгээнд гарсан өнгөрсөн хугацааны өөрчлөлтийг хейджийн хэрэгслийн бодит үнэ цэн, мөнгөн гүйлгээнд гарсан өнгөрсөн хугацааны өөрчлөлттэй харьцуулах эсвэл хейджээр хамгаалагдсан зүйл ба хейджийн хэрэгслийн бодит үнэ цэн буюу мөнгөн гүйлгээний хоорондох статистикийн хамаарлыг тайлбарлах гэх мэт.
    - Хейджийн үр өгөөжийн бодит утга 80-125 хувийн хооронд гарсан.
- Мөнгөн гүйлгээний хейджийн хувьд түүнд хамаарах төлөвлөгөөт ажил гүйлгээ хэрэгжих магадлал өндөртэй байх.

- Хейджийн үр өгөөжийг найдвартай хэмжих боломжтой байх. Мөн хейдж хийсэн эрсдэлд хамаарах зүйлийн мөнгөн гүйлгээ, бодит үнэ цэн болон хейджийн хэрэгслийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжтой байх.
- Хейджийн хугацааны туршид хейджийг тодорхой давтамжтайгаар байнга үнэлж, үр өгөөжийг нь тодорхойлж байна. Янз бүрийн шалтгааны улмаас хейдж үр өгөөжгүй болдог. Тухайлбал, хейджээр хамгаалагдсан зүйл ба хейджийн хэрэгслийг ялгаатай валютаар илэрхийлсэн, дуусгавар хугацаа нь ялгаатай, эдгээрт ялгаатай суурь хүү болон хувьцааны индекс ашигладаг, өөр өөр зах зээлийн өргөн хэрэглээний барааны үнийг ашигладаг, янз бүрийн талуудын эрсдэлд хамаардаг, эсвэл хейджийг бүртгэх өдөр хейджийн хэрэгслийн бодит үнэ цэн нь тэгээс ялгаатай утгатай байх.

Гадны этгээдтэй хийсэн бүх төрлийн дериватив гэрээг хейджийн хэрэгсэл болгон үзэх боломжтой. Харин дериватив бус санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөр нь гадаад валютын эрсдэлээс хамгаалах тохиолдолд л хейджийн хэрэгсэл болно. Жишээлбэл, хорогдуулсан өртгөөр бүртгэсэн дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтыг гадаад валютын эрсдэлээс хамгаалсан тохиолдолд хейджийн хэрэгслээр тодорхойлж болно.

Банкны гаргасан өөрийн өмчийн хэрэгсэл нь санхүүгийн өр төлбөр болохгүй тул хейджийн хэрэгсэл болохгүй.

Санхүүгийн хэрэгслийг хэсэгчлэн үзэж, тодорхой нэг хэсгийг хейджийн хэрэгсэл гэж тодорхойлж болно. Тухайлбал, хүүний түвшний свопын нэг хэсгийг компанийн өр төлбөрийн хүүний түвшний эрсдэлд хамаарах мөнгөн гүйлгээний хейдж гэж тодорхойлж болох юм. Энэ тохиолдолд хейджээр тодорхойлсон хэсэгт харгалзах бодит үнэ цэнийн өсөлт, бууралтыг өөрийн хөрөнгийн хэсэгт сан байгуулан тусгах ба харин үлдсэн хэсэгт нь харгалзах өсөлт, бууралтыг тайлант хугацааны орлого, зардалд бүртгэнэ.

Хоёр, түүнээс дээш тооны дериватив ба тэдгээрийн тодорхой хэсгийг хамтад нь хейджийн хэрэгсэл гэж тодорхойлж болно.

Дараах тохиолдолд хейджийн бүртгэлийг зогсооно:

- Хейджийн хэрэгслийн хугацаа дууссан, эсвэл хэрэгслийг худалдсан, хэрэгжүүлсэн эсвэл зогсоосон.
- Тухайн хейдж нь хейджийн шалгуурыг хангахаа болисон.
- Мөнгөн гүйлгээний хейджийн хувьд төлөвлөж буй ажил гүйлгээ хэрэгжихээ болисон.
- Банк тухайн хэрэгслийг хейдж гэж үзэхээ болисон.

Г. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

1) Энгийн дериватив

Деривативыг анх удаа хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр нь үнэлэх ба бодит үнэ цэнийн өөрчлөлтийг орлого, зардалд бүртгэнэ. Хэлцэл хийсэн өдөр деривативын бодит үнэ цэнийг тэг гэж үнэлсэн бол уг деривативыг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, харуулахгүй. Деривативын нэрлэсэн дүнг тэнцлийн гадуурх дансанд бүртгэнэ. Деривативын бодит үнэ цэнийг үнэлэх арга, загварыг банк дотооддоо тогтоож, мөрдөнө. Хэрэв банк деривативыг үнэлэх тусгайлсан аргачлалыг дотооддоо батлаагүй бол Монголбанкнаас зарласан ханш буюу эсвэл зах зээлийн ханшийг үнэлгээний сууриар тооцож, үнэлгээ хийнэ. Деривативыг бодит үнэ цэнээр дахин үнэлэхдээ хэлцлийн хугацаа дуусах үед эсвэл тухайн арилжааны позици хаагдах хүртэл сард нэгээс доошгүй удаа гүйцэтгэнэ. Харин жилийн эцсийн тайланд бүх деривативыг үнэлж, толилуулна.

Дериватив хэлцлээр үүсэх өглөг, авлагын зөрүүг бодит үнэ цэнээр үнэлнэ.

Деривативын бодит үнэ цэн нь тухайн хэлцлээр үүсэх өглөг ба авлагын зөрүүгээр тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл бодит үнэ цэн эерэг бол хөрөнгө, сөрөг бол өр төлбөр үүснэ.

Харин опшин хэлцлийн хувьд премиумыг (premium) тэнцэлд деривативаар бүртгэж, хэлцлийн хугацаа дуусах буюу тухайн арилжааны позици хаагдах хүртэл дахин үнэлнэ.

2) Хейджийн хэрэгсэл

Бодит үнэ цэнийн хейдж, мөнгөн гүйлгээний хейдж, гадаадын цэвэр хөрөнгө оруулалтын хейдж гэсэн гурван төрлийн хейдж байдаг.

Бодит үнэ цэнийн хейджийн хувьд дериватив хейджийн хэрэгслийг бодит үнэ цэнээр нь хэмжинэ. Бодит үнэ цэнийн хейджийн хувьд хейджээр хамгаалагдсан зүйл ба хейджийн хэрэгслийн аль алиных нь бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тайлант үеийн орлого, зардалд бүртгэх замаар үүсэх орлого, зардлыг

тэнцвэржүүлнэ. Хейджийн үр нөлөөгөөр тодорхойлогдсон хөрөнгө, өр төлбөрийг бодит үнэ цэнээр үнэлнэ. Нэг санхүүгийн хэрэгслийн үнэлгээний орлого нь нөгөө хэрэгслийнхээ үнэлгээний зардлыг хаана. Хейдж бүрэн үйлчилж байгаа тохиолдолд эдгээр орлого, зардал яг тэнцэх ба харин тэнцэхгүй тохиолдолд эдгээр орлого, зардлын зөрүүгээр олз, гарз тайлагнана.

Мөнгөн гүйлгээний хейджийн хувьд хейджийн хэрэгслийн орлого, зардлын үр өгөөжтэй хейдж гэж тодорхойлогдсон хэсгийг "Дахин үнэлгээний сан – Борлуулахад бэлэн үнэт цаас" дансанд, харин үр өгөөжгүй хэсгийг тайлант үеийн орлого, зардалд хүлээн зөвшөөрнө.

Хейджийн үр өгөөжийг тодорхойлохдоо хейджийн хэрэгсэл ба хейджээр хамгаалагдсан зүйлийн бодит үнэ цэн буюу мөнгөн гүйлгээний өөрчлөлтийг хооронд нь харьцуулна. Хейджээр хамгаалагдсан зүйл ба хейджийн хэрэгслийн бодит үнэ цэнийг үнэлэх арга, загварыг банк дотооддоо тодорхойлж мөрдөнө.

Хейджийн үр өгөөжийг тооцоолж гаргаад, 80% - 125% хооронд гарч байгаа тохиолдолд уг хейджийг үр өгөөжтэй байна гэж үзнэ. Энэ интервалд багтаагүй бол хейджийг үр өгөөжгүй гэж үзнэ. Жишээлбэл, бодит утга нь хейджийн хэрэгслийн зардлын хувьд 120 төгрөг, мөнгөн зүйлийн орлогод 100 төгрөг байгаа тохиолдолд хейджийн үр өгөөжийг тодорхойлоход 120/100 харьцуулбал 120%, 100/120 харьцуулбал 83% гарна. Энэ жишээний хувьд хейджийн бүртгэлийн бусад нөхцөл хангагдсан тохиолдолд банк уг хейджийг үр өгөөжтэй хейдж гэж дүгнэнэ.

Мөнгөн гүйлгээний хейджийн хувьд хейджийн бүртгэлийг зогсоосон бол дахин үнэлгээний санд хуримтлуулсан дүнг орлого, зардалд шилжүүлэн бүртгэнэ.

Д. БҮРТГЭЛ

1) Форвард арилжаа

Гадаад валютыг форвард хэлцлээр худалдан авах арилжаа

Форвард хэлцлийг байгуулсан өдрөөр тэнцлийн гадуур форвард хэлцлийн авлага, өглөгийг бүртгэх ба форвард хэлцлийн хугацаа дуусах буюу позици хаагдахад тэнцлийн гадуурх авлага, өглөгийг зарлагадна. Санхүүгийн тайлагналын өдрөөр форвард хэлцлийн бодит үнэ цэнийг үнэлнэ. Бодит үнэ цэн эерэг гарсан тохиолдолд хөрөнгө, сөрөг гарсан тохиолдолд өр төлбөр бүртгэнэ.

Санхүүгийн тайлагналын өдөр форвард хэлцлийн деривативыг үнэлээд, өр төлбөр хүлээн зөвшөөрсөн бол (тэнцлийн дотуур)

Дебит: Деривативын бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн зардал
Кредит: Форвард арилжаа (өр төлбөр)

Санхүүгийн тайлагналын өдөр форвард хэлцлийн деривативыг үнэлээд, хөрөнгө хүлээн зөвшөөрсөн бол (тэнцлийн дотуур)

Дебит: Форвард арилжаа (хөрөнгө)
Кредит: Деривативын бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн орлого

Форвард хэлцлийн хугацаа дуусахад худалдан авах валютын хэлцлийн дүнгээр холбогдох гадаад валютын дансыг нэмэгдүүлнэ.

Дебит: Мөнгөн хөрөнгийн гадаад валютын холбогдох данс
Кредит: Валют хөрвүүлэлтийн түр данс

Хэлцлээр худалдах валютын гэрээнд заасан ханшаар илэрхийлсэн дүнгээр холбогдох мөнгөн хөрөнгийн дансыг хорогдуулна.

Дебит: Валют хөрвүүлэлтийн түр данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Форвард арилжаа дансны үлдэгдлийг дээрх гүйлгээнээс үүссэн валют хөрвүүлэлтийн түр дансанд хаана.

Форвард арилжааны данс кредит үлдэгдэлтэй бол

Дебит: Форвард арилжаа
Кредит: Валют хөрвүүлэлтийн түр данс

Форвард арилжааны данс дебит үлдэгдэлтэй бол

Дебит: Валют хөрвүүлэлтийн түр данс
Кредит: Форвард арилжаа

Дээрх бичилтүүд хийгдсэний дараа валют хөрвүүлэлтийн түр дансны үлдэгдлээр арилжааны үр дүн тодорхойлогдоно.

Хэрэв ашигтай бол

Дебит: Валют хөрвүүлэлтийн түр данс
Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Хэрэв алдагдалтай бол

Дебит: Гадаад валютын арилжааны зардал
Кредит: Валют хөрвүүлэлтийн түр данс

Дээрх гүйлгээнүүдийн үр дүнд Валют хөрвүүлэлтийн түр данс болон тухайн хэлцэлтэй холбоотой үүссэн Форвард арилжааны данс тэг үлдэгдэлтэй болно.

Мөн гадаад валютын хэрэгжээгүй (цэвэр) орлого, зардалд бүртгэсэн деривативын бодит үнэ цэнийн өөрчлөлтийг гадаад валютын арилжааны хэрэгжсэн орлого, зардалд шилжүүлэн бүртгэнэ. Ингэхдээ дараах журналтын бичилтийг хийнэ.

Хэрэгжээгүй цэвэр орлогын хувьд:

Дебит: Деривативын бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн орлого (хэрэгжээгүй)
Кредит: Гадаад валютын арилжааны орлого (хэрэгжсэн)

Хэрэгжээгүй цэвэр зардлын хувьд:

Дебит: Гадаад валютын арилжааны зардал (хэрэгжсэн)
Кредит: Деривативын бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн зардал (хэрэгжээгүй)

Үнэт металлын хувьд дээрхтэй нэгэн адил бүртгэх боловч Бусад санхүүгийн бус хөрөнгө болон үнэт металлын орлого, зардал дансдыг ашиглан бүртгэнэ.**Жишээ: Гадаад валют худалдан авах форвард арилжаа**

Банк 12-р сарын 6-нд биелэгдэхээр 1 сая ам.долларыг 1500 төгрөгийн ханшаар худалдан авах форвард хэлцлийг 10-р сарын 6-нд хийсэн. 10-р сарын 6-нд тус банк энэ хэлцэлтэй холбогдуулан зээлд хамаарах үүргийг тэнцлийн гадуурх дансанд бүртгэсэн. 10-р сарын 31-нд Монголбанкны албан ханш 1400 төгрөг байсан ба 11-р сарын 30-нд албан ханш 1550 болсон. Харин хэлцэл биелэгдэх өдөр ханш 1600 болсон гэж үзье.

Энэ жишээний хувьд 10-р сарын 31-ний өдрөөрх деривативын бодит үнэ цэнийг Монголбанкны албан ханш (1400) ба хэлцлийн ханшийн (1500) зөрүүгээр тодорхойлоход сөрөг гарч байгаа (1400 – 1500) тул энэ нь өр төлбөр болно. Янз бүрийн валютаар банк хооронд байршуулсан хөрөнгийн хүүгийн түвшинг ашиглаж, уг деривативтай адил төстэй дуусгавар хугацаа, нөхцөлийг мөн авч үзэх шаардлагатай тул энэ нь уг деривативын бодит үнэ цэнийн нарийвчилсан тооцоолол болж чадахгүй (энэ жишээнд деривативын хугацаа 2 сар). Энэ тооцоололд ашиглагдах банк хоорондын захад байршуулсан хөрөнгийн хүүгийн түвшинг банк өөрөө тодорхойлж ашиглана. Хэрэв банк деривативын бодит үнэ цэнийг тооцоолох техникийн боломжгүй тохиолдолд мэргэшсэн үнэлгээчинд хандаж болно. Бодит үнэ цэнийг тооцоолох жишээг энэ бүлгийн төгсгөлд оруулсан.

10-р сарын 31-нд:

Дебит: Деривативын бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн зардал 100 сая төгрөг (1400-1500)
Кредит: Форвард арилжааны дериватив өр төлбөр 100 сая төгрөг

Тэнцлийн гадуурх Дериватив санхүүгийн хэрэгсэл бүлгийн форвард арилжааны авлагад 1 сая ам.доллар, форвард арилжааны өглөгт 1500 сая төгрөг гэж тус тус бүртгэнэ.

11-р сарын 30 бол дараагийн тайлагналын өдөр юм. Дээрхийн нэгэн адил деривативын бодит үнэ цэнийг Монголбанкны албан ханш (1550) ба хэлцлийн ханшийн (1500) зөрүүгээр тодорхойлоход 50 сая төгрөгөөр эерэг гарч байна (1 сая төгрөгийг ханшийн зөрүү 50-иар үржүүлсэн (1550 – 1500)). Өмнөх сард 100 сая төгрөгийн сөрөг бодит үнэ цэнийг (өр төлбөрт) бүртгэснийг буцаана:

Дебит: Форвард арилжааны дериватив өр төлбөр 100 сая төгрөг

Кредит: Деривативын бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн зардал 100 сая төгрөг (1500-1400)

Дебит: Форвард арилжааны дериватив хөрөнгө 50 сая төгрөг
Кредит: Дериватив бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн орлого 50 сая төгрөг (1550-1500)

12-р сарын 5-нд:

Форвард хэлцлийг биелүүлж, ам.долларыг хэлцлийн ханшаар худалдан авсан бол

Дебит: Мөнгөн хөрөнгө (ам.доллар) худалдан авсан 1 сая ам.доллар

Кредит: Валют хөрвүүлэх түр данс 1600 сая төгрөг

Дебит: Валют хөрвүүлэх түр данс 1500 сая төгрөг

Кредит: Мөнгөн хөрөнгө (төгрөгөөр) 1500 сая төгрөг (төлбөрийг хэлцлийн ханшаар барагдуулсан)

Форвард арилжааны дериватив хөрөнгө дансыг хааж, 50 сая төгрөгийг валют хөрвүүлэх дансанд шилжүүлэн, валют хөрвүүлэх дансны үлдэгдэл 50 сая төгрөгийг гадаад валютын арилжааны орлого, зардалд (хэрэгжсэн) дээр тайлбарласны дагуу бүртгэнэ (үүнийг мөн доор гадаад валют худалдах форвардын жишээнд оруулсан).

Дебит: Валют хөрвүүлэх түр данс 50 сая төгрөг

Кредит: Форвард арилжааны дериватив хөрөнгө 50 сая төгрөг

Дебит: Валют хөрвүүлэх түр данс 50 сая төгрөг

Кредит: Гадаад валютын арилжааны орлого 50 сая төгрөг

Арилжааны позицийг хаах үед хэрэгжээгүй (цэвэр) орлого, зардлыг хэрэгжсэн орлого, зардалд шилжүүлэн бүртгэнэ.

Дебит: Дериативын бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн орлого 50 сая төгрөг (зөвхөн цэвэр орлогын энэ дансанд бүртгэнэ)
Кредит: Гадаад валютын арилжааны орлого 50 сая төгрөг

Дээрх гүйлгээнүүдийн эцэст Форвард арилжааны дериативын дансд, валют хөрвүүлэх данс хаагдаж, цэвэр дүнгээр тухайн форвард арилжаа нийт 100 сая төгрөгийн ашигтай хэрэгжсэн үр дүн гарна.

Тэнцлийн гадуурх Дериватив санхүүгийн хэрэгсэл бүлгийн форвард арилжааны авлага 1 сая доллар, форвард арилжааны өглөг 1500 сая төгрөг гэж тус тус бүртгэснийг зарлагадна.

Гадаад валютыг форвард хэлцлээр худалдах арилжаа

Форвард хэлцлийг байгуулсан өдрөөр тэнцлийн гадуур форвард хэлцлийн авлага, өглөгийг (нэрлэсэн дүн) бүртгэх ба форвард хэлцлийн хугацаа дуусах буюу позици хаагдахад тэнцлийн гадуурх уг авлага, өглөгийг зарлагадна.

Хэрэв дериативын бодит үнэ цэн сөрөг гарсан тохиолдолд санхүүгийн тайлагналын өдөр форвард хэлцлийн дериативыг үнэлээд өр төлбөр хүлээн зөвшөөрсөн бол (тэнцлийн дотуур)

Дебит: Дериативын бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн зардал
Кредит: Форвард арилжаа

Хэрэв дериативын бодит үнэ цэн эерэг гарсан тохиолдолд санхүүгийн тайлагналын өдөр форвард хэлцлийн дериативыг үнэлээд, хөрөнгө хүлээн зөвшөөрсөн бол (тэнцлийн дотуур)

Дебит: Форвард арилжаа
Кредит: Дериативын бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн орлого

Форвард хэлцлийн хугацаа дуусахад худалдан авах валютын албан ханшаар илэрхийлсэн дүнгээр холбогдох гадаад валютын дансыг хорогдуулна.

Дебит: Валют хөрвүүлэлтийн түр данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн гадаад валютын холбогдох данс

Хэлцлээр худалдах валютын гэрээнд заасан ханшаар илэрхийлсэн дүнгээр холбогдох мөнгөн хөрөнгийн дансыг нэмэгдүүлнэ.

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Валют хөрвүүлэлтийн түр данс

Форвард арилжаа дансны үлдэгдлийг дээрх гүйлгээнээс үүссэн валют хөрвүүлэлтийн түр дансанд хаана.

Форвард арилжааны данс кредит үлдэгдэлтэй буюу бодит үнэ цэн сөрөг гарч, өр төлбөр үүссэн бол

Дебит: Форвард арилжаа
Кредит: Валют хөрвүүлэлтийн түр данс

Форвард арилжааны данс дебит үлдэгдэлтэй буюу бодит үнэ цэн эерэг гарч, хөрөнгө үүссэн бол

Дебит: Валют хөрвүүлэлтийн түр данс
Кредит: Форвард арилжаа

Дээрх бичилтүүд хийгдсэний дараа валют хөрвүүлэлтийн түр дансны үлдэгдлээр арилжааны үр дүн тодорхойлогдоно.

Хэрэв ашигтай бол

Дебит: Валют хөрвүүлэлтийн түр данс
Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Хэрэв алдагдалтай бол

Дебит: Гадаад валютын арилжааны зардал
Кредит: Валют хөрвүүлэлтийн түр данс

Хэрэв форвард арилжаа данс үлдэгдэлтэй бол дээрх гүйлгээнээс үүссэн валют хөрвүүлэлтийн түр дансанд хаана.

Арилжааны позицийг хаах үед гадаад валютын хэрэгжээгүй (цэвэр) орлого, зардалд бүртгэсэн деривативын бодит үнэ цэнд гарсан өөрчлөлтийг гадаад валютын арилжааны хэрэгжсэн орлого, зардалд шилжүүлэн бүртгэнэ. Үүнийг дараах дансны харилцаагаар бүртгэнэ:

Хэрэгжээгүй цэвэр орлогын хувьд:

Дебит: Деривативын бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн орлого
Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Хэрэгжээгүй цэвэр зардлын хувьд:

Дебит: Гадаад валютын арилжааны зардал
Кредит: Деривативын бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн зардал

Жишээ: Гадаад валют худалдах форвард арилжаа

Банк нь харилцагч “XX”-тай харилцан тохиролцож, 5-р сарын 9-нд биелэгдэхээр 500,000 ам.долларыг 1375 төгрөгийн ханшаар худалдах форвард хэлцлийг 3-р сарын 10-нд хийсэн. Энэ жишээнд өмнөх жишээний нэгэн адил бодит үнэ цэнийг тооцоолох хялбаршуулсан аргыг ашигласан.

3-р сарын 31-нд дахин үнэлгээ хийх ханш 1368 төгрөг болсон ба банк бодит үнэ цэнийг 3,500,000 төгрөгөөр тооцоолж гаргасан ((1375-1368)*500,000$=3,500,000 төгрөг)

Дебит: Форвард арилжаа (хөрөнгө)	3,500,000	
Кредит: Деривативын бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн орлого		3,500,000

4-р сарын 30-нд албан ханш 1376 төгрөг болж өссөн бол деривативыг дахин үнэлсэн дүн сөрөг 500,000 төгрөг гарсан. Энэ жишээнд хялбаршуулсан аргыг ашиглан хэлцлийн ханш ба Монголбанкны албан ханшийн зөрүүгээр бодит үнэ цэнийг тогтоосон ((1375-1376)*500,000$=-500,000 төгрөг). Үүний үр дүнд бодит үнэ цэнийн өөрчлөлт сөрөг гарч, бодит үнэ цэн 4,000,000 төгрөг болно (3,500,000-(-500,000)):

Дебит: Деривативын бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн зардал		4,000,000
Кредит: Форвард арилжаа (хөрөнгө)	3,500,000	

Кредит: Форвард арилжаа (өр төлбөр) 500,000

Форвард хэлцлийн хугацаа дуусахад ам.долларын данснаас гарсан мөнгөн гүйлгээг тухайн өдрийн албан ханш 1380 төгрөгөөр хүлээн зөвшөөрөх ба 690,000,000 төгрөг болно (500,000$*1380=690,000,000 төгрөг)

Дебит: Валют хөрвүүлэлтийн түр данс 690,000,000
Кредит: Мөнгөн хөрөнгийн гадаад валютын данс 690,000,000

Гэрээнд заасан ханшаар илэрхийлсэн дүнгээр төлбөр хийгдэнэ (500,000$*1375=687,500,000 төг)

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс 687,500,000
Кредит: Валют хөрвүүлэлтийн түр данс 687,500,000

Форвард арилжааны дансыг хаахдаа,

Дебит: Форвард арилжаа (өр төлбөр) 500,000
Кредит: Валют хөрвүүлэлтийн түр данс 500,000

Валют хөрвүүлэлтийн түр дансны үлдэгдлээр форвард арилжааны үр дүнг тодорхойлбол,

Дебит: Гадаад валютын арилжааны зардал 2,000,000
Кредит: Валют хөрвүүлэлтийн түр данс 2,000,000

Деривативын бодит үнэ цэнд гарсан өөрчлөлтийг гадаад валютын ханшийн тэгшитгэлийн хэрэгжээгүй (цэвэр) орлого, зардалд бүртгэж, дээр тайлбарласнаар позицийг хаах үед гадаад валютын арилжааны хэрэгжсэн орлого, зардалд шилжүүлэн бүртгэнэ. Энэ жишээнд ханшийн тэгшитгэлийн цэвэр зардал болох 500,000 төгрөгөөр гадаад валютын арилжааны зардлыг нэмэгдүүлэн 2,500,000 төгрөг болгох (2,000,000 + 500,000) ба энэ нь позици хаасан өдрийн албан ханш ба хэлцлийн ханшийн зөрүүг худалдсан ам.долларaар үржүүлсэнтэй тэнцүү байна ((1380-1375)*500,000$=2,500,000 төгрөг).

2) Своп хэлцэл

Своп хэлцлийн дагуу эхний арилжааг бүртгэхдээ худалдсан валютын дүнгээр балансанд хүлээн зөвшөөрч бүртгэнэ (үнэт металлын своп хэлцлийн бүртгэл үүнтэй адил байх боловч “Бусад санхүүгийн бус хөрөнгө” ба үнэт металлын орлого, зардал дансанд бүртгэнэ)

Дебит: Валют хөрвүүлэлтийн түр данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Худалдан авсан валютын дүнгээр балансанд бүртгэнэ

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Валют хөрвүүлэлтийн түр данс

Своп позици хаах үед (хэлцлийн хоёр дахь арилжаагаар) төлөх буюу төлөгдөхөөр зөвшөөрсөн ирээдүйн мөнгөн гүйлгээний нэрлэсэн дүнг тэнцлийн гадуур бүртгэнэ.

Хэрэв эхний арилжаагаар албан ханш болон арилжааны ханшийн зөрүүгээр орлого үүссэн бол үүнийг хэрэгжсэн орлогод бүртгэнэ

Дебит: Валют хөрвүүлэлтийн түр данс
Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Харин зардал үүссэн бол үүнийг хэрэгжсэн зардалд бүртгэнэ

Дебит: Гадаад валютын арилжааны зардал
Кредит: Валют хөрвүүлэлтийн түр данс

Тайлагналын өдөр (сарын эцэст) своп хэлцлийн бодит үнэ цэнийг тооцоолж, деривативын бодит үнэ цэнээр хөрөнгө, өр төлбөр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

Санхүүгийн тайлагналын өдөр деривативын бодит үнэ цэн сөрөг гарсан тохиолдолд валютын своп хэлцлийн деривативыг өр төлбөрөөр хүлээн зөвшөөрсөн бол

Дебит: Деривативын бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн зардал
Кредит: Валютын своп арилжаа

Санхүүгийн тайлагналын өдөр дериавтивын бодит үнэ цэн эерэг гарсан тохиолдолд валютын своп хэлцлийн деривативыг хөрөнгөөр хүлээн зөвшөөрсөн бол

Дебит: Валютын своп арилжаа

Кредит: Дериативын бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн орлого

Своп хэлцлийн дагуу хоёр дахь арилжааг бүртгэхдээ хэлцлийн гэрээгээр худалдан авах валютын дүнгээр (үнэт металлын хувьд "Бусад санхүүгийн бус хөрөнгө" болон үнэт металлын орлого, зардал дансдыг ашиглан бүртгэнэ)

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Валют хөрвүүлэлтийн түр данс

Харин хэлцлээр худалдах гадаад валютын дүнгээр

Дебит: Валют хөрвүүлэлтийн түр данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Своп арилжаа дансны үлдэгдлийг дээрх гүйлгээнээс үүссэн валют хөрвүүлэлтийн түр дансанд хаана.

Своп арилжааны данс кредит үлдэгдэлтэй бол

Дебит: Валютын своп арилжаа
Кредит: Валют хөрвүүлэлтийн түр данс

Своп арилжааны данс дебит үлдэгдэлтэй бол

Дебит: Валют хөрвүүлэлтийн түр данс
Кредит: Валютын своп арилжаа

Дээрх бичилтүүд хийгдсэний дараа валют хөрвүүлэлтийн түр дансны үлдэгдлээр арилжааны үр дүн тодорхойлогдоно.

Хэрэв ашигтай бол

Дебит: Валютын своп арилжааны түр данс
Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Хэрэв алдагдалтай бол

Дебит: Гадаад валютын арилжааны зардал
Кредит: Валютын своп арилжааны түр данс

Хоёр дахь арилжааны үед нэрлэсэн дүнгээр тэнцлийн гадуур бүртгэсэн дансдыг зарлагадна.

Гадаад валютын хэрэгжээгүй (цэвэр) орлого, зардалд бүртгэсэн дериативын бодит үнэ цэнд гарсан өөрчлөлтийг гадаад валютын арилжааны хэрэгжсэн орлого, зардалд шилжүүлэн бүртгэнэ. Үүнийг дараах дансны харилцаагаар бүртгэнэ:

Хэрэгжээгүй цэвэр орлогын хувьд:

Дебит: Дериативын бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн орлого
Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Хэрэгжээгүй цэвэр зардлын хувьд:

Дебит: Гадаад валютын арилжааны зардал
Кредит: Дериативын бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн зардал

Жишээ: Гадаад валютын своп арилжаа

Банк своп хэлцлээр 2013.3.20-нд харилцагчтай 400,000 ам.долларыг 1260 төгрөгийн ханшаар худалдан авч, түүнийг 2013.4.20-ний өдөр 1280 төгрөгийн ханшаар эргүүлэн худалдах хоёр арилжааг хийсэн.

2013.3.20-ний өдөр албан ханш 1250 төгрөг байсан бол хэлцлийн валютаар (400,000$*1250=500,000,000 төгрөг)

Дебит: Мөнгөн хөрөнгийн гадаад валютын данс	400,000$
Кредит: Валют хөрвүүлэлтийн түр данс	400,000$

Хэлцлийн ханшаар валютыг илэрхийлэх төгрөгийн дүнгээр (400,000$*1260=504,000,000төгрөг)

Дебит: Валют хөрвүүлэлтийн түр данс	504,000,000
Кредит: Мөнгөн хөрөнгийн төгрөгийн холбогдох данс	504,000,000

Албан ханш болон хэлцлийн ханшийн зөрүүг (504 сая - 500 сая = 4 сая төгрөг)

Дебит: Гадаад валютын арилжааны зардал 4,000,000
Кредит: Валют хөрвүүлэлтийн түр данс 4,000,000

Санхүүгийн тайлагналын өдөр үнэлгээ хийх ханш 1265 төгрөг болсон бол энэ нь хэлцлийн ханш 1280 төгрөгөөс доогуур байгаа тул бодит үнэ цэн эерэг гарч байна. Бодит үнэ цэн эерэг 6,000,000 төгрөг гарсан ((1280-1265)*400,000$=6,000,000 төгрөг). Дээр дурдсанчлан энэ нь бодит үнэ цэнийг тооцоолох хялбаршуулсан арга болохыг сануулъя.

Дебит: Своп арилжаа (дериватив) 6,000,000
Кредит: Дериватив бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн орлого 6,000,000

2013.4.20-нд өдөр хоёр дахь арилжааны хийгдэх (хэлцлийн хугацаа дуусах өдөр) үед албан ханш 1285 төгрөг бол (400,000$*1285=514,000,000 төгрөг)

Дебит: Валют хөрвүүлэлтийн түр данс 400,000$ (514,000,000)
Кредит: Мөнгөн хөрөнгийн гадаад валютын данс 400,000$ (514,000,000)

Хэлцлийн ханшаар валютыг илэрхийлэх төгрөгийн дүнгээр (400,000$*1280=512,000,000 төгрөг)

Дебит: Мөнгөн хөрөнгийн төгрөгийн холбогдох данс 512,000,000
Кредит: Валют хөрвүүлэлтийн түр данс 512,000,000

Своп арилжааны дансыг хаахдаа

Дебит: Валют хөрвүүлэлтийн түр данс 6,000,000
Кредит: Своп арилжаа (дериватив) 6,000,000

Валют хөрвүүлэлтийн түр дансны үлдэгдлээр своп арилжааны үр дүнг тодорхойлбол,

Дебит: Гадаад валютын арилжааны зардал 8,000,000
Кредит: Валют хөрвүүлэлтийн түр данс 8,000,000

Валютын арилжааны хэрэгжсэн зардал болох 8,000,000 төгрөгийг хэрэгжээгүй орлого болох 6,000,000 төгрөгөөр бууруулснаар гадаад валютын арилжааны цэвэр зардал 2,000,000 болж байгаа ба энэ нь нөгөө талаасаа позици хаах өдрийн албан ханш 1485 ба хэлцлийн ханш 1480 -ийн хоорондох зөрүүгээр тооцоолсон дүнтэй тэнцэнэ ((1485-1400)*400,000$=2,000,000 төгрөг). Мөн эхний арилжааны үед хүлээн зөвшөөрч, бүртгэсэн арилжааны цэвэр зардал нь албан ханш 1250 ба хэлцлийн ханш 1260 төгрөгийн хоорондох зөрүүгээр тооцоолж 4,000,000 төгрөг гарсан билээ ((1260-1250)*400,000$=4,000,000 төгрөг).

Хүүгийн своп

Зээл, бонд, тэдгээртэй төстэй санхүүгийн хөрөнгө эзэмшиж буй банк тогтмол хүүгийн авлагыг хөвөгч хүүгээр эсвэл хөвөгч хүүгийн авлагыг тогтмол хүүгээр хөрвүүлэх хүсэлтэй үед хүүгийн түвшний своп хэлцэл хийдэг.

Мөн банк өр төлбөр эзэмшдэг бөгөөд холбогдох хүүгийн өглөгтэй холбоотой дээрх өөрчлөлтийг хийхийг хүссэн үед хүүгийн түвшний своп хэлцэл байгуулдаг.

Энэ үед хүүгийн төлбөрийн мөнгөн гүйлгээ солигдоно. Тодруулбал, авах буюу төлөх хүүгийн зөрүү нөгөө талд шилжинэ. Үндсэн өрийн үлдэгдэл хэвээр үлдээх тул, түүнийг солилцох ач холбогдолгүй.

Жишээ: Хүүгийн своп хэлцэл

“А” Банк харилцагчдаа 3 жилийн хугацаатай 12%-ийн хүүтэй 100 сая төгрөгийн зээл олгосон. Харилцагчийн хүсэлтээр тогтмол хүүтэйгээр зээлийг олгосон. Банк хүүгийн свопын хэлцлийг “Б” банктай хийсэн.

Уг дериватив тэнцлийн гадуурх дансанд бүртгэсэн. (“А” банк своп хэлцэл хийж байгаагийн шалтгаан нь уг банк зээлийн эх үүсвэрийг хөвөгч хүү бүхий өр төлбөрөөр санхүүжүүлсэнтэй холбоотой болно)

Олгосон зээлийн хүү эхний жилд 12% байсан боловч Монголбанкнаас тогтоосон бодлогын хүү (Монгол улсын банкны салбарын санхүүгийн зардалд нөлөөлдөг гол үзүүлэлт) өөрчлөгдөхөд жил бүр дагаад өөрчлөгдөнө. Иймээс “Б” банкны харилцагч 1 дэх жилд 12%, 2 дахь жилд 9%, 3 дахь жилд 14%-ийн хүү төлнө.

“А” банк:

1 дэх өдөр: Дебит: Зээл - Харилцагчийн данс 100 сая төгрөг (зээлийн үлдэгдэл)

Кредит: Мөнгөн хөрөнгө 100 сая төгрөг

1 дэх жилийн эцэст:

Дебит: Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага 12 сая төгрөг
Кредит: Хүүгийн орлого 12 сая төгрөг

Энэхүү хялбаршуулсан жишээнд 1 дэх жилийн эцэст деривативын бодит үнэ цэнийг маш бага дүнтэй гарсан гэж (өөрөөр хэлбэл, тэгтэй ойролцоо гарсан) үзвэл хөвөгч хүүгийн түвшинд үндэслэн тодорхойлсон харилцан шилжүүлэх хүүгийн орлого нь 12 сая төгрөг болно. Эндээс деривативын бодит үнэ цэнтэй холбоотой тохируулга хийхгүй.

2 дахь жилийн эцэст:

2 дахь жилд "Б" банктай байгуулсан дериватив (хүүгийн своп)-тай холбогдуулан банкны хүүгийн орлого нь 9 сая төгрөг болж буурна. Ингэснээр деривативын бодит үнэ цэн сөрөг гарч, өр төлбөр хүлээн зөвшөөрч бүртгэх ба деривативын бодит үнэ цэнийн өөрчлөлттэй холбоотойгоор үүссэн орлого, зардлыг тайлант хугацааны орлого, зардалд бүртгэнэ. Энэ жишээнд 2 дахь жилийн эцэст деривативын бодит үнэ цэн ойролцоогоор сөрөг утгатай 3 сая төгрөгөөр илэрхийлэгдэнэ. Банк илүү дэлгэрэнгүй үнэлгээ хийж, нарийвчилсан дүнг гаргахын тулд мэргэшсэн үнэлгээчдийг ажиллуулж болно.

Дебит: Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага 12 сая төгрөг
Кредит: Хүүгийн орлого 12 сая төгрөг

Дебит: Хүүгийн орлого (деривативын бодит үнэ цэнийн өөрчлөлт) 3 сая төгрөг
Кредит: Своп арилжаа (өр төлбөр) - "Б" банк 3 сая төгрөг

3 дахь жилийн эцэст:

3 дахь жилд "Б" банктай байгуулсан дериватив (хүүгийн түвшний своп) -тай холбогдуулан банкны хүүгийн орлого нь 14 сая төгрөг болно. Ингэснээр деривативын бодит үнэ цэн эерэг гарч, хөрөнгө хүлээн зөвшөөрч бүртгэх ба деривативын бодит үнэ цэнийн өөрчлөлттэй холбоотойгоор үүссэн орлого, зардлыг тайлант хугацааны орлого, зардалд бүртгэнэ. Энэ жишээнд 3 дахь жилийн эцэст деривативын бодит үнэ цэн ойролцоогоор сөрөг утгатай 2 сая төгрөгөөр илэрхийлэгдэнэ. Банк илүү дэлгэрэнгүй үнэлгээ хийж, нарийвчилсан дүнг гаргахын тулд мэргэшсэн үнэлгээчдийг ажиллуулна.

Дебит: Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага 12 сая төгрөг
Кредит: Хүүгийн орлого 12 сая төгрөг

Дебит: Своп арилжаа (хөрөнгө) - "Б" банк 2 сая төгрөг
Кредит: Хүүгийн орлого (деривативын бодит үнэ цэнийн өөрчлөлт) 2 сая төгрөг

Зээлийг буцааж төлөх үед:

Дебит: Мөнгөн хөрөнгө 100 сая төгрөг (үндсэн төлбөр)
Кредит: Зээл - Харилцагчийн данс 100 сая төгрөг

"Б" банкнаас авсан болон төлсөн хүүг своп арилжааны дансанд бүртгэнэ.

"Б" банк:

1 дэх өдөр: Дебит: Зээл - Харилцагчийн данс 100 сая төгрөг (үндсэн төлбөр)
Кредит: Мөнгөн хөрөнгө 100 сая төгрөг

1 дэх жилийн эцэст:

Дебит: Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага 12 сая төгрөг
Кредит: Хүүгийн орлого 12 сая төгрөг

Дээр тайлбарласнаар деривативын бодит үнэ цэн нь маш бага дүнтэй тул бүртгэхгүй.

2 дахь жилийн эцэст:

2 дахь жилийн эцэст нэмэлт хүү 3 сая төгрөг, нийт хүү 12 сая төгрөг болж деривативын бодит үнэ цэн эерэг гарна (энэ нь уг деривативын бодит үнэ цэнийн ойролцоо тооцоолол болно).

Дебит: Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага 9 сая төгрөг
Кредит: Хүүгийн орлого 9 сая төгрөг

Дебит: Своп арилжаа (хөрөнгө) - "А" банк 3 сая төгрөг
Кредит: Хүүгийн орлого (деривативын бодит үнэ цэнийн өөрчлөлт) 3 сая төгрөг

3 дахь жилийн эцэст:

3 дахь жилийн эцэст нийт 12 сая төгрөгийн хүү авах ба үүний 2 сая төгрөгийг нь “А” банкинд төлөх тул дериативын бодит үнэ цэн сөрөг гарна (энэ нь уг дериативын бодит үнэ цэнийн ойролцоо тооцоолол болно).

Дебит: Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	14 сая төгрөг
Кредит: Хүүгийн орлого	14 сая төгрөг

Дебит: Хүүгийн орлого (дериативын бодит үнэ цэнийн өөрчлөлт)	2 сая төгрөг
Кредит: Своп арилжаа (хөрөнгө) - “А” банк	2 сая төгрөг

Зээлийг эргүүлэн төлөх үед:

Дебит: Мөнгөн хөрөнгө	100 сая төгрөг (үндсэн төлбөр)
Кредит: Харилцагчийн данс	100 сая төгрөг

Дээр тайлбарласнаар хүүгийн түвшний свопын үр дүнд “А” банкинд хөвөгч хүү, “Б” банкинд тогтмол хүү төлөгдөнө.

3) Опшин арилжаа

Гадаад валют, үнэт металлын арилжааны эрхийг худалдах

Хэрэв банк гадаад валют, үнэт металлын колл болон пут опшин хэлцлийн эрхийг худалдсан бол авсан премиумын дүнгээр опшин арилжааны дансанд бүртгэнэ. Гадаад валютын опшинтой холбоотой бүртгэлийг дараах байдлаар хийнэ. Үнэт металлын хувьд бүртгэл нь адилхан боловч “Бусад санхүүгийн бус хөрөнгө” болон үнэт металлын орлого, зардал дансдыг ашиглан бүртгэнэ.

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Опшин арилжаа

Худалдсан ба худалдан авсан гадаад валют, үнэт металлын нэрлэсэн дүнг тэнцлийн гадуурх дансанд бүртгэнэ.

Тайлагналын өдөр банк опшины бодит үнэ цэнийг тодорхойлж, уг дүнгээр Санхүүгийн тайланд дериативыг харуулна. Бодит үнэ цэнийг Блэйк-Шоулесийн загвар болон үнэлгээний бусад загварыг ашиглан банкны шинжээч эсвэл гэрээний дагуу хөндлөнгийн үнэлгээчин тодорхойлж болно.

Хэрэв опшиныг дахин үнэлэх үед бодит үнэ хэлцлийн үнээс давсан бол

Дебит: Дериативын бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн зардал
Кредит: Опшин арилжаа

Хэрэв опшиныг дахин үнэлэх үед бодит үнэ хэлцлийн үнээс бага бол

Дебит: Опшин арилжаа
Кредит: Дериативын бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн орлого

Хэлцэл биелсэн үед гэрээгээр худалдан авах валют, үнэт металлын дүнгээр

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Валют хөрвүүлэлтийн түр данс

Худалдах валют, үнэт металлын дүнгээр

Дебит: Валют хөрвүүлэлтийн түр данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Валютын опшин арилжааны дансыг валют хөрвүүлэлтийн түр дансанд хаана

Дебит: Опшин арилжаа
Кредит: Валют хөрвүүлэлтийн түр данс

Дээрх гүйлгээ хийгдсэний дараа тухайн арилжааны үр дүнг тооцно.

Хэрэв ашигтай бол

Дебит: Валют хөрвүүлэлтийн түр данс
Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Хэрэв алдагдалтай бол

Дебит: Гадаад валютын арилжааны зардал
Кредит: Валют хөрвүүлэлтийн түр данс

Хэлцэл биелээгүй бол зөвхөн премиумын дансыг орлогод хаана.

Дебит: Опшин арилжаа
Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Хэрэгжээгүй орлого, зардлыг хэрэгжсэн орлого, зардалд шилжүүлэн бүртгэнэ.

Гадаад валютын арилжааны эрхийг худалдан авах

Банк гадаад валютын колл болон пут опшин хэлцлийн эрхийг худалдан авсан бол төлсөн үнийн дүнгээр опшин арилжааны дансанд бүртгэнэ. Үнэт металлын хувьд дээр дурдсан дансдыг ашиглана.

Дебит: Опшин арилжаа
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Худалдсан ба худалдан авсан гадаад валют, үнэт металлын нэрлэсэн дүнг тэнцлийн гадуурх дансанд бүртгэнэ.

Тайлагналын өдөр банк опшины бодит үнэ цэнийг тодорхойлж, уг дүнгээр Санхүүгийн байдлын тайланд деривативыг харуулна. Бодит үнэ цэнийг Блэйк-Шоулесийн загвар болон үнэлгээний бусад загварыг ашиглан банкны шинжээч эсвэл гэрээний дагуу хөндлөнгийн үнэлгээчин тодорхойлж болно.

Хэрэв опшиныг дахин үнэлэх үед бодит үнэ хэлцлийн үнээс бага бол

Дебит: Деривативын бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн зардал
Кредит: Опшин арилжаа

Хэрэв опшиныг дахин үнэлэх үед бодит үнэ хэлцлийн үнээс давсан бол

Дебит: Опшин арилжаа
Кредит: Деривативын бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн орлого

Хэлцэл биелсэн бол гэрээгээр худалдан авах валют, үнэт металлын дүнгээр

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Валют хөрвүүлэлтийн түр данс

Худалдах валют, үнэт металлын дүнгээр

Дебит: Валют хөрвүүлэлтийн түр данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Опшин арилжааны дансны үлдэгдлийг валют хөрвүүлэлтийн түр дансанд хаана

Дебит: Валют хөрвүүлэлтийн түр данс
Кредит: Опшин арилжаа

Дээрх гүйлгээ хийгдсэний дараа тухайн арилжааны үр дүнг тооцно.

Хэрэв ашигтай бол

Дебит: Валют хөрвүүлэлтийн түр данс
Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Хэрэв алдагдалтай бол

Дебит: Гадаад валютын арилжааны зардал
Кредит: Валют хөрвүүлэлтийн түр данс

Хэлцэл биелээгүй бол зөвхөн премиумын дансыг зардалд хаана.

Дебит: Гадаад валютын арилжааны зардал
Кредит: Опшин арилжаа

Хэрэгжээгүй орлого, зардлыг хэрэгжсэн орлого, зардалд шилжүүлэн бүртгэнэ.

Жишээ: Форвард хэлцлээр гадаад валют худалдан авах опшин

Банк 20Х3 оны 11-р сарын 30-нд 1500 төгрөгийн ханшаар 1 сая ам.доллар худалдан авах опшиныг худалдан авсан ба 15,000,000,000 төгрөгийн опшины 2%-иар опшины примиум төлсөн. Хэлцэлд 10-р сарын 6-нд гарын үсэг зурж баталгаажуулсан ба энэ өдөр банк опшин арилжааг (дебит) бүртгэсэн.

Монголбанкнаас зарласан ам.долларын албан ханш 10-р сарын 30-нд 1400 төгрөг, 11-р сарын 30-нд 1550 төгрөг байсан.

10 дугаар сарын 6-нд:

Дебит: Опшин арилжаа – хөрөнгө	30 сая төгрөг (опшины өртөг)
Кредит: Мөнгөн хөрөнгө	30 сая төгрөг

10 дугаар сарын 30-нд:

Хэлцлийн ханштай харьцуулахад 1400 төгрөгийн албан ханш хэт доогуур байгаа тул дериватив бодит үнэ цэн сөрөг гарна. Энэ жишээний хувьд дериватив бодит үнэ цэн ойролцоогоор 100 сая төгрөг болж байна. Гэхдээ практик дээр банк илүү дэлгэрэнгүй үнэлгээ хийж, нарийвчилсан дүнг гаргахын тулд хөндлөнгийн болон дотоодын мэргэшсэн үнэлгээчдийг ажиллуулна. Опшины бодит үнэ цэнийн өөрчлөлт 130 сая төгрөг (100 – (-30)).

Дебит: Дериватив бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн зардал	130 сая төгрөг
Кредит: Опшин арилжаа – хөрөнгө	30 сая төгрөг
Кредит: Опшин арилжаа - өр төлбөр	100 сая төгрөг

11 дүгээр сарын 30-нд:

Хэлцлийн ханштай харьцуулахад 1550 төгрөгийн албан ханш өндөр байгаа тул дериватив бодит үнэ цэн ойролцоогоор 50 сая төгрөг (1550-1500)-өөр эерэг дүнтэй гарч байна. Опшины бодит үнэ цэнийн өөрчлөлт 150 сая төгрөг (1550 – 1400 өмнөх тайлагналын өдрийн албан ханш):

Дебит: Опшин арилжаа – өр төлбөр	100 сая төгрөг
Дебит: Опшин арилжаа - хөрөнгө	50 сая төгрөг
Кредит: Дериватив бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн зардал	130 сая төгрөг
Кредит: Дериватив бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн орлого	20 сая төгрөг

11-р сарын 30-нд арилжаа хийгдэж, опшины позицийг хаан, хэрэгжээгүй орлогыг хэрэгжсэн орлогод шилжүүлж, бүртгэнэ.

Дебит: Дериватив бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн орлого	20 сая төгрөг
Кредит: Гадаад валютын арилжааны орлого	20 сая төгрөг (1550-1500-30)
Дебит: Мөнгөн хөрөнгө ($)	1550 сая төгрөг (албан ханшаар)
Кредит: Мөнгөн хөрөнгө (MNT)	1500 сая төгрөг (хэлцлийн ханшаар)
Кредит: Опшин арилжаа	50 сая төгрөг (позици хаах)

4) Хейджийн хэрэгсэл

Бодит үнэ цэнийн хейдж

Бодит үнэ цэнийн хейджээр хамгаалсан эрсдэл гэж хөрөнгө, өр төлбөр, тэнцлийн гадуур бүртгэсэн болзошгүй үүрэг, эсвэл эдгээрийн тодорхой хэсгийн бодит үнэ цэн өөрчлөгдөхийг ойлгоно.

Бодит үнэ цэнийн хейджийн жишээнд хүүгийн түвшний свопыг ашиглан тогтмол хүү бүхий зээлийн хүүгийн түвшний эрсдэлийг хөвөгч хүүгээр арилжаалж байгаа тохиолдол багтана. Өөр нэг жишээ нь хувьцааны форвард буюу опционыг ашиглан борлуулахад бэлэн хувьцааны үнэ буурч болзошгүй эрсдэлийг багасгах явдал юм.

Мөн хөвөгч хүү бүхий бондын хүүг тогтмол хүүгээр солих зорилгоор зээлийн эрсдэл, хүүгийн түвшний эрсдэлийг хейджээр хамгаалах жишээг дурдаж болно.

Хейджийн хэрэгсэл болсон гадаад валютын арилжааны хэлцлийг бодит үнэ цэнийн хейдж гэж тодорхойлсон бол тухайн хэлцлийн бодит үнэ цэнээр дериватив бүртгэнэ.

Хэрэв гадаад валютын хейджид хамаарах дериватив нь санхүүгийн хөрөнгө бол

Дебит: Холбогдох дериватив данс (хөрөнгө)	
Кредит: Дериватив бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн орлого	

Хэрэв санхүүгийн тайлагналын өдөр дериватив бодит үнэ цэн буурсан бол

Дебит: Дериватив бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн зардал	
Кредит: Холбогдох дериватив данс (хөрөнгө)	

Хэрэв санхүүгийн тайлагналын өдөр дериватив бодит үнэ цэн өссөн бол

Дебит: Холбогдох дериватив данс (хөрөнгө)

Кредит: Дериативын бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн орлого

Хэрэв дериативыг санхүүгийн өр төлбөрөөр хүлээн зөвшөөрсөн бол дээр тайлбарласан байдлаар бүртгэнэ. Энэ бүртгэл нь бусад төрлийн хейджийн хувьд ижил байх боловч дериативын бодит үнэ цэнийн өөрчлөлтийг орлого, зардлын өөр дансанд бүртгэдэг гэдгээрээ ялгаатай юм. Ижил төстэй нөхцөл байдалд энэхүү зааварт багтсан бусад жишээг ашиглаж болно.

Хейджийн бүртгэлийг дараах үе шаттайгаар хөтөлнө:

- Хейджийн хэрэгсэл (дериватив)-ийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тайлант хугацааны орлого, зардалд бүртгэж, бодит үнэ цэнээр илэрхийлнэ;
- Зөвхөн хейджээр хамгаалсан эрсдэлтэй холбоотойгоор бодит үнэ цэнийн өөрчлөлтөөр хейджээр хамгаалагдсан зүйлсийн дансны үнийг тохируулна. Энэ нь хөрөнгө, өр төлбөрийг бүхэлд нь бодит үнэ цэнээр илэрхийлнэ гэсэн үг биш бөгөөд харин холбогдох эрсдэлээс хамаарах бодит үнэ цэнийн өөрчлөлтөөр суурь үзүүлэлтийг тохируулна.
- Хейджээр хамгаалсан эрсдэлд хамаарах бодит үнэ цэнийн өөрчлөлтийг хейджийн хэрэгслийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөр хааж тайлант үеийн орлого, зардалд бүртгэнэ;
- Үр өгөөжгүй хэсгийг шууд орлогын тайланд бүртгэнэ.

Хейджийн бүртгэлийн үед бодит үнэ цэнийн өөрчлөлтийг харгалзах тайлант хугацаанд нь бүртгэнэ. Өөрөөр хэлбэл хейджээр хамгаалагдсан зүйлийн суурь дүнг холбогдох эрсдэлээс хамаарах бодит үнэ цэнийн өөрчлөлтөөр тохируулна.

Хейджийн бүртгэлийг ашиглаагүй тохиолдолд холбогдох орлого, зардлыг ялгаатай тайлант хугацаанд хүлээн зөвшөөрөх тул уялдаатай байх зарчим алдагддаг. Бодит үнэ цэнийн хейдж нь хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөр дериативын бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нөхөн бүртгэх боломж олгодог. Эдгээрийг орлогын тайланд нэгэн зэрэг тайлагнах (тогтвортой илэрхийлэл) ба үр өгөөжгүй хэсгийг салгаж бүртгэнэ.

Жишээ: Бодит үнэ цэнийн хейдж - Гадаад валютын эрсдэл

“А” банк 3 сарын дараа барагдуулах, 1,000,000 ам.долларын зээлийг ханшийн эрсдэлээс хамгаалах зорилгоор хейдж хийж, “Б” банкнаас 3 сарын дараа 1,000,000 ам.долларыг 1400 төгрөгөөр худалдан авах форвард хэлцэл хийсэн.

Тайлагналын өдөр банк дериативын бодит үнэ цэнийг тооцоолоход эерэг 5,000,000 төгрөг гарсан. Энэ жишээний хувьд хялбаршуулсан байдлаар тооцоолж төгрөгийн албан ханш 1405 ба хэлцлийн ханшийн хоорондох зөрүүгээр дээрх дүн тодорхойлсон ((1405-1400) *1,000,000$=5,000,000 төгрөг). Дериативын бодит үнэ цэнийг илүү нарийвчлан тооцоолохын тулд ялгаатай валютаар байршуулсан хөрөнгийн хүүгийн түвшний зөрүүг үндэслэсэн үнэлгээний загварыг ашиглана.

Дебит: Валютын форвард арилжааны дериватив	5,000,000
Кредит: Дериативын бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн орлого	5,000,000

Ханшийн зөрүү нь дериативын бодит үнэ цэнэтэй ижил байна гэсэн таамаглалын дагуу 1,000,000 ам.долларын зээлд ханшийн тэгшитгэл хийнэ

Дебит: Дериативын бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн зардал	5,000,000
Кредит: Зээл	5,000,000

Энэ тохируулгыг зээлийн төлбөр хийгдэж, зээлийн хугацаа дуусах хүртэл бүртгэнэ.

Ийнхүү тохируулга нь валютын зээл (хейджээр хамгаалагдсан зүйл) болон хейдж хийж буй форвард хэлцлийн (хейджийн хэрэгсэл) бодит үнэ цэнийн орлого, зардлын зөрүүг тэнцвэржүүлнэ.

Жишээ: Бодит үнэ цэнийн хейдж - Хүүгийн эрсдэл

“А” банк 20Х2 оны 6-р сарын 30-нд улирал тутамд хүү төлөх нөхцөлтэй, 3 жилийн хугацаатай, 7.5%-ийн тогтмол хүүтэй, 10 сая төгрөгийн өрийн хэрэгсэл гаргасан. “А” банк 3 жилийн туршид 7.5%-ийн тогтмол хүүг шилжүүлээд хөвөгч хүү төлөх хүүгийн түвшний своп хэлцлийг өөр банктай байгуулсан.

6-р сарын 30-наас хойшх 3 сарын хугацаанд хөвөгч хүү 5.5% байх ба 20Х2 оны 9-р сарын 30-наас хойшх 3 сарын хугацаанд хөвөгч хүү 6% байхаар тогтоосон. 20Х2 оны 12-р сарын 31-нд төлбөр барагдуулахаас өмнө свопын бодит үнэ цэн 200,000 төгрөг байсан.

Өрийн хэрэгсэл гаргаад эх үүсвэр дайчлах үед дараах бичилтийг хийнэ:

Дебит: Мөнгөн хөрөнгө	10,000,000
Кредит: Бусад эх үүсвэр (Гаргасан бонд)	10,000,000

20X2 оны 12-р сарын 31-нд дараах бичилт хийгдэнэ:

Уг өр төлбөрийн хүүг хагас жилээр төлсөн бол (10 сая төгрөгийг 7.5%/2 -аар үржүүлнэ):

Дебит: Хүүгийн зардал	375,000
Кредит: Мөнгөн хөрөнгө	375,000

Энэ дериватив (хүүгийн түвшний своп) -ын дагуу "А" банк 6 сарын хугацаанд нийт 287,500 төгрөгийн хөвөгч хүүг төлнө (10 сая*5.5%/4 + 10 сая*6%/4). Мөнгөн төлбөр хийгдэхээс өмнө дериватив бодит үнэ цэн 200,000 төгрөг. Своп хэлцлийн дагуу "А" банк өөр банкнаас 375,000 төгрөгийн хүү аваад, 287,500 төгрөгийн хүү төлөх ба өөрөөр хэлбэл "А" банк своп хэлцлийн төлбөрт цэвэр дүнгээр 87,500 (375,000 – 287,500) төгрөгийг авах тул дериватив бодит үнэ үнэ эерэг гарч байна.

Мөнгөн төлбөр хийгдэхээс өмнө свопын бодит үнэ цэнийг бүртгэхдээ:

Дебит: Дериватив санхүүгийн хөрөнгө (Своп арилжааны авлага)	200,000
Кредит: Хүүгийн зардал	200,000

Своп хэлцлийн дагуу хийгдсэн мөнгөн төлбөрийг бүртгэхдээ (төлөгдсөн цэвэр дүнгээр):

Дебит: Мөнгөн хөрөнгө	87,500
Кредит: Дериватив санхүүгийн хөрөнгө (Своп арилжааны авлага)	87,500

Ингэснээр своп арилжааны позици 112,500 төгрөг болох болно. Өрийн хэрэгслийн бодит үнэ цэнд хийх тохируулга (өрийн хэрэгслийн бодит үнэ цэнийн өөрчлөлт) нь энэ своп хэлцлийн бодит үнэ цэнийн өөрчлөлттэй (төлбөрийг хийсний дараа) тэнцүү 112,500 төгрөг байна. Үүнийг дараах байдлаар бүртгэнэ:

Дебит: Хүүгийн зардал	112,500
Кредит: Бусад эх үүсвэр (Гаргасан бонд)	112,500

Мөнгөн гүйлгээний хейдж

Дараах шинжийг агуулсан, мөнгөн гүйлгээ өөрчлөгдөж болзошгүй эрсдэлд мөнгөн гүйлгээний хейдж хийдэг:

1) Хөрөнгө, өр төлбөр, тэнцлийн гадуур бүртгэсэн болзошгүй үүрэг (зөвхөн валютын эрсдэлд хамаарах), эсвэл хэрэгжих магадлал өндөртэй төлөвлөгөөт арилжаа зэрэгт хамаарах эрсдэлтэй холбоотой,

2) Орлогын тайланд нөлөөлөл үзүүлдэг.

Хөвөгч хүүтэй өрийн хэрэгслийн ирээдүйд төлөгдөх хүүгийн төлбөр гэх мэт одоогийн хөрөнгө, өр төлбөртэй холбоотой ирээдүйн мөнгөн гүйлгээ үүсч болно. Мөн ирээдүйн мөнгөн гүйлгээ нь гадаад валютыг худалдах буюу худалдан авах төлөвлөгөөт арилжаатай холбоотой байж болно. Хүүгийн түвшин, гадаад валютын ханш, хувьцааны үнэ, барааны үнэ өөрчлөгдсөний улмаас ирээдүйн мөнгөн гүйлгээ өөрчлөгддөг.

Мөнгөн гүйлгээний хейджийн жишээнд хөвөгч хүүг тогтмол хүүгээр хөрвүүлэх хүүгийн своп, бараа материалыг ирээдүйд гадаад валютаар худалдах төлөвлөгөөт арилжаанд хейдж хийсэн гадаад валютын форвард хэлцэл, бараа материал, үндсэн хөрөнгийг ирээдүйд гадаад валютаар худалдан авах төлөвлөгөөт арилжаа зэрэг орно. Өөр нэг жишээ нь форвард арилжаатай адил ирээдүйд арилжаа хийгдэх тэнцлийн гадуур бүртгэсэн болзошгүй үүрэгт хамаарах тэнцэлд хараахан бүртгээгүй гадаад валютын ханшийн эрсдэлийн хейдж юм. Мөн гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс хамгаалсан бүртгэлийн валютаар илэрхийлэгдсэн, гэрээгээр хүлээсэн болзошгүй үүрэгтэй холбоотой хейдж ч эрсдэлийг бууруулдаг.

Байгуулсан хэлцлийг мөнгөн гүйлгээний хейдж гэж тодорхойлсон бол тухайн хэлцлийн бодит үнэ цэнээр дериватывыг бүртгэнэ.

Хэрэв уг дериватив нь санхүүгийн хөрөнгө бол

Дебит: Холбогдох дериватывын данс (хөрөнгө)
Кредит: Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого эсвэл дериватывын төрлөөс хамаарсан холбогдох орлогын данс

Санхүүгийн тайлагналын өдөр деривативын бодит үнэ цэн буурсан бол уг бууралтын үр ашигтай хэсгийг бусад дэлгэрэнгүй орлогод тусган, хейджийн дахин үнэлгээний санд бүртгэж, өөрийн хөрөнгөөр тайлагнана.

Дебит: Бусад өөрийн хөрөнгө (Хейджийн дахин үнэлгээний сан)
Кредит: Холбогдох деривативын данс (хөрөнгө)

Деривативын бодит үнэ цэнийн бууралтын үр өгөөжгүй хэсгийг зардалд бүртгэхэд

Дебит: Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал эсвэл холбогдох зардлын данс
Кредит: Холбогдох деривативын данс (хөрөнгө)

Хэрэв санхүүгийн тайлагналын өдөр деривативын бодит үнэ цэн өссөн бол уг өсөлтийн үр ашигтай хэсгийг бусад дэлгэрэнгүй орлогод тусган, хейджийн дахин үнэлгээний санд бүртгэж, өөрийн хөрөнгөөр тайлагнана.

Дебит: Холбогдох деривативын данс (хөрөнгө)
Кредит: Бусад өөрийн хөрөнгө (Хейджийн дахин үнэлгээний сан)

Деривативын бодит үнэ цэнийн өсөлтийн үр ашиггүй хэсгийг орлогод бүртгэхэд

Дебит: Холбогдох деривативын данс (хөрөнгө)
Кредит: Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого эсвэл холбогдох орлогын данс

Хэрэв деривативыг анх хүлээн зөвшөөрөх үед санхүүгийн өр төлбөр үүссэн бол дээрх бичилтийн урвуугаар бүртгэнэ.

Жишээ: Энгийн хейдж

20X9 оны 1-р сарын 1-нд Францад байрладаг нэгэн компани АНУ-ын компанид 1,000,000 ам.долларын бараа худалдсан. Энэ өдөр албан ханш $1.5 =1 евро байсан. 20X9 оны 1-р сарын 31-нд төлбөр хийгдэхээс өмнө ам.долларын ханш еврогийн эсрэг сулрана гэж компани үзсэн. Үүний улмаас компанид зардал үүснэ.

Компани энэ эрсдэлээс хамгаалахын тулд 20X9 оны 1-р сарын 1-нд ам.доллараар зээлийн эх үүсвэр татсан. 1-р сарын 1-нд спот ханш $1.6 = 1 евро байсан.

Компани валютын ханшийг $1.5 =1 евро болгож царцаасан. Валютын ханш өөрчлөгдсөнөөр хөрөнгийн үнэ цэн өсөх буюу буурах боловч үүнийг өр төлбөртэй нэгтгэж цэвэршүүлнэ.

	Хөрөнгө	Өр төлбөр
20X9 оны 1-р сарын 1-ний үнэ цэн @$1.5=1 евро	666,667	666,667
20X9 оны 1-р сарын 31-ний үнэ цэн @$1.6 =1 евро	625,000	625,000
	41,667	41,667
	Зардал	Орлого

Хейджийн дийлэнх нь (одоогийн ба ирээдүйн) хөрөнгө, өр төлбөрийг тэнцүүлдэг. Гэхдээ бүх зүйл төгс байдаггүй тул компанид зээлийн эрсдэл болон төлбөр хойшлох эрсдэл нүүрлэсэн хэвээр байдаг. Энэ жишээнд хүүг харгалзаагүй ч энэ нь ийм арилжааны зардал юм. Үүнтэй нэгэн адил банк харилцагчдын тусгай хэрэгцээнд зориулан еврогоор олгосон зээлтэй холбоотойгоор эрсдэлийг хаахын тулд тодорхой валютаар (евро) зээлийн эх үүсвэр татан төвлөрүүлж болно.

Жишээ: Мөнгөн гүйлгээний хейдж – Гадаад валютын эрсдэл

20X2 оны 9-р сарын 30-нд Герман улсын нэгэн компани 1 сая ам.доллараар тоног төхөөрөмж худалдан авахаар төлөвлөсөн. Хөрөнгийг 20X3 оны 3-р сарын 31-нд авч, төлбөрийг нь 20X3 оны 6-р сарын 30-нд барагдуулахаар төлөвлөж байгаа.

Тус компани гадаад валютын ханшийн эрсдэлийн эсрэг хейдж хийхийн тулд 20X3 оны 6-р сарын 30-нд тогтмол тооны еврогоор 1 сая ам.доллар худалдан авах форвард хэлцэл хийсэн. Энэхүү форвард гэрээг төлөвлөгөөт арилжаанд хамаарах ханшийн эрсдэлийн мөнгөн гүйлгээний хейдж гэж тодорхойлсон. Валютын ханш дараах байдалтай байв:

Он, сар, өдөр	Спот ханш	Форвард ханш
20X2 оны 9 дүгээр сарын 30	1.22	1.23
20X2 оны 12 дугаар сарын 31	1.23	1.24

20X3 оны 3 дугаар сарын 31	1.25	1.25
20X3 оны 7 дугаар сарын 30	1.26	Тодорхойгүй

Зах зээлийн жишиг үнэлгээг ашиглан тодорхойлсон 20X2 оны 12-р сарын 31 ба 20X3 оны 3-р сарын 31-нд валютын форвард хэлцлийн бодит үнэ цэн харгалзан 9,500 ба 19,700 байсан. 20X3 оны 6-р сарын 30-ний бодит үнэ цэн 30,000 евро болсон ба энэ нь тухайн өдрөөр төлөгдөх цэвэр дүн юм. Форвард хэлцэл болон хүлээсэн үүрэгтэй холбоотойгоор ямар нэгэн төлбөр тооцоо гараагүй тул 20X2 оны 9-р сарын 30-нд ямар нэгэн журналын бичилт хийхгүй. Мөн форвард хэлцэл байгуулах өдөр түүний бодит үнэ цэн тэг байсан.

Уг хейджийг зохих ёсоор баримтжуулсан ба 20X2 оны 12-р сарын 31-нд үр өгөөжтэй гэж үзсэн бол 20X2 оны 9-р сарын 30-ээс хойшх уг форвард хэлцлийн бодит үнэ цэнийн орлогыг бүртгэхдээ:

Дебит: Холбогдох деривативын данс (хөрөнгө) – Форвард арилжааны авлага 9,500
Кредит: Бусад өөрийн хөрөнгө (Хейджийн дахин үнэлгээний сан) 9,500

20X3 оны 3-р сарын 31-нд тоног төхөөрөмжийг хүлээн авах үед:

Дебит: Тоног төхөөрөмж (Үндсэн хөрөнгө) 1,250,000 (1 сая ам.доллар * спот ханш 1.25)
Кредит: Дансны өглөг (Бусад санхүүгийн өр төлбөр) 1,250,000 евро

20X3 оны 3-р сарын 31-нд деривативын бодит үнэ цэн 10,200 еврогоор өссөнийг бүртгэхдээ (EUR 19,700 – EUR 9,500):

Дебит: Холбогдох деривативын данс (хөрөнгө)–Форвард арилжааны авлага10,200
Кредит: Бусад өөрийн хөрөнгө (Хейджийн нөөц (өөрийн хөрөнгийн данс)) 10,200

20X3 оны 6-р сарын 30-нд тоног төхөөрөмжийн үнийг төлөх үед:

Дебит: Дансны өглөг (Бусад санхүүгийн өр төлбөр) 1,250,000 евро
Дебит: Валютын арилжааны зардал 10,000 евро
Кредит: Мөнгөн хөрөнгө 1,260,000 (1 сая ам.доллар * спот ханш 1.26)

Төлбөр барагдуулах өдөр деривативын бодит үнэ цэн 10,300 еврогоор өссөнийг бүртгэхдээ (EUR 30,000 – EUR 19,700):

Дебит: Холбогдох деривативын данс (хөрөнгө) – Форвард арилжааны авлага 10,300 евро
Кредит: Валютын арилжааны орлого (хэрэгжсэн) 10,300 евро

Хейджийг бүртгээгүй байсан ч гадаад валютаар илэрхийлэгдсэн өглөгийн ханшийн тэгшитгэлийн орлого, зардалд деривативын бодит үнэ цэнийн өсөлтийг хаах тул сүүлийн тайлант хугацаанд гадаад валютын форвардыг хейджээр бүртгэхгүй.

Форвард гэрээний дагуу төлсөн цэвэр мөнгөн төлбөр:

Дебит: Мөнгөн хөрөнгө 30,000
Кредит: Холбогдох деривативын данс (хөрөнгө)–Форвард арилжааны авлага 30,000

Дээрх жишээнд хейджийг үр өгөөжтэй гэж үзсэн. Хэрэв тийм биш бол деривативын бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тайлант хугацааны орлого, зардал болон өөрийн хөрөнгөнд хуваах бүртгэнэ.

Банк дээрх жишээнд заасан хейджийн иж бүрэн бүртгэлийг ашиглахын тулд хейджийг бүртгэж байгаа тухайгаа болон СТОУС-д заасан хейджийн бүртгэлийг ашиглах шаардлагыг хангаж байгаагаа Монголбанкинд мэдэгдэж, зөвшөөрөл авна.

Жишээ: **Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын гадаад валютын эрсдэлийн хейдж**

Форвард хэлцлийг ашиглан борлуулахад бэлэн гэж ангилсан хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалтын гадаад валютын эрсдэлд хийсэн хейджийг хэрхэн бүртгэх вэ?

Өгөгдөл

Швейцарийн А компани Х компанийн хувьцааг худалдан авч, борлуулахад бэлэн гэж ангилсан. Х компанийн хувьцаа нь АНУ-ын биржид бүртгэлтэй, доллараар илэрхийлэгдсэн бөгөөд ногдол ашгаа ам.доллааараар төлдөг. Уг хувьцааг 10 сая ам.доллараар худалдан авсан.

Ам.доллар Швейцарь франкийн (CHF) эсрэг суларч, үүний улмаас ирээдүйд алдагдал хүлээхийг А компанийн удирдлага хүсээгүй. Тус компанийн удирдлага уг үнэт цаасыг дор хаяж 2 жил эзэмшиж

төлөвлөгөөтэй байгаа ба 2 жилийн дараа ам.доллар худалдаж, Швейцарь франк худалдан авах форвард хэлцэл байгуулсан. Хэлцлийн нэрлэсэн үнэ 9 сая ам.доллар ба энэ нь А компанид оруулсан 9 сая ам.долларын бодит үнэ цэн бүхий хөрөнгө оруулалтанд хейдж хийж байгаа явдал юм. А компанийн удирдлага спот ханшийн өөрчлөлтийн улмаас бий болсон деривативын бодит үнэ цэнийн өөрчлөлтийг USD/CHF-ийн спот ханш өөрчлөгдсөнөөр хувьцааны бодит үнэ цэнийн хейдж хийсэн хэсгийн өөрчлөлттэй харьцуулах замаар хейджийг үр өгөөжийг тогтоохоор шийдвэрлэсэн.

Форвард ханшийн зөрүүнд хамаарах форвард гэрээг хейджээр бүртгэхгүй, бодит үнэ цэнээр үнэлж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг орлого, зардалд бүртгэнэ (форвард ханшийн зөрүүг форвард ба спот ханшуудын зөрүүгээр тодорхойлно).

Шийдэл

Хэрэв хейджийн бүртгэлийн шалгуур хангагдсан бол А компанийн удирдлага бодит үнэ цэнийн өөрчлөлтийг дараах байдлаар бүртгэнэ:

(а) Форвард гэрээ: компанийн удирдлага форвард гэрээний бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс шалтгаалан үүссэн орлого, зардлыг орлогын тайланд харуулна. Үүнд спот гэрээ (хейджийн бүртгэлд тусгагдсан) ба форвард ханшийн зөрүү багтана.

(б) Хөрөнгө оруулалт: компанийн удирдлага хөрөнгө оруулалтын хейдж хийсэн хэсгийн дүнд ханшийн тэгшитгэл хийхэд үүссэн орлого, зардалтай холбоотой бодит үнэ цэнийн өөрчлөлтийн хэсгийг орлогын тайланд харуулна (9 сая ам.доллар ба ам.долларын бодит үнэ цэнийн аль багаар).

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийн үлдсэн хэсгийг борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын адил өөрийн хөрөнгийн дансанд хойшлуулан бүртгэнэ. Хэрэв ам.долларaар илэрхийлэгдсэн хөрөнгө оруулалтын бодит үнэ цэн нь хейдж хийсэн 9 сая ам.долларaас бага гарвал хейдж үр өгөөжгүй болно.

Жишээ: **Капиталжуулсан зээлийн зардал ба хейджийн бүртгэл**

Хөрөнгийг бүтээн босгох ажлыг санхүүжүүлж буй зээлийн эх үүсвэрт хейдж хийсэн хүүгийн түвшний свопын бодит үнэ цэнийн өөрчлөлтийг капиталжуулах уу?

Өгөгдөл

В компани цахилгаан станц барихаар 10 сая төгрөгийн зээл авсан. Тус компани уг зээлд хөвөгч хүү төлдөг боловч үүнд хөвөгч хүүг авч, тогтмол хүү төлөх хүүгийн түвшний свопоор хейдж хийсэн. В компани НББОУС 23-г мөрдөг ба цахилгаан станцын өртгийг тооцоолохдоо шалгуур хангасан зээлийн зардлыг капиталжуулдаг.

Шийдэл

Хейджийн бүртгэлийн шалгуур хангагдаж байгаа үед капиталжуулж болно. В компани зохих зээлийн зардлыг капиталжуулах сонголтыг хийсэн тул свопын үр өгөөжтэй хэсгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг уг цахилгаан станцын өртөгт капиталжуулна.

Хэрэв хейджийн бүртгэлийн шалгуур хангагдаагүй бол В компани уг деривативыг арилжааны үнэт цаасаар бүртгэнэ. Энэ үед свопын бодит үнэ цэнийн өөрчлөлтийг орлогын тайлан харуулах ба уг цахилгаан станцын өртөгт капиталжуулахгүй болно.

Жишээ: Гадаад валютын арилжааны деривативын бодит үнэ цэнийн тооцоолол*

* Энэ жишээнд бодит үнэ цэнийг тооцоолохдоо Монголбанкны спот ханшийг ашиглаагүй бөгөөд харин тооцоололд ам.доллар болон төгрөгийн хадгаламжийн хүүгийн түвшний зөрүүг ашигласан.

Банк 5,000 ам.доллар худалдан авах форвард хэлцэл хийсэн. Хэлцэл хийсэн өдөр 2013 оны 11-р сарын 30 ба төлбөр барагдуулах өдөр 2014 оны 1-р сарын 23.

Хэлцлийн ханш 1430.

12-р сарын 31-нд Монголбанкны спот ханш 1,650 төгрөг байсан. Хүүгийн түвшинг (Хүүгийн түвшний парити) ашиглан онолын форвард ханшийг тодорхойлъё.

12-р сарын 31-нд төгрөг зээлдүүлэх хүү 8.5% ба ам.доллар зээлэх хүү 0.2% байсан.

Онолын форвард ханшийг тооцоолохын тулд дараах томъёог ашиглана

1,650 + (1,650*(8.5%-0.2%)*23/360) = 1658.75

Энэ форвардын бодит үнэ цэн нь 12-р сарын 31-нд (1,658.75-1,430)*5,000 = 1,143,747

Банк зээл авах ба олгох хүүгийн түвшний хоорондын маржин их байгааг харуулсан форвардын онолын ханшийг тогтооход ашиглах төгрөгийн хүүгийн түвшинд үндэслэн төлбөрийг тогтоох боловч ам.доллар худалдаж, төгрөг худалдан авахдаа үүнийг эсрэгээр нь мөрдөнө. Төгрөг худалдан авах үед 12.5%-ийн хүүгийн түвшинг ашиглах нь тохиромжтой байж болно.

Е. ТОДРУУЛГА

Гадаад валют, үнэт металлыг арилжаалах хэлцэл, бусад деривативыг ангилал бүрээр нь бүлэглэж, холбогдох үлдэгдэл, тайлант хугацаанд гарсан өөрчлөлт, хүлээн зөвшөөрсөн үнэлгээний ба арилжааны орлого, зардлыг тодруулна.

Тодруулгад форвард, своп, фьючерс, опшин хэлцэл, бусад деривативтай холбоотойгоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн деривативын бодит үнэ цэнийн тооцоолол, түүнд ашигласан үнэлгээний аргыг оруулна.

Гадаад валют, үнэт металл, үнэт цаасыг худалдах эсвэл худалдан авахаар байгуулсан форвард, своп, фьючерс, опшин хэлцэлтэй холбоотой хүлээж болзошгүй эрсдэл, түүнд банкны зүгээс хийсэн үнэлгээ, шинжилгээг тодруулна.

Хейдж, түүнтэй холбоотой эрсдэлүүдийг тодруулна. Банк хейджийг бүртгэсэн тохиолдолд иж бүрэн бөгөөд зохистой тодруулга хийх үүднээс НББОУС 39 ба СТОУС 7-ийн дагуу дэлгэрэнгүй шинжилгээг хийнэ.

Ё. ХЯНАЛТ

- Ажилтнуудын ажил үүргийг зааглан тусгаарлана.
- Гүйлгээний баримтын бүрдлийг хангана.
- Хэлцлийн нэр, төрлөөр дэлгэрэнгүй бүртгэл хөтөлнө.
- Дэлгэрэнгүй бүртгэлийг хяналтын дансны гүйлгээ, үлдэгдэлтэй тохируулна.
- Арилжааны бүртгэлийг үндсэн баримт, гэрээ хэлцэлтэй нь тулган шалгана.

4.5. БУСАД САНХҮҮГИЙН БА САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ

А. ШУУД ХОЛБОГДОХ СТАНДАРТУУД

- СТОУС 7 Санхүүгийн хэрэгсэл: Тодруулга
- СТОУС 9 Санхүүгийн хэрэгсэл
- СТОУС 13 Бодит үнэ цэнийн хэмжилт
- НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- НББОУС 2 Бараа материал
- НББОУС 17 Түрээс
- НББОУС 23 Зээлийн өртөг
- НББОУС 36 Хөрөнгийн үнэ цэнийн бууралт
- НББОУС 39 Санхүүгийн хэрэгсэл: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Б. ТОДОРХОЙЛОЛТ

Бусад санхүүгийн хөрөнгөнд дараах зүйлсийг хамруулна:

- Бусдаас авах авлага
- Банк, салбар хоорондын тооцооны авлага
- Өмчлөх бусад хөрөнгө - санхүүгийн хөрөнгө
- Бусад

Бусад санхүүгийн бус хөрөнгөнд дараах зүйлсийг хамруулна:

- Урьдчилгаа
- Зах зээлийн хүүгээс доогуур хүүтэйгээр ажилтнуудад олгосон зээлийн урьдчилгаа
- Бараа материал, үнэ бүхий зүйлс
- Үнэт металл
- Өмчлөх бусад хөрөнгө (хөдлөх ба үл хөдлөх хөрөнгө)

- Тайлант үеийн татварын авлага
- Хойшлогдсон татварын хөрөнгө
- Бусад санхүүгийн бус хөрөнгө

НББОУС 1-ийн дагуу санхүүгийн тайланд санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгийг салгаж харуулна. Иймээс бусад санхүүгийн хөрөнгө ба бусад санхүүгийн бус хөрөнгийг тусад нь толилуулна.

Бусад санхүүгийн хөрөнгө гэж бусад аж ахуйн нэгжээс мөнгө болон бусад санхүүгийн хөрөнгийг авах гэрээний эрхийг хэлнэ. Хэрэв мөнгө болон бусад санхүүгийн хөрөнгийг авах гэрээний эрх үүсэхгүй тохиолдолд уг хөрөнгийг *бусад санхүүгийн бус хөрөнгө* гэж үзнэ. Санхүүгийн хөрөнгийн дэлгэрэнгүй тодорхойлолтыг НББОУС 32.11-т заасан бөгөөд үүнийг энэ зааварт багтсан тодорхойлолтонд зааснаар тогтоох боломжгүй тохиолдолд ашиглана.

Авлага нь нийлүүлсэн бараа, ажил, үйлчилгээний үнэ, бусдаас авахаар хүлээн зөвшөөрөгдсөн тооцоо юм. Авлагад банкны үндсэн бус үйл ажиллагаанаас үүссэн авлагыг хамруулна. Тухайлбал зээлээр борлуулсан эд хогшил, ажиллагсад болон бусад байгууллага, хүмүүсээс авах зээлээс бусад тооцооны авлага гэх мэт төрлийн авлага багтана.

Банкны төв, салбаруудын хооронд хийгдэж байгаа төлбөр тооцоогоор үүсэх авлага, өглөгийг *салбар хоорондын тооцооны* дансанд бүртгэнэ.

Банкуудын хооронд хийгдэж байгаа төлбөр тооцоогоор үүсэх авлага, өглөгийн түр дансдын үлдэгдлийг *банк хоорондын клирингийн тооцооны дансанд* бүртгэнэ.

Бусад санхүүгийн хөрөнгөнд авлага (арилжааны ба бусад авлага, тооцоо) болон ирээдүйд төлөгдөхөөр хүлээгдэж буй бусад санхүүгийн хөрөнгө багтана.

Урьдчилгаа нь хөрөнгө оруулалтын бус зориулалтаар төлсөн мөнгө буюу бэлтгэн нийлүүлэгчид төлсөн боловч ажил, үйлчилгээ, бараагаа хараахан аваагүй урьдчилгаа болон урьдчилж төлсөн зардлуудыг хамарна. Урьдчилгаа буюу урьдчилж төлсөн тооцоо дансанд үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийг худалдан авахтай холбоотой урьдчилгаа төлбөрийг бүртгэхгүй.

Урьдчилж төлсөн тооцоонд бараа, ажил, үйлчилгээний үнэнд төлсөн урьдчилгаа төлбөрийг бүртгэнэ.

Бусад урьдчилгааанд ажилтнуудад олгосон томилолтын урьдчилгаа, бусад дараа тайлангийн тооцоо багтана.

Зах зээлийн хүүгээс доогуур хүүтэйгээр ажилтнуудад олгосон зээлийн урьдчилгаа гэж НББОУС 19-ийн дагуу цалингийн урьдчилгаа гэж бүртгэн, зээлийн хугацаанд хорогдуулдаг, ажилтнуудад олгосон зээлийг анх удаа хүлээн зөвшөөрөх үеийн зардлыг хэлнэ. Энэ хөрөнгийн бүртгэлийн онцлогийг “Зээл” бүлэгт дэлгэрэнгүй тайлбарласан.

Бараа материал, үнэ бүхий зүйл гэж банкны үйл ажиллагаанд шаардагдах ашиглалтанд шууд тавьж олгосноос бусад бараа, материал, үнэ бүхий зүйл, хангамжийн зүйлс, маягтыг энэ дансанд бүртгэнэ.

Үнэт металлд банкны худалдан авч байршуулсан, арилжааны зориулалттай алт, мөнгө, бусад үнэт металлууд багтана.

- *Цэвэршүүлсэн алт:* Олон улсын жишиг буюу 999.9 сорьцтой, гадаад валютаар борлуулахад бэлэн олон улсын төлбөр тооцооны хэрэгсэл.
- *Цэвэршүүлсэн мөнгө*: Алтыг цэвэршүүлэхэд ялгарсан 999 сорьцтой, гадаад валютаар борлуулахад бэлэн олон улсын төлбөр тооцооны хэрэгсэл.
- *Цэвэршүүлээгүй алт:* Гадаад валютаар шууд борлуулах нөхцөл хангагдаагүй дотоодод хайлж, хадгалагдаж буй бохир алт.
- *Цэвэршүүлээгүй мөнгө:* Гадаад валютаар шууд борлуулах нөхцөл хангагдаагүй дотоодод хайлж, хадгалагдаж буй бохир мөнгө.

Үнэт металлыг унц, төгрөгөөр давхар бүртгэнэ. Нэг унц нь 31.1034768 граммтай тэнцэнэ.

Өмчлөх бусад хөрөнгө гэж зээл, хүүгийн төлбөрийн тооцоогоор бусдаас авсан санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгийг ойлгоно. Үүнд үл хөдлөх (барилга байгууламж) болон хөдлөх хөрөнгө (суудлын машин, тоног төхөөрөмж, бараа материал) багтахаас гадна үнэт цаас гэх мэт санхүүгийн хөрөнгө мөн багтана. Өмчлөх бусад хөрөнгөнд худалдан борлуулах зориулалттай, банкны үйл ажиллагаанд ашиглагдахгүй хөрөнгө багтана.

Татварын авлага гэж тайлант болон өмнөх үеийн татвар ногдуулах ашиг, алдагдалтай холбогдуулан татварын эрх бүхий байгууллагаас нөхөгдөхөөр хүлээгдэж буй дүнг хэлнэ.

Хойшлогдсон татварын хөрөнгө гэж хасагдах түр зөрүү, татварын алдагдлыг дараагийн тайлант үед шилжүүлэхтэй холбоотойгоор ирээдүйн тайлант үед нөхөгдөх орлогын татварын дүнг хэлнэ.

В. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

СТОУС-д заасан хөрөнгө хүлээн зөвшөөрөх үндсэн шалгуурыг хангаж, уг хөрөнгийг эзэмших хүчин төгөлдөр эрх банкинд үүссэн тохиолдолд бусад санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Зээлдэгч гэрээний нөхцлийг зөрчиж, барьцаа хөрөнгийг өмчлөх эрхийг банкинд шилжүүлсэн буюу зээл, авлагыг барагдуулах зорилгоор банк зээлдэгчтэй байгуулсан гэрээнд барьцаа болгон заасан хөрөнгийн эзэмших, өмчлөх, захиран зарцуулах эрхийг өөртөө шилжүүлэн авсан бол өмчлөх бусад хөрөнгийг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

Өмчлөх бусад хөрөнгийг худалдахаар гэрээ хийж, төлбөрийг хэсэгчлэн барагдуулж дуусгах магадлалтай бөгөөд хөрөнгөтэй холбоотой бүх эрсдэл, өгөөжийг худалдан авагч талд шилжүүлсэн үед банк өмчлөх бусад хөрөнгийг данснаас хасч, гэрээний дагуу төлөгдсөн ба төлөгдөх мөнгийг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Банк өмчлөх бусад хөрөнгийн төрөл, ангиллаас (санхүүгийн хөрөнгө, бараа материалын зүйл, үндсэн хөрөнгө гэх мэт) шалтгаалан хөрөнгийг данснаас хасах шалгуурыг үнэлж, шинжилнэ.

Өмчлөх бусад хөрөнгийг борлуулах, засварлах, хадгалах, хамгаалахтай холбогдон гарах урсгал зардлыг тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрнө.

Хэрэв өмчлөх бусад хөрөнгийг засварласны үр дүнд түүний хүчин чадал, чанар сайжирч, үнэ цэн нь материаллаг дүнгээр өсч байвал холбогдох засварын зардлыг хөрөнгийн өртөгт шингээж бүртгэнэ.

Өмчлөх бусад хөрөнгийг борлуулахад үүсэх олз, гарзыг тайлант хугацааны орлого, зардлаар хүлээн зөвшөөрнө.

Г. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

Авлагыг эрсдэлийн санг хассан цэвэр дүнтэй тэнцэх хорогдуулсан өртгөөр хэмжинэ.

Урьдчилгааг банкнаас төлсөн дүнгээр хэмжинэ.

Гадаад валютаар төлөгдөх авлага болон тооцоог Монголбанкнаас зарласан албан ханшаар төгрөгт хөрвүүлэн төгрөг, гадаад валютаар давхар бүртгэх ба ханшийн хэлбэлзлээс үүсэх орлого, зардлыг гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого, зардлаар хүлээн зөвшөөрнө.

Банкны үйл ажиллагаанд хэрэглэгдэх ба ашиглалтанд шууд тавьж олгосноос бусад бараа, материал, үнэ бүхий зүйл, хангамжийн зүйлсийг “Бараа материал, үнэ бүхий зүйл” дансанд бүртгэнэ. Бараа материал, үнэ бүхий зүйлийн үнэлгээг эхэлж авсныг эхэлж зарлагадах арга эсвэл дундаж өртгийн аргаар гүйцэтгэнэ. Мөн материалын үнэ бүхий зүйлийг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар үнэлнэ.

Гадаад валютаар худалдан авсан материал хангамжийн зүйлийг бүртгэлд тусгах өдрийн Монголбанкнаас зарласан албан ханшаар төгрөгт хөрвүүлэн бүртгэнэ. Мөнгөн бус зүйлийн хувьд ханшийн тэгшитгэл хийхгүй.

Бараа материал эвдэрч, гэмтсэн, бүхэлдээ буюу хэсэгчлэн ашиглалтаас гарсан, худалдах үнэ нь буурсан зэрэг тохиолдолд бараа материалын өртөг нөхөгдөх боломжгүй болно. Бараа материалын өртгийг цэвэр боломжит үнэ цэн хүртэл бууруулсанаар хөрөнгийг худалдах үнэ буюу зарцуулах дүнгээс ихгүй дүнгээр тайлагнана.

Цэвэр боломжит үнэ цэнийн үнэлгээг тайлагналын өдрөөр гүйцэтгэнэ. Бараа материалын өртгийг бууруулсан шалтгаан байхгүй болсон эсвэл эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас цэвэр боломжит үнэ цэн эргэн өссөн талаар бодитой нотолгоо байгаа тохиолдолд өртгийг бууруулсан дүнг буцаах бичилт хийх (буцаах дүн нь анх бууруулж бичсэн дүнгээс хэтрэхгүй) ба ингэснээр бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар илэрхийлнэ. Жишээлбэл, худалдах үнэ нь буурсан шалтгаанаар бараа материалын зүйлийг цэвэр боломжит үнэ цэнээр илэрхийлсэн үед дараагийн тайлант хугацаанд бараа материалын үнэлгээ өснө.

Үнэт металлыг мөнгөжүүлсэн, мөнгөжүүлээгүй үнэт металл гэж ангилна. Үнэт металлыг бодит үнэ цэнээс боловсруулалт болон худалдааны зардлыг хассан дүнгээр үнэлж, тайлагнана. Үнэт металлыг худалдсан үед арилжааны орлого, зардал хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Мөнгөжүүлсэн үнэт металлыг гадаад валютын нэгэн адил бүртгэж, унцаар илэрхийлнэ. Мөнгөжүүлээгүй үнэт металлыг (граммаар хэмжиж) төгрөгөөр үнэлж, илэрхийлнэ.

Өмчлөх бусад хөрөнгөнд анх авах үед нь бодит үнэ цэнээр бүртгэж, бусад санхүүгийн (үнэт цаас) ба санхүүгийн бус (хөдлөх ба үл хөдлөх хөрөнгө) хөрөнгөнд ангилж бүртгэсэн хөрөнгө багтана. Өмчлөх бусад хөрөнгийг анх хүлээн зөвшөөрсний дараах тайлант хугацаанд хэрхэн хэмжиж, ангилах нь хөрөнгийн онцлог шинж, банкны бодлого, төлөвлөгөөнөөс шалтгаална. Хэрэв банк хөдлөх ба үл хөдлөх хөрөнгө хэлбэртэй барьцааг худалдан борлуулах, өөрөө ашиглах эсвэл эдийн засгийн өгөөж авах зорилгоор эзэмших эсэхээ хараахан шийдээгүй тохиолдолд өмчлөх хөрөнгийг “Бусад санхүүгийн бус хөрөнгө”-ийн харгалзах дансанд бүртгэнэ. Үүний нэгэн адил банк санхүүгийн хөрөнгийг хэрхэх эсэхээ шийдээгүй нөхцөлд санхүүгийн хөрөнгө хэлбэртэй өмчлөх бусад хөрөнгийг (үнэт цаас) “Бусад санхүүгийн хөрөнгө”-ийн харгалзах дансанд бүртгэнэ.

Хэрэв банкны удирдлага олж авсан үл хөдлөх хөрөнгөө (барилга байгууламж) ашиглахаар шийдвэрлэсэн бол өмчлөх бусад хөрөнгийг үндсэн хөрөнгөнд хамаарах нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлж, ангиллыг өөрчилнө. Хэрэв банк өөрөө ашиглалгүйгээр бусдад түрээслүүлэх болон капиталын өгөөж хүртэх зорилгоор барилга байгууламжийг эзэмшилдээ үлдээхээр шийдвэрлэсэн бол өмчлөх бусад хөрөнгийг хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийн дансанд шилжүүлж, ангиллыг өөрчилнө. Банк өмчлөх бусад хөрөнгө байдлаар олж эзэмшсэн хөдлөх ба үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулахаар шийдвэрлэсэн бол уг хөрөнгийг бараа материалын адил бүртгэж, “Борлуулах зориулалттай хөрөнгө” дансанд шилжүүлж, ангиллыг өөрчилнө. "Борлуулах зориулалттай хөрөнгө"-д бүртгэсэн хөрөнгө нь Нягтлан бодох бүртгэлийн багц материалын дөрөвдүгээр хавсралт "Банкны санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх аргачлал"-ын 3.7.И заалтад дурдсан тодорхойлолтын шаардлагыг хангахгүй, эсхүл шаардлагад нийцэхгүй гэж Монголбанкнаас дүгнэвэл уг хөрөнгийг Өмчлөх бусад хөрөнгөнд (буцаан) бүртгэнэ.

Санхүүгийн хөрөнгө (үнэт цаас) хэлбэртэй өмчлөх бусад хөрөнгийг яаж ангилахаа шийдээгүй нөхцөлд “Бусад санхүүгийн хөрөнгө”-өөр бүртгэнэ. Гэхдээ уг хөрөнгийг “борлуулахад бэлэн үнэт цаас”-ийн адил бүртгэх тул уг үнэт цаасыг бодит үнэ цэнээр хэмжиж, тайлагнана. Бодит үнэ цэнээр илэрхийлэх шаардлага нь бүх төрлийн өрийн үнэт цаасанд мөрдөгдөх ба харин өмчийн үнэт цаасанд НББОУС 39-ийн дагуу тодорхой хязгаарлалт тавигдсан байдаг (бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжгүй тохиолдолд өртгөөр нь илэрхийлнэ). Иймд банк өмчлөх бусад хөрөнгийн бодит үнэ цэнийг сар бүр тодорхойлж, бодит үнэ цэнд гарсан өөрчлөлтийг өөрийн хөрөнгөнд бүртгэнэ. Өмчлөх бусад хөрөнгийг “Бусад санхүүгийн хөрөнгө”-өөр бүртгэсэн сарын эцэст анхны дахин үнэлгээг хийнэ. Борлуулахад бэлэн үнэт цаасны бүртгэлийн удирдамжийг энэ зааврын “Хөрөнгө оруулалт” бүлэгт оруулсан.

Хэрэв банкны удирдлага (өмчлөх бусад хөрөнгөөр бүртгэсэн) хөрөнгийг хөрөнгө оруулалтын үнэт цаас байдлаар эзэмших нь тодорхой байгаа тохиолдолд үнэт цаасыг “Хөрөнгө оруулалт”-ын тохирох ангиллаар ангилан, бүртгэнэ (үнэт цаасны онцлог шинж, банкны удирдлагын шийдвэрээр арилжааны үнэт цаас, хугацааны эцэст хүртэл эзэмших үнэт цаас, борлуулахад бэлэн үнэт цаас, зээл ба авлага гэж ангилсан бусад үнэт цаас). Банк өмчлөх бусад хөрөнгийг холбогдох зээл, хуримтлуулсан хүүгийн авлагын нийт дүн (барьцаат хөрөнгийг борлуулаад орох орлогыг зээлийн дүнгээр хязгаарласан нөхцөлд) ба уг хөрөнгийн тухайн үеийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн аль багаар нь анх үнэлж, бүртгэнэ.

Хэрэв зээл, түүнд хамаарах авлагын (хүү ба шимтгэл) дүн нь өмчлөх бусад хөрөнгийн зах зээлийн үнээс их байгаа тохиолдолд өмчлөх бусад хөрөнгийг бодит үнэ цэнээс борлуулах зардлыг хассан дүнгээр бүртгэж, зээл, түүнд хамаарах авлагын дүнг мөн энэ хэмжээ хүртэл бууруулна. Эдгээрийн зөрүүг өмчлөх бусад хөрөнгийн зардалд бүртгэж, орлогын тайланд толилуулна. Энэ тооцооллыг хөрөнгийн үнэлгээчин борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнийг тогтоосны дараа хөрөнгийг анхны удаад хүлээн зөвшөөрөх үед дээрх байдлаар бүртгэнэ. Хэрэв банк өмчлөх бусад хөрөнгийг дансны үнээр нь удаан хугацаагаар (6 сар, түүнээс урт хугацаанд) борлуулж чадахгүй бол уг хөрөнгийн дансны үнийг бууруулж тохируулах шаардлагатай болох тул банк уг хөрөнгийн зах зээлийн үнэлгээг жилд нэг болон түүнээс дээш давтамжтайгаар дахин үнэлж тогтооно. Хөрөнгийг зах зээлийн үнэтэй нийцүүлэн үнэ цэнийг бууруулсан бол тохируулгыг зардалд бүртгэнэ. Банк өмчлөх бусад хөрөнгийн үнийн бууралтыг эрсдэлийн сангийн дансанд бүртгэнэ.

Өмчлөх бусад хөрөнгийн (санхүүгийн ба санхүүгийн бус) үнэ цэнийн бууралт болон хөрөнгийн бодит үнэ цэнийг СТОУС-ын дагуу тооцох аргачлалыг банк дотооддоо боловсруулж, мөрдөнө.

СТОУС-ын дагуу санхүүгийн хөрөнгийн (үнэт цаас) хэлбэртэй өмчлөх бусад хөрөнгийн хувьд үнэт цаасны дансны үнэ нь бодит үнэ цэн буюу хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнээс хэтэрсэн тохиолдолд эрсдэлийн сангийн зардлыг үнэт цаасны дансны үнэ ба бодит үнэ цэн буюу хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийн зөрүүгээр тодорхойлно. Жишиг үнэ

бүхий үнэт цаасны хувьд зах зээлийн үнэнд үндэслэн бодит үнэ цэнийг тодорхойлох ба жишиг үнэ олдохгүй тохиолдолд үнэлгээний аргыг ашиглан тодорхойлно. Энэ талаар "Хөрөнгө оруулалт" бүлэгт дэлгэрэнгүй тайлбарласан.

Холбогдох активын ангиллын журмын дагуу банк үнэт цаас хэлбэртэй өмчлөх бусад хөрөнгөнд эрсдэлийн сан байгуулна. Түүнчлэн тайлант жилийн эцэст СТОУС-ын дагуу өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тооцоолно. СТОУС-ын дагуу тооцоолсон дүнг орлогын тайланд толилуулах ба энэ дүнгээс холбогдох активын ангиллын журмын дагуу байгуулах эрсдэлийн сан хэтэрсэн тохиолдолд эдгээрийн зөрүүг өөрийн хөрөнгийн нөөцийн дансанд бүртгэнэ. Хэрэв СТОУС-ын дагуу байгуулсан эрсдэлийн сан холбогдох активын ангиллын журмаар байгуулсан эрсдэлийн сангаас өндөр гарсан тохиолдолд СТОУС-ын дагуу байгуулах эрсдэлийн санг зардалд бүртгэж, орлогын тайланд толилуулах ба өөрийн хөрөнгийн нөөцийн дансны үлдэгдэл тэг болно.

Банк санхүүгийн бус хөрөнгө хэлбэртэй өмчлөх бусад хөрөнгийн хувьд СТОУС-ын дагуу үнэ цэнийн бууралтыг хэмжихдээ санхүүгийн тайлангийн өдрөөр хөрөнгийн үнэ цэн буурсан эсэхийг шалгах ба үнэ цэн буурсан шинж тэмдэг байгаа бол тухайн хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцож, дансны үлдэгдэлтэй харьцуулан, хөрөнгийн бодит үнэ цэнээс хэтэрсэн дансны үлдэгдлээр эрсдэлийн сан байгуулна. Эрсдэлийн сангийн зардлыг буцаах нөхцөл хангагдсан үед эрсдэлийн сангийн зардлын буцаалтыг анх бүртгэсэн эрсдэлийн сангийн зардлаас хэтрүүлэлгүйгээр бүртгэнэ.

Тайлант хугацааны татварын илүү төлөлт (авлага) болон хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрч, хэмжих талаар энэ зааврын "Орлогын албан татвар" бүлгээс үзнэ үү.

Холбогдох активын ангиллын журмын дагуу бусад хөрөнгөнд эрсдэлийн сан байгуулна.

Түүнчлэн тайлант жилийн эцэст СТОУС-ын дагуу бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тооцож болно. Банк бусад хөрөнгөнд багтсан хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралтыг тооцох СТОУС-д нийцэх аргачлалыг дотооддоо боловсруулж, мөрдөнө.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн бусад хөрөнгийн эрсдэлийн санг гадаад валютаар байгуулж, уг дансанд ханшийн тэгшитгэл хийнэ.

Банк дээрх аргачлалын аль нэгийг сонгож, бүртгэлийн бодлогодоо тусган, тууштай мөрдөнө.

Д. БҮРТГЭЛ

<u>1) Авлага</u>

Авлагыг ижил төстэй шинжээр нь төрөлжүүлж бүртгэнэ.

Дебит: Авлагын холбогдох данс
Кредит: Мөнгөн хөрөнгө эсвэл хөрөнгийн холбогдох данс

Авлагыг төлөгдсөн тухай бүрт хаана.

Дебит: Мөнгөн хөрөнгө эсвэл хөрөнгийн холбогдох данс
Кредит: Авлагын холбогдох данс

Авлага төлөгдсөн дүнгээр түүнд байгуулсан эрсдэлийн санг буцаана.

Дебит: Авлагын эрсдэлийн сан
Кредит: Авлагын эрсдэлийн сангийн зардал эсвэл Бусад орлого

Авлагад эрсдэлийн сан байгуулахад

Дебит: Авлагын эрсдэлийн зардал
Кредит: Авлагын эрсдэлийн сан

Авлагыг төлүүлж авч чадахгүй бол банкны холбогдох журам, удирдлагын шийдвэрийн дагуу эрсдэлийн сангаас хаана.

Дебит: Авлагын эрсдэлийн сан
Кредит: Авлагын холбогдох данс

Эрсдэлийн сангаас хасагдсан авлага төлөгдсөн бол

Дебит: Мөнгөн хөрөнгө эсвэл хөрөнгийн холбогдох данс
Кредит: Бусад орлого - Эрсдэлийн сангаас хаагдсан авлагын эргэн төлөлт

2) Салбар хоорондын тооцоо

Салбар хоорондын тооцоо нь зөвхөн банкны төвөөр дамжиж хийгдэнэ.

Харилцагчийн болон банкны дотоодын төлбөрийг салбар хоорондын тооцоогоор шилжүүлбэл

Дебит: Харилцагчийн харилцах данс ба холбогдох данс
Кредит: Салбар хоорондын тооцооны түр данс

Төлбөрийг хүлээж авсан нэгж нь кредит мэдэгдлийг үндэслэж

Дебит: Салбар хоорондын тооцооны түр данс
Кредит: Харилцагчийн харилцах данс ба холбогдох данс

Банкны салбар хооронд зөвхөн бэлэн мөнгөний зузаатгал хийх болон системийн дотоодод хөрөнгийн тооцоо, жилийн үр дүнгийн хаалтын гүйлгээнд дебит мэдэгдлээр төлбөр суутган тооцож болно.

Салбар хоорондын тооцооны түр дансны үлдэгдлээр тухайн хугацаанд салбар хоорондын тооцоогоор хийсэн гүйлгээний цэвэр авлага, өглөг тодорхойлогдох ба энэ дансны үлдэгдлийг тухай бүр Салбар хоорондын тооцооны авлага, өглөгийн дансанд хаана.

Салбар хоорондын тооцооны түр данс Дебит үлдэгдэлтэй буюу авлагатай бол

Дебит: Салбар хоорондын тооцооны авлага буюу өглөг
Кредит: Салбар хоорондын тооцооны түр данс

Салбар хоорондын тооцооны түр данс Кредит үлдэгдэлтэй буюу өглөгтэй бол

Дебит: Салбар хоорондын тооцооны түр данс
Кредит: Салбар хоорондын тооцооны авлага буюу өглөг

Салбар хоорондын тооцоог гүйлгээ хийгдэж буй валютын төрөл бүрээр тусад нь бүртгэнэ.

3) Урьдчилгаа

Ажилтнууд албан үүрэг гүйцэтгэх, сургалт, семинарт хамрагдахаар гадаад, дотоодод томилолтоор явахад удирдлагын шийдвэрийн дагуу гарах зардлыг урьдчилан олгодог.

Дебит: Дараа тайлангийн тооцоо
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Томилолтын тайлан, зардлын баримтыг үндэслэн тооцоо хийж, холбогдох зардлаар хаахад

Дебит: Зардлын холбогдох данс
Кредит: Дараа тайлангийн тооцоо

Томилолтын тооцоогоор урьдчилгаанаас илүү, дутуу зарцуулсан бол зөрүүг нэмж олгох буюу буцааж тушаалгана.

Мөн бараа, үйлчилгээг хүлээн аваагүй үед төлбөрийг урьдчилж гүйцэтгэхэд урьдчилгаа тооцоо үүсдэг.
Дебит: Урьдчилж төлсөн тооцоо
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Бараа, үйлчилгээг хүлээж авсан үедээ урьдчилгаа тооцоог хааж, хүлээн авсан хөрөнгөө бүртгэнэ.

Дебит: Холбогдох хөрөнгө эсвэл зардал
Кредит: Урьдчилж төлсөн тооцоо

Байгууллага, хүмүүстэй хийсэн гэрээгээр үйл ажиллагааны зардлыг урьдчилан төлбөл урьдчилж төлсөн зардлаар бүртгэнэ.

Дебит: Урьдчилж төлсөн зардал
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Зардал хэрэгжсэн үед урьдчилж төлсөн зардлыг холбогдох тайлант үед зардлаар хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

Дебит: Зардлын холбогдох данс
Кредит: Урьдчилж төлсөн зардал

Ханшийн тэгшитгэлээр үнэт металлын ханш буурсан бол

Дебит: Үнэт металлын үнэлгээний зардал

Кредит: Үнэт металлын холбогдох данс

Ханшийн тэгшитгэлээр үнэт металлын ханш өссөн бол

Дебит: Үнэт металлын холбогдох данс
Кредит: Үнэт металлын үнэлгээний орлого

4) Бараа материал, үнэ бүхий зүйлс

Материал, үнэ бүхий зүйлс худалдаж авахад

Дебит: Материал, үнэ бүхий зүйл
Кредит: Мөнгөн хөрөнгө болон тооцооны холбогдох данс

Материал, үнэ бүхий зүйлийн зарцуулалтын тайланг үндэслэн түүнийг зардалд бүртгэнэ.

Дебит: Зардлын холбогдох данс
Кредит: Материал, үнэ бүхий зүйл

Хэрэв материал, хангамжийн зүйлсийг ашиглалтанд шууд тавьж олгосон бол шууд зардалд бүртгэнэ.
Дебит: Үйл ажиллагааны зардал – Материал хангамжийн зардал
Кредит: Мөнгөн хөрөнгө болон тооцооны холбогдох данс

Банк барьцаа хөрөнгийг эзэмшсэн үед тэнцлийн гадуурх "Авсан барьцаа" данснаас уг хөрөнгийг зарлагадаж, өмчлөх бусад хөрөнгийг бүртгэнэ.

Дебит: Өмчлөх бусад хөрөнгө
Кредит: Холбогдох зээл, авлагын данс

СТОУС-ын дагуу барьцаа хөрөнгийн дансны үнэ нөхөгдөх боломжгүй үед эрсдэлийн сангийн зардлыг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Өмчлөх бусад хөрөнгийг худалдан борлуулах замаар дансны үнийг нөхөх гэж байгаа бол уг хөрөнгийг бараа материалын зүйлээр бүртгэсэн тохиолдолд уг үнэлгээг бодит үнээс борлуулалтын зардлыг хассан дүнд үндэслэн гүйцэтгэнэ. Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө эсвэл "Борлуулах зориулалттай хөрөнгө"-өөр ангилан санхүүгийн бус хөрөнгийн хувьд эрсдэлийн сангийн зардлыг хэрхэн үнэлэх талаар энэ зааврын холбогдох бүлэгт оруулсан. Худалдан борлуулах замаар өртгийг нь нөхөх хөдлөх ба үл хөдлөх хөрөнгөнд хамаарах журналын бичилтийг доор харуулав.

Өмчлөх бусад хөрөнгөнд эрсдэлийн санг байгуулахад

Дебит: Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал
Кредит: Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сан

Үүнтэй нэгэн адил санхүүгийн хөрөнгө хэлбэртэй өмчлөх бусад хөрөнгийн хувьд эрсдэлийн сангийн зардлыг дараах байдлаар бүртгэнэ. Эрсдэлийн санг тооцоолох талаар "Хөрөнгө оруулалт" бүлэгт оруулсан.

Дебит: Өмчлөх бусад санхүүгийн хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал
Кредит: Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сан

Өмчлөх бусад хөрөнгийг борлуулах, засварлах, хадгалах, хамгаалахтай холбогдон гарах урсгал зардлыг бүртгэхэд

Дебит: Өмчлөх бусад хөрөнгийн урсгал зардал
Кредит: Мөнгөн хөрөнгийн болон бусад холбогдох данс

Өмчлөх бусад (санхүүгийн ба санхүүгийн бус) хөрөнгийг худалдсан бол

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Дебит: Өмчлөх бусад санхүүгийн хөрөнгийн эрсдэлийн сан (санхүүгийн ба санхүүгийн бус)
Дебит: Эрсдэлийн сангийн нөөц– зөвхөн санхүүгийн хөрөнгийн хувьд
Кредит: Өмчлөх бусад хөрөнгө (санхүүгийн ба санхүүгийн бус)

Өмчлөх бусад хөрөнгийг олзтой худалдсан үед дансны үнээс хэтэрсэн зөрүүг "Бусад орлого - Хөрөнгө борлуулалтын олз" дансанд бүртгэнэ.

Өмчлөх бусад хөрөнгийг гарзтай худалдсан үед дансны үнийн хэтэрсэн зөрүүг "Бусад зардал - Хөрөнгө борлуулалтын гарз" дансанд бүртгэнэ.

Худалдсан өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн санг буцаана.

Дебит: Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сан (санхүүгийн ба санхүүгийн бус)
Кредит: Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал (санхүүгийн ба санхүүгийн бус) эсвэл Бусад орлого (Монголбанкинд сар бүр хүргүүлэх тайланд "Бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн зардлын буцаалт" нэрээр тайлагнана)

Өмчлөх бусад хөрөнгийг борлуулах боломжгүй бол холбогдох журамд заасны дагуу банкны удирдлагын шийдвэрээр данснаас хасна. Уг шийдвэрт үндэслэн дараах байдлаар бүртгэнэ:

Дебит: Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сан
Кредит: Өмчлөх бусад хөрөнгө

5) Үнэт металл

Үнэт металл худалдан авах

Худалдан авсан үнэт металлыг албан ханшаар

Дебит: Үнэт металлын холбогдох данс
Кредит: Үнэт металлын хөрвүүлэлтийн түр данс

Худалдан авах ханшаар холбогдох мөнгөн хөрөнгийн дансыг бууруулна.

Дебит: Үнэт металлын хөрвүүлэлтийн түр данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Валютын хөрвүүлэлтийн дансыг орлого, зардлын дансанд хаана.

Ашигтай бол

Дебит: Үнэт металлын хөрвүүлэлтийн түр данс
Кредит: Үнэт металлын арилжааны орлого

Алдагдалтай бол

Дебит: Үнэт металлын арилжааны зардал
Кредит: Үнэт металлын хөрвүүлэлтийн түр данс

Үнэт металл худалдах

Үнэт металлыг худалдахдаа хэлцлийн валютаар

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Үнэт металлын хөрвүүлэлтийн түр данс

Үнэт металлаа дансны үнээр нь (Монголбанкнаас зарласан ханшаар) бүртгэн хэлцлийн ханшаар илэрхийлэх валютаар

Дебит: Үнэт металлын хөрвүүлэлтийн түр данс
Кредит: Үнэт металлын холбогдох данс

Ашигтай үед

Дебит: Үнэт металлын хөрвүүлэлтийн түр данс
Кредит: Үнэт металлын арилжааны орлого

Алдагдалтай үед

Дебит: Үнэт металлын арилжааны зардал
Кредит: Үнэт металлын хөрвүүлэлтийн түр данс

Санхүүгийн тайланд үнэт металлын арилжааны орлого, зардлыг хооронд нь хааж, цэвэршүүлэн, орлого эсвэл зардлаар толилуулна.

Үнэт металлын ханшийн тэгшитгэл

Үнэт металлыг Монголбанкнаас зарласан албан ханшаар үнэлж, ханшийн зөрүүг тайлант хугацааны орлого, зардлаар хүлээн зөвшөөрнө.

Ханшийн тэгшитгэлээр үнэт металлын ханш буурсан бол

Дебит: Үнэт металлын ханшийн тэгшитгэлийн зардал
Кредит: Үнэт металлын холбогдох данс

Ханшийн тэгшитгэлээр үнэт металлын ханш өссөн бол

Дебит: Үнэт металлын холбогдох данс
Кредит: Үнэт металлын ханшийн тэгшитгэлийн орлого

Санхүүгийн тайланд үнэт металлын ханшийн тэгшитгэлийн орлого, зардлыг хооронд нь хааж, цэвэршүүлэн, орлого эсвэл зардлаар толилуулна.

Е. ТОДРУУЛГА

Бусад авлага, урьчилгаа тооцоотой холбогдуулан дараах зүйлсийг тодруулна:

- Бусад авлагыг барагдуулах хугацаагаар ангилан харуулах.
- Бусад авлагын эрсдэлийн сангийн тайлант хугацааны өөрчлөлт, эрсдэлийн сангаас хаасан авлагын дүн.
- Бусад хөрөнгийг данснаас хасахад үүссэн ашиг, алдагдал.

Бараа материал, үнэ бүхий зүйл, үнэт металлтай холбогдуулан дараах зүйлсийг тодруулж болно:

- Мөнгөжүүлээгүй үнэт металлын өртөг ба бодит үнэ цэнийн үнэлгээ, ашигласан үнэлгээний арга
- Хөрөнгийн үнэ цэнийн бууралт;
- Материал үнэ бүхий зүйлсийг данснаас хасахад үүссэн олз, гарз
- Өмчлөх бусад хөрөнгийн хувьд хөрөнгийн үлдэгдэл, тайлант хугацаанд бүртгэсэн өмчлөх бусад хөрөнгийн дүн, данснаас хассан хөрөнгийн дүн, тайлант хугацаанд худалдан борлуулсан өмчлөх бусад хөрөнгийн дүн, уг арилжаанаас үүссэн олз, гарзыг гаргаж өгнө.
- СТОУС 7-ын дагуу тодруулах шаардлагатай зүйлсийг (энэ зааврын Санхүүгийн эрсдэл болон өөрийн хөрөнгийн удирдлага, бусад тодруулга бүлэгт оруулсан) бусад бүх санхүүгийн хөрөнгийн хувьд дараах байдлаар ангилан тодруулна 1) хугацаа хэтрээгүй бөгөөд үнэ цэн буураагүй; 2) хугацаа хэтэрсэн боловч үнэ цэн буураагүй; 3) үнэ цэн буурсан. Мөн бусад санхүүгийн хөрөнгийн зээлийн шинж чанарыг тодруулах ба ялангуяа хугацаа хэтрээгүй бөгөөд үнэ цэн буураагүй санхүүгийн хөрөнгийн хувьд зээлийн шинж чанарыг тодруулна. Энэ тодруулгыг банкны дотоод үнэлгээ болон хөндлөнгийн зэрэглэлд үндэслэн гүйцэтгэнэ. Хэрэв ийм зэрэглэл ашиглагддаггүй бол банк зээлийн эрсдэлийг харуулсан бусад ангилалд хөрөнгийг үлдэгдлийг ангилаж бүртгэнэ (жишээлбэл, тайлагналын өдрөөс хойш төлөгдсөн болон хойшлуулсан дүнд үндэслэнэ). Мөн банк хугацаа хэтрээгүй бөгөөд үнэ цэн буураагүй гэж ангилагдсан бусад санхүүгийн бус хөрөнгийн хувьд насжилтын судалгаа хийж, хөрөнгөнд эрсдэлийн санг ганцаарчлан байгуулна.
- Санхүүгийн тайлангийн тодруулгад багтах бусад тодруулгыг санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх аргачлал (Хавсралт 4)-д заасан. Банк иж бүрэн, үнэн зөв тодруулга бэлтгэхийн тулд энэ зааврын Хавсралт 4-аас гадна энэ зааварт багтсан санхүүгийн хэрэгслүүдэд хамаарах бусад стандарт, СТОУС 7-г дагаж мөрдөнө.

Ё. ХЯНАЛТ

- Ажилтнуудын ажил үүргийг зааглан тусгаарлана.
- Авлага, урьдчилгааг тооцоо үүссэн субъект бүрээр, материал үнэ бүхий зүйлийг нэр төрлөөр нь дэлгэрэнгүй бүртгэл хөтөлнө.
- Дэлгэрэнгүй бүртгэлийг хяналтын дансны гүйлгээ, үлдэгдэлтэй тохируулна.
- Салбар хоорондын тооцоог банкны төв, салбарын хооронд байнга нийлүүлж тохируулна.
- Санхүүгийн тайланд салбар хоорондын тооцоог цэвэршүүлж үзүүлнэ.
- Гүйлгээний баримтын бүрдлийг хангана.
- Авлага, урьдчилгааг тайлангийн үеийн эцэст холбогдох талтай тулган баталгаажуулна.
- Орлого, зарцуулалтын баримтын бүрдлийг хангана.
- Үнэт металлын дэлгэрэнгүй бүртгэл хөтлөнө.
- Үнэт металлын дэлгэрэнгүй бүртгэлийг хяналтын дансны гүйлгээ, үлдэгдэлтэй тохируулна.
- Үнэт металлыг биетээр тоолж шалгана.
- Биетээр оршин байгаа үнэт металлыг балансанд тайлагнасан үлдэгдэлтэй тохируулна.

Өмчлөх бусад хөрөнгөтэй холбогдуулан:

- Банк нь зээлийг мөнгөн хөрөнгөөр төлүүлэх чиглэл баримтална.
- Ажилтнуудын ажил, үүргийг зааглан тусгаарлана.

- Хөрөнгийн нэр, төрлөөр дэлгэрэнгүй бүртгэл хөтөлнө.
- Дэлгэрэнгүй бүртгэлийг хяналтын дансны гүйлгээ, үлдэгдэлтэй тохируулна.
- Гүйлгээний баримтын бүрдлийг хангана.
- Зээлийн төлбөрт авсан өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээг зах зээлийн үнэлгээтэй уялдуулан бодитойгоор тогтооно.

4.6. ҮНДСЭН ХӨРӨНГӨ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗОРИУЛАЛТТАЙ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ, БОРЛУУЛАХ ЗОРИУЛАЛТТАЙ ХӨРӨНГӨ

А. ШУУД ХОЛБОГДОХ СТАНДАРТУУД

- СТОУС 13 Бодит үнэ цэнийн хэмжилт
- НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- НББОУС 16 Үндсэн хөрөнгө
- НББОУС 17 Түрээс
- НББОУС 23 Зээлийн өртөг
- НББОУС 36 Хөрөнгийн үнэ цэнийн бууралт
- НББОУС 40 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө
- СТОУС 5 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагаа

Б. ТОДОРХОЙЛОЛТ

Үндсэн хөрөнгө нь бараа, ажил, үйлчилгээ үзүүлэх, бусдад түрээслүүлэх эсвэл захиргааны зориулалтаар ашиглах үүднээс банк эзэмшиж байгаа бөгөөд нэгээс дээш жилээр ашиглагдах биет хөрөнгө юм.

Элэгдэл нь хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацаанд тодорхой аргаар хуваарилж зардалд шингээсэн хуваарилалт юм.

Элэгдүүлэх дүн гэж хөрөнгийн өртгөөс үлдэх өртгийг хассан зөрүүг хэлнэ.

Ашиглалтын хугацаа нь хөрөнгийг ашиглахаар тооцоолж буй банкны тогтоосон хугацааг болон тухайн хөрөнгийг ашиглаад бий болгох бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, түүнтэй адилтгах зүйлсийн нэгжийг хэлнэ.

Хөрөнгийн өртөг гэж хөрөнгийг худалдаж авах эсвэл барьж байгуулах үеийн бодит үнэ цэн, эсвэл төлсөн мөнгө, түүнтэй адилтгах зүйлсийн дүн юм.

Үлдэх өртөг гэж хөрөнгийн ашиглалтын хугацаа дуусахад хөрөнгийг худалдаж, борлуулаад олохоор тооцоолж буй цэвэр мөнгөн орлого буюу хөрөнгийг данснаас хасахтай холбоотой аливаа зардлыг хасаад банкинд орж ирэх цэвэр дүнг хэлнэ.

Дансны үнэ гэж хуримтлагдсан элэгдэл, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр дүн юм.

Үнэ цэнийн бууралтын зардал гэж хөрөнгийн нөхөгдөх дүнгээс давсан дансны үнийг хэлнэ.

Нөхөгдөх дүн гэж хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан дүн ба ашиглалтын үнэ цэнийн аль ихийг хэлнэ.

Ашиглалтын үнэ цэн гэж тухайн хөрөнгийг ашиглалтын хугацааны эцэст зарж борлуулах, эсвэл үргэлжлүүлэн ашиглахаас үүсэх ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэн юм.

Түрээс нь түрээслүүлэгч тохиролцсон хугацаагаар хөрөнгийг ашиглах эрхийг түрээслэгчид шилжүүлээд, тодорхой төлбөр авах хэлцэл юм.

Санхүүгийн түрээс нь түрээсийн хөрөнгийн эзэмшилтэй холбоотойгоор хойшид үүсэх эрсдэл болон өгөөжийг бүгдийг түрээслэгч хүлээдэг түрээс юм. Санхүүгийн түрээсийн үед хөрөнгийг өмчлөх эрхийг эцэст нь шилжүүлдэг эсвэл шилжүүлдэггүй ч байж болно.

Гүйцэх горим гэж нягтлан бодох бүртгэлийн бодлого өөрчлөгдсөн өдрөөс хойш гарсан ажил гүйлгээ, үйл явдлыг шинэ бүртгэлийн бодлогоор бүртгэх, мөн тооцооллын өөрчлөлтийн нөлөөг гарсан тайлант хугацаа болон ирээдүйн тайлант хугацаануудад хүлээн зөвшөөрч бүртгэхийг хэлнэ.

Үндсэн хөрөнгөнд газар, газрын сайжруулалт, барилга байгууламж, түрээсийн сайжруулалт, тээврийн хэрэгсэл, тавилга, эд хогшил, компьютер, түүний дагалдах хэрэгсэл, бусад үндсэн хөрөнгийг хамруулна.

Түрээсийн хөрөнгө гэж банк өөрөө санхүүгийн түрээсээр худалдан авч, ашиглаж буй хөрөнгийг хэлнэ. Уг хөрөнгийг үндсэн хөрөнгийн нэгэн адил үнэлж, хэмжих боловч тусдаа дансанд бүртгэж тайлагнана.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө гэж хөрөнгийн үнийг өсгөх, түрээсийн орлого олох зорилгоор эзэмшиж (өмчлөгчийн эсвэл санхүүгийн түрээсээр түрээслэгчийн) буй хөрөнгийг хэлэх бөгөөд үүнд дор дурдсанаас бусад үл хөдлөх хөрөнгө багтана:

(а) бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх буюу үзүүлэх эсвэл удирдлагын зориулалтаар ашиглаж байгаа; эсвэл

(б) бизнесийн хэвийн нөхцөлд худалдан борлуулах гэж байгаа

Банк ашгийн бус зорилгоор буюу холбогдох зардлаа нөхөхийн тулд хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийг эзэмшиж болно.

Борлуулах зориулалттай хөрөнгө. Банк эргэлтийн бус хөрөнгийн дансны үнийг үргэлжлүүлэн ашиглах замаар биш борлуулах замаар нөхөж авах бол уг хөрөнгийг борлуулах зориулалттай хөрөнгө гэж ангилна. Ийм хөрөнгийг одоогийн нөхцөл байдлыг нь өөрчлөлгүйгээр ердийн нөхцлөөр худалдан борлуулах боломжтой байх ба хөрөнгийг борлуулах магадлал өндөр байх ёстой.

Банкны бүрэлдэхүүн хэсэг гэж үйл ажиллагаа, санхүүгийн тайлагналын зорилгоор банкны бусад үйл ажиллагаанаас ялган тодорхойлох боломжтой үйл ажиллагаа буюу мөнгөн гүйлгээг хэлнэ. Өөрөөр хэлбэл, банкны бүрэлдэхүүн хэсэгт ашиглахын зэрэгцээ мөнгө бий болгогч нэгжийг ойлгоно.

Зогсоосон үйл ажиллагаа гэж борлуулахаар эзэмшиж байгаа эсвэл борлуулсан банкны бүрэлдэхүүн хэсгийг хэлэх бөгөөд үүнд үйл ажиллагаа явуулж буй газар зүйн бүс, бизнесийн томоохон чиглэл, түүнийг худалдах үйл ажиллагааны хэсэг эсвэл буцааж худалдахын тулд олж эзэмшсэн охин компани багтана.

В. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

Хөрөнгө хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж, үндсэн хөрөнгийн тодорхойлолтонд нийцсэн бөгөөд худалдан борлуулах зориулалтгүй хөрөнгийг үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

Санхүүгийн түрээсийн гэрээгээр хөрөнгө түрээсэлж байгаа нөхцөлд түрээсийн хөрөнгийг хүлээн авахаар гэрээнд заасан өдөр холбогдох үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын явцад гарсан зардал нь хөрөнгийн ерөнхий чанарыг сайжруулж, анх тогтоосон бүтээмжийг дээшлүүлж, банкны ирээдүйд хүртэх өгөөжийг нэмэгдүүлж байвал ийм зардлыг үндсэн хөрөнгийн өртөгт капиталжуулж бүртгэнэ. Энэ шинжийг агуулаагүй бусад бүх засвар, үйлчилгээний урсгал зардлыг тайлант үеийн зардалд бүртгэнэ. Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах үед авсан мөнгөн дүн ба дансны үнийн зөрүүг тухайн тайлант хугацааны орлого, зардалд бүртгэнэ.

Дараах шалгуур хангагдсан үед хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Үүнд: хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой эдийн засгийн өгөөжийг банк хүртэх магадлалтай ба хөрөнгийн өртгийг найдвартай хэмжих боломжтой. Мөн тусгай шалгуурыг хангах шаардлагатай бөгөөд энэ нь үл хөдлөх хөрөнгийг захиргааны зориулалтаар (банк, түүний салбарын оффисын барилга байгууламж байдлаар ашиглагдаагүй) ашиглах бус, харин түрээслэх эсвэл үнэ цэнийг өсгөх, эсвэл аль алийг нь хүртэх зорилгоор эзэмших явдал юм. "Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө"-д бүртгэсэн хөрөнгө Нягтлан бодох бүртгэлийн багц материалын дөрөвдүгээр хавсралт "Банкны санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх аргачлал"-ын 3.7.з заалтад дурдсан тодорхойлолтын шаардлагыг хангахгүй, эсхүл шаардлагад нийцэхгүй гэж Монголбанкнаас дүгнэвэл уг хөрөнгийг өмчлөх бусад хөрөнгөнд (буцаан) бүртгэнэ.Хөрөнгийг худалдааны хэвийн нөхцлөөр одоогийн байдлаар нь худалдан борлуулах боломжтой бөгөөд хөрөнгийг худалдан авах магадлал өндөр байх үед борлуулах зориулалттай хөрөнгийг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ (ихэнхдээ эргэлтийн бус хөрөнгийн ангиллыг өөрчлөх замаар энэ ангиллын хөрөнгийг үүсгэж бүртгэдэг).

Хөрөнгийг худалдан авах магадлалыг өндөр байлгахын тулд хөрөнгийг худалдан борлуулахыг зохих түвшний удирдлага зорьсон байх ба худалдан авагчийг хайж олох идэвхтэй үйл ажиллагаа, төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байна. Мөн хөрөнгийг зах зээлд түүний тухайн үеийн бодит үнэ цэнтэй холбоотой үнээр худалдахаар идэвхтэй сурталчилна. СТОУС 5.9-д зааснаас бусад тохиолдолд хөрөнгийг энэ ангилалд бүртгэснээс хойш нэг жилийн дотор худалдан борлуулсан байх ба хөрөнгийг худалдан борлуулах үйл ажиллагааг авч хэрэгжүүлсэн байна. Хувьцаа эзэмшигчдийн зүгээс зөвшөөрөл өгсөн байх нь борлуулах магадлал өндөр байх эсэх үнэлгээний нэг хэсэг болно. Хөрөнгийг худалдах хугацааг хойшлуулж болзошгүй нөхцөл байдлыг СТОУС 5.9-д заасан. Хөрөнгийг худалдах хугацааг хойшлуулах шалтгаан нь банкны хяналтаас давсан үйл ажиллагаатай холбоотой бөгөөд хөрөнгийг худалдан борлуулах банкны төлөвлөгөө нь хэвээр байгааг нотлох хангалттай нотолгоо байгаа тохиолдолд хөрөнгийг борлуулах зориулалттай хөрөнгийн ангилалд нь үлдээнэ.

Тайлант хугацааны эцэст ангиллыг харуулах зорилгоор борлуулах зориулалттай хөрөнгөөр ангилсан эргэлтийн бус хөрөнгийг харьцуулсан санхүүгийн тайланд ангиллыг нь өөрчлөн тайлагнаж болохгүй.

Тиймээс дээрх нөхцөл хангагдаж, хөрөнгийг борлуулах зориулалттай хөрөнгийн ангилалд шилжүүлэн бүртгэх нь ховор тохиолддог. СТОУС 5-ын дагуу борлуулах зориулалттай хөрөнгийн шалгуур хангасан хөрөнгийг Санхүүгийн тайланд тусад нь (Монголбанкинд сар бүр хүргүүлэх санхүүгийн тайланд "Борлуулах зориулалттай хөрөнгө"-д оруулан) тайлагнах ба харин зогсоосон үйл ажиллагааны үр дүнг Орлогын дэлгэрэнгүй тайланд тусад нь толилуулна. Банк нь Санхүүгийн байдлын тайланд тусдаа мөрөөр харуулах, борлуулах зориулалттай хөрөнгөөр ангилах шалгуурыг биелүүлсэн хөрөнгийг эзэмшиж байж болно. Гэхдээ банк үүнийг зогсоосон үйл ажиллагаа гэж үзэхгүй байгаа бол энэ талаар Монголбанкинд мэдэгдэнэ.

Г. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

Үндсэн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь хэмжиж, бүртгэнэ.

Үндсэн хөрөнгийг худалдан авсан бол өртөг нь хөнгөлөлт, буцаалтыг хассан худалдан авалтын үнэ, гаалийн татвар, буцаан олгогдохгүй худалдааны татвар (НӨАТ) болон тухайн хөрөнгийг ашиглахад бэлэн болгож байршуулах ба ашиглахад шаардлагатай нөхцлийг хангахад шууд хамаарах зардал зэргээс бүрдэнэ.

Үндсэн хөрөнгийг банк ашиглах зорилгоор барьж байгуулсан бол хөрөнгийн өртөг нь барилгын материал, шууд холбогдох цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, талбай бэлтгэх зардал, бусад холбогдох нэмэлт зардал болон барилгын ажлыг гэрээгээр гүйцэтгэгчид төлөх төлбөр зэргээс бүрдэнэ. Энэ тохиолдолд хөрөнгийн өртгийн бүрэлдэхүүнд НББОУС 23-д заасан шалгуурыг хангасан хүүгийн зардлыг оруулах ба харин хэвийн бус хорогдол гэж үзэх зардлыг оруулахгүй.

Бэлтгэл ажиллагаа шаардагдах хөрөнгийг худалдан авах, барьж байгуулах (барилга ба биет бус хөрөнгө гэх мэт), үйлдвэрлэхэд шууд хамааралтай зээллэгийн зардлыг хөрөнгийн өртөгт шингээнэ (капиталжуулна). Зээллэгийн зардалд хөрөнгө зээлж авахтай холбоотой хүү болон бусад зардал багтана.

Зээллэгийн зардалд дараах зардлыг оруулна:

1. НББОУС 39 Санхүүгийн хэрэгсэл: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт -д тайлбарласан үр ашигт хүүгийн аргаар тооцоолсон хүүгийн зардал. Үр ашигт хүүгийн түвшинд бонд гаргах болон хөрөнгийг санхүүжүүлэх зээлийн эх үүсвэрийг татан төвлөрүүлэхтэй холбоотой зардал (үүнд бондын урамшуулал, хямдруулалтыг оруулна) багтана.
2. Санхүүгийн түрээст багтсан санхүүгийн үйлчилгээний зардал. Энэ нь газар, барилгын ажилд ашиглах тоног төхөөрөмжинд хамаатай байж болно.
3. Зээлийн эх үүсвэрийг гадаад валютаар авсан тохиолдолд хүүгийн зардалд хамаарах гадаад валютын ханшийн зөрүү.

Хувь нийлүүлсэн хөрөнгө болон хуримтлагдсан ашгаас санхүүжүүлсэн хөрөнгөтэй холбоотой зээллэгийн зардлыг капиталжуулахгүй. Гэхдээ НББОУС 32 -ын дагуу өр төлбөрөөр ангилсан давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг санхүүгийн зардал гэж үзэх тул капиталжуулж болно.

Банк бэлтгэл ажиллагаа шаардагдах хөрөнгийг олж бэлтгэхийн тулд санхүүжилтийн эх үүсвэр авсан бол уг хөрөнгөнд шууд хамаарах зээллэгийн зардлыг тогтоох боломжтой байдаг ("Хейдж" хэсэгт орсон жишээг үзнэ үү).

Жишээ (Зээллэгийн өртөг):

Банк оффисийн барилга барьж байгаа. Уг барилгын санхүүжилтийн 40%-ийг гаргахын тулд уг хөрөнгөөр баталгаажсан бондыг банк гаргасан. Энэ эх үүсвэрийг зөвхөн барилгын ажилд зарцуулна. Жилийн хүү 750 мянган төгрөг.

750 мянган төгрөгийн хүүгийн зардал нь зээллэгийн зардал болох тул барилгын өртөгт капиталжуулна.

Хүлээн зөвшөөрч, хэмжих

Хүүг капиталжуулахдаа:

Дебит: Дуусаагүй барилга эсвэл Биет бус хөрөнгө
Кредит: Хүүгийн зардал

Капиталжуулсан хүү нь хөрөнгийн өртгийн нэг хэсэг болох ба цаашид хөрөнгийн нийт өртгийн хүрээнд

элэгдүүлэлт, дахин үнэлгээг тооцно.

Бусад өр төлбөр

Зарим тохиолдолд бэлтгэл ажиллагаанд шаардлагатай хөрөнгөнд хамаарах үйл ажиллагааг гүйцэлдүүлэхийн тулд нэмэлт эх үүсвэр шаардлагатай болдог ба үүнийг бусад өр төлбөрөөс авч болно.

Бусад эх үүсвэрээс харгалзах хүүгийн түвшинг капиталжуулах хүүгийн түвшин гэх ба үүнийг зээлийн зардлын жигнэсэн дундаж байдлаар тооцоолох бөгөөд үүнд бэлтгэл ажиллагааг санхүүжүүлэх хөрөнгөнд шууд хамаарах зээл багтахгүй.

Жишээ (Бусад өр төлбөр):

Банк 100 сая төгрөгийн өртөг бүхий оффисийн барилга барьж байгаа. Үүний 60 сая төгрөгийг 8%-ийн хүүтэй урт хугацаат зээлээр санхүүжүүлсэн. Үлдсэн 40 сая төгрөгийг бусад өр, зээлээр санхүүжүүлсэн. Бусад өр, зээлийн 35%-ийнх нь өртөг 10%, 65%-ийнх нь 12%.

Эхний жилийн зээлийн зардал нь: 60 сая төгрөг * 8% = 4.8 сая төгрөг

Нийт = 9.32 сая төгрөг

Уг төслийн дундаж зээлийн түвшин = 9.32% (9.32 сая төгрөг/100 сая төгрөг)

Бусад өр төлбөрийн жигнэсэн дундаж түвшин =11.3% ((35% * 10%) +(65% * 12%))

Хандиваар авсан хөрөнгийг авсан өдрийн бодит үнэ цэнээр үнэлж, хэмжинэ.

Хэд хэдэн үндсэн хөрөнгийг багцаар худалдан авсан бол харгалзах бодит үнэ цэнээр нь өртгийг хуваарилж хэмжинэ.

Үндсэн хөрөнгийг өөр хөрөнгөөр мөнгө оролцуулан солилцох замаар олж бэлтгэж болно. Доорхоос бусад тохиолдолд үндсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмжинэ: (а) хөрөнгийг солилцох нь арилжааны бус шинжтэй эсвэл (б) авсан ба өгсөн хөрөнгийн аль алиных нь бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжгүй. Хэрэв авсан хөрөнгийн бодит үнэ цэнийг хэмжих боломжгүй бол уг хөрөнгийг өгсөн хөрөнгийн дансны үнээр бүртгэнэ.

Санхүүгийн түрээсээр хөрөнгө авсан бол түрээсэлсэн хөрөнгийн бодит үнэ цэн ба түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнийн аль багаар түрээсийн хөрөнгийг хэмжинэ. Түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнийг тооцоолоход ашиглах үр ашигт хүү нь түрээслэгчийн ашиглаж буй нуугдмал хүү байна.

Үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд толилуулахдаа анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл, үнийн цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр буюу өртгөөр үнэлж илэрхийлнэ.

Хөрөнгийн өгөөжийг банк хэрхэн хүртэхийг харгалзан үзсэний үндсэн дээр банкны удирдлагын бодлого, шийдвэрээр үндсэн хөрөнгийг ашиглах зохистой хугацааг тогтоож, элэгдэл тооцох тохиромжтой аргыг сонгоно.

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгөнд элэгдэл байгуулахгүй.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өртөг, ашиглалтын хугацаа, элэгдүүлэх арга өөрчлөгдвөл нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзээд гүйцээх горимоор бүртгэнэ.

Үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулах банкны бодлого нь татварын хуулиар тогтоосон хувь хэмжээнээс зөрүүтэй бол зөрүүг хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрөөр бүртгэж, тайлагнана. Энэ талаар орлогын албан татварын бүртгэлийн хэсэгт тайлбарласан болно.

Өртгийн аргыг (дээр дурдсанчлан) үргэлжлүүлэн ашиглаж болно. Мөн, хөрөнгийн тодорхой бүлэгт багтсан бүх хөрөнгийг дахин үнэлж байгаа тохиолдолд тухайн бүлэгт багтсан үндсэн хөрөнгийг дахин үнэлнэ.

Дахин үнэлгээний үед хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралтыг тусгасан бодит үнэ цэнийг илтгэх дүнгээр үнэлнэ. Энэ тохиолдолд тодорхой хугацааны давтамжтайгаар дахин үнэлгээг үргэлжлүүлэн хийх шаардлагатай болно. Дахин үнэлгээг хийх үйл явц нь хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс шалтгаална. Хөрөнгийн дансны үнэ ба бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү үүсч байвал зайлшгүй дахин үнэлгээг хийнэ.

Газар, барилга байгууламжийг эрх бүхий үнэлгээчнээр үнэлүүлнэ. Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн зах зээлийн үнэлгээг ихэнхдээ хөрөнгийн үнэлгээчин тодорхойлно. Хэрэв үндсэн хөрөнгийн онцлог шинж болон бизнесийн үйл ажиллагааны явцаас бусад тохиолдолд ховорхон

арилжаалагддаг гэсэн шалтгаанаар хөрөнгийн бодит үнэ цэнийн талаарх нотолгоо зах зээлээс олдохгүй тохиолдолд банк орлогын буюу орлуулах өртгийн аргаар бодит үнэ цэнийг үнэлж болно.

Үндсэн хөрөнгийг дахин үнэлэх үед дахин үнэлгээ хийж буй өдрөөрх хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн дансыг дараах аргуудын аль нэгээр бүртгэнэ:

- хөрөнгийн нийт дансны үнэтэй хувь тэнцүүлэн дахин илэрхийлэх ба ингэснээр хөрөнгийн дансны үнэ нь уг хөрөнгийг дахин үнэлсэн дүнтэй тэнцэнэ. Хөрөнгийн орлуулах өртгийг тодорхойлохын тулд индекс ашиглах замаар дахин үнэлсэн үед энэ аргыг ашигладаг.
- Хуримтлагдсан элэгдлийг тэглэж, хөрөнгийг дахин үнэлсэн дүнгээр шинээр бүртгэх. Энэ аргыг ихэвчлэн барилга байгууламжинд ашигладаг.

Хуримтлагдсан элэгдлийг тэглэж, дахин илэрхийлэх үед тохируулах дүн нь доор тайлбарласан байдлаар бүртгэсэн дансны дүнг өсгөх буюу бууруулна. Хэрэв дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ өссөн бол уг өсөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэж, дахин үнэлгээний нэмэгдэл дансанд хуримтлуулна. Харин өмнө дахин үнэлгээгээр хөрөнгийн дансны үнийг бууруулж бүртгэсэн бол ийнхүү бууруулсан хэмжээгээр дахин үнэлгээний нэмэгдлийг орлого, зардалд бүртгэнэ. Хэрэв дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ буурсан бол орлого, зардалд бүртгэнэ. Гэхдээ өмнө дахин үнэлгээгээр хөрөнгийн дансны үнийг нэмэгдүүлж бүртгэсэн бол ийнхүү нэмэгдүүлсэн хэмжээгээр дахин үнэлгээний бууралтыг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэнэ. Бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэсэн бууралт нь өөрийн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансанд хуримтлуулсан дүнг бууруулна.

Хэрэв үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн бол тухайн хөрөнгийн бүлэгт багтаж буй бүх хөрөнгийг дахин үнэлнэ. Үндсэн хөрөнгийн бүлэг гэж хөрөнгийг ижил төстэй шинж чанар, банкны үйл ажиллагаанд ашиглагдах байдлаар нь бүлэглэхийг хэлнэ. Үндсэн хөрөнгийн дараах бүлгүүд байж болно. Үүнд: газар, барилга, тавилга эд хогшил, оффисын төхөөрөмж гэх мэт. Үндсэн хөрөнгийн бүлэгт багтсан хөрөнгүүдийг нэгэн зэрэг дахин үнэлэх ба ингэснээр хөрөнгийг ганцаарчлан дахин үнэлээд, санхүүгийн тайланд янз бүрээр үнэлсэн хөрөнгүүдийг нийлбэр байдлаар тайлагнахаас зайлсхийж байгаа юм. Банк тодорхой хөрөнгүүдэд дахин үнэлгээний загварыг, бусад хөрөнгүүдэд өртгийн загварыг ашиглахаар шийдвэрлэж болно. Энэ талаар банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогод заасан байна.

Хөрөнгийн дансны үнийг тайлагналын өдрөөрх бодит үнэ цэнээс материаллаг хэмжээгээр зөрүүгүй байлгах үүднээс хөрөнгийн дахин үнэлгээг тодорхой давтамжтайгаар гүйцэтгэнэ. Хөрөнгийн дахин үнэлгээний давтамж ямар байх нь тухайн үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс шалтгаалан тогтоогдоно. Дахин үнэлсэн хөрөнгийн бодит үнэ цэн, дансны үнэ хоорондоо материаллаг зөрүүтэй байгаа нөхцөлд нэмэлт дахин үнэлгээ хийх шаардлагатай. Үндсэн хөрөнгийн зарим зүйлийн бодит үнэ цэн мэдэгдэхүйц их хэмжээгээр өөрчлөгдөж, жил бүр дахин үнэлэх шаардлага гарч болно. Бодит үнэ цэн нь харьцангуй тогтвортой байдаг үндсэн хөрөнгийн хувьд ийнхүү жил бүр дахин үнэлгээ хийгээд байх шаардлагагүй.

Банк хөрөнгийн үнэ цэн өсч, буурсны улмаас уг хөрөнгийг бодитой бус дүнгээр тайлагнахаас зайлсхийх зорилгоор хөрөнгийн үнийн өсөлт, бууралтыг тусгахуйц давтамжтайгаар дахин үнэлгээг хийнэ. Банк өөрийн барилга, байгууламжийн (эсвэл дахин үнэлгээний загварыг ашигласан бусад хөрөнгийн) бодит үнэ цэнийг үнэлж, үүнийгээ банкны бүртгэлд тусгагдсан дансны үнэтэй нь наад зах нь хагас жил тутамд харьцуулах үүрэг хүлээнэ. Энэ үнэлгээнд зах зээлийн болон бусад хэрэгцээтэй мэдээллийг ашиглана. Энэ шинжилгээний зорилго нь хөндлөнгийн хөрөнгийн үнэлгээчдийн бэлтгэсэн үнэлгээний тайланд үндэслэн барилга (дахин үнэлэх бусад хөрөнгө) -ын бодит үнэ цэн (зах зээлийн үнэлгээ) -ийг өмнө нь хүлээн зөвшөөрсөн дүнгээс материаллаг зөрүүгүй байлгах явдал юм. Зарим нэгэн барилгын хувьд мэдэгдэхүйц зөрүү илэрвэл хөндлөнгийн хөрөнгийн үнэлгээчдээр СТОУС-ын дагуу үнэлгээг хийлгэнэ. Энэ нөхцөлд банк зохих мэдлэг, туршлагатай мэргэшсэн хөрөнгийн үнэлгээчнээр үнэлгээг хийлгэнэ. Иймд дахин үнэлгээг хийх давтамж нь зах зээл дээрх бодитой өөрчлөлтөөс шалтгаална. Зах зээлийн үнэ мэдэгдэхүйц хэмжээгээр өөрчлөгдвөл хөндлөнгийн үнэлгээчдийг жил бүр ажиллуулах шаардлагатай болно. Зах зээлийн үнэ харьцангуй тогтвортой байдаг нөхцөлд 3 - 5 жил тутамд хөрөнгийн дахин үнэлгээг хийнэ.

Санхүүгийн тайлангийн өдрөөр үндсэн хөрөнгийн үнэ цэн буурсан эсэхийг тогтооно. Хэрэв үнэ цэн буурсан гэх нотолгоо байгаа бол тухайн хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцоолж, дансны үнэтэй харьцуулан, үнэ цэнийн бууралтыг тодорхойлно. Хөрөнгийн нөхөгдөх дүн гэж хөрөнгийн буюу мөнгө бий болгогч нэгжийн бодит үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан дүн ба ашиглалтын үнэ цэнийн аль ихийг хэлнэ. Нөхөгдөх дүнг тооцоолох, ялангуяа ашиглалтын үнэ цэнийг тодорхойлох дэлгэрэнгүй удирдамжийг НББОУС 36-д оруулсан. Иймээс банк хөрөнгийн дансны үнэ нөхөгдөх дүнгээс хэтэрсэн тохиолдолд үнэ цэнийн бууралтын зардлыг хүлээн зөвшөрч, бүртгэнэ

Хэрэв үнэ цэнийн бууралтын алдагдал байхгүй гэх нотолгоо байгаа бол үнэ цэнийн бууралтыг буцааж болох ба буцаалт нь хуримтлагдсан үнэ цэнийн бууралтаас хэтрэхгүй. Өөрөөр хэлбэл, хөрөнгийн үнэ цэнийн бууралтын буцаалтанд харгалзах дансны үнийн өсөлт нь хөрөнгийн үнэ цэн буураагүй үеийн дансны үнэ (элэгдэл, хорогдол хассан цэвэр дүн) -ээс хэтрэхгүй.

Үндсэн хөрөнгийг банкны салбар, нэгжүүдийн хооронд дотооддоо шилжүүлэх үед шилжүүлсэн хөрөнгийг дансны үнээр шинээр бүртгэх эсвэл анхны өртгөөр бүртгэж, хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг нь давхар бүртгэх эсэхийг банкны бүртгэлийн бодлогоор тогтоож, тууштай мөрдөнө.

Банк хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг өөрийн үйл ажиллагаандаа ашиглахгүй, харин бусдад түрээслүүлэх буюу капиталын өгөөж хүртэх зорилгоор өмчилнө.

Үл хөдлөх хөрөнгийн зарим хэсгийг (тухайлбал, барилгын тодорхой давхар) салгаж үнэлэх боломжтой тохиолдолд хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгөөр бүртгэж болно. Иймээс барилгыг хоёр хэсэгт салган бүртгэж болно: үндсэн хөрөнгө (банкны ашиглаж буй хэсэг) ба хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө (гуравдагч талд түрээслүүлсэн хэсэг). Үүнд банкны салбарын дээрх орон сууц болон арилжааны зориулалттай хөрөнгө багтана.

Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийг анхны удаад өртгөөр хэмжинэ. Түүнд шууд хамааралтай арилжааны зардлыг хөрөнгийн өртөгт оруулна. Худалдан авсан хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийн өртөгт худалдан авсан үнэ, бусад шууд холбоотой зардал багтана. Шууд холбоотой зардалд хуулийн үйлчилгээний төлбөр, хөрөнгийг шилжүүлэхэд төлөх татвар, бусад зардал хамрагдана.

Банк бодит үнэ цэнийн загвар (үндсэн хөрөнгөнд ашигладаг дахин үнэлгээний загвартай адил) ба өртгийн загварын аль нэгийг сонгож, хөрөнгө оруулалтын зориулалттай бүх хөрөнгөндөө тууштай мөрдөнө.

Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийг үндсэн хөрөнгийн нэгэн адилаар бүртгэх ба доорх хоёр зүйлээр ялгаатай:

1. Хөрөнгийн дахин үнэлгээгээр өсч, буурсан зөрүүг орлого, зардалд бүртгэнэ.

2. Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийг жил бүр дахин үнэлж байгаа тохиолдолд уг хөрөнгийг элэгдүүлэхгүй. Гэхдээ бодит үнэ цэнийг жил бүр буюу наад зах нь жил бүрийн эцсээр тодорхойлно. Ингэснээр хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийн үнэ цэнийг тайлант жилийн эцсээрх нөхцөл байдлыг харгалзан жил бүр шинэчлэнэ.

Банк өртгийн аргыг сонгосон бол СТОУС 5 “Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагаа”-ын дагуу борлуулах зориулалттай хөрөнгө гэж ангилснаас (эсвэл борлуулах зориулалттай гэж ангилсан худалдах хөрөнгийн бүлэгт багтсанаас) бусад тохиолдолд хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгөө НББОУС 16 -ын дагуу бүртгэнэ (үндсэн хөрөнгийн нэгэн адил бүртгэнэ). Борлуулах зориулалттай хөрөнгийн шалгуурыг хангасан (эсвэл борлуулах зориулалттай гэж ангилсан худалдах хөрөнгийн бүлэгт багтсан) хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийг СТОУС 5-д нийцүүлэн хэмжинэ.

Борлуулах зориулалттай хөрөнгийг дансны үнэ ба борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн аль багаар хэмжиж, тайлагнана. Өөрөөр хэлбэл борлуулах зориулалттай хөрөнгийн дансны үнэ нь борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээс бага болсон тохиолдолд эдгээрийн зөрүүгээр хөрөнгийн үнэлгээг бууруулан бүртгэнэ. Борлуулах зориулалттай хөрөнгийг тайлант жилийн төгсгөлд дахин үнэлж байх ба элэгдэл тооцохгүй. Энэ шалгуурыг хангахын тулд ийм хөрөнгө нь зах зээлд тохиромжтой үнээр идэвхтэй арилжаалагдаж, нэг жилийн дотор зарагдах магадлал өндөртэй байх ёстой.

Хөрөнгийг худалдан борлуулахтай зэрэгцэн өр төлбөрийг барагдуулж байгаа тохиолдолд (барилгыг зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн байж болох юм) уг өр төлбөрийг борлуулах өр төлбөрт бүртгэнэ.

Д. БҮРТГЭЛ

<u>1) Үндсэн хөрөнгө худалдан авах ба бэлтгэх</u>

Банк үндсэн хөрөнгийг худалдан авахад өртгөөр нь

Дебит: Үндсэн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Хэрэв үндсэн хөрөнгийн үнийг урьдчилан төлсөн ба хөрөнгөө биетээр хараахан хүлээн аваагүй бол үндсэн хөрөнгийн санхүүжилтийн дансанд бүртгэнэ.

Дебит: Үндсэн хөрөнгийн санхүүжилт
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Үндсэн хөрөнгийг биетээр хүлээн авах үед үүссэн тооцоог хааж, үндсэн хөрөнгийг орлогодоно.

Дебит: Үндсэн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Үндсэн хөрөнгийн санхүүжилт

Барилга, байгууламжийг өөрөө барьж байгуулж байгаа тохиолдолд холбогдох өртгийг Дуусаагүй барилга дансанд хуримтлуулна.

Дебит: Үндсэн хөрөнгө - Дуусаагүй барилга
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Харин барилгын ажил дуусч, мэргэжлийн байгууллагаас ашиглах зөвшөөрөл авсан бол дуусаагүй барилгаа үндсэн хөрөнгийн дансруу шилжүүлж бүртгэнэ.

Дебит: Үндсэн хөрөнгө - Барилга байгууламж
Кредит: Үндсэн хөрөнгө - Дуусаагүй барилга

Санхүүгийн түрээсийн гэрээгээр хөрөнгө авахад

Дебит: Үндсэн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Санхүүгийн түрээсийн өглөг

2) Үндсэн хөрөнгийн элэгдэл, үнэ цэнийн бууралт

Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг бүртгэхдээ

Дебит: Элэгдлийн зардал
Кредит: Хуримтлагдсан элэгдлийн данс

Үнэ цэнийн бууралтын зардлыг бүртгэхдээ

Дебит: Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын зардал
Кредит: Хуримтлагдсан элэгдлийн данс

Дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг дахин үнэлгээний нэмэгдэл дансруу хаана.

Дебит: Дахин үнэлгээний нэмэгдэл
Кредит: Хуримтлагдсан элэгдлийн данс

Хэрэв хөрөнгийн үнэ цэнийн бууралт нь дахин үнэлгээний нэмэгдлээс хэтэрсэн бол хэтэрсэн зөрүүгээр

Дебит: Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын зардал
Кредит: Хуримтлагдсан элэгдлийн данс

Жишээ: Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Банк 20Х0 оны 1-р сарын 1-нд 200 сая төгрөгөөр барилга худалдан авсан. Уг хөрөнгийн ашиглалтын хугацаа 20 жил ба элэгдлийг шулуун шугамын аргаар тооцоолдог. 20Х4 оны 12-р сарын 31-нд гадаад хүчин зүйлийн улмаас барилгын үнэ цэн буурсан гэж үзсэн. Банкны хийсэн тооцооллоор энэ үед уг барилгын худалдах үнэ 100 сая төгрөг ба хөрөнгийг худалдсан тохиолдолд 5 сая төгрөгийн зардал гарах боломжтой. Мөн уг барилгыг үргэлжлүүлэн ашиглавал ирээдүйд орох мөнгөн гүйлгээ нь 120 сая төгрөг болохыг үнэлсэн.

Үнэ цэнийн бууралтыг тодорхойлохдоо эхлээд хөрөнгийнхөө дансны үнийг тогтооно. Хөрөнгийн анхны өртөг 200 сая, ба 5 жил ашигласан байна. Хуримтлагдсан элэгдэл нь 50 сая төгрөг болж байна (200/20*5). Дансны үнэ нь 200 саяас 50 саяыг хасаад 150 сая болж байна.

Дараа нь нөхөгдөх дүнг тооцоолно. Бодит үнэ цэнээс зардлыг хассан цэвэр дүн нь 95 сая (100сая - 5сая). Ашиглалтын үнэ цэн нь 120 сая. Нөхөгдөх дүн нь эдгээрийн их нь буюу 120 сая болж байна.

Энэ тохиолдолд 30 сая төгрөгийн үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрнө (150сая - 120сая). Журналын бичилт нь:

Дебит: Барилгын үнэ цэнийн бууралтын зардал	30 сая
Кредит: Барилгын хуримтлагдсан элэгдэл	30 сая

Жишээ: Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын буцаалт

Дээрх жишээний хувьд хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг хэрхэн буцаах талаар авч үзье. 20Х5 оны 12-р сард барилгын ойр орчмын дэд бүтцийн асуудлыг Засгийн газраас шийдсэнээр хөрөнгийн нөхөгдөх дүн 142 сая төгрөг болж өссөн. 20Х5 оны элэгдлийн зардал 10 сая төгрөг байсан гэвэл дансны үнэ нь 110 сая төгрөг болно (120сая - 10сая).

Энэ тохиолдолд хөрөнгийн дансны үнийг 32 саяар нэмэгдүүлж өсгөх болж байна. Үүнээс 30 сая буюу өмнө нь үнэ цэнийн бууралтын гарзаар хүлээн зөвшөөрсөн дүнгээр ашиг бүртгэх ба зөрүүг нь хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлд хүлээн зөвшөөрнө.

Дебит: Барилгын хуримтлагдсан үнэ цэнийн бууралт	30 сая
Дебит: Барилга	2 сая
Кредит: Барилгын үнэ цэнийн бууралтын орлого	30 сая
Кредит: Дахин үнэлгээний нэмэгдэл	2 сая

3) Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ

Дахин үнэлсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн дансыг дор дурьдсан хоёр аргын аль нэгээр бүртгэнэ:

i. Хуримтлагдсан элэгдлийг хөрөнгийн дансны үнийн өөрчлөлттэй хувь тэнцүүлэн дахин тооцох
ii. Хуримтлагдсан элэгдлийг тэглэж, хөрөнгийг шинээр бүртгэх

Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ нэмэгдсэн нөхцөлд дахин үнэлгээний нэмэгдлээр бүртгэнэ.

i. Хуримтлагдсан элэгдлийг хөрөнгийн дансны үнийн өөрчлөлттэй хувь тэнцүүлэн дахин тооцохоор сонгосон бол үндсэн хөрөнгө болон хуримтлагдсан элэгдлийг үндсэн хөрөнгийн өсөлтөөр хувь тэнцүүлэн өсгөнө

Дебит: Холбогдох үндсэн хөрөнгө
Кредит: Холбогдох хуримтлагдсан элэгдэл
Кредит: Дахин үнэлгээний нэмэгдэл

ii. Хуримтлагдсан элэгдлийг тэглэж, хөрөнгийг шинээр бүртгэхээр сонгосон бол эхлээд хуримтлагдсан элэгдлийн дансаа хаана

Дебит: Холбогдох хуримтлагдсан элэгдэл
Кредит: Холбогдох үндсэн хөрөнгө

Дараа нь үндсэн хөрөнгийн өсөлтийг бүртгэнэ

Дебит: Холбогдох үндсэн хөрөнгө
Кредит: Дахин үнэлгээний нэмэгдэл

Дахин үнэлсэн хөрөнгийг давтан дахин үнэлээд үнэ цэн буурсан бол уг дахин үнэлгээний нэмэгдлийг бууруулах ба нэмэгдлээс хэтэрсэн дүнг хөрөнгийн үнэ цэнийн бууралтын зардалд бүртгэнэ.

Дебит: Дахин үнэлгээний нэмэгдэл
Дебит: Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын зардал /хэтэрсэн дүнгээр/
Кредит: Холбогдох үндсэн хөрөнгө

Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ буурсан бол бууралтыг үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын зардалд бүртгэнэ.

i. Хуримтлагдсан элэгдлийг хөрөнгийн дансны үнийн өөрчлөлттэй хувь тэнцүүлэн дахин тооцохоор сонгосон бол

Дебит: Холбогдох хуримтлагдсан элэгдэл
Дебит: Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын зардал
Кредит: Холбогдох үндсэн хөрөнгө

ii. Хуримтлагдсан элэгдлийг тэглэж, хөрөнгийг шинээр бүртгэхээр сонгосон бол эхлээд хуримтлагдсан элэгдлийн дансаа хаана

Дебит: Холбогдох хуримтлагдсан элэгдэл
Кредит: Холбогдох үндсэн хөрөнгө

Дараа нь үндсэн хөрөнгийн бууралтыг бүртгэнэ

Дебит: Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын зардал
Кредит: Холбогдох үндсэн хөрөнгө

Дахин үнэлсэн хөрөнгөө дараа давтан дахин үнэлэх үед үнэлгээ нь өсвөл өмнө хүлээн зөвшөөрсөн зардалтай тэнцэхүйц орлого хүлээн зөвшөөрөөд илүү гарч буй дүнгээр хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг хүлээн зөвшөөрнө.

Дебит: Холбогдох үндсэн хөрөнгө
Кредит: Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын орлого
Кредит: Дахин үнэлгээний нэмэгдэл /хүлээн зөвшөөрсөн зардлаас хэтэрсэн зөрүүгээр/

4) Үндсэн хөрөнгийг данснаас хасах, шилжүүлэх

Хэрэв хөрөнгийг ашиглалтаас хасч, борлуулсан буюу хөрөнгөөс эдийн засгийн өгөөж хүртэхгүй болсон нөхцөлд үндсэн хөрөнгийг данснаас хасна.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа дууссанаар акталж данснаас хасах үед үндсэн хөрөнгийн дансыг хуримтлагдсан элэгдэл дансанд нь хаана.

Дебит: Холбогдох хуримтлагдсан элэгдэл
Кредит: Холбогдох үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг ашиглалтын хугацаа дуусахаас өмнө акталж данснаас хассан бол ашиглалтаас хасч буй хөрөнгийн дансны үнээр гарз бүртгэнэ.

Дебит: Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз
Кредит: Холбогдох үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг худалдаж борлуулсан бол хүлээн авсан төлбөрийн цэвэр дүн ба хөрөнгийн дансны үнийн хоорондох зөрүүг олз, гарзаар бүртгэнэ.

Дебит: Мөнгөн хөрөнгө болон тооцооны холбогдох данс /авсан цэвэр дүнгээр/
Дебит эсвэл Кредит: Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз эсвэл олз /зөрүүгээр/
Кредит: Холбогдох үндсэн хөрөнгө /дансны үнээр/

Үндсэн хөрөнгийг банкны салбар, нэгжүүдийн хооронд дотооддоо шилжүүлэх үед үндсэн хөрөнгийг авч байгаа нэгж нь:

Дебит: Холбогдох үндсэн хөрөнгө
Кредит: Салбар хоорондын тооцоо

Үндсэн хөрөнгийг өгсөн нэгж нь:

Дебит: Салбар хоорондын тооцоо
Кредит: Холбогдох үндсэн хөрөнгө

5) Үндсэн хөрөнгийн засвар, үйлчилгээ

Үндсэн хөрөнгийн засвар, үйлчилгээний зардлыг капиталжуулсан бол

Дебит: Үндсэн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Мөнгөн хөрөнгө ба тооцооны холбогдох данс

Үндсэн хөрөнгийн засвар, үйлчилгээний зардлыг тайлант үеийн зардлаар бүртгэсэн бол

Дебит: Засвар, үйлчилгээний урсгал зардал
Кредит: Мөнгөн хөрөнгө ба тооцооны холбогдох данс

6) Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

Үндсэн хөрөнгийг хөрөнгө оруулалтын зориулалттай барилга эсвэл барилгын хэсэг гэсэн хөрөнгөнд шилжүүлэн эсвэл ангиллыг өөрчлөн бүртгэсэн бол өртгийн загварыг ашигладаг тохиолдолд

Дебит: Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө - өртгөөр
Кредит: Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл
Дебит: Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл
Кредит: Үндсэн хөрөнгийн анхны өртөг

Үндсэн хөрөнгийг хөрөнгө оруулалтын зориулалттай барилга эсвэл барилгын хэсэг гэсэн хөрөнгөнд шилжүүлэн эсвэл ангиллыг өөрчлөн бүртгэсэн бол дахин үнэлгээний загварыг ашигласан тохиолдолд

Дебит: Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө
Дебит: Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл
Кредит: Үндсэн хөрөнгийн анхны өртөг

Кредит: Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл

Өмчлөгчдийн эзэмшилд буй хөрөнгийг бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө болгосон тул дээрх жишээнд өөрийн хөрөнгийн данс ашигласан бөгөөд банк уг хөрөнгийн ангиллыг өөрчлөх хүртэл НББОУС 16-д нийцүүлэн бүртгэнэ. Банк НББОУС 16-ийн дагуу тооцоолсон дансны үнэ ба бодит үнэ цэнийн зөрүүг НББОУС 16-д заасан дахин үнэлгээний нэгэн адил бүртгэнэ. Өөрөөр хэлбэл:

- Дансны үнэд гарсан өсөлтийг дараах байдлаар бүртгэнэ:
  - Үнийн өсөлт нь тухайн хөрөнгийн өмнөх үнэ цэнийн бууралтын зардлыг буцаах бол уг өсөлтийг орлого, зардалд бүртгэнэ. Харин орлого, зардалд бүртгэх дүн нь хөрөнгийн үнэ цэн буураагүй үеийн дансны үнэ (элэгдэл хассан цэвэр дүн) -ийг сэргээх хүртэлх өсөлтийн дүнгээс хэтрэх ёсгүй.
  - Үнийн өсөлтийн үлдсэн хэсгийг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэж, өөрийн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансыг өсгөнө. Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийг худалдан борлуулсны дараа өөрийн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг хуримтлагдсан ашиг дансанд хаана. Дахин үнэлгээний нэмэгдлийг хуримтлагдсан ашигт хаах үед ямар нэгэн орлого, зардал бүртгэхгүй.
- Хөрөнгийн дансны үнийн бууралтыг зардалд бүртгэнэ. Гэхдээ уг хөрөнгөтэй холбогдуулан дахин үнэлгээний нэмэгдэл өмнө нь бүртгэсэн бол хөрөнгийн үнийн бууралтыг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэж, өөрийн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг бууруулна.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлсэн бол

Дебит: Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө
Кредит: Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл (олз)

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулсан бол

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

<u>7) Борлуулах зориулалттай хөрөнгө</u>

Хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулах зардлыг хассан дүн нь дансны үнээс өндөр гарсан нөхцөлд өмчлөх бусад хөрөнгийг (барилга, байгууламж) борлуулах зориулалттай хөрөнгийн ангилалд шилжүүлж бүртгэсэн бол борлуулах зориулалттай хөрөнгийн дансны үнээр бүртгэнэ:

Дебит: Борлуулах зориулалттай хөрөнгө
Кредит: Өмчлөх бусад хөрөнгө (Бусад санхүүгийн бус хөрөнгө)

Хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулах зардлыг хассан дүн нь дансны үнээс бага гарсан нөхцөлд өмчлөх бусад хөрөнгийг (барилга, байгууламж) борлуулах зориулалттай хөрөнгийн ангилалд шилжүүлж бүртгэсэн бол борлуулах зориулалттай хөрөнгийг бодит үнэ цэнээс борлуулах зардлыг хассан дүнгээр бүртгэнэ:

Дебит: Борлуулах зориулалттай хөрөнгө
Дебит: Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сан
Кредит: Өмчлөх бусад хөрөнгө (Бусад санхүүгийн бус хөрөнгө)

Үндэн хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулах зардлыг хассан дүн нь дансны үнээс өндөр гарсан нөхцөлд тухайн үндсэн хөрөнгийн дансны үнээр бүртгэнэ:

Дебит: Борлуулах зориулалттай хөрөнгө
Дебит: Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралт
Кредит: Үндсэн хөрөнгө

Хэрэв борлуулах зориулалттай хөрөнгийн үнэ цэн буурсан бол үнэлгээг бууруулах дүнгээр

Дебит: Хөрөнгийн үнэ цэнийн бууралтын зардал
Кредит: Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт

Бараа материал, үндсэн хөрөнгийг борлуулах зориулалттай хөрөнгийн ангилалд шилжүүлж бүртгэх нь өмчлөх бусад хөрөнгийг энэ ангилалд шилжүүлж бүртгэхтэй нэгэн адил байна. Өөрөөр хэлбэл, ангилал өөрчилж буй хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулах зардлыг хассан дүнг тодорхойлж, дараа нь үүнийгээ уг хөрөнгийн дансны үнэтэй харьцуулан дансны үнийг бууруулж бүртгэх эсэхээ тогтооно.

Е. ТОДРУУЛГА

Тайлант хугацааны элэгдлийн зардлын дүн, ашигласан элэгдлийн арга, элэгдүүлэх хувь хэмжээг үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийн ангилал бүрээр тодруулна.

Хэрэв үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралттай холбоотой хөдөлгөөн гарсан бол хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын зардал эсвэл буцаалт, холбогдох тооцоолол, үнэлгээг тодруулна.

Хэрэв үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн бол үнэлгээ хийгдсэн өдөр, дахин үнэлгээний нэмэгдэл дансанд гарсан өсөлт, бууралт, ашигласан үнэлгээний аргачлал, эсвэл хөрөнгийн үнэлгээчдээр үнэлүүлсэн эсэх талаар тус тус тодруулна.

Санхүүгийн түрээсээр авсан хөрөнгө, холбогдох санхүүгийн түрээсийн өглөг болон барьцаанд байгаа үндсэн хөрөнгийн талаар тодруулна.

Бүтээн босгох ажлын үе шатанд байгаа буюу үндсэн хөрөнгийн өртөгт хүлээн зөвшөөрсөн зардлын дүнг тодруулна.

Үндсэн хөрөнгийн санхүүжилтээр бүртгэсэн, хараахан хүлээн аваагүй үндсэн хөрөнгийн худалдан авалтын тухай тодруулна.

Үндсэн хөрөнгийг данснаас хасахад үүссэн олз ба гарзыг тодруулна.

Борлуулах зориулалттай хөрөнгө гэж ангилсан эргэлтийн бус хөрөнгө болон борлуулсан хөрөнгийн тодруулгад тайлант хугацаанд хамааралтай дараах мэдээлэл багтана. Үүнд:

- Тухайн эргэлтийн бус хөрөнгийн тайлбар;
- Хөрөнгийг худалдах, эсвэл данснаас хасахтай холбоотой нөхцөл байдал, баримт мэдээ болон холбогдох арга зам, цаг хугацаа;
- Хөрөнгийн өртгийг бодит үнэ цэнээс борлуулах зардлыг хассан дүн болтол бууруулахад бүртгэсэн зардал, эсвэл хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулах зардлыг хассан дүн өсөхөд хүлээн зөвшөөрч, бүртгэсэн орлого болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусад нь харуулаагүй орлого, зардлын дүн;
- Эргэлтийн бус хөрөнгийг худалдах төлөвлөгөөг өөрчилсөн бол холбогдох тайлант хугацаанд багтаан уг шийдвэрийг гаргах болсон учир шалтгаан, нөхцөл байдал, энэ шийдвэрийн тайлант хугацааны болон өмнөх хугацаанд толилуулсан үйл ажиллагаанд үзүүлэх үр нөлөө.

Санхүүгийн тайлангийн тодруулгад багтах бусад тодруулгыг санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх аргачлал (Хавсралт 4)-д заасан.

Ё. ХЯНАЛТ

- Ажилтнуудын ажил, үүргийг зааглан тусгаарлана.
- Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангийн үлдэгдэлтэй нийлж тохируулна.
- Үндсэн хөрөнгө бүрт хувийн дугаар өгч, картын бүртгэл хөтөлнө.
- Үндсэн хөрөнгийг жилд нэгээс доошгүй удаа тоолж, дансны үлдэгдэлтэй тулгаж шалгана.

4.7. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

А. ШУУД ХОЛБОГДОХ СТАНДАРТУУД

- СТОУС 13 Бодит үнэ цэнийн хэмжилт
- НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- НББОУС 36 Хөрөнгийн үнэ цэнийн бууралт
- НББОУС 38 Биет бус хөрөнгө

Б. ТОДОРХОЙЛОЛТ

Биет бус хөрөнгө гэдэг нь биет шинж чанаргүй, тодорхойлж болохуйц мөнгөн бус хөрөнгө юм.

Хорогдол гэдэг нь биет бус хөрөнгийн хорогдуулах дүнг түүний ашиглалтын хугацаанд системтэй хуваарилж, зардалд шингээсэн хуваарилалт юм.

Хорогдуулах дүн гэдэг нь биет бус хөрөнгийн анхны өртгөөс үлдэх өртгийг хассан дүнг хэлнэ.

Биет бус хөрөнгөнд материаллаг дүнтэй төрөл бүрийн программ хангамж, патент, худалдааны тэмдэг, гүүдвил зэрэг хамрагдана.

В. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

Биет бус хөрөнгө нь доорх шалгуурыг хангаж байвал хүлээн зөвшөөрнө:

- Тодорхойлогдохуйц байх. Биет бус хөрөнгө доорх нөхцөлүүдээс хангаж байвал тодорхойлогдохуйц байна гэж үзнэ:
    - Тусад нь авч үзэх боломжтой буюу бусдад түрээсэлж, борлуулж, шилжүүлж, арилжаалж болдог байх.
    - Гэрээ, эсвэл бусад хууль эрхийн актын улмаас үүссэн байх.
- Хянагдах боломжтой байх: Банк хөрөнгөнд хяналт тавих чадвартай байх нь чухал. Хөрөнгөөс ирээдүйн үр өгөөж олох боломжтой ба тэр үр өгөөжийг зөвхөн өөрөө хүртэх боломжтой байх үед хяналт тогтсон гэж үзнэ.
- Ирээдүйд эдийн засгийн өгөөж авчрах.
- Өртгийг нь найдвартай хэмжих боломжтой байх.

Дотооддоо бий болгосон биет бус хөрөнгө нь хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж байгаа эсэхийг үнэлэхийн тулд банк хөрөнгийг бий болгох үе шатыг дараах байдлаар ангилна:

- судалгааны үе шат
- хөгжүүлэлтийн үе шат

Судалгаа, хөгжүүлэлтийн зардлыг хүлээн зөвшөөрөх:

- Судалгааны зардлыг гарсан тухай бүрт нь зардлаар хүлээн зөвшөөрнө.
- Хэрэв биет бус хөрөнгийг бий болгох судалгааны үе шатыг хөгжүүлэлтийн үе шатаас ялгаж чадахгүй байгаа бол зарцуулсан зардлыг зөвхөн судалгааны үе шатанд гарсан гэж үзээд зардлаар хүлээн зөвшөөрнө.
- Биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаагүй хөгжүүлэлтийн зардлыг гарсан тухай бүрт зардлаар хүлээн зөвшөөрнө.
- Биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангасан хөгжүүлэлтийн зардлыг гарсан тухай бүрт биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө.

Г. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

Биет бус хөрөнгийг анх удаад нь өртгөөр хүлээн зөвшөөрнө.

Худалдаж авсан биет бус хөрөнгийн өртөг нь хөнгөлөлт ба хямдруулалтыг хасч, импортын болон буцаагдахгүй худалдааны татварыг оруулж тооцсон худалдан авалтын үнэ ба хөрөнгийг тухайн зориулалтаар нь ашиглахад бэлэн болгохтой холбоотой шууд нэмэлт зардлуудын нийлбэрээр тодорхойлогдоно.

Бизнесийн нэгдлийн үр дүнд биет бус хөрөнгө худалдан авсан нөхцөлд биет бус хөрөнгийн өртгийг түүний худалдан авалтын өдрийн бодит үнэ цэнээр илэрхийлнэ.

Хандиваар, эсвэл хөрөнгийн солилцоогоор авсан биет бус хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмжинэ.

Дотооддоо бий болгосон биет бус хөрөнгийн хувьд хөгжүүлэлтийн үе шатанд хамаарах зардлын дүнгээр биет бус хөрөнгийг хэмжинэ.

Компьютерын программ хангамжийг:

- Худалдаж авсан бол өртгөөр нь үнэлнэ.
- Хэрэв техник хангамжийн үйл ажиллагааны системийг худалдан авсан бол түүнийг техник хангамжийн өртөгт шингээнэ.
- Хэрэв компьютерын программ хангамжийг дотооддоо бий болгосон бол түүний хөгжүүлэлтийн үе шатанд гарсан зардлаар бүртгэнэ.

Биет бус хөрөнгийн хорогдол:

- Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа тодорхой бол ашиглалтын хугацаанд хорогдуулна. Биет бус хөрөнгийг тохиромжтой аргаар хорогдуулна. Хэрэв тохиромжтой арга тодорхойлогдохгүй бол шулуун шугамын аргаар хорогдуулна.
- Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа тодорхойгүй бол хорогдуулахгүй, үнэ цэнийн бууралтыг үнэлж бүртгэнэ. НББОУС 36-ын дагуу үнэ цэн буурсан гэх шинж тэмдэг байгаа эсэхээс үл хамааран ашиглалтын хугацаа тодорхойгүй биет бус хөрөнгийн дансны үнийг нөхөгдөх дүнтэй нь харьцуулах замаар үнэ цэнийн бууралтыг жил бүр шалгана.

Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа:

- Гэрээ болон бусад хууль эрх зүйн заалтын дагуу бий болсон биет бус хөрөнгийн ашиглагдах хугацаа нь тухайн гэрээнд заасан хугацаанаас хэтрэх ёсгүй.
- Хэрэв эрх нь шинэчлэгдэж болохоор хязгаартай хугацаатайгаар өгөгдсөн бол зөвхөн үлэмж хэмжээний зардал гаргахгүйгээр шинэчлэлтийг батлах нотолгоо байгаа үед хөрөнгийн ашиглагдах хугацааг шинэчилж тогтооно.

Хэрэв банк холбогдох хүчин зүйлсэд хийсэн шинжилгээнд үндэслэн биет бус хөрөнгийг ашигласнаар бий болох нийт цэвэр мөнгөн гүйлгээний хугацааг урьдчилан тооцох боломжгүй байна гэж үзвэл тухайн биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа тодорхойгүй байна гэж үзнэ.

Биет бус хөрөнгөнд элэгдэл, хорогдол тооцоогүй үед ашиглалтын хугацааг тайлант жилийн төгсгөлд хянаж, тухайн хөрөнгийн тодорхойгүй ашиглагдах хугацааг хэвээр үлдээх шалтгаан байгаа эсэхийг тогтооно. Ийм шалтгаан байхгүй бол тодорхойгүй ашиглалтын хугацааг тодорхой хугацаагаар сольж, өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзээд, бүртгэлд тусгана.

Банк ашиглалтын хугацаа нь тодорхойгүй биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг түүний нөхөгдөх дүнг дансны үнэтэй харьцуулах замаар жил бүр болон тухайн биет бус хөрөнгийн үнэ цэн буурсан гэх ямар нэгэн шинж тэмдэг мэдэгдэх тухай бүрт үнэлнэ. Биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг үнэлэхдээ:

- Дансны үнийг тооцоолно.
- Нөхөгдөх дүнг тодорхойлно. Нөхөгдөх дүнг уг хөрөнгийн ашиглалтын үнэ цэн (хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэн) ба борлуулалтын цэвэр үнэ (бодит үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан цэвэр дүн)-ийн аль ихээр тодорхойлно.
- Дансны үнэ ба нөхөгдөх дүнгийн аль багаар үнэлнэ. Хэрэв нөхөгдөх дүн нь дансны үнээс бага бол эдгээрийн зөрүүгээр үнэ цэнийн бууралт хүлээн зөвшөөрнө. Ийнхүү хүлээн зөвшөөрсний дараах тайлант хугацаанд хүлээн зөвшөөрч бүртгэсэн үнэ цэнийн бууралт байхгүй болсон гэж үзвэл үүнийг буцаана.

Шаардлагатай гэж үзвэл биет бус хөрөнгийг дахин үнэлж болох ба бүртгэл нь дээр дурдсан үндсэн хөрөнгийн дахин үнэлгээтэй ижил хийгдэнэ. Бодит үнэ цэнийг дараах нөхцөлийг бүгдийг хангасан идэвхтэй зах зээлээс тодорхойлно. Үүнд: зах зээлд нэг төрлийн зүйлсийг арилжаалдаг, арилжаанд оролцоход бэлэн худалдан авагч ба борлуулагч байнга байдаг, худалдах үнийг олон нийт нээлттэй олж авах боломжтой. Тайлант хугацааны эцэст хөрөнгийн дансны дүн, бодит үнэ цэн хоорондоо материаллаг зөрүүтэй байх үед дахин үнэлгээг хийнэ. Биет бус хөрөнгийн идэвхтэй зах зээл ховор тул биет бус хөрөнгийг дахин үнэлэх нь маш ховор.

Д. БҮРТГЭЛ

Биет бус хөрөнгийг худалдан авахад

Дебит: Холбогдох биет бус хөрөнгө
Кредит: Мөнгөн хөрөнгө ба тооцооны холбогдох данс

Биет бус хөрөнгийн хорогдлын зардлыг хүлээн зөвшөөрч хуримтлуулахад

Дебит: Биет бус хөрөнгийн хорогдлын зардал
Кредит: Биет бус хөрөнгийн хуримтлагдсан хорогдол

Биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг бүртгэхэд

Дебит: Биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтын зардал
Кредит: Биет бус хөрөнгийн хуримтлагдсан хорогдол

Биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтын буцаалтыг бүртгэхэд

Дебит: Биет бус хөрөнгийн хуримтлагдсан хорогдол
Кредит: Бусад орлого - Биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтын орлого

Биет бус хөрөнгийг данснаас хасахад

Дебит: Холбогдох хуримтлагдсан хорогдол
Кредит: Холбогдох биет бус хөрөнгө

Хэрэв биет бус хөрөнгийг данснаас хасах үед ашиглалтын хугацаа дуусаагүй бөгөөд хорогдуулах өртгийг хараахан бүрэн нөхөөгүй бол хорогдуулаагүй үлдсэн өртгийн дүнг гарзаар бүртгэнэ.

Дебит: Биет бус хөрөнгө данснаас хассаны гарз
Кредит: Холбогдох биет бус хөрөнгө

Хэрэв биет бус хөрөнгийг бусдад худалдан борлуулж данснаас хассан бол хөрөнгийн дансны үнэ ба орсон мөнгө хоёрын зөрүүгээр олз, гарз үүснэ.

Биет бус хөрөнгийг олзтой борлуулсан бол

Дебит: Мөнгөн хөрөнгө болон тооцооны холбогдох данс /хүлээн авсан цэвэр дүнгээр/
Кредит: Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /зөрүүгээр/
Кредит: Холбогдох биет бус хөрөнгө /дансны үнээр/

Биет бус хөрөнгийг гарзтай борлуулсан бол

Дебит: Мөнгөн хөрөнгө болон тооцооны холбогдох данс /хүлээн авсан цэвэр дүнгээр/
Дебит: Биет бус хөрөнгө данснаас хассаны гарз /зөрүүгээр/
Кредит: Холбогдох биет бус хөрөнгө /дансны үнээр/

Е. ТОДРУУЛГА

Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа тодорхой бол ашиглалтын хугацаа, хорогдол тооцоолсон арга зэргийг тодруулна.

Хэрэв биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралттай холбоотой хөдөлгөөн гарсан бол хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдал эсвэл буцаалт, холбогдох тооцоолол, үнэлгээг тодруулна.

Хэрэв биет бус хөрөнгийг дахин үнэлсэн бол үнэлгээ хийгдсэн өдөр, дахин үнэлгээний нөөц дансанд гарсан өсөлт, бууралт, үнэлгээний ямар аргачлалыг ашигласан, эсвэл хөрөнгийн үнэлгээчдээр үнэлүүлсэн эсэх талаар тус тус тодруулна.

Бүтээн босгох ажлын үе шатанд байгаа биет бус хөрөнгийн өртөгт хүлээн зөвшөөрсөн зардлын дүнг тодруулна.

Үндсэн хөрөнгийн санхүүжилтэнд бүртгэсэн, хараахан хүлээн аваагүй биет бус хөрөнгийн худалдан авалтын тухай тодруулна.

Санхүүгийн тайлангийн тодруулгад багтах бусад тодруулгыг санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх аргачлал (Хавсралт 4)-д заасан.

Ё. ХЯНАЛТ

- Ажилтнуудын ажил, үүргийг зааглан тусгаарлана.
- Биет бус хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангийн үлдэгдэлтэй нийлж тохируулна.

ТАВ. ӨР ТӨЛБӨР

А. ТОДОРХОЙЛОЛТ

Өнгөрсөн үйл ажиллагааны үр дүнд бий болсон, эдийн засгийн өгөөжийг өөртөө агуулж буй нөөцийн гадагшлах урсгалаар төлөгдөхөөр хүлээгдэж буй банкны бусдын өмнө хүлээх үүрэг хариуцлагыг өр төлбөр гэнэ.

Б. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

Хүлээсэн үүргээ биелүүлснээр эдийн засгийн өгөөжтэй нөөц хөрөнгийн гадагшлах урсгал бий болох магадлалтай бөгөөд дүнг нь бодитой хэмжих боломжтой тохиолдолд өр төлбөрийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, толилуулна.

В. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

Санхүүгийн тайланг толилуулахдаа түүхэн өртөг, тайлант үеийн өртөг, цэвэр боломжит үнэ цэн, өнөөгийн үнэ цэн, бодит үнэ цэн гэх мэт хэмжилтийн суурьуудыг ашигладаг.

Г. АНГИЛАЛ

Санхүүгийн тайланд өр төлбөрийг дараах байдлаар ангилж, толилуулна:

1. Харилцагчийн харилцах, хадгаламж
2. Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр
3. Бусад эх үүсвэр (хоёрдогч өглөгийг оруулсан)
4. Бусад санхүүгийн ба санхүүгийн бус өр төлбөр

Давуу эрхийн хувьцаа өр төлбөрийг тодорхойлолтыг хангаж, өөрийн хөрөнгө болохгүй байж болно. Энэ тохиолдолд үүнийг Санхүүгийн тайланд өр төлбөрөөр тайлагнана. Деривативын бодит үнэ цэн сөрөг гарсан тохиолдолд уг деривативыг өр төлбөр гэж үзээд, дериватив санхүүгийн өр төлбөрөөр тайлагнана.

Д. ТОДРУУЛГА

Өр төлбөрийн ангилал бүрээр нягтлан бодох бүртгэлийн ерөнхий ба тусгай бодлогыг тодруулна.

Мөн санхүүгийн тайланд толилуулаагүй боловч СТОУС-ын дагуу тодруулах шаардлагатай эсвэл санхүүгийн тайланд толилуулсан хэдий ч дэлгэрүүлж тайлбарлах мэдээллийг тодруулна.

5.1. ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ

А. ШУУД ХОЛБОГДОХ СТАНДАРТУУД

- СТОУС 7 Санхүүгийн хэрэгсэл: Тодруулга
- СТОУС 9 Санхүүгийн хэрэгсэл
- НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- НББОУС 32 Санхүүгийн хэрэгсэл: Толилуулга
- НББОУС 39 Санхүүгийн хэрэгсэл: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Б. ТОДОРХОЙЛОЛТ

Харилцагчдын харилцах, хадгаламж нь аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс (цаашид харилцагч гэх) харилцах, хадгаламжийн хэлбэрээр татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Харилцагчдын харилцах нь ямар нэгэн хязгаарлалтгүй эх үүсвэр бөгөөд үүнийг харилцагчийн өдөр тутмын төлбөр тооцоонд ашиглана. Харилцагчдын харилцах дансанд хүү хуримтлуулан тооцоолж болно.

Харилцагчдын хадгаламж нь хүү болон бусад нөхцөлтэй гэрээгээр байршуулсан эх үүсвэр бөгөөд үүнийг харилцагчийн өдөр тутмын төлбөр тооцоонд ашиглахгүй. Банк хадгаламжийн дансанд гэрээний нөхцөлд заасан хүү төлнө. Хадгаламжийн дансанд хугацаагүй хадгаламж, хугацаатай хадгаламж болон бусад төрлийн хадгаламж хамрагдана.

В. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

Харилцах ба хадгаламжийн гэрээ, хэлцлийн дагуу харилцагч эх үүсвэрийг байршуулж, санхүүгийн хөрөнгийг буцааж өгөх үүргийг банк хүлээсэн үед харилцах, хадгаламжийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, толилуулна.

Г. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

Харилцах, хадгаламжийг анх удаа хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр үнэлнэ. Бодит үнэ цэн нь гэрээний дагуу байршуулсан эх үүсвэрийн дүнтэй тэнцүү байна.

Санхүүгийн тайланд харилцах, хадгаламжийг хорогдуулсан өртгөөр үнэлж, тайлагнана. Харилцах, хадгаламжийн хорогдуулсан өртөг нь анх хүлээн зөвшөөрч хэмжсэн дүн (бодит үнэ цэн)-ээс тайлант хугацаанд нэмэгдсэн харилцах, хадгаламжийн орлого, харилцах, хадгаламжийн үлдэгдэлд тооцсон хүүгийн өглөгийг нэмж, тайлант хугацаанд хийгдсэн зарлагын гүйлгээ, холбогдох шимтгэлийг хасч тодорхойлогдоно.

Гадаад валютаар бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг Монголбанкнаас зарласан албан ханшаар тооцож төгрөгт хөрвүүлэн, төгрөг, гадаад валютаар давхар бүртгэх ба ханшийн хэлбэлзлээс үүсэх орлого, зардлыг гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого, зардлаар хүлээн зөвшөөрнө.

Харилцах, хадгаламжийн дансны хүүгийн зардлыг холбогдох заавар, журам, харилцах, хадгаламжийн дансны гэрээнд заасан хувиар тооцоолж, хуримтлуулан бүртгэнэ.

Д. БҮРТГЭЛ

<u>1) Харилцах, хадгаламжийн данс нээх, хаах, хүүгийн бүртгэл</u>

Харилцагч харилцах, хадгаламжийн данс нээж орлогын гүйлгээ хийхэд
Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Харилцагчийн харилцах буюу хадгаламж

Харилцагч дансаа хааж, зарлагын гүйлгээ хийхэд
Дебит: Харилцагчийн харилцах буюу хадгаламж
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Банк харилцагчийн харилцах, хадгаламжийн дансны үлдэгдэлд төлөх хүүг хуримтлуулахад
Дебит: Харилцах, хадгаламжинд төлсөн хүүгийн зардал
Кредит: Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг

<u>2) Харилцагчийн бэлэн мөнгөний орлого, зарлагын гүйлгээ</u>

Харилцагч өөрийн харилцах, хадгаламжийн данснаас бэлнээр зарлагадахад
Дебит: Харилцах, хадгаламжийн холбогдох данс
Кредит: Касс дахь бэлэн мөнгө

Харилцагч харилцах буюу хадгаламжийн дансандаа бэлнээр орлого тушаахад
Дебит: Касс дахь бэлэн мөнгө
Кредит: Харилцах, хадгаламжийн холбогдох данс

<u>3) Бэлэн бус төлбөр тооцоо</u>

Данс эзэмшигчийн бичсэн төлбөрийн даалгавар, түүнтэй адилтгах баримтыг үндэслэн харилцах данснаас төлбөр хийвэл

Дебит: Харилцагчийн харилцах данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс, эсвэл төлбөр хүлээн авагчийн холбогдох данс

Банк хоорондын тооцоогоор харилцагчийн харилцах, хадгаламжийн дансанд бэлэн бусаар орлого орж ирвэл

Дебит: Монголбанк, бусад банкин дахь харилцах эсвэл банк хоорондын (клирингийн) тооцооны авлага
Кредит: Харилцагчийн холбогдох харилцах, хадгаламжийн данс

Харилцагчийн харилцах, хадгаламжийн данснаас банк хоорондын тооцоогоор бэлэн бусаар зарлагын гүйлгээ гарвал

Дебит: Харилцагчийн холбогдох харилцах, хадгаламжийн данс
Кредит: Монголбанк, бусад банкин дахь харилцах эсвэл банк хоорондын (клирингийн) тооцооны өглөг

Харилцагчийн харилцах, хадгаламжийн данснаас банкны шимтгэл суутгасан бол

Дебит: Харилцагчийн холбогдох харилцах, хадгаламжийн данс
Кредит: Холбогдох хураамж, шимтгэлийн орлого

4) Хадгаламжийн сертификат

Банк хадгаламжийн сертификат, түүнтэй адилтгах зарцуулалтын хувьд хязгаарлалтгүй үнэт цаасыг нэрлэсэн үнээр нь гаргаж харилцагчдаас эх үүсвэр татсан бол

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс эсвэл Харилцах, хадгаламжийн данс
Кредит: Хадгаламжийн сертификат

Эх үүсвэрийн хүүг хуримтлуулсан бол
Дебит: Хадгаламжинд төлсөн хүүгийн зардал
Кредит: Хуримтлуулж тооцсон хүүгийн холбогдох өглөг

Хуримтлуулсан хүүг төлөхөд
Дебит: Хуримтлуулж тооцсон хүүгийн холбогдох өглөг
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Хадгаламжийн сертификатыг эзэмшигч нь цуцлах буюу буцаан олгоход
Дебит: Хадгаламжийн сертификат
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс эсвэл Харилцах, хадгаламжийн данс

Е. ТОДРУУЛГА

Харилцагчдын харилцах, хадгаламжийн үлдэгдэл, түүнд тайлант хугацаанд гарсан өөрчлөлтийг илэрхийлэгдсэн валютаар болон хугацаагаар нь ангилан харуулж, тодруулна.

Мөн харилцах, хадгаламжийн үлдэгдлийг дараах байдлаар бүлэглэж санхүүгийн тайланд тодруулна. Үүнд:

- Засгийн газрын харилцах, хадгаламж
- Санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж
- Санхүүгийн бус байгууллагын харилцах, хадгаламж
- Иргэдийн харилцах, хадгаламж
- Өрх гэр, иргэдэд үйлчлэгч ашгийн бус байгууллагын харилцах, хадгаламж
- Эдийн засгийн харьяат бусын харилцах, хадгаламж

Түүнчлэн санхүүгийн тайлангийн тодруулгад багтах бусад тодруулгыг санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх аргачлал (Хавсралт 4)-д заасан.

Ё. ХЯНАЛТ

- Ажилтнуудын ажил үүргийг зааглан тусгаарлана.
- Банкны тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, заавар журамд тусгайлан заагаагүй бол данс эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр харилцах болон хадгаламжийн данснаас хасалт хийхийг хориглоно.
- Гүйлгээний баримтын бүрдлийг хангаж, гүйлгээг үндсэн баримттай нь тулган шалгана.
- Харилцагч, хадгаламж эзэмшигчдийн дансаар гүйлгээ хийхдээ холбогдох дансны үлдэгдэлтэй тулгаж хянана.
- Тайлант үеийн эцэст харилцагч, хадгаламж эзэмшигчтэй дансны үлдэгдлийг тулган баталгаажуулна.

5.2. БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС ТАТСАН ЭХ ҮҮСВЭР

А. ШУУД ХОЛБОГДОХ СТАНДАРТУУД

- СТОУС 7 Санхүүгийн хэрэгсэл: Тодруулга
- СТОУС 9 Санхүүгийн хэрэгсэл
- НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- НББОУС 32 Санхүүгийн хэрэгсэл: Толилуулга
- НББОУС 39 Санхүүгийн хэрэгсэл: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Б. ТОДОРХОЙЛОЛТ

Энэ нь Монголбанк болон дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагын байршуулсан харилцах, хадгаламжаас бүрдэх санхүүгийн өр төлбөр юм.

Монголбанкнаас авсан зээлд Монголбанкнаас тодорхой зориулалт, хүү, хугацаа, эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр зээлсэн эх үүсвэр хамрагдана.

Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлд дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас тодорхой зориулалт, хүү, хугацаа, эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр зээлсэн эх үүсвэр хамрагдана.

Дотоод, гадаадын банк санхүүгийн байгууллагын байршуулсан харилцахад дотоод гадаадын банк, санхүүгийн байгууллагаас банкинд төлбөр тооцооны зориулалттай байршуулсан бөгөөд ямар нэг хязгаарлалтгүй эх үүсвэр хамрагдана.

Дотоод, гадаадын банк санхүүгийн байгууллагын байршуулсан хадгаламжинд дотоод гадаадын банк, санхүүгийн байгууллагаас банкинд хүү болон бусад нөхцөлтэй гэрээгээр байршуулсан эх үүсвэр хамрагдана.

В. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

Холбогдох заавар, журам, гэрээ, хэлцлийн дагуу бусад банк, санхүүгийн байгууллагаас эх үүсвэр байршуулж, санхүүгийн хөрөнгийг буцааж өгөх үүргийг банк хүлээсэн үед харилцах, хадгаламжийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, толилуулна.

Г. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

Бусад банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан харилцах, хадгаламжийг анх удаа хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр үнэлнэ. Бодит үнэ цэн нь гэрээний дагуу байршуулсан эх үүсвэрийн дүнтэй тэнцүү байна.

Санхүүгийн тайланд бусад банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан харилцах, хадгаламжийг хорогдуулсан өртгөөр үнэлж, тайлагнана. Харилцах, хадгаламжийн хорогдуулсан өртөг нь анх хүлээн зөвшөөрч хэмжсэн дүн (бодит үнэ цэн)-ээс тайлант хугацаанд нэмэгдсэн харилцах, хадгаламжийн орлогын гүйлгээ, харилцах, хадгаламжийн үлдэгдэлд тооцсон хүүг нэмж, тайлант хугацаанд хийгдсэн зарлагын гүйлгээ, холбогдох шимтгэлийг хасч тодорхойлогдоно.

Бусад банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийг анх удаа хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр хэмжинэ. Зээлийн эх үүсвэрийн анхны бодит үнийг тогтоохдоо эргүүлэн төлөх дүнгээс зээлтэй шууд холбоотой зардлыг хасна. Шууд холбоотой зардалд шимтгэл, хураамж, урамшуулал гэх мэт уг зээлийн эх үүсвэрийг татахтай шууд холбоотой ажил гүйлгээний зардлууд багтана.

Санхүүгийн тайланд бусад банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийг хорогдуулсан өртгөөр үнэлж, тайлагнана. Бусад банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хорогдуулсан өртгийг зээлийн анх хүлээн зөвшөөрч хэмжсэн дүн (бодит үнэ цэн)-гээс буцаан төлсөн зээлийн үндсэн төлбөр ба хойшлогдсон зардлыг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулан хуримтлуулсан дүнг хасч тодорхойлно. Банк үр ашигт хүүгийн хувшинг тооцохдоо тухайн санхүүгийн хэрэгслийн гэрээний бүх нөхцлийг харгалзан үзэж, мөнгөн гүйлгээг үнэлнэ. Энэ тооцоололд үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болсон гэрээний талуудын хооронд төлөгдөх бүх хураамж, шимтгэл, бусад бүх урамшуулал, хямдруулалтыг багтаана.

Санхүүгийн үйлчилгээний шимтгэлийн ангилал, бүртгэлийг “Зээл” бүлэгт тодорхойлсон бөгөөд санхүүгийн үйлчилгээний шимтгэл, төлбөрийн бүртгэл нь уг шимтгэл, хураамжийг үнэлэх болон холбогдох санхүүгийн хэрэгслийн бүртгэлийн сууриас шалтгаална. Санхүүгийн үйлчилгээний шимтгэл нь үзүүлсэн үйлчилгээний онцлог шинжийг тусгахгүй ч байж болно. Иймээс санхүүгийн хэрэгслийн үр ашигт хүүгээр тооцоолох шимтгэл ба үзүүлсэн үйлчилгээнд хамаарах шимтгэл, тодорхой үйл ажиллагаатай холбогдуулан авах төлбөр, хураамжийг ялгаатай бүртгэнэ.

Зээлдэгч банк үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болсон шимтгэл, хураамжийг хойшлуулан бүртгэж, холбогдох эх үүсвэрийн дүнг бууруулна. Үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болсон шимтгэл, хураамжийг хоёр төрөлд ангилж болно: зээл олгохтой холбоотой шимтгэл, хураамж (зээл олголтын хураамж) ба зээлийн хэлцэлд заасан үүрэгтэй холбоотой шимтгэл, хураамж (хүлээсэн үүргийн хураамж).

Зээл олголтын хураамж нь дараах зүйлсээс бүрдэнэ:

- Зээлдэгчийн “урьдчилж төлсөн” хүү эсвэл зээлийн нэрлэсэн хүүгийн түвшинг бууруулах хураамж, шимтгэл. Зээлдэгчийн санхүүгийн байдлыг үнэлэх, баталгаа, барьцаа хөрөнгө, бусад хэлцлийг үнэлж, гэрчлэх, нөхцлийг харилцан зөвшилцөх, баримт боловсруулах, арилжааг хаах зэрэг үйл ажиллагаатай холбоотой бол шимтгэл, хураамжийг зээл олголттой холбоотой гэж үзнэ.
- Зээл олгох үйл ажиллагаанд шууд хамаарах бусад шимтгэл, хураамж (жишээлбэл, зээл олгосны

шагналд төлсөн эсвэл хурдан хугацаанд зээл гаргахад зориулан зээлдэгчид төлсөн шимтгэл, хураамж).

Зээлийн шимтгэлийг хэрхэн бүртгэх нь зээлийг олгогдох магадлалтай эсэх болон зээлд хамаарах үүрэг нь НББОУС 39-ийн хүрээнд багтсан эсэхээс шалтгаалан тодорхойлогдоно. Хэрэв зээл олгогдох магадлалтай бөгөөд зээлд хамаарах үүрэг нь НББОУС 39-ийн хамрах хүрээнд багтаагүй тохиолдолд шимтгэлийг санхүүгийн хэрэгсэлд зориулагдсан төлбөр гэж үзэх тул хойшлуулан бүртгэж, үр ашигт хүүгийн аргаар тохируулна. Өөрөөр хэлбэл зээл олгогдсон бөгөөд энэ нь НББОУС 39-ийн хамрах хүрээнд багтаагүй тохиолдолд шимтгэлийг зээлийн хугацаанд хэсэгчлэн хуваарилж хойшлуулан бүртгэх тул орлого эсвэл зардалд шууд бүртгэхгүй. Хэрэв зээл олгогдоогүй тохиолдолд шимтгэлийг шийдвэр гарсан өдрөөр зээлдүүлэгч нь орлогод, зээлдэгч нь зардалд бүртгэнэ.

Зээлийн шугамыг бүхлээр нь эсвэл хэсэгчлэн ашиглах магадлалтай гэх нотолгоо байгаа бол шимтгэлийг НББОУС 39-д заасны дагуу хойшлуулан бүртгэнэ. Энэ тохиолдолд шимтгэлийг зээл олгох хүртэл хорогдуулж бүртгэхгүй. Жишээлбэл, бизнесийн төсөлд зээлийн шугамыг ашиглаж болно. Хэрэв зээлийн шугамыг 20 сая төгрөгөөр нээсэн ба үүнээс зөвхөн 5 сая төгрөгийг ашиглаж, зээл олгосон бол нийт төлсөн хураамжийн дөрөвний нэг нь энэхүү 5 сая төгрөгийн зээлд харгалзах ажил гүйлгээний өртөг болох тул үүнийг зээл олгогдох хүртэл хойшлуулан бүртгэнэ. Зээлийн шугамыг ашиглах магадлалтай гэх нотолгоо байхгүй бол шимтгэл нь зээлийн шугамыг нээх төлбөр болох ба үүнийг хойшлуулан бүртгэж, зээлийн шугамын хүчинтэй байх хугацаанд хорогдуулна.

Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, тэдгээрийн байршуулсан харилцах, хадгаламжид төлсөн хүүгийн зардлыг гэрээнд заасан нөхцөл, хувь хэмжээгээр тооцоолж, хуримтлуулан бүртгэнэ.

Гадаад валютаар байршуулсан харилцах, хадгаламж, авсан зээлийг Монголбанкны албан ханшаар тооцож төгрөгт хөрвүүлэн, төгрөг, гадаад валютаар давхар бүртгэх ба ханшийн хэлбэлзлээс үүсэх орлого, зардлыг гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого, зардлаар хүлээн зөвшөөрнө.

Банк татан төвлөрүүлсэн эх үүсвэр (хадгаламж, зээл, хоёрдогч өглөг болон бусад эх үүсвэр)-ийг зах зээлийн хүүгийн түвшинд эсвэл зах зээлийн нөхцлөөс мэдэгдэхүйц ялгаатай хүүтэйгээр авсан эсэхийг үнэлнэ. Банкны удирдлага татан төвлөрүүлсэн эх үүсвэрийг зах зээлийн хүүгээр олж авсан эсэхийг шинжилж, үнэлэхдээ зэрэгцүүлэгдэх ажил гүйлгээ (ижил валют, дуусгавар хугацаа, барьцаатай) болон тухайн санхүүгийн хэрэгслийг анх гаргаж байх үеийн зах зээлийн нөхцөл (тухайлбал, төв банкны бодлогын хүүгийн түвшин, евробор, лайбор гэх мэт холбогдох бусад хүүгийн түвшин) зэрэгт үндэслэнэ. Банкны хийсэн энэ үнэлгээг санхүүгийн тайлангийн тодруулгад оруулна. Зах зээлийн хүүгээс ялгаатай хүү бүхий (ялангуяа, зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй) зээл болон бусад эх үүсвэрийн бүртгэлийг энэ зааврын “Бусад эх үүсвэр” бүлэгт оруулсан.

Д. БҮРТГЭЛ

1) Монголбанк болон бусад банкнаас авсан зээл

Монголбанк болон бусад банкнаас зээл авахад гэрээний дүнгээр эх үүсвэрийн дансанд бүртгэнэ.

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Монголбанк, бусад банкнаас авсан зээлийн эх үүсвэр

Зээлийн эх үүсвэрт багтсан шууд холбоотой материаллаг дүнтэй зардлыг

Дебит: Эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс, эсвэл тухайн банкны харилцах, хадгаламж

Хойшлогдсон зардлыг зээлийн хугацаанд үр ашигт хүүгийн аргаар хорогдуулахад

Дебит: Зээлийн хүүгийн зардал
Кредит: Эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр

Зээлийн хүүг хуримтлуулж бүртгэхэд
Дебит: Зээлийн хүүгийн зардал
Кредит: Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн өглөг

Хүүгийн төлбөр хийхэд
Дебит: Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн өглөг
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс, эсвэл тухайн банкны харилцах, хадгаламж

Өмнө хуримтлуулж бүртгээгүй, тайлант үед ногдох хүүгийн дүнгээр

Дебит: Зээлийн хүүгийн зардал

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс эсвэл тухайн банкны харилцах, хадгаламж

Зээлийг буцааж төлөхөд

Дебит: Монголбанк, бусад банкнаас авсан зээлийн эх үүсвэр
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс, эсвэл тухайн банкны харилцах, хадгаламж

Хэрэв хаагдсан эх үүсвэрийн дансанд хамаарах хойшлогдсон зардлын данс нь үлдэгдэлтэй бол үүнийг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулж, хүүгийн зардлын дансанд хаана.

Жишээ: **Зээлийн эх үүсвэрийн хорогдуулсан өртгийг тооцоолох**
Банк 20X0 оны 1 дүгээр сарын 1-нд нэгэн харилцагчаас 4 жилийн хугацаатай, жилийн 10% хүүтэй, 400 сая төгрөгийн зээлийн эх үүсвэрийг татаж, зээл олгосны шимтгэлд 4 сая төгрөг төлсөн. Зээлийн гэрээнд зааснаар жил бүрийн 12-р сарын 31-ний өдөр үндсэн төлбөрөөс 100 сая төгрөгийг хүүгийн хамт төлнө.
Төлсөн шимтгэлийг эх үүсвэрийн анхны үнэнд шингээх ба зээлийн эх үүсвэрийг хүлээн зөвшөөрөх анхны үнэ 396 сая төгрөг болно (400сая-4сая).
Үр ашигт хүүг дараах тэгшитгэлээс тооцоолно:
$396{,}000 = 100{,}000*(1-(1+i)^{-4})/i + 40{,}000*(1+i)^{-1} + 30{,}000*(1+i)^{-2} + 20{,}000*(1+i)^{-3} + 10{,}000*(1+i)^{-4}$
Эндээс хүүгийн хувь нь i= 10.4859% болж байна. Тэгвэл хорогдуулалтын хүснэгт дараах байдалтай гарна. (мянган төгрөгөөр)

Жил	Хүү тооцох хугацаа	Зээлийн үлдэгдэл	Хүүгийн төлбөр	Гэрээний дагуу хийгдэх төлбөр	Зээлийн төлөлт	Хорогдуулаагүй хойшлогдсон зардлын үлдэгдэл	Эх үүсвэрийн цэвэр дүн (хорогдуулсан өртөг)	Хүүгийн зардал	Хойшлогдсон зардлын хорогдуулалт
		(a)	(b) =(a)*10%	(c)	(d)= (c)-(b)	(e)=(a)-(f)	(f)	(g)=(f)* 10.4859%	(h)=(b)-(g)
	20X0.1.1	**400,000**				**4,000**	**396,000**		
1	20X0.12.31	300,000	40,000	140,000	100,000	2,476	297,524	41,524	1,524
2	20X1.12.31	200,000	30,000	130,000	100,000	1,278	198,722	31,198	1,198
3	20X2.12.31	100,000	20,000	120,000	100,000	440	99,560	20,838	838
4	20X3.12.31	-	10,000	110,000	100,000	-	-	10,440	440
									4,000

Зээлийн эх үүсвэрийг дотоодын банкнаас татан төвлөрүүлэх үед:
20X0.1.1-ны өдөр

Дебит: Бусад банкинд байршуулсан мөнгө (харилцах данс) 400,000
Кредит: Дотоодын банкнаас авсан зээл 400,000
Дебит: Эх үүсвэрийн хойшлогдсон зардал (өр төлбөрийг бууруулна) 4,000
Кредит: Бусад банкинд байршуулсан мөнгө 4,000

20X0.12.31-ны өдөр

Дебит: Зээлийн хүүгийн зардал 41,524
(үр ашигт хүүгийн хувиар тооцоолж гаргасан)
Кредит: Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг 40,000
Кредит: Эх үүсвэрийн хойшлогдсон зардал 1,524

Дебит: Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг 40,000
Дебит: Дотоодын банкнаас авсан зээл 100,000
Кредит: Бусад банкинд байршуулсан мөнгө 140,000

20X0.12.31-нд санхүүгийн тайланд энэ эх үүсвэрийг дараах цэвэр дүнгээр толилуулна:

Дотоодын банкнаас авсан зээл	300,000
Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	40,000
Хасах нь: Төлөгдсөн хүүгийн өглөг	40,000
Хойшлогдсон зардал*	(2,476)
Зээлийн эх үүсвэрийн цэвэр дүн	297,524

* Өр төлбөрийг бууруулах энэхүү дансны дүнг анх хойшлуулан бүртгэсэн 4,000 төгрөгийг 1,524 (4,000-1,524=2,476) -өөр бууруулж гаргасан.

2) Бусад банк санхүүгийн байгууллагаас байршуулсан харилцах хадгаламж

Бусад банк, санхүүгийн байгууллагаас харилцах, хадгаламж байршуулахад

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Бусад банк санхүүгийн байгууллагаас байршуулсан харилцах хадгаламж

Байршуулсан харилцах, хадгаламжаас зарлагын гүйлгээ хийхэд буюу хаахад

Дебит: Бусад банк санхүүгийн байгууллагаас байршуулсан харилцах хадгаламж
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Харилцах, хадгаламжийн хүүг хуримтлуулж бүртгэхэд

Дебит: Хүүгийн зардлын холбогдох данс
Кредит: Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг

Хүүгийн төлбөр хийхэд

Дебит: Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс эсвэл тухайн банкны харилцах, хадгаламж

Өмнө хуримтлуулж бүртгээгүй, тайлант үед ногдох хүүгийн дүнгээр

Дебит: Хүүгийн зардлын холбогдох данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс эсвэл тухайн банкны харилцах, хадгаламж

Е. ТОДРУУЛГА

Банк, санхүүгийн байгууллагаас татсан бусад эх үүсвэрийг нэр төрлөөр дараах байдлаар ангилж тайлант үеийн эхний ба эцсийн үлдэгдэл, өөрчлөлтийг тодруулна. Үүнд:

- Банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан харилцах
- Банк, санхүүгийн байгууллагаас хадгаламж
- Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл
- Монголбанкнаас авсан зээл

Үүнээс гадна банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийг валютын төрөл, зээлдүүлэгч банк дотоодын ба гадаадын гэж ангилах буюу материаллаг дүн бүхий эх үүсвэр, санхүүжилтийн талаар тусад нь тайлбарлаж тодруулж болно.

Ё. ХЯНАЛТ

- Ажилтнуудын ажил үүргийг зааглан тусгаарлана.
- Харилцагч, зээлдүүлэгч банк, санхүүгийн байгууллага бүрээр өр төлбөрийн дэлгэрэнгүй бүртгэл хөтөлнө.
- Дэлгэрэнгүй бүртгэлийг хяналтын дансны гүйлгээ, үлдэгдэлтэй тохируулна.
- Өр төлбөр болон холбогдох дүнгүүдийн үлдэгдлийг харилцагч зээлдүүлэгчтэй тулган баталгаажуулна.
- Өр төлбөрийн гүйлгээний анхан шатны баримт болон эрх зүйн баримт бичгийг бүрдүүлнэ.
- Дансны үлдэгдлийн баталгаа гаргуулна.

5.3. БУСАД ЭХ ҮҮСВЭР

А. ШУУД ХОЛБОГДОХ СТАНДАРТУУД

- СТОУС 7 Санхүүгийн хэрэгсэл: Тодруулга
- СТОУС 9 Санхүүгийн хэрэгсэл
- НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- НББОУС 32 Санхүүгийн хэрэгсэл: Толилуулга
- НББОУС 39 Санхүүгийн хэрэгсэл: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Б. ТОДОРХОЙЛОЛТ

Бусад эх үүсвэрт банкнаас гаргасан өрийн бичиг, үнэт цаас, репо үнэт цаас, гадаад валютын арилжааны эх үүсвэр, аккредитивийн эх үүсвэр, баталгааны эх үүсвэр, төслийн зээлийн санхүүжилт, хамтын зээлжүүлэлтийн эх үүсвэр, бусад эх үүсвэрээс бүрдэх санхүүгийн өр төлбөр багтана.

Банкнаас гаргасан өрийн бичигт бонд, өрийн бичиг гэх зэрэг бондын нөхцлөөс шалтгаалан хүү төлөх буюу дуусгавар хугацаатай бөгөөд хугацааны эцэст эргүүлэн төлөх үүргийг бондын эзэмшигчийн өмнө хүлээж, татсан эх үүсвэр хамрагдана. Энэ дансанд хадгаламжийн сертификатыг бүртгэхгүй.

Репо үнэт цаас (хэлцэл) гэж банк өөрийн эзэмшиж буй үнэт цаасыг тохиролцсон хугацааны эцэст урьдчилан тохиролцсон үнээр буцаан худалдан авах нөхцөлтэйгөөр худалдах хэлцлийг ойлгоно. Репо

үнэт цаасыг худалдан авсан банкны хувьд уг хэлцэл нь *урвуу репо* болно. Урвуу репог гэрээнд оролцогч талууд, шинж чанар, дуусгавар хугацаанаас нь шалтгаалан “Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө”, “Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө”, “Зээл” зэрэг ангиллын аль нэгээр ангилан бүртгэж, тайлагнана.

Арилжааны эх үүсвэрт гадаад валютыг үндэсний мөнгөн тэмдэгтээр солих явцад худалдах болон худалдан авахад шаардлагатай мөнгөн хөрөнгийн эх үүсвэр хамрагдана.

Аккредитивийн эх үүсвэрт банкнаас харилцагчид нээсэн тодорхой хугацаа, хүү болон бусад нөхцөлтэй гэрээгээр нээсэн аккредитивийн төлбөрийг төлөх баталгаа болгон харилцагчийн данснаас тусгаарласан эх үүсвэр хамрагдана.

Баталгааны эх үүсвэрт банк харилцагчийн нэрийн өмнөөс захиалагчийн өмнө хүлээх үүргийн баталгаа болгон харилцагчийн данснаас тусгаарласан эх үүсвэр хамрагдана.

Төслийн зээлийн эх үүсвэрт дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас хэрэгжүүлэх тодорхой зориулалт, хүү, хугацаа, эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр мөнгөн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх төслийн зээлийн эх үүсвэр хамрагдана.

Хамтын зээлжүүлэлтийн эх үүсвэр гэж хамтын зээлжүүлэлтийн хэлцлийн дагуу оролцогч банкнаас удирдагч банкинд байршуулсан эх үүсвэрийг хэлнэ.

Түрээс нь түрээслүүлэгч тохиролцсон хугацаагаар тодорхой хөрөнгийг ашиглах эрхийг түрээслэгчид шилжүүлээд, тодорхой төлбөр авах хэлцэл юм.

Санхүүгийн түрээс нь түрээсийн хөрөнгийн эзэмшилтэй холбоотойгоор хойшид үүсэх эрсдэл болон өгөөжийг бүгдийг шилжүүлдэг түрээс юм. Энэ нь барьцаа бүхий зээлтэй төстэй. Санхүүгийн түрээсийн тодорхойлолтыг хангахгүй түрээсийг үйл ажиллагааны түрээс гэнэ. Санхүүгийн ба үйл ажиллагааны түрээсийн хоорондох ялгааг энэ зааврын “Зээл” бүлэгт оруулсан.

Түрээсийн өр төлбөрийг санхүүгийн тайланд “Бусад эх үүсвэр”-ийн мөрөнд харуулах ба үүнд санхүүгийн түрээс (банк бусад банк, санхүүгийн байгууллагатай санхүүгийн түрээсийн хэлцэл хийсэн үед) болон үйл ажиллагааны түрээсийн (банк үйл ажиллагааны хэлцлийн дагуу өглөгтэй үед) өглөг аль аль нь багтана.

Хоёрдогч өглөг, хөрвөх өр төлбөр, түрээсийн өглөг зэргийг “Бусад санхүүгийн ба санхүүгийн бус өр төлбөр” бүлэгт оруулсан.

В. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

Холбогдох заавар, журам, гэрээ, хэлцлийн дагуу бусад эх үүсвэрийг байршуулж, банк түүнийг буцааж өгөх үүрэг хүлээсэн үед тусгай зориулалттай бусад эх үүсвэрийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, толилуулна.

Түрээсийн гэрээ хүчин төгөлдөр болж, түрээсийн төлбөрийг авснаар санхүүгийн түрээсийн өглөгийг хүлээн зөвшөөрнө.

Г. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

Банкнаас гаргасан өрийн бичгийг анхны удаа хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээс шууд холбогдох зардлыг хассан дүнгээр үнэлнэ. “Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө” бүлэгт дурдсаны дагуу санхүүгийн өр төлбөрийн хувьд (гаргасан бонд ба бусад үнэт цаас) ажил гүйлгээний өртгийг анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс хасна. Энэ нь уг үнэт цаасыг гаргахад орсон цэвэр мөнгөн дүнгээр илэрхийлэгддэг.

Банкнаас гаргасан өрийн бичгийг хорогдуулсан өртгөөр үнэлж, санхүүгийн тайланд толилуулна. Хорогдуулсан өртгийг тодорхойлохдоо анхны үнээс үндсэн төлбөрийн төлөлтийг хасч, үр ашигт хүүгийн аргаар тооцоолсон урамшууллын хорогдуулалтыг хасах буюу хямдруулалтын хорогдуулалтыг нэмнэ. “Хөрөнгө оруулалт” бүлэгт хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаасны жишээ нь урамшуулал, хямдруулалттайгаар гаргасан бондтой хамаарах ба хорогдуулах хүснэгтийн тооцоолол нь ижилхэн болно. Харин данс нь банкны гаргасан бонд, бусад үнэт цаасны хувьд өөр байна.

Бусад эх үүсвэрийг анх удаа хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээс шууд холбогдох зардлыг хассан дүнгээр үнэлнэ. “Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө” бүлэгт дурдсаны дагуу санхүүгийн өр төлбөрийн хувьд (гаргасан бонд ба бусад үнэт цаас) ажил гүйлгээний өртгийг анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс хасна. Эх үүсвэрийн бодит үнэ цэн нь байршуулсан эх үүсвэрийн дүнтэй тэнцүү байна.

Бусад эх үүсвэрийг хэлцэлд үр ашигт хүүгээр тооцсон хорогдуулсан өртгөөр үнэлж, санхүүгийн тайланд толилуулна. Хорогдуулсан өртгийг банкнаас гаргасан бонд болон банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн хорогдуулсан өртгийг тооцохтой адил тооцоолно (Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө" бүлэгт оруулсан жишээг үз).

Арилжааны эх үүсвэрийг гадаад валют худалдах, худалдан авах банкны тухайн өдрийн ханшаар тооцон нэрлэсэн дүнгээр бүртгэнэ (энэ дүнг төгрөгөөр холбогдох дансанд хуримтлуулан бүртгэнэ). Гадаад валютыг үндэсний мөнгөн тэмдэгтээр солих явцад худалдах болон худалдан авахад шаардлагатай мөнгөн хөрөнгийн эх үүсвэр энд хамрагдана. Энэ дансанд гадаад валютаар илэрхийлэгдсэн дүнг бүртгэхдээ Монголбанкнаас зарласан албан ханшаар төгрөгт (бүртгэлийн валют) хөрвүүлэн бүртгэнэ.

Аккредитивийн болон баталгааны эх үүсвэрийг гэрээнд заасан нэрлэсэн дүнгээр буюу уг дансанд тусгайлан хуваарилсан дүнгээр бүртгэх бөгөөд уг дансны ашиглалтыг хязгаарласан байдаг.

Төслийн зээлийн эх үүсвэрийг бусад эх үүсвэрт мөрдөгдөх зарчмын дагуу хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

Төслийн зээлийн эх үүсвэрт төлөх хүүг гэрээнд заасан хувь хэмжээгээр, өдөр бүр хуримтлуулан тооцож тухайн тайлант хугацааны зардалд бүртгэнэ. Гэхдээ үр ашигт хүүгийн түвшин нь гэрээнд заасан нэрлэсэн хүүгийн түвшнээс ялгаатай байж болох тул банк сар бүр үр ашигт хүүгийн аргыг ашиглан хүүгийн зардлыг тооцоолж, шаардлагатай тохиолдолд сар бүр холбогдох тохируулгыг бэлтгэнэ.

Банк санхүүгийн түрээсээр хөрөнгө авсан нөхцөлд түрээсийн өглөгийг түрээсэлсэн хөрөнгийн бодит үнэ цэн ба түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнийн аль багаар хэмжинэ. Түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнийг тооцоолоход ашиглах үр ашигт хүү нь түрээсийн гэрээнд заасан буюу эсвэл түрээслэгчийн ашиглаж буй нуугдмал хүү эсвэл зах зээлийн дундаж хүү байж болно.

Түрээсийн хамгийн бага төлбөрийг санхүүгийн зардал ба төлөгдөөгүй өр төлбөрийг бууруулж хуваарилна. Тайлант хугацааны өр төлбөрийн үлдэгдлээс хүүгийн үечилсэн тогтмол түвшингээр тооцоолж, санхүүгийн зардлыг түрээсийн хугацаанд хуваарилна. Практик дээр түрээлэгч санхүүгийн зардлыг түрээсийн хугацаанд хуваарилахдаа хялбарчилсан, ойролцоо тооцоолол ашиглаж болно.

Санхүүгийн түрээсийн явцад хөрөнгийн элэгдлийн зардал болон санхүүгийн зардал жил бүр гарна. Түрээсийн хөрөнгийг элэгдүүлэх бодлого нь банкны өмчлөлд буй хөрөнгийн элэгдэлтэй адил байх ба элэгдлийг тооцоолохдоо НББОУС 16 "Үндсэн хөрөнгө" ба НББОУС 38 "Биет бус хөрөнгө" -ийг тус тус мөрдөнө. Хэрэв түрээсийн хугацааны эцэст түрээсийн хөрөнгийг өмчлөх эрх түрээслэгчид шилжих нь тодорхой бус тохиолдолд хөрөнгийг түрээсийн хугацаа ба ашиглалтын хугацааны аль богино хугацаанд элэгдүүлнэ. Түрээсийн хөрөнгийн элэгдүүлэх өртгийг уг хөрөнгийг ашиглахаар таамаглаж буй хугацаанд системтэйгээр хуваарилна. Үүний үр дүнд түрээсийн хөрөнгө, түүнтэй холбоотой өр төлбөр нь анх хүлээн зөвшөөрөх үед тэнцүү байх боловч үүнээс цаашид хоорондоо тэнцэхгүй.

Гадаад валютаарх эх үүсвэрийг Монголбанкнаас зарласан албан ханшаар тооцож төгрөгт хөрвүүлэн төгрөг, валютаар давхар бүртгэх ба ханшийн хэлбэлзлээс үүсэх орлого, зардлыг гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого, зардалд бүртгэнэ.

Д. БҮРТГЭЛ

<u>1) Банкнаас гаргасан бонд, өрийн бичиг</u>

Банкнаас бонд, өрийн бичиг гаргасан бол үнэт цаасны нэрлэсэн үнээр холбогдох үнэт цаасны дансанд бүртгэх ба нэрлэсэн үнэ, бодит үнийн зөрүүгээр урамшуулал, хямдруулалтын дансанд бүртгэж, "Банкнаас гаргасан өрийн бичиг", "Гаргасан үнэт цаас" гэсэн мөрөөр тайлагнана.

Урамшуулалтай бол

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс эсвэл Харилцах, хадгаламжийн данс
Кредит: Хорогдуулаагүй урамшуулал
Кредит: Банкнаас гаргасан бонд, өрийн бичиг

Хямдруулалттай бол

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс эсвэл Харилцах, хадгаламжийн данс
Дебит: Хорогдуулаагүй хямдруулалт
Кредит: Банкнаас гаргасан бонд, өрийн бичиг

Өрийн бичиг, бондын хүүг хуримтлуулахад

Дебит: Үнэт цаасны хүүгийн зардал
Кредит: Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг

Хурмтлуулсан хүүг төлөхөд

Дебит: Хуримтлуулж тооцсон хүүгийн холбогдох өглөг
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс эсвэл Харилцах, хадгаламжийн данс

Хэрэв өрийн бичиг, бондыг анх урамшуулалтай гаргасан бол урамшууллыг хорогдуулах дүнгээр хүүгийн зардлыг бууруулна. Үр ашигт хүүгийн түвшин нь нэрлэсэн хүүгийн түвшнээс бага байгаагийн улмаас хүлээн зөвшөөрч, бүртгэх хүүгийн зардлыг гаргахдаа нэрлэсэн хүү болон урамшууллыг аль алийг нь бууруулна.

Дебит: Хорогдуулаагүй урамшуулал ба хямдруулалт
Кредит: Үнэт цаасны хүүгийн зардал

Хэрэв өрийн бичиг, бондыг анх хямдруулалттай гаргасан бол хямдруулалтыг хорогдуулах дүнгээр хүүгийн зардлыг нэмэгдүүлнэ. Үр ашигт хүүгийн түвшин нь нэрлэсэн хүүгийн түвшнээс өндөр байгаагийн улмаас хүлээн зөвшөөрч, бүртгэх хүүгийн зардлыг гаргахдаа нэрлэсэн хүүг нэмэгдүүлж, хямдруулалтыг бууруулна. Энэ мэтээр анхны удаад хүлээн зөвшөөрсөн хямдруулалтыг бонд буюу өрийн бичгийн хугацаанд хорогдуулна.

Дебит: Үнэт цаасны хүүгийн зардал
Кредит: Хорогдуулаагүй урамшуулал ба хямдруулалт

Өрийн бичиг, бондын хугацаа дуусахад банк төлбөрийг барагдуулсан бол

Дебит: Банкнаас гаргасан өрийн бичиг
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс эсвэл Харилцах, хадгаламжийн данс

Өрийн бичиг, бондын нэрлэсэн хугацаа дуусахаас өмнө банк эзэмшигчээс нь эргүүлэн авсан бол өрийн бичгийн дансны үлдэгдэл ба төлсөн мөнгөний дүнгийн зөрүүгээр олз, гарз үүснэ.

Үндсэн дүнгээр
Дебит: Банкнаас гаргасан өрийн бичиг
Дебит эсвэл Кредит: Бонд, өрийн бичиг барагдуулсны олз, гарз
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс эсвэл Харилцах, хадгаламжийн данс

Урамшуулалтай бол
Дебит: Хорогдуулаагүй урамшуулал ба хямдруулалт
Кредит: Үнэт цаасны хүүгийн зардал/Бонд, өрийн бичиг барагдуулсны олз, гарз

Хямдруулалттай бол
Дебит: Үнэт цаасны хүүгийн зардал/Бонд, өрийн бичиг барагдуулсны олз, гарз
Кредит: Хорогдуулаагүй урамшуулал ба хямдруулалт

2) Репо үнэт цаас

Репо үнэт цаасыг гаргасан банк репо нөхцлөөр худалдсан үнэт цаасаа хөрөнгө оруулалтаар үргэлжлүүлэн бүртгэх ба харин репо хэлцэлд хамаарах мөнгөн гүйлгээг “Репо нөхцлөөр худалдсан үнэт цаас” дансанд бүртгэнэ. Өр төлбөрийн энэхүү дансыг репогийн зорилгоор авсан зээл гэж үзнэ.

Репо үнэт цаасыг худалдан авсан банк репо хэлцэлд харгалзах аливаа гүйлгээг “Репо нөхцлөөр худалдан авсан үнэт цаас (Урвуу репо)” дансанд бүртгэнэ. Урвуу репог гэрээнд оролцогч талууд (банк, санхүүгийн байгууллага, харилцагч эсэх), шинж чанар, дуусгавар хугацаанаас нь шалтгаалан “Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө”, “Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө”, “Зээл” зэрэг ангиллын аль нэгээр ангилан бүртгэж, тайлагнана (өөрөөр хэлбэл оролцогч нь банк, санхүүгийн байгууллага бөгөөд 3 хүртэлх сарын хугацаатай бол энэ нь мөнгөн хөрөнгийн тодорхойлолтыг хангах ба уг шалгууруудыг биелүүлэхгүй байгаа бол “Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө”-өөр ангилан, бүртгэнэ).

Буцаан худалдан авах хэлцэл буюу үнэт цаас барьцаалсан зээл (Репо). Санхүүгийн хөрөнгийг тогтсон үнээр эсвэл борлуулах үнэ дээр зээлдэгчийн өгөөжийг нэмсэн үнээр эргүүлэн худалдан авах хэлцэл байгуулан худалдсан эсвэл гаргасан тал эргүүлэн авах нөхцөл бүхий хэлцлийн дагуу худалдсан тохиолдолд уг хөрөнгийг шилжүүлсэн тал нь уг хөрөнгийн эзэмшилтэй холбоотой эрсдэл, өгөөжийг өөртөө үлдээсэн байгаа тул санхүүгийн хөрөнгийг данснаас хасч болохгүй.

Хэрэв хөрөнгийг шилжүүлсэн талд хөрөнгийг худалдан борлуулах буюу барьцаалах эрх үлдээгүй бол уг хөрөнгийн ангиллыг өөрчлөлгүйгээр санхүүгийн байдлын тайландаа харуулах ба эсрэг тохиолдолд ангиллыг нь СТОУС-ын дагуу өөрчилж, санхүүгийн байдлын тайланд тусдаа мөрөөр харуулна. Репо үнэт цаасыг барьцаанд байгаа үнэт цаас дансанд шилжүүлэн бүртгэж, тусгаарлана.

Энэ дансыг Монголбанкинд сар бүр хүргүүлэх тайланд Хөрөнгө оруулалтаар харуулна. Энэ данс нь тусгаарласан үнэт цаасыг бүртгэх данс юм (өөрөөр хэлбэл барьцаанд буй үнэт цаасыг харуулна). Репогийн хоёр дахь алхамыг хэрэгжүүлсний дараа (эргүүлэн худалдаж авсны дараа) үнэт цаасыг анхны дансанд нь буцааж бүртгэнэ.

Худалдан авагч банкны хувьд үүнийг барьцаат зээл олгож байгаатай нэгэн адил бүртгэнэ. Худалдан авсан үнэт цаасыг балансанд бүртгэхгүй харин тэнцлийн гадуур бүртгэнэ. Олгосон зээлийг репо нөхцлөөр худалдан авсан үнэт цаас (урвуу репо) дансанд бүртгэнэ (Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө, Зээл бүлгүүдийг үзнэ үү).

Банк репо нөхцлөөр үнэт цаас худалдан авсан бол

(а) Худалдан авсан банк нь

Дебит: Урвуу репо (Репо нөхцлөөр худалдан авсан үнэт цаас)
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс эсвэл Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө

Үнэт цаасыг тэнцлийн гадуур барьцаа хөрөнгөөр бүртгэнэ.

(б) Худалдсан банк нь

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс эсвэл Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө
Кредит: Репо нөхцлөөр худалдсан үнэт цаас

Дебит: Барьцаанд тавьсан үнэт цаас*
Кредит: Холбогдох үнэт цаас, хөрөнгө оруулалтын данс (Хөрөнгө оруулалт)*

* Энэ нь зээлдүүлэгч уг үнэт цаасыг худалдах болон барьцаанд тавих эрхтэй байгаатай холбоотой. Бусад тохиолдолд уг ангиллыг ашиглахгүй.

Гэрээний дагуу репо нөхцлөөр үнэт цаас худалдсан банк үнэт цаасыг буцаан худалдан авч, үнэт цаасны хүүг төлөх үед

(а) Худалдан авсан банк нь

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс эсвэл Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө
Кредит: Урвуу репо (Репо нөхцлөөр худалдан авсан үнэт цаас)
Кредит: Хүүгийн холбогдох орлого

Үнэт цаасыг тэнцлийн гадуур барьцаа хөрөнгийн данснаас зарлагадна.

(б) Худалдсан банк нь
Дебит: Репо нөхцлөөр худалдсан үнэт цаас
Дебит: Хүүгийн холбогдох зардал
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс эсвэл Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө

Дебит: Холбогдох үнэт цаас, хөрөнгө оруулалтын данс
Кредит: Барьцаанд тавьсан үнэт цаас

Репо нөхцлөөр үнэт цаас худалдсан банк гэрээт хугацаандаа үнэт цаасаа эргүүлэн аваагүй, түүнд бодогдсон хүүг төлөөгүй нөхцөлд үнэт цаасыг худалдан авсан банкинд барьцааны үнэт цаасыг худалдах буюу өмчлөх эрх үүснэ.

(а) Худалдан авсан банк нь

Дебит: Өмчлөх бусад хөрөнгө - Санхүүгийн хөрөнгө
Кредит: Урвуу репо (Репо нөхцлөөр худалдан авсан үнэт цаас)
Кредит: Хүүгийн холбогдох орлого

Үнэт цаасыг тэнцлийн гадуур барьцаа хөрөнгийн данснаас зарлагадна.

(б) Худалдсан банк нь

Дебит: Репо нөхцлөөр худалдсан үнэт цаас
Дебит: Хүүгийн холбогдох зардал
Кредит: Барьцаанд тавьсан үнэт цаас

Репо хэлцлийг сар дамжин хийсэн бол хүүг хуримтлуулан тооцож, санхүүгийн тайланд тусгана.

3) Арилжааны эх үүсвэрийн тооцоо

Бусад эх үүсвэрээс арилжааны эх үүсвэрийг тусгаарлахад

Дебит: Харилцах, хадгаламжийн холбогдох данс
Кредит: Гадаад валютын арилжааны эх үүсвэр

Гадаад валютын бүртгэлийг "Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө", "Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө" бүлэгт тайлбарласан.

4) Аккредитивийн тооцоо

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд өөр хоорондоо харилцан бараа бүтээгдэхүүн худалдах, худалдан авах, ажил үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаатай холбогдон тэдгээрийн харилцагч банкуудын хооронд хийгдэх бэлэн бус тооцооны нэг хэлбэр нь аккредитивийн тооцоо юм. Харилцагчийн нийлүүлэгч талаас ачуулсан барааны төлбөрийг харилцагч төлөх чадварыг баталгаажуулахыг шаардсан үед банк харилцагчийн нэрийн өмнөөс аккредитивийг нээдэг. Аккредитивийг нийлүүлэгчийн банк руу мэдээлэл болгон илгээх бөгөөд нийлүүлэгчийг бараагаа ачуулж, нийлүүлж буй барааны холбогдох бичиг баримтуудыг бэлтгэн илгээх үйл ажиллагаагаа эхлэх зөвшөөрлийг олгодог.

Аккредитивийн тооцоог бараа бүтээгдэхүүн худалдах, ажил үйлчилгээ үзүүлэгчийн (бэлтгэн нийлүүлэгчийн) банк ба бараа бүтээгдэхүүн худалдан авагч, ажил үйлчилгээ хүлээн авагчийн (худалдан авагчийн) банкны хооронд хийнэ.

Аливаа нэг харилцагчид зориулан банкнаас аккредитив нээсэн бол харилцагч банкинд дараах зүйлсийг гарган өгөх замаар банкийг эрсдэлээс хамгаалдаг:

i. Бусад данснаас тусгаарлан авсан тодорхой хадгаламж буюу мөнгөн дүн
ii. Харилцагчийн харилцах данснаас шаардагдах дүнг татан авах эрх
iii. Импортын зээл

Аккредитивийг ихэвчлэн гадаад валютаар гаргадаг бөгөөд үүний үр дүнд хэрэглэгдэх гадаад валютын арилжааны ханш нь нөгөө талын банк нийлүүлэгчид холбогдох төлбөрийг хийх өдрийн хэрэгжиж буй ханш болно. Тийм учраас банк хэрэв нийлүүлэгчид илгээх төлбөр нь тухайн аккредитивийг төлөх валютаар хийгдээгүй (харилцагчаас банк руу тушаахдаа) бол валютын ханшны эрсдэлээс бүрэн хамгаалж чадах хангалттай хэмжээний мөнгө харилцагчийн дансанд байгаа эсэхийг хянан үзэж баталгаажуулах хэрэгтэй.

Банк өөрийн журмын дагуу аккредитив нээлгэхийг хүссэн банк, байгууллага, иргэдээс баримт бүрдүүлэн, аккредитив нээх хөрөнгийн эх үүсвэрийг тодорхойлсны үндсэн дээр аккредитив нээж хөрөнгө тусгаарлана.

Харилцагчийн төлсөн мөнгөөр эсвэл харилцагчийн данснаас тусгай зориулалттай эх үүсвэрт хуваарилахдаа дараах байдлаар бүртгэнэ:

Дебит: Мөнгөн хөрөнгө эсвэл Харилцах, хадгаламжийн холбогдох данс
Кредит: Аккредитивийн эх үүсвэр

Аккредитивын гэрээний дагуу төлбөр хийгдэхэд

Дебит: Аккредитивийн эх үүсвэр
Кредит: Холбогдох харилцагчийн данс эсвэл Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

5) Баталгааны эх үүсвэр

Баталгаа гаргагч харилцагчийн албан хүсэлтийн дагуу банк аливаа баталгааг нээнэ. Баталгаа гаргагч харилцагчаас төлбөрийн болон бусад үүргийн үнийн дүнгийн тодорхой хувиар банкинд эх үүсвэр байршуулж болно.

Банк баталгааны эх үүсвэрийг дараах байдлаар гаргана. Үүнд:

i. Харилцагчийн данснаас баталгааны дүнг тусгаарлан авч хязгаарлах
ii. Зээл (шугаман болон бусад) олгох замаар нээж болох бөгөөд баталгаа хүлээн авагчаас өгсөн удирдамжинд заасан хугацаагаар эх үүсвэрийг хязгаарлана.

Баталгааны эх үүсвэрийг тусгаарлахад дараах гүйлгээг хийх бөгөөд тэнцлийн гадуурх бүртгэлд хүлээж болзошгүй үүрэг хэмээн үзэж давхар бүртгэнэ.

Дебит: Мөнгөн хөрөнгө эсвэл Харилцагчийн харилцах, хадгаламжийн данс
Кредит: Баталгааны эх үүсвэр

Баталгаа хүлээн авагчийн нэхэмжлэхийн дагуу төлбөр шилжүүлэх эсвэл харилцагчид буцаан олгоход
Дебит: Баталгааны эх үүсвэр
Кредит: Мөнгөн хөрөнгө, Харилцагчийн харилцах, хадгаламжийн данс

Төслийн зээлийн эх үүсвэрийн бүртгэл нь банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн бүртгэлтэй ижил байна. Гэхдээ бүргэлийн данс нь ялгаатай.

6) Зах зээлийн хүүгээс ялгаатай хүүтэй эх үүсвэрийн бүртгэл

Зах зээлийн хүүгээс ялгаатай хүүтэй эх үүсвэрийн нягтлан бодох бүртгэл, холбогдох жишээг "Бусад санхүүгийн ба санхүүгийн бус өр төлбөр" бүлэгт оруулсан.

7) Санхүүгийн түрээсийн өглөг

Санхүүгийн түрээсийн гэрээгээр хөрөнгө авахад (эсвэл хөрөнгийг түрээсэлж байгаа тохиолдолд)

Дебит: Үндсэн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Санхүүгийн түрээсийн өглөг

Санхүүгийн түрээсийн хүүгийн зардлыг хуримтлуулах бол

Дебит: Хүүгийн зардал
Кредит: Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг

Банк түрээслүүлэгчид түрээсийн төлбөр шилжүүлэхэд

Дебит: Санхүүгийн түрээсийн өглөг
Дебит: Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

8) Үйл ажиллагааны түрээсийн өглөг

Банк үйл ажиллагааны түрээсээр хөрөнгө (барилга байгууламж гэх мэт) түрээслэн авсан (өөрөөр хэлбэл банк хөрөнгийг өмчлөгчөөс түрээсэлсэн) бол тухайн тайлант хугацаанд харгалзах зардлыг дараах байдлаар бүртгэнэ:

Дебит: Түрээсийн зардал
Кредит: Түрээсийн өглөг

Банк түрээслүүлэгчид түрээсийн төлбөр шилжүүлэхэд

Дебит: Түрээсийн өглөг
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

9) Түрээсийн хөрөнгийг борлуулаад эргүүлэн түрээслэх арилжаа

Түрээсийн хөрөнгийг борлуулаад эргүүлэн түрээслэх арилжааны зорилго нь хөрөнгөө ашиглахын зэрэгцээ эзэмшигчийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх явдал юм. Хөрөнгийг эзэмшиж байсан этгээд түрээслэгчид хөрөнгөө худалдаад, эргүүлэн түрээслэн авч түрээслэгч болно. Түрээсийн төлбөр болон худалдах үнийг багц байдлаар хэлэлцэн тохиролцдог тул тэдгээр нь хоорондоо харилцан хамааралтай байдаг. Түрээсийн хөрөнгийг борлуулаад эргүүлэн түрээслэх арилжааны бүртгэл нь түрээсийн төрлөөс хамаарна (санхүүгийн түрээс эсвэл үйл ажиллагааны түрээс гэдгээс хамаарна).

Хэрэв хөрөнгийн өмчлөлтэй холбоотой бүх эрсдэл, өгөөжийг түрээсээр шилжүүлсэн бол энэ нь санхүүгийн түрээс болно. Дангаараа болон хамтдаа түрээсийг санхүүгийн түрээс гэж ангилахад хүргэдэг нөхцөл байдлын жишээг дурдвал:

- Түрээсийн хугацааны эцэст хөрөнгө өмчлөх эрхийг түрээслэгчид шилжүүлнэ.
- Түрээслэгч нь түрээсийн хөрөнгийг бодит үнэ цэнээс харьцангуй бага үнээр худалдан авах сонголт хийх эрхтэй байдаг ба уг эрхээ эдлэн хөрөнгийг худалдан авах нь түрээсийн эхэнд тодорхой болсон байх.
- Хэдийгээр түрээсийн хөрөнгийн эрхийг шилжүүлээгүй байсан ч түрээсийн хугацаа нь хөрөнгийн ашиглалтын хугацааны дийлэнхийг хамарсан байх.
- Түрээсийн эхэнд түрээсийн хамгийн бага төлбөрийн өнөөгийн үнэ цэн нь түрээсийн хөрөнгийн бодит үнэ цэнтэй ойролцоо байх.

- Түрээсийн хөрөнгийг зөвхөн түрээслэгч ямар нэгэн томоохон өөрчлөлт хийлгүйгээр ашиглаж болох онцгой шинжтэй.

Санхүүгийн түрээсээс бусад түрээсийг үйл ажиллагааны түрээс гэнэ.

Хэрэв борлуулаад эргүүлэн түрээслэх арилжаа нь санхүүгийн түрээс үүсгэж байгаа бол дансны үнээс хэтэрсэн борлуулалтын үнийн зөрүүг борлуулагч-түрээслэгч нь шууд орлогод бүртгэж болохгүй. Харин үүнийг хойшлуулан бүртгэж, түрээсийн хугацаанд хорогдуулна.

Жишээ: Түрээсийн хөрөнгийг борлуулаад эргүүлэн түрээслэх

Банк 1 сая төгрөгийн дансны үнэ бүхий үл хөдлөх хөрөнгөтэй. Банк уг хөрөнгөө 1.4 сая төгрөгөөр борлуулаад эргүүлэн түрээсэлсэн. Энэхүү түрээсийн арилжааг санхүүгийн түрээсээр ангилж, бүртгэсэн. 0.4 сая төгрөгийн урамшууллыг түрээсийн хугацаанд хорогдуулна. Түрээсийн төлбөр 0.1 сая төгрөг.

Дебит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө 1.4 сая төгрөг
Кредит: Үндсэн хөрөнгө* 1 сая төгрөг
Кредит: Түрээсийн хөрөнгийг борлуулаад эргүүлэн түрээслэхтэй холбоотой хойшлогдсон орлого 0.4 сая төгрөг

* Борлуулаад эргүүлэн түрээсэлсэн хөрөнгийн данс нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хойшлогдсон орлогыг түрээсийн хугацаанд жил тутамд 0.02 сая төгрөгөөр хорогдуулна (хөрөнгийг 20 жил ашиглана гэж тооцсон):

Дебит: Түрээсийн хөрөнгийг борлуулаад эргүүлэн түрээслэхтэй холбоотой хойшлогдсон орлого 0.02 сая төгрөг
Кредит: Түрээсийн хөрөнгийг борлуулаад эргүүлэн түрээслэхтэй холбоотой орлого 0.02 сая төгрөг

Дараа нь банк түрээслэгчийн хувьд санхүүгийн түрээсийг бүртгэнэ:

Дебит: Үндсэн хөрөнгө 1.4 сая төгрөг
Кредит: Санхүүгийн түрээсийн өглөг 1.4 сая төгрөг

1.4 сая төгрөгийн санхүүгийн түрээсийн өглөгийн 0.1 сая төгрөг нь тайлант хугацаанд харгалзах хэсэг юм.

Түрээсийн үлдэгдэл ба хүүгийн дүнгийн талаарх мэдээллийг түрээсийн баримтжуулалтанд багтаана. Түрээсийн үлдэгдэл ба санхүүгийн зардлыг сар бүрт хуваарилсан төлбөрийн хуваарийг түрээслүүлэгчээс авч болно. Уг арилжааг цаашид санхүүгийн түрээсээр бүртгэх буюу өөрөөр хэлбэл санхүүгийн түрээсийн өглөгийг түрээсийн хугацаанд төлөгдөх төлбөрөөр бууруулна. Мөн хүүгийн зардлыг түрээсийн хугацаанд төлж, бүртгэнэ. Хүүгийн түвшин тогтмол тул сар өнгөрөх тусам банкны төлөх хүү багасч, үлдэгдэл төлбөр нэмэгдэнэ. Үүний зэрэгцээ үндсэн хөрөнгийг түрээсийн хугацаанд элэгдүүлнэ.

Хэрэв борлуулаад эргүүлэн түрээслэх арилжаа нь үйл ажиллагааны түрээс үүсгэж байгаа бол уг арилжааг бодит үнэ цэнээр гүйцэтгэх бөгөөд хөрөнгийг данснаас хасахад үүссэн олз, гарзыг тайлант хугацааны орлого, зардалд шууд бүртгэнэ.

Жишээ: Түрээсийн хөрөнгийг борлуулаад эргүүлэн түрээслэх – Үйл ажиллагааны түрээс

Хэрэв дээрх жишээг үйл ажиллагааны түрээс болгон авбал (жишээлбэл, хөрөнгийг зөвхөн 1 жилээр түрээсэлсэн, түрээсийн төлбөр 0.1 сая төгрөг):

Дебит: Холбогдох мөнгөн хөрөнгө 1.4 сая төгрөг
Кредит: Үндсэн хөрөнгө 1 сая төгрөг
Кредит: Үндсэн хөрөнгийг данснаас хассаны олз 0.4 сая төгрөг

0.1 сая төгрөгийн төлбөр нь түрээстэй холбоотойгоор хүлээсэн үүрэг (тэнцлийн гадуурх данс) болох ба сард төлөх төлбөрийг дараах байдлаар бүртгэнэ:

Дебит: Түрээсийн зардал
Кредит: Барилгын шинэ эзэмшигчид өгөх өглөг

Дээр дурдсаны дагуу борлуулаад эргүүлэн түрээслэх үйл ажиллагааны түрээсийн хөрөнгийн бодит үнэ цэн нь тухайн хөрөнгийн дансны үнээс доогуур байгаа тохиолдолд эдгээрийн зөрүүг шууд гарзад бүртгэнэ. Энэ заалт нь хөрөнгийн дансны үлдэгдлийн үнэ цэнийн бууралтыг бүртгэхэд ач холбогдолтой юм. Борлуулах арилжааг бодит үнэ цэнээр гүйцэтгэсэн тохиолдолд борлуулалтаас үүссэн аливаа олзыг

шууд хүлээн зөвшөөрч, бүртгэх ба үүний үр дүнд жирийн хөрөнгө борлуулах арилжаа хийгдэнэ.

Хөрөнгийг худалдах үнэ нь бодит үнэ цэнээс өндөр бол бодит үнэ цэнээс хэтэрсэн худалдах үнийн зөрүүг жинхэнэ ашиг орлого гэж үзэхгүй. Үүний шалтгаан нь ирээдүйн түрээсийн өглөг нь зах зээлийн үнэ цэнээс илүү гарч нэмэгдэж байгаатай холбоотой. Иймээс бодит үнэ цэнээс хэтэрсэн борлуулах үнийн хэсгийг хойшлуулан бүртгэж, хөрөнгийн ашиглалтын хугацаанд хорогдуулна. Үүний улмаас хөрөнгийн бодит үнэ цэнээс хамааран жилийн түрээсийн зардлыг бууруулна.

Хөрөнгийг худалдах үнэ нь бодит үнэ цэнээс доогуур байгаа тохиолдолд үүссэн орлого, зардлыг шууд хүлээн зөвшөөрч, бүртгэх (барилгыг бодит үнэ цэнээр бус өртгөөр бүртгэсэн тохиолдолд) ба харин энэ үед гарсан зардлыг зах зээлийн хүүгээс доогуур үнээр ирээдүйд төлөгдөх түрээсийн төлбөрөөр нөхөж байгаа бол үүссэн орлого, зардлыг (зах зээлийн түвшнээс доогуур төлөгдөх ирээдүйн төлбөрийн дүнг нөхөх хэмжээгээр) хойшлуулан бүртгэж, хөрөнгийн ашиглалтын хугацаанд хорогдуулна.

Е. ТОДРУУЛГА

Бусад эх үүсвэрийг дараах байдлаар ангилж тайлант үеийн эхний ба эцсийн үлдэгдэл, өөрчлөлтийг тодруулна:

- Банкнаас гаргасан өрийн бичиг (өөрөөр хэлбэл гаргасан вексел, гаргасан үнэт цаас)
- Банкнаас гаргсан үнэт цаас
- Төслийн зээлийн эх үүсвэр
- Репо үнэт цаас
- Хамтын зээлжүүлэлтийн эх үүсвэр
- Бусад эх үүсвэр

Санхүүгийн түрээсийн өглөгтэй холбогдуулан дараах зүйлсийг тодруулна:

- Түрээсийн гэрээний ерөнхий мэдээлэл, онцлог заалтууд, хугацаа, түрээсийн төлбөр
- Түрээстэй холбоотой хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тооцоолол
- Түрээстэй холбоотой болзошгүй өр төлбөр
- Түрээсийн хөрөнгийг буцаан түрээсэлсэн эсэх

Шаардлагатай тохиолдолд бусад зүйлсийг тусад нь тодруулж болно.

Репо хэлцлээр худалдсан үнэт цаасны төрөл, мөнгөн дүн, холбогдох мэдээллийг тодруулна.

Бусад эх үүсвэрийг валютын төрөл, зээлдүүлэгч банк (дотоодын ба гадаадын), дуусгавар хугацаагаар нь ангилах буюу мэдэгдэхүйц өндөр дүн бүхий эх үүсвэр, санхүүжилтийн талаар тусад нь тодруулна.

Түүнчлэн санхүүгийн тайлангийн тодруулгад багтах бусад тодруулгыг санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх аргачлал (Хавсралт 4)-д заасан.

Ё. ХЯНАЛТ

- Ажилтнуудын ажил үүргийг зааглан тусгаарлана.
- Харилцагч, зээлдүүлэгч банк, санхүүгийн байгууллага бүрээр эх үүсвэрийн дэлгэрэнгүй бүртгэл хөтөлнө.
- Дэлгэрэнгүй бүртгэлийг хяналтын дансны гүйлгээ, үлдэгдэлтэй тохируулна.
- Эх үүсвэр болон холбогдох дансдын үлдэгдлийг санхүүгийн тайлангийн өдрөөр эх үүсвэр эзэмшигчтэй тулган баталгаажуулна.
- Эх үүсвэрийн гүйлгээний анхан шатны баримт болон эрхзүйн баримт бичгийг шаардлагын түвшинд бүрдүүлнэ.

5.4. БУСАД САНХҮҮГИЙН БА САНХҮҮГИЙН БУС ӨР ТӨЛБӨР

А. ШУУД ХОЛБОГДОХ СТАНДАРТУУД

- СТОУС 7 Санхүүгийн хэрэгсэл: Тодруулга
- СТОУС 9 Санхүүгийн хэрэгсэл
- НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- НББОУС 17 Түрээс
- НББОУС 19 Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж
- НББОУС 32 Санхүүгийн хэрэгсэл: Толилуулга
- НББОУС 39 Санхүүгийн хэрэгсэл: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Б. ТОДОРХОЙЛОЛТ

Бусад санхүүгийн өр төлбөрт дараах өр төлбөр багтана:

- Бусдад өгөх өглөг
- Банк, салбар хоорондын тооцооны өглөг
- Мөнгөн гуйвуулгын өглөг
- Ногдол ашгийн өглөг
- Бусад санхүүгийн өглөг

Мөн хоёрдогч өглөг ба давуу эрхийн хувьцаа (өр төлбөр) зэрэг нь санхүүгийн өр төлбөр болох бөгөөд эдгээрийг Санхүүгийн тайланд тусдаа мөрөөр харуулна.

Бусад санхүүгийн бус өр төлбөрт дараах өр төлбөр багтана:

- Цалингийн өглөг, ЭМ, НДШ-ийн өглөг, ХХОАТ-ын өглөг
- Тайлант үеийн орлогын албан татварын өглөг
- Бусад татварын өглөг
- Хойшлогдсон татварын өглөг
- Нийгмийн хөгжлийн сан (өр төлбөр)
- Хуулийн байгууллагаар шийдэгдэж байгаа зүйлсэд байгуулсан нөөц
- Зээлтэй холбоотой хүлээсэн үүрэгт байгуулсан нөөц
- Мөнгөөр төлөгдөх хувьцааны опцион
- Борлуулах зорилготой өр төлбөр
- Хойшлогдсон орлого
- Тэтгэврийн сан (өр төлбөр)
- Түрээсийн хөрөнгийг борлуулаад эргүүлэн түрээслэхтэй холбоотой буцаалтын хойшлогдсон орлого (Түрээсийн хойшлогдсон орлого)

Санхүүгийн ба санхүүгийн бус өр төлбөрийг салгаж тайлагнахыг СТОУС-д шаардсан байдаг. Иймээс бусад санхүүгийн өр төлбөрийг бусад санхүүгийн бус өр төлбөрөөс салгаж тайлагнана.

Бусад санхүүгийн өр төлбөр гэж ихэнхдээ бусад этгээдэд мөнгө ба бусад санхүүгийн хөрөнгийг шилжүүлэхээр хүлээсэн гэрээний үүргийг ойлгоно. Хэрэв мөнгө ба бусад санхүүгийн хөрөнгийг шилжүүлэх гэрээний бус үүрэг хүлээсэн бол энэ нь *санхүүгийн бус өр төлбөр* болно. Санхүүгийн хөрөнгийн дэлгэрэнгүй тодорхойлолтыг НББОУС 32.11-д заасан бөгөөд банк нийтлэг тохиолдол, нөхцөл байдлыг энэ зааврын дагуу өр төлбөрийн ангиллыг тогтоох боломжгүй тохиолдолд уг стандартыг ашиглана.

Бусдад өгөх өглөг нь банкны зээл, хадгаламж, хөрөнгө оруулалт зэргээс бусад үндсэн бус үйл ажиллагааны үр дүнд бусад байгууллага, иргэдийн өмнө хүлээх үүргийг харуулна.

Банкны дотоодод төв, салбаруудын хооронд хийгдэж байгаа төлбөр тооцоогоор үүсэх авлага, өглөгийг *салбар хоорондын тооцооны* дансанд бүртгэнэ.

Банкуудын хооронд хийгдэж буй төлбөр тооцоогоор түр үүсэх авлага, өглөгийг *банк хоорондын клирингийн тооцооны* дансанд бүртгэнэ.

Мөнгөн гуйвуулгын өглөг гэж гуйвуулга хүлээн авагчид олгогдоогүй байгаа гуйвуулгыг хэлнэ.

Ногдол ашгийн өглөг гэж ногдол ашиг олгохоор зарласны дараа хувьцаа эзэмшигчдэд олгохоор хуваарилж, бүртгэсэн ногдол ашгийг хэлнэ.

Хуримтлуулж тооцоолсон өр төлбөр гэж төлөгдөөгүй боловч үүсч бий болсон өр төлбөрийг хэлнэ.

Бусад санхүүгийн өр төлбөрт санхүүгийн өр төлбөрийн өмнөх ангиллуудад багтаагүй, ирээдүйд төлөгдөх тооцооны өглөг, бусад санхүүгийн өр төлбөр багтана.

Цалингийн өглөг нь цалин, хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, амралтын цалин, урамшуулалт цалин, мөнгөн бус хэлбэрээр олгогдож буй тэтгэмж гэх мэт ажилтнуудтай холбоотой зардалд бүртгэсэн өр төлбөрийг хэлнэ.

Нийгмийн хөгжлийн сангийн өр төлбөр гэж ажилтанд банкны зүгээс олгохоор холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу хүлээсэн үүрэг эсвэл үүсмэл үүргийг ойлгоно.

Хуулийн байгууллагаар шийдэгдэж байгаа зүйлсэд байгуулсан нөөц нь банк бусдад хохирол учруулсны улмаас үүссэн хэрэгтэй холбогдуулан хүлээсэн, төлөгдөх магадлалтай өр төлбөрийг хэлнэ.

Зээлтэй холбоотой хүлээсэн үүрэгт байгуулсан нөөц гэж санхүүгийн хүндрэлд орсон зээлдэгчийн зээлийн нөхцлийг хөнгөвчлөхийн тулд гаргасан санхүүгийн баталгаа, бусад хүлээсэн үүрэгтэй холбоотой үүсэх зардалд бүртгэсэн өр төлбөрийг ойлгоно.

Тэтгэврийн сангийн өр төлбөр гэж улсын тэтгэврийн сангаас (хуулийн дагуу цалингаас заавал суутгах эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл) гадуур тэтгэвэр, тэтгэмж олгох зорилгоор хувийн тэтгэврийн сангаар дамжуулан ажилтнууддаа тэтгэвэр, түүнтэй адил төстэй тэтгэмж олгохоор холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу хүлээсэн үүрэг эсвэл үүсмэл үүргийг ойлгоно.

Мөнгөөр төлөгдөх хувьцаанд суурилсан төлбөрийн өглөг гэж мөнгөөр төлөгдөх хувьцаанд суурилсан ажил гүйлгээгээр ажилтнууд болон гадны этгээдэд үзүүлсэн ажил, үйлчилгээний өр төлбөрийг хэлнэ. Хувьцаанд суурилсан төлбөрийг "Өөрийн хөрөнгө" бүлгээс үзнэ үү.

Борлуулах зорилготой өр төлбөр гэж бүлэг хөрөнгийг худалдан борлуулахтай холбоотойгоор үүссэн өр төлбөрийг ойлгоно. Ийм өр төлбөрийн ангиллыг өөрчилж, санхүүгийн тайланд тусад нь тайлагнана.

Хойшлогдсон орлого гэж урьдчилан авсан боловч банкны зүгээс үйлчилгээ үзүүлж дуусах хүртэл хараахан орлого гэж тооцохгүй тул хойшлуулан бүртгэж, тайлант хугацааны орлогод оруулаагүй төлбөрийг хэлнэ.

Хойшлогдсон тусламжийн орлого гэж дараагийн тайлант хугацаанд хэрэгжих төсөлтэй холбогдуулан авсан эх үүсвэрийг хэлэх бөгөөд зарцуулсан тайлант хугацаанд нь үүнийг орлогод хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Хөрөнгөөр өгсөн буцалтгүй тусламжийн хувьд хойшлогдсон тусламжийн орлого нь уг эргэлтийн бус хөрөнгийг олж бэлтгэхтэй холбоотой ба үүнийг уг биет буюу биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаанд хойшлуулан бүртгэнэ. Мөн Монголбанк болон Засгийн газраас олгосон зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй зээлд хамааралтай буцалтгүй тусламж тодорхойлогдож болох ба энэ нь Засгийн газрын буцалтгүй тусламжийн тодорхойлолтонд нийцвэл хойшлогдсон тусламжаар бүртгэн, уг зээлийн хугацаанд хойшлуулна.

Дараах нөхцөлд *түрээсийн хөрөнгийг борлуулаад эргүүлэн түрээслэхтэй холбоотой хойшлогдсон орлого* үүснэ:

- Хэрэв санхүүгийн түрээсийн хөрөнгийг борлуулаад эргүүлэн түрээсэлсэн тохиолдолд борлуулаад түрээсэлж буй тал нь дансны үнээс хэтэрсэн зөрүүг шууд орлого, зардалд бүртгэж болохгүй. Харин түрээсийн хугацаанд хойшлуулан бүртгэж, хорогдуулна.

Хэрэв үйл ажиллагааны түрээсийн хөрөнгийг борлуулаад эргүүлэн түрээсэлсэн тохиолдолд хөрөнгийг худалдсан үнэ ба дансны үнийн зөрүүг уг хөрөнгийг цаашид түрээслэх хугацаанд хойшлуулан бүртгэж, хорогдуулна.

Тайлант үеийн татварын өглөг болон хойшлогдсон татварын өглөгийг "Орлогын албан татвар" бүлэгт тодорхойлсон.

*Бусад санхүүгийн бус өр төлбөр*т ажилтнуудад өгөх өглөг (өөрөөр хэлбэл, цалингийн өглөг, НДШ-ийн өглөгөөс бусад), орлогын албан татвараас бусад төрлийн татварын өглөг багтана.

Хоёрдогч өглөг нь банкыг татан буулгах үед бусад өр төлбөрийг барагдуулсны дараа төлж барагдуулах өр төлбөрийг хэлнэ. Хоёрдогч өглөгийг бусад өглөгийг барагдуулсны дараа төлж барагдуулах тул зээлдэгчийн хувьд эрсдэлтэй бөгөөд өгөөж өндөртэй байдаг (өөрөөр хэлбэл хүүгийн түвшин өндөр). Энэ нь өөрийн хөрөнгийн зохистой харьцаанд тооцогдож хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийн тодорхойлолтыг хангана. Хоёрдогч өглөгийг санхүүгийн тайланд тусдаа мөрөөр харуулна. Зарим төрлийн хоёрдогч өр төлбөрийн хувьд хөрвөх нөхцөл заасан тохиолдолд өр төлбөрийн хугацааны эцэст эсвэл төлбөр барагдуулах өдөр хувьцаа эзэмшигчдийн албан ёсны шийдвэрээр энгийн хувьцаанд хөрвүүлж болно.

В. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

Банк нь гэрээ буюу хэлцэлд зааснаар эсвэл хуулийн дагуу үүрэг хүлээсэн үед холбогдох өр төлбөрийг санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрч, толилуулна. Өр төлбөрийг хүлээн зөвшөөрч, бүртгэхдээ холбогдох зардлыг аккруэл сууриар (СТОУС-д заасны дагуу) хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

Ногдол ашгийн өглөгийг ногдол ашиг зарласан үед хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Тайлант жилийн эцсийн өдрөөс санхүүгийн тайланг албан ёсоор баталгаажуулж гаргах өдрийг хүртэлх хугацаанд зарласан ногдол ашгийг санхүүгийн тайланд дараа үеийн үйл явдлаар тодруулна.

Ажилтнуудын тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой өр төлбөрийг зохих дотоод журам, гэрээний дагуу СТОУС-ын зарчимд нийцүүлэн тайлант хугацаанд зардал, өглөгөөр тус тус хүлээн зөвшөөрнө (НББОУС 19-ийн дагуу аккруэл сууриар бүртгэнэ).

Нийгмийн хөгжлийн санг банкны удирдлагын тушаал, шийдвэрээр эсвэл тухайн тайлант хугацаанд хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн болон үүсмэл үүргийн дагуу хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

НББОУС 37-д заасан хүлээн зөвшөөрөлтийн шалгуур хангагдсан нөхцөлд хуулийн байгууллага, шүүхээр шийдвэрлүүлж байгаа зарга маргаан, түүнтэй адилтгах зүйлсэд байгуулсан нөөцийг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ (өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн, тайлагналын өдрөөр хүлээж буй үүрэг, эдийн засгийн нөөцийн гадагшлах хөдөлгөөн, өр төлбөрийг барагдуулахын тулд гарах мөнгөн гүйлгээ зэрэг нь хийгдэх магадлалтай бөгөөд дүнг нь найдвартай хэмжих боломжтой байх).

Зээлд хамаарах үүрэг үүссэн тайлагналын өдрөөр уг үүрэгтэй холбоотой зээлийн эрсдэл байдаггүй (банк ба эрх эзэмшигчийн хооронд мөнгө шилжихгүй) тул НББОУС 37 ба НББОУС 39-д заасан хүлээн зөвшөөрөлтийн шалгуур хангагдсан нөхцөлд зээлд хамаарах үүрэгт зориулсан нөөцийг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Иймээс дараах хоёр шалгуур зэрэг хангагдах үед нөөцийг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ:

- Гэрээний нөхцлийн дагуу эх үүсвэрийг зарцуулах магадлал тайлагналын өдөр өндөр байгаа (жишээлбэл, нээсэн зээлийн шугамыг ашиглаж зээл олгох, санхүүгийн баталгааны гэрээний дагуу төлбөр хийгдэх)
- Тайлагналын өдрөөр үнэ цэн буурсан буюу банк гэрээний дагуу зээлдэгч/эрх эзэмшигчид урьдчилан олгосон хөрөнгөө бүрэн нөхөж авах боломжгүй гэх бодитой нотолгоо байгаа.

СТОУС 5-д заасан шалгуур хангагдаж байгаа нөхцөлд борлуулах зорилготой өр төлбөрийг борлуулах зориулалттай хөрөнгийн хамт хүлээн зөвшөөрч, бүртгэнэ (үүнийг “Бусад санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгө” бүлэгт оруулсан).

Г. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

СТОУС-д зааснаар өр төлбөрийг барагдуулахаар таамаглаж буй ирээдүйн мөнгөн гүйлгээг дискаунтчилсан өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэх үед өр төлбөр үүсгэж хүлээн авсан хөрөнгийн дүнгээр эсвэл уг өр төлбөрийг барагдуулахад төлөх мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн дүнгээр өр төлбөрийг үнэлнэ.

Өр төлбөрийг анх удаа хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр үнэлнэ. “Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө” бүлэгт дурдсанаар санхүүгийн өр төлбөрийн хувьд ажил гүйлгээний зардлыг анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс хасна. Ихэнх тохиолдолд бодит үнэ цэн нь дайчилсан эх үүсвэрийн дүнтэй тэнцүү байдаг.

Бусад санхүүгийн өр төлбөрийг үр ашигт хүүгийн аргаар тооцоолсон хорогдуулсан өртгөөр үнэлж, санхүүгийн тайланд толилуулна. Хүүтэй өр төлбөрийн хувьд хорогдуулсан өртгийг банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн хорогдуулсан өртгийн адил тооцоолох (Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө” бүлэгт оруулсан жишээг үзнэ үү) ба харин хүүгүй өр төлбөрийн хувьд хорогдуулсан өртөг нь анх хүлээн зөвшөөрсөн төлөгдөөгүй өр төлбөрийн дүнтэй тэнцүү байдаг.

Хойшлогдсон орлого, хуримтлуулан тооцоолсон өр төлбөр, гуйвуулгын өглөгийг төлөх буюу төлөгдсөн дүнгээр үнэлж, бүртгэнэ. Бусад өглөгийг гэрээ, хэлцлийн дагуу төлөх дүнгээр бүртгэнэ.

Нийгмийн хөгжлийн санг ажилтнуудад олгох тэтгэвэр, тэтгэмжийн төлөгдөх дүнгээр зардалд хүлээн зөвшөөрч, өр төлбөр үүсгэн бүртгэнэ. Практик дээр санг тогтмол дүнгээр бус харин банкны захирлуудын зөвлөл буюу бусад удирдах дээд байгууллагын шийдвэрээр жил бүр байгуулна. Нийгмийн хөгжлийн сан нь өр төлбөрийн тодорхойлолтыг хангаж байгаа тохиолдолд үүнийг тайлант жилийн цэвэр ашгаас тооцоолж гаргасан дүнгээр үнэлж, бүртгэнэ (өөрөөр хэлбэл зардал болон холбогдох өр төлбөрийг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ). Хэрэв нийгмийн хөгжлийн сан нь өр төлбөрийн тодорхойлолтыг хангахгүй тохиолдолд банк уг санг хуримтлагдсан ашгаас хуваарилан байгуулах ба энэ үед өр төлбөр үүсч, зардал бүртгэхгүй. Ийм тэтгэмжийг төлөх хуулиар хүлээсэн үүрэг (хуульд заасан эсвэл банкны дотоод журамд заасан тэтгэмжийг заавал олгох ёстой) эсвэл үүсмэл үүрэг байгаа (ажилтнуудын зарим хэсэг нь жил бүр уг тэтгэмжийг авна гэж ажилтнууд таамаглаж байгаа буюу өөрөөр хэлбэл энэ нь банкны гаргах шийдвэрээс шалтгаалах) тохиолдолд л өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Эндээс харахад хуулиар хүлээсэн үүрэгт Монгол улсын хууль, тогтоомжоос гадна банкны дотоод журам, дүрэм, хөдөлмөрийн гэрээнд заасан үүргийг хамруулна. Үүсмэл үүрэг нь хууль, тогтоомж, гэрээ, банкны дотоод журам, дүрэмд заагаагүй хэдий ч өнгөрсөн жилүүдэд олгож байсан тэтгэмжинд үндэслэн тэтгэмж авах талаарх

ажилтнуудын таамаглал болон өмнө нь өгч байсан тэтгэмжийг үргэлжлүүлэн өгөх тухай банкны шийдвэртэй холбоотойгоор үүссэн үүрэг юм.

Банк тэтгэмж өгөх үүрэг хүлээгээгүй хэдий ч өөрийн шийдвэрээр тэтгэмж олгох боломжтой нөхцөлд өр төлбөрийг хүлээн зөвшөөрч, бүртгэхгүй. Энэ тохиолдолд банк уг санг хуримтлагдсан ашгаас хуваарилж, өөрийн хөрөнгийн дансанд бүртгэж болно.

Дебит: Хуримтлагдсан ашиг
Кредит: Нийгмийн хөгжлийн сан (Өөрийн хөрөнгө)

Нийгмийн хөгжлийн сан нь янз бүрийн төрлийн тэтгэвэр, тэтгэмжээс бүрдсэн байдаг ба тэтгэмжийн төрлөөс шалтгаалан түүний бүртгэл янз бүр байж болно. Иймд тэтгэмжийн төрлүүдэд ялгаатай стандартууд мөрдөгдөнө. Тэтгэмжийг өр төлбөр эсвэл өөрийн хөрөнгийн сангаар бүртгэхэд аль алинд нь СТОУС-ын дагуу шинжилгээг хийж гүйцэтгэнэ.

Тэтгэвэр, шагнал (жишээлбэл, тодорхой ойн тэмдэглэлт баярыг тохиолдуулан ажилтнуудад олгож буй шагнал, урамшуулал) гэх мэт урт хугацааны тэтгэмж нь Монгол улсын хууль, тогтоомжийн дагуу заавал төлөх тэтгэмж болох тул НББОУС 19 “Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж”-д хамаарна. Ажилтнуудад олгох урт хугацаат тэтгэмж гэж уг тэтгэмжийг ажилтнуудад олгохоор бүртгэсэн тайлант жилийн эцсээс хойш 12 сарын дотор төлөхгүй тэтгэмжийг ойлгоно. Урт хугацаат тэтгэмжийг бүртгэхдээ цаг хугацааны үнэ цэнийн зөрүүг мэдэгдэхүйц их гэж үзэж байгаа тохиолдолд ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнээр үнэлнэ. НББОУС 19-ын дагуу тэтгэмж ба шагнал, урамшууллыг банкны ажилтнуудын ажлаас гарах магадлалыг харгалзан ирээдүйн хугацаанд хамаарах тэтгэмжийн өглөг буюу шагнал, урамшууллын өглөгийн өнөөгийн үнэ цэнд үндэслэн хүлээн зөвшөөрч, бүртгэсэн урт хугацаат тэтгэмжийн дүнг тайлант хугацаа бүрийн төгсгөлд үнэлж байна. Мөн төсөвлөсөн нэгжийн кредитийн аргаар өр төлбөрийг тооцоолохдоо зарим урт хугацаат тэтгэмжийн нарийн нийлмэл байдал, хэмжээг цалингийн өсөлт, инфляци зэрэг актуар тооцооллыг ашиглана.

Хүлээн зөвшөөрсөн өр төлбөрийн дүн нь тайлагналын өдрөөрх тогтоосон тэтгэмжийн өр төлбөрийн өнөөгийн үнэ цэнээс хэрэгжээгүй актуар олз, гарз болон төсөвлөсөн нэгжийн кредитийн аргаар тооцсон өнгөрсөн үйлчилгээний зардлыг хасч тодорхойлогдоно. Өнөөгийн үнэ цэнийн тооцоололд тохирох актуарыг ашиглана. Уг дүнг заавал актуар тооцоололд үндэслэх албагүй бөгөөд харин банкны удирдлагаас (банкны гүйцэтгэх удирдлага, захирлуудын зөвлөл) баталсан, төлбөр хийх хүртэлх хугацааны туршид тооцоолсон ирээдүйн төлбөрийн талаарх харьцангуй нарийвчлал багатай үнэлгээнд үндэслэж болно.

Ажилтнуудын урт хугацаат тэтгэмжээс гадна ажилтнуудыг орон сууц худалдан авахад тусламж үзүүлэх, хоол унааны тэтгэмж, байр сууцны тэтгэмж гэх мэт өөр зориулалт бүхий нийгмийн хөгжлийн сан байж болно. Аливаа тэтгэмж нь НББОУС 19-д багтсан богино хугацааны тэтгэмж (хоол унааны тэтгэмж, сар бүрийн байр сууцны тэтгэмж гэх мэт) болох эсэх эсвэл орон сууц худалдан авах тэтгэмж гэх мэт тодорхой бус дүнтэй өр төлбөр буюу нөөц болох эсэхийг банк шинжилнэ.

Дээрх зорилгоор өр төлбөр үүсгэж, бүртгэхийн (Дебит: Холбогдох үйл ажиллагааны зардал, Кредит: Нийгмийн хөгжлийн сангийн өр төлбөр) тулд дээр дурдсанчлан өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөдөр үүрэг хүлээсэн байх шаардлагатай. Өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүсч, тайлагналын өдрөөр мөрдөх хууль эрхзүйн болон үүсмэл үүргийн хувьд банк СТОУС-ын дагуу өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй. Гэхдээ дээрх зорилгоор банк өөрийн хөрөнгийн санг хуримтлагдсан ашгаас хуваарилан байгуулахаар шийдвэрлэж болно.

Богино хугацаат тэтгэмжийн хувьд түүний бүртгэл нь цалин хөлсийн бүртгэлтэй адил хийгдэх буюу, өөрөөр хэлбэл тайлант хугацааны эцсийн байдлаар нийгмийн хөгжлийн сангийн дүнд дараагийн тайлант хугацаанд төлөгдөх дүнгүүд зөвхөн багтах ба өр төлбөр ч үүсэхгүй байж болно (тухайн тайлант хугацаанд хамаарах бүх тэтгэмжийг урьдчилаад төлсөн тохиолдолд). Энэ нь банкны ажилтнуудын ажилласан хугацаанд нь багтаан зардалд бүртгэх цалин хөлс, цалинтай холбоотой бусад зардал (амралтын цалин, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, шагнал, урамшуулал, мөнгөн бус тэтгэмж) -ын бүртгэлд мөн үйлчилнэ.

Банк нөөц үүсгэж бүртгэх шаардлагатай тохиолдолд ирээдүйн тайлант хугацаа бүрийн эцэст төлөгдөх дүнг үнэлж, үүнийг тэтгэмж олгогдож дуусах хүртэлх төлөвлөж буй хугацаанд хуваарилна. Үүнийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзэх ба ингэснээр цаг хугацаа өнгөрөхөд тэтгэмжийн дүн, төлбөрийн хугацаа өөрчлөгдвөл уг өөрчлөлтийг НББОУС 8-ын дагуу орлого, зардалд бүртгэнэ.

Банк хадгаламж буюу бусад эх үүсвэр (хоёрдогч өглөг, Монголбанк, Засгийн газар, олон улсын

санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийг оруулсан)-ийг ямар нөхцөлтэйгээр татан төвлөрүүлсэн талаарх шинжилгээг хийнэ. Банк дайчилсан эх үүсвэрийн хувьд валютын төрөл, дуусгавар хугацаа, барьцаа хөрөнгө, хүүгийн түвшинтэй холбоотой шинжилгээ хийнэ. Үүнийг тогтоох суурь нь "Зээл" бүлэгт дурдсанаар НББОУС 39-ийн хэрэгжүүлэх удирдамж бөгөөд НББОУС 39-ийн ХУ77-д зааснаар зах зээлийн гүйлгээ нь санхүүгийн хэрэгсэл ба өр төлбөрийг үүсгэх бөгөөд энэ нь тухайн санхүүгийн хэрэгсэл ба өр төлбөрийн бодит үнэ цэнийг үнэлэх суурь нь болно. Ялангуяа, өрийн хэрэгслийн хувьд түүнийг гаргах үеийн зах зээлийн нөхцөл байдал эсвэл ижил төстэй хэрэгслийн зах зээлийн нөхцөл ба хүүгийн түвшинг (өөрөөр хэлбэл, үлдэж буй дуусгавар хугацаа, мөнгөн төлбөрийн онцлог, валютын төрөл, зээлийн эрсдэл, барьцаа хөрөнгө, хүүгийн суурь) үндэслэн бодит үнэ цэнийг нь тогтооно. Хэрэв тодорхой эх үүсвэрийн хүүгийн түвшин нь зах зээлд давамгайлж буй ижил төстэй эх үүсвэрийн хүүгийн түвшнээс ялгаатай байгаа тохиолдолд тодорхой нөхцөл хангагдаагүй бол эх үүсвэрийн бодит үнэ цэнийг авсан мөнгөн гүйлгээний дүнтэй тэнцүү гэж үзэхгүй бөгөөд өр төлбөрийг анх удаад хүлээн зөвшөөрөхдөө ямар нэгэн орлого, зардал бүртгэхгүй. Иймээс банк зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй эх үүсвэр татан төвлөрүүлсэн тохиолдолд өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөх үед орлого хүлээн зөвшөөрч, бүртгэнэ (банк уг орлогыг шууд орлогод бүртгэх үү эсвэл буцалтгүй тусламжийн тодорхойлолтыг хангаж байгаа бол зээлийн хугацаанд хойшлуулан бүртгэх эсэхийг нэмж шинжилнэ). Эх үүсвэрийг зах зээлийн хүүгээс дээгүүр хүүтэйгээр татан төвлөрүүлсэн тохиолдолд өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхтэй хамт зардал хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Гэхдээ практик дээр зах зээлийн хүүгээс дээгүүр хүүтэй эх үүсвэр дайчлах нь их ховор тохиолддог. "Зээл" бүлэгт оруулсан жишээгээр зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй эх үүсвэрт мөн ашиглаж болох тайлбарыг оруулсан ба гагцхүү журналын бичилт нь л өөр байх болно.

Зах зээлийн хүүгээс ялгаатай хүүгийн жишээнд Монгол улсын засгийн газар, олон улсын санхүүгийн байгууллагаас олгож буй, харьцангуй бага хүүтэй, урт хугацаат зээлийн эх үүсвэр орно. Энэ тохиолдолд банк нь уг эх үүсвэрийг анх удаад хүлээн зөвшөөрч, бүртгэх, ямар орлого, зардалд хүлээн зөвшөөрөх болон түүнд хамаарах хөрөнгийг бүртгэх талаар бодлоготой байна. Дараах нөхцөл хангагдсан тохиолдолд тусгай хүүтэй эх үүсвэрийг хүлээн зөвшөөрч болно:

- Монгол улсын Засгийн газар, олон улсын санхүүгийн байгууллагаас олгож буй, харьцангуй бага хүүтэйгээр олгож буй зээлийн эх үүсвэр;
- Банк эх үүсвэрийг зээлдүүлэгчдийн тогтоосон харилцагчдад тусгай нөхцлөөр хүргэх буюу өөрөөр хэлбэл зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй зээлийн эх үүсвэрийг тодорхой салбар эсвэл харилцагчдад (тухайлбал, жижиг дунд аж ахуйн нэгж, бага орлоготой иргэд гэх мэт) зах зээлийн хүүгээс доогуур хүүтэйгээр зээлдүүлж байгаа;
- Зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй зээлийн эх үүсвэрээр зах зээлийн хүүгээс доогуур хүүтэйгээр (харилцагч зээлдэгчдэд) олгож буй зээлийг санхүүжүүлж байгаа бол; үүнийг тодорхой шалгуурыг хангасан харилцагчид олгож, тодорхой төрлийн зээлийн сегмент (тусгай зах зээл) гэж үзнэ;
- Эх үүсвэр байршуулж буй талтай хийсэн гэрээнд түүний ашиглалтын талаар тодорхой заалтууд орсон байх (өөрөөр хэлбэл, тодорхой харилцагч эсвэл секторт, тогтсон хүүтэйгээр зээлдүүлэх, олгох зээлийн хүүгийн түвшин болон ерөнхий нөхцөл нь хөнгөлөлттэй байх гэх мэт); банк зээлийн зарцуулалтыг хянаж, гэрээний заалтууд биелэгдэж байгаа эсэх талаар зээлдүүлэгчдэд мэдээлнэ.

Энэ тохиолдолд дээрх нөхцлийг хангасан бөгөөд жилийн санхүүгийн тайланд банкны удирдлагын зүгээс гаргасан шийдвэрийн талаар тодруулснаар өр төлбөрийг анх удаад хүлээн зөвшөөрөх үед үүссэн орлого, түүнтэй холбоотой хөрөнгийг анх удаад хүлээн зөвшөөрөх үед үүссэн зардлыг бүртгэхгүй (хэрэв орлого, зардлыг бүртгэсэн бол эдгээрийг хооронд нь хааж, цэвэршүүлнэ).

Монгол улсын Засгийн газар, олон улсын санхүүгийн байгууллагаас олгож буй зээлийн эх үүсвэрээс гадна эх үүсвэр зээлийн хооронд тодорхой холбоо байгаа тохиолдол, тухайлбал: зах зээлийн тусгай сегментэд хандсан Засгийн газрын тодорхой хөтөлбөрүүд (үнэ тогтворжуулах хөтөлбөр, моргежийн зээлийн хөтөлбөр гэх мэт) байж болно. Гэхдээ энэ тохиолдолд нөхцөл өөрчлөгдсөнөөр СТОУС-ын дагуу өөр нөхцөл байдал үүсч болзошгүй тул банк зээлийн гэрээ ба Засгийн газрын хөтөлбөрийг байнга үнэлж, шинжилж байх нь зүйтэй.

Хэрэв зээлийн эх үүсвэр нь дээрх нөхцлийг хангахгүй бол үүнийг анх хүлээн зөвшөөрөх үед орлого (ховор тохиолдолд гарз үүснэ) бүртгэнэ. Банк эх үүсвэрийг өөрийн шийдвэрээр зарцуулах эрхтэй байдаг (өөрөөр хэлбэл зээлийн гэрээнд ямар нэгэн хязгаарлалт тавигдаагүй) бөгөөд уг эх үүсвэрийг ашиглан харилцагчдад зах зээлийн хүүтэй зээл олгох шийдвэр гаргах боломжтой буюу харилцагчдад олгож буй зээлийн гэрээнд доогуур хүүтэй байх талаар огт дурдагдаагүй үе тохиолддог (жишээлбэл, тусгай сегмент оршин байгаа хэдий ч банк уг тусгай хөтөлбөрт хамрагдсанаар үүсэх эдийн засгийн өгөөжийг харгалзан

шийдвэр гаргах бүрэн эрхтэй байж болно).

Зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй зээлийг анх удаад хүлээн зөвшөөрөх үеийн орлогыг дараах байдлаар тооцоолно. Эхлээд зээлийн өнөөгийн үнэ цэнийг тооцохдоо зээлийн ашиглалтын хугацаанд төлөгдөх төлбөрийг зах зээлийн хүүгийн түвшнөөр дискаунтчилж гаргана. Өнөөгийн үнэ цэнийн энэ дүнг зээлийг анх бүртгэсэн дүнтэй харьцуулж, эдгээрийн ялгавраар анх хүлээн зөвшөөрөх үеийн орлогыг тооцоолно. Уг орлогын дүнг зээлийн хугацаанд хуваарилж, хүүгийн зардалд шингээнэ (зах зээлийн хүүгийн түвшин нь нэрлэсэн хүүгээс өндөр байдаг). Зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй бусад бүх төрлийн зээлд үүнтэй ижил тооцооллыг гүйцэтгэх ба харин дансны харилцаа нь ялгаатай байна (“Зээл” Бүлгийн жишээг үзнэ үү).

Анх хүлээн зөвшөөрөх үеийн орлогыг зээлийн эх үүсвэрийн ашиглагдах хугацаанд хуваарилах эсвэл шууд орлогод бүртгэх эсэх нь уг эх үүсвэр буцалтгүй тусламжийн тодорхойлолтонд нийцэж байгаа эсэхээс шалтгаална. Энэ нь ялангуяа Засгийн газар, Монголбанкнаас авч буй эх үүсвэрт илүү хамааралтай. НББОУС 20.10А-д зааснаар зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй Засгийн газрын зээлд багтсан тусламжийг Засгийн газрын буцалтгүй тусламжаар бүртгэнэ. Зээлийг НББОУС 39 Санхүүгийн хэрэгсэл: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийн дагуу үнэлж, бүртгэдэг учир зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй авсан дүн нь хүлээн авсан дүн ба НББОУС 39-д нийцүүлэн тооцоолсон дансны анхны дүнгийн зөрүүгээр тодорхойлогдоно. Банк нөхөн олгохоор төлөвлөж буй зээлийн тусламжийн өртгийг тогтоохдоо холбогдох нөхцөл байдал, биелүүлэх ёстой үүргийг анхаарна.

НББОУС 20.3-д зааснаар Засгийн газрын тусламж гэдэг нь тодорхой шалгуурыг хангасан аж ахуйн нэгж эсвэл хэд хэдэн аж ахуйн нэгжид эдийн засгийн тусгай өгөөжийг хүртээх зорилготой засгийн газрын үйл ажиллагаа юм. Засгийн газрын буцалтгүй тусламж нь аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбоотой өнгөрсөн болон ирээдүйн хугацаанд дагаж мөрдөх тодорхой нөхцөлтэйгөөр нөөц хэлбэртэйгээр шилжүүлсэн Засгийн газрын туслалцаа юм. НББОУС 20-д заасан засгийн газрын буцалтгүй тусламжийн нөхцлийг биелүүлэхийн тулд эх үүсвэрийн гэрээнд тусгай нөхцлүүдийг оруулна (жишээлбэл, тодорхой сектор, харилцагчийн сегментийн зээлийн нөхцөлд тавигдах тусгай шалгуур, зээлдүүлэгч нь Засгийн газрын байгууллага байх буюу Засгийн газар, түүний байгууллагуудын хамтын ажиллагааны нэг хэсэг байх шалгуур). Хэрэв буцалтгүй тусламжийн шалгуурыг биелүүлсэн тохиолдолд анх удаа хүлээн зөвшөөрөх үеийн орлогыг хойшлуулан бүртгэж, зээлийн хугацаанд хүлээн зөвшөөрнө.

Ийм ажил гүйлгээг зохих ёсоор бүртгэхийн тулд НББОУС 20-д заасан тусгай нөхцлүүдийг анхаарна. Нэгдүгээрт, бодит үнэ цэнээр илэрхийлэх мөнгөн бус тусламжийг оруулсан Засгийн газрын буцалтгүй тусламжийг дараах ул үндэслэлтэй нотолгоог бий болох хүртэл хүлээн зөвшөөрч, бүртгэхгүй: а) буцалтгүй тусламжинд хамаарах нөхцлийг банк хангаж ажиллах; б) банк буцалтгүй тусламжийг авсан байх. Тусламжийг биетээр хүлээн авсан байх нь дангаараа үндэслэлтэй нотолгоо болж чадахгүй. Мөн Засгийн газрын буцалтгүй тусламжаар нөхөн төлөгдөхөөр төлөвлөж буй зардалтай холбоотойгоор зарлагыг хүлээн зөвшөөрөх хугацаанд буцалтгүй тусламжийг системтэйгээр хуваарилан орлогод бүртгэнэ.

Тусламжийг анх удаа хүлээн зөвшөөрөх үед бодит үнэ цэнийн зөрүүг хойшлогдсон тусламжийн орлогод бүртгэх ба холбогдох буцалтгүй тусламжийг (зээлийн хугацаанд хуваарилсан) уг зээлийн хүүгийн нэмэлт зардлыг бууруулах замаар цэвэршүүлэн бүртгэх буюу эсвэл “Үйл ажиллагааны бусад орлого”-ын тусламжийн орлогын дансанд салгаж бүртгэнэ. Тусламжийн орлогыг цэвэршүүлэн бүртгэж байгаа нөхцөлд хүүгийн зардлыг бууруулсан Засгийн газрын буцалтгүй тусламжийн дүнг жилийн санхүүгийн тайлангийн тодруулгад харуулна. Түүнчлэн тусламжийн орлогыг хуваарилахдаа нэмэлт хүүгийн зардал ба тусламжийн орлого байнга ижил гардаг үр ашигт хүүгийн арга болон нэмэлт хүүгийн зардал ба тусламжийн орлого ялгаатай гардаг шулуун шугамын аргын алийг нь ч ашиглаж болно.

Засгийн газраас олгосон зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй зээлийн бүртгэлийг харуулсан жишээг доор оруулав.

Жишээ: Засгийн газраас авсан хүүгүй зээл

Банк нь аж үйлдвэрлэлийг дэмжих бүс нутагт байрладаг тул Засгийн газрын агентлагаас 500,000 төгрөгийн хүүгүй зээл авсан. Уг зээлийг 3 жилийн дараа эргүүлэн төлнө. Ийм зээлийн зах зээлийн жилийн хүү нь 3.5% байсан.

Засгийн газраас авсан зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй энэ зээлийг НББОУС 39-ийн дагуу үнэлж, бүртгэнэ. Зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй зээлд багтсан буцалтгүй тусламжийг НББОУС 39-д нийцүүлэн тодорхойлсон анхны өртөг ба авсан мөнгөний зөрүүгээр тодорхойлно (НББОУС 20.10А).

НББОУС 39-ийн дагуу тооцоолсон бодит үнэ цэн 450,000 төгрөг гарсан бол уг зээлийг анхны удаад

бодит үнэ цэн болох 450,000 төгрөгөөр бүртгэнэ (С500,000/(1+0.035)^3). Зээлийн бодит үнэ цэн ба авсан мөнгөний хоорондох зөрүү болох 50,000 төгрөгийг НББОУС 20-ын дагуу засгийн газрын буцалтгүй тусламжаар бүртгэнэ.

Зээлийг анх удаа хүлээн зөвшөөрөх үеийн олзыг дараах байдлаар бүртгэнэ:

Дебит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	500,000
Кредит: Бусад эх үүсвэр	450,000
Кредит: Хойшлогдсон тусламжийн орлого	50,000

Эхний жилийн төгсгөлд хүүгийн зардал болон тусламжийн орлогыг дараах байдлаар бүртгэсэн:

Дебит: Хүүгийн зардал	15,750
(450,000-иас 3.5%иар бодож хорогдуулсан дүн)	
Кредит: Бусад эх үүсвэр	15,750
Дебит: Хойшлогдсон тусламжийн орлого	15,750
Кредит: Тусламжийн орлого	15,750

Тусламжийн орлогыг үр ашигт хүүгийн аргаар хуваарилах ба ингэснээр Орлогын тайланд үзүүлэх үр нөлөөлөл огт байхгүй болно. Мөн үүнийг шулуун шугамын аргаар хуваарилж болох (жил тутамд 16,667 төгрөг) ба энэ тохиолдолд тусламжийн орлого ба хүүгийн зардал зөрүүтэй гарна.

2 ба 3 дахь жилийн хувьд ижилхэн журналын бичилт хийх боловч дүнгүүд нь бага зэрэг зөрүүтэй байх болно. Тухайлбал: 2 дахь жилийн хүүгийн зардал 16,300 төгрөг болох ба үүнийг 465,750-аас 3.5%-иар тооцоолж гаргасан. Тухайн зээл хүүтэй байсан бол зах зээлийн хүүгийн түвшин ба нэрлэсэн хүүгийн түвшний зөрүүгээр нэмэгдэл хүүгийн зардлыг тодорхойлох байсан.

НББОУС 39-ийг зээлд буцааж хэрэглэх үед өнгөрсөн хугацааны бодит үнэ цэнийг тооцоолох шаардлагатай тавигдаж буй талаар НББОУСЗ анхааруулсан. Иймд НББОУСЗ уг нэмэлт өөрчлөлтийг 2009 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр ба түүнээс хойш тайлант хугацаанд мөрдөх шийдвэр гаргасан.

Хэрэв буцалтгүй тусламжийн тодорхойлолтыг хангахгүй бөгөөд тусдаа сегментийн тайлбарыг ашиглаагүй тохиолдолд уг эх үүсвэрийг хувьцаа эзэмшигчид (толгой компани) татан төвлөрүүлээгүй тохиолдолд зээлийг анх удаа хүлээн зөвшөөрөх үеийн орлогыг шууд орлогод бүртгэнэ. Хүүгийн зардлыг зээлийн хугацаанд зах зээлийн хүүгийн түвшинд хүлээн зөвшөөрнө.

Дээрх жишээний хувьд үүнийг дараах байдлаар бүртгэнэ. Анх удаа хүлээн зөвшөөрөх үеийн орлогыг бүртгэхдээ:

Дебит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	500,000
Кредит: Бусад эх үүсвэр	450,000
Кредит: Өр төлбөрийг зах зээлийн хүүгээс доогуур түвшинд анх удаад хүлээн зөвшөөрсний орлого*	50,000

*Анх удаа хүлээн зөвшөөрөх үеийн орлого нь үйл ажиллагааны бусад орлогод хамаарна.

Эхний жилийн төгсгөлд хүүгийн зардлыг дараах байдлаар бүртгэнэ:

Дебит: Хүүгийн зардал	15,750
(450,000-иас 3.5%-иар бодож хорогдуулсан дүн)	
Кредит: Бусад эх үүсвэр	15,750

2 ба 3 дахь жилийн хувьд ижилхэн журналын бичилт хийх боловч дүнгүүд нь бага зэрэг зөрүүтэй байх болно. Тухайлбал, 2 дахь жилийн хүүгийн зардал 16,300 төгрөг болох ба үүнийг 465,750-аас 3.5%-иар тооцоолж гаргасан. Тухайн зээл хүүтэй байсан бол зах зээлийн хүүгийн түвшин ба нэрлэсэн хүүгийн түвшний зөрүүгээр нэмэгдэл хүүгийн зардлыг тодорхойлох байсан.

Зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй зээлийн эх үүсвэрийг хувьцаа эзэмшигчдээс (толгой компани) татан төвлөрүүлж байгаа тохиолдолд анх удаа хүлээн зөвшөөрөх үеийн орлогыг “Бусад өөрийн хөрөнгө”-өөр ангилсан дансанд өмчийн хуваарилалт байдлаар бүртгэнэ.

Дебит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	500,000
Кредит: Бусад эх үүсвэр*	450,000
Кредит: Бусад өөрийн хөрөнгө – Бусад (36900000)	50,000

Эхний жилийн төгсгөлд хүүгийн зардлыг дараах байдлаар бүртгэнэ:

Дебит: Хүүгийн зардал	15,750
(450,000-иас 3.5%иар бодож хорогдуулсан өртөг)	

Кредит: Бусад эх үүсвэр	15,750

Банк зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй зээлд хамааралгүйгээр буцалтгүй тусламж авч болно. Тухайлбал, банк ашгийн бус төслийг санхүүжүүлэх зорилгоор Засгийн газар, дотоодын болон олон улсын бусад байгууллагаас эх үүсвэр авсан байж болно. Банк уг эх үүсвэрийг урьдчилан тодорхойлж, эдгээр байгууллагатай тохиролцсон зорилгоор зарцуулах тул үүнийг тусгай зориулалттай гэж үзнэ. Нэгэнт уг эх үүсвэр нь тусгай зориулалттай тул банк уг эх үүсвэрийг аваад тусгай зориулалтаар зарцуулах хүртэл өр төлбөрөөр (хойшлогдсон тусламж) бүртгэнэ. Энэ нь ирээдүйн тайлант хугацаанд хэрэгжих төсөлд хамаарах эх үүсвэрийг санхүүгийн тайланд хойшлогдсон тусламжаар бүртгэнэ гэсэн үг юм. Хойшлогдсон тусламжаар бүртгэсэн эх үүсвэрийг тухайн төслийн хүрээнд гарсан зардалтай уялдуулан тайлант хугацаануудад хуваарилж, орлогод бүртгэх буюу өөрөөр хэлбэл банк төслийн хүрээнд гарсан зардлын дүнгээр тусламжийн орлогыг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

Жишээ: Үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх буцалтгүй тусламж

Банк 20X1 онд буурай хөгжилтэй бүс нутгийн хувийн жижиг аж ахуйн нэгжүүдэд туслалцаа үзүүлэх зорилгоор 500,000 төгрөгийн мөнгөн хэлбэрийн буцалтгүй тусламж авсан. Энэхүү тусламжийг гэрээнд заасан зориулалтаар зарцуулах ба зарцуулагдаагүй үлдэгдлийг буцааж өгнө. Банкны удирдлагын үзэж байгаагаар энэ төсөлд оролцоноор банкны нийгмийн хариуцлага нэмэгдэх юм. 20X1 онд 200,000 төгрөгийг тогтсон зориулалтаар зарцуулсан. Үүнийг дараах байдлаар бүртгэнэ:

Эх үүсвэрийг авах үед (тусгай төслийн зориулалтаар эх үүсвэрийг зарцуулахын өмнө):

Дебит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	500,000
Кредит: Хойшлогдсон тэтгэмжийн орлого	500,000

Эх үүсвэрийг зарцуулах үед:

Дебит: Бусад зардал (хандив тусламж ба бусад)	200,000
Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	200,000
Дебит: Хойшлогдсон тэтгэмжийн орлого	200,000
Кредит: Тэтгэмжийн орлого	200,000

Үүний үр дүнд банкны 20X1 оны ашиг өөрчлөгдөхгүй. Банк 20X1 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайланд 300,000 төгрөгийн хойшлогдсон тусламжийн орлогыг тайлагнана (500,000-аас хасах нь 200,000).

Жишээ: Үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх буцалтгүй тусламж

Зарим тохиолдолд банк өөрийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх хэлбэрээр (тухайлбал, мэргэжлийн тодорхой үйлчилгээ, тусгай төсөл гэх мэт) эх үүсвэрийг авсан байж болно. Ийм тусламжийг орлогод хамаарах тусламж гэж үзэх ба түүний бүртгэл нь өмнөх жишээний буюу төлөгдөхөөр төлөвлөж буй тусламжийн хэмжээгээр зардлыг бүртгэх хугацаанд тусламжийн орлогыг тодорхой аргаар орлогод бүртгэх тусламжийн бүртгэлтэй ижил байна. Иймд авсан эх үүсвэрийг анхны удаад хойшлуулан бүртгээд дараа дараагийн тайлант хугацаанд зарлага гарсан даруйд орлогод хүлээн зөвшөөрч, санхүүгийн тайланд толилуулна. Дээрх жишээтэй харьцуулахад гол ялгаа нь үйл ажиллагааны зардал болох тусгай дансанд бүртгэж байгаа явдал юм (бусад бичилтүүд нь ижил байна).

Эх үүсвэрийг зарцуулах үед:

Дебит: Мэргэжлийн бусад үйлчилгээ (эсвэл холбогдох бусад данс)
200,000
Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө эсвэл Дансны өглөг (эсвэл холбогдох бусад данс)
200,000

Тусламжийн орлогыг Монголбанкинд сар бүр илгээх санхүүгийн тайланд үйл ажиллагааны бусад орлогоор харуулна. НББОУС 20-д буцалтгүй тусламжийн орлогыг тайлагнан харуулах мөрийн зүйлийг сонгох сонголт багтсан байдаг буюу өөрөөр хэлбэл тусламжийн орлогыг бусад орлогоор эсвэл холбогдох зардлыг бууруулан харуулах байдлаар (холбогдох зардалтай цэвэршүүлэн тайлагнах) тайлагнаж болно. Тэгэхээр уг орлогыг хэрхэн харуулах нь банкны удирдлагын шийдвэрээс хамаарах ба бүртгэх аргыг хэрхэн сонгосон талаараа банк санхүүгийн тайлангийн тодруулгад тайлбарлан нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэсэгт тусгах ба уг сонгосон бодлогоо тууштай мөрдөнө. Буцалтгүй тусламжийг бүртгэлийн бодлогодоо тодруулахдаа жилийн санхүүгийн тайланд ашигласан толилуулгын аргыг

тайлбарласан байна. Мөн тусламжийг тайлагнасан байдал нь орлого, зардалд хэрхэн нөлөөлсөн талаар тусгайлан тодруулна (НББОУС 20.29, НББОУС 20.31, НББОУС 20.39).

Банк хөрөнгө олж бэлтгэхтэй холбоотойгоор тусламж авч болно (өөрөөр хэлбэл хөрөнгөтэй холбоотой тусламж). Ийм тусламж авсан банк эргэлтийн бус хөрөнгө (биет бус ба биет хөрөнгө) худалдан авах буюу олж бэлтгэх ба үүний үр дүнд санхүүгийн тайланд хойшлогдсон тусламжийн орлогыг бусад санхүүгийн бус өр төлбөрөөр харуулна. Ийм тусламжийг холбогдох биет ба биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаанд хойшлуулан бүртгэж, холбогдох хөрөнгийг элэгдүүлэх буюу хорогдуулахтай зэрэгцэн орлогод шилжүүлэн хүлээн зөвшөөрнө.

Жишээ: Хөрөнгө худалдан авахад зориулсан буцалтгүй тусламж

600,000 төгрөгийн буцалтгүй тусламж авах үед (хөрөнгө худалдан авахаас өмнө):

Дебит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	600,000
Кредит: Хойшлогдсон тэтгэмжийн орлого	600,000

Эх үүсвэрийг зарцуулах үед (900,000 төгрөгөөр компьютер худалдан авсан ба үүний 600,000 төгрөгийг буцалтгүй тусламжийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн):

Дебит: Компьютер, дагалдах хэрэгсэл	900,000
Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	900,000

Уг үндсэн хөрөнгийг жилийн эхээр худалдан авсан ба 3 жилийн ашиглалтын хугацаатай тохиолдолд жилийн элэгдлийн зардал нь 300,000 (900,000төгрөг/3жил) төгрөг болох ба 200,000 (600,000төгрөг/3жил) төгрөгийн тэтгэмжийн орлогыг жил бүр (20X1, 20X2, 20X2 онуудад) дараах байдлаар бүртгэнэ:

Дебит: Хуримтлагдсан элэгдэл ба үнэ цэнийн бууралт	300,000
Кредит: Компьютер, дагалдах хэрэгсэл	300,000

Дебит: Хойшлогдсон тэтгэмжийн орлого	200,000
Кредит: Тэтгэмжийн орлого	200,000

Үүний үр дүнд хөрөнгийн ашиглалтын хугацаа дуусахад үндсэн хөрөнгө ба хойшлогдсон тусламжийн орлогын дансны үлдэгдэл тэг болно.

НББОУС 20-д зааснаар хөрөнгөтэй холбоотой Засгийн газрын буцалтгүй тусламжийг санхүүгийн тайланд хойшлогдсон орлогоор (Монголбанкинд сар бүр хүргүүлэх санхүүгийн тайланд энэ хувилбараар харуулна) эсвэл хөрөнгийн үлдэгдэл дүнг тусламжийн дүнгээр бууруулах замаар тус тус харуулж болно. Үүний үр дүнд хөрөнгөтэй холбоотой тусламжийг санхүүгийн тайланд хоёр аргаар харуулах нь жилийн эцсийн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч болох нөхцөл юм. Эхний аргыг сонгосон тохиолдолд тусламжийг хойшлогдсон тусламжийн орлогод бүртгэж, хөрөнгийн ашиглалтын хугацаанд системтэйгээр хуваарилан орлогод хүлээн зөвшөөрөх бол харин хоёрдахь аргын дагуу хөрөнгийн дансны үлдэгдлийг бууруулан бүртгэнэ. Хоёрдахь аргын үед элэгдүүлэх хөрөнгийн ашиглалтын хугацаанд тусламжийг элэгдлийн зардлаар бууруулан бүртгэнэ. Орлогод хамаарах тусламжийн хувьд уг орлогыг хэрхэн харуулах нь банкны удирдлагын шийдвэрээс хамаарах ба аль аргыг хэрхэн сонгосон талаараа банк жилийн эцсийн санхүүгийн тайландаа тайлбарлан нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэсэгт тусгах ба уг сонгосон бодлогоо тууштай мөрдөнө.

Буцалтгүй тусламжинд хамаарах нөхцлийг банк бүрэн хангасан гэх үндэслэлтэй нотолгоо байгаа бөгөөд тусламжийг хүлээн авах хүртэл тусламжийг бүртгэлд тусгахгүй. Тусламжийг биетээр хүлээн авсан байх нь дангаараа үндэслэлтэй нотолгоо болж чадахгүй тул банк үүнийг өр төлбөрөөр бүртгэнэ (хойшлогдсон тусламжийн орлого).

Шүүх, хуулийн байгууллагаар шийдүүлэх зарга маргаан, түүнтэй адилтгах зүйлсэд байгуулсан нөөцийг санхүүгийн тайланг баталгаажуулах хугацаанд олдсон мэдээлэлд үндэслэн тооцоолсон мөнгөн дүнгээр бүртгэнэ. Нөөцийн дүнг тайлант хугацааны эцэст дахин үнэлж, нөөцийн үлдэгдэлд гарсан өөрчлөлтийг орлого, зардалд бүртгэнэ (нягтлан бодох бүртгэлийн алдаанаас бусад тохиолдолд).

Зээлд хамаарах хүлээж болзошгүй үүрэгт зориулсан нөөцийг хэмжиж, үнэлэх арга замыг дараах байдлаар тайлбарлан харуулав.Үүнд:

Зээлийн шугам. Нээсэн зээлийн шугамын дүнг зээлд хамаарах үүрэгт оруулан тооцох ба нээсэн шугамыг буцаах боломжгүй буюу банк нээсэн зээлийн шугамыг ашиглуулахаас татгалзах боломжгүй тохиолдолд үүнтэй холбоотой нөөц байгуулах шаардлагатай эсэхийг үнэлнэ (ийм эрх нь ихэнхдээ зээлийн стандарт гэрээнд багтсан байдаг ба банк зээлдэгч шаардлага хангахгүй нөхцөлд зээлийн

шугамыг ашиглан зээл олгохоос татгалзаж болно).

Мөн банкны нээсэн зээлийн шугамыг ашиглахгүй байх боломжтой тул зээлдэгчийн бизнесийн онцлог болон санхүүжүүлсэн төслийн байдлаас шалтгаалан зээлийн шугамыг ашиглах нотолгоо байгаагаас бусад тохиолдолд өнгөрсөн үйлчилгээний үр дүнгээр хүлээх үүрэг үүсэхгүй. Иймээс зээлийн шугамыг ашиглах магадлал өндөр болох хүртэл ямар ч нөөц бүртгэхгүй.

Балансанд бүртгэсэн зээлтэй нэгэн адил түүврийн зарчим ашиглан зээл тус бүрт эсвэл зээлийн багцад нээсэн зээлийн шугамд нөөц байгуулж болно. Уг нөөц нь ашиглагдах магадлал өндөртэй зээлийн шугамын дүн ба хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг зээлийн үр ашигт хүүгээр дискаунтчилан тооцоолж гаргасан нөхөгдөх дүнгийн зөрүүтэй тэнцүү байна. Зээлийн барьцаанд тавьсан хөрөнгө гэх мэт бусад бүх төлбөрийн эх сурвалжийг харгалзан үзнэ. Хэрэв үнэ цэнийн бууралтыг тооцоолох зорилгоор зээлийн шугамыг хамтад нь үнэлж байгаа бол дараах томъёоллыг ашиглана:

Активын дүн x LGD x PD x Yнэ цэн буураагүй зээлийн багцын LIP x PDD

Энд: PDD – Зээлийн шугамыг ашиглах магадлал.
LGD – Алдагдал үүсэх магадлал
PD - Төлбөр төлөгдөхгүй байх магадлал
LIP – Алдагдал тодорхойлох хүчин зүйл

Зээлийн шугамыг ашиглах магадлалыг ижил нөхцөл, хугацаа, санхүүжилт бүхий зээлийн шугамын бодитоор олгогдсон зээлийн түүхэн мэдээлэлд үндэслэн үнэлнэ. Банк LGD, PD, LIP -ийг тогтоохдоо өмнөх санхүүгийн тайлангийн зээлийн активт харгалзах зээлийн шугамын үзүүлэлтүүдийг ашиглана.

Санхүүгийн баталгаа, батлан даалт. НББОУС 39.9-д зааснаар санхүүгийн баталгааны гэрээ гэж өрийн хэрэгслийн анхны буюу өөрчлөгдсөн нөхцлийн дагуу зээлдэгч нь төлбөрөө хугацаандаа барагдуулаагүйн улмаас үүссэн гарзыг эзэмшигчдэд нөхөн төлөх зорилгоор тодорхой төлбөрийг барагдуулахыг уг хэрэгслийг гаргагчаас шаардаж буй гэрээ юм. Санхүүгийн баталгааны гэрээний тодорхойлолтыг хангаагүй бүх хэрэгслийг дериватив гэж бүртгэх ба үүнд үнэ цэнийн бууралтыг тооцоолохгүй.

НББОУС 39.49в -ийн дагуу ийм гэрээг анх удаад хүлээн зөвшөөрч, бүртгэсний дараа уг хэрэгслийг гаргагч нь дараах дүнгүүдийн аль ихээр хэмжинэ: (i) НББОУС 37 “Нөөц, болзошгүй зүйл ба болзошгүй өр төлбөр”-ийн дагуу тодорхойлсон дүн; ба (ii) анх удаад хүлээн зөвшөөрсөн дүнгээс НББОУС 18 “Орлого”-ын дагуу хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан хорогдлыг хассан дүн.

НББОУС 37-д заасан нөөцийн үнэлгээг дан ганц зээл болон зээлийн багцын хувьд гүйцэтгэнэ. Дан ганц зээл болон багцалсан зээлийн хувьд нөөцийг байгуулахдаа дараах хүчин зүйлсийг харгалзана:

- Баталгааны нөхцлийн дагуу төлбөр гүйцэтгэх магадлал;
- Баталгааны дагуу төлсөн дүнг банкинд эргүүлэн төлөх боломжгүй нөхцөл байдалд хүргэж болзошгүй бөгөөд баталгаа эзэмшигчтэй холбоотой үнэ цэнийн бууралт үүсэх үйл явдал.

Хэрэв баталгааны дагуу төлбөр гүйцэтгэх магадлал өндөр бөгөөд үнэ цэн буурсан гэх нотолгоо байгаа тохиолдолд нөөцийг балансанд бүртгэсэн зээлтэй ижил зарчмаар байгуулна. Зээлийн барьцаанд тавьсан хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хангуулах гэх мэт төлбөрийн бүх эх сурвалжийг харгалзан үзнэ. Хэрэв үнэ цэнийн бууралтыг тооцоолох зорилгоор зээлийн баталгааг хамтад нь үнэлж байгаа бол дараах томъёоллыг ашиглана:

Активын дүн x LGD x PD x Yнэ цэн буураагүй зээлийн багцын LIP x PDD

Зээлийн шугамыг ашиглах магадлалыг гаргасан баталгааны онцлог, түүхэн мэдээлэлд (тухайлбал, гаргасан боловч хараахан нөхөгдөөгүй байгаа баталгаатай холбоотойгоор төлөгдсөн дүн) үндэслэн үнэлнэ.

Балансын өдрөөр санхүүгийн баталгаанд харгалзах нөөцийн дүнг тухайн баталгаатай холбоотой хойшлогдсон шимтгэлийн орлогын дүнтэй харьцуулна. Хэрэв хойшлогдсон орлого нь бага гарвал өр төлбөрийн дүнг шаардлагатай нөөцийн хэмжээ хүртэл нэмэгдүүлнэ. Хэрэв нөөц нь хойшлогдсон орлогын дүнгээс бага байвал нэмж журналын бичилт хийх шаардлагагүй.

Аккредитив. Зөвхөн хаагдаагүй аккредитивийг нөөцийн үнэлгээнд хамруулна. Хаагдсан аккредитивтай холбоотойгоор зээлийн эрсдэл үүсэхгүй (өөрөөр хэлбэл харилцагч мөнгөө байршуулсан тохиолдолд). Санхүүгийн баталгаатай нэгэн ижил зарчмаар нөөцийн дүнг тооцоолно. Аккредитивт НББОУС 39.47с зарчмыг мөрдөхгүй (хэлбэр бүрээр тусгай нөхцөл, хугацааг үнэлэх шаардлагатай) тул үүнтэй холбоотой нөөцийг аккредитивийн хойшлогдсон шимтгэлийн орлогоос тусад нь өр төлбөрөөр бүртгэнэ.

Хойшлогдсон орлогод (хойшлогдсон тусламжийн орлогыг оруулаагүй) урьдчилан төлөгдсөн хүү, үр ашигт хүүгийн дүнд багтаагүй,иймээс хөрөнгийн дүнг бууруулаагүй боловч санхүүгийн бус өр төлбөр гэж үзэх хойшлогдсон шимтгэл хураамж багтана (жишээлбэл, зээлийг олгохоос өмнө төлөгдсөн ба тэнцлийн гадуур бүртгэсэн зээлд хамаарах үүрэгтэй холбоотой шимтгэл, хураамж эсвэл гаргасан баталгаанд зориулсан шимтгэл). Шимтгэлийг хойшлогдсон орлогоор бүртгэх (бусад санхүүгийн өр төлбөрөөр бүртгэх) эсвэл хөрөнгийн үнийг бууруулж бүртгэх (үр ашигт хүүгийн түвшинд оруулан тооцох) эсэх гэх мэтээр санхүүгийн үйлчилгээг хэрхэн бүртгэхийг тогтоохын тулд санхүүгийн үйлчилгээний шимтгэлийн тухай жишээг оруулсан "Зээл" бүлгээс үзнэ үү. Банкинд ховор боловч бусад санхүүгийн өр төлбөрт багтсан бусад төрлийн орлого үүсэх тохиолдол гардаг. Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн урамшуулал, хямдруулалтын хорогдол нь үр ашигт хүүгийн түвшинд хийгдэх тохируулга болох ба үүнийг хойшлогдсон орлого (санхүүгийн бус өр төлбөр) бус харин холбогдох санхүүгийн хэрэгслийн тохируулга байдлаар бүртгэнэ.

Түрээсийн хөрөнгийг борлуулаад эргүүлэн түрээслэхтэй холбоотой хойшлогдсон орлогыг хөрөнгийг худалдсан үнэ ба дансны үнийн зөрүү дүнгээр бүртгэх (санхүүгийн түрээсээр хөрөнгийг борлуулаад эргүүлэн түрээсэлсэн) ба үүнийг уг хөрөнгийг ашиглахаар төлөвлөж буй хугацаанд хорогдуулна. Хэрэв үйл ажиллагааны түрээсийн хувьд хөрөнгийг борлуулаад эргүүлэн түрээсэлсэн бол хойшлогдсон орлогыг хөрөнгийн бодит үнэ цэн ба худалдах үнийн зөрүүгээр бүртгэх бөгөөд үүнийг уг хөрөнгийг ашиглахаар төлөвлөж буй хугацаанд хорогдуулна.

Борлуулах зорилготой өр төлбөрийг борлуулах зориулалтаар эзэмшиж буй хөрөнгөтэй дүйцэх ангилалд ангилна.

Хувийн тэтгэврийн сангийн өр төлбөр гэж тогтоосон шимтгэлийн сан ба тогтоосон тэтгэмжийн сантай холбоотойгоор үүсдэг.

Тогтоосон шимтгэлийн сангийн дагуу банкны хуулиар хүлээсэн үүрэг болон үүсмэл үүрэг нь уг санд хуримтлуулахаар зөвшөөрсөн шимтгэлийн дүнгээр хязгаарлагдана. Иймээс ажилтнуудад олгох ажил эрхлэлтийн дараах тэтгэмж нь банкнаас төлсөн шимтгэлийн дүн болон үүнд харгалзах хөрөнгө оруулалтын өгөөжөөр хязгаарлагдана. Иймээс актуар эрсдэл (авах тэтгэмж нь тооцоолж байснаас бага байх) ба хөрөнгө оруулалтын эрсдэлийг (хөрөнгийг хүлээгдэж буй өгөөжөөс доогуур өгөөж бүхий зүйлд хөрөнгө оруулсан) ажилтан хариуцна. Ажилтан тайлант хугацаанд банкиндаа ажилласан нөхцөлд банк тогтоосон шимтгэлийн санд шимтгэл төлөх үүрэг хүлээх ба үүнийг өр төлбөрөөр (тооцоолсон зардал) бүртгэнэ (НББОУС 2, НББОУС 16 гэх зэрэг бусад стандартанд уг шимтгэлийг хөрөнгийн өртөгт шингээхээр зааснаас бусад тохиолдолд зардалд бүртгэнэ). Хэрэв төлсөн шимтгэл нь тайлант хугацааны шимтгэлийн дүнгээс хэтэрсэн тохиолдолд банк уг зөрүүг өр төлбөр бус харин хөрөнгөөр (урьдчилж төлсөн зардал) бүртгэх ба ирээдүйд төлөгдөх шимтгэлийг бууруулах буюу буцаан авна.

Тогтоосон шимтгэлийн санд төвлөрүүлсэн шимтгэлийг тайлант хугацааны эцсээс хойш 12 сарын дотор ажилтнуудад олгохгүй нөхцөлд үүнийг тайлант хугацааны эцсээрх компанийн эрсдэл багатай бондын зах зээлийн өгөөж эсвэл зах зээл идэвхигүй тохиолдолд Засгийн газрын бондын өгөөжийн хувийг ашиглан тогтоосон үр ашигт хүүгийн түвшинг ашиглан дискаунтчилна. Компанийн бонд болон Засгийн газрын бондын валютын төрөл, хугацаа нь ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн өр төлбөрийг илэрхийлсэн валют, тооцоолсон хугацаатай тохирч байвал зохино. Засгийн газрын бондын хувьд ижил хугацаатай бонд байхгүй тохиолдолд (жишээлбэл, 20 эсвэл 30 жилийн хугацаатай засгийн газрын бонд байхгүй бол) банк дундаж үнэлгээг ашиглана (жишээлбэл, 20 эсвэл 30 жилийн хугацаатай АНУ-ын төв банкны үнэт цаасны өгөөжийн түвшинг урт хугацаанд Монгол улсын жилийн инфляцийн таамаглалаар нэмэгдүүлж гаргах).

Тогтоосон тэтгэмжийн сангийн дагуу банк зөвшөөрсөн тэтгэмжийг одоо ажиллаж байгаа болон өмнө нь ажиллаж байсан ажилтнуудаа олгох үүрэг хүлээх ба актуар эрсдэл (тэтгэмжийн зардал нь тооцоолж байснаас өндөр гарах) болон хөрөнгө оруулалтын эрсдэлийг банк өөрөө хариуцна. Хэрэв актуар болон хөрөнгө оруулалтын зардал төлөвлөж байснаас өндөр гарвал банкны зүгээс төлөх дүн өснө. Актуар төсөөллийг боловсруулахдаа өр төлбөр, зардлыг үнэлж, актуар орлого, зардал гарах магадлалыг тооцоолж байх шаардлагатай тул тогтоосон тэтгэмжийн сангийн бүртгэл нэлээд нарийн байна. Мөн тэтгэмжийг үүссэн хугацаанаас нь хойш нэлээд хэдэн жилийн дараа барагдуулах болдог тул өр төлбөрийг үнэлэхдээ дискаунтчилдаг. Хэрэв банкинд тогтоосон тэтгэмжийн сан нэгээс олон байдаг бол материаллаг дүн бүхий сангийн тооцооллыг бусдаас нь салгаж гүйцэтгэнэ.

- Өмнөх ба тайлант хугацаанд хамаарах, ажилтнуудад олгох тэтгэмжийн дүнг актуар аргаар үнэн зөв үнэлэх. Үүний тулд банк тайлант болон өмнөх хугацаанд харгалзах тэтгэмжийг тодорхойлж, тэтгэмжийн зардалд нөлөөлөх хүн ам зүйн (ажилтнуудын халаа сэлгээ, нас баралт гэх мэт) болон санхүүгийн хувьсагчийн (ирээдүйн цалингийн өсөлт, эрүүл мэндийн зардлын өсөлт гэх мэт) үнэлгээг

гүйцэтгэнэ;

- Тэтгэмжийн өр төлбөр, түүнээс тайлант хугацаанд харгалзах зардлыг тогтоохын тулд өнөөгийн үнэ цэнийг үнэлэхдээ төсөвлөсөн нэгжийн кредитийн аргыг ашиглан тэтгэмжийг дискаунтчилна;
- Төлөвлөгдсөн сангийн хөрөнгийн бодит үнэ цэнийг тодорхойлох;
- Актуар орлого, зардлын нийт дүн, үүнээс хүлээн зөвшөөрч бүртгэсэн актуар орлого, зардлын дүнг тодорхойлох;
- Санг байршуулах буюу өөрчлөх үед үүсэх үйлчилгээний зардлыг тодорхойлох;
- Сангаас тэтгэмж олгосон эсвэл санг бууруулсан үед үүссэн орлого, зардлыг тодорхойлох.

Тогтоосон тэтгэмжийг өр төлбөрөөр бүртгэсэн дүнг дараах дүнгүүдийн нийлбэрээр тодорхойлно. Үүнд: тогтоосон тэтгэмжийн өр төлбөрийн өнөөгийн үнэ цэн, нэмэх нь хүлээн зөвшөөрөгдөөгүй актуар орлого (хасах нь актуар зардал), хасах нь хүлээн зөвшөөрөгдөөгүй өнгөрсөн үйлчилгээний зардал, хасах нь үүссэн өр төлбөрийг барагдуулах зорилготой тайлант хугацааны эцсээрх төлөвлөгөөт хөрөнгийн бодит үнэ цэн. Тогтоосон тэтгэмжийн өр төлбөрийн өнөөгийн үнэ цэн нь төлөвлөгдсөн сангийн хөрөнгийн бодит үнэ цэнийг хасаагүй нийт өр төлбөрийн дүнгээр тодорхойлогдоно.

Банк тогтоосон тэтгэмжийн өр төлбөрийн өнөөгийн үнэ цэн болон төлөвлөгөөт хөрөнгийн бодит үнэ цэнийг жилийн санхүүгийн тайланд бүртгэсэн дүн тайлант хугацааны эцсээр тодорхойлогдох дүнгээс материаллаг зөрүүгүй байхаар тооцож, тогтоосон хугацааны давтамжтайгаар тодорхойлно. НББОУС 19-д зааснаар банк ажлаас халагдсаны тэтгэмжийн материаллаг дүн бүхий өр төлбөрийн үнэлгээг гүйцэтгэхдээ мэргэшсэн актуарчийг оролцуулж болно. Практик шалтгааны улмаас банк тайлант хугацааны эцсээс өмнө өр төлбөрийн дэлгэрэнгүй үнэлгээг мэргэшсэн актуарчаар гүйцэтгүүлж болно. Түүний хийсэн үнэлгээнд үндэслэн материаллаг арилжаа болон тайлант хугацааны эцэс хүртэл тохиолдсон үйл явдлын (зах зээлийн үнэ, хүүгийн түвшин өөрчлөгдөх) улмаас гарсан материаллаг өөрчлөлтүүдтэй холбоотойгоор үнэлгээг шинэчлэнэ. Дискаунтын хувь хэмжээг тогтоосон шимтгэлийн сангийн нэгэн адил тодорхойлно.

Банк бусад стандартын дагуу хөрөнгийн өртөгт шингээх тохиолдлоос бусад үед дараах дүнгүүдийн нийлбэрийг зардалд бүртгэнэ. Үүнд: банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу тайлант үеийн үйлчилгээний зардал, хүүгийн зардал, төлөвлөгөөт хөрөнгө болон нөхөн олговрын эрхийн хүлээгдэж буй өгөөж, өнгөрсөн үйлчилгээний зардал, тэтгэмжийг бууруулах болон барагдуулсны үр нөлөө, орлого, зардлаас гадуур бүртгэхгүй боловч НББОУС 19-д заасан хязгаарлалтын үр нөлөө. Өөр стандартын дагуу ажилтнуудад хамаарах зарим тэтгэмжийн зардлыг үндсэн хөрөнгө, бараа материал гэх мэт хөрөнгийн өртөгт оруулахаар шаарддаг. Жишээлбэл, НББОУС 2-д зааснаар бараа материалын хувиргалтын зардалд үйлдвэрлэлийн нэгжтэй шууд холбоотой цалин хөлс гэх мэт зардал багтана. Ингэхдээ материалыг эцсийн бүтээгдэхүүн болгон хувиргах үед гарсан үйлдвэрлэлийн хувьсах ба тогтмол нэмэгдэл зардлыг (шууд бус хөдөлмөрийн зардал мөн багтана) системтэйгээр хуваарилна. Түүнчлэн НББОУС 16-ийн дагуу үндсэн хөрөнгийн өртөгт уг хөрөнгийг бүтээн босгох болон олж бэлтгэхтэй холбоотой ажилтны тэтгэмжийн зардал багтана.

Тэтгэврийн сангийн бүртгэлийн онцлог болон банк янз бүрийн төрлийн санг бий болгож, хэрэгжүүлж байгаагаас шалтгаалан банк бүртгэл, тодруулгыг СТОУС-д бүрэн нийцүүлэх үүднээс НББОУС 19-г дэлгэрэнгүй судлах хэрэгтэй. Банк хувийн тэтгэврийн сангийн талаарх дэлгэрэнгүй тайлбар, НББОУС 19-д заасан тодруулгаас бусад холбогдох нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тодруулна.

Хоёрдогч өглөгийг бусад эх үүсвэрийн нэгэн адил анхны удаад бодит үнэ цэнээр үнэлж, санхүүгийн тайланд хорогдуулсан өртгөөр хэмжиж тайлагнана.

Ажил, үйлчилгээг үзүүлсэн даруйд мөнгөөр төлөгдөх хувьцаанд суурилсан төлбөрийн өглөгийг (опционыг оруулсан) хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Банк мөнгөөр төлөгдөх хувьцаанд суурилсан төлбөр бүхий арилжаагаар үйлчилгээг үзүүлсэн даруйд өр төлбөрийг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Банкинд үзүүлсэн ажил, үйлчилгээг өр төлбөрийн бодит үнэ цэнээр үнэлнэ. Банк өр төлбөрийг барагдуулах хүртэл тайлант хугацаа бүрийн эцэст болон төлбөр барагдуулах өдрөөр өр төлбөрийг бодит үнэ цэнээр дахин үнэлж (наад зах нь жил нэг удаа), үнэлгээнд гарсан өөрчлөлтийг тайлант хугацааны орлого, зардалд бүртгэнэ.

Хэрэв өмчөөр хаагдах хувьцаанд суурилсан төлбөр бүхий арилжаагаар банкинд үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд үүнийг өөрийн хөрөнгийн хувьцаанд суурилсан төлбөр барагдуулах капиталын дансанд бүртгэх тул өр төлбөр бүртгэхгүй. (“Өөрийн хөрөнгө” бүлгийг үзнэ үү)

Гадаад валютаар илэрхийлэгдсэн бусад санхүүгийн ба санхүүгийн бус өр төлбөрийг Монголбанкнаас зарласан ханшаар тооцож төгрөгт хөрвүүлэн төгрөг, валютаар давхар бүртгэх ба ханшийн тэгшитгэлээс үүсэх өөрчлөлтийг тайлант хугацааны орлого, зардалд бүртгэнэ. Мөнгөн бус хэлбэртэй санхүүгийн ба санхүүгийн бус өр төлбөр (мөн мөнгөн бус хэлбэртэй хөрөнгө) -т НББОУС 21-ийн дагуу ханшийн тэгшитгэл хийхгүй.

Д. БҮРТГЭЛ

<u>1) Өглөг, урьдчилгаа</u>

Харилцагч, зээлдэгчдээс хүүгийн болон бусад орлого урьдчилж төлөгдөхөд

Дебит: Мөнгөн хөрөнгийн данс эсвэл Харилцагчийн харилцах, хадгаламж
Кредит: Урьдчилж төлөгдсөн орлого

Урьдчилж төлөгдсөн орлогыг тайлант үед хуваарилж

Дебит: Урьдчилж төлөгдсөн орлого
Кредит: Холбогдох орлогын данс

Бараа материал, бусад хөрөнгө, үйлчилгээг зээлээр худалдан авахад

Дебит: Хөрөнгийн холбогдох данс эсвэл Зардлын холбогдох данс
Кредит: Өглөг

Бараа, үйлчилгээний үнийг төлөхөд
Дебит: Өглөг
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Тайлант үеийн эцэст нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн дагуу зардал хуримтлуулж бүртгэхэд

Дебит: Зардлын холбогдох данс
Кредит: Өглөг

Хуримтлуулсан өглөгийг мөнгөөр төлөхөд

Дебит: Өглөг
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг, ногдол ашгийн өглөг, орлогын албан татварын өглөг, салбар хоорондын тооцооны өглөг, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, хувь хүний орлогын албан татварын өглөг, цалингийн өглөг зэрэг дансдын зааврыг харгалзах бүлгүүдээс үзнэ үү. Эдгээр дансдыг (ногдол ашгаас бусад) харгалзах тайлант хугацаанд нь холбогдох зардал, өглөгт бүртгэнэ. Бүртгэсэн өглөгийг төлөгдсөн үед нь данснаас хасч бүртгэнэ.

Нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар, цалингийн өглөгийг хуримтлуулсан өглөг, түүнтэй холбоотой орлого, зардлын бүлэгт багтсан ажил гүйлгээг бүртгэхтэй нэгэн адил бүртгэнэ.

<u>2) Ажилтнуудын тэтгэвэр, тэтгэмжийн өглөг ба Нийгмийн хөгжлийн сан</u>

“Хэмжилт ба үнэлгээ” хэсэгт тайлбарласан өр төлбөрийн шалгуурыг (холбогдох хууль, тогтоомж, журмаар хүлээсэн үүрэг ба үүсмэл үүрэг) хангаж байгаа нөхцөлд холбогдох журналын бичилтийг гүйцэтгэнэ. Бусад тохиолдолд өөрийн хөрөнгийн дансанд (нөөц ба хуримтлагдсан ашиг) бүртгэх ба энэ талаар “Өөрийн хөрөнгө” бүлгээс харна уу.

Ажилтнуудад олгох тэтгэвэр, тэтгэмж, шагнал, урамшууллын төлөгдөх дүнгээр

Дебит: Зардлын холбогдох данс
Кредит: Ажилтнуудын тэтгэвэр, тэтгэмжийн өглөг

Тайлант хугацааны эцэст өр төлбөрийн дүнг тодорхойлох арга зам нь өр төлбөрийн төрлөөс шалтгаалах ба энэ талаар “Хэмжилт ба үнэлгээ” хэсгээс үзнэ үү.

Нийгмийн хөгжлийн сан байгуулахад

Дебит: Зардлын холбогдох данс
Кредит: Нийгмийн хөгжлийн сан

Нийгмийн хөгжлийн сангаас зориулалтын дагуу хөрөнгө зарцуулахад

Дебит: Нийгмийн хөгжлийн сан
Кредит: Холбогдох хөрөнгийн данс

Хэрэв ажилтнуудад олгох шагнал, урамшуулал, тэтгэвэр, тэтгэмжийг хувьцаа, түүнтэй адилтгах өмчийн хэрэгслээр төлж барагдуулах бол өөрийн хөрөнгийн бүлэгт тайлбарласан "Хувьцаанд суурилсан төлбөр"-ийн дагуу бүртгэнэ.

Банкны бүх удирдлагад олгох бага хүүтэй, 20 жилийн хугацаатай моргежийн зээл гэх мэт зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй зээлийг банк ажилтнууддаа олгож болно. Хэрэв банкны удирдах албан тушаалтан банкнаас гарах бол уг зээлийн хүүг банкны стандарт хувь хэмжээгээр (тухайн үеийн өнөөгийн зах зээлийн түвшин) тооцно. Бага хүүтэй зээлийн бүртгэлд уг зээлийг анх удаад хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнийг хүлээгдэж буй ирээдүйн хүү болон үлдэгдэл төлбөрийн өнөөгийн зах зээлийн түвшинг ашиглан дискаунтчилсан өнөөгийн үнэ цэнээр тодорхойлно. Энэхүү дүн ба ажилтнуудад олгосон дүнгийн зөрүүг ажилтнуудын тэтгэмжийн урьдчилгаа төлбөрөөр бүртгэж, тэтгэмжийн хугацаанд орлого, зардалд хуваарилж хорогдуулна. Тэтгэмжийн хугацаа гэж ажилтнуудын ажиллах хугацаа бөгөөд энэ нь зээлийн хугацаанаас хэтрэхгүй.

Анх удаад хүлээн зөвшөөрөх үед СТОУС-д нийцүүлэн дараах бичилтийг хийнэ:

Дебит: Банкны ажилтнуудад олгосон зээл (нэрлэсэн дүн буюу олгосон дүн)
Кредит: Холбогдох мөнгөн хөрөнгийн данс / Харилцагчийн харилцах

Дебит: Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэйгээр ажилтнуудад олгосон зээлийн урьдчилгаа (бусад санхүүгийн бус хөрөнгө)
Кредит: Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэйгээр ажилтнуудад олгосон зээлийн бодит үнэ цэнийн тохируулга ("Банкны ажилтнуудад олгосон зээл" дансанд бүртгэх ба нэрлэсэн дүнг бууруулна)

Хэрэв зээлийн хугацаа 20 жил бол ажилтнуудад олгосон зээлийн урьдчилгааг зээлийн хугацаанд шулуун шугамын сууриар хорогдуулах ба анх хүлээн зөвшөөрч хойшлуулан бүртгэсэн зардлыг жил бүр 5%-иар хорогдуулж, орлогын тайланд ажилтнуудын тэтгэмжээр тусгана:

Дебит: Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэйгээр ажилтнуудад олгосон зээл ("Цалин хөлс, нэмэгдэл"-ийн данс) - Зардлын данс
Кредит: Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэйгээр ажилтнуудад олгосон зээлийн урьдчилгаа (бусад санхүүгийн бус хөрөнгө)

Хүүгийн орлогын тооцооллыг оруулсан тоон жишээг "Зээл" бүлэгт оруулсан.

Нийгмийн хөгжлийн сангийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрч, бүртгэхтэй холбоотой СТОУС-ын шаардлага хангагдаж байгаа үед дараах бичилтийг хийнэ:

Дебит: Тэтгэмж, нийгмийн халамж /Ажилтнуудад олгосон нөхөн олговор, хөнгөлөлт ("Цалин хөлс, нэмэгдэл"-ийн данс) – зардлын данс
Кредит: Нийгмийн хөгжлийн сан (өр төлбөр)

Төлбөр барагдуулах үед:

Дебит: Нийгмийн хөгжлийн сан (өр төлбөр)
Кредит: Холбогдох мөнгөн хөрөнгийн данс

Тэтгэврийн сангийн өр төлбөр

Дийлэнх тэтгэмжийн сан нь улсын нийгмийн даатгалын сангаас тогтоосон шимтгэлийн сан байдаг. Ийм сангийн хувьд банк (ба ажилтнууд) тооцоолсон дүнгээр санд хөрөнгө хуримтлуулах ба ямар нэгэн өр төлбөр үүсэхгүй. Ажилтнууд тэтгэвэр тогтоолгох үед тэдэнд тэтгэвэр төлөх боловч үүнтэй холбоотой нэмэлт үүргийг банк хүлээхгүй.

Дебит: Эрүүл мэнд нийгмийн даатгалын шимтгэлийн зардал
Кредит: Эрүүл мэнд нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг

Шимтгэлийг ажилтны ажилласан тайлант хугацааны эцсээс хойш 12 сарын дотор олгохоос бусад тохиолдолд дээрхтэй ижил зарчмаар тогтоосон шимтгэлийн хувийн санг бүртгэнэ. Энэ тохиолдолд дискаунтын түвшинг ашиглан дискаунтчилна ("Хэмжилт ба үнэлгээ" хэсэгт тайлбарласан). Дараах дансны харилцааг хийнэ:

Дебит: Ажилтнуудтай холбоотой зардал – тогтоосон тэтгэврийн шимтгэл
Кредит: Хувийн тэтгэврийн сангийн өр төлбөр – тогтоосон шимтгэл

Тогтоосон тэтгэмжийн сангаас ажилтнуудад тусгай тэтгэвэр олгохоор амласан байдаг ба үүнийг ажилласан жил болон сүүлийн цалинд үндэслэн тогтооно. Банк ирээдүйн тэтгэвэрт төлөх өр төлбөрийг

үүсгэнэрт төлөх өр төлбөрийг к илтнуудад тусгай тэтгэвэр олгохоор амласан байдаг ба үүнийг ажилласан жил болон н). Дараах дансны харилцааг хийнэ:хгүй. Ажилтнууд үртгэсэн зардлыг жил бүр 5%-иар хорогдуулж, орлогын тайланд ажилтнуудын тэтгэмжээр эдүйн тэтгэврийн өр төлбөрт зориулан хөрөнгийн санг үүсгэж, ашиглана.

Өнгөрсөн жилийн цэвэр өр төлбөр (тэтгэврийн өр төлбөрөөс тэтгэврийн хөрөнгийг хасна) ба банкны тооцоолол буюу актуарчийн тооцоололд үндэслэн гаргасан энэ жилийн цэвэр өр төлбөрийн хоорондох зөрүүг зардалд бүртгэнэ. Хэрэв өр төлбөрийг дахин үнэлээгүй буюу актуар орлого, зардал үүсээгүй тохиолдолд цэвэр өр төлбөрийг өсгөх бүртгэлийг дараах байдлаар хийнэ:

Дебит: Ажилтнуудтай холбоотой зардал – тогтоосон тэтгэвэр шимтгэл*
Кредит: Хувийн тэтгэврийн сангийн өр төлбөр – тогтоосон шимтгэл

* Тогтоосон тэтгэмжийн өр төлбөр /(хөрөнгө)-т тайлант хугацаанд гарсан өөрчлөлттэй тэнцэх үйлчилгээний зардал, цэвэр хүүгийн зардал энэ дүнд багтана. Тухайн хугацаанд төлсөн шимтгэл ба олгосон тэтгэмжийн дүнг харгалзан тогтоосон хямдруулах хүүгтогтоосон тэтгэмжийг цэвэр өр төлбөр (хөрөнгө) -ийн дүнгээр үржүүлж, хүүгийн цэвэр зардлыг тооцно.

Цэвэр өр төлбөр буурсан тохиолдолд дээрх журналын бичилтийг буцааж, урвуу бичилт хийнэ. Хэрэв банк тайлант хугацааны эцэст тэтгэврийн цэвэр хөрөнгө эзэмшиж байгаа (өөрөөр хэлбэл хувийн тэтгэврийн сангийн сөрөг өглөг) бол уг хөрөнгийг бусад санхүүгийн хөрөнгөөр тайлагнана.

3) Мөнгөн гуйвуулгын өглөг

Гуйвуулгаар ирсэн мөнгийг бүртгэж авахад

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Мөнгөн гуйвуулгын өглөг

Гуйвуулгын мөнгийг олгоход

Дебит: Мөнгөн гуйвуулгын өглөг
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

4) Банк хоорондын тооцоо

Банк хоорондын төлбөр тооцоог Монголбанкны төлбөр тооцооны системээр дамжуулан гүйцэтгэнэ.

Харилцагчийн төлбөрийг банк хоорондын тооцоогоор шилжүүлбэл

Дебит: Харилцагчийн харилцах данс ба холбогдох данс
Кредит: Банк хоорондын тооцооны түр данс

Банк хоорондын тооцооны түр дансны үлдэгдлээр тухайн хугацаанд банк хоорондын тооцоогоор хийсэн гүйлгээний цэвэр авлага, өглөг тодорхойлогдох ба энэ дансны үлдэгдлийг тухай бүр банк хоорондын төлбөр тооцооны клирингийн дансанд хаана.

Дебит: Банк хоорондын тооцооны түр данс
Кредит: Клирингийн данс / Клирингийн саатал

5) Хөрвөх өр төлбөр

Хэрэв өр төлбөрийг өөрийн хөрөнгөд хөрвүүлэх нөхцөлийн улмаас өр төлбөрийн үнэ цэн өөрчлөгдөж байгаа бол хөрвөх өр төлбөрийн дүнг өр төлбөр ба өөрийн хөрөнгийн хэсэг гэж салгаж бүртгэнэ. Өр төлбөрийн хэсгийг өр төлбөрийн зах зээлийн хүүгийн хувийг ашиглан хүү болон үндсэн өрийн дүнг дискаунтчилж, тооцоолно (өөрөөр хэлбэл хөрвөх нөхцөлгүй ижил төстэй өрийн хэрэгслийн хүүгийн түвшинг ашиглах ба энэ нь хөрвөх өглөгийн хүүгийн түвшнээс өндөр байдаг).

Нийт дүнгээс өр төлбөрийг хасаад үлдсэн хэсгийг өөрийн хөрөнгө гэж үзнэ.

Жишээ: **Хөрвөх бонд**

20х4 оны 1 дүгээр сарын 1-нд банк 1000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 2000 ширхэг хөрвөх бондыг 1,946,880 төгрөгөөр гаргасан. 6%-ийн хүүг жилийн бүрийн эцэст төлнө. Банк 20х6 оны 12 дугаар сарын 31-нд бондыг төлж барагдуулна.

Анх хүлээн зөвшөөрөх үед

Бондыг хөрвөх нөхцөлгүй гаргасан тохиолдолд үр ашигт хүү 8% болно гэж банк тооцоолсон.

Бондын үндсэн төлбөрийн өнөөгийн үнэ цэн нь:

2,000,000x0,794 (3 дахь жил, дискаунтын хувь 8%) = 1,588,000
Хүүгийн төлбөрийн өнөөгийн үнэ цэн: 120,000 x 2,577
(3 жилийн хүүгийн хуримтлуулсан төлбөр, 8%) = 309,240
Өр төлбөрийн нийт дүн: = 1,897,240
Бондын өртөг: = 1,946,880
Өмчийн хэсэг = 49,640

Дээрх тооцооллоос харахад бондыг 102,760 төгрөгийн хямдруулалттайгаар гаргасан байна (2,000,000-1,897,240=102,760).

Энэхүү 102,760 төгрөгийн хямдруулалтыг дараах байдлаар хорогдуулна:

Жил	Он сар өдөр	Бондын дансны үлдэгдэл	Хүүгийн төлбөр	Хүүгийн зардал	Бондын хямдруулалтын хорогдол
		$(a)_1=(a)_0+(d)$	(b)	(c) =(a)*8%	(d)=(c)-(b)
	20X4.01.01	**1,897,240**			
1	20X4.12.31	1,929,019	120,000	151,779	31,779
2	20X5.12.31	1,963,341	120,000	154,322	34,322
3	20X6.12.31	2,000,000	120,000	156,659	36,659
					102,760

Журналын бичилт:

20x4 оны 1 дүгээр сарын 1

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс 1,946,880
Дебит: Хөрвөх өр төлбөр (өр төлбөр болох хэсэг) - Хямдруулалт 102,760
Кредит: Хөрвөх өр төлбөр (өр төлбөр болох хэсэг) 2,000,000
Кредит: Хөрвөх өр төлбөрийн өмчийн хэсэг 49,640

20x4 оны 12 дугаар сарын 31

Дебит: Хүүгийн зардал 151,779
Кредит: Хөрвөх өр төлбөр (өр төлбөр болох хэсэг) - Хямдруулалт 31,779
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс 120,000

Өмчийн хэсгийг хувьцааны опшин гэж үзнэ. Хэрэв уг өрийг хувьцаанд хөрвүүлбэл:

Дебит: Хөрвөх өр төлбөрийн өмчийн хэсэг 49,640
Дебит: Хөрвөх өр төлбөр (өр төлбөр болох хэсэг) 2,000,000
Кредит: Хувь нийлүүлсэн хөрөнгө/Нэмж төлөгдсөн капитал 2,049,640

Хэрэв уг өрийг хувьцаанд хөрвүүлээгүй бол:

Дебит: Хөрвөх өр төлбөрийн өмчийн хэсэг 49,640
Дебит: Хөрвөх өр төлбөр (өр төлбөр болох хэсэг) 2,000,000
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс 2,000,000
Кредит: Өөрийн хөрөнгийн холбогдох данс 49,640

6) Санхүүгийн өр төлбөрийг өмчийн хэрэгслээр төлж барагдуулах (СТОУТХ 19)

Санхүүгийн өр төлбөрийг өмчийн хэрэгслээр барагдуулахдаа тухайн өмчийн хэрэгслийн бодит үнэ цэнээр бүртгэнэ (үүсэх аливаа зөрүүг нэмж төлөгдсөн капитал дансанд бүртгэнэ). Өр төлбөрийг ч мөн бодит үнэ цэнээр үнэлнэ. Хэрэв өр төлбөрийг бодит үнэ цэнээр үнэлээгүй бол үүний улмаас үүсэх аливаа зөрүүг орлогын тайланд тусгана.

7) Нөөц ба болзошгүй өр төлбөр

Банк өөрийн буруутай үйлдлийн улмаас бусдад хохирол учруулсан, томоохон бүтцийн өөрчлөлт хийх, алдагдалтай гэрээ байгуулах болон тэдгээртэй адилтгах зүйлсэд зориулсан нөөц байгуулж болно. Жишээлбэл, алдагдалтай гэрээ гэдэг нь гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд гарах зайлсхийх боломжгүй зардал нь гэрээний дагуу хүртэх эдийн засгийн өгөөжөөс давах нөхцөлтэй хийгдсэн гэрээг хэлнэ. Уг гэрээнд заасан зайлсхийх боломжгүй зардалд гэрээг цуцлах хамгийн бага цэвэр зардал буюу энэ нь тус гэрээг биелүүлэхэд үүсэх зардлаас бага байх бөгөөд гэрээг биелүүлэхгүй байснаар бий болсон нөхөн олговор, торгууль үүнд багтана.

Нөөц (сан) гэж хугацаа, дүн нь тодорхойгүй өр төлбөрийг хэлнэ. Төлбөрийг барагдуулах магадлалтай үед үүнийг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Нэг жилийн дотор төлөгдөхгүй нөөцийг дискаунтчилна.

Нөөцийн төлөгдөх хугацаа, ирээдүйд төлөгдөх дүн тодорхойгүй байдаг нь үүнийг дансны өглөг, хуримтлуулсан өглөг гэх мэт бусад өр төлбөрөөс ялгана. Дансны өглөг нь авсан буюу нийлүүлсэн бараа, үйлчилгээний үнэнд төлөхөөр нэхэмжилсэн буюу бэлтгэн нийлүүлэгчийн албан ёсоор зөвшөөрсөн өр төлбөр бол харин хуримтлуулсан өр төлбөр нь авсан буюу нийлүүлсэн бараа, үйлчилгээний үнэнд төлөх, хараахан төлөгдөөгүй, нэхэмжлээгүй буюу бэлтгэн нийлүүлэгчийн албан ёсоор нэхэмжлээгүй өр төлбөр бөгөөд ажилтнуудад төлөх өглөг бас үүнд багтана. Хэдийгээр заримдаа хуримтлуулсан өглөгийн хугацаа, дүнг тооцоолох шаардлагатай байдаг боловч тодорхойгүй байдал нь нөөцтэй харьцуулахад бага байдаг. Хуримтлагдсан өр төлбөрийг аливаа арилжаа ба өглөгийн нэг хэсэг болгон бүртгэдэг бол нөөц/санг тусад нь бүртгэдэг.

Нөөцийг зөвхөн дараах тохиолдолд бүртгэнэ:

(i) Өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулиар хүлээсэн болон үүсмэл үүрэг хүлээсэн;

(ii) Үүргийг биелүүлэхийн тулд төлбөр барагдуулах магадлалтай;

(iii) Өр төлбөрийн дүнг найдвартай тооцоолох боломжтой.

Үүсмэл үүрэг гэж дараах үүргийг хэлнэ:

(i) Өнгөрсөн практик, бодлого, тайлангаар банк тодорхой үүргийг хүлээж байгаагаа бусад талуудад илэрхийлсэн;

(ii) Үүний үр дүнд банк дээрх үүргээ биелүүлнэ гэсэн итгэл тэдгээр талуудад бий болсон.

Жишээ: Хуулийн байгууллагаар шийдэгдэж байгаа зүйлсэд байгуулсан нөөц

Банк буруу зар сурталчилгаа явуулсны улмаас 350 хадгаламж эзэмшигч шүүхэд гомдол гаргасан. Тэдний үзэж байгаагаар банк тодорхой бус мэдээлэл түгээсний улмаас 30 сая төгрөгийн орлогоо авч чадаагүй ажээ. Энэ хэргийг 2XX2 оны 4 дүгээр сарын 1-нд үүсгэсэн. Мөрдөн байцаах болон шүүн таслах ажиллагаа 2 жил үргэлжлэхээр таамаглаж байгаа ба дээрх шалтгаанаар хохирсон хадгаламж эзэмшигчийн тоо 500 болж өсч болзошгүй тул хохирлын дүн 40 сая төгрөг болж болзошгүй.

2XX2 оны 4 дүгээр сарын 1-нд банкны хуульч болон бусад шинжээчид шүүхийн шийдвэрээр банк 15 сая төгрөгийн төлбөр барагдуулах магадлалтай гэж таамагласан.

Банк энэ өр төлбөрт нөөц байгуулна. 15 сая төгрөгийн төлбөрийг 2 жилийн дараа 2XX4 оны 3 дугаар сард эсвэл 4 дүгээр сард барагдуулах тул тухайн мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг тооцох шаардлагатай болох ба үүний тулд 15 сая төгрөгийг уг өр төлбөрт хамаарах эрсдэлийг илэрхийлсэн дискаунтын түвшингээр дискаунтчилна.

Дискаунтын түвшинд мөнгөний цаг хугацааны үнэ цэн, өр төлбөрт тусгайлан хамаарах эрсдэлийн өнөөгийн зах зээлийн үнэлгээг тусгана. Дискаунтын түвшинд ирээдүйн мөнгөний урсгалын үнэлгээнд тохируулсан эрсдэлийг тусгахгүй. Энэ жишээний хувьд өр төлбөрийн эрсдэлийг тусгасан хүүгийн түвшин нь жилийн 24% буюу сарын 2% байсан гэе.

15 сая төгрөгийг 24 сарын хугацаанд 2%-иар дискаунтчилахад өр төлбөрийн өнөөгийн үнэ цэн нь 9,326,000 төгрөг болж байна (15,000,000/(1+0.02)^24). Энэ нь нөөцийн дансны дүнг илэрхийлнэ.

Дебит: Торгууль, нөхөн олговрын зардал	9,326,000
Кредит: Нөөц	9,326,000

Тайлант хугацаа бүрийн эцэст нөөцийн дүнг нягталж, тухайн үеийн хамгийн сайн тооцооллыг харуулсан тохируулгыг хийнэ. Хэрэв үүргийг биелүүлэхийн тулд эдийн засгийн өгөөж бүхий хөрөнгийг шилжүүлэх магадлалгүй болсон бол нөөцийг буцааж хаана. Дискаунтчилсан үед цаг хугацаа өнгөрөх тутам нөөцийн дүн өснө. Уг өсөлтийг зээлийн хүүгийн зардалд бүртгэнэ.

Нөөцийг зөвхөн анх бүртгэж байсан үеийн зориулалтаар зарцуулна. Зардлыг харгалзах зориулалтын дагуу байгуулсан нөөцөд хаана. Өөрөөр хэлбэл, зардлыг өөр зориулалтаар байгуулсан нөөцөд хаахгүй.

Болзошгүй өр төлбөр нь:

i. Өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн бөгөөд ирээдүйн тодорхой бус үйл явдал тохиолдсоноор эсвэл үл тохиолдсоноор оршин байх нь баталгаажих хүлээж болзошгүй өр; эсвэл

ii. Өнгөрсөн үйл явдлын улмаас үүссэн өнөөгийн үүрэг бөгөөд дараах шалтгаанаар бүртгэгдэгүй байгаа:

i. Үүргийг биелүүлэхэд төлбөр хийгдэх магадлал байхгүй; эсвэл

ii. Өр төлбөрийн дүнг найдвартай хэмжих боломжгүй.

Банк болзошгүй өр төлбөрийг Санхүүгийн тайланд харуулахгүй. Банк төлбөр барагдуулах нь тодорхой байхаас бусад тохиолдолд болзошгүй өр төлбөрийг тодруулгад тусгана. Банкны практикт бүх болзошгүй өр төлбөрийг тэнцлийн гадуур бүртгэдэг.

Банк болзошгүй өр төлбөрөө тайлагнах шаардлагатай байдаг. Жишээлбэл, банк бусдад хохирол учруулсны улмаас шүүхэд дуудагдаж байгаатай холбоотойгоор гарч болзошгүй зардлын дүнг тодруулна. Энэ тохиолдолд холбогдох мөнгөн гүйлгээг тооцоолох боломжтой боловч төлөх магадлалгүй тул нөөцийг хүлээн зөвшөөрч, бүртгэхгүй.

Банк харилцагчдын төлөгдөхөөр урьдчилан таамаглаж буй зүйлд харилцагчдынхаа өмнөөс баримт үйлдэж болно. Банкны тамга тэмдгийг дарсан байх ба нөгөө тал төлбөрөө барагдуулаагүй үед төлбөрийг хийхээр үйлдсэн баримтыг төлбөр хийгдэх хүртэл эсвэл уг баримтын хугацаа дуусгавар болох хүртэл болзошгүй өр төлбөрт бүртгэнэ. Үүнд баримтын болон арилжааны аккредитив, вексел, зайлшгүй шаардлагатай үед хэрэглэх аккредитив (үүнийг мөн хугацаагүй баталгаа гэж нэрлэдэг) зэрэг багтана. Эдгээртэй холбогдуулан банкинд мөнгө эргэн төлөгдөхгүй байх эрсдэл үүснэ. Үүний улмаас балансын өдрөөр хүчин төгөлдөр буй ийм баримтыг болзошгүй өр төлбөр гэж үзнэ.

Мөн банк янз бүрийн зорилгоор баталгаа гаргадаг. Балансын өдрөөр хүчин төгөлдөр буй баталгааг болзошгүй өр төлбөр гэж үзнэ. Баталгаатай холбогдуулан банкинд төлбөрийн нэхэмжлэл ирэхгүй боловч төлбөр төлж болзошгүй эрсдэл үүсч байгаа тул үүнийг болзошгүй өр төлбөрөөр бүртгэнэ.

Зээлд хамаарах үүргийг мөн болзошгүй өр төлбөр гэж үзнэ. Банк харилцагчидтайгаа зээл олгох гэрээ байгуулсан боловч уг гэрээний дагуу хараахан зээл олгоогүй байж болно. Зээлд хамаарах үүрэгт хараахан ашиглагдаагүй байгаа овердрафтын дүн, өөрт ноогдох дүнг хараахан шилжүүлээгүй байгаа хамтын зээлжүүлэлтийн дүн зэрэг багтана. Банк хүлээсэн үүргийн дагуу мөнгийг шилжүүлэхэд бэлэн байна.

Банк зээлд хамаарах үүрэгт зориулсан нөөцийг “Хэмжилт ба үнэлгээ” хэсэгт оруулсан удирдамжийн дагуу тодорхойлно. СТОУС 7-д заасан санхүүгийн эрсдэлтэй холбоотой хийгдэх тодруулгыг “Санхүүгийн эрсдэл болон өөрийн хөрөнгийн удирдлага, бусад тодруулга” бүлэгт оруулсан.

8) Зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй зээл ба бүцалтгүй тусламж

Үүссэн янз бүрийн нөхцөл, бүртгэлийн нарийн төвөгтэй байдлыг харуулсан дэлгэрэнгүй удирдамжийг, холбогдох жишээний хамт энэ бүлгийн “Хэмжилт ба үнэлгээ” хэсэгт оруулсан.

9) Мөнгөөр төлөгдөх хувьцаанд суурилсан өр төлбөр

“Өөрийн хөрөнгө” бүлгийг үзнэ үү. Үнэлгээ, хэмжилттэй холбоотой заалтуудыг энэ бүлгийн “Хэмжилт ба үнэлгээ” хэсэгт оруулсан.

10) Хоёрдогч өглөг

Захиран зарцуулах эрхийг хязгаарласан, 5 жилээс дээш хугацаатай, үйл ажиллагааны эцсийн үр дүнд хувь нийлүүлсэн хөрөнгөнд оруулах болзолтой эх үүсвэрийг тусад нь салгаж хоёрдогч өглөгийн дансанд бүртгэнэ. Хоёрдогч өглөгийг бусад эх үүсвэртэй адилхан бүртгэнэ.

Хоёрдогч өглөгийг хугацааны эцэст нь өөрийн хөрөнгөнд хөрвүүлэх нөхцөлтэй гаргаж болно. Хэрэв хоёрдогч өглөгийг өөрийн эх үүсвэрээр барагдуулах зөвшөөрлийг хувьцаа эзэмшигчид өгдөг бол өрийн хэрэгслийг эзэмшигчид эрх үүсэхгүй (өрийн хэрэгслийг эзэмшигчийн сонголтыг харгалзахгүй). Энэ тохиолдолд өөрийн хөрөнгөнд хөрвүүлэх хэсгийг үнэлэх боломжгүй болох тул хоёрдогч өглөгийг 100% өр төлбөрөөр тайлагнах ба хувьцааны опцион байхгүй гэж үзнэ.

Өр төлбөрийг хоёрдогч өглөг рүү шилжүүлэхэд

Дебит: Эх үүсвэр, өр төлбөрийн холбогдох данс
Кредит: Хоёрдогч өглөг

Хоёрдогч өглөгийг мөнгөөр барагдуулсан бол

Дебит: Хоёрдогч өглөг
Кредит: Мөнгөн хөрөнгө

Хоёрдогч өглөгийг өөрийн эх үүсвэрээр буюу хувьцаагаар барагдуулахад

Дебит: Хоёрдогч өглөг
Кредит: Энгийн хувьцаа

Кредит: Нэмж төлөгдсөн капитал

Зарим тохиолдолд хоёрдогч өглөг нь НББОУС 32-ын дагуу өр төлбөр бус харин өөрийн хөрөнгийн тодорхойлолтыг хангаж болно. Ийм тохиолдолд үүнийг өөрийн хөрөнгөнд бүртгэнэ. Өөрийн хөрөнгөөр ангилах шалгуурыг "Өөрийн хөрөнгө" бүлэгт оруулсан (өр төлбөр ба өөрийн хөрөнгийг харьцуулсан).

Е. ТОДРУУЛГА

Бусад өр төлбөрт багтсан хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг, бусдад өгөх өглөг, салбар хоорондын өглөг, клирингийн тооцооны өглөг, тооцооны бусад өглөг, тухайлбал, татвар, НДШ-ийн өглөг, ажилтнуудтай үүссэн тооцоо зэргийг өмнөх тайлант үеийн үлдэгдэлтэй харьцуулан тодруулна.

Ажилтнуудын тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн хөгжлийн сантай холбоотойгоор дараах зүйлсийг тодруулна:

- Тэтгэвэр, тэтгэмжийн төрлүүд, тэдгээрт харгалзах зардал
- Урт хугацаат тэтгэвэр, тэтгэмжийн актуар тооцоолол, холбогдох орлого, зардал
- Удирдах албан тушаалтнуудад олгохоор тооцоолсон нийт тэтгэвэр, тэтгэмжийн дүн
- Ажилтнуудад хувьцаагаар олгосон шагнал, урамшуулал, тэтгэвэр, тэтгэмж ба хувьцаанд суурилсан төлбөрийн нөхцөл

Банк зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй зээлийг анх удаа хүлээн зөвшөөрөх үед орлого бүртгээгүй бол энэ бүлгийн "Хэмжилт ба үнэлгээ" хэсэгт оруулсан удирдамжийн дагуу уг бүртгэлд хамаарах банкны удирдлагын шийдвэрийг тодруулна.

Түүнчлэн санхүүгийн тайлангийн тодруулгад багтах бусад тодруулгыг санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх аргачлал (Хавсралт 4)-д заасан.

Ё. ХЯНАЛТ

- Ажилтнуудын ажил үүргийн хуваарийг тусгаарлана.
- Өр төлбөрийг тооцоо үүссэн субъект бүрээр дэлгэрэнгүй бүртгэл хөтөлнө.
- Дэлгэрэнгүй бүртгэлийг хяналтын дансны үлдэгдэлтэй тохируулна.
- Ажил гүйлгээний анхан шатны баримтын бүрдлийг хангана.
- Тайлант үеийн эцэст холбогдох талтай өр төлбөрийн дүнг тулган баталгаажуулна.

ЗУРГАА. ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

А. ШУУД ХОЛБОГДОХ СТАНДАРТУУД

- СТОУС 2 Хувьцаанд суурилсан төлбөр
- СТОУС 7 Санхүүгийн хэрэгсэл: Тодруулга
- СТОУС 9 Санхүүгийн хэрэгсэл
- НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- НББОУС 32 Санхүүгийн хэрэгсэл: Толилуулга
- НББОУС 39 Санхүүгийн хэрэгсэл: Хүлээн зөвшөөрөлт, хэмжилт
- СТОУСТХ 17 Мөнгөн бус хөрөнгийг эзэмшигчдэд хуваарилах нь

Б. ТОДОРХОЙЛОЛТ

Эздийн өмч буюу өөрийн хөрөнгө нь банкны бүх өр төлбөрийг барагдуулсны дараа үлдэх хөрөнгө юм.

Хувьцаа нь банкинд хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн санал өгөх, ногдол ашиг авах, банкыг татан буулгахад түүний эд хөрөнгөөс тодорхой хэсгийг өмчлөх эрхийг гэрчилж буй үнэт цаас юм. Хувьцаа нь энгийн болон давуу эрхийн хувьцаа гэсэн хоёр төрөлтэй байна.

Банкнаас гаргасан нийт давуу эрхийн болон энгийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнг *хувь нийлүүлсэн хөрөнгө* гэнэ.

Нэмж төлөгдсөн капитал нь хувьцааны нэрлэсэн үнээс илүү төлөгдсөн зөрүүг хэлнэ.

Банк гаргасан хувьцаанаасаа эргүүлэн худалдан авсан хувьцааг *халаасны хувьцаа* гэнэ.

Хуримтлагдсан ашиг нь үйл ажиллагаа эхэлсэн үеэс хуримтлагдаж, ногдол ашигт хуваарилах буюу сан байгуулсны дараа үлдэж буй цэвэр ашиг юм.

Нөөцийн сан гэж ерөнхий эрсдэлээс хамгаалахад зориулан байгуулсан санг хэлнэ.

В. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

Өөрийн хөрөнгө дараах шалгуурыг хангавал хүлээн зөвшөөрч, бүртгэнэ:

- Ирээдүйд эдийн засгийн үр өгөөж гадагшлах магадлалтай;
- Өртгийг бодитой тооцох боломжтой.

Г. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

Өөрийн хөрөнгийг түүхэн өртгөөр үнэлж, бүртгэнэ.

Д. АНГИЛАЛ

Санхүүгийн тайланд өөрийн хөрөнгийг хувьцаа эзэмшигчдээс оруулсан хувь нийлүүлсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг, хуримтлагдсан ашгийн тусгай зориулалтын сангууд гэсэн дэд ангиллаар толилуулна. Үүнд хамрагдах зүйлс нь:

1. Энгийн болон давуу эрхийн хувьцаа
2. Дахин үнэлгээний нэмэгдэл
3. Нөөцүүд буюу тусгай зориулалтын сангууд
4. Тайлант жилийн болон хуримтлагдсан ашиг алдагдал

Е. БҮРТГЭЛ

6.1. ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

Хувьцаа эзэмшигчид банкинд хувьцаагаар хөрөнгө оруулна.

Нээлттэй хэлбэрээр зохион байгуулагдсан банкны хувьд үнэт цаас гаргаж нийтэд санал болгох, худалдах ажиллагаа нь Монгол Улсын “Үнэт цаасны зах зээлийн тухай” хууль, холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдэх ба нягтлан бодох бүртгэлийг СТОУС, Монгол Улсад мөрдөгдөж буй холбогдох хууль, тогтоомж болон энэхүү зааврын дагуу гүйцэтгэнэ.

Хувьцаа нь банкны дүрмээр тогтоосон нэрлэсэн үнэтэй байна.

Банкны удирдлагын эрх бүхий субъектын шийдвэр, Монголбанкны зөвшөөрлийг үндэслэн хувьцаа эзэмшигчдээс банкны хувьцаат капиталыг нэмэгдүүлэхэд

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Энгийн (давуу эрхийн) хувьцаа

6.2. НЭМЖ ТӨЛӨГДСӨН КАПИТАЛ

Нэмж төлөгдсөн капитал нь хувьцааны нэрлэсэн үнээс илүү төлөгдсөн дүнг бүртгэдэг, хувьцааны урамшууллыг илэрхийлсэн данс юм. Энэ нь халаасны хувьцаа, хувьцаа эргэлтээс гаргалттай холбоотой зарим ажил гүйлгээгээр өсч, буурна.

Хувьцааг нэрлэсэн үнээс илүү үнээр гаргахад

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс (худалдсан үнээр)
Кредит: Энгийн хувьцаа (нэрлэсэн үнээр)
Кредит: Нэмж төлөгдсөн капитал (үнийн зөрүүгээр)

Монгол Улсын "Компанийн тухай" хуулийн дагуу нэрлэсэн үнэтэй хувьцааг нэрлэсэн үнээс доогуур үнээр борлуулахыг хориглоно.

6.3. ДАВУУ ЭРХИЙН ХУВЬЦАА

Давуу эрхийн хувьцааг гаргасан нөхцлөөс нь шалтгаалан өөрийн хөрөнгө болон өр төлбөрөөр бүртгэнэ. Компанийн тухай хуулийн дагуу давуу эрхийн хувьцаа гэж бусад төрлийн хувьцаа, ялангуяа энгийн хувьцаатай холбоотой зарим нэг давуу эрхийг агуулсан хувьцааг хэлнэ. Давуу эрхийн хувьцааны олон төрөл байдаг боловч энэ нь тогтмол ногдол ашиг хуваарилж, банкийг татан буулгах үед тогтмол хэмжээний хөрөнгө авах эрхийг хэлнэ (ийм эрх бүхий давуу эрхийн хувьцааг оролцоотой давуу эрхийн хувьцаа гэнэ).

Банкны гаргасан өрийн ба өмчийн хэрэгслийг хооронд нь ялгах зарчмыг НББОУС 32-д тодорхойлсон ба санхүүгийн хэрэгслийг ангилахдаа гэрээний хэлбэр бус харин агуулгыг анхаарна. Санхүүгийн хэрэгслийг ангилах үед ашиглагдах түүний "агуулга" нь тухайн хэрэгслийн гэрээний нөхцлөөр тодорхойлогдоно.

НББОУС 32-ын дагуу дараах хоёр нөхцөл зэрэг хангагдаж байгаа тохиолдолд тухайн хэрэгслийг өмчийн хэрэгсэл гэж тодорхойлсон:

- Бусад аж ахуйн нэгжид мөнгө болон бусад санхүүгийн хөрөнгө шилжүүлэх гэрээний үүрэг хүлээгээгүй;
- Тухайн хэрэгслийг банкны хувьцаагаар барагдуулах үед энэ нь дараах төрлийн хэлцэл болох бол:
    - Банк тодорхойгүй тооны хувьцаа гарган өр төлбөрийг барагдуулах үүрэг хүлээгээгүй дериватив бус хэлцэл;
    - Банк тодорхой тооны хувьцааг тогтсон дүн бүхий мөнгө болон бусад санхүүгийн хөрөнгөөр арилжаалах дериватив хэлцэл.

Дээрхээс бусад тохиолдолд банкны гаргасан хэрэгслийг санхүүгийн өр төлбөр гэж үзнэ. Хэрэв гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд тодорхой нөхцөл тавилгүйгээр мөнгөн болон бусад санхүүгийн хөрөнгийг шилжүүлэхээс татгалзах эрхгүй тохиолдолд тухайн хэлцлийг эздийн өмчөөр бүртгэнэ. Хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгө буцалтгүй ба банк ногдол ашгийг төлөхөөс татгалзах эрхтэй тохиолдолд энэхүү давуу эрхтэй хувьцааг өөрийн хөрөнгөөр ангилна. Хэрэв банк давуу эрхийн хувьцааг эргүүлэн төлөх буюу ногдол ашгийг заавал төлөх үүрэгтэй бол тухайн хувьцааг санхүүгийн өр төлбөр гэж үзнэ. Эдгээр шалгуур нь бусад санхүүгийн хэрэгсэл буюу тухайлбал хоёрдогч өглөгт мөн ашиглагдана.

Жишээ: Банк ногдол ашгийг өмнөх хугацаанд жил бүр төлж байсан ч татгалзах эрхтэй болсон

Банк 6%-иар тогтмол ногдол ашиг төлөх, хувьцаанд хөрвөх, худалдан авах эрхтэй, хоёрдогч өглөгтэй. Ногдол ашгийг банкны шийдвэрээр хойшлуулж болдог. Уг хэрэгслийг гаргагч (банк) нь ногдол ашгийг жил бүр төлж байсан түүхтэй бөгөөд уг хэрэгслийг эзэмшиж буй этгээд жил бүр ногдол ашиг авна гэж таамагласны үндсэн дээр уг хоёрдогч өглөгийн өнөөгийн үнийг тогтоосон. Мөн банк ногдол ашгийг жил бүр төлөх бодлого баримталдаг.

Хэдийгээр хэрэгслийг гаргагч ногдол ашиг төлөх үүрэг хүлээсэн боловч уг үүрэг нь гэрээний дагуу үүсээгүй байна. Иймээс энэ бондыг өөрийн хөрөнгөөр ангилна.

Жишээ: 6%-ийн тогтмол ногдол ашгийг төлөх бөгөөд эргүүлэн төлөх нөхцөлтэй давуу эрхийн хувьцаа

Эргүүлэн төлөх нөхцөлтэй давуу эрхийн хувьцааг санхүүгийн өр төлбөр ба өөрийн хөрөнгийн аль нь болохыг тогтоохын тулд тухайн хэрэгслийн үндсэн төлбөр ба өгөөжид хамаарах гэрээний нөхцлийг

шалгана. Энэ жишээнд уг хэрэгслийн нөхцлөөр тогтмол ногдол ашгийг заавал төлөх бөгөөд банк заасан хугацаанд тогтмол дүнгээр эргүүлэн төлнө. Банк мөнгө шилжүүлэх гэрээний үүргээс (ногдол ашиг болон үндсэн төлбөр) зайлсхийх боломжгүй тул уг хэрэгслийг бүхэлд нь санхүүгийн өр төлбөрөөр ангилна.

Жишээ: Ногдол ашгийг заавал төлөх, эргүүлэн авахгүй давуу эрхийн хувьцаа

Давуу эрхийн хувьцааг эргүүлэн авахгүй бол түүний ангиллыг тогтоохдоо бусад нөхцлийг харгалзана. Ангиллыг хийхдээ санхүүгийн өр төлбөр ба өмчийн хэрэгслийн тодорхойлолт, гэрээний агуулгыг үнэлнэ.

Тухайн хэрэгслийн үндсэн төлбөр ба өгөөжид хамаарах гэрээний тодорхой нөхцлийг авч үзнэ. Энэ жишээнд уг хувьцааг эргүүлэн авах боломжгүй бөгөөд үндсэн төлбөрт хувьцааны шинж чанар агуулагдаж байгаа боловч ногдол ашгийг төлөх гэрээний үүрэг хүлээнэ. Хэрэв банкны хөрөнгө эсвэл хуримтлагдсан ашиг нь хүрэлцэхгүй шалтгаанаар ногдол ашгаа төлөх боломжгүй тохиолдолд дээрх үүргийг биелүүлэх боломжгүй болно. Тиймээс ногдол ашиг төлөхөөр хүлээж буй үүрэг нь санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангана.

Хувьцаа нь бүрэлдэхүүн хэсэг бүрээр салган бүртгэх боломжтой нийлмэл хэрэгсэл юм. Хувьцааны ногдол ашгийг зах зээлийн дундаж хувь хэмжээгээр бус харин анхнаасаа тогтмол хувь хэмжээгээр тогтоосон бөгөөд үүний зэрэгцээ банкны шийдвэрээр ногдол ашгийг төлөх эсэх талаар ямар нэгэн заалт огт байхгүй тохиолдолд холбогдох мөнгөн гүйлгээг байнга гарна гэж үзэн уг хувьцаа нийлмэл хэрэгсэл болно.

Жишээ: Хугацаагүй өр төлбөр

“Хугацаагүй” өрийн хэрэгсэл (“хугацаагүй” бонд ба өрийн бичиг гэх мэт) нь ямар нэгэн хугацаа заагаагүй боловч гэрээний дагуу тогтсон хугацааны давтамжтайгаар хүүгийн төлбөрийг төлдөг хэрэгсэл юм. Уг хэрэгслийн эзэмшигч нь үндсэн өр төлбөрийг эргүүлэн авах эрхгүй буюу эсвэл ойрын хугацаанд үндсэн өрийг төлүүлэх эрхгүй байдаг. Банк тогтмол хүү төлж байгаа учир энэхүү хэрэгсэл нь санхүүгийн өр төлбөр болно. Банк 1 сая төгрөгийн нэрлэсэн дүнгээс жил бүр 8%-иар хүү бодох санхүүгийн хэрэгсэл гаргасан. 8%-ийн хүүгийн түвшин нь уг хэрэгслийг гаргах үеийн зах зээлийн хүүгийн түвшин гэж үзвэл уг хэрэгслийн хүүгийн төлбөрийг өнөөгийн үнэ цэнээр үнэлж, бүхэлд нь санхүүгийн өр төлбөрөөр ангилна. Энэ нөхцөл байдалд уг хэрэгслийг эзэмшигч нь санхүүгийн хөрөнгөөр, гаргагч банк нь санхүүгийн өр төлбөрөөр бүртгэнэ.

Өрийн ба өмчийн хэрэгслийг ангилахдаа гэрээний нөхцлүүдийг нэг бүрчлэн харгалзан үзнэ. Санхүүгийн хэрэгслийг буруу ангилсны улмаас гарсан өр төлбөр, бусад харьцаа, ашгийн дүн нь хөрөнгө оруулагч болон санхүүгийн тайлангийн бусад хэрэглэгчдэд нөлөө үзүүлж болзошгүй юм. Иймээс банк гэрээний нөхцөлд хийсэн шинжилгээ болон СТОУС-ын дагуу гүйцэтгэсэн шинжилгээнд үндэслэн давуу эрхийн хувьцааг өөрийн хөрөнгө ба өр төлбөрийн аль нэгээр ангилсан талаарх шалтгаанаа баримтжуулж, тайлбарлана (жишээлбэл, эргүүлэн төлөхгүй хувьцаа, ногдол ашгийг банкны шийдвэрээр төлөх эрх гэх мэт).

Дээрх шинжилгээнд үндэслэн давуу эрхийн хувьцааг өөрийн хөрөнгө гэж тодорхойлсон тохиолдолд дараах байдлаар бүртгэнэ:

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс (худалдсан үнээр)
Кредит: Давуу эрхийн хувьцаа (өөрийн хөрөнгө) (нэрлэсэн үнээр)
Кредит: Нэмж төлөгдсөн капитал (зөрүүгээр)

Дээрх шинжилгээнд үндэслэн давуу эрхийн хувьцааг өр төлбөр гэж тодорхойлсон тохиолдолд дараах байдлаар бүртгэнэ:

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс (худалдсан үнээр)
Кредит: Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр) (худалдсан үнээр буюу бодит үнэ цэнээр)

Зарим тохиолдолд өр төлбөрөөр бүртгэсэн давуу эрхийн хувьцаанд өмчийн опцион буюу энгийн хувьцаанд хөрвүүлэх опцион агуулагдсан байдаг. Мөн дээр тайлбарласанчлан өөрийн хөрөнгө болох хэсэгтэй байж болно. Энэ тохиолдолд давуу эрхийн хувьцаанд өр төлбөр, өөрийн хөрөнгө аль аль нь багтаж байгаа ба эдгээр хэрэгслийг анх гаргах үед салгаж бүртгэнэ.

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)
Кредит: Хувьцааны опшин (өөрийн хөрөнгө)

6.4. ХАЛААСНЫ ХУВЬЦАА

Банк өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авсан бол халаасны хувьцаа гэж үзэх ба үүнд НББОУС 32-т заасны дагуу дараах шаардлага тавигдана.

- Халаасны хувьцааны дүнгээр өөрийн хөрөнгийг бууруулна. Хэдийгээр банк өөрийн өмчийн хэрэгслийг эзэмшиж байгаа боловч үүнийг санхүүгийн хөрөнгө гэж үзэхгүй тул ийнхүү өөрийн хөрөнгөөс хасч харуулна.
- Банкны өөрийн өмчийн хэрэгслийг худалдан авах, худалдах, шинээр гаргах, эргэлтээс гаргах зэрэг тохиолдолд ямар нэгэн орлого, зардал бүртгэхгүй. Үүний шалтгаан нь халаасны хувьцаатай холбоотой арилжаа нь банкны өөрийн өмчлөгчийн хувьд хийгдэх арилжаа учир орлого, зардал олох арилжаа биш гэдэгтэй холбоотой.
- Банкны өөрийн өмчийн хэрэгслээ худалдан авах, худалдахтай холбоотой төлсөн буюу төлөгдсөн мөнгийг өөрийн хөрөнгөнд бүртгэнэ.

Хувьцааны арилжаатай холбоотой зардлыг бүртгэхдээ өөрийн хөрөнгийг бууруулж, халаасны хувьцааг худалдан авахтай шууд холбоотой зардлыг өөрийн хөрөнгөнд бүртгэн, өмчийн өөрчлөлтийн тайланд харуулна.

Халаасны хувьцааг өртгийн ба нэрлэсэн үнийн аргаар бүртгэнэ.

1) Халаасны хувьцааг бүртгэх нэрлэсэн үнийн арга

Банк хувьцаагаа эргүүлэн худалдан авахад Халаасны хувьцаа дансанд нэрлэсэн үнээр нь бүртгэнэ.

Дебит: Халаасны хувьцаа (нэрлэсэн үнээр)
Дебит эсвэл Кредит: Нэмж төлөгдсөн капитал (үнийн зөрүүгээр)
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс (төлсөн дүнгээр)

Хэрэв халаасны хувьцааг эргүүлэн худалдаж, эргэлтэнд гаргасан бол

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс (авсан дүнгээр)
Дебит эсвэл Кредит: Нэмж төлөгдсөн капитал (үнийн зөрүүгээр)
Кредит: Халаасны хувьцаа (нэрлэсэн үнээр)

2) Халаасны хувьцааг бүртгэх өртгийн арга

Банк хувьцаагаа эргүүлэн худалдан авахад Халаасны хувьцаа дансанд төлсөн дүнгээр буюу өртгөөр нь бүртгэнэ.

Дебит: Халаасны хувьцаа (өртгөөр)
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс (өртгөөр)

Хэрэв халаасны хувьцааг эргүүлэн худалдаж, эргэлтэнд гаргасан бол

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс (авсан дүнгээр)
Дебит эсвэл Кредит: Нэмж төлөгдсөн капитал (зөрүүгээр)
Кредит: Халаасны хувьцаа (өртгөөр)

Нэмж төлөгдсөн капитал дансны үлдэгдэл хүрэлцэхгүй тохиолдолд нэмж төлөгдсөн капитал дансыг тэглэсний дараа уг нэмж төлөгдсөн капитал дансны дебит талд бичигдэх дүнг хуримтлагдсан ашиг дансанд бүртгэнэ.

6.5. ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭГДЭЛ

Дараах тохиолдолд дахин үнэлгээний нэмэгдэл бий болно. Үүнд:

- Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгөнд дахин үнэлгээний загварыг ашигласан;
- Банк борлуулахад бэлэн гэж ангилсан үнэт цаас эзэмшдэг бол энэ үнэт цаасыг бодит үнэ цэнээр бүртгэж, данснаас хасах хүртэл бодит үнэ цэнд гарсан өөрчлөлтийг өөрийн хөрөнгөнд бүртгэнэ (үнэ цэнийн бууралт үүсээгүй тохиолдолд).

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн бүртгэлийг энэхүү зааврын үндсэн хөрөнгийн бүртгэлийн бүлэгт тусгасан. Мөн борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаасны дахин үнэлгээний бүртгэлийг Хөрөнгө оруулалт бүлэгт тусгасан болно.

6.6. ХУРИМТЛАГДСАН АШИГ, АЛДАГДАЛ

Хуримтлагдсан ашиг дансанд орлого, зардлыг бүртгэхгүй. Хуримтлагдсан ашгийг нэмэгдүүлэх, эсвэл бууруулах дараах нийтлэг зүйлс байна.

Хуримтлагдсан ашгийн дебитэд:

- Тайлант үеийн цэвэр алдагдал
- Өмнөх үеийн залруулга ба нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт
- Ногдол ашиг хуваарилалт
- Халаасны хувьцааны гүйлгээ

Хуримтлагдсан ашгийн кредитэд:

- Тайлант үеийн цэвэр ашиг
- Өмнөх үеийн залруулга, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт
- Дахин үнэлгээний бууралт (хэрэгжсэн хэсэг)
- Өөрийн хөрөнгийн сан, нөөцийн дансыг хаах буцаалт

Тайлант жилийн эцэст банк, түүний салбарууд хаалтын гүйлгээ хийж, тухайн жилийн цэвэр ашиг, алдагдлыг тодорхойлно.

Тайлант үеийн болон өмнөх жилийн хуримтлагдсан ашгийг тусдаа дансанд бүртгэж болно.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл, түүнд гарсан өөрчлөлтийг орлогын дэлгэрэнгүй тайланд дэлгэрэнгүй орлого, зардлаар толилуулж, нийт дэлгэрэнгүй орлогыг тооцоолох ба энэ нь хуримтлагдсан ашигт хамаарахгүй тул үүнийг өмчийн өөрчлөлтийн тайланд толилуулна.

Ашгийн хуваарилалт

Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал ба удирдлага тайлант жилийн цэвэр ашгийг хуваарилах шийдвэр гаргаж, ногдол ашиг хуваарилах талаар Монголбанкнаас зөвшөөрөл авна.

Ногдол ашиг хуваарилахаар зарласан үед хуваарилах ногдол ашгийн дүнгээр

Дебит: Өмнөх жилийн хуримтлагдсан ашиг
Кредит: Ногдол ашгийн өглөг

Ногдол ашгийг мөнгөөр олгоход

Дебит: Ногдол ашгийн өглөг
Кредит: Мөнгөн хөрөнгийн данс болон хувьцаа эзэмшигчдийн харилцах, хадгаламж

Ногдол ашгийг хувьцаагаар хуваарилахаар шийдвэрлэсэн бол

Дебит: Өмнөх жилийн хуримтлагдсан ашиг
Кредит: Хувь нийлүүлсэн хөрөнгө

Жилийн цэвэр ашгаас банкны нөөцийн сан, банк хөгжүүлэх сан болон бусад тусгай зориулалтын санд хөрөнгө хуваарилахаар шийдвэрлэсэн бол хуваарилах хөрөнгийн дүнгээр

Дебит: Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг
Кредит: Сангийн холбогдох данс

6.7. БУСАД ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

1) Тусгай зориулалттай сан (Нийгмийн хөгжлийн санг оруулсан)

Банк тусгай зориулалтын сан байгуулан ашиглаж болно. Тухайлбал: банк зээлдэгчидтэй холбоотой үүсэх зардлыг хаах үүднээс банкны хууль тогтоомж, бусад эрх зүйн баримт бичигт шаардсаны дагуу сан байгуулж болох юм. Мөн банкны хувьцаа эзэмшигчид, эсвэл бусад эрх бүхий байгууллагын шийдвэрээр сан байгуулж болно. Мөн банк байгуулж болохгүй сангийн талаар журам гаргаж болно.

Зээл болон түүнтэй адилтгах бусад активт байгуулсан эрсдэлийн сангаас бусад санг хуримтлагдсан ашгаас байгуулах тул зардалд бүртгэхгүй.

Өнгөрсөн үйл явдлын үр дүнд эрх зүйн, эсвэл үүсмэл үүрэг үүссэн үед НББОУС 37-ийн дагуу зардал бүртгэж, уг санг өр төлбөрөөр хүлээн зөвшөөрнө. Өөр тохиолдолд зардалд бүртгэх замаар сан байгуулж,

өр төлбөрийг үүсгэхгүй. Гэхдээ дээр дурдсан ийм санг банкны хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий бусад этгээдийн шийдвэрээр хуримтлагдсан ашгаас байгуулж болно.

Тусгай зориулалттай сангаас ногдол ашиг хуваарилж болохгүй. Түүнчлэн банкны хуримтлагдсан ашиг хүрэлцэхгүй эсвэл алдагдлыг хуримтлуулсан (өөрөөр хэлбэл, тайлант болон өнгөрсөн жилүүдэд алдагдалтай ажилласны улмаас хуримтлагдсан ашиг данс сөрөг үлдэгдэлтэй гарсан) тохиолдолд тусгай зориулалттай сан байгуулж болохгүй.

Тусгай зориулалттай санг байгуулахад

Дебит: Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг
Кредит: Сангийн холбогдох данс

Тусгай зориулалтын сангаас зориулалтын дагуу хөрөнгө зарцуулахад

Дебит: Сангийн холбогдох данс
Кредит: Холбогдох хөрөнгийн данс

Банк тусгай зориулалтын санг ашиглаж байх үед тусгай зардал (тухайлбал, ажилтнуудтай холбоотой зардал) гарсан тохиолдолд уг зардлыг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Жишээ нь: хуримтлагдсан ашгаас хуваарилсан нийгмийн хөгжлийн сан нь СТОУС-д заасан өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх шалгуурт нийцээгүй тул өөрийн хөрөнгөд багтах сан юм. Ажилтнуудад тэтгэмж олгох эсэхийг банк шийдвэрлэх бөгөөд тодорхой ажилтнуудад уг тэтгэмжийг олгоно гэдгийг ажилтнууд нь мэдэж байгаа боловч банк уг тэтгэмжийг олгохоор амлаагүй тохиолдолд “Бусад санхүүгийн ба санхүүгийн бус өр төлбөр” бүлэгт заасны дагуу бүртгэнэ.

Банкны шийдвэрийн дагуу тусгай зориулалтаар сан байгуулсан бол үүнийг дараах байдлаар бүртгэнэ. Өөрийн хөрөнгөөс нийгмийн хөгжлийн санг байгуулахтай холбоотой үнэлгээний шаардлага СТОУС-д байдаггүй бөгөөд банк дотооддоо боловсруулсан журмын дагуу хуримтлагдсан ашгаас санг байгуулж болно.

Дебит: Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг
Кредит: Нийгмийн хөгжлийн сан (өөрийн хөрөнгө)

Тайлант жилд банк ажилтнууддаа өмнөх жилүүдэд байгуулсан сангаас тэтгэмж олгох шийдвэр гарсан бөгөөд ажилтнуудтай гэрээ байгуулах (эрх зүйн ба үүсмэл үүрэг) эсвэл тэдэнд мэдэгдэх (зарим нэгэн ажилтнууд тэтгэмж авах талаар ажилтнуудад мэдээлэх) замаар үүрэг хүлээсэн тохиолдолд үүнийг дараах байдлаар бүртгэнэ. “Бусад санхүүгийн ба санхүүгийн бус өр төлбөр” бүлэгт тэтгэмжийн дүнг хэрхэн тооцоолон гаргах талаар оруулсан.

Дебит: Холбогдох зардлын данс (Ажилтнуудтай холбоотой тэтгэмж, шагнал, урамшууллын зардал)
Кредит: Нийгмийн хөгжлийн сангийн өр төлбөр / Цалингийн өглөг

Нийгмийн хөгжийн санд хуваарилсан өөрийн хөрөнгийн санг буцааж, хуримтлагдсан ашигт хаах үед:
Дебит: Нийгмийн хөгжлийн сан (өөрийн хөрөнгө)
Кредит: Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг

Үүний үр дүнд тухайн тайлант үед хуримтлагдсан ашигт ямар ч өөрчлөлт гарахгүй (хүлээн зөвшөөрсөн зардлын дүнгээр буурах хэдий ч нийгмийн хөгжлийн санг нэмж байгуулсан дүнгээр эргээд өснө). Мөн СТОУС-д заасан өр төлбөр, зардлыг хүлээн зөвшөөрөх шалгуур хангагдаж байх үед зардлыг хүлээн зөвшөөрч, бүртгэх юм.

Тусгай зориулалтын санд холбогдох активын ангиллын журам болон СТОУС-ын дагуу шаардсан зээлийн эрсдэлийн сангийн зөрүүг бүртгэх Эрсдэлийн сангийн нөөц багтана. Энэхүү сан, түүний тооцооллыг “Зээл”, “Хөрөнгө оруулалт”, “Бусад санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгө” бүлгүүдээс харна уу. Уг санг хуримтлагдсан ашгаас байгуулах үед:

Дебит: Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг
Кредит: Эрсдэлийн сангийн нөөц

Уг санг бууруулахад:

Дебит: Эрсдэлийн сангийн нөөц
Кредит: Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг

2) Хувьцаанд суурилсан төлбөр

Банкнаас ажилтан, албан хаагчиддаа хувьцаа, түүнтэй адилтгах өмчийн хэрэгслээр (жишээлбэл, хувьцааны опшин) эсвэл түүнд суурилсан мөнгөн төлбөрөөр шагнал, урамшуулал олгох, гуравдагч этгээдэд төлбөр тооцоо барагдуулахыг хувьцаанд суурилсан төлбөр гэнэ. СТОУС 2 -ыг дараах төлбөр тооцоонд мөрдөнө:

- хувьцаагаар төлөгдөх төлбөр;
- хувьцаанд суурилсан мөнгөөр төлөгдөх төлбөр;
- Банк бараа, ажил, үйлчилгээ худалдан аваад, гэрээний нөхцлийн дагуу уг бараа, ажил, үйлчилгээний төлбөрийг мөнгөөр (бусад хөрөнгөөр) эсвэл хувьцаа гарган барагдуулах сонголт олгож байгаа тохиолдол.

Хэрэв банкны ажилтнууд болон гуравдагч этгээд банкинд үйлчилгээ үзүүлээд, түүнийхээ төлбөрт банкны толгой компани эсвэл банкны нэгдлийн бусад компанийн өмчийн хэрэгслийг авч байгаа тохиолдолд уг ажил гүйлгээг СТОУС 2-д нийцүүлэн бүртгэх ба банк уг ажил гүйлгээг хувьцаанд суурилсан төлбөрийн дансаар дамжуулан бүртгэнэ.

Баталгаажих хугацаа гэдэг нь хувьцаанд суурилсан төлбөрийн хэлцэлд заасан баталгаажих бүх нөхцөл хангагдах хугацааг хэлнэ. Баталгаажих нөхцөл гэж банк бараа, ажил, үйлчилгээг авч, хувьцаанд суурилсан төлбөрийн хэлцлийн дагуу төлбөрийг мөнгө, бусад хөрөнгө, өөрийн өмчийн хэрэгслээр нөгөө талд (ажилтан, бэлтгэн нийлүүлэгч) барагдуулах үүрэг хүлээсэн эсэхийг тогтоох нөхцлийг ойлгоно. Баталгаажих нөхцөл нь үйлчилгээний болон гүйцэтгэлийн гэж байдаг. Үйлчилгээний нөхцлийн дагуу бараа, ажил, үйлчилгээг заасан хугацаанд бүрэн нийлүүлэхийг шаарддаг. Гүйцэтгэлийн нөхцлийн дагуу нөгөө тал нь тодорхой хугацаанд багтан үйлчилгээ үзүүлэх буюу тодорхой даалгаварыг биелүүлэхийг (тухайлбал, банкны тодорхой хугацаанд харгалзах ашгийг нэмэгдүүлэх гэх мэт) шаарддаг. Жишээлбэл, ажилтнуудтай гэрээ байгуулснаас хойш 5 жил ажиллахыг шаардах ба уг нөхцлийн хангаснаар ажилтан шагналыг авах эрх үүсэх буюу хувьцааны опционыг авах эрхтэй болно. Баталгаажих хугацаа заагаагүй зарим хөтөлбөрийг доор тайлбарласан.

Зөвшөөрсөн өдөр гэж банк ба нөгөө тал (ажилтнуудыг оруулсан) хувьцаанд суурилсан төлбөрийн хэлцлийн бүх нөхцлийг харилцан зөвшөөрч, уг хэлцлийг байгуулсан өдөр юм. Зөвшөөрсөн өдөр банк нь харилцагч талдаа баталгаажих нөхцлийг тавьж, мөнгө, бусад хөрөнгө, өөрийн өмчийн хэрэгслийг эзэмших эрхийг шилжүүлнэ. Хэрэв уг хэлцлийг баталгаажуулах ёстой бол түүнийг зөвшөөрсөн өдрийг батлагдсан өдөр гэж тооцно.

Хувьцаагаар төлөгдөх төлбөр гэж банк хувьцааны төлбөрт бараа, ажил, үйлчилгээ авсан эсвэл бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа үнийг нь мөнгөөр бус хувьцаагаар барагдуулахыг хэлнэ. Энэ тохиолдолд банк мөнгөөр төлбөрийг барагдуулах үүрэг хүлээхгүй.

Мөнгөөр төлөгдөх хувьцаанд суурилсан төлбөр бүхий ажил гүйлгээ гэж өр төлбөрөөр тооцон банкны бэлтгэн нийлүүлэгчдэд төлөх бараа, ажил, үйлчилгээний үнийг банк, банкны нэгдэлд багтсан аж ахуйн нэгжийн өмчийн хэрэгсэл (хувьцаа, хувьцааны опционыг оруулсан)-ийн үнэ (үнэлгээ)-д үндэслэн тооцсон ажил гүйлгээг хэлнэ.

Жишээлбэл, хэрэв банк ажилтнууддаа хувьцаа хуваарилах төлөвлөгөөний дагуу үүрэг хүлээсэн бөгөөд үүнийг ажилтнууд нь санаачилсан бол энэ нь мөнгөөр төлөгдөх хувьцаанд суурилсан төлбөр болно. Хэрэв хувьцаа хуваарилах төлөвлөгөөнд хамрагдсан ажилтнууд эзэмшиж буй хувьцаагаа ямар нэгэн хязгаарлалтгүйгээр гуравдагч этгээдэд худалдах эрхтэй тохиолдолд энэ нь өмчөөр хаагдах хувьцаанд суурилсан төлбөр болно. Хувьцаанд суурилсан төлбөрийг зөв ангилах нь чухал бөгөөд банк ангилал хийхэд хамаарах СТОУС 2-ын заалтуудыг болон уг төлбөртэй холбоотой дэлгэрэнгүй шинжилгээг гүйцэтгэж, баримтжуулна.

а) Хувьцаанд суурилан төлбөр барагдуулах тухай хэлцэл хийгдсэнээр холбогдох өөрийн хөрөнгийг бүртгэнэ (өмчөөр хаагдах хувьцаанд суурилсан төлбөр).

Дебит: Зардлын холбогдох данс эсвэл Хөрөнгийн холбогдох данс
Кредит: Хувьцааны опцион

Ажилтнуудтай холбоотой хувьцаанд суурилсан төлбөрийн хувьд холбогдох зардлын дансыг ашиглана. Гэхдээ гуравдагч талын хувьд хөрөнгө худалдан авахын тулд хувьцаа гаргасан бол хөрөнгийн дансанд (тухайлбал, бараа материал) бүртгэнэ. Бэлтгэн нийлүүлэгч үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд зардалд бүртгэнэ.

Банк үйлчилгээг үзүүлж дуусаны дараа хувьцаанд суурилсан төлбөрийг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Ажилтнуудтай холбоотой өмчөөр хаагдах хувьцаанд суурилсан төлбөрийн хувьд банк ажилтны үзүүлсэн үйлчилгээг хэмжихдээ зөвшөөрсөн өмчийн хэрэгслийн бодит үнэ цэнийг ашиглах ба өөрийн хөрөнгийг шууд нэмэгдүүлэн бүртгэнэ. Өмчөөр хаагдах хувьцаанд суурилсан төлбөр бүхий хэлцэлтэй холбоотой хүлээсэн үүргийг бусад дэлгэрэнгүй орлогоор бус харин өөрийн хөрөнгийн өөрчлөлт байдлаар тайлагнана.

Өмчөөр хаагдах төлбөрт хамаарах зардлыг зөвшөөрсөн өмчийн хэрэгслийн бодит үнэ цэнд үндэслэн баталгаажих хугацаанд хуваарилж бүртгэнэ. Бодит үнэ цэнийг зөвшөөрсөн өдрөөр үнэлэх ба цаашид дахин үнэлэхгүй. Жишээлбэл, хэрэв зөвшөөрсөн өдрөөр өмчийн хэрэгслийн бодит үнэ цэн 100 төгрөг байсан ба баталгаажих хугацаа 5 жил (өөрөөр хэлбэл ажилтанд хувьцаа эзэмших эрх үүсэхийн тулд банкиндаа 5 жил ажиллах шаардлага тавигдаж байна) байгаа тохиолдолд жил бүр 20 төгрөгийн зардал хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

Хэрэв зөвшөөрсөн өмчийн хэрэгслийг шууд баталжуулсан бол нөгөө тал (ихэнхдээ ажилтнууд) уг өмчийн хэрэгслийг тодорхой нөхцөл тавилгүй эзэмших эрх үүсгэхийн тулд нэмэлт үйлчилгээ үзүүлэх шаардлагагүй болно. Энэ тохиолдолд зөвшөөрсөн өдрөөр банк үзүүлсэн үйлчилгээг бүрэн хүлээн зөвшөөрч, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэн бүртгэнэ. Энэ нь зардлыг нийт дүнгээр шууд хүлээн зөвшөөрч, бүртгэх буюу өөрөөр хэлбэл дээрх жишээний хувьд 5 жилд хуваарилж бүртгэхгүй, харин 100 төгрөгийг хувьцаанд суурилсан төлбөрийн зардалд шууд бүртгэнэ.

Баталгаажих хугацааны эцэст хийгдэх бүртгэл нь тухайн хөтөлбөрийн үйл явцаас шалтгаалан хийгдэнэ (жишээлбэл, ажилтан хувьцааг эзэмших эсвэл хувьцааны опционыг хэрэгжүүлэх боломжтой болох). Зохих бүртгэлийг хийхийн тулд СТОУС 2-д заасан шинжилгээг гүйцэтгэнэ.

б) Хэрэв төлбөрийг хувьцааны үнэнд суурилан тогтоосон боловч төлбөрийг эцэстээ мөнгөөр төлөх бол өр төлбөрт хүлээн зөвшөөрнө (мөнгөөр төлөгдөх хувьцаанд суурилсан төлбөр).

Дебит: Зардлын холбогдох данс эсвэл Хөрөнгийн холбогдох данс
Кредит: Бусад өр төлбөр - Мөнгөөр төлөгдөх хувьцааны опцион

Дээр дурдсанаар ажилтнуудтай холбоотой хувьцаанд суурилсан төлбөрийг ажилтнуудтай холбоотой зардалд бүртгэнэ. Гэхдээ гуравдагч этгээдийн хувьд хөрөнгө худалдан авахын тулд хувьцаа гаргасан бол хөрөнгийн дансанд (тухайлбал, бараа материал) бүртгэнэ. Гуравдагч этгээд үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд зардалд бүртгэнэ.

Хувьцаанд суурилсан төлбөртэй холбоотой өр төлбөрийг тайлагналын хугацаа бүрийн төгсгөлд бодит үнэ цэнээр дахин үнэлж, уг үнэлгээгээр үүссэн зөрүүг тухайн тайлант хугацааны орлого, зардалд хүлээн зөвшөөрнө. Дэлгэрэнгүй тайлбарыг “Бусад санхүүгийн ба санхүүгийн бус өр төлбөр” бүлгээс үзнэ үү.

Банк баталгаажих хугацааг анхаарч үзсэний үндсэн дээр үзүүлсэн үйлчилгээний зардал болон холбогдох өр төлбөрийг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Жишээлбэл, хувьцааны зарим эрхийг шууд зөвшөөрсөн байдаг ба энэ тохиолдолд ажилтнуудад мөнгө авах эрх үүсгэхийн тулд тодорхой хугацаанд ажиллах шаардлагагүй байдаг. Үгүйсгэх нотолгоо олдохгүй тохиолдолд хувьцааны эрх авах ажилтнууд зохих ёсоор ажиллаж, нөхцлийг хангасан гэж банк үзнэ. Иймээс банк ажилтнуудтай холбоотой зардлыг шууд бүртгэж, холбогдох өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Хэрэв ажилтнууд тодорхой хугацаанд (тухайлбал, 5 жил) ажиллах хүртэл хувьцааны эрхийг баталгаажуулахгүй тохиолдолд холбогдох зардал, өр төлбөрийг уг хугацаанд хуваарилж бүртгэнэ.

Төлбөрийг мөнгөөр төлж барагдуулсан бол

Дебит: Бусад өр төлбөр - Мөнгөөр төлөгдөх хувьцааны опцион
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс эсвэл Харилцагчийн холбогдох данс

Хэрэв төлбөрийг мөнгөөр барагдуулаагүй тохиолдолд банк тухайн нөхцөл байдалд үндэслэн бүртгэнэ.

в) Хэрэв хувьцаанд суурилан төлбөрийг мөнгөөр эсвэл өмчийн хэрэгслээр аль алинаар авч болох сонголттой нөхцөлд үүнийг мөнгөөр төлөгдөх хувьцаанд суурилсан төлбөрийн нэгэн адил бүртгэх ба өр төлбөр үүсгэнэ.

Хувьцаанд суурилсан төлбөрийн нөхцөл өөрчлөгдөхөд банк СТОУС 2-д заасан байдлаар дэлгэрэнгүй шинжилж, нөхцөл байдалд тохирох бүртгэлийг хөтөлнө.

3) Хувьцаа эзэмшигчдээс оруулсан бусад хөрөнгө

Гуравдагч талаас банкинд хандивласан хөрөнгийг тайлант хугацааны орлогод бүртгэх ба харин хувьцаа эзэмшигчдээс хандивласан хөрөнгөөр өөрийн хөрөнгөө нэмэгдүүлж бүртгэнэ (тухайн хувьцаа эзэмшигч

нь өмчлөгчийн байдлаар ажил гүйлгээнд оролцсон тохиолдолд). Нийтлэг гардаг нөхцөл байдлыг доор үзүүлэв.

Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгийг банк эргүүлэн өгөх үүрэг хүлээгээгүй бөгөөд үүний дүнгээр хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлээгүй тохиолдолд:

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Бусад өөрийн хөрөнгө – Бусад*

*Хэрэв оруулсан хөрөнгө нь мөнгөн хэлбэртэй хөрөнгө байсан бол банк үүнийг хувь нийлүүлсэн хөрөнгөнд оруулно.

Зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй зээлийг хувьцаа эзэмшигчдээс авсан тохиолдолд анх удаа хүлээн зөвшөөрөх үед үүсэх олзыг өөрийн хөрөнгөнд бүртгэнэ (энэ талаар "Бусад санхүүгийн ба санхүүгийн бус өр төлбөр" бүлэгт тайлбарласан):

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Бусад өөрийн хөрөнгө эсвэл Нэмж төлөгдсөн капитал
Кредит: Бусад эх үүсвэр (эсвэл өр төлбөрийн холбогдох данс)

Нэмэлт хүүгийн зардлыг (зах зээлийн хамгийн өндөр хүүгийн түвшинг ашиглан тооцсон) орлогын тайланд (өөрийн хөрөнгөнд бус) хүлээн зөвшөөрдөг тул анх удаад хүлээн зөвшөөрөх үед үүсэх олзыг хорогдуулан бүртгэхгүй.

4) Бусад өөрийн хөрөнгө

Банк ханшийн тэгшитгэл, үнэлгээний сан, хөрвөх ба бусад өр төлбөрийн өөрийн хөрөнгө болох хэсэг (өр төлбөрийн тодорхойлолтыг хангаж буй давуу эрхийн хувьцаа, баталгаа бүхий зээл гэх мэт), бусад санг бусад өөрийн хөрөнгөнд бүртгэнэ.

Ханшийн тэгшитгэл, үнэлгээний сан дансанд банкны бүртгэлийн валют нь банкны нэгдлийн бүртгэлийн валютаас зөрүүтэй үед санхүүгийн тайлангийн хөрвүүлэлтээс үүссэн ханшийн зөрүүг бүртгэнэ (тухайлбал, банкны охин компани нь гадаадын аж ахуйн нэгж бол). Энэ тохиолдолд гадаад дахь охин компанийн санхүүгийн тайланг төгрөгт хөрвүүлэх үед үүссэн зөрүүг тухайн тайланд жилд багтаан энэ дансанд бүртгэнэ.

Дээр дурдсан бусад зүйлсийг "Бусад санхүүгийн ба санхүүгийн бус өр төлбөр", "Өөрийн хөрөнгө" бүлгүүдэд оруулсан.

Ё. ТОДРУУЛГА

Банк өөрийн хөрөнгөтэй холбогдуулан дараах зүйлсийг санхүүгийн тайланд тодруулна

- Хувь нийлүүлсэн хөрөнгийг бүрдүүлж буй хувьцааны тоо ширхэг, нэрлэсэн үнэ, хувьцаанд хамааралтай эрх, давуу эрх, эрхийн хязгаарлалт болон тайлант хугацаанд нэмж гаргасан хувьцааны тоо, үүссэн нэмж төлөгдсөн капитал, хувь нийлүүлсэн хөрөнгөнд гарсан бусад өөрчлөлт, халаасны хувьцаанд гарсан өөрчлөлт, гаргасан хувьцааны опшин зэргийг тодруулна.
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулгын улмаас хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдэлд гарсан залруулгын дүнг тодруулж, дэлгэрэнгүй тайлбар хийнэ.
- Холбогдох стандартанд шаардсаны дагуу бусад дэлгэрэнгүй орлогыг тодруулна.
- Өөрийн хөрөнгөнд багтсан сангууд, тэдгээрийн зорилгыг тодруулна.
- Хувьцаа эзэмшигчидтэй хийсэн өмчийн ажил гүйлгээг тодруулна.
- Холбогдох бүх мэдээллийг Өмчийн өөрчлөлтийн тайланд толилуулна.
- Өөрийн хөрөнгийн удирдлагын тодруулгууд (Санхүүгийн эрсдэл болон өөрийн хөрөнгийн удирдлага, бусад тодруулга бүлэгт оруулсан).

Түүнчлэн санхүүгийн тайлангийн тодруулгад багтах бусад тодруулгыг санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх аргачлал (Хавсралт 4)-д заасан.

Ж. ХЯНАЛТ

- Ажилтнуудын ажил үүргийг зааглан тусгаарлана.
- Хувьцаа эзэмшигч бүрээр дэлгэрэнгүй бүртгэл хөтөлнө.
- Дэлгэрэнгүй бүртгэлийг хяналтын дансны гүйлгээ, үлдэгдэлтэй тохируулна.
- Өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангана.

- Тусгай зориулалтын сангуудын зарцуулалтыг банкны эрх бүхий удирдлагаас баталж, хяналт тавина.

7.1. ОРЛОГО

А. ШУУД ХОЛБОГДОХ СТАНДАРТУУД

- НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- НББОУС 18 Орлого
- НББОУС 21 Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө

Б. ТОДОРХОЙЛОЛТ

Орлого нь тайлант хугацаанд хөрөнгийн дотогшлох урсгал болон хөрөнгийн сайжруулалт, эсвэл хувь нийлүүлэгчдээс оруулсан хөрөнгөтэй холбоогүйгээр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, өр төлбөрийг бууруулах хэлбэрээр гарах эдийн засгийн үр өгөөжийн өсөлт юм.

Орлогод орлого болон олз багтана. Орлого нь банкны үйл ажиллагааны явцад үүсдэг бөгөөд төлбөр, хураамж, хүү болон ногдол ашиг зэргийг хамруулна. Банкны үндсэн орлого нь хүүгийн орлого ба хураамж, шимтгэлийн орлого юм.

Олз гэж банкны үйл ажиллагааны явцад үүсч болох, орлогын тодорхойлолтонд нийцэх бусад зүйлсийг ойлгоно. Тухайлбал, олзонд эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах үеийн олз, хэрэгжсэн ба хэрэгжээгүй олз (тухайлбал, гадаад валютын, үнэт цаасны үнэлгээний ба арилжааны гэх мэт) багтана. Олзыг тайлант хугацааны орлогод бүртгэсэн тохиолдолд эдийн засгийн шийдвэр гаргагчдад чухал мэдээлэл өгнө гэж үзэж байгаа бол ихэнхдээ дангаар нь тайлагнана. Олзыг ихэнхдээ холбогдох зардлыг хассан цэвэр дүнгээр тайлагнана.

Хүүгийн орлого нь тодорхой гэрээний үндсэн дээр зээлдэгчдэд олгосон зээл, бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгийг ашиглуулсны төлөө авч буй төлбөр юм.

В. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

Орлогыг дараах нөхцөлд хүлээн зөвшөөрнө:

- Орлогын дүнг бодитой тооцон гаргах боломжтой;
- Ажил гүйлгээний эцсийн өгөөжийг банк хүртэх магадлалтай байх

Орлого, олзыг дараах байдлаар ангилна:

1. Хүүгийн орлого
2. Бусад орлого
    - i. Хүүгийн бус орлого
        - а) Арилжааны орлого
        - б) Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого
        - в) Хураамж, шимтгэлийн орлого
        - г) Бусад хүүгийн бус орлого
    - ii. Бусад орлого, олз

Бусад орлогод банкны үндсэн үйл ажиллагаа (өөрөөр хэлбэл лиценз бүхий үйл ажиллагаа) -нд хамаарахгүй ажил гүйлгээнээс үүссэн орлого болон олз багтана.

Г. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

Орлогыг хүлээн авсан мөнгө эсвэл үүссэн авлагын бодит үнэ цэнээр үнэлнэ.

Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн түвшингээр тооцож, үнэлнэ. Гэрээний дагуу нэмэлт төлбөр, хойшлогдсон орлого, зардал гараагүй нөхцөлд хүүгийн орлогыг гэрээнд заасан нэрлэсэн хүүгийн хувь хэмжээгээр тооцож, үнэлнэ. Хямдруулалт, урамшуулал, хойшлуулсан орлого, зардлыг холбогдох санхүүгийн хэрэгслийн хугацаанд үр ашигт хүүгийн аргаар хуваарилж, бүртгэнэ.

Үйл ажиллагааны түрээсийн хувьд түрээсийн төлбөрийг түрээсийн хугацаанд үйл ажиллагааны түрээсийн орлогод хүлээн зөвшөөрнө.

Д. БҮРТГЭЛ

1) Хүүгийн орлого

Хүүг хуримтлуулан тооцох үед хүүгийн орлогод бүртгэнэ.

Дебит: Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага
Кредит: Хүүгийн орлого

Хүүгийн орлогыг өдөр бүр тооцоолж, хуримтлуулна.

Хүүгийн орлогын бүртгэлийг харгалзах бүтээгдэхүүн, үйлчилгээний бүлэг тус бүрт тусгасан болно. Тухайлбал, зээлийн хүүгийн орлогын бүртгэлийг зээлийн бүлгээс, үнэт цаасны хүүгийн орлогын зааврыг хөрөнгө оруулалтын бүлгээс тус тус үзнэ үү.

2) Арилжааны орлого

Гадаад валют, үнэт металл, үнэт цаас гэх мэт санхүүгийн хэрэгслийг худалдан борлуулахад худалдсан өдрийн дансны үлдэгдэл ба борлуулсан үнийн зөрүүг арилжааны орлого, зардалд бүртгэнэ.

Арилжааны орлого, зардлын бүртгэлийн зааврыг харгалзах санхүүгийн хэрэгслийн бүлэгт тусгасан. Тухайлбал, үнэт цаасны арилжааны орлогын бүртгэлийг хөрөнгө оруулалтын бүлгээс үзнэ үү.

3) Ханшийн тэгшитгэлийн орлого

Гадаад валютын ханш өөрчлөгдөх тухай бүрт гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ ба дахин үнэлсэн дүнгийн зөрүүг ханшийн тэгшитгэлийн орлого, зардалд бүртгэнэ. Гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгийг худалдаж, өр төлбөрийг барагдуулах үед ханшийн зөрүүний хэрэгжээгүй орлого, зардлыг хэрэгжсэн орлого, зардалд шилжүүлэн бүртгэнэ.

Санхүүгийн тайланд ханшийн тэгшитгэлийн орлого, зардлыг хооронд нь хааж, цэвэршүүлэн, орлого эсвэл зардлаар толилуулна.

Хөрөнгийн хувьд гадаад валютын ханш өссөн үед

Дебит: Гадаад валютаар илэрхийлэгдэх хөрөнгө
Кредит: Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого

Өр төлбөрийн хувьд гадаад валютын ханш буурсан үед

Дебит: Гадаад валютаар илэрхийлэгдэх өр төлбөр
Кредит: Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого

4) Үнэлгээний тэгшитгэлийн орлого

Бодит үнэ цэнээр үнэлж, толилуулах хөрөнгө, өр төлбөрийн дансдын хуучин, шинэ үнэлгээний зөрүүг үнэлгээний тэгшитгэлийн орлого, зардалд бүртгэнэ.

Санхүүгийн тайланд үнэлгээний тэгшитгэлийн орлого, зардлыг хооронд нь хааж, цэвэршүүлэн, орлого эсвэл зардлаар толилуулна.

Хөрөнгийн хувьд бодит үнэ цэн өссөн үед

Дебит: Холбогдох хөрөнгийн данс
Кредит: Үнэлгээний тэгшитгэлийн орлого

Өр төлбөрийн хувьд бодит үнэ цэн буурсан үед

Дебит: Холбогдох өр төлбөрийн данс
Кредит: Үнэлгээний тэгшитгэлийн орлого

Бодит үнэ цэнээр үнэлж, бүртгэсэн санхүүгийн хэрэгслийн (тухайлбал, арилжааны үнэт цаас, дериватив, борлуулахад бэлэн үнэт цаас) дахин үнэлгээний бүртгэлийг “Хөрөнгө оруулалт”-ын бүлэгт дэлгэрэнгүй харуулсан.

“Бусад санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгө”-ийн бүлэгт заасны дагуу үнэт металлыг худалдан борлуулах хүртэл дахин үнэлгээ хийхгүй бөгөөд ямар нэгэн үнэлгээний хэрэгжээгүй орлого, зардал бүртгэхгүй. Гэхдээ үнэт металлын үнэ цэн буурсан тохиолдолд дансны үнийг нь цэвэр боломжит үнэ цэн хүртэл нь бууруулна. Энэ зорилгоор бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал дансыг ашиглана. Үнэт металлын арилжааны хэрэгжээгүй орлого, зардлын дансыг “Санхүүгийн дериватив хөрөнгө”-ийн бүлгээс үзнэ үү.

5) Хураамж, шимтгэлийн орлого

Бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлснээр хураамж, шимтгэлийн орлогыг бүртгэнэ.

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс эсвэл харилцагчийн харилцах, хадгаламжийн данс
Кредит: Холбогдох хураамж, шимтгэлийн орлого

Банк хураамж, шимтгэлийг холбогдох санхүүгийн үйлчилгээг үзүүлж дуусмагц, СТОУС-д нийцүүлэн, харгалзах тайлант хугацаанд нь үнэн зөв бүртгэсэн эсэхийг нягтална. НББОУС 18-ын удирдамжинд багтсан шаардлага, холбогдох жишээг "Зээл" бүлэгт оруулсан. Үр ашигт хүүгийн шимтгэлийг төлөгдсөн үед нь бус харин холбогдох санхүүгийн хэрэгслийн эзэмших хугацаанд хойшлуулан, хүүгийн орлогоор ангилан бүртгэнэ.

6) Бусад орлого

Хангамжийн зориулалттай нэгжүүдээс орох орлого, үндсэн хөрөнгө борлуулсны олз, үйл ажиллагааны түрээс зэрэг үндсэн бус үйл ажиллагаанаас олох орлого, олзыг үүнд хамруулна (өөрөөр хэлбэл лиценз авалгүйгээр явуулж буй үйл ажиллаганы орлого).

Банк хөрөнгөө үйл ажиллагааны түрээсээр түрээслүүлсэн тохиолдолд түрээсийн гэрээний дагуу түрээсийн төлбөрийг хуримтлуулан тооцоолж, орлогоор бүртгэнэ

Дебит: Үйл ажиллагааны түрээсийн авлага
Кредит: Хөрөнгийн түрээсийн орлого

Үндсэн хөрөнгө борлуулсны олзыг бүртгэхэд

Дебит: Мөнгөн хөрөнгийн дансн эсвэл бусад харилцагчийн харилцах данс буюу бусад тооцооны данс
Кредит: Үндсэн хөрөнгө борлуулсны олз

Бусад орлогыг бүртгэхэд

Дебит: Мөнгөн хөрөнгийн данс эсвэл бусад тооцооны данс
Кредит: Бусад орлого

Бусад төрлийн орлогын бүртгэлийг санхүүгийн тайлангийн холбогдох бүлэгт дэлгэрэнгүй оруулсан Тухайлбал, буцалтгүй тусламжийн бүртгэлийг "Бусад санхүүгийн ба санхүүгийн бус өр төлбөр" бүлэгт оруулсан.

Е. ТОДРУУЛГА

Орлого хүлээн зөвшөөрөхөд баримталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тодруулна.

Орлогын нэр төрөл бүрээр хүлээн зөвшөөрсөн дүнг тодруулна. Мөн банк орлогын гол нэр төрлийн талаар тодруулна.

Түүнчлэн санхүүгийн тайлангийн тодруулгад багтах бусад тодруулгыг санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх аргачлал (Хавсралт 4)-д заасан.

7.2. ЗАРДАЛ

А. ШУУД ХОЛБОГДОХ СТАНДАРТУУД

- НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- НББОУС 18 Орлого
- НББОУС 21 Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө

Б. ТОДОРХОЙЛОЛТ

Зардал нь хувьцаа эзэмшигчдэд олгосон хуваарилалттай холбоогүй, өөрийн хөрөнгийг бууруулж буй хөрөнгийн хорогдол буюу гадагшлах урсгал эсвэл өр төлбөр үүсэх зэрэг хэлбэрээр тайлант хугацаанд бий болсон эдийн засгийн өгөөжийн бууралт юм.

Гарз гэж банкны үйл ажиллагааны явцад үүсч болох, зардлын тодорхойлолтонд нийцэх бусад зүйлсийг ойлгоно.

Хүүгийн зардал нь банкны үйл ажиллагааны эх үүсвэрт ашиглах зорилгоор бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн төлбөр буюу өртөг юм.

В. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

Зардлыг дараах нөхцөлд хүлээн зөвшөөрнө:

- Зардлын дүнг бодитой тооцох боломжтой;
- Ажил гүйлгээний үр дүнд эдийн засгийн өгөөж буурсан

Зарим зардал болон олсон орлогын хоорондох шууд хамаарлыг үндэслэн орлогын тайланд зарим зардлыг хүлээн зөвшөөрнө. Үүнийг орлого, зардал тохируулах гэх ба ижил төстэй ажил гүйлгээ эсвэл бусад үйл явдлын шууд ба хамтарсан үр дүнд орлого ба зардлыг нэгэн зэрэг буюу нэгтгэн хүлээн зөвшөөрөхийг хэлнэ. Гэхдээ хөрөнгө буюу өр төлбөрийн тодорхойлолтонд нийцээгүй зүйлсийг балансанд хүлээн зөвшөөрөх нь орлого, зарлагыг тохируулах зарчимтай нийцэхгүй.

Зардлыг дараах байдлаар ангилна:

1. Хүүгийн зардал
2. Эрсдэлийн сангийн зардал
3. Бусад зардал
    i. Хүүгийн бус зардал
        а) Бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал
        б) Арилжааны зардал
        в) Ханш, үнэлгээний тэгшилгэлийн зардал
        г) Хураамж, шимтгэлийн зардал
        д) Үйл ажиллагааны бусад зардал
    ii. Бусад зардал, гарз
4. Орлогын татварын зардал
5. Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал

Бусад зардалд банкны үндсэн үйл ажиллагаа (өөрөөр хэлбэл лиценз бүхий үйл ажиллагаа) -нд хамаарахгүй ажил гүйлгээнээс үүссэн зардал болон гарз багтана.

Г. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

Зардлыг төлсөн мөнгө эсвэл үүссэн өглөгийн бодит үнэ цэнээр үнэлнэ.

Хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн түвшингээр тооцож үнэлнэ. Татан төвлөрүүлсэн эх үүсвэртэй холбоотой нэмэлт урамшуулал, хямдруулалт, хойшлогдсон орлого болон зардал гараагүй нөхцөлд хүүгийн зардлыг гэрээнд заасан нэрлэсэн хүүгийн хувь хэмжээгээр тооцож, үнэлнэ.

Д. БҮРТГЭЛ

<u>1) Хүүгийн зардал</u>

Хүүгийн зардлыг татан төвлөрүүлсэн хөрөнгийн төрлөөр ангилж бүртгэнэ.

Хүүг хуримтлуулан тооцоход

Дебит: Хүүгийн зардал
Кредит: Хуримтлуулж тооцсон хүүгийн холбогдох өглөг

Хүүг хуримтлуулалгүй, шууд төлсөн бол

Дебит: Хүүгийн холбогдох зардал
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Хүүгийн зардлын бүртгэлийг харгалзах бүтээгдэхүүн, үйлчилгээний бүлэгт тусгасан болно. Тухайлбал, хадгаламж болон бусад банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрт төлсөн хүүгийн зардлын бүртгэлийг тухайн эх үүсвэр тус бүрийн бүлгээс үзнэ үү.

Банк хураамж, шимтгэл бүхий санхүүгийн өр төлбөрийн хувьд уг хураамж, шимтгэлийг хойшлуулан бүртгэж, үр ашигт хүүг тодорхойлон бүртгэх эсэхийг тогтооно. Хэрэв хураамж, шимтгэлийг үр ашигт хүүнд оруулан тооцсон бол үүнийг хүүгийн зардалд бүртгэнэ. Үүнээс бусад хураамж, шимтгэлийг хүүгийн бус зардлаар ангилж, “Үйлчилгээний шимтгэл, хураамжийн зардал”-аар тайлагнана. Санхүүгийн үйлчилгээг үзүүлсэн үед холбогдох зардлыг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

<u>2) Эрсдэлийн сангийн зардал</u>

Хөрөнгийн үнэ цэн буурч, эрсдэлийн сан байгуулахад холбогдох эрсдэлийн зардлыг хүлээн зөвшөөрнө.

Эрсдэлийн сангийн зардлын бүртгэлийг харгалзах хөрөнгийн бүлэгт тусгасан. Тухайлбал, зээлийн эрсдэлийн сангийн бүртгэлийг зээлийн бүлгээс, үнэт цаасны эрсдэлийн сангийн бүртгэлийг хөрөнгө оруулалтын бүлгээс тус тус үзнэ үү.

<u>3) Арилжааны зардал</u>

Гадаад валют, үнэт металл, үнэт цаас гэх мэт санхүүгийн хэрэгслийг худалдан борлуулахад худалдсан өдрийн дансны үлдэгдэл ба борлуулсан үнийн зөрүүг арилжааны орлого, зардалд бүртгэнэ.

Арилжааны орлого, зардлын бүртгэлийг харгалзах санхүүгийн хэрэгслийн бүлэгт тусгасан болно. Тухайлбал, үнэт цаасны арилжааны орлогын бүртгэлийг хөрөнгө оруулалтын бүлгээс үзнэ үү.

4) Ханшийн тэгшитгэлийн зардал

Гадаад валютын ханш өөрчлөгдөх тухай бүрд гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөрийн дансдын хуучин шинэ үнэлгээний зөрүүг ханшийн тэгшитгэлийн орлого, зардалд бүртгэнэ. Хөрөнгийг худалдах болон өр төлбөрийг барагдуулахад ханшийн тэгшитгэлийн хэрэгжээгүй ашиг, алдагдлыг хэрэгжсэн ашиг алдагдалд шилжүүлэн ангилна.

Санхүүгийн тайланд ханшийн тэгшитгэлийн орлого, зардлыг хооронд нь хааж, цэвэршүүлэн, орлого эсвэл зардлаар толилуулна.

Хөрөнгийн хувьд гадаад валютын ханш буурсан үед

Дебит: Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал
Кредит: Гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө

Өр төлбөр, өөрийн хөрөнгийн хувьд гадаад валютын ханш өссөн үед

Дебит: Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал
Кредит: Гадаад валютаар илэрхийлэгдсэн өр төлбөр

5) Үнэлгээний тэгшитгэлийн зардал

Бодит үнэ цэнээр үнэлж, толилуулах хөрөнгө, өр төлбөрийн дансдын хуучин шинэ үнэлгээний зөрүүг үнэлгээний тэгшитгэлийн орлого, зардалд бүртгэнэ.

Санхүүгийн тайланд үнэлгээний тэгшитгэлийн орлого, зардлыг хооронд нь хааж, цэвэршүүлэн, орлого эсвэл зардлаар толилуулна.

Хөрөнгийн хувьд бодит үнэ цэн буурсан үед

Дебит: Үнэлгээний тэгшитгэлийн зардал
Кредит: Холбогдох хөрөнгийн данс

Өр төлбөрийн хувьд бодит үнэ цэн өссөн үед

Дебит: Үнэлгээний тэгшитгэлийн зардал
Кредит: Холбогдох өр төлбөрийн данс

Бодит үнэ цэнээр үнэлж, бүртгэсэн санхүүгийн хэрэгслийн (тухайлбал, арилжааны үнэт цаас, дериватив, борлуулахад бэлэн үнэт цаас) дахин үнэлгээний бүртгэлийг “Хөрөнгө оруулалт”-ын бүлэгт дэлгэрэнгүй харуулсан.

“Бусад санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгө”, “Орлого”-ын бүлэгт заасны дагуу үнэт металлыг худалдан борлуулах хүртэл дахин үнэлгээ хийхгүй бөгөөд ямар нэгэн үнэлгээний хэрэгжээгүй орлого, зардал бүртгэхгүй. Гэхдээ үнэт металлын үнэ цэн буурсан тохиолдолд дансны үнийг нь цэвэр боломжит үнэ цэн болтол бууруулна. Энэ зорилгоор бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал дансыг ашиглана. Үнэт металлын арилжааны хэрэгжээгүй орлого, зардлын дансыг “Санхүүгийн дериватив хөрөнгө”-ийн бүлэгт тайлбарласан санхүүгийн дериватив бүртгэлд ашиглана.

6) Үйл ажиллагааны бусад зардал

Үйл ажиллагааны бусад зардалд банкны үндсэн үйл ажиллагаатай холбогдон гарч байгаа цалин хөлс, татвар, шимтгэл гэх мэт удирдлага, борлуулалтын зардал багтана.

Үйл ажиллагааны бусад зардлыг төрөл тус бүрээр ангилж, бүртгэнэ.

Гарсан зардлыг шууд мөнгөөр төлөхөд

Дебит: Холбогдох зардлын данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс эсвэл Харилцагчийн харилцах, хадгаламжийн данс

Зээлээр ажил үйлчилгээ гүйцэтгүүлэх үед мөнгөөр төлөгдөөгүй боловч нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьяр тайлант хугацаанд ногдох зардлыг хуримтлуулж бүртгэхэд

Дебит: Холбогдох зардлын данс
Кредит: Холбогдох өглөгийн данс

Зээлээр гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний үнэ буюу хуримтлуулж бүртгэсэн зардлыг мөнгөөр төлөх үед

Дебит: Холбогдох өглөгийн данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс эсвэл Харилцагчийн харилцах, хадгаламжийн данс

Банкны үйл ажиллагаанд хэрэглэгдэх хангамжийн зүйлс, маягтыг худалдан авч, ашиглалтанд шууд тавьж олгоход

Дебет: Материал хангамжийн зардал
Кредит: Мөнгөн хөрөнгө болон тооцооны холбогдох данс

Банк үйл ажиллагааны түрээсийн гэрээний дагуу түрээсийн төлбөр төлөхөд

Дебит: Түрээсийн зардал
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Хэрэв түрээсийн төлбөрийг урьдчилан төлсөн бол

Дебит: Урьдчилж төлсөн түрээсийн зардал
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Урьдчилж төлсөн түрээсийн зардлыг жинхэнэ хэрэгжилтийн сууриар зардалд хуваарилахад

Дебит: Түрээсийн зардал
Кредит: Урьдчилж төлсөн түрээсийн зардал

Цалин хөлс, нэмэгдэл

Банк Монгол улсын Иргэний хууль, бусад холбогдох хууль, тогтоомжийн дагуу үндсэн болон түр ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, түүнд тодорхойлсон цалинг тухай бүр тооцож олгох ба ингэхдээ татвар, шимтгэлийн тооцоог хийж холбогдох татвар, санхүүгийн байгууллагад төлж, тайлагнана.

Цалин олговрыг тооцооны хүснэгт, бусад баримтыг үндэслэн олгохоор тооцсон дүнгээр

Дебит: Цалингийн зардал
Кредит: Цалингийн өглөг

Даатгуулагчаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн дүнгээр

Дебит: Цалингийн өглөг
Кредит: НДШ-ийн өглөг

Цалингаас суутгах ХХОАТ-ын дүнгээр

Дебит: Цалингийн өглөг
Кредит: Суутган тооцсон татварын өглөг (ХХОАТ-ын өглөг)

Эдгээр болон бусад суутгалуудыг хассаны дараа гарт олгох дүнгээр

Дебит: Цалингийн өглөг
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс эсвэл Ажилтнуудын цалингийн данс

Хувь хүний орлогын татварыг харьяа татварын байгууллагад шилжүүлсэн бол

Дебит: Суутган тооцсон татварын өглөг
Кредит: Татварын байгууллагын харилцах эсвэл Холбогдох харилцах данс

Цалин хөлс, нэмэгдэл, хөнгөлөлтөөс тооцсон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг бүртгэхэд

Дебит: НД ба ЭМДШ-ийн зардал
Кредит: ЭМНД ба ЭМДШ-ийн өглөг

Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг харьяа нийгмийн даатгалын байгууллагад төлөхөд

Дебит: НД ба ЭМДШ-ийн өглөг
Кредит: ЭМХолбогдох харилцах данс

Банк нь дотоод журам, эрх бүхий удирдлагын шийдвэрээр ажилчдад тогтмол болон цаг үеийн хөнгөлөлт үзүүлж болно. Хөнгөлөлт олгох үед олгохоор тооцсон дүнгээр

Дебит: Хөнгөлөлтийн зардал
Кредит: Цалингийн өглөг

Тэтгэврийн сангийн бүртгэлийг "Бусад санхүүгийн ба санхүүгийн бус өр төлбөр" бүлэгт оруулсан. Ажилтнуудад олгосон зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй зээлд хамаарах тэтгэмжийн бүртгэлийг "Зээл" бүлэгт харуулсан.

Банк ажилтнууддаа бусад төрлийн тэтгэмж олгох үед нийгмийн хөгжлийн сан байгуулж, ашиглаж болно. Энэхүү тэтгэмжтэй холбоотой бүртгэлийг "Бусад санхүүгийн ба санхүүгийн бус өр төлбөр" ба "Өөрийн хөрөнгө" зэрэг бүлэгт оруулсан.

7) Бусад зардал

Үүнд банкны лиценз бүхий үйл ажиллагаанд хамаарахгүй буюу үндсэн үйл ажиллагаатай холбогдолгүй зардлуудыг хамруулна. Мөн үүнд бизнесийн бус ажил гүйлгээний зардал буюу гарз багтаж болно.

Хууль тогтоомж зөрчсний улмаас торгууль төлбөл

Дебит: Торгуулийн зардал
Кредит: Холбогдох харилцах данс

Үндсэн хөрөнгийг данснаас хасахад

Дебит: Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө данснаас хассаны гарз
Кредит: Үндсэн хөрөнгө

Зардлын төрөл бүрээр хийх бүртгэлийн удирдамжийг санхүүгийн байдлын тайлангийн зүйлийн холбогдох бүлэгт дэлгэрэнгүй оруулсан (тухайлбал, зээлд хамаарах үүрэг янз бүрийн зарга маргаанд байгуулсан нөөцийн бүртгэлийг "Бусад санхүүгийн ба санхүүгийн бус өр төлбөр" бүлэгт оруулсан).

Е. ТОДРУУЛГА

Зардал хүлээн зөвшөөрөхөд баримталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тодруулна. Зардлын нэр төрөл бүрээр хүлээн зөвшөөрсөн дүнг тодруулна.

Түүнчлэн санхүүгийн тайлангийн тодруулгад багтах бусад тодруулгыг санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх аргачлал (Хавсралт 4)-д заасан.

7.3. АШИГ, АЛДАГДАЛ

Тайлант жилийн эцэст орлого, зардлын дансдыг тайлант үеийн ашиг алдагдлын дансанд хааж, тайлант жилийн цэвэр ашиг, алдагдлыг тодорхойлно.

Орлогын дансдыг хаахад

Дебит: Орлогын дансууд
Кредит: Тайлант үеийн ашиг/алдагдал

Зардлын дансдыг хаахад

Дебит: Тайлант үеийн ашиг/алдагдал
Кредит: Зардлын дансууд

Ашиг, алдагдлын дансны хаалтын бичилтийг санхүүгийн тайланд өөрийн хөрөнгө, түүний тохируулгыг хийхэд ашиглана.

Тайлант үеийн ашиг, алдагдлын дансны цэвэр үлдэгдлээр тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал тодорхойлогдох ба уг дансны үлдэгдлийг хуримтлагдсан ашиг дансанд хаана.

Тайлант хугацаанд банк ашигтай ажилласан бол цэвэр ашгийн дүнгээр

Дебит: Тайлант үеийн ашиг
Кредит: Хуримтлагдсан ашиг

Банк алдагдалтай ажилласан бол цэвэр алдагдлын дүнгээр

Дебит: Хуримтлагдсан ашиг
Кредит: Тайлант үеийн алдагдал

7.4. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР

А. ШУУД ХОЛБОГДОХ СТАНДАРТУУД

- НББОУС 12 Орлогын албан татвар
- БТХ-21 Орлогын албан татвар - Дахин үнэлсэн элэгдэл тооцдоггүй хөрөнгийн нөхөлт
- БТХ-25 Орлогын албан татвар - Аж ахуйн нэгжийн татварын статус эсвэл түүний хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд гарсан өөрчлөлт

Б. ТОДОРХОЙЛОЛТ

Нягтлан бодох бүртгэлийн ашиг, алдагдал (Татварын өмнөх ашиг, алдагдал) гэж СТОУС-ын дагуу тооцоолж гаргасан, тайлант үеийн татварын зардлыг хасахын өмнөх ашиг, алдагдлыг хэлнэ.

Татвар ногдуулах орлого (татварын алдагдал) гэж Монгол улсын татварын хуулийн дагуу тооцож, тухайн дүнгээс тайлант үед төлөх орлогын албан татварыг тооцох орлогыг хэлнэ.

Тайлант хугацааны татвар гэдэг нь тайлант хугацааны татвар ногдуулах орлогоос тооцоолж гаргасан, төлөх ёстой орлогын албан татварын өглөгийн дүн юм.

Хойшлогдсон татварын өглөг гэдэг нь татвар ногдох түр зөрүүгээс шалтгаалан ирээдүйн тайлант хугацаанд төлөх орлогын албан татварын өглөгийн дүн юм.

Хойшлогдсон татварын хөрөнгө гэдэг нь хасагдах түр зөрүү, татварын алдагдлыг дараагийн тайлант үеүү шилжүүлэх, ашиглагдаагүй татварын хөнгөлөлтийг дараагийн үеүү шилжүүлэхтэй тус тус холбоотойгоор ирээдүйн тайлант үед нөхөгдөх орлогын татварын дүнг хэлнэ.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өглөг нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварын төлөгдөөгүй өглөг ба урьдчилж төлсөн дүнгээс ялгаатай ойлголт юм.

Татварын авлага гэж урьдчилж төлсөн татвар буюу тайлант хугацааны татварыг давуулан төлсөн буюу илүү төлсөн татварыг хэлнэ.

Татварын өглөг гэж тайлант хугацааны эсвэл өмнөх хугацааны төлөгдөөгүй татварыг ойлгоно.

Татварын түр зөрүү гэдэг нь татварын хөрөнгө, өр төлбөрийн дансны үлдэгдэл ба татварын суурийн хоорондох зөрүүг хэлнэ. Түр зөрүүний нөлөөг хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн дансанд бүртгэнэ. Түр зөрүү нь татвар ногдох түр зөрүү ба хасагдах зөрүү гэсэн хоёр хэлбэртэй.

Татвар ногдох түр зөрүү гэдэг нь хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийг нөхөх эсвэл барагдуулах үед ирээдүйн тайлант үеийн татвар ногдуулах ашиг (татварын алдагдал)-ийг тодорхойлоход татвар ногдох орлогод үүсэх түр зөрүү юм.

Хасагдах түр зөрүү гэдэг нь хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийг нөхөх эсвэл барагдуулах үед ирээдүйн тайлант үеийн татвар ногдуулах ашиг (татварын алдагдал)-ийг тодорхойлоход татвар ногдох орлогоос хасагдах дүнгээс үүсэх түр зөрүү юм.

Хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь гэдэг нь татварын зорилгоор тухайн хөрөнгө, өр төлбөрийг үнэлсэн дүн юм.

Татварын зардал (Орлогын албан татварын орлого) гэж тайлант хугацааны татварын зардал (тайлант хугацааны татварын орлого) ба хойшлогдон татварын зардлын (хойшлогдсон татварын орлого) нийлбэрийг хэлнэ.

В. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

Банк хөрөнгө, өр төлбөрийн татварын суурийг дансны үлдэгдэлтэй нь харьцуулна. Гадаад валютын ханшийн тэгшитгэлийг оруулсан бүх төрлийн дахин үнэлгээг хэрэгжсэн болон хэрэгжээгүй үед нь татвар ногдох эсэхийг татварын хуультай харьцуулж үзнэ.

Хэрэв аливаа орлого буюу олзод татвар ногдуулдаг (одоо болон ирээдүйд) эсвэл аливаа зардал буюу гарзыг татвараас хасдаг (одоо болон ирээдүйд) тохиолдолд банк тайлант үеийн татварыг хуримтлуулах буюу татварын хууль, тогтоомжийн дагуу уг ажил гүйлгээтэй холбоотойгоор хойшлогдсон татварыг бүртгэнэ. Банк татвар ногдуулахгүй орлого болон татвараас хасагдахгүй зардлын хувьд (татварын байнгын зөрүү үүссэн үед) эдгээр нь татварын тооцоонд огт хамаарахгүй тул тайлант үеийн татварыг хуримтлуулах буюу хойшлогдсон татварыг бүртгэхгүй. Иймд банк тайлант хугацаанд татвар ногдуулах

болон татвараас хасагдах орлого, зардал (энэ нь тайлант хугацааны татварын тооцоонд орсон байдаг), тайлант хугацаанд татвар ногдуулахгүй буюу татвараас хасахгүй боловч ирээдүйд татвар ногдуулах буюу татвараас хасагдах орлого, зардал (энэ нь тайлант хугацааны хойшлогдсон татварын тооцоонд орсон байдаг), хэзээ ч татвар ногдуулахгүй буюу татвараас хасагдахгүй орлого, зардал (тайлант үеийн болон хойшлогдсон татварын тооцоонд аль алинд нь багтаагүй) зэргийг ялгаатай авч үзнэ.

Татварын тооцоололд ашиглагдах татварын хувь хэмжээг банкны төлөхөөр хүлээгдэж буй хувь хэмжээгээр авна.

Хойшлогдсон татварыг үүсч буй нөхцөл байдлаас шалтгаалан хөрөнгө эвсэл өр төлбөрийн аль тохирохоор хүлээн зөвшөөрнө. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын зардал нь үйл ажиллагааны зардал болно.

Тайлант хугацааны ба өмнөх хугацааны төлөгдөөгүй татварыг тухайн тайлант хугацаанд өр төлбөрөөр хүлээн зөвшөөрч, “Татварын өглөг” дансанд бүртгэнэ. Татварт төлсөн дүн нь төлөх татвараас давсан буюу өөрөөр хэлбэл татварыг урьдчилж төлсөн бол илүү төлсөн дүнг хөрөнгөөр хүлээн зөвшөөрч, “Татварын авлага” дансанд бүртгэнэ.

Татварын алдагдлыг дараагийн жилд шилжүүлэх эсвэл ашиглагдаагүй татварын хөнгөлөлтийг дараагийн жилд шилжүүлэхтэй холбоотойгоор хүртэх боломжтой өгөөжийг хойшлогдсон татварын хөрөнгөнд бүртгэнэ.

Татвар ногдох түр зөрүүг анх хүлээн зөвшөөрөхдөө хойшлогдсон татварын өглөгт бүртгэх ба хойшлогдсон татварын өглөг нь ирээдүйн тайлант үед хасагдах түр зөрүүгээр буурна.

Хасагдах түр зөрүүг анхлан хойшлогдсон татварын хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх ба энэ нь ирээдүйн тайлант үед үүсэх татвар ногдох түр зөрүүгээр буурна.

Түр зөрүүг бүртгэхэд үүссэн хойшлогдсон татварын өглөг, хойшлогдсон татварын хөрөнгө данс нь тодорхой хугацааны дараа нөхөгдөж, үлдэгдэлгүй болно.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг тэдгээр нь ирээдүйд бий болох буюу хэрэгжих магадлалтай тохиолдолд л зөвхөн хүлээн зөвшөөрнө. Өөрөөр хэлбэл тухайн банк үр ашгийг хэрэгжүүлэх буюу өр төлбөрийг хаахын тулд ирээдүйд хангалттай татвар ногдох орлогыг олно гэж үзсэн үедээ татварын алдагдал болон хөнгөлөлттэй холбоотой хойшлогдсон татварын хөрөнгө, өглөгийг хүлээн зөвшөөрч бүртгэн, санхүүгийн тайландаа толилуулна.

Татварын алдагдлыг дараагийн жилд шилжүүлэх эсвэл ашиглагдаагүй татварын хөнгөлөлтийг дараагийн жилд шилжүүлэхтэй тус тус холбоотойгоор үүссэн хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрөх шалгуур нь хасагдах түр зөрүүг бүртгэх үед үүссэн хойшлогдсон татварын хөрөнгийг бүртгэхтэй ижилхэн. Гэхдээ ашиглаагүй татварын алдагдал байгаа нь ирээдүйд татвар ногдох орлого олохгүй байх баттай нотолгоо болох талтай. Иймээс банк алдагдалтай ажилласан бол татварын түр зөрүүг хаахад хүрэлцэх хэмжээгээр эсвэл татварын алдагдлыг дараагийн жилд эсвэл ашиглагдаагүй татварын хөнгөлөлтийг дараагийн жилд шилжүүлэн ашиглахад хүрэлцэх татвар ногдуулах ашиг бий болно гэсэн нотолгоо байгаа үед татварын алдагдлыг дараагийн жилрүү шилжүүлэх эсвэл ашиглагдаагүй татварын хөнгөлөлтийг дараагийн жилрүү шилжүүлэхтэй тус тус холбоотойгоор үүсэх хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Банк хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрч, бүртгэхээс өмнө татварын алдагдлыг эсвэл ашиглагдаагүй татварын хөнгөлөлтийг дараагийн жилрүү шилжүүлэн ашиглахад хүрэлцэх татвар ногдуулах ашиг бий болгох ашигт ажиллагааг үнэлэх шалгуурыг анхааралдаа авна.

Г. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

Тайлант хугацаанд зардал болон орлогыг уялдуулах зарчим татварын бүртгэлд ч мөрдөгдөнө. Татвар нь цэвэр орлого буюу ашигт суурилсан байдаг. Тиймээс тайлант хугацаанд банкны хүлээн зөвшөөрсөн татварын зардлын дүн нь тайлагнасан татварын өмнөх ашиг, алдагдалтай холбоотой байна.

Тайлант болон өмнөх хугацаанд хамаарах аж ахуйн нэгжийн орлогын албан татварын өглөгийг тайлант хугацааны эцсээр хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээгээр татварын эрх бүхий байгууллагад төлөх эсвэл хүлээн авах дүнгээр хэмжинэ.

Орлогын албан татварын өглөгийг холбогдох татварын хуульд нийцүүлэн тооцоолдог бол орлогын тайланд тусгагдах орлого, зардал, ашгийг СТОУС-д нийцүүлэн толилуулна. Энэ нь одоогийн болон ирээдүйн тайлант хугацааны татварыг өглөгийг хуримтлуулан бүртгэнэ гэсэн үг юм. Иймээс эдгээрийн хооронд түр ба байнгын зөрүү үүсдэг.

Татварын байгууллага санхүүгийн тайлагналд ашигладгаас ялгаатайгаар татвар ногдох орлого буюу ашгийг тодорхойлдог бөгөөд татвар ногдуулвал зохих орлогыг тооцоолохдоо зардал гэж зөвшөөрөөгүй зүйлс болон тэдний зүгээс татвар ногдохгүй буюу татвараас чөлөөлөгдөнө хэмээн тодорхойлсон тодорхой орлогын зүйлсээс шалтгаалан татварын байнгын зөрүү бий болдог. Татвараас хасагдахгүй зардлын улмаас татварын байнгын зөрүү үүсч байдаг. Байнгын зөрүүг дараа үеүдэд буцаахгүй бөгөөд энэ нь тухайн тайлант үеийн татварын зардлыг тооцоолох үед залруулагддаг байна. Иймд тайлант үеийн татварын зардал нь байнгын зөрүүг залруулж тодорхойлсон ашгийг татварын хувь хэмжээгээр үржүүлээд гарсан дүнтэй тэнцэнэ. Өөрөөр хэлбэл байнгын зөрүү нь тохируулагдахгүй зөрүү тул үүнийг хойшлуулан бүртгэхгүй, тайлант үеийн татварын зардалд хамруулна. Зарим хүүгийн орлогод татвар ногдуулахгүй бөгөөд энэ нь татварын байнгын зөрүү үүсгэнэ. Татварын байнгын зөрүүг хэзээ ч татварт төлөхгүй тул хойшлогдсон татварын хөрөнгө буюу өр төлбөрөөр бүртгэхгүй.

Татварын түр зөрүү нь орлого, зардлыг орлогын тайлан ба татварын тайланд хүлээн зөвшөөрөх цаг хугацааны ялгаанаас үүсэх тул үүнийг хойшлуулан бүртгэнэ. Татварын түр зөрүү нь татвар ногдуулах орлогоос ирээдүйд хасагдах зардал, ирээдүйд татвар ногдуулах орлого зэргээс шалтгаалан үүсдэг. Үүний улмаас хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь болон СТОУС-д нийцүүлэн тооцоолсон дансны үнийн хооронд зөрүү үүсдэг. Иймд эдгээр зүйлд хамаарах татварыг хойшлуулан бүртгэнэ.

Түр зөрүү = Хөрөнгө, өглөгийн дансны үнэ – Хөрөнгө, өглөгийн татварын суурь

Хойшлогдсон татварын хөрөнгө, өглөг = Түр зөрүү * Татварын хувь (%)

Хойшлогдсон татварын хөрөнгө, өглөгийг тооцохдоо хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээг ашиглана. Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээг ашиглан тоцоолно. Гэхдээ засгийн газраас татварын хувь хэмжээг хэсэг хугацааны дараа өөрчлөхөөр баталсан нь татварын орчинд үлэмж өөрчлөлт оруулсан байж болно. Энэ тохиолдолд татварын өөрчлөгдсөн хувь хэмжээг ашиглан татварын хөрөнгө, өр төлбөрийг тоцоолно. Янз бүрийн түвшний татвар ногдуулах орлогод ялгаатай хувь хэмжээгээр татвар ногдуулдаг тохиолдолд түр зөрүүг буцаахаар хүлээгдэж буй хугацааны татвар ногдуулах орлогод ашиглах таамаглаж буй татварын дундаж хувь хэмжээг ашиглан хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг тооцоолно.

Хойшлогдсон татварын өглөг ба хойшлогдсон татварын хөрөнгийн хэмжилт нь тайлант хугацааны эцэст хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийг нөхөх буюу барагдуулах замаар үүсэж байгаа татварын үр нөлөөг тусгана.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өглөгийг дискаунтчилж өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэхгүй.

Тайлант үеийн болон хойшлогдсон татварыг доор дурдсанаас бусад тохиолдолд орлого, зардалд бүртгэж, тайлант үед хүлээн зөвшөөрнө:

а) Тухайн тайлант хугацаанд эсвэл үүнээс ялгаатай тайлант хугацаанд орлого, зардлаас гадуур хүлээн зөвшөөрч, бүртгэсэн ажил гүйлгээ, үйл явдлыг бусад дэлгэрэнгүй орлого буюу шууд өөрийн хөрөнгөнд бүртгэсэн,
б) компанийн нэгдэл үүсэх.

Орлого, зардлаас гадуур бүртгэсэн зүйлтэй холбоотойгоор татвар яригдаж байгаа тохиолдолд түүнтэй холбоотой тайлант үеийн болон хойшлогдсон татварыг орлого, зардлаас гадуур хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Иймээс хүлээн зөвшөөрч, бүртгэсэн зүйлд хамаарах тайлан үеийн болон хойшлогдсон татварыг тухайн тайлант хугацаанд болон ялгаатай хугацаанд бүртгэнэ. Өөрөөр хэлбэл бусад дэлгэрэнгүй орлогын зүйлийг бусад дэлгэрэнгүй орлогоор, өөрийн хөрөнгөөр бүртгэсэн бол өөрийн хөрөнгөнд бүртгэнэ.

Татварын түр зөрүү үүсгэж, хойшлогдсон татварыг орлого, зардлаар дамжуулан бүртгэхэд гардаг түгээмэл жишээнд үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийг элэгдүүлж, хорогдуулах хувь хэмжээ нь татварын хувь хэмжээнээс зөрүүтэй байх, татварын алдагдлыг хойшлуулах, хангалттай баримтжуулаагүйгээс шалтгаалан хуримтлуулсан зардал буюу зарим нэг төрлийн нөөц, сан, татварын хөнгөлөлт зэрэг багтана. Түүнчлэн гадаад валютын хэрэгжээгүй орлого, зардал, деривативын бодит үнэ цэнийн өөрчлөлт (хэрэгжээгүй зөрүү) зэрэг зүйлсийг хэрэгжээгүй үед нь татвар ногдуулах буюу татвараас хасахгүй боловч хэрэгжсэн үед нь татвар ногдуулж, татвараас хасдаг тул эдгээрийн улмаас хойшлогдсон татвар үүснэ. Хураамж, шимтгэл (ялангуяа, хангалттай баримтжуулалт хийгдээгүй үед орлого, зардлыг хойшлуулахыг СТОУС шаардаж болно), хойшлуулсан буцалтгүй тусламжийн орлого, СТОУС-д заасан тусгай тохируулгууд (жишээлбэл, зах зээлийн хүүгийн түвшнээс дээгүүр эсвэл доогуур хүүтэй зээл ба зээлийн эх үүсвэр), аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг тооцоолох үед цаг хугацааны зөрүү үүсгэхээр тодорхойлогдсон бусад зүйлсийн бүртгэл тус тус үүнд хамаарна.

Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийг татварын зорилгоор элэгдүүлж, хорогдуулахад татварын байгууллагаас тогтоосон хувь хэмжээ нь санхүүгийн тайлагналын зорилгоор элэгдүүлж, хорогдуулах хувь хэмжээнээс ялгаатай байж болно. Банк нягтлан бодох бүртгэлийн зорилгоор ашиглах хөрөнгийн ашиглалтын хугацааг тодорхойлсон суурийг харьцуулж, баримтжуулах ба элэгдэл, хорогдлын хувь хэмжээ ялгаатай тохиолдолд хойшлогдсон татварыг тооцоолно (энэ үед үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн татварын суурь ба нягтлан бодох бүртгэлийн суурь хоорондоо ялгаатай тодорхойлогдоно). Энэ тохиолдолд татварын зорилгоор үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн тооцооллыг тусад нь гүйцэтгэнэ.

Бусад дэлгэрэнгүй орлого эсвэл шууд өөрийн хөрөнгөөр дамжуулан бүртгэх хойшлогдсон татвар үүсгэх зүйлсийг дурдвал хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөнд ашиглах бодит үнэ цэнийн загвар, халаасны хувьцааны арилжаа, хувьцаа эзэмшигчдээс татан төвлөрүүлсэн зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй зээлийн эх үүсвэр (үүний улмаас үүсэх анх хүлээн зөвшөөрөх үеийн олзыг өөрийн хөрөнгөнд бүртгэнэ), гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүүг өөрийн хөрөнгөнд бүртгэх (бүртгэл валют нь ялгаатай гадаад дахь охин компанитай тохиолдол) зэрэг багтана.

Компанийн нэгдэл үүссэний улмаас татварын түр зөрүү үүсч болно. СТОУС 3-ын дагуу банк бизнесийн нэгдлийн худалдан авалтын өдрөөр хойшлогдсон татварын хөрөнгө эсвэл хойшлогдсон татварын өр төлбөрийг хөрөнгө, өр төлбөр болгон хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Иймээс хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр нь компанийн нэгдэл үүссэнтэй холбоотой бий болох гүүдвил эсвэл тохиролцоот худалдан авалтын орлогын дүнг өөрчилнө. Гэвч банк гүүдвилийг анхны удаад хүлээн зөвшөөрөх үед үүссэн хойшлогдсон татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрч, бүртгэхгүй.

Д. БҮРТГЭЛ

Орлогын албан татварыг урьдчилж төлөхөд татварын авлагад бүртгэнэ.

Дебит: Татварын хөрөнгө
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Татварын хувь хэмжээгээр тооцоолсон тайлант хугацаанд хамаарах татварыг ААНОАТ-ын өглөгт бүртгэнэ.

Дебит: Татварын зардал
Кредит: Тайлант үеийн орлогын албан татварын өглөг

Татварын хөрөнгө, өр төлбөрийг хааж цэвэршүүлсэн бол

Дебит: Тайлант үеийн орлогын албан татварын өглөг
Кредит: Татварын авлага

Татварын түр зөрүүгийн нөлөөгөөр хойшлогдсон татварын хөрөнгө үүсэхэд

Дебит: Хойшлогдсон татварын хөрөнгө
Кредит: Тайлант үеийн орлогын албан татварын өглөг

Хойшлогдсон татварын хөрөнгийг бууруулж, түр зөрүүг тохируулах үед

Дебит: Татварын зардал
Кредит: Хойшлогдсон татварын хөрөнгө

Татварын түр зөрүүгийн нөлөөгөөр хойшлогдсон татварын өглөг үүсэхэд

Дебит: Татварын зардал
Кредит: Хойшлогдсон татварын өглөг

Хойшлогдсон татварын өглөгийг татварын түр зөрүүгээр бууруулж тохируулах үед

Дебит: Хойшлогдсон татварын өглөг
Кредит: Тайлант үеийн орлогын албан татварын өглөг

Жишээ: **Хойшлогдсон татварын хөрөнгө - Алдагдал шилжүүлэх**

Банк 20Х1 онд 120 сая төгрөгийн алдагдалтай ажилласан ба холбогдох хуулийн дагуу үүнийгээ ирэх хоёр жилд шилжүүлж болох ба гурав дахь жилээс уг алдагдлыг хойшлуулахгүй.

Ирээдүйн татвар ногдуулах ашиг ба бусад хүчин зүйлсийн таамаглалд суурилан уг алдагдлаас 80 сая төгрөгийг нь заасан хугацаанд багтаан ашиглах боломжтой гэж үнэлсэн. Орлогын албан татварын хувь хэмжээ 10%. Банкны үнэлгээгээр ирэх 2 жилийн татвар ногдуулах ашиг нь 80 сая төгрөгийн алдагдлыг шилжүүлэхэд хүрэлцэнэ. Иймээс эргэн нөхөгдөх бөгөөд хүлээн зөвшөөрч бүртгэх хойшлогдсон татварын хөрөнгө нь 8 сая төгрөг болох ба үүнийг дараах байдлаар бүртгэнэ.

20Х1 оны 12 дугаар сарын 31-нд

Дебит: Хойшлогдсон татварын хөрөнгө 8 сая
Кредит: Тайлант үеийн орлогын албан татварын зардал 8 сая

Хэрэв банк ирэх 2 жилд 80 сая төгрөгийг бүхэлд нь ашиглахад хүрэлцэх татварын ашигтай ажиллаж чадахааргүй болсон тохиолдолд банкны удирдлага хэдий хэмжээний татварын алдагдлыг шилжүүлэн тооцохыг өөрийн төсөв болон бусад мэдээлэлд үндэслэн үнэлнэ. Жишээлбэл, банкны таамаглаж байгаагаар зөвхөн 30 сая төгрөг нөхөгдөх бол хойшлогдсон татварын хөрөнгө нь 8 сая төгрөг бус харин 3 сая төгрөг болно.

Хэрэв банк 20Х2 оны татвар ногдуулах бодит орлогод үндэслэн 20Х2 оны татварын тайланд 50 сая төгрөгийн татварын алдагдлыг нөхөх боломжтой гэж үзээд бууруулж харуулсан тохиолдолд 20Х2 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 5 сая төгрөгийн хойшлогдсон татварын хөрөнгө ашиглагдах юм.

Дебит: Хойшлогдсон татварын зардал 5 сая
Кредит: Хойшлогдсон татварын хөрөнгө 5 сая

Энэ бичилт нь орлого, зардалд сөрөг нөлөөлөл үзүүлэх (өөрөөр хэлбэл хойшлогдсон татварын зардлыг 5 сая төгрөгөөр нэмэгдүүлнэ) боловч татварын алдагдлыг шилжүүлсэн тооцсоны үр дүнд тайлант үеийн татварын зардал 5 сая төгрөгөөр буурах ба улмаар тайлант үеийн татварын зардал буурснаар тайлант үеийн татварын өглөг 5 сая төгрөгөөр буурна.

Үлдсэн 30 сая төгрөгийг дараагийн жилд нь ашиглах бөгөөд дээрхтэй нэгэн адил бүртгэнэ.

Жишээ: **Хойшлогдсон татварын хөрөнгийн тооцоо**

Банк 500,000 төгрөгөөр үндсэн хөрөнгө худалдан авсан ба 10 жил элэгдүүлнэ, үлдэх өртөггүй. Уг хөрөнгийг санхүүгийн бүртгэлийн зорилгоор давхар бууруулах аргаар 20%-иар элэгдүүлнэ, харин татварын зорилгоор шулуун шугамын аргаар элэгдүүлдэг.

	Анхны өртөг	Элэгдлийн зардал	Дансны дүн	
Санхүүгийн бүртгэлд	500,000	100,000	400,000	Бүртгэлийн суурь
Татварын зорилгоор	500,000	50,000	450,000	Татварын суурь
Түр зөрүү			50,000	
Хойшлогдсон татварын хөрөнгө			5,000	50000 *10% татварын хувь хэмжээ

Банк татварын болон санхүүгийн бүртгэлийн зорилгоор ижилхэн шулуун шугамын аргыг ашиглах боловч хөрөнгийн ашиглалтын хугацаа нь СТОУС болон татварын хууль, тогтоомжийн дагуу ялгаатай байгаа тохиолдолд дээрхтэй нэгэн адил нөхцөл байдал үүснэ.

Хойшлогдсон татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрч бүртгэх шаардлагатай үед дараах байдлаар бүртгэнэ:

Дебит: Хойшлогдсон татварын зардал
Кредит: Хойшлогдсон татварын өглөг

Е. ТОДРУУЛГА

Хойшлогдсон татварын хөрөнгийг эргэлтийн бус, өглөгийг урт хугацаатай гэж үзнэ.

Хойшлогдсон татварын хөрөнгө болон хойшлогдсон татварын өр төлбөрийг санхүүгийн тайланд нэгтгэсэн цэвэр дүнгээр толилуулна. Энэ нь банк санхүүгийн байдлын тайландаа хойшлогдсон татварын хөрөнгө ба хойшлогдсон татварын өглөгийн аль нэгийг толилуулна гэсэн үг юм.

Санхүүгийн тайлангийн тодруулгад багтах бусад тодруулгыг санхүүгийн тайлангийн тодруулгыг бэлтгэх аргачлал (Хавсралт 6)-д заасан.

НББОУС 12-д заасан дараах дэлгэрэнгүй тодруулгыг тусад нь харуулна:

- Татварын зардлыг бүрдүүлж буй гол элементүүдийг тусад нь тодруулна:
    - Тайлант үеийн татварын зардал (орлого)
    - Өмнөх тайлант хугацааны татварт хамаарах боловч энэ тайлант хугацаанд хийгдсэн тохируулга
    - Хойшлогдсон татварын дансыг хаах болон өмнө хаасан дансыг буцаах үед үүссэн хойшлогдсон татварын зардал буюу түр зөрүүг үүсгэх ба буцаахтай холбоотой хойшлогдсон татварын зардлын дүн
    - Тайлант үеийн татварын зардлыг бууруулахад ашиглагдах, өмнөх хугацааны бүртгээгүй татварын алдагдал, татварын хөнгөлөлт, түр зөрүүнээс үүссэн өгөөжийн дүн
    - Өмнө нь хүлээн зөвшөөрсөн татварын алдагдал, татварын хөнгөлөлт, хойшлогдсон татварын зардлыг бууруулахад ашиглагдах өмнөх хугацааны түр зөрүүнээс үүссэн өгөөжийн дүн.
- Өөрийн хөрөнгөнд шууд бүртгэсэн буюу кредитлэсэн зүйлстэй холбоотой тайлант үеийн болон хойшлогдсон татварын нийт дүн
- Бусад дэлгэрэнгүй орлогын төрөл тус бүрд харгалзах орлогын албан татварын дүн
- Татварын зардал (орлого) ба нягтлан бодох бүртгэлийн ашгийн хоорондын хамаарлыг дараах хэлбэрээр тайлбарлах:
    - Татварын зардал (орлого) ба нягтлан бодох бүртгэлийн ашгийн хоорондох тохируулгыг харуулахдаа мөрдөгдөж буй татварын хувь хэмжээгээр үржүүлж, тооцоололд ашигласан татварын хувь хэмжээг тодруулна. Эсвэл татварын дундаж хувь хэмжээ ба ашигласан хувь хэмжээний хооронд тохируулга хийж, тооцоололд ашигласан татварын хувь хэмжээний үндэслэлийг тодруулна.
- Мөрдөгдөж буй татварын хувь хэмжээг өмнөх оны хувь хэмжээтэй харьцуулан, өөрчлөгдсөн тохиолдолд шалтгааныг нь тайлбарлана.
- Хасагдах татварын түр зөрүүгийн дүн (түүний хүчин төгөлдөр байх хугацаа), санхүүгийн байдлын тайланд түр зөрүү үүсгэж буй ашиглагдаагүй татварын алдагдал, ашиглагдаагүй татварын хөнгөлөлт.

7.5. ЗОГСООСОН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Банк үйл ажиллагааныхаа тодорхой хэсгийг хаах эсвэл худалдан борлуулахаар болсон бол зогсоосон үйл ажиллагаа гэж үзэх ба энэ нь:

(а) үйл ажиллагааны тусдаа чиглэл/төрөл эсвэл тодорхой газар зүйн бүсэд явуулдаг үйл ажиллагаа,
(б) үйл ажиллагааны тусдаа чиглэл/төрөл эсвэл тодорхой газар зүйн бүсэд явуулдаг үйл ажиллагааны нэг хэсэг болсон, эсвэл
(в) компанийн нэгдлийг худалдан авах үед буцааж худалдах зорилгоор авсан охин компани байж болно.

Зогсоосон үйл ажиллагаатай холбоотой хөрөнгө, өр төлбөрийг үлдээсэн (борлуулаагүй) бол үүнийг борлуулах зориулалттай хөрөнгө ба борлуулах өр төлбөрт тус тус бүртгэнэ. СТОУС 5-ын шалгуурууд хангагдсан нөхцөлд ийм хөрөнгө, өр төлбөрийг борлуулах зориулалттай хөрөнгө ба борлуулах өр төлбөрөөр ангилж, бүртгэнэ. Холбогдох тодорхойлолт, бүртгэл, энэ ангилалд хамаарах СТОУС 5-ын заалтууд, орлого, зардлыг тасралтгүй үйл ажиллагааны орлого, зардалд бүртгэх зэргийн талаар “Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, борлуулах зориулалттай хөрөнгө” бүлэгт оруулсан.

НАЙМ. ТЭНЦЛИЙН ГАДУУРХ ДАНС

Тэнцлийн гадуурх дансууд нь зээл, зээлтэй адилтгах хөрөнгөтэй холбоотой хүлээх үүрэг, болзошгүй үүрэг, барьцаа хөрөнгө, тэнцлээс хассан хөрөнгө, харилцагчийн өмнөөс батлан даасан хөрөнгө, дериватив, барьцаанд тавьсан хөрөнгө зэрэг банкны зарим үйл ажиллагааг бүртгэх дансд юм.

8.1. ЗЭЭЛ, ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨНД ХАМААРАХ ҮҮРЭГ

а. Тодорхойлолт

Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөтэй холбоотой хүлээх үүрэгт банкнаас харилцагчийн нэрийн өмнөөс гаргасан баталгаа, батлан даалт, нээсэн зээлийн шугам, аккредитив гэх зэрэг бусдын өмнөөс хүлээж болзошгүй банкны үйлчилгээтэй холбоотой бүх үүрэг багтана. Эдгээр хэрэгслийн гол зорилго нь харилцагчийн шаардсаны дагуу банк хөрөнгө гарган өгөх боломжтой гэдгийг харуулахад оршино.

б. Хэмжилт ба үнэлгээ

Зээлд хамаарах үүргийг гэрээнд заасан болзошгүй өр төлбөрийн үнийн дүнгээр бүртгэнэ.

в. Бүртгэл

1) Баталгаа, батлан даалт

Төлбөрийн нөхцөл нь банкнаас харилцагчийн болон өөрийн нэрийн өмнөөс гадаад, дотоодын банк, төлбөр хүлээн авагчдад гаргасан цаашид хүлээж болзошгүй үүргийг батлан даалт гэнэ. Баталгаа гэдэг нь харилцагч гуравдагч талд хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй нөхцөл байдал үүсвэл банк харилцагчийн өмнөөс төлбөрийг барагдуулах үүрэг хүлээсэн буцаан дуудахгүй баталгаа бөгөөд зээлтэй адил эрсдэл агуулдаг.

Банкнаас холбогдох журмын дагуу гаргасан батлан даалтыг үндэслэн тэнцлийн гадуур бүртгэж, батлан даалтын хугацаа дуусч, төлбөр төлөгдөх үед зарлагадна. Батлан даалт гаргуулагч нь төлбөрийг хугацаандаа төлөөгүй нөхцөлд банк харилцагчийн өмнөөс төлбөрийг барагдуулж (батлан даалтын нөхцөлийн дагуу), тухайн харилцагчтай зээлийн гэрээ байгуулна. Баталгааг тэнцлийн дотор зээлийн багцад тусгах бөгөөд үүнтэй зэрэгцэн тэнцлийн гадуурх дүнг зарлагадна. Банкны барагдуулсан баталгааны төлбөр нь харилцагчийн санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдал буюу өөрөөр хэлбэл үнэ цэнийн бууралтыг харуулдаг учраас зээлийн дансны үнэ нь урьдчилан тооцсон эргэн төлөгдөх дүнтэй тэнцүү байдаг. Эрсдэлийн сантай холбоотой хийх үнэлгээг “Зээл” бүлэгт оруулсан.

2) Аккредитив

Банк нь харилцагч, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн төлбөр тооцоо хийх хүсэлтийг үндэслэн холбогдох хууль тогтоомжийн дагуу аккредитивийг нээнэ.

Тодорхой нөхцөл, хугацааны дагуу аккредитивт заасан үнийн дүнг харилцагчийн өмнөөс гуравдагч талд төлж барагдуулахаа хүлээн зөвшөөрч буй банкны бичгээр гаргасан үүрэг амлалт болох баримт, арилжааны аккредитивыг тэдгээрт харгалзах бараа бүтээгдэхүүний ачилт эсвэл харилцагчийн мөнгөн хадгаламжийг барьцаалдаг учраас эдгээр төлбөрийн арга хэрэгслүүд нь эрсдэл багатай байдаг.

Банк аккредитив гаргахдаа харилцагчийн барагдуулахаар хүлээж буй төлбөрийн дүнгээр импортын эсвэл экспортын аккредитивыг дансанд бүртгэнэ.

Аккредитивын хугацаа болоход харгалзах төлбөрийг хийж, тэнцлийн гадуурх дүнг зарлагадна. Хэрэв аккредитивын хүсэлт гаргагч нь заасан хугацаандаа төлбөрөө барагдуулж чадахгүй бол банк харилцагчийн өмнөөс төлбөрийг барагдуулж, тухайн холбогдох харилцагчтай зээлийн гэрээ байгуулж, түүнийгээ тэнцлийн дотор зээлийн багцад оруулна. Ийм тохиолдолд банк үнэ цэнийн буурсан нотолгоо байгаа эсэх, зээлийн дансны үнэ нь эргэн төлөгдөх буюу нөхөгдөх дүнтэйгээ тэнцүү байгаа эсэх (дээрх ‘Баталгаа, батлан даалт’ хэсэгт тайлбарласны дагуу) -ийг СТОУС-ын дагуу үнэлж, тэнцлийн гадуурх аккредитивыг зарлагадна.

3) Зээлийн шугам ба овердрафтын зээлд ашиглагдаагүй зээлийн шугам

Зээл олгохоор хүлээсэн үүрэг нь зээл (овердрафтыг оруулаад), баталгаа, батлан даалт болон аккредитивын хэлбэрээр зээл олгох үүргийн ашиглагдаагүй хэсгийг харуулна. Зээл олгохоор хүлээсэн үүргийн эрсдэлтэй холбоотой ашиглагдаагүй үүргийн дүнтэй тэнцүү алдагдал хүлээж болно.

Зээлийн шугам. Зээлийн шугам нь зээл олгохоор хүлээсэн банкны үүргийн хамгийн түгээмэл хэлбэр бөгөөд зээлийн дүнг бүтнээр нь эсвэл хэсэгчлэн авах хүсэлт гаргах эрхтэй хүсэлтээр зээл авах боломжийг олгодог.

Харилцагчид зээлийн шугам нээсэн тухай бүрт үүнийг тэнцлийн гадуурх зээлд хамаарах үүрэг дансанд бүртгэнэ. Хэрэв харилцагч зөвшөөрсөн хязгаарын тодорхой хэсгийг авах хүсэлт гаргавал тухайн хэсгийг балансанд зээл болгон бүртгэх бөгөөд зээлийн шугамын зөвшөөрсөн дүнгийн ашиглагдаагүй үлдсэн хэсгийг тэнцлийн гадуурх дансанд үлдээнэ.

Эдгээр ажил гүйлгээг бүртгэхэд зээлийн шугам дансыг ашиглана.

Харилцагч олгогдоогүй дүнг хүссэн үедээ шаардах эрхтэй ба эсвэл тодорхой нэг өдөр авч болно. Банк мөнгөн хөрөнгийн болон хөрвөх чадвараа тооцохдоо зээлийн шугамын дагуу гарахаар хүлээгдэж буй дүнг тодорхойлно. Банк өөрийн хөрвөх чадвараа зохистой тогтоохын тулд зээлийн шугамыг хэрхэн ашиглах талаар харилцагчаас холбогдох мэдээлэл авч байх шаардлагатай.

Банк зээл олгох буюу зээлийн шугам нээх гэрээний нөхцлийг зөрчсөн гэрээний хувьд авах арга хэмжээг тодорхойлох нь зүйтэй. Тухайлбал, харилцагч ямар нэгэн зөрчил гаргасан нөхцөлд гэрээг цуцлах эрхтэй байж болно

Овердрафтын зээлийн шугам. Банк харилцагчдаа зөвшөөрөхөд тухайн харилцагч овердрафтын зээлийн шугамыг тогтсон хязгаараас хэтрүүлэлгүй нээнэ. Овердрафтын авч болох дээд хязгаар ба бодитоор зээлсэн дүнгийн хоорондох зөрүү нь ашиглагдаагүй хязгаарыг харуулна. Ихэнх тохиолдолд гэрээний дагуу харилцагч банкинд мэдэгдэлгүйгээр овердрафтын дээд хязгаарт хүртэл зээлийг өсгөх эрхтэй байна. Гэрээнд өөрөөр заагаагүй бол банк зээлийн шугамын ашиглагдаагүй дүнг шуурхай гарган өгөхөд бэлэн байна.

Харилцагч олгогдоогүй овердрафтын дүнг хүссэн үедээ шаардах эрхтэй ба эсвэл тодорхой нэг өдөр авч болно. Банк мөнгөн хөрөнгийн болон хөрвөх чадвараа тооцохдоо овердрафтын зээлийн шугамын дагуу гарахаар хүлээгдэж буй дүнг тодорхойлно. Банк хөрвөх чадвараа зохистой тогтоохын тулд овердрафтын зээлийн шугамыг хэрхэн ашиглах талаар харилцагчаас тодорхой мэдээлэл авч байх шаардлагатай.

Овердрафтын ашиглагдаагүй зээлийн шугамын хувьд банк дээр тайлбарласан зээлийн шугамтай адил бүртгэнэ. Харин ашиглагдаагүй дүнг тэнцлийн гадуурх “Овердрафтын зээлийн шугам” дансанд бүртгэнэ.

4) Худалдсан зээлтэй холбоотой хүлээж болзошгүй үүрэг

Банк зээл, зээлийн багцаа бусдад худалдсан боловч зээлтэй холбоотой тодорхой эрсдэл хүлээж, гэрээний дагуу үүрэг хүлээсэн бол үүссэн болзошгүй үүргийг энэ дансанд бүртгэнэ.

5) Үйл ажиллагааны түрээсээр хүлээсэн үүрэг

Үйл ажиллагааны түрээсээр хүлээсэн үүрэг нь банкны үйл ажиллагааны түрээсийн ирээдүйн бүх төлбөрийг агуулдаг. Банк түрээслэгч байх тохиолдолд цуцлах боломжгүй үйл ажиллагааны түрээсээр ирээдүйд төлөх хамгийн бага түрээсийн төлбөрийг (өөрөөр хэлбэл үйл ажиллагааны түрээсээр хүлээсэн үүрэг) төлөгдөх хугацаанд нь суурилан тодруулна. Зөвхөн “үл цуцлах” нөхцөл бүхий үйл ажиллагааны түрээсийн үед л энэхүү үүргийг хүлээнэ. Тухайн түрээс нь “үл цуцлагдах” гэх тодорхойлолтыг хангах эсэхийг тогтоохын тулд банк үйл ажиллагааны түрээсийн гэрээний заалтыг анхааралдаа авна. Хэрэв түрээсийг бүхлээр нь цуцлах боломжтой гэж үзвэл цуцлахад төлөх торгууль болон мэдэгдэл өгсөн хугацааны төлбөр төлөх үүрэг хүлээсэн үед үүнийг тэнцлийн гадуурх дансанд бүртгэж, тодруулна.

Үйл ажиллагааны түрээсээр хүлээсэн үүргийг түрээсийн хугацааны эцэс хүртэлх дискаунтчилаагүй мөнгөн гүйлгээний дүнгээр бүртгэнэ.

6) Хамтын зээлжүүлэлтээр хүлээсэн үүрэг

Банк бусад банктай хамтын зээлжүүлэлтийн гэрээ хийсэн боловч эх үүсвэрийг шилжүүлээгүй эсвэл хамтын зээлжүүлэлтэнд эх үүсвэргүй оролцож буй тохиолдолд хүлээсэн болзошгүй үүргийн дүнгээр энэ дансанд бүртгэнэ.

7) Бусад болзошгүй үүрэг

Үүнд тэнцлийн гадуурх дансны жагсаалтад ороогүй бусад үүрэг эсвэл банкны харилцагчийн өмнө хүлээсэн бусад үүрэг багтана. Тухайлбал: үнэт металыг борлуулах эсвэл худалдан авах үүргээс гадна тусгай үйлчилгээ үзүүлэхээр үүрэг хүлээсэн байж болно.

Мөн НББОУС 37-ын дагуу болзошгүй өр төлбөрийн тодорхойлолтыг хангах банкнаас хийх боломжит төлбөрүүдийг бүртгэнэ. Төлбөр төлөгдөх магадлал нь 50 хувиас бага (өөрөөр хэлбэл, төлбөр төлөгдөх магадлал багатай) болохыг банкны удирдлага үнэлсэн нөхцөлд энэхүү хүлээсэн үүргийг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрөхгүй, харин төлөгдөх боломжтой болсноор эрсдэлд өртөх дүнг (болзошгүй төлбөрийн хамгийн их дүн) “Бусад болзошгүй үүрэг” дансанд бүртгэж, тодруулна.

8.2. БАРЬЦАА ХӨРӨНГӨ

а. Тодорхойлолт

Барьцаа хөрөнгө гэж зээл, зээлтэй адилтгах хөрөнгөтэй холбогдуулан эргүүлэн авах нөхцөлтэйгөөр харилцагчаас банкинд барьцаа болгон өгсөн хөрөнгийг ойлгоно. Барьцаа хөрөнгөнд санхүүгийн (үнэт цаас) болон санхүүгийн бус (барилга байгууламж, бараа материал) хөрөнгө багтана.

б. Хэмжилт ба үнэлгээ

Барьцаа хөрөнгийг зээл олгосон өдрийн (барьцааг хүлээн зөвшөөрч) зах зээлийн үнээр бүртгэнэ.

в. Бүртгэл

Банкнаас барьцаа болгон хүлээн авсан хөрөнгийг тэнцлийн гадуур бүртгэнэ.

Зээлдэгч зээл, авлагынхаа төлбөл зохих нийт дүнг хугацаанд нь төлсөн тохиолдолд барьцаанд авсан хөрөнгийг уг тэнцлийн гадуурх данснаас зарлагадна.

Зээлдэгч төлбөрөө хугацаанд нь барагдуулж чадаагүй бөгөөд шүүхээс зээлийн үлдэгдэл төлбөрийг хаахын тулд барьцаанд авсан хөрөнгийг эзэмших эрхийг банк өөртөө шилжүүлэн авахыг зөвшөөрсөн тохиолдолд тухайн хөрөнгийг тэнцлийн гадуурх данснаас зарлагадна. Уг хөрөнгийг өмчлөх бусад хөрөнгийн дансдын (“Бусад санхүүгийн хөрөнгө” эсвэл ”Бусад санхүүгийн бус хөрөнгө”) аль нэгнийх нь дебит талд бичих бөгөөд санхүүгийн байдлын тайланд толилуулна. Харгалзах өмчлөх бусад хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй тайлбарыг “Бусад санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгө” бүлэгт оруулсан.

Барьцаа хөрөнгийн талаарх мэдээлэл нь зээлийн багц болон бусад санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэлд өртөх магадлалыг үнэлэхэд чухал бөгөөд СТОУС-ын дагуу зээлийн үнэ цэнийн бууралтыг тооцоолоход ашиглагдана. Түүнчлэн СТОУС 7-ын дагуу хийх тодруулгад барьцаа хөрөнгийн талаар дэлгэрэнгүй, шинэчлэгдсэн мэдээллийг оруулна. Дэлгэрэнгүй тодруулгыг энэ зааврын “Санхүүгийн эрсдэл болон өөрийн хөрөнгийн удирдлага, бусад тодруулга” бүлгээс үзнэ үү.

Үнэт цаас

Банк үнэт цаасны үнэ цэнийн өөрчлөлтийг харгалзан үзсэний үндсэн дээр үнэт цаасыг барьцаа болгон авч болно. Үнэт цаасыг нэг сараас ихгүй хугацаагаар дахин үнэлнэ. Хэрэв өмчлөл нь банкны мэдэлд шилжин ирээгүй байгаа бол харилцагч гэрээг зөрчсөн даруйд өмчлөх эрхийг эзэмших арга хэмжээ авна.

Хөдлөх хөрөнгө

Авто тээврийн хэрэгсэл зэрэг хөдлөх хөрөнгийн үнэ цэн нь цаг хугацаа өнгөрөхийн хирээр буурч байдаг бөгөөд хөдлөх хөрөнгийг барьцаа болгон хүлээн авахдаа банк уг үнэ цэнийн бууралтыг харгалзан үзэж, бүртгэнэ. Мөн тэдгээр хөрөнгө нь эвдэрч гэмтэх, банкны хяналтаас гарахдаа амархан байдаг. Хэрэв өмчлөх эрх нь банкинд шилжин ирээгүй байгаа бол харилцагч гэрээг зөрчсөн даруйд өмчлөх эрхийг эзэмших хуульд заасан арга хэмжээг авна. Хөрөнгийн үнэ цэнэ болон нөхцөл байдлын талаарх шинжээчийн үнэлгээг байнга (жилд нэгээс доошгүй удаа) хийж байх шаардлагатай.

Үл хөдлөх хөрөнгө

Үл хөдлөх хөрөнгийг хурдан хугацаанд худалдан борлуулах боломжтой үнэд суурилан үнэлнэ. Хэрэв хөрөнгийн зах зээл идэвхигүй бөгөөд банк үнэ цэнийг нь бүртгэхэд хүндрэлтэй байгаа тохиолдолд зах зээлийн өнөөгийн үнээс доогуур бүртгэж болно. Хэрэв өмчлөх эрх нь банкинд шилжин ирээгүй байгаа бол харилцагч гэрээг зөрчсөн даруйд өмчлөх эрхийг эзэмших арга хэмжээг авна. Банк төлбөрөө төлөхгүй байгаа харилцагчийн хөрөнгийг битүүмжлэх болон хөрөнгийг хураан хяналтандаа авч, худалдан борлуулах эрхийг баталгаажуулахад шаардагдах хугацааг харгалзан үзнэ. Хөрөнгийн үнэ цэнэ болон нөхцөл байдлын талаарх шинжээчийн үнэлгээг байнга (жилд нэгээс доошгүй удаа) хийж байх шаардлагатай.

Үнэт металл

Үнэт металл хадгалалт, хамгаалалт, хуурамч зүйлсээр солигдох эрсдэлээс сэргийлэхэд банк анхаарах ёстой. Барьцаанд авсан үнэт металлын үнэ цэн буурч болзошгүй байдаг тул үүнийг нэг сараас багагүй хугацаанд дахин үнэлнэ. Хэрэв өмчлөх эрх нь банкинд шилжин ирээгүй байгаа бол харилцагч гэрээг зөрчсөн даруйд өмчлөх эрхийг эзэмших арга хэмжээг авна.

Бусдаас авсан баталгаа, батлан даалт

Банк ийм төрлийн барьцаа хөрөнгийн бичиг баримт нь эх хувилбараар байгаа эсэх, гэрээг зөрчих, төлбөрөө төлж чадахгүй байх нөхцөл байдал үүсэхэд төлбөрийг барагдуулах хөрөнгөтэй буюу хариуцлагатай батлан даагч эсэхийг голчлон анхаарна. Банкны зүгээс батлан даалт, баталгааг төлүүлэх тохиолдлуудыг тодорхойлж, гэрээ зөрчигдөх буюу төлбөр төлөгдөхгүй нөхцөл байдал үүсэхэд төлбөр төлүүлэх тодорхой арга зам болон түүнийг гүйцэтгэх эрх зүйн чадамжийг судалж, бий болгоно.

Бусад барьцаа

Зээлийн гэрээ зөрчигдөх буюу төлбөр төлөхгүй тохиолдолд бусад барьцааг бэлэн мөнгөнд хурдан хөрвөх шинж чанарыг харгалзан хөрөнгийг барьцаанд авна. Банк гэрээ зөрчигдөх буюу төлбөр төлөгдөхгүй нөхцөл байдал үүсэхэд төлбөрөө төлүүлэх тодорхой арга зам болон түүнийг гүйцэтгэх эрх зүйн чадамжийг бий болгоно.

8.3. ТЭНЦЛЭЭС ХАССАН ХӨРӨНГӨ

а. Тодорхойлолт

Уг бүлэгт хамаарах хөрөнгө нь холбогдох хууль, журмын дагуу эргэн төлөгдөхгүй гэж үзсэн банкны удирдлагаас гарсан албан ёсны шийдвэрт тулгуурлан банкны тэнцлээс хассан хөрөнгө юм.

б. Хэмжилт ба үнэлгээ

Хассан хөрөнгийг тэнцлээс хассан дүнгээр нь бүртгэнэ.

в. Бүртгэл

<u>Үнэт цаасны эрсдэлийн сангаар хаасан үнэт цаас</u>

Үнэт цаасны үнэ цэнийн бууралтаас шалтгаалан холбогдох эрсдэлийн сангаар нь хаасан бол үүнийг тэнцлийн гадуурх “Үнэт цаасны эрсдэлийн сангаар хаасан үнэт цаас” дансанд бүртгэнэ.

Хэрэв үнэт цаасны (өмнө нь балансаас хассан) үнэ цэн нь дараагийн тайлант үед материаллаг дүнгээр эргэж өссөн, тухайн хөрөнгийн эргэн төлөгдөх байдал өссөн зэргийг илтгэх нөхцөл байдал өөрчлөгдсөн (гэрээний нөгөө талын эрсдэл буурсан гэх мэт) тохиолдолд банкны удирдлага тэдгээрийн нөхөгдөх дүнг дахин үнэлж болно. Энэ тохиолдолд банкны удирдлага тэдгээр хөрөнгө нь бүхлээрээ буюу хэсэгчлэн нөхөгдөх боломжтой гэж дүгнэсэн бол тэдгээрийн нөхөгдөх дүнг балансанд эргүүлэн хүлээн зөвшөөрч бүртгэх шийдвэр гаргаж болно (өөрөөр хэлбэл, өмнөх балансаас хассан гүйлгээг буцаана). Ийм тохиолдолд харгалзах хөрөнгийг тэнцлийн гадуурх данснаас зарлагадах бөгөөд түүнийг нөхөгдөх дүнгээр нь санхүүгийн байдлын тайланд “Хөрөнгө оруулалт” дансанд бүртгэнэ. Үнэт цаасыг бүртгэх дэлгэрэнгүй тайлбарыг “Хөрөнгө оруулалт” бүлэгт оруулсан.

<u>Зээлийн эрсдэлийн сангаар хаасан зээл</u>

Банк зээлийн үлдэгдэл төлбөрийг төлүүлэх арга хэмжээ үргэлжлүүлэн авах талаар тодорхой тусгасан журамтай байна. Тухайлбал: шүүхэд нэхэмжлэл гаргах, өр барагдуулах байгууллагад хандах зэрэг багтана. Зээлийн төлбөрийг барагдуулахад шаардагдах зардал ямар байхыг тогтоож, цаашид өр авлагыг барагдуулах чиглэлээр авах арга хэмжээг эрчимжүүлэн, гаргасан шийдвэр, авч хэрэгжүүлж буй арга хэмжээг баримтжуулна. Холбоотой талын зээл төлөгдөхгүй бол тухайн зээлдэгчид илүү давуу нөхцөл олгосон эсэхийг тогтоохын тулд тусгайлсан хяналт шалгалт хийх шаардлагатай.

Тодорхой нэг зээлийг эргэн төлөгдөхгүй гэж тооцон нийт зээлийн дүнд эрсдэлийн сан байгуулсан бол эргэн төлөгдөх магадлалыг харгалзан банкны удирдлага холбогдох хууль, журмын дагуу тухайн зээлийг эрсдлийн сангаар хаах шийдвэр гаргаж болно. Хэрвээ банкны удирдлага зээлийг балансаас хасах шийдвэр гаргасан бол банк зээлдэгч нэг бүрийн холбогдох дансыг нягтлан үзэж санхүүгийн байдлын тайлангийн холбогдох зээлийн дүн, түүнд харгалзах эрсдэлийн санг зарлагадан, улмаар зээлийн үлдэгдэл төлбөрийн дүнг тэнцлийн гадуурх “Зээлийн эрсдэлийн сангаар хаасан зээл” дансанд бүртгэнэ.

Хэрэв балансаас хассан зээлийн төлбөр дараагийн тайлант үед эргэн төлөгдвөл түүнийг ашиг, алдагдлын дансанд орлого болгон бүртгэх бөгөөд эргэн төлөгдсөн дүнгээр тэнцлийн гадуурх данснаас зарлагадна.

Бусад хөрөнгийн хувьд үнэ цэнийг буурахад хүргэсэн нөхцөл байдал өөрчлөгдсөн бол банк зээлийн эргэн төлөгдөх байдлыг дахин үнэлнэ. Энэ тохиолдолд банкны удирдлагын зүгээс уг хөрөнгө бүхэлдээ буюу хэсэгчлэн эргэн төлөгдөх боломжтой гэдэг дүгнэлтэнд хүрвэл эргэн төлөгдөх дүнг балансанд бүртгэх шийдвэр гаргана (өөрөөр хэлбэл, өмнө тэнцлээс хассан дүнг буцаах). Холбогдох зээлийг тэнцлийн гадуурх данснаас хасч, нөхөгдөх дүнгээр нь санхүүгийн байдлын тайланд “Зээл”-ийн холбогдох дансанд бүртгэнэ. Зээлийг нягтлан бодох бүртгэлд тусгах дэлгэрэнгүй тайлбарыг энэ зааврын “Зээл” бүлэгт оруулсан.

Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сангаар хаасан хөрөнгө

Зарим онцгой тохиолдолд өмчлөх бусад хөрөнгө бүхлээрээ нөхөгдөхгүй байж болно. Тухайлбал, өмчлөх бусад хөрөнгө нь борлогдохгүй, эргэн төлөх боломжгүй болсон үнэт цаас эсвэл худалдан авах хүн олдохгүй, банк өөр зориулалтаар ашиглах боломжгүй бөгөөд банкинд ямар нэгэн эдийн засгийн үр өгөөж авчирдаггүй барилга, байшин гэх мэт. Ийм тохиолдолд банкны удирдлагын шийдвэрээр өмчлөх бусад хөрөнгийг харгалзах эрсдэлийн сангаар нь хааж, холбогдох дүнг тэнцлийн гадуурх "Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сангаар хассан хөрөнгө" дансанд бүртгэж, хөрөнгийг худалдах арга хэмжээг үргэлжлүүлэн авна.

Хэрэв тэнцлээс хассан хөрөнгийг зах зээлд буцаан борлуулах боломжтой болж, банкны удирдлага тодорхой хэмжээний төлбөр хүлээн авахаар байвал банкны удирдлагаас гаргасан шийдвэрт тулгуурлан тэнцлийн гадуурх данснаас зарлагадаж, түүнийг санхүүгийн байдлын тайланд нөхөгдөхөөр тооцсон дүнгээр нь хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

Үнэт металлын эрсдэлийн сангаар хаасан үнэт металл

Ийм төрлийн хөрөнгийг үнэ цэн буурсны улмаас балансаас хасч байгаа үед түүнийг тэнцлийн гадуурх данс болох "Үнэт металлын эрсдэлийн сангаар хаасан үнэт металл" дансанд бүртгэнэ.

Хэрэв үнэт металлын (өмнө нь тэнцлээс хассан) үнэ цэн нь дараагийн тайлант үед материаллаг дүнгээр өссөн, тухайн хөрөнгийн эргэн төлөгдөх байдал өссөнийг хариулах нөхцөл байдал өөрчлөгдсөн тохиолдолд банкны удирдлага тэдгээрийн эргэн төлөгдөх байдлыг дахин үнэлж болно. Энэ тохиолдолд банкны удирдлага тэдгээр хөрөнгө нь бүхлээрээ буюу хэсэгчлэн эргэн төлөгдөх боломжтой гэж дүгнэсэн бол удирдлагын зүгээс тэдгээрийн нөхөгдөх буюу эргэн төлөгдөх дүнг балансанд хүлээн зөвшөөрч бүртгэхээр шийдэж болно (өөрөөр хэлбэл, өмнөх тэнцлээс хассан гүйлгээг буцаана). Ийм тохиолдолд харгалзах хөрөнгийг тэнцлийн гадуурх данснаас зарлагадах бөгөөд түүнийг нөхөгдөх дүнгээр нь санхүүгийн байдлын тайлан дах "Бусад санхүүгийн бус хөрөнгө" дансанд бүртгэнэ. Үнэт металлыг нягтлан бодох бүртгэлд тусгах дэлгэрэнгүй тайлбарыг "Бусад санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгө" бүлэгт оруулсан.

Авлагын эрсдэлийн сангаар хаасан авлага

Хэрэв авлагын тодорхой дүн нь нөхөгдөх магадлал бага гэж банкны удирдлага үнэлж, түүнийг тэнцлийн гадуур бүртгэхээр шийдвэр гаргасан бол авлагыг харгалзах эрсдэлийн сангаар нь тэнцлээс хасч, тэнцлийн гадуурх "авлагын эрсдлийн сангаар хаасан авлага" дансанд бүртгэнэ. Банк авлага төлүүлэн авахад чиглэсэн арга хэмжээгээ үргэлжлүүлнэ.

Бусад хөрөнгийн хувьд үнэ цэнийг буурахад хүргэсэн нөхцөл байдал арилсан бол банкны удирдлага авлагын эргэн төлөгдөх байдлыг дахин үнэлж үзнэ. Энэ тохиолдолд банкны удирдлагын зүгээс тэдгээр хөрөнгүүд нь бүхэлдээ буюу хэсэгчлэн эргэн төлөгдөх боломжтой гэж үзвэл төлөгдөх дүнг тэнцэлд бүртгэх шийдвэр гаргаж (өөрөөр хэлбэл, өмнө тэнцлээс хассаныг буцаах) болно. Энэ нөхцөлд холбогдох хөрөнгийг тэнцлийн гадуурх данснаас зарлагадаж, эргэн төлөгдөх дүнгээр нь санхүүгийн байдлын тайланд, тодруулбал санхүүгийн байдлын тайлан дах "Бусад санхүүгийн хөрөнгө" дансанд бүртгэнэ. Авлагыг нягтлан бодох бүртгэлд тусгах дэлгэрэнгүй тайлбарыг "Бусад санхүүгийн хөрөнгө" бүлэгт оруулсан.

Хуримтлуулж тооцохыг зогсоосон хүү

Зээлийн үндсэн төлбөр, хүүгийн төлбарийн аль нэг нь зээлийн гэрээнд заагдсан хугацаанаас хойш 90 хоногийн дотор төлөгдөөгүй бол 91 дэх хоногоос эхлэн хүүг хуримтлуулан тоцоохыг зогсоож өмнө нь хуримтлуулсан хүүг буцаана. Буцаасан хүүгийн дүнгээр " Хуримтлуулж тооцохыг зогсоосон хүү" дансанд бүртгэх бөгөөд банкны зүгээс зээлийн үндсэн төлбөр болон хүүг төлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг үргэлжлүүлэн авна. Банк уг хүүг зээлдэгч нэг бүрийн нэрийн дансдаар задлан бүртгэх бөгөөд зээл болон хүүг нэгэн зэрэг төлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Хэрэв зээлийн хүү төлөгдсөн бол төлөгдсөн дүнгээр тэнцлийн гадуурх данснаас зарлагадаж, санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

8.4. ДЕРИВАТИВ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛ

а. Тодорхойлолт

Биет хэлбэрээр шилжүүлэхгүй нөхцөлтэй гэрээ гэж хүүний түвшин, валютын ханш, үнэт цаасны үнэ болон бусад индексийн өөрчлөлтөөс шалтгаалан суурь хөрөнгийг биетээр шилжүүлэлгүй, мөнгөн хөрөнгө хүлээн авах буюу төлөх үүргийг хэлнэ.

Ийм төрлийн арилжааг хоёр төрөлд хуваана: 1) спот арилжаа (гэрээ хийснээс хойш 3 хүртэлх ажлын өдөрт багтаан хэрэгжихээр хүлээгдэж буй арилжаа) ба 2) хугацаа заасан арилжаа (гэрээ хийснээс хойш 3-аас дээш ажлын өдөрт хэрэгжихээр хүлээгдэж буй арилжаа).

б. Хэмжилт ба үнэлгээ

Банк дериватив санхүүгийн хэрэгсэлтэй холбоотой гэрээ, хэлцэлд оролцож байгаа бол хэлцэл хүчин төгөлдөр болсноор хэлцлээр үүссэн авлага (эрх), өглөг (үүрэг) -ийг хэлцлийн дуусах хугацаа хүртэл тэнцлийн гадуур холбогдох дансанд бүртгэнэ.

Санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ өөрчлөгдвөл дахин үнэлэх ба гарах үр дүнг орлого, зардлын дансанд бүртгэж, толилуулна.

в. Бүртгэл

Деривативын авлага, өглөгийг нэрлэсэн дүнгээр (тооцоолсон дүнгээр) нь ажил гүйлгээ тус бүрт тэнцлийн гадуурх дансанд толилуулна. Холбогдох деривативын бодит үнэ цэнийг санхүүгийн байдлын тайланд дериватив санхүүгийн хөрөнгө, дериватив санхүүгийн өр төлбөр болгон толилуулна. Деривативын бодит үнэ цэнд гарч буй өөрчлөлтийг орлогын тайланд хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Хөрөнгийг худалдах буюу худалдан авах дериватив гүйлгээ эхэлсэн өдөр банк тухайн гүйлгээнээс үүссэн авлага, өглөгийг тэнцлийн гадуурх дансанд орлогодоно.

Хэлцлийн хугацаа дуусч хэрэгжихэд эдгээр авлага, өглөгийг тэнцлийн гадуурх данснаас зарлагадна. Үүнтэй зэрэгцээд деривативын бодит үнэ цэнийг санхүүгийн байдлын тайлангаас зарлагадна. Дэлгэрэнгүй мэдээллийг “Дериватив санхүүгийн хөрөнгө” бүлэгт оруулсан.

8.5. ХАРИЛЦАГЧИЙН ӨМНӨӨС БАТЛАН ДААСАН ХӨРӨНГӨ

а. Тодорхойлолт

Энэ дансанд банкнаас үзүүлэх дараах үйлчилгээг бүртгэнэ:

- Үнэт цаасны хадгаламжийн үйлчилгээ (Кастодиан);
- Бусад үйлчилгээ.

Кастодиан банк буюу кастодиан нь аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санхүүгийн хөрөнгийг хадгалж, хамгаалах үүрэгтэй. Кастодианы үүрэг нь:

- Гадаад болон дотоод валют (бэлэн), үнэт металл зэрэг арилжааны бараа болон хувьцаа, бонд зэрэг үнэт цаас буюу хөрөнгийг найдвартай хадгалах
- Үнэт цаас, валютыг худалдан авах буюу зарж борлуулах арилжааны төлбөр тооцоог гүйцэтгэх
- Хөрөнгийн талаар мэдээлэл цуглуулах, тэдгээрээс орлого олох (ногдол ашиг, бондоос купон (хүүний төлбөр) авах) холбогдох нэмэлт үйлчилгээг үзүүлэх
- Бондыг зах зээлээс буцаан худалдан авах, тендерийн санал гаргах, компанийн нэгдэл үүсгэх, хувьцааг жижиглэн хуваах, хувьцааны ногдол ашиг тараах гэх мэт өөрийн эзэмшиж байгаа үнэт цаастай холбоотой арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл гэх мэт шаардлагатай мэдээллээр хангах
- Дансны гүйлгээг гүйцэтгэх болон бусад бэлэн мөнгөний гүйлгээг удирдах
- Гадаад валютын арилжааны гүйлгээг хийх
- Хамтын сан, хөрөнгө оруулалтын сан зэрэг тусгай хэрэглэгчдэд зориулан нэмэлт үйлчилгээ үзүүлэх

Бусад үйлчилгээнд хэрэглэгчийн өмнөөс үнэт цаасыг худалдан авах, борлуулахтай холбоотой брокерын үйлчилгээ андеррайтингийн үйлчилгээ гэх зэрэг үйлчилгээ багтана. Банк үнэт цаасны эзэмшигч биш (өөрөөр хэлбэл, харилцагчид үнэт цаасны жинхэнэ эзэмшигчид) хэдий ч шимтгэлийн орлого (ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрдөг) олохын тулд харилцагчийн өмнөөс ажил гүйлгээ, арилжааг гүйцэтгэнэ.

б. Хэмжилт ба үнэлгээ

Харилцагчийн өмнөөс батлан даасан хөрөнгийг өртөг болон нэгжийн тоо ширхгээр бүртгэнэ.

в. Бүртгэл

Банк кастодиан үйлчилгээний хүрээнд үнэт цаас авах бүрт энэ нь харилцагчийн нэрийн өмнөөс худалдан авсан үнэт цаасны төрлөөс шалтгаалж холбогдох дансдын үлдэгдэл дүнг өсгөнө.

Банк брокерын үйлчилгээ үзүүлэхээр хөрөнгө авах бүртээ хүлээн авсан хөрөнгийн төрлөөс хамаарч холбогдох дансдад тэнцлийн гадуурх зүйлс болгон бүртгэнэ.

Харилцагч эдгээр хөрөнгө/үнэт цаасыг банкнаас эргүүлэн татах хүсэлт гаргавал холбогдох дүнг тэнцлийн гадуурх данснаас зарлагадна.

8.6. БАРЬЦААНД ТАВЬСАН ХӨРӨНГӨ

а. Тодорхойлолт

Бусад банк, компаниас авсан санхүүжилтийн эх үүсвэрийн барьцаанд тавьсан хөрөнгийг энэ хэсэгт бүртгэнэ. Банк репо арилжаанд ашиглагдаж байгаа хөрөнгө болон бусад барьцаанд тавьсан өөрийн бүх хөрөнгийг тогтооно. Барьцаанд тавьсан хөрөнгийг төрлөөр (үл хөдлөх хөрөнгө, үнэт цаас гэх мэт) нь бүлэглэж, барьцаанд тавьсан хөрөнгийн холбогдох дансанд бүртгэнэ.

б. Хэмжилт ба үнэлгээ

Эдгээр хөрөнгийг харгалзах хөрөнгийн төрлөөс нь хамааруулан тэдгээрийн бодит үнэ эсвэл хорогдуулсан өртгөөр бүртгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд (гадаад валютаар илэрхийлэгдсэн үнэ цаас, борлуулахад бэлэн үнэт цаас болон арилжааны үнэ цаас, дахин үнэлгээний загварыг ашигласан үндсэн хөрөнгө гэх мэт) дахин үнэлнэ.

в. Бүртгэл

Банкны хөрөнгийн аль нэг хэсгийг гэрээний дагуу барьцаа болгон өгөх бүрт уг барьцааны дүнг барьцаанд тавьсан хөрөнгө гэж тэнцлийн гадуурх дансанд бүртгэнэ. Барьцааны гэрээний хугацаа нь дууссаны дараа банк барьцаанд тавьсан хөрөнгийн дүнг тэнцлийн гадуурх данснаас зарлагадна.

8.7. ТЭНЦЛИЙН ГАДУУРХ БУСАД ДАНСУУД

1. Гадаад худалдааны санхүүжилтэнд зориулан гадаадын банкуудад нээсэн шугам

Энэ дансанд худалдааны санхүүжилтийн зорилгоор гадаадын банкнаас хүлээн авсан хөрөнгө болон тэдэнд төлбөл зохих дүнг бүртгэнэ. Хүлээн авах мөнгөний дүнг бүртгэж шугам нээх нь зээлийг зөвшөөрөгдсөн хэмжээнд олгох ач холбогдолтой юм.

Банк худалдааны санхүүжилтийн зорилгоор гадаадын банкинд нээсэн зээлийн шугамаа өсгөх тухай бүр энэ дансыг өсгөж бүртгэнэ. Хэрэв гэрээний хугацаа дууссан эсвэл гэрээний харилцааг дуусгах шалтгаан болсон өөр бусад нөхцөл үүсвэл нийт дүнг тэнцлийн гадуурх данснаас зарлагадна.

Биржид бүртгэлтэй банкны зэрэглэл, үнэлгээ буурч байгаа эсэхийг байнга хянах ба буурсан тохиолдолд банкыг алдагдалд оруулахаас эсвэл үйл ажиллагаа муудахаас хамгаалах арга хэмжээ авна. Корреспондент банкны хэвлэн нийтэлсэн санхүүгийн тайланг ашиглан тухайн банкны санхүүгийн байдлыг хянана.

Зээлийн шугам буцаан үл дуудагдах нөхцөлтэй буюу өөрөөр хэлбэл банк төлбөр төлөхөөс татгалзах нөхцөлт бус эрхгүй байх (ийм төрлийн эрхийг ихэвчлэн зээлийн гэрээнд оруулдаг ба тухайлбал зээлдэгчийн санхүүгийн байдал хангалтгүй байгаатай холбоотойгоор зээл олгохоос банк татгалзаж болно) тохиолдолд харгалзах дүнг нь зээлд хамаарах үүрэгт бүртгэж, нөөц байгуулах шаардлагатай эсэхийг тогтооно.

2. Гадаадын банкуудад нээсэн бусад шугам

Уг данс нь худалдааны санхүүжилтээс бусад ажил гүйлгээнд зориулан гадаадын банкнаас хүлээн авах бусад шугамыг хамарна.

Банк худалдааны санхүүжилтээс бусад ажил гүйлгээнд зориулан банкинд нээсэн зээлийн шугамаа өсгөх тухай бүр өссөн дүнгээр бүртгэнэ. Хэрэв гэрээний хугацаа дууссан эсвэл гэрээний харилцааг дуусгах шалтгаан болсон өөр бусад нөхцөл үүсвэл нийт дүнг тэнцлийн гадуурх данснаас зарлагадна.

Биржид бүртгэлтэй банкны зэрэглэл, үнэлгээ буурч байгаа эсэхийг байнга хянах ба буурсан тохиолдолд банкны дээд удирдлага банкыг алдагдалд оруулах эрсдэлээс хамгаалах тодорхой арга хэмжээ авна. Корреспондент банкны хэвлэн нийтэлсэн санхүүгийн тайланг ашиглан тухайн банкны санхүүгийн байдлыг хянана.

3. Худалдааны санхүүжилтэнд зориулан дотоодын банкуудад нээсэн шугам

Энэ данс нь худалдааг санхүүжүүлэх ажил гүйлгээний хүрээнд дотоодын банкнаас хүлээн авах буюу тэдэнд төлөх мөнгөний хязгаарыг хамтад нь агуулдаг. Хүлээн авах мөнгөний дүнг бүртгэж шугам нээх нь зээлийг зөвшөөрөгдсөн хэмжээнд олгох ач холбогдолтой юм.

Банк худалдааны санхүүжилтийн зорилгоор банкинд нээсэн зээлийн шугамаа өсгөх тухай бүр өссөн дүнгээр бүртгэнэ. Хэрэв гэрээний хугацаа дуусан эсвэл гэрээний харилцааг дуусгах шалтгаан болсон өөр бусад нөхцөл үүсвэл нийт дүнг тэнцлийн гадуурх данснаас зарлагадна.

Биржид бүртгэлтэй банкны зэрэглэл, үнэлгээ буурч байгаа эсэхийг байнга хянах ба буурсан тохиолдолд банкны дээд удирдлага банкыг алдагдалд оруулах эрсдэлээс хамгаалах тодорхой арга хэмжээ авна. Корреспондент банкны хэвлэн нийтэлсэн санхүүгийн тайланг ашиглан тухайн банкны санхүүгийн байдлыг хянана.

4. Дотоодын банкуудад нээсэн бусад шугам

Энэ данс нь худалдааны санхүүжилтийн ажил гүйлгээнээс бусад ажил гүйлгээнд зориулан дотоодын банкнаас хүлээн авах буюу тэдэнд төлөх мөнгөний хязгаарын аль алиныг хамардаг. Хүлээн авах мөнгөний хязгаар тогтоох нь батлагдаагүй зээл олгогдохгүй байх ач холбогдолтой.

Банк худалдааны санхүүжилтийн бус зорилгоор банкинд нээсэн зээлийн шугамаа өсгөх тухай бүр өссөн дүнгээр бүртгэнэ. Хэрэв гэрээний хугацаа дуусан эсвэл гэрээний харилцааг дуусгах шалтгаан болсон өөр бусад нөхцөл үүсвэл нийт дүнг тэнцлийн гадуурх данснаас зарлагадна.

Биржид бүртгэлтэй банкны зэрэглэл, үнэлгээ буурч байгаа эсэхийг байнга хянах ба буурсан тохиолдолд банкны дээд удирдлага банкыг алдагдалд оруулах эрсдэлээс хамгаалах тодорхой арга хэмжээ авна. Корреспондент банкны хэвлэн нийтэлсэн санхүүгийн тайланг ашиглан тухайн банкны санхүүгийн байдлыг хянана.

5. Бусад компани, банкны өмнөөс удирдах хөрөнгө

Харилцагчийн өмнөөс банкны удирдаж буй хөрөнгийг энэ дансанд бүртгэнэ. Хөрөнгийг бусад компани/банк болон иргэдийн өмнөөс удирдаж байгаа үед тухайн хөрөнгийг хадгалан хамгаалж, удирдах чадвар, тусгай зөвшөөрөл зэргийг үндэслэнэ. Жишээлбэл, банк зээл олгоод, хэсэг хугацааны дараа зээлийг өөр компанид зарсан (факторинг). Банк зээлийн үйл ажиллагааг удирдаж болно (мөнгөн төлбөрийг хураах, нөгөө компанид хүргэх гэх мэт).

Зарим гэрээ хэрэгжүүлж буй банкийг удирдаж буй хөрөнгөөсөө үр ашиг хүртэхийг шаарддаг. Тухайн хөрөнгөтэй холбогдох банкны үүрэг, хариуцлагыг нарийн заасан тодорхой гэрээг байгуулна. Банк өөрийн удирдаж буй тухайн хөрөнгийн үр дүнг харилцагчид жилд нэгээс доошгүй удаа тайлагнана.

Банк ийнхүү хөрөнгийг удирдахтай холбоотой үүсэх эрсдэлийг хаах даатгалыг сайтар судалж үзнэ.

6. Хамтын зээлжүүлэлтийн оролцогч банкинд хамаарах зээл

Хамтын зээлжүүлэлтийн гэрээний дагуу удирдагч банк оролцогч банкны өмнөөс түүнд ноогдох зээлийг удирдаж байгаа үед энэ дансанд бүртгэнэ. Гэрээний хугацаа дуусгавар болсон эсвэл удирдагч банкны хүлээсэн үүрэг хүлээхээ болисон даруйд нийт дүнг энэ данснаас зарлагадна.

7. Эрсдэлийг шилжүүлж худалдсан зээл

Зээлийг гуравдагч талд борлуулсан боловч зээлийн гэрээ зөрчигдөх буюу төлбөр төлөгдөхгүй нөхцөлд банкинд буцаагдахгүй тохиолдолд тухайн зээлийг эрсдэлийг шилжүүлж худалдсан гэж ойлгоно. Худалдсан зээлийн багцаас төлбөр гаргуулах гэх мэт зарим эрсдэлийг авч үлдсэнээс бусад тохиолдолд зээлийг энэ дансанд бүртгэх бөгөөд тэнцлийн дотуурх данснаас хасна. Ингэхдээ НББОУС 39-ын үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангасан эсэхийг тогтоосон шинжилгээг үндэслэнэ.

Банк борлуулсан өрийн багцын талаар зээлийг худалдан авсан нөгөө талын аливаа асуултанд хариулахад бэлэн байх тул худалдан авсан нөгөө тал төлбөрийг хурааж дуусах, эсвэл хураах оролдлогоо зогсоох хүртэл холбогдох бүртгэл тооцоо, баримтуудыг хадгална.

Эдгээр гүйлгээтэй холбогдох төлбөр, хураамж, шимтгэлийг гарах бүрт үүссэн орлого, зардлыг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

8. Үүрэг хүлээлгүй баталсан баталгааны шугам

№	Үнэ цэн буурсан хөрөнгө	Хугацаа хэтрээгүй	30 хүртэлх хоногоор хугацаа хэтэрсэн	30-90 хоногоор хугацаа хэтэрсэн	91-180 хоногоор хугацаа хэтэрсэн	181-360 хоногоор хугацаа хэтэрсэн	360-аас дээш хоногоор хугацаа хэтэрсэн
1	Арилжааны үнэт цаас						
2	Борлуулахад бэлэн үнэт цаас						
3	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас						
4	Зээл ба авлага гэж ангилсан бусад үнэт цаас						
5	Хараат, хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт						
6	Барьцаанд байгаа үнэт цаас						
7	Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага						
8	Хасах нь: Эрсдэлийн сан						
9	**Дүн**						

Тэмдэглэл. (Хөрөнгө оруулалттай холбоотой тайлбар, тэмдэглэлийг хийнэ. Тухайлбал, хугацаа хэтэрсэн боловч үнэ цэн буураагүй хөрөнгө байгаа бол тодруулах ба хүлээж болзошгүй үүрэг, эрсдэлийн үнэлгээ, үнэ цэнийн бууралтыг тооцоолсон аргачлалыг тайлбарлана.)

……
……
……
……

6. ЗЭЭЛ

6.1. Олгосон зээлийн үлдэгдэл, түүнд гарсан өөрчлөлт

№	Үзүүлэлт	Бизнесийн зээл	Хэрэглээний зээл	Орон сууцны зээл	Бусад зээл	Нийт дүн
1	Эхний үлдэгдэл					
2	Нэмэгдсэн					
3	Хасагдсан (-)					
	Төлөгдсөн					
	Данснаас хассан					
4	Эцсийн үлдэгдэл					
5	Зээлийн хойшлогдсон төлбөр					
6	Нэмэх нь: Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага					
7	Хорогдуулсан өртөг					

6.2. Зээлийн барьцаа хөрөнгийн тодруулга

№	Төрөл	Бизнесийн зээл	Хэрэглээний зээл	Орон сууцны зээл	Бусад зээл	Нийт дүн
1	Баталгаагүй зээл					
2	Бусад банкны баталгаа бүхий зээл					
3	Гуравдагч талын баталгаа бүхий зээл					
4	Барьцаат зээл:					
5	- Орон сууц					
6	- Бусад үл хөдлөх хөрөнгө					
7	- Арилжааны үнэт цаас					
8	- Мөнгөн хадгаламж					
9	- Бусад хөрөнгө					
10	**Дүн**					

6.3. Зээлийн эрсдэлийн сангийн өөрчлөлт

№	Үзүүлэлт	Бизнесийн зээл	Хэрэглээний зээл	Орон сууцны зээл	Бусад зээл	Нийт дүн
1	Эхний үлдэгдэл					
2	Нэмж байгуулсан					
3	Хасагдсан (-)					
	Зээл төлөгдсөн					
	Сангаас хаасан					
	Бусад					
4	Эцсийн үлдэгдэл					

6.4. Зээлийн үнэ цэнийн бууралт

№	Үнэ цэн буурсан зээл	Хугацаа хэтрээгүй	30 хүртэлх хоногоор хугацаа хэтэрсэн	30-90 хоногоор хугацаа хэтэрсэн	91-180 хоногоор хугацаа хэтэрсэн	181-360 хоногоор хугацаа хэтэрсэн	360-аас дээш хоногоор хугацаа хэтэрсэн
1	Бизнесийн зээл						
2	Хэрэглээний зээл						
3	Орон сууцны зээл						
4	Бусад зээл						
5	Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага						
6	Хасах нь: Эрсдэлийн сан						
7	**Дүн**						

6.5. Зээлийн төвлөрөл

№	Зээлдэгч	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл	
		Дүн	Хувь (%)	Дүн	Хувь (%)
1	Засгийн газарт олгосон зээл				
2	Банк хоорондын захаар олгосон зээл				
3	Бусад санхүүгийн байгууллагад олгосон зээл				
4	Санхүүгийн бус байгууллагад олгосон зээл				
5	- Улсын байгууллага				
6	- Хувийн байгууллага				
7	Иргэдэд олгосон зээл				
8	Өрх гэр, иргэдэд үйлчлэгч ашгийн бус байгууллага (Улс төрийн нам, сүм хийд)-д олгосон зээл				
9	Эдийн засгийн харьяат бус (оршин суугч бус)				
11	**Дүн**				

Тэмдэглэл. (Зээлтэй холбоотой тайлбар, тэмдэглэлийг хийнэ. Тухайлбал, хугацаа хэтэрсэн боловч үнэ цэн буураагүй зээл байгаа бол тодруулах ба хүлээж болзошгүй үүрэг, эрсдэлийн үнэлгээ, үнэ цэнийн бууралтыг тооцоолсон аргачлал, томоохон зээлдэгчдийн зээл, холбоотой талд олгосон зээлийг тодруулна.)

.....

.....

.....

.....

7. ДЕРИВАТИВ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛ

№	Төрөл	Хөрөнгөөр хүлээн зөвшөөрсөн		Өр төлбөрөөр хүлээн зөвшөөрсөн		Орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Орлого	Зардал
1	Форвард арилжаа						
2	Своп арилжаа						
3	Опцион арилжаа						
4	Фьючерс арилжаа						
5	Бусад арилжаа						
6	**Дүн**						

Тэмдэглэл. (Дериватив санхүүгийн хэрэгсэл, хейджтэй холбоотой тайлбар, тэмдэглэлийг хийнэ. Тухайлбал, эрсдэлийн үнэлгээ, бодит үнэ цэн тооцоолсон аргачлалыг тодруулна.)

.....

.....

.....

.....

8. БУСАД САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

8.1 Бусдаас авах авлага

№	Үзүүлэлт	Бусдаас авах авлага	Авлагын эрсдэлийн сан	Бусдаас авах авлага (цэвэр дүнгээр)
1	Эхний үлдэгдэл			
2	Нэмэгдсэн			
3	Хасагдсан (-)			
	Төлөгдсөн			
	Данснаас хассан			
4	Эцсийн үлдэгдэл			

Тэмдэглэл. (Бусдаас авах авлагыг төлөгдөх хугацаандаа байгаа, хугацаа хэтэрсэн, төлөгдөх найдваргүй эсэх, авлагын эрсдэлийн сан байгуулсан аргачлал, гадаад валютаар илэрхийлэгдсэн авлага, зээлийн эрсдэлийн талаар болон бусад тайлбар тэмдэглэлийг хийнэ. Мөн хугацаа хэтэрсэн боловч үнэ цэн буураагүй хөрөнгө байгаа бол тодруулна)

.....

.....

.....

9. БУСАД САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ

9.1. Бусад тооцоо

№	Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Урьдчилгаа		
2	Зах зээлийн хүүгээс доогуур хүүтэйгээр ажилтнуудад олгосон зээлийн урьдчилгаа		
3	Улсын тэмдэгтийн хураамж		
4	Зээл барагдуулахтай холбоотой тооцоо		
5	Дараагийн тайлангийн тооцоо		
6	Бусад		
7	**Нийт дүн**		

9.2. Үнэт металл

№	Үзүүлэлт	Үнэт металлын төрөл			Үнэт металлын хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	Үнэт металлын эрсдэлийн сан	Цэвэр дүн
		Цэвэршүүлсэн алт	Цэвэршүүлсэн мөнгө	Бусад цэвэршүүлсэн металл			
1	Эхний үлдэгдэл						
2	Нэмэгдсэн дүн						
3	Хасагдсан дүн						
4	Эцсийн үлдэгдэл						

Тэмдэглэл. (Үнэт металлын өртгийг тодорхойлоход ашигласан арга, бараа материалын бүртгэлийн систем, өртөг болон цэвэр боломжит үнийн аль багыг сонгох аргын талаар тайлбар, тэмдэглэл хийнэ.)

.....

.....

.....

9.3. Татвар, нийгмийн даатгалын шимтгэл (НДШ)-ийн авлага

№	Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ААНОАТ-ын авлага		
2	НӨАТ-ын авлага		
3	НДШ-ийн авлага		
4	ХХОАТ-ийн авлага		
5	Бусад татварын тооцоо		
6	**Дүн**		

Тэмдэглэл. (Татвар, НДШ-ийн авлагатай холбоотой тайлбар, тэмдэглэлийг хийнэ.)

.....

.....

.....

10. ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГӨ

№	Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Өмчлөх бусад санхүүгийн хөрөнгө		
2	Өмчлөх бусад санхүүгийн хөрөнгийн эрсдэлийн сан		
3	Үл хөдлөх хөрөнгө		
4	Хөдлөх хөрөнгө		
5	Өмчлөх бусад санхүүгийн бус хөрөнгийн эрсдэлийн сан		
6	**Дүн**		

Тэмдэглэл. (Өмчлөх бусад хөрөнгөтэй холбоотой тайлбар, тэмдэглэлийг хийнэ.)

.....

.....

.....

11. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

№	Үзүүлэлт	Барилга байгууламж	Компьютер, дагалдах хэрэгсэл	Тээврийн хэрэгсэл	Тавилга эд хогшил	Дуусаагүй барилга	Үндсэн хөрөнгийн санхүүжилт (урьдчилгаа)	Түрээсийн хөрөнгө	Борлуулаад буцаан түрээсэлсэн хөрөнгө	Бусад үндсэн хөрөнгө	Нийт дүн
1	**ҮНДСЭН ХӨРӨНГӨ /өртөг/**										
1.1	Эхний үлдэгдэл										
1.2	*Нэмэгдсэн дүн*										
	Өөрөө бий болгосон										
	Худалдаж авсан										
	Үнэ төлбөргүй авсан										
	Дахин үнэлгээний нэмэгдэл										
1.3	*Хасагдсан дүн* (-)										
	Худалдсан										
	Үнэгүй шилжүүлсэн										
	Акталсан										
1.4	Үндсэн хөрөнгө дахин ангилсан										
1.5	Үндсэн хөрөнгө, ХОЗҮХХ* хооронд дахин ангилсан										
1.6	Эцсийн үлдэгдэл										
2	**ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ**										
2.1	Эхний үлдэгдэл										
2.2	Нэмэгдсэн дүн										
	Байгуулсан элэгдэл										
	Дахин үнэлгээгээр нэмэгдсэн										
	Үнэ цэнийн бууралтын буцаалт										
2.2	Хасагдсан дүн										
	Данснаас хассан хөрөнгийн элэгдэл										
	Дахин үнэлгээгээр хасагдсан										
	Үнэ цэнийн бууралт										
2.4	Эцсийн үлдэгдэл										
3	ДАНСНЫ ЦЭВЭР ДҮН										
3.1	Эхний үлдэгдэл										
3.2	Эцсийн үлдэгдэл										

Тэмдэглэл. (Үндсэн хөрөнгөтэй холбоотой тайлбар, тэмдэглэлийг хийнэ. Тухайлбал, хөрөнгийн өртгийг тооцох аргачлал, ашигласан элэгдлийн арга, элэгдүүлэх хувь хэмжээг хөрөнгийн ангилал бүрээр тодруулна. Хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг энд оруулна)

.....
.....
.....
.....

12. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗОРИУЛАЛТТАЙ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ

Тэмдэглэл. (Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хувьд ашигласан хэмжилтийн суурь: бодит үнэ цэнийн загвар ашигладаг бол бодит үнэ цэнийг тодорхойлоход ашигласан арга, бодит үнэ цэнийн тохируулгаас үүссэн олз, гарз; хэрэв түрээсэлдэг бол түрээсийн орлого, түрээсэлсэн хөрөнгөтэй холбоотой гарсан зардал; Хэрэв өртгийн загвар ашигладаг бол хөрөнгийн ашиглалтын хугацаа, элэгдэл тооцох арга болон НББОУС-40 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө-д заасны дагуу бусад тодруулгыг хийнэ.)

№	Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		

.....
.....
.....
.....

13. БОРЛУУЛАХ ЗОРИЛГООР ЭЗЭМШИЖ БУЙ ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ (ЭСВЭЛ БОРЛУУЛАХ БҮЛЭГ ХӨРӨНГӨ) БОЛОН ӨР ТӨЛБӨР

Тэмдэглэл. (Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө эсвэл борлуулах бүлэг хөрөнгө болон өр төлбөрийн тодорхойлолт, хэмжилтийн суурь, борлуулалт хийгдсэн аль эсвэл хийгдэхэд хүргэсэн нөхцөл байдал, борлуулах арга, хугацаа, хүлээн зөвшөөрсөн олз ба гарз болон бусад тайлбар, тэмдэглэлийг хийнэ.)

№	Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө		
2	Борлуулах зорилгоор эзэмшиж буй өр төлбөр		

.....
.....
.....
.....

14. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

№	Үзүүлэлт	Програм хангамж	Гүүдвил	Бусад биет бус хөрөнгө	Биет бус хөрөнгийн санхүүжилт (урьдчилгаа)	Нийт дүн
1	**Биет бус хөрөнгө /өртөг/**					
1.1	Эхний үлдэгдэл					
1.2	*Нэмэгдсэн дүн*					
	Өөрөө бий болгосон					
	Худалдаж авсан					
	Үнэ төлбөргүй авсан					
	Дахин үнэлгээний нэмэгдэл					
1.3	*Хасагдсан дүн (-)*					
	Худалдсан					
	Үнэгүй шилжүүлсэн					
	Акталсан					
1.4	Эцсийн үлдэгдэл					
2	**Хуримтлагдсан хорогдол**					
2.1	Эхний үлдэгдэл					
2.2	*Нэмэгдсэн дүн*					
	Байгуулсан хорогдол					
	Дахин үнэлгээгээр нэмэгдсэн					
	Үнэ цэнийн бууралтын буцаалт					
2.3	Хасагдсан дүн					
	Данснаас хассан хөрөнгийн хорогдол					
	Дахин үнэлгээгээр хасагдсан					
	Үнэ цэнийн бууралт					
2.4	Эцсийн үлдэгдэл					
3	**ДАНСНЫ ЦЭВЭР ДҮН**					
3.1	Эхний үлдэгдэл					
3.2	Эцсийн үлдэгдэл					

Тэмдэглэл. (Биет бус хөрөнгөтэй холбоотой тайлбар, тэмдэглэлийг хийнэ. Тухайлбал, хөрөнгийн өртгийг тооцох аргачлал, ашигласан хорогдуулах аргыг хөрөнгийн ангилал бүрээр тодруулна. Хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг энд оруулна)

.....
.....
.....
.....

15. ХАРИЛЦАГЧДЫН ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ

№	Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Харилцах дансны нэрлэсэн үлдэгдэл		
2	Харилцах дансанд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг		
3	Хугацаагүй хадгаламж		
4	Хугацаатай хадгаламж		
5	Бусад төрлийн хадгаламж		
6	Хадгаламжинд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг		
7	**Дүн**		

Тэмдэглэл. (Харилцагчдын харилцах, хадгаламжтай холбоотой тайлбар, тэмдэглэлийг хийнэ. Тухайлбал, харилцах, хадгаламжийн үлдэгдлийг валютаар болон хугацаагаар ангилан тодруулж болно)

.....

.....

.....

.....

16. БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС ТАТСАН ЭХ ҮҮСВЭР

№	Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан харилцах, хадгаламж		
2	Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл		
3	Төлөгдөх хугацаандаа байгаа зээл		
4	Хугацаа хэтэрсэн зээл		
5	Эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр		
6	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг		
7	**Дүн**		

Тэмдэглэл. (Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэртэй холбоотой тайлбар, тэмдэглэлийг хийнэ. Тухайлбал, валютын төрөл, зээлдүүлэгч банкаар тодруулж болно.)

.....

.....

.....

17. БУСАД ЭХ ҮҮСВЭР

№	Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Банкнаас гаргасан өрийн бичиг		
2	Банкнаас гаргасан үнэт цаас		
3	Төслийн зээлийн санхүүжилт		
4	Буцаан худалдан авах нөхцөлөөр худалдсан үнэт цаас (репо)		
5	Хамтын зээлжүүлэлтийн эх үүсвэр		
6	Бусад		
7	Бусад эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр		
8	Бусад эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг		
9	**Дүн**		

Тэмдэглэл. (Бусад эх үүсвэртэй холбоотой тайлбар, тэмдэглэлийг хийнэ. Тухайлбал, валютын төрөл, зээлдүүлэгч банкаар тодруулж болно. Санхүүгийн түрээстэй холбогдуулан гэрээний ерөнхий мэдээлэл, хугацаа, түрээсийн төлбөр, болзошгүй өр төлбөр, буцаан түрээсэлсэн эсэхийг тодруулна.)

.....

.....

.....

18. БУСАД САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР

18.1 Бусдад өгөх өглөг

№	Ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Дансны өглөг		
2	Төлөгдөх хугацаандаа байгаа		
3	Хугацаа хэтэрсэн		
4	Нийт дүн		

Тэмдэглэл. (Бусад санхүүгийн өр төлбөртэй холбоотой тайлбар, тэмдэглэлийг хийнэ.)

.....

.....

.....

19. БУСАД САНХҮҮГИЙН БУС ӨР ТӨЛБӨР

19.1 Татварын өглөг

№	Татварын өрийн төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	НӨАТ-ын тооцоо		
2	ААНОАТ тооцоо /ТТ-02 Нийтлэг/		
3	ХАОАТ-ын тооцоо /Суутган-1/		
4	ХАОАТ-ын тооцоо /Суутган-2/		
5	Бусад татварын тооцоо		
6	ААНОАТ өглөг /ТТ-13 Бусдаас суутгасан/		
7	**Нийт дүн**		

19.2 Богино хугацаат нөөц (өр төлбөр)

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан (ашигласан нөөц)	Ашиглаагүй буцаасан дүн	Эцсийн үлдэгдэл
1	Хуулийн байгууллагаар шийдэгдэж байгаа зүйлсэд байгуулсан нөөц					
2	Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөнд хамаарах үүргийн нөөц					
3						
4	**Нийт дүн**					

Тэмдэглэл. (Нөөцийн төрлөөр тайлбар, тэмдэглэл хийнэ)

.....

.....

.....

19.3 Бусад өглөг

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Цалингийн өглөг		
2	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг		
3	Хойшлогдсон татварын өглөг		
4	Нийгмийн хөгжлийн сан (өр төлбөр)		
5	Хойшлогдсон орлого		
6	Мөнгөөр төлөгдөх хувьцааны опцион		
7	Тэтгэврийн сан (өр төлбөр)		
8	Түрээсийн хойшлогдсон орлого		
9			
10	**Нийт дүн**		

Тэмдэглэл. (Гадаад валютаар илэрхийлэгдсэн өр төлбөрийн дүнг тусад тодруулна)

.....

.....

.....

20. ХОЁРДОГЧ ӨГЛӨГ

Тэмдэглэл. (Хоёрдогч өглөгтэй холбоотой тайлбар, тэмдэглэлийг хийнэ.)

.....

.....

.....

21. ӨӨРИЙН ХӨРӨНГӨ , ТҮҮНИЙ УДИРДЛАГА

21.1. Өмчийн хэлбэр

№	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Дүн (төг)	Эзлэх хувь (%)
1	Төрийн		
2	Хувийн		
3	Хувьцаат		
4	Дүн		

21.2. Хувь нийлүүлсэн хөрөнгө

№	Үзүүлэлт	Давуу эрхийн хувьцаа			Эргэлтэнд байгаа бүрэн төлөгдсөн энгийн хувьцаа			Өмчийн цэвэр дүн (төгрөгөөр)
		Тоо ширхэг	Нэгжийн нэрлэсэн үнэ	Дүн (төг)	Тоо ширхэг	Нэгжийн нэрлэсэн үнэ	Дүн (төг)	
1	Эхний үлдэгдэл							
2	Нэмэгдсэн							
3	Хасагдсан (-)							
4	Эцсийн үлдэгдэл							

Тэмдэглэл. (Хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаатай холбоотой тайлбар, тэмдэглэлийг хийнэ. Тухайлбал, халаасны хувьцааг нэмж авсан, эргүүлэн гаргасан бол энэ талаар тодруулна.)

.....

.....

.....

21.3. Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл

№	Үзүүлэлт	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний нэмэгдэл	Нийт дүн
1	Эхний үлдэгдэл				
2	Нэмэгдсэн дүн				
	Дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү				
	Дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзын буцаалт **				
3	Хасагдсан дүн /-/				
	Дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү				
	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
	Дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз***				
4	Эцсийн үлдэгдэл				

**- Дахин үнэлсэн хөрөнгийн өмнөх тайлант хугацаанд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзын дүнгээс хэтэрсэн дүн

***- Дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз нь тухайн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн дүнгээс хэтрэхгүй хэмжээ хүртэл байхаар дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзыг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрнө. Үлдсэн дүнг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Тэмдэглэл. (Хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой тайлбар, тэмдэглэлийг хийнэ.)

.....

.....

.....

.....

21.4. Эрсдэлийн сангийн нөөц

№	Үзүүлэлт	Үнэт цаас	Зээл	Бусад	Нийт дүн
1	Эхний үлдэгдэл				
2	Нэмэгдсэн дүн				
	Нэмж байгуулсан эрсдэлийн сангийн нөөц				
3	Хасагдсан дүн /-/				
	Эрсдэлийн сангийн нөөцийн буцаалт				
	Эрсдэлийн сангийн нөөцийн хэрэгжсэн дүн				
4	Эцсийн үлдэгдэл				

Тэмдэглэл. (Бусад өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүн тус бүрээр тодруулж тайлбар, тэмдэглэлийг хийнэ)

.....

.....

.....

.....

21.6. Өөрийн хөрөнгийн удирдлага

№	Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	**Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө:**		
2	Хувь нийлүүлсэн хөрөнгө - Энгийн хувьцаа		
3	Нэмж төлөгдсөн капитал - Энгийн хувьцаа		
4	Халаасны хувьцаа		
5	Хуримтлагдсан ашиг (алдагдал)		
6	**Дүн**		
7	**Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө:**		
8	Хувь нийлүүлсэн хөрөнгө - Давуу эрхийн хувьцаа		
9	Нэмж төлөгдсөн капитал - Давуу эрхийн хувьцаа		
10	Дахин үнэлгээний нэмэгдэл		
11	Бусад өөрийн хөрөнгө		
12	Хоёрдогч өглөг		
13	**Дүн**		
14	**Өөрийн хөрөнгийн нийт дүн**		
15	**Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт:**		
16	Өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа		
17	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа		
18	Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа		

21.7. Эрсдэлээр жигнэсэн активын задаргаа

№	Активыг жигнэх эрсдэлийн хувь хэмжээ	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл	
		Хөрөнгө	Эрсдэлээр жигнэсэн актив	Хөрөнгө	Эрсдэлээр жигнэсэн актив
1	0%				
2	20%				
3	50%				
4	70%				
5	100%				
6	150%				
7	**Дүн**				

Тэмдэглэл. (Өөрийн хөрөнгийн удирдлагын талаарх тайлбар, тэмдэглэлийг хийнэ)

.....

.....

.....

.....

22. ХҮҮГИЙН ОРЛОГО

Тэмдэглэл. (Хүүгийн орлогыг тооцоолоход ашигласан үр ашигт хүүгийн түвшин, бусад тайлбар, тэмдэглэлийг тодруулна)

.....

.....

.....

.....

23. ХҮҮГИЙН ЗАРДАЛ

Тэмдэглэл. (Хүүгийн зардлыг тооцоолоход ашигласан үр ашигт хүүгийн түвшин, бусад тайлбар, тэмдэглэлийг тодруулна)

.....

.....

.....

.....

24. ЭРСДЭЛИЙН САНГИЙН ЗАРДАЛ

№	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
1	Банк, санхүүгийн байгуулагуудад байршуулсан хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал		
2	Үнэт цаасны эрсдэлийн сангийн зардал		
3	Зээлийн эрсдэлийн сангийн зардал		
4	Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал		
5	Үнэт металлын эрсдэлийн сангийн зардал		
6	Бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал (Авлагын эрсдэлийн сангийн зардал гэх мэт)		
7	**Дүн**		

25. АРИЛЖААНЫ ЦЭВЭР ОРЛОГО, ЗАРДАЛ

№	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
1	Гадаад валютын арилжааны цэвэр орлого, зардал		
2	Үнэт цаасны арилжааны цэвэр орлого, зардал		
3	Үнэт металлын арилжааны цэвэр орлого, зардал		
4	Бусад арилжааны цэвэр орлого, зардал		
5	**Дүн**		

26. ХАНШ, ҮНЭЛГЭЭНИЙ ТЭГШИТГЭЛИЙН ЦЭВЭР ОРЛОГО, ЗАРДАЛ

№	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
1	Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн цэвэр орлого, зардал		
2	Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн цэвэр орлого, зардал		
3	Деривативын бодит үнэ цэнийн үнэлгээний тэгшитгэлийн цэвэр орлого, зардал		
4	Үнэт металлын үнэлгээний тэгшитгэлийн цэвэр орлого, зардал		
5	Бусад үнэлгээний тэгшитгэлийн цэвэр орлого, зардал		
6	**Дүн**		

27. БАНКНЫ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖ, ШИМТГЭЛИЙН ЦЭВЭР ОРЛОГО

Тэмдэглэл. (Банкны бүтээгдэхүүн үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого, зардлын төрөл тус бүрээр тайлбар, тэмдэглэл хийнэ)

.....

.....

.....

.....

28. БУСАД ОРЛОГО, ОЛЗ (ГАРЗ), АШИГ (АЛДАГДАЛ)

№	Орлогын төрөл	Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
1	Хөрөнгө данснаас хассаны олз		
2	Борлуулсан буюу дамжуулан түрээсэлсэн хөрөнгийн олз		
3	Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийн дахин үнэлгээний олз		
4	Түрээсийн орлого		
5	Торгуулийн орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Тэнцлийн гадуурх данснаас орсон орлого		
8	Хараат компани, хамтын хяналттай компанийн ашгаас хуваарилсан орлого		
9	Хөрөнгийг зах зээлийн түвшнээс өндөр хувь хэмжээгээр анх удаад хүлээн зөвшөөрсний орлого		
10	Өр төлбөрийг зах зээлийн түвшнээс бага хувь хэмжээгээр анх удаад хүлээн зөвшөөрсний орлого		
11	Тусламжийн орлого		
12	Бусад		
13	**Нийт дүн**		

Тэмдэглэл. (Бусад орлого, олзтой холбоотой тайлбар, тэмдэглэл хийнэ)

.....

.....

.....

.....

29. УДИРДЛАГА БА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ЗАРДАЛ

29.1 Борлуулалт маркетингийн болон ерөнхий удирдлагын зардлууд

№	Зардлын төрөл	Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
1	Ажилтнуудтай холбоотой зардал		
2	Сургалт		
3	Зээл болон бусад авлагыг барагдуулахтай холбоотой зардал		
4	Өмчлөх бусад хөрөнгийн урсгал зардал		
5	Мэргэжлийн үйлчилгээний хураамж		
6	Зарлал, сурталчилгаа, маркетингийн зардал		
7	Элэгдэл, хорогдлын зардал		
8	Түрээсийн зардал		
9	Ашиглалтын зардал		
10	Үндсэн хөрөнгийн урсгал засвар, борлуулах үйл ажиллагааны зардал		
11	Програм хангамж, автоматжуулалтын урсгал зардал		
12	Бичиг хэргийн зардал		
13	Харуул, аюулгүй байдлын зардал		
14	Харилцаа холбооны зардал		
15	Түлш шатахуун, тээврийн зардал		
16	Мөнгө хураалтын зардал		
17	Албан томилолт		
18	Ариун цэвэр		
19	Газар эдэлбэр		
20	Үл хөдлөх хөрөнгийн татвар		
21	Төлсөн эрхийн шимтгэл		
22	Данснаас хассан зээл ба авлага		
23	Данснаас хассан өмчлөх бусад хөрөнгө		
24	Үйл ажиллагааны бусад зардал		
25	**Нийт дүн**		

29.2 Бусад зардал, гарз

№	Зардлын төрөл	Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
1	Хөрөнгө данснаас хассаны гарз		
2	Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийн дахин үнэлгээний гарз		
3	Зочин төлөөлөгч, баяр ёслолын зардал		
4	Хандив		
5	Торгууль		
6	Хараат компани, хамтын хяналттай компанийн алдагдлаас хуваарилсан зардал		
7	Хөрөнгийг зах зээлийн түвшнээс доогуур хувиар анх удаа хүлээн зөвшөөрөх үеийн зардал		
8	Өр төлбөрийг зах зээлийн түвшнээс дээгүүр хувиар анх удаа хүлээн зөвшөөрөх үеийн зардал		
9	Зээлд хамаарах үүрэг ба хуулийн байгууллагаар шийдэгдэж байгаа зүйлсэд байгуулсан нөөцийн зардал		
10	Бусад		
11	**Нийт дүн**		

Тэмдэглэл. (Бусад зардал, гарзтой холбоотой тайлбар, тэмдэглэл хийнэ. Тухайлбал, ажилтнуудын тоо, цалингийн зардал, бусад холбогдох тодруулгыг хийнэ.)

.....
.....
.....
.....

30. ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ

№	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
1	Тайлангийн үеийн орлогын татварын зардал		
2	Хойшлогдсон татварын зардал /орлого/		
3	Орлогын татварын зардал /орлого/ -ын нийт дүн		

Тэмдэглэл. (Орлогын татварын зардал /орлого/-ын бүрэлдэхүүн тус бүрээр тайлбар, тэмдэглэл хийнэ.)

.....
.....
.....
.....

31. ХОЛБООТОЙ ТАЛУУДТАЙ ХИЙСЭН АЖИЛ ГҮЙЛГЭЭ

31.1 Толгой компани, хамгийн дээд хяналт тавигч компани, хувь хүний талаарх мэдээлэл****

Үзүүлэлт	Толгой компани	Хамгийн дээд хяналт тавигч толгой компани	Хамгийн дээд хяналт тавигч хувь хүн	Тайлбар
Нэр				
Бүртгэгдсэн /оршин суугаа/ улс				
Эзэмшлийн хувь				

****- НББОУС- 24 Холбоотой талуудын тодруулга-д заасны дагуу тодруулна.

31.2 Тэргүүлэх удирдлагын бүрэлдэхүүнд олгосон нөхөн олговрын тухай мэдээлэл
Тэргүүлэх удирдлага гэдэгт .....

№	Нөхөн олговорын нэр	Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
1	Богино болон урт хугацааны тэтгэмж		
2	Ажил эрхлэлтийн дараах, ажлаас халагдсаны тэтгэмж		
3	Хувьцаанд суурилсан төлбөр		
4	**Нийт дүн**		

*****- Тэргүүлэх удирдлагад ямар бүрэлдэхүүнийг хамруулснаа тодруулна. Тухайлбал, захирлуудын зөвлөл, удирдах зөвлөлийн гишүүд гэх мэт.

31.3 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ

№	Холбоотой талын нэр	Ажил гүйлгээний утга	Дүн	Тайлбар
1				
2				

32. БОЛЗОШГҮЙ ХӨРӨНГӨ БА ӨР ТӨЛБӨР

Тэмдэглэл. (Болзошгүй хөрөнгө ба өр төлбөрийн мөн чанар, хэрэв практик боломжтой бол тэдгээрийн санхүүгийн нөлөөллийн тооцооллыг тодруулна.)

.....
.....
.....
.....

33. ТАЙЛАГНАЛЫН ҮЕИЙН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

Тэмдэглэл. (Тайлагналын өдрийн дараах үл залруулагдах үйл явдлын материаллаг ангилал тус бүрийн хувьд мөн чанар, санхүүгийн нөлөөллийн тооцоолол зэргийг тодруулж бусад тайлбар, тэмдэглэл хийнэ.)

.....
.....
.....
.....

34. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Тайлант хугацаанд хийгдсэн хөрөнгө оруулалт (төгрөгөөр)										Эцсийн үлдэгдэл
			Аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгөөр	Улсын төсвийн хөрөнгөөр	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Банк, санхүүгийн байгууллагаас татсан зээлийн эх үүсвэрээр	Гадаадын шууд хөрөнгө оруулалт	Гадаадын зээл	Гадаадын буцалтгүй тусламж	Төсөл хөтөлбөр хандив	Бусад эх үүсвэр	Дүн	
1	**Биет хөрөнгө**												
1.1	Газрын сайжруулалт												
1.2	Барилга байгууламж												
1.2.1	Үүнээс: Орон сууцны барилга												
1.2.2	Авто зам												
1.3	Машин, тоног төхөөрөмж												
1.4	Тээврийн хэрэгсэл												
1.5	Тавилга эд хогшил												
1.6	Компьютер, бусад хөрөнгө												
1.7	Биологийн хөрөнгө												
1.8	Бусад биет хөрөнгө												
1.9	Үүнээс: ХОЗҮХХ												
1.1.0	**Биет хөрөнгийн дүн**												
2	**Биет бус хөрөнгө**												
2.1	Зохиогчийн эрх												
2.2	Компьютер, программ хангамж												
2.2.1	Үүнээс: Прогром хангамж												
2.2.2	Мэдээллийн сан												
2.3	Патент												
2.4	Барааны тэмдэг												
2.5	Тусгай зөвшөөрөл												
2.6	Газар эзэмших эрх												
2.7	Бусад биет хөрөнгө												
2.7.1	Үүнээс: Зураг төсвийн ажил,ТЭЗҮ боловсруулах туршилт судалгаа												
2.8	**Биет бус хөрөнгийн дүн**												
3	Хайгуул үнэлгээний хөрөнгө												
3.1	Үүнээс: Биет хөрөнгө												
3.2	Биет бус хөрөнгө												
4	**Нийт хөрөнгө**												

ХОЗҮХХ-Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

35. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Тэмдэглэл. (Эрсдэлийн удирдлага, зохион байгуулалт, эрсдэлийг үнэлж, хэмжиж, хянан, тайлагнах тогтолцооны талаар товч тайлбар хийнэ.)

.....
.....
.....
.....
.....

35.1. Валютын эрсдэлийн тодруулга

№	Төрөл	Эхний үлдэгдэл				Эцсийн үлдэгдэл			
		Санхүүгийн хөрөнгө	Санхүүгийн өр төлбөр	Дериватив	Цэвэр позиц	Санхүүгийн хөрөнгө	Санхүүгийн өр төлбөр	Дериватив	Цэвэр позиц
1	Төгрөг								
2	Ам. Доллар								
3	Юань								
4	Евро								
5	Фунтстерлинг								
6									
	Дүн								

35.2. Валютын ханшийн өөрчлөлтийн мэдрэмтгий байдал

№	Төрөл	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл	
		Ашиг, алдагдалд үзүүлэх нөлөөлөл	Өөрийн хөрөнгөнд үзүүлэх нөлөөлөл	Ашиг, алдагдалд үзүүлэх нөлөөлөл	Өөрийн хөрөнгөнд үзүүлэх нөлөөлөл
1	Ам доллар 20%-иар чангарсан				
2	Ам доллар 20%-иар суларсан				
3	Юань 20%-иар чангарсан				
4	Юань 20%-иар суларсан				
5	Евро 20%-иар чангарсан				
6	Евро 20%-иар суларсан				
7	Бусад валют 20%-иар чангарсан				
8	Бусад валют 20%-иар суларсан				
9	**Дүн**				

35.3. Хүүгийн түвшний эрсдэлийн тодруулга

№	Үзүүлэлт	Хугацаагүй ба 3 сар хүртэлх хугацаатай	3 - 6 сарын хугацаатай	6 -12 сарын хугацаатай	1 жилээс дээш хугацаатай	Мөнгөн бус	Нийт дүн
1	**ӨМНӨХ ОН:**						
2	Нийт санхүүгийн хөрөнгө						
3	Нийт санхүүгийн өр төлбөр						
4	**Цэвэр хүүгийн дүн**						
5	**ТАЙЛАНТ ОН:**						
6	Нийт санхүүгийн хөрөнгө						
7	Нийт санхүүгийн өр төлбөр						
8	**Цэвэр хүүгийн дүн**						

Тэмдэглэл. (Зах зээлийн эрсдэлтэй холбоотой тайлбар, тэмдэглэлийг хийнэ.)

.....
.....
.....
.....
.....

35.4. Эргэн төлөгдөх хугацааны шинжилгээ

№	Үзүүлэлт	Хугацаагүй ба 3 сар хүртэлх хугацаатай	3 - 6 сарын хугацаатай	6 -12 сарын хугацаатай	1 жилээс дээш хугацаатай	Мөнгөн бус	Нийт дүн
1	**ӨМНӨХ ОН:**						
2	Нийт санхүүгийн хөрөнгө						
3	Нийт санхүүгийн өр төлбөр						
4	**Санхүүгийн хэрэгслийн хөрвөх чадварын зөрүү**						
5	**ТАЙЛАНТ ОН:**						
6	Нийт санхүүгийн хөрөнгө						
7	Нийт санхүүгийн өр төлбөр						
8	**Санхүүгийн хэрэгслийн хөрвөх чадварын зөрүү**						

Тэмдэглэл. (Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлтэй холбоотой тайлбар, тэмдэглэлийг хийнэ.)

.....

.....

.....

.....

.....

36. БОДИТ ҮНЭ ЦЭНИЙН ТОДРУУЛГА

36.1. Хорогдуулсан өртгөөр илэрхийлсэн санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнийн тодруулга

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл	
		Дансны үнэ	Бодит үнэ цэн	Дансны үнэ	Бодит үнэ цэн
1	**САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ**				
2	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө				
3	Хөрөнгө оруулалт				
4	- Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө				
5	- Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас				
6	- Зээл ба авлага гэж ангилсан бусад үнэт цаас				
7	Зээл				
8	Дериватив санхүүгийн хөрөнгө				
9	Бусад санхүүгийн хөрөнгө				
10	**Хорогдуулсан өртгөөр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгийн дүн**				
11	**САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР**				
12	Харилцагчийн харилцах, хадгаламж				
13	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр				
14	Бусад эх үүсвэр				
15	Бусад санхүүгийн өр төлбөр				
16	Хоёрдогч өглөг				
17	**Хорогдуулсан өртгөөр илэрхийлсэн санхүүгийн өр төлбөрийн дүн**				

36.2. Бодит үнэ цэнээр илэрхийлсэн санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнийн шатлал

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл			Эцсийн үлдэгдэл		
		Идэвхтэй зах зээлийн жишиг үнэ (Нэгдүгээр түвшин)	Зах зээлийн мэдээллийг ашиглан үнэлгээний аргачлалаар гаргасан дүн (Хоёрдугаар түвшин)	Зах зээлийн мэдээлэл олдоогүй үед үнэлгээний аргачлалаар гаргасан дүн (Гуравдугаар түвшин)	Идэвхтэй зах зээлийн жишиг үнэ (Нэгдүгээр түвшин)	Зах зээлийн мэдээллийг ашиглан үнэлгээний аргачлалаар гаргасан дүн (Хоёрдугаар түвшин)	Зах зээлийн мэдээлэл олдоогүй үед үнэлгээний аргачлалаар гаргасан дүн (Гуравдугаар түвшин)
1	**САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ**						
2	Хөрөнгө оруулалт						
3	- Арилжааны үнэт цаас						
4	- Борлуулахад бэлэн үнэт цаас						
5	Дериватив санхүүгийн хөрөнгө						
6	Бусад санхүүгийн хөрөнгө						
7	**Бодит үнэ цэнээр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгийн дүн**						
8	**САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР**						
9	Дериватив санхүүгийн өр төлбөр						
10	Бусад санхүүгийн өр төлбөр						
11	**Бодит үнэ цэнээр илэрхийлсэн санхүүгийн өр төлбөрийн дүн**						

36.3. Бодит үнэ цэнийн шатлалын гуравдугаар түвшинд хамаарах хэрэгслүүдийн өөрчлөлт, хөдөлгөөний нэгтгэл

№	Үзүүлэлт	Арилжааны үнэт цаас		Борлуулахад бэлэн үнэт цаас		Дериватив санхүүгийн хөрөнгө	Дериватив санхүүгийн өр төлбөр
		Өрийн хэрэгсэл	Өмчийн хэрэгсэл	Өрийн хэрэгсэл	Өмчийн хэрэгсэл		
1	**20... оны 1 дүгээр сарын 1-ээрх бодит үнэ цэн**						
2	Тайлант жилийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн орлого, зардал						
3	Бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрсөн орлого, зардал						
4	Худалдан авсан						
5	Нэмж гаргасан						
6	Худалдсан						
7	Эргүүлэн төлсөн						
8	Гуравдугаар түвшнээс шилжүүлсэн						
9	Гуравдугаар түвшинд шилжүүлсэн						
10	**20... оны 12 дугаар сарын 31-ээрх бодит үнэ цэн**						

Тэмдэглэл. (Бодит үнэ цэнэтэй холбоотой тайлбар, тэмдэглэлийг хийнэ.)

.....
.....
.....
.....
.....

37. ТЭНЦЛИЙН ГАДУУРХ ДАНСД

	Тэнцлийн гадуурх дансд	Өмнөх үеийн дүн	Тайлант үеийн дүн
1	Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөнд хамаарах үүрэг (цэвэр дүн)		
2	Барьцаа хөрөнгө		
3	Тэнцлээс хассан хөрөнгө		
4	Дериватив санхүүгийн хэрэгсэл		
5	Харилцагчийн өмнөөс батлан даасан хөрөнгө		
6	Барьцаанд тавьсан хөрөнгө		
7	Тэнцлийн гадуурх бусад дансууд		

Тэмдэглэл. (Тэнцлийн гадуурх дансдтай холбоотой тайлбар, тэмдэглэлийг хийнэ.)

.....
.....
.....
.....
.....

Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын
2017 оны 11 дүгээр сарын 21-ны өдрийн А/294/340
тоот хамтарсан тушаалын дөрөвдүгээр
хавсралт

БАНКНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТОДРУУЛГА БЭЛТГЭХ АРГАЧЛАЛ

НЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1.1. Банкны нийтлэг зориулалттай иж бүрэн санхүүгийн тайланг бэлтгэхэд энэ аргачлалыг мөрдөнө.

Санхүүгийн тайлан, түүний зорилго

1.2. Санхүүгийн тайлан нь банкны санхүүгийн тайлан ба санхүүгийн үр дүнг тодорхой бүтцээр илэрхийлэх санхүүгийн цэгцтэй ерөнхий мэдээлэл юм.

1.3. Санхүүгийн тайлангийн зорилго нь хэрэглэгчдийг эдийн засгийн шийдвэр гаргахад шаардагдах тухайн банкны санхүүгийн байдал (хөрөнгө, өр төлбөр, өөрийн хөрөнгө), санхүүгийн үр дүн (ашиг, алдагдал), санхүүгийн байдалд гарсан өөрчлөлт (мөнгөн гүйлгээ), өмчийн өөрчлөлтийн тухай мэдээллээр хангахад оршино.

1.4. Банкны удирдлага өөрийн банкны санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, түүнд хариуцлага хүлээнэ.

Санхүүгийн тайлан бэлтгэх үндэслэл ба зарчим

Банк нь санхүүгийн тайлан бэлтгэхдээ дараах ерөнхий зарчмуудыг баримтална:

1.5. *СТОУС-д нийцэх*. Банкны санхүүгийн тайлан нь СТОУС-д бүрэн нийцсэн байна.

1.6. *Нягтлан бодох бүртгэлийн бодлого*. Банкны удирдлага өөрийн бодит нөхцөлд ялангуяа банкныхаа санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнг үнэн зөвөөр илэрхийлэх бүртгэлийн бодлогыг мөрдөнө. Сонгосон бүртгэлийн бодлого нь Монгол улсын хууль, тогтоомж, Монголбанкнаас гаргасан журам, заавар, аргачлалд нийцнэ. Банк нягтлан бодох бүртгэлийн тодорхойлогдоогүй зүйлсийг Монголбанкинд мэдэгдэж, зөвшөөрөл авна.

1.7. *Үнэн зөв толилуулга*. Санхүүгийн тайланд банкны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлнэ. Үнэн зөв толилуулгад дан ганц тоогоор илэрхийлэгдсэн мэдээлэл төдийгүй нэмэлт тайлбар, тодруулгыг багтаана.

1.8. *Тасралтгүй байх зарчим*. Банкны удирдлага санхүүгийн тайланг бэлтгэхдээ өөрийн банкны үйл ажиллагааны тасралтгүй зарчмаар үргэлжлэх чадварт үнэлэлт өгнө. Банкийг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоогоогүй тохиолдолд удирдлага тасралтгүй байх зарчмыг үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэнэ. Мөн банкны үйл ажиллагааг тасалдуулахад хүргэх үйл явдал, нөхцөл байдал үүссэн бол банкны удирдлага нэн даруй Монголбанкинд мэдэгдэнэ.

Банкны удирдлага тасралтгүй байх зарчим хадгалагдаж буй эсэхийг үнэлэхдээ тайлагналын өдрөөс хойш арван хоёр сар буюу түүнээс дээш хугацааг хамарсан ирээдүйн талаарх боломжит бүх мэдээллийг ашиглана. Банк ашигтай ажиллаж байсан түүхтэй бөгөөд санхүүгийн нөөцийг байршуулахад бэлэн байгаа бол нэмэлт шинжилгээ хийлгүйгээр тасралтгүй байх зарчим биелэгдэж байна гэж үзэж болно.

1.9. *Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь*. Банк мөнгөн гүйлгээний тайлангаас бусад санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьяр бэлтгэнэ. Аккруэл суурь гэж мөнгө хүлээн авсан эсвэл төлсөн эсэхээс үл хамааран орлогыг олсон үед болон зардлыг гарсан тухай бүрт нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг хэлнэ.

1.10. *Илэрхийллийн тогтвортой байдал*. Банкны үйл ажиллагаанд гарсан үлэмж хэмжээний өөрчлөлт болон СТОУС-д шаардсанаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн илэрхийлэл ба ангиллыг нэг тайлант үеэс нөгөө тайлант үед өөрчлөхгүй.

Хэрэв ийм өөрчлөлт хийхээр төлөвлөж буй бол үүнийг Монголбанкинд урьдчилан мэдэгдэнэ.

1.11. *Цэвэр дүнгээр толилуулах*. Энэ заавар болон СТОУС-д шаардсан буюу зөвшөөрснөөс бусад тохиолдолд хөрөнгө ба өр төлбөр болон орлого ба зардлыг нэгтгэж цэвэр дүнгээр тайлагнахгүй.

1.12. *Харьцуулах боломжтой байх зарчим*. Энэ заавар болон СТОУС-ын шаардлагаар банкны санхүүгийн тайлангийн тоон мэдээллийг арга зүйн хувьд бүх тайлант хугацааны тоо мэдээтэй харьцуулж болохоор зохион байгуулна. Санхүүгийн тайланд зэрэгцүүлэх зорилгоор оруулж байгаа өмнөх хугацааны дүнг тайлант хугацааныхтай яг ижил хугацаагаар тасалбар болгон харуулна. Тухайлбал, орлогын дэлгэрэнгүй тайланг 6 дугаар сарын 30-ны өдрөөр бэлтгэж байгаа тохиолдолд толилуулах дүн нь тайлант ба өмнөх хугацааны аль алиных нь хувьд оны эхнээс (1 дүгээр сарын 1-ний өдөр) 6 дугаар сарын 30-ны (тайлагналын өдөр) хоорондох хугацаагаар тасалбар болно.

1.13. *Цаг хугацаандаа байх зарчим*. Санхүүгийн тайланг цаг хугацаанд нь багтаан бэлтгэж, толилуулах нь мэдээллийг хэрэглэгчдийн шийдвэрт нөлөөлөх боломжтой хугацаанд багтаан шийдвэр гаргагчдад хүргэхийг хэлнэ. Банкны үйл ажиллагааны онцгой хүндрэлтэй байдал зэрэг нь санхүүгийн тайланг цаг хугацаанд нь тайлагнахгүй байх шалтгаан болохгүй.

Санхүүгийн тайлангийн бүтэц ба агуулга

1.14. Банкны иж бүрэн санхүүгийн тайлан доорх бүрэлдэхүүн хэсэгтэй байна:

(а) Санхүүгийн байдлын тайлан;
(б) Орлогын дэлгэрэнгүй тайлан:
(в) Өмчийн өөрчлөлтийн тайлан;
(г) Мөнгөн гүйлгээний тайлан;
(д) Санхүүгийн тайлангийн тодруулга.

1.15. Банкны тайлан, тодруулгын үзүүлэлтийг төгрөг, мөнгөөр илэрхийлнэ.

1.16. Иж бүрэн санхүүгийн тайлан гэж санхүүгийн тайлангийн тодруулгыг багтаасан тайланг хэлэх ба үүнийг жилээр толилуулна. Санхүүгийн тайлангийн жил 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно. Банк сарын санхүүгийн тайлангаа заагдсан хугацаанд багтаан, тогтсон хэлбэр, загвараар Монголбанкинд хүргүүлнэ.

ХОЁР. НЭГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1. Санхүүгийн тайлангийн нэгтгэлд холбогдох СТОУС-ыг дагаж мөрдөнө.

2.2. Банк, банкны толгой компани, тэдгээрийн хараат болон охин компани нэгдсэн буюу тусдаа тайланг Монголбанкинд гаргаж өгнө.

2.3. Банк охин компанид хяналт тогтоосон өдрөөс эхлэн нэгдсэн санхүүгийн тайлан бэлтгэх бөгөөд охин компанид тогтоосон хяналтаа алдсан өдрөөс нэгдсэн санхүүгийн тайлан бэлтгэж Монголбанкинд гаргаж өгөхөө зогсооно.

ГУРАВ. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

3.1. Банкны санхүүгийн байдлыг тодорхой хугацаагаар буюу тайлагналын өдрөөр тасалбар болгон харуулдаг тайлан нь санхүүгийн байдлын тайлан юм.

3.2. Санхүүгийн байдлыг хөрөнгө, өр төлбөр, өөрийн хөрөнгөөр харуулна.

(а) Хөрөнгө гэдэг нь банкны хяналтанд байгаа бөгөөд өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүсч, ирээдүйд эдийн засгийн үр өгөөж өгөх нөөц юм.

(б) Өр төлбөр гэдэг нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд бий болсон, эдийн засгийн өгөөжийг өөртөө агуулж буй нөөцийн гадагшлах урсгалаар төлөгдөхөөр хүлээгдэж буй банкны бусдын өмнө хүлээх үүрэг хариуцлагыг хэлнэ.

(в) Өөрийн хөрөнгө гэдэг нь банкны хөрөнгөөс өр төлбөрийг хассаны дараа үлдэх хэсэг юм.

3.3. Банк санхүүгийн байдлын тайландаа хөрөнгө ба өр төлбөрийг шинж чанар, хөрвөх чадвараар жагсааж, толилуулна.

3.4. Хөрөнгө, өр төлбөр, өөрийн хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд зохих үнэлгээгээр илэрхийлж, нийт дүнгээр толилуулна. Хөрөнгө ба өглөгийн дүнг суутган тооцсон, эсвэл ингэж тооцохыг СТОУС ба хууль тогтоомжоор зөвшөөрсөнөөс бусад тохиолдолд балансад тусгасан аливаа хөрөнгө, өр төлбөрийн дүнг нэгийг нь нөгөөгөөс нь хасч тооцохгүй.

3.5. Санхүүгийн байдлын тайланг (СТ-1) загварын дагуу бэлтгэнэ. СТОУС-д нийцүүлэн бэлтгэх жилийн санхүүгийн тайланг зэрэгцүүлсэн байдлаар толилуулна. Өөрөөр хэлбэл тайлант хугацааны үзүүлэлтийг нэг баганаар, зэрэгцүүлэгдэх хугацааны үзүүлэлтийг өөр баганаар тайлагнана. СТ-1 хэлбэрээр тайлагнасан банкны 12 дугаар сарын тайлан ба аудитын дүгнэлт санал бүхий жилийн эцсийн тайлангийн хооронд зөрүү гарсан бол энэ талаар Монголбанкинд мэдэгдэж, тайлбар гаргаж өгнө.

3.6. Санхүүгийн байдлын зүйлсийг тайлант жилийн эхнээс өссөн дүнгээр гаргах ба эхний үлдэгдэл нь тухайн тайлант санхүүгийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөрх үлдэгдэл байна.

Санхүүгийн байдлын зүйлс

3.7. Хөрөнгийн дараах зүйлсийг тусад нь толилуулна:

(а) Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө - үнэ цэнийн өөрчлөлтөөс өчүүхэн бага эрсдэл хүлээдэг бөгөөд 3 хүртэлх сарын дотор төлөгдөх мөнгөн дүнд хөрвөх чадвартай хөрөнгийг хэлнэ. 3 сараас урт хугацаагаар хязгаарлагдсан мөнгийг мөнгөн хөрөнгөд оруулахгүй. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд бэлэн мөнгө (касст байгаа үндэсний ба гадаад валютын мөнгөн тэмдэгт, зоос, гадаад валютын чек) -нөөс гадна 3 хүртэлх сарын хугацаатай бөгөөд үнэ цэн буурах эрсдэл багатай Монголбанкинд байршуулсан мөнгө, Монголбанкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цаас, бусад банкинд байршуулсан мөнгө зэрэг багтана. Үүнд: Монголбанкинд байршуулсан төгрөгийн ба гадаад валютын харилцах, хадгаламж; гадаад, дотоодын бусад банкинд байршуулсан төгрөгийн ба гадаад валютын харилцах, хадгаламж; 3 хүртэлх сарын хугацаатай Монголбанкны үнэт цаас ба Засгийн газрын үнэт цаас; мөнгөтэй адилтгах бусад хөрөнгө; эдгээр хөрөнгөнд хуримтлуулан тооцсон хүүг оруулна.

(б) Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө - Монголбанкинд байршуулж буй заавал байлгах нөөц, Монголбанк болон бусад гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, 3 сараас дээш хугацаатай репо, 3 сараас урт хугацаагаар хязгаарлагдсан мөнгө, эдгээр хөрөнгөнд хуримтлуулан тооцсон хүүг мөн оруулна. Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийг эрсдэлийн сан хассан цэвэр дүнгээр тайлагнана.

(в) Хөрөнгө оруулалт - 3 сараас дээш хугацаатай Монголбанкны үнэт цаас, 3 сараас дээш хугацаатай Засгийн газрын үнэт цаас, мөнгөтэй адилтгах хөрөнгийн тодорхойлолтонд багтаагүй бусад өрийн үнэт цаас, арилжааны зориулалттай эсвэл борлуулахад бэлэн, охин компани, хараат компани, хамтын хяналттай компанид оруулсан хөрөнгө оруулалт хамрагдана. Хөрөнгө оруулалтыг эрсдэлийн сан хассан цэвэр дүнгээр тайлагнана. Барьцаанд тавьсан үнэт цаас, хөрөнгө оруулалт гэж репо болон бусад хэлцэлд барьцаа болгон өгсөн үнэт цаасыг ойлгоно. Үүнд эдгээр хөрөнгөтэй холбогдуулан хуримтлуулан тооцсон хүүг мөн оруулна.

(г) Зээл - Банкны зээлийн шинж чанарыг агуулсан, байгууллага, иргэд болон бусад журмын дагуу чанараар нь ангилж харуулна. Зээлийн дүнг зээлийн эрсдэлийн сан ба хойшлогдсон зээлийн төлбөрийг (СТОУС-ын дагуу хойшлуулан бүртгэх, үр ашигт ашигт хүүгийн хувь хэмжээнд багтах зээлийн хураамж, шимтгэл) хассан цэвэр дүнгээр тайлагнана. Эдгээр зүйлсийг тусдаа дансдад бүртгэнэ. Үүнд эдгээр хөрөнгөтэй холбогдуулан хуримтлуулан тооцсон хүүг мөн оруулна.

(д) Дериватив санхүүгийн хөрөнгө - Гадаад валют, үнэт металлын арилжааны своп, форвард, опцион гэрээ, хэлцлээр үүссэн дериватив санхүүгийн хэрэгслийн эерэг утгатай бодит үнэ цэнийг харуулна.

(е) Бусад санхүүгийн хөрөнгө – банкны үйл ажиллагааны хувьд туслах чанартай бөгөөд нийт хөрөнгийн дүнд бага хувь хэмжээтэй, санхүүгийн хөрөнгийн тодорхойлолтыг хангаж буй хөрөнгүүд болох зээлээс бусад тооцооны авлага, банк болон салбар хоорондын тооцоо, өмчлөх бусад хөрөнгө (зээлдэгчээс зээлийн төлбөрт авсан үнэт цаас гэх мэт санхүүгийн хөрөнгө), бусад санхүүгийн хөрөнгийг хамруулна.

(ё) Бусад санхүүгийн бус хөрөнгө - Банкны үйл ажиллагааны хувьд туслах чанарын бөгөөд нийт хөрөнгийн дүнд бага хувь хэмжээтэй, санхүүгийн хөрөнгийн тодорхойлолтыг хангахгүй хөрөнгүүд болох материал, үнэ бүхий зүйлс, үнэт металл, банкны дотоод ажил гүйлгээгээр гарах тооцооны авлага, урьдчилгаа, санхүүгийн бус хөрөнгийн хэлбэртэй өмчлөх бусад хөрөнгө, тайлант хугацааны татварын илүү төлөлт, хойшлогдсон татварын хөрөнгийг хамруулна. Өмчлөх бусад хөрөнгөнд зээлдэгчдээс зээлийн төлбөрт авсан, цаашид худалдан борлуулах зориулалттай хөдлөх ба үл хөдлөх хөрөнгө багтана.

(ж) Үндсэн хөрөнгө - Банкны үйл ажиллагаа, удирдлагын зорилгоор ашиглаж буй барилга байгууламж, компьютер, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил зэргийг хамарна.

(з) Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө - Үүнд ашгийн бус зориулалтаар бусдад түрээслүүлэх болон хөрөнгийн үнийн өсөлтөөс ашиг олох зорилгоор эзэмшиж буй, банкны үйл ажиллагаа, удирдлагын зорилгоор ашиглагдаагүй хөрөнгийг харуулна. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөнд ирээдүйд ашиглагдах дуусаагүй барилга багтана.

(и) Борлуулах зориулалттай хөрөнгө - тайлагналын өдрөөс хойш 12 сарын дотор худалдан борлуулах замаар өртгийг нь нөхөх зорилготой үндсэн хөрөнгө, бусад санхүүгийн бус буюу эргэлтийн хөрөнгийг хамарна. Энэ төрлийн хөрөнгө нь түүнд харгалзах СТОУС-ын шалгуурыг биелүүлсэн байх ба өөрөөр хэлбэл одоогийн нөхцөл байдлаар нь шууд худалдан борлуулах боломжтой, тохиромжтой үнээр идэвхитэй арилжаалагддаг, эргэлт буцалтгүйгээр худалдан борлуулахаар зорьж байгаа хөрөнгө юм.

(й) Биет бус хөрөнгө - Нэгээс дээш жилийн хугацаанд ашиглах банкны үйл ажиллагаа, удирдлагын зориулалтаар ашиглаж буй биет шинж чанаргүй программ хангамж, гүүдвил болон бусад биет бус хөрөнгүүд хамрагдана.

3.8. Өр төлбөрийн дараах зүйлсийг тусад нь толилуулна:

(а) Харилцах - Байгууллага, иргэдээс банкинд төлбөр тооцооны зориулалтай байршуулсан бөгөөд ямар нэг хязгаарлалтгүй эх үүсвэр хамрагдана. Үүнд харилцах дансанд хуримтлуулан тооцсон хүүг мөн оруулна.

(б) Хадгаламж - Байгууллага, иргэдээс банкинд хүү болон бусад нөхцөлтэй гэрээгээр байршуулсан эх үүсвэр хамрагдана. Хадгаламжийг хугацаатай, хугацаагүйгээр ангилж харуулна. Үүнд хадгаламжийн дансанд хуримтлуулан тооцсон хүүг мөн оруулна.

(в) Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр - Монголбанк бусад банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, бусад банк, санхүүгийн байгууллагаас тухайн банкинд байршуулсан харилцах, хадгаламжийн данс, банк санхүүгийн байгууллагаас татсан бусад эх үүсвэр хамрагдана. Үүнд уг эх үүсвэрт хуримтлуулан тооцсон хүүг мөн оруулна.

(г) Бусад эх үүсвэр - Харилцагчид, банкнаас бусад зээлдүүлэгчдээс тодорхой зориулалт, нөхцөлтэй байршуулсан эх үүсвэр болон төлбөр тооцооны бусад хэрэгслийн эх үүсвэр болгон ашиглахаар байршуулсан зээлдүүлэгчээс авсан эх үүсвэр, зээл, баталгаа, батлан даалтын барьцаа, аккредитивын эх үүсвэр, банкны гаргасан өрийн бичиг, үнэт цаас, репо нөхцлөөр худалдсан үнэт цаас, хамтын зээлжүүлэлтийн эх үүсвэр багтана. Мөн хөрвөх эрхтэй зээлийн өр төлбөр болох хэсгийг энд харуулна. Үүнд уг эх үүсвэрт хуримтлуулан тооцсон хүүг мөн оруулна.

(д) Дериватив санхүүгийн өр төлбөр - Гадаад валют, үнэт металлын арилжааны своп, форвард, опцион гэрээ, хэлцлээр үүссэн дериватив санхүүгийн хэрэгслийн сөрөг утгатай бодит үнэ цэнийг харуулна.

(е) Бусад санхүүгийн өр төлбөр - Банкны үйл ажиллагааны хувьд туслах чанартай бөгөөд нийт өр төлбөрийн дүнд бага хувь хэмжээтэй, санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангаж буй өр төлбөр ба үүнд дансны өглөг, банкны дотоод ажил гүйлгээгээр гарах тооцооны өглөг, ногдол ашгийн өглөг, банк хоорондын клирингийн тооцооны өглөг болон бусад санхүүгийн өглөг хамрагдана.

(ё) Бусад санхүүгийн бус өр төлбөр - Банкны үйл ажиллагааны хувьд туслах чанартай бөгөөд нийт өр төлбөрийн дүнд бага хувь хэмжээтэй, санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангахгүй өр төлбөр ба үүнд ажилчидтай хийх тооцооны өглөг, хойшлогдсон буцалтгүй тусламжийн орлого гэх мэт хойшлогдсон орлого, тайлант үеийн ба хойшлогдсон татварын өглөг, татварын бусад өглөг, хуулийн байгууллагаар шийдэгдэж байгуу зүйлсэд байгуулсан нөөц, зээл, зээлтэй адилтгах хөрөнгөнд хамаарах үүргийн нөөц зэрэг хамрагдана.

(ж) Хоёрдогч өглөг - 5 жилээс дээш хугацаатай хоёрдогч өглөгийг өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг тооцохдоо өөрийн хөрөнгөнд оруулах боловч энэ нь өр төлбөрийн шинжийг хадгалсан хэвээр байдаг тул үүнийг санхүүгийн тайланд өр төлбөрөөр толилуулна.

(з) Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр) - НББОУС 32-д заасны дагуу өр төлбөр гэж үзэх давуу эрхийн хувьцааг өр төлбөрөөр толилуулна.

3.9. Өөрийн хөрөнгийн дараах зүйлсийг тусад нь толилуулна:

(а) Хувь нийлүүлсэн хөрөнгө - Банкны хувь нийлүүлсэн хөрөнгө, давуу эрхтэй хувьцаа (НББОУС 32-ын дагуу өмчийн шалгуурыг хангасан), энгийн хувьцааг нэрлэсэн үнээр илэрхийлж, толилуулна.

(б) Нэмж төлөгдсөн капитал - Хувьцааны борлуулсан үнэ нэрлэсэн үнээс илүү гарсан бол зөрүүг тусгах ба халаасны хувьцааг нэрлэсэн үнээс илүү үнээр худалдаж авсан нөхцөлд үүнийг бууруулна.

(в) Халаасны хувьцаа – Банк гаргасан хувьцаагаа өөрөө зах зээл дээрээс эсвэл хувьцаа эзэмшигчдээс шууд эргүүлэн худалдан авсан хувьцааг харуулна.

(г) Дахин үнэлгээний нэмэгдэл - Дахин үнэлгээний үр дүнд үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн өртөгт гарсан нэмэгдлийг өмчийн энэ хэсэгт тусгана. Мөн борлуулахад бэлэн үнэт цаасны бодит үнэ цэнийн өөрчлөлтийг холбогдох дахин үнэлгээний дансанд бүртгэнэ.

(д) Хуримтлагдсан ашиг, алдагдал - Банкны үйл ажиллагааны үр дүнгээс бий болсон өмнөх ба тайлант үеийн хуримтлагдсан ашиг хамрагдана.

(е) Бусад өөрийн хөрөнгө – Хувьцааны опцион, нөөцийн сан, ханш, үнэлгээний тэгшитгэлийн сан, эрсдэлийн сангийн нөөц гэх мэт хуримтлагдсан ашгаас тусгай зориулалтаар тусгаарласан сан, нөөц болон тайлант үеийн бусад дэлгэрэнгүй орлого хамрагдана. Мөн үүнд зээлийн эрсдэлийн сангийн нөөц болон төлөгдөөгүй зээлд хуримтлуулсан хүүгийн эрсдэлийн сангийн нөөц багтана.

ДӨРӨВ. ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

4.1. Орлогын дэлгэрэнгүй тайлан нь банкны тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүнг хэмждэг тайлан юм. Орлогын дэлгэрэнгүй тайланд орлого, зардлыг аккруэл суурьяр бүртгэж, толилуулна.

4.2. Үйл ажиллагааны үр дүнг хэмжихтэй холбогдох элемэнтүүд нь орлого, зардал, олз, гарз болно.

(а) Орлого гэдэг нь тайлант хугацаанд хөрөнгийг өсгөх буюу өр төлбөрийг бууруулах замаар эдийн засгийн үр өгөөж нэмэгдэхийг хэлнэ. Орлогын дүнг найдвартайгаар хэмжих боломжтой тохиолдолд орлогын тайланд орлого болон олзыг хүлээн зөвшөөрнө. Найдвартай хэмжих боломжгүй бол бүртгэхгүй.

(б) Зардал гэдэг нь тайлант хугацаанд хөрөнгийг бууруулах буюу өр төлбөрийг өсгөх замаар эдийн засгийн үр өгөөж буурахыг хэлнэ. Зардлын дүнг найдвартайгаар хэмжих

боломжтой тохиолдолд орлогын тайланд зардал болон гарзыг хүлээн зөвшөөрнө. Найдвартай хэмжих боломжгүй бол бүртгэхгүй.

4.3. Зардлыг холбогдох орлоготой уялдуулан орлогын тайланд хүлээн зөвшөөрөх ба үүнийг орлого, зардлыг уялдуулах зарчим гэнэ. Ингэж орлого, зардлыг уялдуулснаар аливаа зүйл эсвэл ажил гүйлгээний орлого, зардлыг хамтад нь тайлагнаж, үр дүнг нь тодорхойлон гаргах ач холбогдолтой. Гэхдээ СТОУС-ын дагуу уялдуулах зарчмыг мөрдөхдөө хөрөнгө, өр төлбөрийн тодорхойлолтонд нийцэхгүй зүйлсийг балансанд хүлээн зөвшөөрч, харуулахгүй.

4.4. Орлогын дэлгэрэнгүй тайланг (СТ-2) загварын дагуу бэлтгэнэ. Орлогын дэлгэрэнгүй тайлангийн үзүүлэлтүүдийг дүнгээр үзүүлэх ба орлого, зардлын бус шинжтэй зүйлийг орлогын тайланд тусгахгүй. Өмнөх хугацааны дүнг тайлант хугацааныхтай яг ижил хугацаагаар тасалбар болгон харуулна. Тухайлбал, орлогын дэлгэрэнгүй тайланг 6 дугаар сарын 30-аар бэлтгэж байгаа тохиолдолд толилуулах дүн нь тайлант ба өмнөх хугацааны аль алиных нь хувьд оны эхнээс (1 дүгээр сарын 1-ний өдөр) 6 дугаар сарын 30-ны (тайлагналын өдөр) хоорондох хугацаагаар тасалбар болно.

4.5. Банк орлого, зардлыг үндсэн төрлөөр ангилан орлогын дэлгэрэнгүй тайлан бэлтгэж, тодруулна.

Орлого, зардлын зүйлс

4.6. Банк нь СТОУС бусад стандартуудын шаардлагыг хангах үүднээс орлогын тайлангийн доор дурдсан орлого ба зардлын үзүүлэлтийг эдгээр ангиллаар хязгаарлахгүйгээр оруулна.

(а) Хүүгийн орлого - Банкны үйл ажиллагаанаас буй болох орлогын үндсэн төрөлд хүүгийн орлого орох ба үүнд зээлийн хүү болон санхүүгийн зах зээлд хөрөнгө байршуулснаас орох бусад хүү, түүнтэй адилтгах орлого хамрагдана. Тухайлбал, Монголбанк, бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн хүүгийн орлого, үнэт металл, үнэт цаас, зээлийн хүүгийн орлого үүнд багтана. Хүүгийн орлого нь хүүгийн нийт орлогоос буцаалтыг хассан дүнтэй тэнцэнэ.

(б) Хүүгийн зардал - Банкны үйл ажиллагаанаас буй болох зардлын үндсэн төрөлд хүүгийн зардал орох ба үүнд харилцах, хадгаламжинд төлсөн хүү, санхүүгийн зах зээлээс авч байршуулсан бусад эх үүсвэрт төлөх хүүгийн болон тэдгээртэй адилтгах зардал хамрагдана. Тухайлбал: харилцахын үлдэгдэл, хадгаламжинд төлсөн (ба хуримтлуулсан) хүү, үнэт цаасны хүү, зээлийн хүүгийн зардал үүнд багтана. Хүүгийн зардал нь хүүгийн нийт зардлаас буцаалтыг хассан дүнтэй тэнцэнэ.

(в) Хүүгийн цэвэр орлого - Хүүгийн орлогоос хүүгийн зардлыг хассан дүнгээр цэвэр хүүгийн орлого тодорхойлогдоно. Хүүгийн цэвэр орлого нь банкны удирдлага, санхүүгийн тайлангийн хэрэглэгчид тайлант хугацааны дундаж хүү, зээлдүүлсэн хөрөнгөөс олсон дундаж хүүгийн орлого, зээлийн эх үүсвэрт ноогдох дундаж хүү гэх мэт хүүгийн хувь хэмжээг тооцоход ашиглагдана.

(г) Бусад орлого - Банкны үйл ажиллагаанаас орох хүүгийн орлогоос бусад бүх орлого хамрагдана. Үүнд: гадаад валют, үнэт металл, үнэт цаасны арилжааны орлого; гадаад валют, үнэт металл, үнэт цаасны ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого; санхүүгийн деривативын орлого; банкны бүтээгдэхүүн болох картын үйлчилгээ, дансны үйлчилгээ гэх зэрэг үйлчилгээний шимтгэл болон бусад орлого багтана. Бусад орлогод хөрөнгө борлуулсны олз, үндсэн хөрөнгийн түрээсийн орлого, торгуулийн орлого, ногдол ашгийн орлого, тэнцлийн гадуурх тооцооноос хийгдсэн төлөлт, зах зээлийн хүүгээс ялгаатай хүү бүхий хөрөнгө, өр төлбөрийг анх удаа хүлээн зөвшөөрөх үеийн олз, буцалтгүй тусламжийн орлого болон бусад орлогыг хамарна.

(д) Бусад зардал - Банкны үйл ажиллагаатай холбогдон гарсан боловч хүүгийн зардалд хамрагдаагүй бусад зардлуудыг энэ хэсэгт үзүүлнэ. Ажилтнуудтай холбоотой зардалд цалин, шагнал урамшуулал, нөхөн олговор, хөнгөлөлт, тэтгэмж, нийгмийн, халамж, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал багтана. Бусад зардалд мөн дараах зардлууд хамрагдана: зээл болон бусад авлагыг барагдуулахтай холбоотой зардал; өмчлөх бусад хөрөнгийн урсгал зардал; бусад банкаар үйлчлүүлсний хөлс, аудитын төлбөр, мэргэжлийн үйлчилгээний төлбөр, санхүүгийн хураамж, даатгалын хураамж, хуулийн зөвлөгөө авах, өмгөөллийн үйлчилгээний хөлс гэх мэт янз бүрийн үйлчилгээний төлбөр,

хураамж, шимтгэлийн зардал; зар сурталчилгаа, маркетингийн зардал; элэгдэл, хорогдлын зардал; түрээсийн зардал; цахилгаан, халаалт дулаан, ус гэх мэт ашиглалтын зардал; үндсэн хөрөнгийн урсгал засвар болон түүнийг борлуулах үйл ажиллагааны зардал; программ хангамж, автоматжуулалтын урсгал зардал; бичиг хэргийн зардал; харуул, аюулгүй байдлын зардал; харилцаа холбооны зардал; мөнгө хураалтын зардал багтана. Харин дээр дурьдсанаас бусад зардал буюу ариун цэвэр, газар эдэлбэр, зочин төлөөлөгч, баяр ёслол, хандив, торгууль зэрэгтэй холбоотой зардал ба хөрөнгө борлуулсан буюу данснаас хассаны гарз, авлага болон өмчлөх бусад хөрөнгийг данснаас хасах үеийн гарз, зээлд хамаарах үүрэг болон болзошгүй үйл явдалтай (шүүхийн зарга маргаан гэх мэт) холбоотойгоор нөөц байгуулах зардал гэх зэрэг зардлууд бусад зардалд хамаарна.

(е) Орлогын татварын зардал – тайлант хугацааны татвар ногдуулах орлогыг тодорхойлж, түүнд ногдуулж тооцсон татварын зардал (хөнгөлөлт)-ыг энэ хэсэгт тусгана.

(ё) Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал – СТОУС 5-ын дагуу зогсоосон үйл ажиллагаа гэж тодорхойлсон үйл ажиллагааны үр дүнд үүссэн орлого, зардлыг энэ хэсэгт тусгана.

(ж) Бусад дэлгэрэнгүй орлого – тайлант хугацааны цэвэр ашигт хамаарахгүй боловч эзэмшигчийн бус ажил гүйлгээгээр үүссэн хэрэгжээгүй орлого, зардал буюу үнэлгээний санд гарсан хэрэгжээгүй орлого, зардлыг харуулна. Татвар ногдуулах бүх орлого, зардалд хойшлогдсон татварыг хуримтлуулан бүртгэнэ.

(з) Нийт дэлгэрэнгүй орлого – тайлант хугацаанд эзэмшигчийн бус ажил гүйлгээгээр цэвэр хөрөнгөнд гарсан нийт өсөлт, бууралтыг дараах хоёр үзүүлэлтээр төлөөлж харуулна: цэвэр ашиг, алдагдлын дүн (орлогын тайланд тодорхойлогдоно) ба бусад дэлгэрэнгүй орлого.

ТАВ. ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

5.1. Өмчийн өөрчлөлтийн тайлан нь банкны цэвэр хөрөнгө буюу эзэмшигчийн өмчийн хөдөлгөөнийг харуулдаг тайлан юм.

5.2. Өмчийн өөрчлөлтийн тайланд дараах зүйлсийг толилуулна:

(а) тайлант хугацааны цэвэр ашиг, алдагдал;

(б) хувьцаат капиталтай холбогдуулан шууд бүртгэсэн орлого, зардал, олз, гарз, холбогдох дансдын дүн;

(в) нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулгын хуримтлагдсан нөлөөлөл;

(г) эзэмшигчидтэй хийсэн өмчийн ажил гүйлгээ, тэдгээрийг эзэмшигчдэд хуваарилсан байдал;

(д) тайлант хугацааны эхэнд болон санхүүгийн тайлагналын өдрөөрх хуримтлагдсан ашиг, алдагдлын үлдэгдэл, мөн хугацаанд гарсан өөрчлөлт;

(е) тайлант хугацааны эх болон эцэс дэх эзэмшигчийн өмчийн ангилал тус бүрийн дансны үнэ, нэмж төлөгдсөн капитал, сангуудын тохируулга, өөрчлөлт.

5.3. Өмчийн өөрчлөлтийн тайланг СТ-3 загвараар бэлтгэнэ.

5.4. Өөрийн хөрөнгийн тайлант үеийн эхний үлдэгдлийг өмчийн ангилал бүрийн хувьд өмнөх үеийн эцсийн үлдэгдлээр тусгана.

5.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, үндсэн алдааны залруулгыг хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдлийг залруулах замаар тохируулж, залруулагдсан эхний үлдэгдлийг тодорхойлно.

5.6. Дараах зүйлсийн хөдөлгөөнийг тусад нь харуулна:

(а) Хувь нийлүүлсэн хөрөнгө - Хувьцаагаар ногдол ашиг хуваарилах замаар нэмэгдсэн өөрчлөлтийг (өөрөөр хэлбэл хувьцаагаар ногдол ашиг хуваарилах) хувьцаат капиталын

өсөлтөөр илэрхийлнэ. Хувьцаа халаасалсан болон бусад хэлбэрийн бууралтыг хувьцаат капиталын бууралт байдлаар илэрхийлнэ.

(б) Нэмж төлөгдсөн капитал - Хувьцааг нэрлэсэн үнээс илүү үнээр гаргасан үед үүсэх зөрүү нь нэмж төлөгдсөн капиталын өсөлт болох ба эсрэгээр нэмж төлөгдсөн капитал буурна.

(в) Дахин үнэлгээний нэмэгдэл - Үндсэн хөрөнгө болон борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт, бууралтыг өмчийн өөрчлөлтийн энэ хэсэгт тусгана.

(г) Хуримтлагдсан ашиг - Өмнөх үеийн хуримтлагдсан ашгийн үлдэгдэл дээр тайлангийн үеийн цэвэр ашгийг нэмж, алдагдлын шинжтэй тохируулах бичилт болон ногдол ашгийг хасч тооцон, тайлангийн үеийн хуримтлагдсан ашиг (алдагдал)-ын эцсийн үлдэгдлийг тодорхойлно. Мөн түүнчлэн тайлант үед илэрсэн, өмнөх тайлант жилүүдэд харгалзах алдааны залруулгыг хуримтлагдсан ашиг данс руу хааж харуулна.

(д) Бусад өөрийн хөрөнгө – хандивын капитал, хуримтлагдсан ашгаас байгуулсан тусгай зориулалтын нөөц, сангуудын хөдөлгөөнийг харуулна.

5.7. Нийт өмчийн эхний үлдэгдэл дээр нийт нэмэгдсэн өөрчлөлтийн дүнг нэмж, нийт хасагдсан өөрчлөлтийн дүнгээр бууруулж, өмчийн эцсийн үлдэгдлийг тодорхойлно.

ЗУРГАА. МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

6.1. Тайлант хугацааны мөнгөн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг мөнгөн гүйлгээний тайланд үзүүлнэ. Мөнгөн гүйлгээний тайлан нь санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийг бий болгох тухайн байгууллагын чадвар, эдгээр мөнгөн гүйлгээг ашиглах хэрэгцээг үнэлэх үндэс болдог.

6.2. Мөнгөн гүйлгээний тайланг СТ-4 загвараар бэлтгэнэ. Зэрэгцүүлэх зорилгоор оруулж байгаа өмнөх хугацааны дүнг тайлант хугацааныхтай яг ижил хугацаагаар тасалбар болгон харуулна.

6.3. Мөнгөн гүйлгээний тайланг шууд бус аргаар бэлтгэнэ.

6.4. Мөнгөн гүйлгээний тайлан нь дор дурдсан хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

(а) Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ
(б) Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ
(в) Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ
(г) Мөнгөн хөрөнгийн цэвэр өсөлт (бууралт)

Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

6.5. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ нь тухайн банкны өр төлбөр төлөх, үйл ажиллагааны чадавхийг тогтоон барих, ногдол ашиг төлөх ба гадны санхүүжилтийн эх үүсвэрийн тусламжгүйгээр шинэ хөрөнгө оруулалт хийхэд хангалттай хүрэлцэх мөнгө бий эсэхийг илэрхийлдэг гол үзүүлэлт юм.

6.6. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг тайлант үеийн цэвэр ашиг, алдагдлыг доор заасан байдлаар тохируулах замаар тодорхойлно.

- Зээл ба бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал, зээлд хамаарах үүрэг ба болзошгүй өр төлбөрт байгуулсан нөөцөд зориулсан зардлыг нэмнэ.
- Элэгдэл, хорогдлын зардлыг нэмнэ.
- Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөөс бусад хөрөнгийн ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлогыг хасч, зардлыг нэмнэ.
- Орлогын тайланд хүлээн зөвшөөрч, хуримтлуулан тооцсон хүүгийн орлогыг хасч, хүүгийн зардлыг нэмнэ.
- Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, борлуулах зориулалттай хөрөнгө худалдасны олзыг хасч, гарзыг нэмнэ.
- Татварын өмнөх ашгийг тохируулах бусад тохируулгыг нэмэх буюу хасна (тухайлбал, орлогын тайланд шилжүүлсэн, үндсэн хөрөнгө ба хөрөнгө оруулалтын зориулалттай үл

хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний орлого, зардал, ханшийн тэгшитгэлийн хэрэгжээгүй орлого, зардал, арилжааны үнэт цаасны үнэлгээний орлого, зардал, санхүүгийн деривативын бодит үнэ цэнийн өөрчлөлт, хувьцаанд суурилсан төлбөрт хамаарах зардал гэх мэт).

- Зээлийн багц, банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө, арилжааны үнэт цаас, бусад санхүүгийн хөрөнгө ба бусад санхүүгийн бус хөрөнгө зэрэг активын цэвэр өсөлтийг хасч, бууралтыг нэмнэ.
- Харилцах, хадгаламж, бусад банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр болон бусад санхүүгийн болон санхүүгийн бус өр төлбөрийн цэвэр өсөлтийг нэмж, бууралтыг хасна.
- Төлсөн орлогын албан татвар, төлсөн хүүг хасч, авсан хүүг нэмнэ. Орлого, зардалд хамаарах бусад төлбөрийг нэмэх буюу хасна.

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

6.7. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ нь ирээдүйд олох орлого ба мөнгөн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор нэмэлт хөрөнгө, нөөц бий болгоход зарцуулсан мөнгийг илэрхийлдэг.

6.8. Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ нь урт хугацаанд ашиглагдах хөрөнгө болон мөнгөтэй адилтгах хөрөнгөнд ороогүй бусад хөрөнгө оруулалтыг олж эзэмших болон худалдах үйл ажиллагааг хамарна.

6.9. Мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын ажиллагааны мөнгөн орлого хэсэгт хөрөнгө оруулалт (борлуулахад бэлэн үнэт цаас, хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас, зээл ба авлагаар ангилсан үнэт цаас, охин компани, хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт гэх мэт) ба үндсэн хөрөнгийг (хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг оруулсан) худалдаад орсон мөнгөн орлогын дүнг харуулна. Мөн хүлээн авсан хүүгийн орлого, ногдол ашгийг нэмнэ.

6.10. Хөрөнгө оруулалтын ажиллагааны зарлага хэсэгт үнэт цаас болон өмчийн хэрэгсэл худалдан авах хэлбэрээр хөрөнгө оруулалт оруулах (борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт, хугацааны эцэс хүртэл эзэмших хөрөнгө оруулалт, зээл ба авлагаар ангилсан хөрөнгө оруулалт, охин компани, хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт гэх мэт) болон үндсэн хөрөнгө худалдан авах, олж бэлтгэхэд ба их засварт зарцуулсан мөнгөн зарлага зэргийг тусгана.

Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

6.11. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ нь санхүүжилтийн бусад эх үүсвэр, орж ирэх хөрөнгө оруулалттай холбоотойгоор өр төлбөр ба өөрийн хөрөнгө өөрчлөгдөх үйл ажиллагааг хамарна.

6.12. Мөнгөн гүйлгээний тайлангийн санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого хэсэгт бусад эх үүсвэр, хоёрдогч өглөгийг оруулсан урт хугацаагаар авсан зээл ба эх үүсвэр, үнэт цаас худалдсаны орлого, хувьцаа гаргасанаас олсон орлого,бусдаас авсан санхүүжилт болон бусад орлогуудыг харуулна.

6.13. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлага хэсэгт урт ба богино хугацаагаар авсан зээл болон урт хугацаат өглөгийн төлөлт, мөнгөөр төлсөн ногдол ашиг зэрэг мөнгөн зарлага зэргийг харуулна.

Мөнгөн хөрөнгийн цэвэр өсөлт (бууралт)

6.14. Мөнгөн хөрөнгийн цэвэр өсөлт, бууралтыг үндсэн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын, санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний нийлбэрээр тодорхойлно. Мөн үүнд мөнгөн хөрөнгөтэй холбогдуулан үүссэн ханшийн зөрүүний нөлөөллийг багтаах ба уг нөлөөллийг тооцоолохдоо мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг валютын албан ханшаар дахин илэрхийлж, өмнөх ханшаар илэрхийлж байсан дүнгээс хасна.

6.15. Тайлант хугацааны мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлээс эхний үлдэгдлийг хасч тодорхойлсон мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт нь мөнгөн гүйлгээний тайланд тодорхойлогдсон "Бүх цэвэр мөнгөн гүйлгээ"-ний дүнтэй тэнцүү байна.

6.16. Мөнгөн гүйлгээг нэмэгдүүлэх ба хорогдуулахад нөлөөлдөггүй ажил гүйлгээнд хувьцаа гаргаж орлогод авсан үндсэн хөрөнгө, үндсэн хөрөнгө ба санхүүгийн хэрэгслийн дахин үнэлгээ, хувьцаагаар олгох ногдол ашиг гэх мэт орно.

ДОЛОО. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

7.1. Банкны санхүүгийн тайлангийн тодруулгад доорх зүйлсийг хамруулна:

а. Санхүүгийн тайланг бэлтгэх тулгуур үзэл баримтлал, ажил гүйлгээ ба үйл явдлыг бүртгэхээр сонгож авсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаарх тайлбарыг агуулсан байх;

б. Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан гэх зэрэг санхүүгийн тайлангуудад тусгагдаагүй боловч СТОУС-аар шаарддаг мэдээллийг тодруулсан байх;

в. Санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлантай холбоотойгоор хийсэн нарийвчилсан шинжилгээ, нэмэлт тайлбар, болзошгүй үүрэг гэх мэт нэмэлт мэдээллийг санхүүгийн тайлангийн тодруулгад тусгана.

7.2. Санхүүгийн тайлангийн тодруулгад санхүүгийн тайлангийн зүйл тус бүрийн мэдээллийг тайлангийн дэс дараалын дагуу толилуулна. Толилуулж, тодруулж буй дүнг зэрэгцүүлэх сууриар бэлтгэнэ (өөрөөр хэлбэл, тайлант хугацааны дүнг өмнөх хугацааны дүнтэй зэрэгцүүлнэ).

Тайлан бэлтгэх үндэслэл

7.3. Банкны үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, банкны нэр, санхүүгийн тайлангийн дуусгавар болсон огноо, санхүүгийн тайлангийн хамарсан хугацаа, банкны бүтэц, зохион байгуулалтанд гарсан гол өөрчлөлт, санхүүгийн тайлан СТОУС-д нийцсэн тухай тайлбар, нягтлан бодох бүртгэлийн ашиглаж буй суурь, ерөнхий бодлогын товч тайлбар зэргийг товч тодорхойлж, харуулна.

7.4. Шинээр гарсан бөгөөд тухайн тайлант жилийн эхнээс мөрдөж эхлэх СТОУС, дараагийн тайлант үеэс хүчин төгөлдөр үйлчилж эхлэх СТОУС, тайлбарыг тус тус анхааран үзэж, мөрдлөг болгох ба шинэ стандарт, тайлбарыг мөрдсөн жилийн ба түүнээс хойшх жилүүдийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөллийг үнэлнэ. Энэ мэдээллийг СТОУС-д нийцүүлсэн тухай мэдэгдэл эсвэл санхүүгийн тайлангийн тодруулгын холбогдох хэсэгт дурдана.

7.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тодруулахдаа санхүүгийн тайланд тусгасан үзүүлэлтүүдийг бүртгэх аргуудыг тайлбарлан үзүүлнэ. Зарим зүйлсийг хүснэгтээр илэрхийлж болно. Үүнээс гадна нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тодруулахдаа дараах зүйлсийн тухай дурдаж болно:

- Санхүүгийн тайланг бэлтгэж, тайлагнах арга ажиллагаа;
- Банкинд мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэл хөтлөх маягт, аргачлал;
- Бүртгэлийн ба тайлагналын валют;
- Санхүүгийн тайлангийн зүйл тус бүрээр хүлээн зөвшөөрөх зарчим, үнэлж бүртгэх арга (нягтлан бодох бүртгэлийн тусгай бодлого);
- Бүх төрлийн нөөц, сан байгуулах арга;
- Бодит үнэ цэнийн үнэлгээ, тооцоолол;
- Болзошгүй зүйлс;
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга;
- Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх зарчим.

7.6. Тайлант хугацааны төгсгөлд гадаад валютаар илэрхийлэгдсэн зүйлсийг төгрөгт (бүртгэлийн валют) хөрвүүлэхэд ашигласан, Монголбанкнаас зарласан гадаад валютын албан ханшийг тодруулж болно. Энэ мэдээллийг нягтлан бодох бүртгэлийн тодруулгын аль тохиромжтой гэж үзсэн хэсэгт дурдана.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт

7.7. Энэ хэсэгт нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдаа, тооцооллыг өөрчлөлтийн

талаар НББОУС 8-д заасны дагуу тодруулна.

7.8. Хэрэв банк нягтлан бодох бүртгэлийн бодлогоо өөрчилсөн бол өөрчлөх болсон шалтгаан, өөрчлөлтийн шинж чанар, шилжилтийн нөхцлийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлого илүү найдвартай, хамааралтай мэдээллээр хангана гэж үзсэн шалтгаан, түүний санхүүгийн тайланд үзүүлсэн нөлөөлөл зэргийг тодруулна.

7.9. Банк НББОУС 8-д заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтийг гүйцээн мөрдөх горимоор хүлээн зөвшөөрч байгаа бол түүний шинж чанар, санхүүгийн тайланд үзүүлсэн нөлөө, ирээдүйд үзүүлж болзошгүй нөлөөлөл зэргийг тодорхойлох боломжтой үед тодруулна.

7.10. Банк өмнөх тайлант хугацаанд хамаарах алдааг илрүүлж, залруулсан бол энэ талаар тодруулна.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

7.11. НББОУС 7-д заасан мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн шалгуур хангасан хөрөнгө, түүний тайлант үеийн эхний, эцсийн үлдэгдэлд гарсан өөрчлөлт, бусад шаардлагатай нэмэлт тайлбарыг тодруулна. Банкны үйл ажиллагааны цар хүрээг өсгөх, тогтвортой байдлыг хангах зорилгоор гарсан мөнгөн гүйлгээг тусгайлан тодруулж болно.

Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө

7.12. НББОУС 7-ын дагуу мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн шалгуур хангаагүй банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө (3 сараас дээш хугацаатай эсвэл хязгаарлагдсан мөнгө) -ийн тайлант үеийн эхний, эцсийн үлдэгдэлд гарсан өөрчлөлт, үнэ цэн буурсан тохиолдолд уг хөрөнгөтэй холбоотойгоор байгуулсан эрсдэлийн сан, эдгээрийг хүлээн зөвшөөрч, хэмжиж, үнэлэх тусгай бодлогыг товч тайлбарлана.

7.13. Банкны эзэмшилд байгаа боловч банк өөрөө ашиглах боломжгүй, барьцаанд байгаа мөнгөн хөрөнгийг (барьцаанд тавьсан, эсвэл гуравдагч этгээдийн хязгаарласан данс, Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц гэх мэт) тусгайлан тодруулна.

Хөрөнгө оруулалт

7.14. Хөрөнгө оруулалтын үлдэгдэл, тайлант үед гарсан өөрчлөлт, эрсдэлийн санг хөрөнгө оруулалтын ангилал бүрээр тодруулахын зэрэгцээ дараах зүйлсийг нэмж тайлбарлана:

- Тайлант хугацаанд худалдан авсан үнэт цаасны бодит үнэ цэнийн тооцоог хэрхэн хийсэн болон ашигласан үнэлгээний арга;
- Үнэт цаасны ангилал тус бүрээр байгуулсан эрсдэлийн сан;
- Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаасны хувьд эргэн төлөгдөх хугацаа;
- Хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгж, охин компанийн саналын эрхтэй хувьцаанаас банкны эзэмшилд буй хувь, түүнд гарсан өөрчлөлт;
- Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэдэг бол хяналтын эрхгүй хувь оролцоо, түүнд гарсан өөрчлөлт;
- Хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалтыг бүртгэсэн арга, уг аргатай холбогдуулан хийсэн үнэлгээ, тооцооллын нэмэлт тайлбар;
- Барьцаанд байгаа үнэт цаас;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны нэр төрөл;
- Хөрөнгө оруулалтыг данснаас хассанаас үүссэн орлого, зардал;
- Үнэт цаасны арилжаатай холбоотой хүлээж болзошгүй эрсдэл, эрсдэлийн үнэлгээ, шинжилгээ судалгаа.

7.15. Хөрөнгө оруулалтыг нэг ангиллаас нөгөө ангилалд шилжүүлж, өөрчилсөн тохиолдолд (ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх, борлуулахад бэлэн, хугацааны эцэс хүртэл эзэмших) дараах зүйлсийг заавал тодруулна:

- Ангилал өөрчлөгдсөний улмаас ангилал бүрт нэмэгдсэн болон тухайн ангиллаас хасагдсан дүн;
- Хөрөнгийг данснаас хасах хүртэл өмнөх ба тайлант жилд ангиллыг өөрчилсөн бүх санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэн ба дансны дүнг тайлант жил бүрээр;

- Санхүүгийн хөрөнгийг хугацааны эцэс хүртэл эзэмших ангиллаас борлуулахад бэлэн эсвэл ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжих ангилалд шилжүүлж өөрчлөх нь ховор бөгөөд ийм явдал тохиолдсон бол ховор тохиолддог болохыг нь нотлох баримт мэдээ, нөхцөл байдал;
- Санхүүгийн хөрөнгийн ангиллыг өөрчлөх үед ашиг, алдагдал эсвэл бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгийн тайлант болон өмнөх үеийн бодит үнэ цэнийн орлого, зардал;
- Санхүүгийн хөрөнгийн ангиллыг өөрчлөх, данснаас хасах хүртэлх тайлант хугацаа бүрт тухайн санхүүгийн хөрөнгийн ангиллыг өөрчлөөгүй байсан бол орлого, зардал, эсвэл бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөх байсан бодит үнэ цэнийн орлого, зардал болон ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн орлого, зардал, олз, гарз.

Зээл

7.16. Зээлийн өрийн үлдэгдлийг хугацаа, чанар, бүтээгдэхүүний төрлөөр харуулахын зэрэгцээ дараах зүйлсийг нэмж тодруулна:

- Зээлийн барьцаа, батлан даалт;
- Зээлийн эрсдэлийн сангийн тайлант хугацааны өөрчлөлт, үлдэгдэл;
- Тайлант хугацаанд сан байгуулсан эрсдэлийн зардлын дүн;
- Эрсдэлийн сангаас хаасан зээлийн дүн;
- Өмнөх тайлант хугацаанд сангаар хаасан зээлээс тайлант хугацаанд барагдуулсан дүн;
- Зээлийн хүү, түүний эргэн төлөгдөх дүнгийн үнэлгээ;
- Санхүүгийн түрээсийн авлагын хувьд дараах мэдээллийг нэмж тодруулна: санхүүгийн түрээсийн авлага, хэрэгжээгүй санхүүгийн орлого, холбогдох эрсдэлийн сан, түрээсийн авлагын өнөөгийн үнэ цэн зэргийг зохицуулсан тохируулга; мөн эдгээр зүйлсийг дуусгавар хугацаагаар дараах байдлаар ангилж, харуулна: 1 жил дотор төлөгдөх, 1-5 жилийн хооронд төлөгдөх, 5 дээш жилд төлөгдөх.

Дериватив санхүүгийн хэрэгсэл

7.17. Дериватив санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг адил төстэй шинж чанар, төрлөөр нь ангилж харуулахын зэрэгцээ дараах зүйлсийг нэмж тодруулна:

- Форвард, своп, фьючерс, опшин хэлцэлтэй холбоотойгоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн деривативын бодит үнэ цэнийн тооцоолол, түүнд ашигласан үнэлгээний арга;
- Тайлант хугацаанд нэмэгдсэн ба данснаас хассан деривативын дүн;
- Тайлант хугацаанд хэрэгжсэн форвард, своп, фьючерс, опшин хэлцэл, үүнтэй холбогдуулан үүссэн арилжааны олз ба гарз (деривативын бодит үнэ цэнийн өөрчлөлт);
- Форвард, своп, фьючерс, опшин арилжааны авлага, өглөгийн тэнцлийн гадуур бүртгэсэн нэрлэсэн дүн, холбогдох нэмэлт тайлбар;
- Гадаад валют, үнэт металлыг худалдах эсвэл худалдан авахаар байгуулсан форвард, своп, фьючерс, опшин хэлцэлтэй холбоотой хүлээж болзошгүй эрсдэл, түүнд хийсэн үнэлгээ, шинжилгээ;
- Хейджийн хэрэгсэл, хейджийн хэрэглүүрийн төрөл тус бүртэй холбоотой эрсдэл болон хейджээр хамгаалагдсан эрсдэлийн талаар тодруулна. Мөнгөн гүйлгээний эсвэл бодит үнэ цэнийн хейджийн хувьд НББОУС 39-д шаардсан бусад тодруулгыг нэмж тодруулна.

Бусад санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгө

7.18. Бусад авлага, урьдчилгаа тооцоотой холбогдуулан дараах тодруулгыг нэмж бэлтгэнэ:

- Бусад авлагыг барагдуулах хугацаагаар ангилан харуулах;
- Бусад авлагын эрсдэлийн сангийн тайлант хугацааны өөрчлөлт, эрсдэлийн сангаас хаасан авлагын дүн;
- Бусад авлага, урьдчилгааг данснаас хасахад үүссэн олз, гарз.

7.19. Бараа материал, үнэ бүхий зүйлстэй холбогдуулан хөрөнгийн үнэ цэнийн бууралт, бараа, материал, үнэ бүхий зүйлсийг данснаас хасахад үүссэн олз, гарзыг нэмж тодруулж болно.

Өмчлөх бусад хөрөнгө

7.20. Өмчлөх бусад хөрөнгийг чанар, нэр төрлөөр нь ангилж харуулах ба дараах зүйлсийг

тодруулна:

- Тайлант хугацаанд зээлийн өрөнд авсан санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгийн дүн, холбогдох мэдээлэл;
- Данснаас хассан өмчлөх бусад хөрөнгийн дүн;
- Тайлант хугацаанд худалдан борлуулсан хөрөнгийн дүн, үүссэн олз ба гарз;
- Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн өөрчлөлт, үлдэгдэл;
- Тайлант хугацааны эрсдэлийн сангийн зардлын дүн.

Үндсэн хөрөнгө

7.21. Үндсэн хөрөнгийн ангилал тус бүрээр дансны үлдэгдэл, хуримтлагдсан элэгдэл, элэгдлийн зардал, тэдгээрийн тайлант хугацаанд гарсан өөрчлөлтийг хүснэгтийн дагуу харуулах ба дараах мэдээллийг нэмж тодруулна:

- Ашигласан элэгдлийн арга, элэгдүүлэх хувь хэмжээ;
- Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралттай холбоотой хөдөлгөөн гарсан бол хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын зардал эсвэл буцаалт, холбогдох тооцоолол, үнэлгээ;
- Үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн бол үнэлгээ хийгдсэн өдөр, дахин үнэлгээний нэмэгдэл дансанд гарсан өсөлт, бууралт, ашигласан үнэлгээний аргачлал, эсвэл хөрөнгийн үнэлгээчнээр үнэлүүлсэн үнэлгээ;
- Санхүүгийн түрээсээр авсан хөрөнгө, холбогдох санхүүгийн түрээсийн өглөг;
- Барьцаанд байгаа үндсэн хөрөнгө;
- Бүтээн босгох ажлын үе шатанд байгаа үндсэн хөрөнгийн өртөгт хүлээн зөвшөөрсөн зардлын дүн, бүтэц;
- Үндсэн хөрөнгийн санхүүжилтэнд бүртгэсэн, хараахан хүлээн аваагүй үндсэн хөрөнгийн худалдан авалтын урьдчилгаа;
- Үндсэн хөрөнгийг данснаас хасахад үүссэн олз ба гарз.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

7.22. НББОУС 40-д заасны дагуу хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөнд ашигласан хэмжилтийн суурь, бодит үнэ цэнийн загвар ашигладаг бол бодит үнэ цэнийг тодорхойлоход ашигласан арга, бодит үнэ цэнийн тохируулгаас үүссэн олз, гарз, хэрэв түрээсэлдэг бол түрээсийн орлого, түрээсэлсэн хөрөнгөтэй холбоотой гарсан зардал, хэрэв өртгийн загвар ашигладаг бол хөрөнгийн ашиглалтын хугацаа, элэгдэл тооцох арга болон бусад тодруулгыг хийнэ

Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (эсвэл бүлэг хөрөнгө) болон өр төлбөр

7.23. СТОУС 5-д заасны дагуу тодруулна. Борлуулах зориулалттай хөрөнгөөр ангилсан эргэлтийн бус хөрөнгө, өр төлбөрийн тодруулгад тайлант хугацаанд хамааралтай дараах мэдээлэл багтана:

- Тухайн эргэлтийн бус хөрөнгийн тайлбар;
- Хөрөнгийг худалдах эсвэл данснаас хасахтай холбоотой нөхцөл байдал, баримт мэдээ болон холбогдох арга зам, цаг хугацаа;
- Хөрөнгийн өртгийг бодит үнэ цэнээс борлуулах зардлыг хассан дүн болтол бууруулахад бүртгэсэн зардал эсвэл хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулах зардлыг хассан дүн өсөхөд хүлээн зөвшөөрч, бүртгэсэн орлого, болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусад нь харуулаагүй орлого, зардлын дүн;
- Эргэлтийн бус хөрөнгийг СТОУС 8 “Үйл ажиллагааны сегмент”-ийн дагуу толилуулсан тохиолдолд тайлагнасан сегментийн талаар тодруулна.
- Эргэлтийн бус хөрөнгийг худалдах төлөвлөгөөг өөрчилсөн бол холбогдох тайлант хугацаанд багтаан уг шийдвэрийг гаргах болсон учир шалтгаан, нөхцөл байдал, энэ шийдвэрийн тайлант хугацааны болон өмнөх хугацаанд толилуулсан үйл ажиллагаанд үзүүлэх үр нөлөө.

Биет бус хөрөнгө

7.24. Биет бус хөрөнгийн ангилал тус бүрээр дансны үлдэгдэл, хуримтлагдсан хорогдол, хорогдлын зардал, тэдгээрийн тайлант хугацаанд гарсан өөрчлөлтийг хүснэгтийн дагуу

харуулахын зэрэгцээ дараах мэдээллийг нэмж тодруулна:

- Ашиглалтын хугацаа нь тодорхой биет бус хөрөнгийн хувьд хорогдол тооцоход ашигласан арга, хорогдуулах хугацаа, норм, тайлант жилийн хорогдлын зардлын дүн;
- Дахин үнэлгээний өөрчлөлтөөс гарсан өртгийн өсөлт, бууралт ба өмч, орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн өсөлт, бууралт;
- Биет бус хөрөнгийн үнэ цэнийг бууруулахтай холбоотойгоор хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын зардал эсвэл буцаалт, холбогдох тооцоолол, үнэлгээ;
- Бүтээн босгох ажлын үе шатанд байгаа биет бус хөрөнгийн өртөгт хүлээн зөвшөөрсөн зардлын дүн, бүтэц;
- Биет бус хөрөнгийн санхүүжилтэнд бүртгэсэн, хараахан хүлээн аваагүй биет бус хөрөнгийн худалдан авалт;
- Биет бус хөрөнгийг данснаас хасахад үүссэн олз ба гарз.

Харилцагчдын харилцах, хадгаламж

7.25. Харилцах, хадгаламжийн үлдэгдэл, тайлант хугацаанд гарсан өөрчлөлтийг хүснэгтийн дагуу харуулах ба бусад нэмэлт тайлбар, тэмдэглэлийг тодруулна. Тухайлбал, харилцах, хадгаламжийн үлдэгдлийг валютаар болон хугацаагаар ангилан тодруулж болно.

Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр

7.26. Бусад банк, санхүүгийн байгууллагаас татсан бусад эх үүсвэрийг нэр төрлөөр дараах байдлаар ангилж тайлант үеийн эхний ба эцсийн үлдэгдлийг харуулах ба бусад нэмэлт тайлбар, тэмдэглэлийг тодруулна. Үүнээс гадна банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийг валютын төрөл, зээлдүүлэгч банк, дотоодын ба гадаадын банк, санхүүгийн байгууллага гэж ангилах буюу материаллаг дүн бүхий эх үүсвэр, санхүүжилтийн талаар тусад нь тайлбарлаж тодруулж болно.

Бусад эх үүсвэр

7.27. Бусад эх үүсвэрийн ангилал бүрээр тайлант үеийн эхний ба эцсийн үлдэгдэл, өөрчлөлтийг тодруулна. Шаардлагатай тохиолдолд материаллаг дүнтэй бусад эх үүсвэрийг тусад нь тодруулж болно. Мөн бусад эх үүсвэрийн төрлүүдийг валютын төрөл, зээлдүүлэгч банкаар тодруулж, санхүүгийн түрээстэй холбогдуулан гэрээний ерөнхий мэдээлэл, хугацаа, түрээсийн төлбөр, болзошгүй өр төлбөр, буцаан түрээсэлсэн эсэхийг тодруулна. Репо хэлцлээр худалдсан үнэт цаасны төрөл, мөнгөн дүн, холбогдох мэдээллийг тодруулна. Аливаа эх үүсвэрийн хэлцэлийн нөхцлийг хязгаарласан тохиолдолд түүнийг тодруулах, үүнийг зөрчсөн эсэх талаар тодруулна.

Бусад санхүүгийн ба санхүүгийн бус өр төлбөр

7.28. Банк өнгөрсөн үйл явдлын үр дүнд бусад этгээдэд мөнгө төлөх магадлалтай бөгөөд төлөх дүнг найдвартай хэмжих боломжтой тохиолдолд НББОУС 37-ийн дагуу удирдлагын хамгийн сайн үнэлгээний дүнгээр нөөц байгуулна. Хэрэв мөнгөн дүнг найдвартай хэмжих боломжгүй тохиолдолд хамгийн өндөр позицийг оруулсан гарч болзошгүй дүнгүүдийн интервалыг болзошгүй өр төлбөрийн хамт тодруулна.

7.29. Бусад өр төлбөрт багтсан бусдад өгөх өглөг, салбар хоорондын өглөг, клирингийн тооцооны өглөг, клирингийн саатал, тооцооны бусад өглөг, тухайлбал: татвар, НДШ-ийн өглөг (дутуу төлөлт), ажилтан албан хаагчидтай үүссэн тооцоо гэх мэт өр төлбөрийг өмнөх тайлант үеийн үлдэгдэлтэй харьцуулан тодруулна.

7.30. Санхүүгийн түрээсийн өглөгтэй холбогдуулан дараах зүйлсийг тодруулна:

- Түрээсийн гэрээний ерөнхий мэдээлэл, онцлог заалтууд, хугацаа, түрээсийн төлбөр
- Түрээстэй холбоотой хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тооцоолол
- Түрээстэй холбоотой болзошгүй өр төлбөр
- Борлуулаад буцаан түрээсэлсэн хөрөнгө байгаа эсэх
- Санхүүгийн түрээсийн өглөг, хэрэгжээгүй санхүүгийн зардал, түрээсийн авлагын өнөөгийн үнэ цэн зэргийг хооронд нь зохицуулсан тохируулга болон эдгээр зүйлсийг дуусгавар хугацаагаар дараах байдалтай ангилж, харуулна. Үүнд: 1 жил дотор төлөгдөх, 1-5 жилийн хооронд төлөгдөх, 5 дээш жилд төлөгдөх.

7.31. Ажилтнуудад олгох нөхөн олговор, тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн хөгжлийн сантай холбоотойгоор дараах зүйлсийг тодруулна:

- Нөхөн олговор, тэтгэвэр, тэтгэмжийн төрлүүд, тэдгээртэй холбогдон гарсан зардал
- Урт хугацаат тэтгэвэр, тэтгэмжийн актуар тооцоолол, холбогдох орлого, зардал
- Удирдах албан тушаалтнуудад олгохоор тооцоолсон нийт тэтгэвэр, тэтгэмжийн дүн
- Ажилтнуудад хувьцаагаар олгосон шагнал, урамшуулал, тэтгэвэр, тэтгэмж ба хувьцаанд суурилсан төлбөрийн нөхцөл

Хоёрдогч өглөг

7.32. Хоёрдогч өглөгийг бүрдүүлж буй хэрэгслүүдийг дурдаж, тэдгээрийн үлдэгдэлд гарсан өөрчлөлтийг тайлбарлан тодруулна.

Өөрийн хөрөнгө, түүний удирдлага

7.33. Хувь нийлүүлсэн хөрөнгийг бүрдүүлж буй хувьцааны тоо ширхэг, нэрлэсэн үнэ, хувьцаанд хамааралтай эрх, давуу эрх, эрхийн хязгаарлалт болон тайлант хугацаанд нэмж гаргасан хувьцааны тоо, үүссэн нэмж төлөгдсөн капитал, нэмж төлөгдсөн капиталд гарсан бусад өөрчлөлт, халаасны хувьцаанд гарсан өөрчлөлт, гаргасан хувьцааны опцион зэргийг тодруулна. Өөрийн хөрөнгөнд багтсан сангууд, тэдгээрийн зориулалтыг тодруулна.

7.34. Хувьцаа эзэмшигчидтэй хийсэн өмчийн ажил гүйлгээ. Тухайлбал, нэмж гаргасан хувьцаа, хувьцаа эзэмшигчдэд хуваарилсан ногдол ашиг гэх мэт.

7.35. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулгын улмаас хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдэлд гарсан залруулгын дүнг тодруулж, дэлгэрэнгүй тайлбар хийнэ. Мөн холбогдох стандартанд шаардсаны дагуу өөрийн хөрөнгөөр шууд хүлээн зөвшөөрсөн орлого, зардал, олз, гарзын дүнг зүйл тус бүрийн болон нийт дүнгийн хувьд тодруулна.

7.36. Банк өөрийн хөрөнгийнг удирдахад баримтлах зорилгоо тусгайлан тодруулна. Уг зорилго нь дараах байдалтай байж болно (i) Монголбанкнаас тогтоосон өөрийн хөрөнгийн шалгуур үзүүлэлтийг хангах, (ii) банкны тасралтгүй үйл ажиллагааг хангах, (iii) бусад зорилго. Мөн банк Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, тогтоомжийн тодорхой заалтын талаар тодруулж (тухайлбал, өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт), энэ шаардлагыг хэрхэн биелүүлж байгаагаа холбогдох тоо мэдээгээр харуулна.

Хүүгийн орлого ба зардал

7.37. Тайлант хугацааны хүүгийн орлого ба зардалтай холбогдуулан хүүгийн орлого, зардлын ангилал бүрээр дараах мэдээллийг нэмж тодруулна:

- Тайлант үеийн хүүгийн орлого ба зардлын дүнг ангилал бүрээр;
- Эрсдэлийн сан байгуулсан зээлд хамаарах хүүгийн орлогын дүн;
- Цэвэр хүүгийн орлогын дүн;
- Монголбанкны журмын дагуу тэнцлийн гадуурх дансанд бүртгэсэн хүүгийн дүнг ангилал бүрээр.

Эрсдэлийн сангийн зардал

7.38. Банкны санхүүгийн тайланг хэрэглэгчид тухайн банкны санхүүгийн байдал ба үйл ажиллагаанд зээл, авлагаас үүсэх зардал хэрхэн нөлөөлж байгааг судлах шаардлагатай байдаг бөгөөд энэ нь тэдэнд тухайн банк татан төвлөрүүлсэн эх үүсвэрээ хэрхэн үр ашигтай байршуулж байгаа талаар мэдээллийг өгнө.

7.39. Зээл ба авлага нь буцаан төлөгдөх боломжгүй бол холбогдох журмын дагуу эрсдэлийн сангаар хаана. Зарим тохиолдолд хуулийн дагуу бүх асуудлууд шийдэгдэн, зардлын дүн тодорхой болсны дараа л банк зээл ба авлагыг данснаас хасдаг. Энэ тохиолдолд эрсдэлийн сангаас хаах зээл, авлагын талаар баримтлах бодлогоо банк тодруулна.

Арилжааны орлого, зардал

7.40. Валют, үнэт цаас, үнэт металлын арилжааны орлого, зардлын дүнг өмнөх оны дүнтэй зэрэгцүүлэн харуулах ба томоохон ажил, гүйлгээ, арилжааны хэлцлийн тухай нэмэлт тайлбарыг тодруулж болно.

Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого, зардал

7.41. Валют, үнэт цаас, үнэт металлын ханшийн тэгшитгэлийн орлого, зардлын дүнг өмнөх оны дүнтэй зэрэгцүүлэн харуулах ба үнэ, ханшийн томоохон хэлбэлзэл, түүний үр дагаварын тухай тайлбарыг нэмж тодруулж болно.

Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого, зардал

7.42. Үйлчилгээний шимтгэл, хураамжийн орлоготой холбогдуулан орлогын төрөл тус бүрийн дүнг харуулж, холбогдох нэмэлт тодруулгыг бэлтгэнэ.

Бусад орлого, олз

7.43. Бусад орлого, олзын төрлүүдээр тайлант ба өмнөх оны дүнг зэрэгцүүлэн харуулж, шаардлага нэмэлт тайлбар, тэмдэглэлийг тодруулна.

Удирдлага ба үйл ажиллагааны бусад зардал

7.44. Тайлант хугацааны удирдлага ба үйл ажиллагааны бусад зардалтай холбогдуулан дараах нэмэлт тодруулгыг бэлтгэнэ:

- Үндсэн үйл ажиллагаа, удирдлагын зардлын дүн ангилал бүрээр;
- Ажилтнуудтай холбоотой зардлын хувьд нийгмийн ба тэтгэвэрийн шимтгэлийн дүн;
- Хувьцаанд суурилсан төлбөртэй холбогдох зардлын дүн болон СТОУС-д заасан шаардлагатай бусад мэдээлэл;
- Томоохон ажил, гүйлгээ ба хэлцлийн тухай тайлбар.

Орлогын татварын зардал

7.45. Тайлант орлогын татварын зардалтай холбогдуулан дараах нэмэлт тодруулгыг бэлтгэнэ:

- Татвар ноогдох орлогын дүн, тооцоолсон ба бодит татварын зардлын хооронд хийгдэх тохируулга;
- Ногдуулсан татварын зардлын дүн;
- Татварын тооцоогоорх авлага, өглөгийн тайлант үеийн өөрчлөлт, үлдэгдэл;
- Хойшлогдсон татварын хөрөнгө, хойшлогдсон татварын өглөгийн дүн, эдгээрт тайлант үед гарсан өөрчлөлт, түр зөрүүг үүсгэсэн тэнцлийн дансдын үлдэгдэл.

Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ

7.46. Холбоотой талууд хоорондын ажил гүйлгээ нь холбоогүй талуудын ажил гүйлгээний нөхцлөөс ялгаатай байдаг. Тухайлбал банк нь холбоотой талдаа тухайн нөхцөл байдалд олгодгоосоо илүү их хэмжээгээр эсвэл хэт доогуур хүүгийн түвшингээр зээл олгох, тэрчлэн холбоотой талуудын хоорондох зээл ба хадгаламжийн шилжүүлэг нь холбоогүй талтай хийгдэхээс илүү түргэн явагддаг.

7.47. Холбоотой талуудын ажил гүйлгээ нь банкны бизнесийн ердийн үйл ажиллагааны хүрээнд явагдсан ч гэсэн эдгээр нь ихээхэн анхаарал татдаг асуудал тул ийм ажил гүйлгээг ердийн нөхцлөөр хийсэн эсэх талаарх мэдээллийг тодруулна. Банкуудын холбоотой талуудтайгаа хийх арилжаанд Монголбанкнаас хязгаарлалт тавина. Банк холбоотой талуудтай арилжаа хийсэн бол энэхүү ажил гүйлгээний агуулга, төрөл, элемент бүрийг санхүүгийн тайландаа ойлгомжтой тусгаж тодруулна.

7.48. НББОУС 24-д заасны дагуу толгой компанийн нэр, хэрэв хамгийн дээд хяналт тавигч тал нь ялгаатай бол тэрхүү хяналт тавигчийн нэр, удирдах албан тушаалтанд олгосон цалин, урт ба богино хугацаат тэтгэмж, ажил эрхлэлтийн дараах болон ажлаас халагдсаны тэтгэмж, хувьцаанд суурилсан төлбөр, холбоотой талтай хийсэн ажил гүйлгээний талаар тодруулах ба ингэхдээ дараах зүйлсийг харгалзана:

- Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний үр дүнд бүртгэсэн дансдын санхүүгийн байдлын тайланд тусгагдсан үлдэгдлийг тавигдсан нөхцлийн (тухайлбал, хүүгийн түвшин) хамт тодруулна;
- Зээл, урьдчилгаа, харилцах, хадгаламж, хүлээн авсан зүйлс, өрийн вексел тус бүрээр (уг тодруулгад эдгээр зүйлсийн эхний ба эцсийн үлдэгдлийн нийт дүн болон тайлант үед урьдчилгаа, хадгаламж, төлөлт гэх мэт бусад өөрчлөлтийг тусгана);
- Тайлант хугацааны орлогын дэлгэрэнгүй тайланд багтсан холбоотой талын бүх ажил гүйлгээг тодруулна; орлого, хүүгийн зардал, төлсөн үйлчилгээний шимтгэл, үйл

ажиллагааны бусад зардал, гадаад валютын ханшийн тэгшитгэлийн ба арилжааны орлого, зардал, үнэт цаас, деривативын арилжааны ба үнэлгээний орлого, зардал гэх мэт тус бүрийн төрөлд хамаарна;

- Зээлийн болон урьдчилгааны эрсдэлийн зардлын дүн ба уг зардлыг нөхөх зориулалттай тайлангийн өдрөөрх нөөц;
- Болзошгүй үүргээс үүссэн үл цуцлагдах зардал ба гарз; мөн тодруулга хийх шаардлагатай холбоотой талуудын ажил гүйлгээнээс үүссэн нөөц ба болзошгүй өр төлбөр (баталгаа, зээлийн шугам гэх мэт).

Болзошгүй хөрөнгө ба өр төлбөр

7.49. Банк НББОУС 37-ын дагуу тайлагналын өдрийн байдлаар хэрэгжих магадлалтай болзошгүй хөрөнгө ба болзошгүй өр төлбөрийн шинж чанар, боломжтой бол тэдгээрийн үр нөлөөллийг харуулсан тооцооллыг тодруулна.

Тайлагналын үеийн дараах үйл явдал

7.50. НББОУС 10-ын дагуу тайлагналын өдрийн дараах үл залруулагдах үйл явдлын материаллаг ангилал бүрээр эдгээрийн онцлог шинж, санхүүгийн үр нөлөөг тодруулна. Тухайлбал, санхүүгийн тайлагналын өдөр, санхүүгийн тайланг хэвлэн нийтлэх хугацааны хооронд гарсан дараах зүйлсийг тодруулна:

- Банкны үйл ажиллагаа, зохион байгуулалтанд гарсан томоохон өөрчлөлт;
- Нөлөө бүхий үйл явдал (НББОУС 10-д заасан залруулах ба үл залруулах үйл явдал) болон нягтлан бодох бүртгэлийн зааварт багтсан дараа үеийн үйл явдлаас үүссэн олз ба гарз;

Хөрөнгө оруулалтын мэдээ

7.51. Банк тайлант хугацаанд хийсэн хөрөнгө оруулалт буюу өөрийн хөрөнгийн зарцуулалтыг хүснэгтийн дагуу тодруулна.

7.52. Хөрөнгө оруулалт гэж банкны хуримтлалыг шинээр бий болгох, техник технологийг өргөтгөх, сайжруулахад зориулж, тайлант хугацаанд зарцуулсан хөрөнгө, хайгуул, зураг төсвийн ажлыг ойлгоно.

7.53. Банк тайлант хугацаанд бий болсон, худалдан авсан биет болон биет бус хөрөнгө, хайгуул, үнэлгээний хөрөнгийг эх үүсвэр бүрээр тодруулна.

7.54. Биет хөрөнгө гэдэгт банкны санхүүгийн байдлын тайланд тусгагдсан үндсэн хөрөнгөнд хамаарах хөрөнгө, эргэлтийн бус биологийн хөрөнгө, бусад биет хөрөнгийг хамруулна. Барилга, байгууламжийн дүнд багтсан орон сууцны барилга, авто замын дүнг тусад нь тодруулна.

7.55. Биет бус хөрөнгөнд санхүүгийн байдлын тайланд тусгасан биет бус хөрөнгийг хамруулна. Компьютерийн програм хангамжийг дотор нь програм хангамж, мэдээллийн сан гэж ангилна. Бусад биет бус хөрөнгөнд хамаарах барилгын зураг, төсвийн ажил, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын зардлыг тусад нь тодруулна.

7.56. Нийт дүнд биет хөрөнгө биет бус хөрөнгө, хайгуул үнэлгээний хөрөнгийн нийлбэрийг дүгнэнэ.

Эрсдэлийн удирдлага

7.57. Банкны санхүүгийн хэрэгслийн санхүүгийн байдал ба үр дүнд үзүүлсэн үр нөлөөг СТОУС 7-д заасны дагуу тодруулна. Үүнд зээлийн эрсдэл, төлбөрийн чадварын эрсдэл, зах зээлийн эрсдэл гэх зэрэг санхүүгийн хэрэгсэлд хамаарах эрсдэлд өртсөн хөрөнгийн талаарх тоон болон чанарын мэдээлэл багтана.

- Эдгээр эрсдэлийг удирдахтай холбогдуулан банкны удирдлагын баримталж буй зорилго, бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагааг тайлбарлана.
- Банкны эрх бүхий албан тушаалтанд зориулан гаргадаг дотоод мэдээлэлд үндэслэн банкинд нүүрлэж буй эрсдэлийн талаар мэдээллийг гаргана.

7.58. Зээлийн эрсдэлтэй холбоотойгоор санхүүгийн хэрэгслийн төрөл тус бүрээр дараах зүйлсийг тодруулна:

- Үнэт цаас хэлбэрээр эзэмшиж буй барьцааг харгалзан тооцсон, эрсдэлд хамгийн их өртөх хөрөнгийн дүн ба барьцааны талаарх зохих тайлбар
- Хугацаа хэтрээгүй бөгөөд үнэ цэн буураагүй санхүүгийн хөрөнгийн зээлийн шинж чанарын талаарх мэдээлэл. Энэ мэдээллийг банкны гадаад ба дотоод зэрэглэлийг ашиглах замаар олж авна. Хэрэв зэрэглэл тогтоогоогүй бол банк зээлийн эрсдэлийг харгалзах дансдын үлдэгдлийг тодорхой бүлгүүдэд хуваж, үнэлгээг гүйцэтгэнэ.
- Хугацаа хэтэрсэн боловч үнэ цэн буураагүй санхүүгийн хөрөнгийн хувьд банк хугацаа хэтэрсэн боловч үнэ цэн буурсан санхүүгийн хөрөнгийн насжилтын шинжилгээг тодруулгад тусгана.
- Үнэ цэн буурсан санхүүгийн хөрөнгийн хувьд банкны зүгээс үнэ цэнийн бууралтыг тогтоохдоо ашигласан хүчин зүйлс, холбогдох шинжилгээг тодруулгад тусгана.

7.59. Төлбөрийн чадварын эрсдэлтэй холбоотойгоор дараах зүйлсийг тодруулна:

Банк нь дериватив бус санхүүгийн өр төлбөр болон дериватив санхүүгийн өр төлбөрийн хувьд дуусгавар хугацааны шинжилгээг заавал гүйцэтгэсэн байна. Мөн банк төлбөрийн чадварын эрсдэлийг хэрхэн удирдаж байгаа талаарх тайлбарыг дурдана. Дэлгэрэнгүй тодруулгыг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн зааврыг мөрдөнө.

7.60. Зах зээлийн эрсдэлтэй холбоотойгоор дараах зүйлсийг тодруулна:

Банк нь зах зээлийн эрсдэлийн төрөл тус бүрээр (хүүгийн эрсдэл, гадаад валютын ханшийн эрсдэл гэх мэт) хийсэн мэдрэмтгий байдлын шинжилгээг тодруулгад дурдана. Банк эрсдэлийн төрөл тус бүрээр тухайн эрсдэлд өртсөн хөрөнгийн дүнг жилийн эцсийн байдлаар, ашиг, алдагдал, өөрийн хөрөнгөнд эдгээр эрсдэл хэрхэн нөлөөлөх талаар тодруулна. Дээрх шинжилгээг хийхдээ хувьсагчийг 10%-иар өөрчлөх буюу бодитой өөрчлөлт гэж үзэж болох өөр хувь хэмжээгээр өөрчлөх замаар гүйцэтгэнэ. Ашигласан арга, төсөөлөл болон энэ нь өмнөх жилийнхээс ялгаатай бол шалтгааныг тайлбарлана.

Бодит үнэ цэнийн тодруулга

7.61. Бодит үнэ цэнийн тодруулга ба шатлал: Банк бүх төрлийн санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодруулна. Үүнд санхүүгийн тайланд өртгөөр буюу хорогдуулсан өртгөөр илэрхийлсэн дансд ч багтана. Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг ижил төстэй ангид хуваж, бодит үнэ цэнийн шатлалаар нь тодруулгад тусгана. Бодит үнэ цэнийн дараах шатлал байдаг:

- Нэгдүгээр түвшин: Ижил төстэй хөрөнгийн идэвхитэй зах зээлийн залруулаагүй жишиг үнэ
- Хоёрдугаар түвшин: хөрөнгө, өр төлбөртэй холбоотойгоор шууд болон шууд бусаар олж авах боломжтой бөгөөд нэгдүгээр түвшинд багтсан жишиг үнээс бусад орц мэдээлэл
- Гуравдугаар түвшин: зах зээлээс бэлэн олдохгүй мэдээлэлд суурилаагүй орц мэдээлэл
- Нэгдүгээр түвшнээс хоёрдугаар түвшинд шилжүүлсэн мэдээлэл, үүний шалтгааныг тодруулна
- Гуравдугаар түвшний мэдээллийн хувьд тайлант жилийн эхэн ба эцсийн дүнгүүдийн хооронд тохируулга бэлтгэж, өөрчлөлт бүрийг тайлбарлана (хүлээн зөвшөөрсөн орлого/зардал, түвшин хооронд мэдээллийг шилжүүлсэн байдал, худалдан авалт, борлуулалт, төлөлт)

Тэнцлийн гадуурх дансд

7.62. Тайлант хугацаанд тэнцлийн гадуурх дансанд бүртгэсэн зүйлсийн үлдэгдэл, түүнд гарсан өөрчлөлтийг тодруулна. Зэрэгцүүлэх зорилгоор өмнөх хугацааны дүнг тайлант хугацааныхтай яг ижил хугацаагаар тасалбар болгон харуулна.